

ОУСОРЫН ХАМГААГАХ  
УЛСЫН АНГЫН ЭРХЭМ  
БҮРГЭЭ

2009-04-05

БҮРГЭЭ-02

УЛСЫН  
ХАМГААГАХ  
УЛСЫН АНГЫН  
ЭРХЭМ  
БҮРГЭЭ

# БЭРС-2

ХӨРӨНГӨӨР  
БАТАЛГААЖСАН  
ҮНЭТ ЦААС

ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ:  
"БЭРС ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК" ХХК

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ  
MONGOLIAN STOCK EXCHANGE

БЭРС ФИНАНС  
2023-04-06

БҮРТГЭВ-02

"Бэрс Эй Би Эр Плас ЗК" ХХК

СЭХ  
2023-04-06  
БҮРТГЭВ  
№ 01

ҮНЭТ ЦААС ГАРГАХАД ОРОЛЦОГЧ БАЙГУУЛЛАГУУД

Андеррайтер



"ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК" ХХК

[info@golomtcapital.com](mailto:info@golomtcapital.com)

+ 976-7012 1530

[www.golomtcapital.com](http://www.golomtcapital.com)

Зээлийн шинжилгээ гаргагч



"ОНЧ АУДИТ" ХХК

[Info@onch.mn](mailto:Info@onch.mn)

+ 976-7012 0450

[www.onch.mn](http://www.onch.mn)

Хуулийн фирм



"ӨМГӨӨЛЛИЙН ЭМ ДИ ЭС ЭНД ХААНЛЕКС" ХХН

[info@mdsa.mn](mailto:info@mdsa.mn)

+ 976-(11) 330048

[www.mdsa.mn](http://www.mdsa.mn)

Хөрөнгө Итгэмжлэн Удирдагч



ЮНАЙТЕД АЙР ФАЙНЭНС

"ЮНАЙТЕД АЙР ФАЙНЭНС" ХХК

[info@uaf.mn](mailto:info@uaf.mn)

+ 976-7012 2346

[www.uaf.mn](http://www.uaf.mn)







"Бэрс Эй Би Эс Плас ТЗК" ХХК



## ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АНХААРАЛД

Үнэт цаас гаргагч нь Монгол Улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр Баталгаажсан Үнэт Цаасны тухай хууль болон Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Биржийн холбогдох дүрэм, журмуудын дагуу Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргаж байгаа болно.

Энэхүү Үнэт цаасны танилцуулгыг Үнэт цаас гаргагчаас нэг бүрийн 100,000 төгрөгийн үнийн дүн бүхий 90,000 ширхэг Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасыг Монголын Хөрөнгийн Бирж дээр гарган олон нийтэд нээлттэй арилжихтай холбоотойгоор хөрөнгө оруулагчдад зориулж бэлтгэсэн болно.

Энэхүү Үнэт цаасны танилцуулга нь Хөрөнгө оруулагч таны хараат бус үнэлгээ гаргах, шинжилгээ хийхийг орлохгүй бөгөөд тэдгээрт тооцогдохгүй. Хөрөнгө оруулагч та Үнэт цаас гаргагч болоод түүний гаргаж буй үнэт цаас, холбогдох мэдээллийн талаар өөрийн судалгаа шинжилгээг хийсний үндсэн дээр хөрөнгө оруулалт хийж буй бөгөөд өөрийн мэргэжлийн санхүүгийн, хуулийн болон бусад зохих мэргэжлийн зөвлөхүүдтэйгээ зөвлөлдөхийг зөвлөж байна.

Энэхүү Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан зарим ирээдүйн болон зөвхөн одоогоор цаг хугацааны шинж чанартай гаргасан мэдээлэл, мэдэгдэл, тооцоолол, төсөөлөл нь Андеррайтерийн холбогдох эх сурвалжаас цуглуулсан мэдээлэл, итгэл үнэмшил дээр тулгуурласан бөгөөд санаатайгаар ямар нэгэн мэдээллийг орхигдуулаагүй болно. Андеррайтер нь эдгээр мэдээлэл, мэдэгдэл, тооцоолол, төсөөллийг гаргахдаа аль болох үнэн зөв мэдээллийг ашиглан бодит байдалд нийцүүлэхийг зорьсон боловч цуглуулсан мэдээллийн үнэн зөв байдалд хариуцлага хүлээхгүй бөгөөд тооцоолол, ирээдүйн төсөөллийн биелэлтэд баталгаа өгөөгүй болно.

**ЭНЭХҮҮ ТАНИЛЦУУЛГАД ТУСГАСАН ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН БАТАЛГААТ ҮНЭТ ЦААСЫГ САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО БОЛОН МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ БҮРТГЭСЭН НЬ УГ БАТАЛГААТ ҮНЭТ ЦААСАНД ГАРГАСАН БАТАЛГАА БИШ БӨГӨӨД ТҮҮНИЙ АГУУЛСАН МЭДЭЭЛЛИЙН ҮНЭН ЗӨВ, БҮРЭН БҮТЭН БАЙДАЛ БОЛОН АЛИВАА ЭРСДЭЛИЙГ СЭХ БОЛОН МХБ ХАРИУЦАХГҮЙ БОЛОХЫГ АНХААРАХ НЬ ЗҮЙТЭЙ. ЭНЭХҮҮ ҮНЭТ ЦААСЫГ ХУДАЛДАН АВАХ ЗАМААР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙХ НЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ТАНЫ ХУВЬД ЯМАГТ ЭРСДЭЛТЭЙ ҮЙЛДЭЛ БАЙДГИЙГ ОНЦГОЙЛОН АНХААРЧ, БАТАЛГААТ ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА, БАТАЛГААТ ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛЛАГААГ САЙТАР АНХААРАН СУДАЛСНЫ ҮНДСЭН ДЭЭР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИЙДВЭРЭЭ ГАРГАХЫГ ЗӨВЛӨЖ БАЙНА.**

Энэхүү үнэт цаасны танилцуулгад хөрөнгө оруулагч танд тус үнэт цаасыг худалдан авах шийдвэр гаргахад туслах шаардлагатай бүхий л мэдээллийг агуулахыг зорьсон болно. Хөрөнгө оруулагч таны шийдвэр гаргалтад танилцуулгад тусгагдсан мэдээллээс илүү дэлгэрэнгүй, нэмэлт мэдээлэл шаардлагатай болох буюу лавлаж тодруулах зүйл байвал Үнэт цаас гаргагч болон Андеррайтер Голомт Капитал ҮЦК ХХК-д хандаж тодруулна уу.



**НЭР ТОМЬЕОНЫ ТАЙЛБАР**

Нэр томьёо	Тайлбар
Үүрэг гүйцэтгэгч	Гэрээнд заасны дагуу хөрөнгөтэй холбоотой мөнгөн төлбөрийн үүрэг хүлээсэн этгээд
Үйлчилгээ үзүүлэгч	Үүрэг гүйцэтгэгчтэй харилцаж, хөрөнгөтэй холбоотой төлбөрийг цуглуулан тусгай зориулалтын компанид шилжүүлэх, бүртгэх болон гэрээнд заасан бусад үйлчилгээг үзүүлэх хуулийн этгээд
Тусгай зориулалтын компани	Хорооноос хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргах үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл авсан хязгаарлагдмал хариуцлагатай компани
Хөрөнгө итгэмжлэн удирдагч	Тусгай зориулалтын компанитай гэрээ байгуулсан, хөрөнгө оруулагчид барьцаалуулсан хөрөнгийг түүний эрх ашигт нийцүүлэн эзэмшиж, удирдах үүрэг бүхий этгээд
Хөрөнгийн багц	Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны нэг удаагийн гаргалтыг баталгаажуулж байгаа хөрөнгийн нийлбэр
Анхдагч зах зээлийн арилжаа	Үнэт цаас гаргагчийн шинээр болон нэмж гаргасан хувьцаа, өрийн хэрэгсэл, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас болон бусад санхүүгийн хэрэгслийг анхдагч зах зээлд байршуулах, хуваарилалт хийх арилжих үйл ажиллагааг
Хороо	Санхүүгийн Зохицуулах Хороо
Бирж	Монголын Хөрөнгийн Бирж

**ТОВЧИЛСОН ҮГНИЙ ТАЙЛБАР**


Товч үг	Тайлбар
ХБҮЦ	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас
СЗХ	Санхүүгийн Зохицуулах Хороо
МХБ	Монголын Хөрөнгийн Бирж
ХОС	Хөрөнгө оруулалтын сан
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ТЗК	Тусгай зориулалтын компани
ТУЗ	Төлөөлөн Удирдах Зөвлөл



Бэрс Эй Би Эс Плас ТЗК ХХК сэр ... өдөр



ҮНЭТ ЦААС ГАРГАХАД ОРОЛЦОГЧ БАЙГУУЛЛАГУУД.....	2
ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АНХААРАЛД.....	3
НЭР ТОМЬЕОНЫ ТАЙЛБАР.....	4
ТОВЧИЛСОН ҮГНИЙ ТАЙЛБАР.....	4
1 ҮНЭТ ЦААСНЫ ХУРААНГУЙ ТАНИЛЦУУЛГА.....	8
1.1 Үнэт цаасны товч танилцуулга.....	8
1.2 Үнэт цаас гаргагчийн мэдээлэл.....	9
1.3 Үүсгэн байгуулагчийн тухай.....	10
1.4 Мөнгөн урсгалын тооцоолол.....	10
1.5 Хөрөнгийн багцын мэдээлэл.....	10
2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЧИН.....	13
2.1 Макро эдийн засгийн төлөв байдал.....	13
2.2 Хөрөнгийн зах зээлийн нөхцөл байдал.....	17
2.3 ХБУЦ-ны тухай, давуу болон сул талууд.....	19
3 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ.....	24
3.1 Үнэт цаас гаргагчийн ерөнхий мэдээлэл.....	24
3.2 Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагчийн товч мэдээлэл.....	24
3.3 Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн мэдээлэл.....	25
3.4 Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн гишүүдийн мэдээлэл.....	25
3.5 Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн гишүүдийн эрх, үүрэг.....	26
3.6 Үнэт цаас гаргагчийн Санхүүгийн тайлан.....	26
3.7 Үнэт цаас гаргагчийн Санхүүгийн төсөөлөл.....	27
3.8 Үнэт цаасыг хөрөнгө оруулагчдад олгохоос өмнө төлөгдөх төлбөр, зардлын мэдээлэл.....	27
3.9 Зөвшөөрөгдсөн дансдын мэдээлэл.....	28
3.10 Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг буцаан худалдан авах нөхцөл.....	29
4 АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧ ББСБ-ЫН ТУХАЙ.....	31
4.1 Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон үүсгэн байгуулагчийн үйл ажиллагааны тухай.....	31
4.2 Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн хувьцаа эзэмшигч болон холбоотой этгээд.....	34
4.3 Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн бүтэц, зохион байгуулалт.....	36
4.4 Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн хүний нөөц, программ хангамжийн тухай.....	39
4.5 Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн санхүүгийн байдал.....	39
5 ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ.....	45
5.1 Үнэт цаасжуулах хэлцлийн зураглал.....	46
5.2 Үнэт цаасны хүү тогтоосон үндэслэл.....	49





"Бэрс Эй Би Эс Плас ТЗК" ХХК

5.3 Үнэт цаасны төлбөрийн хуваарь..... 49

5.4 Баталгаат үнэт цаасны төлбөр хугацаандаа төлөгдөхгүй нөхцөлд авах арга хэмжээ 50

5.5 Хөрөнгийн багц, түүнд тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлтүүд..... 51

5.6 Хөрөнгийн багцын мэдээлэл..... 52

5.7 Хөрөнгийн багцад өөрчлөлт оруулах тухай..... 54

5.8 Эрсдэлийн удирдлага ..... 56

6 ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ТУХАЙ..... 60

7 ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УДИРДАГЧИЙН ТУХАЙ..... 64

7.1 Ерөнхий танилцуулга..... 64

7.2 Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай байгуулсан гэрээний тухай..... 65

7.3 Хөрөнгө итгэмжлэн удирдагчийг солих ..... 66

8 ХБҮЦ-НЫ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН..... 68

8.1 Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааг зохицуулах хууль эрх зүйн орчин..... 68

8.2 Үнэт цаас гаргах үйл ажиллагааг зохицуулах хууль эрх зүйн орчин ..... 69

8.3 Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон хөрөнгийн багцтай холбоотой хууль эрх зүйн орчин 71

8.4 ТЗК-ийн ХБҮЦ-тай холбоотой үйл ажиллагааны зохицуулалт..... 71

9 ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААГ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАХ ..... 74

9.1 Үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулах ..... 74

9.2 Үнэт цаасны арилжаанд оролцох, захиалга авах заавар..... 75

9.3 Албан татвар..... 75

9.4 Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа..... 76

9.5 Үнэт цаасны арилжаа, хүүгийн төлбөр ..... 76

9.6 Үнэт цаас эзэмшигчийн эрх, үүрэг..... 76

9.7 Үнэт цаас гаргагчийн эрх, үүрэг ..... 76

10 ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДАД ТАЙЛАГНАХ..... 79

10.1 Хөрөнгө оруулагчдад танилцуулах мэдээллүүд, тэдгээрийн тайлангийн хугацаа ..... 79

10.2 Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлэх журмын тухай ..... 81

11 ҮНЭТ ЦААС ГАРГАХАД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУД ..... 83

11.1 Андеррайтер ..... 83

11.2 Зээлийн шинжилгээ гаргагч ..... 84

11.3 Хуулийн шинжилгээ гаргагч..... 85

11.4 Хөрөнгө итгэмжлэн удирдагч..... 86

11.5 Оролцогч байгууллагууд нь нэгдмэл сонирхол, бизнесийн холбоо хамааралтай эсэх талаарх мэдээлэл ..... 87

12 ХАВСРАЛТ..... 89





МОНГОЛЫН ХИЙМЕЛЭГЭЙН ХАМГААГАХ  
МОНГОЛЫН ИТ ОХИ ВЭЛЭГЭЙН

2013-09-15

БҮРТГЭЛЭГ



# БЭРС

## -2 ХБҮЦ

НЭГ. ҮНЭТ ЦААСНЫ ХУРААНГУЙ  
ТАНИЛЦУУЛГА



1 ҮНЭТ ЦААСНЫ ХУРААНГУЙ ТАНИЛЦУУЛГА

1.1 Үнэт цаасны товч танилцуулга


Үнэт цаас гаргагч	Бэрс Эй Би Эс Плас ТЗК ХХК
Анхны үүрэг гүйцэтгүүлэгч	Бэрс Финанс ББСБ ХХК
Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага	Монголын Хөрөнгийн Бирж
Үнэт цаасны төрөл	Автомашины фидуци бүхий хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас
Үнэт цаасны нэр	"Бэрс-2" ХБҮЦ
Нэрлэсэн үнэ	100,000 төгрөг
Санал болгож буй тоо ширхэг	90,000 ширхэг
Татан төвлөрүүлэх нийт дүн	9,000,000,000 төгрөг хүртэл
Үнэт цаас гаргахаар төлөвлөж буй хугацаа	2023.03 сар
Үнэт цаасны хугацаа	24 сар
Үнэт цаасны хүү	19.2%
Үнэт цаасны хүү тооцох суурь хоног	365
Үнэт цаасны хүү төлөх давтамж	Улирал бүр
Үндсэн төлбөр төлөгдөх давтамж	Жилд 1 удаа
Үнэт цаасны хадгалалт, төлбөр тооцоо	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв
Үнэт цаасны зарцуулалт	Компанийн үндсэн үйл ажиллагаа
Барьцаа	Автомашины фидуци бүхий зээлийн багц
Үнэт цаас төлбөр төлөгдөх эх үүсвэр	Хөрөнгийн багц дах зээлийн үндсэн төлбөр болон хүүгийн төлбөр
Үнэт цаасны хүүд ногдох татвар	Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн дагуу Хөрөнгө оруулагч нь үнэт цаасны хүүгийн орлогоос 5 хувийн албан татварыг суутгуулна





Үнэт цаас гаргагч	Бэрс Эй Би Эс Плас ТЗК ХХК
Улсын бүртгэлд бүртгүүлсэн огноо	2022 оны 11 сарын 10
Үнэт цаас гаргагчийн тухай	Бэрс Финанс ББСБ ХХК үүсгэн байгуулсан ХБҮЦ (баталгаат) гаргах үндсэн үйл ажиллагаа бүхий ТЗК
Регистрийн дугаар	6949886
Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ	1,000,000 (нэг сая төгрөг)
Улсын бүртгэлийн дугаар	9011845634
Үйл ажиллагааны үндсэн чиглэл	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах
Хаяг	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 11-р хороо, 7-р хороолол, Ногоон нуур, 101 барилга, 706 тоот
Утас	+976 9911 9632





"Бэрс" ЭЙ Би Эс Плас Т.ХХС-ийн сарын өдөр



### 1.3 Үүсгэн байгуулагчийн тухай

Үүсгэн байгуулагч	Бэрс Финанс ББСБ ХХК
Үүсгэн байгуулагчийн эзэмшиж буй хувь хэмжээ	100% (нэг зуун хувь)
Регистрийн дугаар	6186858
Улсын бүртгэлийн дугаар	9015005096
Үүсгэн байгуулагдсан огноо	2017/05/18
Санхүүгийн Зохицуулах Хорооноос тусгай зөвшөөрөл олгосон огноо, дугаар	2017/07/05, ТЗ 101/622, Банк бус санхүүгийн үйл ажиллагаа: Зээлийн үйл ажиллагаа эрхлэх, Факторингийн үйлчилгээ, Итгэлцлийн үйлчилгээ үзүүлэх, Төлбөрийн баталгаа гаргах
Хаяг байршил	Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 11-р хороо, 7 хороолол, ногоон нуур, 101 барилга, 706 тоот
Арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй эсэх	Үгүй
Үйл ажиллагааны чиглэл	<ul style="list-style-type: none"> <li>➢ Зээлийн үйл ажиллагаа</li> <li>➢ Факторингийн үйлчилгээ</li> <li>➢ Итгэлцлийн үйлчилгээ</li> <li>➢ Төлбөрийн баталгаа гаргах</li> </ul>

### 1.4 Мөнгөн урсгалын тооцоолол


Үнэт цаас гаргагчийн нь Хөрөнгийн багцын эргэн төлөлтийн орлого болон хөрөнгө оруулалтын орлого, улирал бүрийн хүүгийн зардал болон үйл ажиллагааны зардлыг улирал бүрээр тооцоолбол үнэт цаас гаргагч нь ХБҮЦ-ны төлбөрийг төлөх бүрэн чадамжтай гэж дүгнэлээ.

### 1.5 Хөрөнгийн багцын мэдээлэл

Үнэт цаас гаргагч нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс санал болгосон автомашины фидуци бүхий 2022 оны 11-р сарын 07-ны өдрөөр тасалбар болгосон нийт 2,160 зээлийн гэрээнээс бүрдсэн 13,082,498,702 (арван гурван тэрбум зуун наян хоёр сая дөрвөн зуун ерэн найман мянга долоон зуун хоёр) төгрөгийн үнийн дүн бүхий хөрөнгийн багцыг бүрдүүлсэн.

Харин Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үед тус хөрөнгийн багц дахь зээлүүд төлөгдөж 2023 оны 2-р сарын 28-ны өдрөөр тасалбар болгосон 2,318 зээлийн гэрээнээс бүрдсэн 10,005,596,403 (арван тэрбум таван сая таван зуун ерэн зургаан мянга дөрвөн зуун гурав) төгрөгийн үнийн дүн бүхий багц болж өөрчлөгдсөн байна. Хөрөнгийн багцын жагсаалтыг хавсралтаас харна уу.





"Бэрс Эй Би Эс Плас" ХХК 0400 сар 11 өдөр



**Хөрөнгийн багцын үндсэн үзүүлэлт**

<b>Хөрөнгийн багцын үндсэн үзүүлэлт</b>	
<b>Зээлийн төрөл</b>	<b>Дүн /төгрөгөөр/</b>
Нийт автомашины зээлийн үлдэгдэл	10,005,596,403
Зээлийн хөрөнгийн барьцааны дүн	39,498,262,949
Зээлийн гэрээний тоо	2,318
Зээлийн дундаж үлдэгдэл	4,316,478
Барьцааны дүн	39,498,262,949
Жигнэсэн дундаж хүү /сар/	3.44%
Жигнэсэн дундаж хугацаа /сар/	32
Жигнэсэн дундаж LTV%	49%
<b>Багцын зээлийн чанар</b>	<b>100% хэвийн зээл</b>

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл



МОНГОЛЫН ХАМГААГАХ АЖ АХуй  
БЭРЭГЭЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН  
2021 оны 4 дүгээр сар  
Улаанбаатар

# БЭРС -2 ХБҮЦ

ХОЁР. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН  
ОРЧИН



2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЧИН

2.1 Макро эдийн засгийн төлөв байдал

Цаашид Монгол Улсын эдийн засгийн төлөв байдал 2023 онд 5 орчим хувиар, 2024 онд дунджаар 7 хувиар өснө хэмээн таамаглаж байна.

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Нэгж	2019	2020	2021	2022
<b>Бодит сектор</b>					
ДНБ, оны үнээр	тэрбум төг.	36,898	36,958	43,555	52,867
ДНБ, 2015 оны зэрэгцүүлэх үнээр	тэрбум төг.	27,928	26,655	27,092	28,405
ДНБ-ний бодит өсөлт	хувь	5.1%	-5.3%	1.6%	4.8%
Нэг хүнд ногдох ДНБ, оны үнээр	сая төг	11.6	11.4	13.3	N/A
<b>Хүүний түвшин</b>					
Бодлогын хүү	%	11.0%	6.0%	6.0%	13.0%
Инфляцын түвшин	%	5.2%	2.3%	13.4%	13.2%
Хадгаламжийн хүү, жилээр	%	13.17%	12.2%	8.99%	10.5%
Зээлийн хүү, жилээр	%	16.9%	16.9%	15.8%	15.9%
Төгрөг ам.долларын албан ханш	төг.	2,734	2,849	2,849	3,496

Эх сурвалж: ҮСХ, Монголбанк

Монгол Улсын эдийн засгийн өсөлт, бууралт нь экспортын гол нэрийн бүтээгдэхүүний үнийн өөрчлөлт, гадаадын шууд хөрөнгө оруулалт, стратегийн ач холбогдолтой төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтээс шууд хамааралтай байдаг.

2012 онд экспортын гол нэрийн бүтээгдэхүүн болох нүүрсний үнэ дэлхийн зах зээлд өссөнөөр Монгол Улсын эдийн засаг түүхэн дээд түвшин болох 17.3 хувийн өсөлтийг үзүүлж байсан юм. Улмаар уул уурхайн экспортын хэмжээ аажмаар буурч, гадаад ерийн дарамт ихэссэнээр эдийн засаг уналтын мөчлөгт орсон.

Харин 2017 онд Монгол Улс нь Олон Улсын Валютын Сан (ОУВС)-ийн санхүүжилтийн хөтөлбөрийг хэрэгжүүлж, олон улсын зах зээлд зэс, нүүрсний үнэ өссөнөөр эдийн засаг аажмаар сэргэж эхэлсэн. Гэвч 2020 онд Ковид-19 цар тахлын нөлөөгөөр эдийн засаг 5.3 хувиар агшсан нь 1992 оны шилжилтийн үеэс хойш тохиосон хамгийн том уналт болсон юм. Эдүгээ Ковид19 цар тахлын үр нөлөө багассан ч олон улсад өрнөж буй үйл явц нь Монгол улсын эдийн засгийн өсөлтийг удаашруулж байна. 2022 оны 4 дүгээр улирлын байдлаар эдийн засаг 4.8 хувиар өссөн нь байна. Тухайлбал, уул



уурхай, олборлолтын салбар 11.9 хувиар буурсан үзүүлэлттэй байгаа бол хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас, ан агнуурын салбар 12 хувь, мэдээлэл холбоо, бүтээгдэхүүн салбар 11.5 хувь, бүтээгдэхүүний цэвэр татвар 11.5 хувь тус тус өссөн нь эдийн засаг 4.8 хувь өсөхөд голлох нөлөөг үзүүлсэн байна.

**Монгол Улсын нэрлэсэн ДНБ (их наяд төгрөгөөр) болон бодит ДНБ-ний өсөлт, хувиар**



Эх сурвалж: УСХ

Дэлхийн банк, ОУВС, АХБ-ны шинжээчид Монгол Улсын эдийн засгийг 2023 онд дунджаар 5 хувиар, 2024 онд дунджаар 7 хувиар сэргэнэ гэж таамаглаж байна.

**Бодит ДНБ-ийн өсөлтийн төсөөлөл, хувиар**

	2023T	2024T	2025T	2026T	2027T
Дэлхийн банк	5.8%				
АХБ	4.9%				
ОУВС	4.4%	7.0%	6.0%	5.5%	5.0%
<b>Дундаж</b>	<b>5.0%</b>	<b>7.0%</b>	<b>6.0%</b>	<b>5.5%</b>	<b>5.0%</b>

Эх сурвалж: Дэлхийн банк, АХБ, ОУВС

**Дунд хугацаанд инфляцыг 6 хувийн зорилтод түвшинд барина**


2022 оны ОХУ, Украины дайн, эрчим хүчний үнийн өсөлт зэрэг асуудлаас үүдэн дэлхий даяар инфляцын түвшин өсөж, улмаар Монгол Улсын инфляцын түвшин 12.3 хувь, Улаанбаатар хотын инфляцын түвшин 12.0 хувьд хүрсэн.

Тодруулбал, газрын тосны үнэ олон улсын зах зээлд 2022 оны 1 сард 1 баррель нь 89 ам.доллар байсан бол 2022 оны 5 сард 120 ам.долларт хүрч 34 хувиар өссөн нь импортын голлох бүтээгдэхүүн болох шатахууны үнийг өсгөх суурь нөхцөл болсон.





"Бэрс Эй Би Эс Плас" ХХК



Эх сурвалж: YCX, Монголбанк

Монгол банк нь 2021-2023 онд мөнгөний бодлогыг зах зээлийн зарчимд тулгуурлан хэрэгжүүлж, инфляцын түвшнийг 6 хувийн зорилтод түвшинд тогтвортой барих бодлоготой байна. Инфляцын түвшин таамаглаж байснаас өндөр болсонтой холбогдуулан Монгол банкнаас мөнгөний хатуу бодлогыг баримтална. Энэ нь эдийн засгийн удаашралтыг бий болгох тул хөрөнгө оруулагчид мөнгөний тогтвортой өсөлтийг бий болгох санхүүгийн хэрэгслийг илүүчлэх болно.

Дэлхийн банк, ОУВС, АХБ-ны шинжээчид инфляцын түвшнийг 2023 онд дунджаар 11.4 хувьд, 2024 онд дунджаар 9.7 хувьд хүрнэ гэж таамаглаж байгаа нь богино хугацаанд инфляцын түвшин буурах магадлалтайг харуулж байна.

**Инфляцын төсөөлөл, хувиар**



	2023T	2024T	2025T	2026T	2027T
Дэлхийн банк	10.5%	7.5%	6.8%		
АХБ	11.6%	12%	12%	12%	12%
ОУВС	12.1%	9.5%	8.2%	7.3%	6.5%
<b>Дундаж</b>	<b>11.4%</b>	<b>9.7%</b>	<b>9.0%</b>	<b>9.6%</b>	<b>9.3%</b>

Эх сурвалж: Дэлхийн банк, АХБ, ОУВС,

2022 оны эхний 9 сарын урьдчилсан гүйцэтгэлээр Монгол Улсын төсвийн орлого 12.5 их наяд төгрөгт, төсвийн зарлага 12.4 их наяд төгрөгт тус тус хүрч, төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 70 тэрбум төгрөг гарлаа.

**Төсвийн тэнцэл, тэрбум төгрөгөөр**





Эх сурвалж: УСХ

2022 оны 3 дугаар улирлын байдлаар Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 70.22 тэрбум төгрөг байлаа. Нэгдсэн төсвийн орлого өсөлттэй байгаа нь засгийн газраас эдийн засгийг танах үйл ажиллагаа хийж байгаатай холбоотой.

**Гадаад худалдааны тэнцэл, сая ам.доллаар**



Эх сурвалж: УСХ

БНХАУ Ковид19-ын нөхцөл байдлаас болж хөл хориогоо чангатгаж байгаа нь олон улсын нийлүүлэлтэд саад учруулж байна. Энэ нь бүр цаашлаад эдийн засгийн хэтийн төлөвт сөргөөр нөлөөлөх боломжтой.

Тодруулбал, БНХАУ-ын эдийн засаг 2022 оны 3 дугаар улиралд 3.9 хувиар өсөж, үл хөдлөх хөрөнгийн салбар уналттай байгаа тул төв банкнаас мөнгөний тэлэх бодлого баримталж эхэлсэн.

**Мөнгөний хатуу бодлогыг баримталж байна**

2022 оны 3-р улирлын байдлаар мөнгөний нийлүүлэлт өмнөх оны мөн үеэс 0.7 хувиар өсөж, өмнөх оны эцсээс 1.4 хувиар буурч, 27.5 их наяд төгрөгт хүрсэн. М2 мөнгөний жилийн өсөлтөд төгрөгийн харилцах 12 хувиар, валютын харилцах 89 хувиар, валютын хадгаламж 10 хувиар өссөн нь нөлөөлсөн бол төгрөгийн хадгаламж 17 хувиар буурсан нь мөнгөний нийлүүлэлтийн өсөлтөд сөрөг нөлөө үзүүлсэн.





Монгол банкны Мөнгөний бодлогын хороо мөнгөний бодлогын хүүг 2020 онд 6 хувьд барьж байсан бол 2022 оны эцэст инфляцыг нам түвшинд байлгах, хязгаарлах зорилгоор бодлогын хүүг нэмэгдүүлэн 13 хувьд хүргэснээр мөнгөний нийлүүлэлт буурч эхэлсэн. Энэ нь хадгаламжийн хүү нэмэгдэх суурь болж байгаа ба арилжааны банкнуудын хадгаламжийн дундаж хүү 12.3 хувьд хүрсэн нь мөнгөний нийлүүлэлт харилцах данснаас хадгаламж руу шилжих хүлээлтийг бий болгоод байна.

Долларын ханшийн нийлүүлэлтийн гаралтай өсөлт бий болоод байгаа нь 2020 оны 12 сараас хойших хамгийн өндөр үзүүлэлт юм. Долларын ханш цаашид өсөх хандлагатай байгаа тул он дуустал мөнгөний нийлүүлэлт дэх долларжилт нэмэгдэх хүлээлт үүсээд байна.

### M2 мөнгөний нийлүүлэлт, их наяд төгрөгөөр



Эх сурвалж: Монголбанк, YCX


### Ханш тогтворгүй байдал

Экспортын гарц буурсан нь валютын орох урсгалыг бууруулсан, нөгөө талаас тээвэрлэлтийн зардал нэмэгдсэн, дэлхийн зах зээл дээр газрын тосны үнэ өссөн учраас түлш, шатахууны импорт, тээврийн зардалтай холбоотойгоор валютын гарах урсгал нэмэгдэж байна. Эндээс валютын нийлүүлэлт буурч байгаа бөгөөд зах зээл дээр долларын ханш 3,496 төгрөгт хүрч өссөн. 2022 оны 12-р сард Чингис бондын үлдэгдэл болох 127 сая долларын эргэн төлөлтийг хийсэн ба ирэх 12 сард төлөгдөх бондуудын төлбөрийг дахин санхүүжилтээр шийдвэрлэсэн нь ам.долларын ханш ирэх онуудад тогтвортой байх суурь нөхцөлийг бүрдүүлээд байна.

### 2.2. Хөрөнгийн зах зээлийн нөхцөл байдал

2022 онд Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал хүндхэн байсан ч хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 16 хувиар өсөж 6.9 их наяд төгрөгт хүрлээ. Энэ хугацаанд Мон бийф ХК, Сэндли ББСБ, Төрийн банк ХК, Голомт банк ХК, Монголын Хөрөнгийн Бирж ХК-иуд олон нийтэд анх удаа хувьцаагаа санал болгож зах зээл дээрээс нийт 182 тэрбум төгрөгийг босгосон бол 2021, 2022 онуудад Инвекор ББСБ ХК, Омни актив ТЗК ХХК, Симпл ассет ТЗК ХХК, Бэрс Эй Би Эс актив ТЗК ХХК, Нөмөр Кредит Ассет ТЗК ХХК, Лэнд МН актив ТЗК ХХК, Бичил Эй Би Эс актив ТЗК ХХК зэрэг компаниуд хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргаж зах зээл дээрээс 93.85 тэрбум төгрөг босгосон байна.





Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжааны идэвхи

2022 онд Монголын хөрөнгийн бирж дээр нийт 603 сая ширхэг үнэт цаасны 580 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий арилжаа хийгдсэн бол тэр дундаа хувьцааны арилжааны үнийн дүн өмнөх оны мөн үеэс 12.6 хувиар өссөн байна. Харин 2021 онд Эрдэнэс Таван Толгой компанийн бондын арилжаа хийгдсэнтэй холбоотой 2022 онд өмнөх онтой харьцуулахад бага үзүүлэлттэй гарчээ.

Хөрөнгийн зах зээлийн голлох үзүүлэлтүүд

Макро эдийн засгийн орчны сорилтуудтай холбоотой Монголын хөрөнгийн биржийн ТОП 20 индекс 2022 онд 14.4 хувийн уналттай хаагдлаа. Хөрөнгийн биржийн толь болсон ТОП 20 индекс унахад төв банкнаас инфляцын түвшинг бууруулахад чиглэсэн мөнгөний хатуу бодлого, гадаад валютын албан нөөц буурснаас иргэдийн төгрөгт итгэх итгэл алдарсан, Монгол Улсын засгийн газрын бондын өгөөж түүхэн үзүүлэлтүүдээс өссөн зэрэг хүчин зүйлс голлон нөлөөллөө.



Тэмдэглэл: ТОП 20 индексийн үнэ ашиг, үнэ дансны үнэ, үнэ орлогын харьцааг зохистой гаргах үүднээс хэт өндөр хазайлттай гарсан Ард санхүүгийн нэгдэл, Улсын их дэлгүүр зэрэг компаниудын үзүүлэлтийг хасаж тооцлоо

Үнэлгээний харьцаа үзүүлэлтүүдээс харвал Монголын хөрөнгийн биржийн ТОП 20 индексийн үнэ ашгийн харьцаа 2022 оны байдлаар 14 буюу 2019, 2020, 2021 оны

УЛААНБААТАР ХОТ

БЭРС ЭЙ БИ ЭС ПЛАГ ТЭК

АТ 2020 100886

Бүртгэлийн үндэслэл

Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ

үзүүлэлтүүдээс багаар үнэлэгдэж байна. Харин үнэ дансны үнийн харьцааны хувьд бодитоор үнэлэгдэж байх боломжтой.

### ТОП-20 индексийн үзүүлэлтүүд




Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

### 2.3. ХБҮЦ-ны тухай, давуу болон сул талууд

#### Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны зураглал


Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас нь Монгол улсын "Хөрөнгөөр Баталгаажсан Үнэт Цаасны тухай" хуульд зааснаар санхүүгийн мөнгөн урсгал бий болгох хөрөнгөөр баталгааждаг ба хөрөнгө оруулагч нь уг хөрөнгийн орлогоос тэргүүн ээлжид төлбөрөө гаргуулах эрхийг баталгаажуулсан үнэт цаас юм. Тухайлбал, олон улсад хамгийн түгээмэл танигдсан бүтээгдэхүүн бол АНУ-ын моргейжийн гэрээг багцалсан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас юм. Энгийнээр тайлбарлавал тухайн компанийн ирээдүйд орж ирэх гэрээгээр баталгаажсан мөнгөн урсгалыг багцлан, бүтээгдэхүүн болгож ирээдүйн төлбөрийг тухайн гэрээгээр баталгаажсан мөнгөн урсгалаар төлөх үйл явц юм.

#### Схем 1. ХБҮЦ-ны зураглал





"Бэрс Эй Би Эс Плас ТЗК" ХХК



**Анхны үүрэг гүйцэтгүүлэгч** – Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т заасанчлан анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь өөрийн санхүүгийн тайлан, тэнцэлд туссан хөрөнгийг тусгай зориулалтын компанид шилжүүлсэн, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд байна.

**Тусгай Зориулалтын компани** – Тус хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т заасанчлан Тусгай Зориулалтын Компани нь Компанийн тухай хууль болон Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасан журмын дагуу байгуулагдсан, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тусгай зөвшөөрөл авсан хязгаарлагдмал хариуцлагатай компани байна.

**Хөрөнгө Итгэмжлэн удирдагч** – Тус хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-т заасанчлан Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь тусгай зориулалтын компанитай гэрээ байгуулсан, хөрөнгө оруулагчид барьцаалуулсан хөрөнгийг түүний эрх ашигт нийцүүлэн эзэмшиж, удирдах эрх үүрэг бүхий этгээд байна.

**Үйлчилгээ үзүүлэгч** – Тус хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-т заасанчлан Үйлчилгээ үзүүлэгч нь Үнэт цаас гаргагчтай байгуулсан Төлбөр цуглуулах, үйлчилгээ үзүүлэх гэрээний хүрээнд Хөрөнгөтэй холбоотой төлбөр цуглуулан ТЗК-д шилжүүлэх, бүртгэх, тайлагнах болон үйлчилгээ үзүүлэх гэрээнд заасан хөрөнгөтэй холбоотой бусад үйлчилгээ, үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд байна.

**Хуулийн фирм** – ТЗК-иас тогтоосон хууль зүйн шалгуур үзүүлэлтийн дагуу санамсаргүй түүврийн сонгосон хөрөнгийн багцад багтсан зээлийн дансдад дүн шинжилгээ хийж, хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргах ажиллагаанд хөндлөнгийн хууль зүйн үйлчилгээ үзүүлж, хууль зүйн дүгнэлт гаргах, үнэт цаас гаргагчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх эрх бүхий хуулийн этгээд;

**Аудитын байгууллага** – Үнэт цаас гаргагчийн зээлийн багцад болон санхүү аудитын дүгнэлт гаргах, ТЗК-тай холбоотой аудитын дүгнэлт гаргах этгээд.

**Зээлийн шинжилгээ гаргагч** – Хөрөнгийн багц дахь зээлүүд нь ТЗК-иас тогтоосон санхүүгийн шалгуур үзүүлэлтэд нийцэж буй эсэхэд санхүүгийн дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргах үнэт цаасны зах зээлд оролцогчид үйлчилгээ үзүүлэх эрх бүхий аудитын компани.

### **Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны онцлог**

#### **Тодорхой байдал**

Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас нь Зээлийн багцын ирээдүйн мөнгөн урсгалаар баталгаажсан байдаг. Цаашлаад зээлийн үндсэн хүү, төлөгдөх хугацаа, үе шатлал зэрэг нь хуваарийн дагуу явагддаг учир мөнгөн хөрөнгө эргэн төлөгдөх баталгаат урсгалтай.

#### **Найдвартай байдал**

Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн тайлан балансаас зээлийн багцыг хасаж ТЗК-д шилжүүлснээр тусдаа хяналтын бүтцэд оруулдаг.

#### **Эрсдэлийг бууруулна**



Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн тайлан балансаас зээлийн багцыг хасаж бүртгэсний хүрээнд компанийн аливаа эрсдэл, мөнгөн хөрөнгө тасалдал, дампуурал зэрэг нь хөрөнгөөр баталгаажсан зээлийн багцад нөлөө үзүүлэхгүй.

### Өндөр өгөөж

ХБҮЦ-ны өгөөжийн түвшин өндөр тогтох боломжтой байдаг ба эрсдэлээр жигнэсэн өгөөжийн хувьд харьцангуй өндөр.

### Менежмент

Зээлийн багцыг шаардах эрхийг Тусгай Зориулалтын Компанид шилжүүлэхээс гадна хөрөнгө итгэмжлэн удирдагч нь зээлийн багцад хяналт тавьснаар олон талт менежментийн системийг бий болгоно.

### Үнэт цаасжуулалт

Тусгай зориулалтын компани нь ирээдүйн орлогоо барьцаалан шинээр санхүүжилт татах боломжтой байдаг. ХБҮЦ гаргаж татан төвлөрүүлэх дүн нь зээлийн багцад суурилж тодорхойлогддог.

### Эрсдэл

Компанийн зээлийн багцыг салгаж дампуурах эрсдэлийг хязгаарлаж өгдөг хэдий ч багц зээл нь тасалдах эрсдэлтэй. Мөн харилцаанд орж буй талуудын уялдаа холбоог нарийн тодорхойлж өгөөгүйгээс үүдэн үүргийн гүйцэтгэл хангагдахгүй байх, ХБҮЦ-ны эргэн төлөлтийн үйл ажиллагаа тасалдах магадлалтай. Түүнчлэн ТЗК-ийн баталсан журмуудыг баримталж ажиллахгүй байх эрсдэл гарах магадлалтай.

Дотоодын Хөрөнгийн зах зээлд "Монголын Ипотекийн Корпораци ОССК" ХХК 2013 оноос эхлэн ХБҮЦ гаргах үйл ажиллагаа явуулж байна. Үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш 32 удаагийн хэлцлээр нийт 4.6 их наяд төгрөгийн орон сууцны ипотекийн зээлийн арилжаалсан байна.

2021 онд "Инвескор ББСБ" ХК, 2022 онд "Омни Актив ББСБ" ХХК, Симпл ассет ТЗК ХХК, Бэрс Эй Би Эс актив ТЗК ХХК, Нөмөр Кредит Ассет ТЗК ХХК, Лэнд МН актив ТЗК ХХК, Бичил Эй Би Эс актив ТЗК ХХК, нь ХБҮЦ гарган амжилттай арилжаалсан байна.

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас нь дараах хоёр төрлөөс бүрдэнэ. 1) Баталгаат үнэт цаас, 2) Барьцаат үнэт цаас.

1) Баталгаат үнэт цаас		2) Барьцаат үнэт цаас
Үнэт цаас гаргагч	Тусгай зориулалтын компани	Орон сууцны санхүүжилтийн компани, Банк

### 1) Баталгаат үнэт цаас нь

Хөрөнгийг анхны үүрэг гүйцэтгүүлэгч, үнэт цаас гаргагчийг үүсгэн байгуулагч, худалдагчийн санхүүгийн тайлан, тэнцлээс хасаж, хөрөнгөтэй холбоотой шаардах эрх болон олох орлогыг тусгай зориулалтын компанийн санхүүгийн тайлан, тэнцэлд шилжүүлэн анхны үүрэг гүйцэтгүүлэгч, үүсгэн байгуулагч, худалдагчийг хөрөнгөтэй холбоотой үүргээс бүрэн чөлөөлснийг гэрчилсэн үнэт цаас байна.





2) Барьцаат үнэт цаас нь

Үнэт цаас гаргагчийн санхүүгийн тайлан, тэнцэлд тусгаарлан бүртгэгдсэн, орон сууцны зээлийн болон хуулиар зөвшөөрсөн бусад үл хөдлөх эд хөрөнгийн барьцаатай холбоотой шаардах эрхээр баталгаажсан, үнэт цаасны танилцуулгад заасан хугацаанд үндсэн төлбөр, түүний хүүг хөрөнгө оруулагчид төлөх үүргийг гэрчилсэн үнэт цаас байна.

Схем 2. ХБҮЦ хөгжил



Үнэт цаас худалдан авагчид үүсэх давуу тал

Давуу тал	Сул тал
<ul style="list-style-type: none"> <li>Аюулгүй байдал/ Компанийн эрсдэлийг хааж өгсөн/</li> <li>Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн үйл ажиллагаа тасалдах, дампуурсан тохиолдолд ч ХБҮЦ хэвийн төлөгдөнө.</li> <li>Худалдан авагчдын мөнгөн урсгал орж ирэх хугацаа, төлбөр төлөх дараалал тодорхой</li> <li>Гэрээлэгдсэн учир эргэн төлөлтийн мөнгөн урсгал орж ирэх эх үүсвэр тодорхой.</li> <li>Биржээр дамжуулж хугацааны өмнө борлуулах боломжтой өндөр</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Эргэн дуудах нөхцөл</li> <li>Зээлийн багцын төлөлт хугацаанаас өмнө орж ирсэн тохиолдолд ХБҮЦ-ыг эргэн дуудах нөхцөлтэй гаргадаг. Ингэснээр худалдан авсан хөрөнгө оруулагчид хугацаанаас өмнө эргэн төлөлтөө авах магадлалтай. "Бэрс Эй Би Эс Плас ТЗК" ХХК-ийн гаргаж буй ХБҮЦ-ны хувьд ХБҮЦ-ны тухай хуульд зааснаас бусад тохиолдолд эргэн дуудаж төлөлт хийх нөхцөлгүй тул энэхүү эрсдэлийг хаасан байна.</li> <li>Бүтцийн эрсдэл</li> <li>ХБҮЦ-тай холбоотой оролцогч талуудын уялдаа холбоог журам бүтцээр зохицуулаагүй тохиолдолд үүргийн гүйцэтгэл хангагдахгүй мөнгөн урсгалд эрсдэл үүсэх</li> </ul>







БЭРС  
-2 ХБҮЦ

ГУРАВ. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН  
ТУХАЙ

3 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ

3.1 Үнэт цаас гаргагчийн ерөнхий мэдээлэл

Үнэт цаас гаргагч "Бэрс Эй Би Эс Плас" ХХК нь анх 2022 оны 11 сарын 10-ны өдөр төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа гэх үйл ажиллагааны чиглэлээр үүсгэн байгуулагдаж, СЗХ-ны 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 28 тоот тогтоолоор хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авч, 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн улсын бүртгэлд бүртгүүлж ТЗК болсон.

Үнэт цаас гаргагч	Бэрс Эй Би Эс Плас ТЗК ХХК
Улсын бүртгэлд бүртгүүлсэн огноо	2022 оны 11 сарын 10
Регистрийн дугаар	6949886
Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ	1,000,000 (нэг сая) төгрөг
Гаргасан болон зарласан хувьцааны тоо	Нэг бүр нь 1,000 төгрөгийн үнэ бүхий 1,000 хувьцаа
Улсын бүртгэлийн дугаар	9011845634
Үйл ажиллагааны үндсэн чиглэл	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах
Хаяг	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 11-р хороо, 7-р хороолол, Ногоон нуур, 101 барилга, 706 тоот
Утас	+976 9911 9632

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн улсын бүртгэлийн гэрчилгээ


3.2 Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагчийн товч мэдээлэл


Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу Тусгай зориулалтын компанийг банк, банк бус санхүүгийн байгууллага, орон сууцны санхүүжилтийн компани болон Хорооноос зөвшөөрсөн санхүүгийн бусад байгууллага байгуулж болно гэж заасны дагуу Үнэт цаас гаргагчийг хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдсан банк бус санхүүгийн байгууллага болох "Бэрс Финанс" ББСБ ХХК нь үүсгэн байгуулсан. "Бэрс Финанс" ББСБ ХХК нь 2017 оны 5 сарын 18-ны өдөр хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэгдсэнээс хойш үйл ажиллагаагаа явуулж байна.

Үүсгэн байгуулагч нь Үнэт цаас гаргагчийн энгийн хувьцаа эзэмшлийн 100 хувь болох нэг бүр нь 1,000 төгрөгийн 1,000 ширхэг нийт 1,000,000 төгрөгийн үнийн дүн бүхий энгийн хувьцааг эзэмшиж байна.


Хувьцаа эзэмшлийн бүтэц

№	Хувьцаа эзэмшигч	Тоо ширхэг	Нэгж үнэ /төгрөг/	Нийт /төгрөг/	Дүрмийн санд эзлэх хувь
1	Бэрс Финанс ББСБ ХХК	1,000	1,000	1,000,000	100%





"Бэрс Эй Би Эс Плас ТЗК" ХХК сар эдөр



### 3.3 Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн мэдээлэл

Үнэт цаас гаргагчийн дүрмийн 4.3-т "Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөө цагт компанийн эрх барих дээд байгууллагын бүрэн эрхийг Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл хэрэгжүүлнэ" гэж заасан.

Үнэт цаас гаргагчийн 2022 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн Хувьцаа эзэмшигчийн ээлжит бус хурлын 22/24а/02 тоот шийдвэрээр Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийг 3 гишүүнтэй байхаар шийдвэрлэсэн бөгөөд ТУЗ-ийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна.

СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журмын 3.3-т ТЗК-ийн ТУЗ-ийн гишүүн нь гурваас дээшгүй ТЗК-ийн ТУЗ-ийн гишүүний албан тушаалыг хавсран эрхэлж болно гэж заасны дагуу ТУЗ-ийн хараат бус гишүүн, ТУЗ-ийн дарга Б.Болор-Эрдэнэ нь "Бэрс Эй Би Эс Актив ТЗК" ХХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүнээр давхар ажиллаж байгаа болно.

### 3.4 Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн гишүүдийн мэдээлэл

#### ❖ ТУЗ-ийн дарга, хараат бус гишүүн Б.Болор-Эрдэнэ


Б.Болор-Эрдэнэ нь Монгол Улсын Их Сургуульд Олон Улсын эдийн засгийн харилцааны магистрын зэрэгтэй, 2021 оноос хойш Монгол Улсын Их Сургуульд Олон улсын эдийн засгийн харилцаа чиглэлээр докторантаар суралцаж байна. Тэрээр Голомт Банкны харилцагчийн үйлчилгээний хэлтсийн захирал, "НҮБ-ийн ХАС"-ийн ЗЗХ-ын гишүүн, Баянгол дүүргийн Иргэдийн хурлын төлөөлөгчөөр ажиллаж байсан туршлагатай ба одоогоор "Мета Майнд" ХХК-ийн гадаад харилцаа хариуцсан захирал, "Бэрс Эй Би Эс Актив ТЗК" ХХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүнээр тус тус ажиллаж байна.

#### ❖ ТУЗ-ийн хараат бус гишүүн Д.Ганхүрэл

Д.Ганхүрэл нь Монгол Улсын Их Сургуулийн Хууль Зүйн Сургуульд эрх зүйн бакалавр, Японы Чүо Их Сургуульд эрх зүйн чиглэлээр магистрын зэрэгтэй, 2021 оноос хойш Япон улсын Нагояа Их Сургуульд Эрх зүйн докторантаар суралцаж байна. Тэрээр Эм Би Эс хуулийн нөхөрлөлд өмгөөлөгчийн туслах, Япон улсын Накано Нозава хуулийн фирмд хуульчийн туслахаар ажилласан туршлагатай. Одоогоор Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуульд багш, "Корэкс" ХХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүнээр тус тус ажиллаж байна.

#### ❖ ТУЗ-ийн ердийн гишүүн С.Отгонбат

С.Отгонбат нь Алтай Коллежид Компьютерын техникийн инженерийн бакалаврын зэрэг, Монгол Улсын Их Сургуульд Олон Улсын эдийн засгийн харилцааны магистрын зэрэгтэй. Тэрээр Оргил Хотхон ХХК-д Гүйцэтгэх захирал, Номин Холдинг ХХК-д Ахлах менежерээр ажилласан туршлагатай. Одоогоор Бичил Глобус Финанс ББСБ ХХК-д Гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн гишүүн, Бэрс Финанс ББСБ ХХК-д Гүйцэтгэх захирал, "Бэрс Эй Би Эс Актив ТЗК" ХХК болон "Бичил Эй Би Эс Актив ТЗК" ХХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр тус тус ажиллаж байна.



### 3.5 Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн гишүүдийн эрх, үүрэг

ТУЗ-ийн гишүүний эрх, үүргийг Үнэт цаас гаргагчийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журам болон холбогдох хууль тогтоомжид зааснаар тодорхойлно. Тухайлбал, Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь дараах эрх, үүргийг хүлээж байна.

1. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны танилцуулгад тусгагдсан мэдээллийн үнэн зөвийг хариуцах;
2. Улиралд 1-ээс доошгүй удаа хуралдах;
3. Хувьцаа эзэмшигчийн хурлыг зарлан хуралдуулах, хурлаар хэлэлцэх асуудлыг батлах;
4. Үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагч, аудитор болон хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдийг томилох, солих;
5. Үнэт цаас гаргахтай холбоотой мэргэжлийн оролцогч, үйлчилгээ үзүүлж буй хуулийн этгээдтэй гэрээ байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих;
6. Хөрөнгийн багцыг сонгох шалгуур үзүүлэлтийг батлах;
7. Үнэт цаас гаргагчийн хөрөнгийн бүртгэлийг хянаж, хөрөнгө оруулагч, харилцагчдын эрх ашгийг хамгаалж ажиллах;
8. Үнэт цаасны танилцуулгын хүрээнд татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих;
9. Үнэт цаас гаргагчийн нэр дээр данс нээх, аудит, тайлан бүртгэлийг хянах, хөрөнгө оруулагчдад төлөх төлбөр болон бусад төлбөр, зардлын төсвийг батлах;
10. ТУЗ-ийн хараат бус гишүүн нь ТЗК-ийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, хөрөнгө оруулагчид хүргэх тогтоосон болон тухай бүр мэдээлэх мэдээллийн үнэн зөв, баталгаат байдалд хяналт тавьж ажиллах;
11. Хөрөнгийг бүртгэлээс хасах, нэмэх;
12. ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд тусгасан Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд хамаарах журам батлах, гэрээ байгуулах;
13. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь хөрөнгийн ашиглалт, нөөц хөрөнгийн талаар зөрчил гаргасан тохиолдолд шаардлагатай холбогдох арга хэмжээг авах үүнтэй холбоотой шийдвэр гаргах;
14. Хөрөнгө оруулагчдаас болон эрх бүхий зохицуулах төрийн байгууллагаас хүсэлт ирүүлсэн даруйд холбогдох мэдээллийг тэдгээрт цаг тухайд нь хүргэх.

ТЗК-ийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байх бөгөөд хурлын чөлөөт цагт ТУЗ нь үйл ажиллагааг удирдаж, хяналт тавьж ажиллана. Мөн ТУЗ-ийг төлөөлж аливаа бичиг баримтад ТУЗ-ийн дарга (Б.Болор-Эрдэнэ) төлөөлж гарын үсэг зурна хэмээн үнэт цаас гаргагчийн дүрэмд тусгасан байна.

### 3.6 Үнэт цаас гаргагчийн Санхүүгийн тайлан

Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагч, анхны үүрэг гүйцэтгүүлэгч болох Бэрс Финанс ББСБ ХХК нь 1,000,000 төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэйгөөр Бэрс Эй Би Эс Плас ТЗК ХХК-ийг үүсгэн байгуулсан бөгөөд эхлэлтийн тайлан баланс дараах байдалтай байна.





**Үнэт цаас гаргагчийн эхлэлтийн тайлан баланс**

Дансны нэр	Хөрөнгө	Эх үүсвэр
Мөнгөн хөрөнгө	1,000,000	
Хувь нийлүүлсэн хөрөнгө		1,000,000
<b>Нийт</b>	<b>1,000,000</b>	<b>1,000,000</b>

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн санхүүгийн тайлан, Үнэт цаас гаргагчийн дүрэм

**3.7 Үнэт цаас гаргагчийн Санхүүгийн төсөөлөл**

**Үнэт цаас гаргагчийн ХБҮЦ-ны хугацаан дахь санхүүгийн төсөөлөл, сая төгрөгөөр**

	У1	У2	У3	У4	У5	У6	У7	У8
ХБҮЦ үлдэгдэл	9,000	9,000	9,000	4,500	4,500	4,500	4,500	-
Багцын эхний үлдэгдэл	10,006	8,146	6,766	5,305	3,844	2,411	1,329	660
Багцын эцсийн үлдэгдэл	8,146	6,766	5,305	3,844	2,411	1,329	660	(79)
Орох урсгал	-	-	-	-	-	-	-	-
Үндсэн төлбөр	1,484	1,407	1,489	1,490	1,460	1,098	659	750
Илүү төлөлт	1,189	1,013	831	643	455	278	172	75
Хүүгийн төлөлт	927	819	674	523	373	229	140	71
Хадгаламжийн хүү	33	90	143	195	107	154	182	205
Гарах урсгал	-	-	-	-	-	-	-	-
Купоны төлбөр	432	432	432	432	216	216	216	216
ХБҮЦ Үндсэн төлбөр	-	-	-	4,500	-	-	-	4,500
Тогтмол зардлууд	-	-	-	-	-	-	-	-
ТУЗ цалин	3	3	3	3	3	3	3	3
ХИУ төлбөр	9	9	9	9	9	9	9	9
Үйлчилгээ үзүүлэгч	90	81	75	66	57	40	24	22
Аудитор	-	-	-	10	-	-	-	10
Захиргааны үйлчилгээ	5	5	5	5	5	5	5	5
Багц нэмэгдүүлсэн дүн	814	1,039	860	672	482	295	162	85
Эхний үлдэгдэл	1	2,282	4,042	5,796	2,950	4,574	5,766	6,500
Эцсийн үлдэгдэл	2,282	4,042	5,796	2,950	4,574	5,766	6,500	2,751

**3.8 Үнэт цаасыг хөрөнгө оруулагчдад олгохоос өмнө төлөгдөх төлбөр, зардлын мэдээлэл**


Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Үнэт цаас гаргагчийн ХБҮЦ-ыг хөрөнгө оруулагчдад олгохоос өмнөх дараах төлбөрүүдийг Үнэт цаас гаргагчийн өмнөөс хариуцаж төлөх бөгөөд Үнэт цаас гаргагчаас тус төлбөрүүдийг нэхэмжлэхгүй. Үүнд:

- Андеррайтерийн үйлчилгээний төлбөр,
- Зээлийн багц нь санхүүгийн шалгуур үзүүлэлт хангасан эсэх талаарх хөндлөнгийн аудитын тайлангийн үйлчилгээний төлбөр,





"Бэрс Эй Би Эс Плас ТЗК" ХХК



- Зээлийн багц нь хуулийн шалгуур үзүүлэлтэд нийцсэн эсэх талаарх хуулийн хөндлөнгийн дүн шинжилгээний тайлан гаргах үйлчилгээний төлбөр,
- Хэлцлийн зөвлөхийн үйлчилгээний төлбөр,
  - Маркетингийн зардал
  - СЭХ болон МХБ-д бүртгүүлэхтэй холбоотой төлбөр, хураамжууд,
  - ХБҮЦ гаргах болон арилжаалахтай холбоотой маркетингийн зардал

Үнэт цаас гаргагчийн ТУЗ-өөс батлах Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх журамд зааснаар ХБҮЦ-ны болон ТЗК-аас гарах бусад зардлыг дараах дарааллын дагуу төлнө. Үүнд:

- ТЗК-ийн татварын төлбөр;
- ХБҮЦ-ны хүүгийн орлогын татвар;
- Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн төлбөр, үүргийн гүйцэтгэлийн хангуулахтай холбоотой зардал;
- Үйлчилгээ үзүүлэгчийн шимтгэл, зардал;
- Аудитын зэрэг бусад мэргэжлийн оролцогчид, үйлчилгээ үзүүлсэн этгээдийн үйлчилгээний төлбөр;
- ТУЗ-ийн гишүүдийн цалин;
- ХБҮЦ-ны хүүгийн төлбөр;
- ХБҮЦ-ны үндсэн төлбөр;
- Журамд заасан бусад зардал.

### 3.9 Зөвшөөрөгдсөн дансдын мэдээлэл

Төлбөр цуглуулах данс:

ТЗК нь Төлбөр цуглуулах дансыг банканд тусгайлан нээлгэнэ. Төлбөр цуглуулах данс нь Үйлчилгээ үзүүлэгчийн нээсэн Зээлийн эргэн төлөлтийн дансанд цугларсан мөнгийг хүлээн авах, үнэт цаасны төлбөр төлөх зорилгоор ашиглах бөгөөд төлбөр хүлээн авах бэлэн байдлыг хангана. ТЗК болон Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь ТЗК-ийн нэрийн өмнөөс ТУЗ-өөс баталсан журам болон төсвийн дагуу төлбөр цуглуулах данснаас зардал гаргах эрхтэй байна.

Зээлийн эргэн төлөлтийн данс:

Үйлчилгээ үзүүлэгч нь Зээлийн эргэн төлөлтийг өөрийн харилцах данс буюу зээлийн эргэн төлөлтийн дансанд цуглуулах ба ТЗК-ийн хөрөнгийн багцад буй Зээлийн үндсэн болон хүүгийн төлөлтийг бусад хөрөнгөөс ангид бүртгэнэ. Зээлийн эргэн төлөлтийн дансыг зарцуулах эрхтэй этгээд нь үйлчилгээ үзүүлэгч байна.

Хадгаламжийн данс:

ТЗК-ийн мөнгөн хөрөнгийг ашиглагдахгүй хугацаанд үр ашигтай байлгах үүднээс тодорхой хэмжээг хадгаламжийн дансанд байршуулна. Тус хадгаламжийн данснаас зөвхөн ТЗК-ийн байгуулсан төлбөр цуглуулах данс руу зарлага гаргах боломжтой байна.


Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь шаардлагатай тохиолдолд хадгаламжийг цуцлан, мөнгөн үлдэгдлийг төлбөр цуглуулах данс руу татан шаардлагатай зарцуулалтыг хийх эрхтэй байна.







"Бэрс Эй Би Эс Плас ТЗК" ХХК



Унэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв дэх данс:

ТЗК-ийн мөнгөн хөрөнгийг ашиглагдахгүй хугацаанд үр ашигтай байлгах үүднээс тодорхой хэмжээг СЭХ-ноос хүлээн зөвшөөрсөн дараах хөрөнгө оруулалтыг тогрогөөр хийж болно. Үүнд:

1. Арилжааны банкны хадгаламжид байршуулах;
2. Монгол Улсын Засгийн газар, Монголбанкаас гаргасан үнэт цаасыг худалдан авах;
3. Зохицуулагч байгууллагаас хориглоогүй аливаа хэлбэрээр хөрөнгө оруулах.

Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь шаардлагатай тохиолдолд уг дансан дахь мөнгөн үлдэгдлийг төлбөр цуглуулах данс руу татан, шаардлагатай зарцуулалтыг хийх эрхтэй байна. Мөн тус үнэт цаасны данснаас зөвхөн ТЗК-ийн байгуулсан төлбөр цуглуулах данс руу зарлага гаргах боломжтой байна.

ТЗК-ийн үнэт цаасны хүүгийн болон үндсэн төлбөрийн төлөлтийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр дамжуулан төлбөрийн хуваарийн дагуу өөрийн брокерын үйл ажиллагаа эрхэлдэг компанид нээлгэсэн Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн дансанд шилжүүлнэ.

### **3.10 Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг буцаан худалдан авах нөхцөл**

Үнэт цаас гаргагч нь хөрөнгийн багцыг хуульд заасан дараах үндэслэлээр анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдах тохиолдолд ХБҮЦ-ыг буцаан худалдан авна. Үүнд:

- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 18.2.3-д заасны дагуу Хөрөнгийн багцад байгаа хөрөнгийн 20 ба түүнээс дээш хувь нь хугацаа хэтэрсэн хөрөнгөд тооцогдвол;
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.11.5-д заасны дагуу Хөрөнгийн багцын үлдэгдлийн дүн түүний анхны үнийн 20 хувьд хүрсэн тохиолдолд анхны үүрэг гүйцэтгүүлэгч, үүсгэн байгуулагч, худалдагчтай тохиролцсон;






БЭРС

-2 ХБҮЦ

ДӨРӨВ. АНХНЫ ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН ТУХАЙ



"Бэрс Эй Би Эс Плас ТБК" ХХК



#### 4 АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧ ББСБ-ЫН ТУХАЙ

##### 4.1 Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон үүсгэн байгуулагчийн үйл ажиллагааны тухай

Бэрс Финанс ББСБ ХХК нь 2017 оны 5 дугаар сарын 18-нд үүсгэн байгуулагдаж, СЗХ-ны 2017 оны 11-р сарын 20-ны өдрийн 495 тоот тогтоолын дагуу ТЗ 101/622 дугаар бүхий ББСБ үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авч, СЗХ-ны 2017 оны 07-р сарын 05-ны өдрийн 144 тоот тогтоолын дагуу зээлийн үйл ажиллагаа эрхлэх, 2018 оны 11-р сарын 14-ний өдрийн 344 тоот тогтоолын дагуу факторингийн үйлчилгээ үзүүлэх, 2020 оны 06-р сарын 10-ны өдрийн 350 дугаар тогтоолын дагуу итгэлцлийн үйлчилгээ үзүүлэх, СЗХ-ны 2022 оны 02-р сарын 23-ны өдрийн 76 дугаар тогтоолын дагуу төлбөрийн баталгаа гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа явуулж байна. Тус компани нь өдгөө 21 салбар, 80 гаруй ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

	<b>БЭРС ФИНАНС ББСБ ХХК</b>
	Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 11-р хороо, 7 хороолол, ногоон нуур, 101 барилга, 706 тоот
	9015005096
	6186858
	<a href="mailto:info@bersfinance.mn">info@bersfinance.mn</a>
	(976) 7712-2020
	<a href="http://www.bersfinance.mn">www.bersfinance.mn</a>

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Санхүүгийн Зохицуулах Хорооноос олгогдсон тусгай зөвшөөрлийн хүрээнд ББСБ-ын дараах үйл ажиллагааг эрхэлж байна:

##### Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн үйл ажиллагааны чиглэл

№	Үйл ажиллагааны чиглэл	усгай зөвшөөрөл олгосон огноо	Одоогоор тус чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг эсэх
1	Зээл	7/5/2017	Тийм
2	Факторинг	11/14/2018	Тийм
3	Итгэлцэл	6/10/2020	Тийм
4	Төлбөрийн баталгаа гаргах	2/23/2022	Тийм


##### Зээлийн үйл ажиллагаа

Бэрс Финанс ББСБ нь 17 аймаг, дүүрэгт салбар нэгжүүдээрээ дамжуулан иргэдийн бичил зээл олголтын үйл ажиллагааг үзүүлж байна. Нийт салбар, нэгжүүдийн зээлийн багцын үлдэгдлийг харахад Эрдэнэт, Хан-Уул, Өмнөговь, Эрдэнэт өргөө салбаруудын зээлийн багцын үлдэгдэл хамгийн өндөр байна.





"Бэрс Эй Би Эс Плас ТЗК" ХХК сар өдөр



Зураг 1. Бэрс Финанс ББСБ байршил



Эх сурвалж: Бэрс Финанс ББСБ компанийн мэдээлэл

Үнэт цаас гаргагч нь 21 салбартайгаар үйл ажиллагаа явуулж байгаагаас 2 нь Улаанбаатар хот, 19 нь орон нутагт харьяалагддаг. Нийт зээлийн үлдэгдэл 2022 оны эцсийн байдлаар 38 тэрбум төгрөг байна. Үнэт цаас гаргагч нь улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй бусад ББСБ нь нийт зээлийн үлдэгдлийн 1.4 хувийг бүрдүүлж байна.

**Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй ББСБ-уудын зээлийн үлдэгдэл, тэрбум төгрөгөөр**



Эх сурвалж: СЗХ, Бэрс Финанс ББСБ санхүүгийн тайлан


Бэрс Финанс ББСБ нь 2022 оны эцсийн байдлаар 6,993 зээлдэгчийн нийт 38 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. Энэ нь 2021 оны эцэстэй харьцуулахад 8.1 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлт юм.

**Зээлийн багцын төвлөрөл**

2022 оны эцсийн байдлаар Үнэт цаас гаргагчийн Топ-40 зээлдэгчийн хамгийн өндөр дүнтэй зээл нь 2.6 тэрбум төгрөгөөр хэмжигдэж байна. Топ-40 зээлдэгчид олгосон








"Бэрс Эй Би Эс Плас ТЗК" ХХК



нийт зээлийн үлдэгдэл нь нийт зээлийн багцын 20.5 хувийг л бүрдүүлж байна. Иймд Үнэт цаас гаргагчийн зээлийн төвлөрөл бага буюу зээлийн багцын эрсдэл багатай байна.

Үнэт цаас гаргагчийн зээлийн багцын төвлөрлийн үзүүлэлтүүд, мянган төгрөгөөр




Эх сурвалж: Бэрс Финанс ББСБ санхүүгийн тайлан

### Зээлийн багцын чанар

2021 оны байдлаар нийт зээлд эзлэх анхаарал хандуулах зээл 2 хувь, чанаргүй зээл 2.8 хувь байсан бол 2022 оны 4 дүгээр улирлын байдлаар цар тахлын нөлөөлөл буурсантай холбоотойгоор эдийн засагт сэргэлт үүсэж анхаарал хандуулах зээлийн нийт зээлд эзлэх дүн 1.0 хувь, чанаргүй зээл 1.2 хувь болж буурсан байна.

Үнэт цаас гаргагчийн чанаргүй зээлийн хувь




Эх сурвалж: Бэрс Финанс ББСБ санхүүгийн тайлан

### Зээлийн жигнэсэн дундаж хүү

Зээлийн жигнэсэн дундаж хүү 2020 оны 4 дүгээр улиралд 3.8 хувь байсан нь бодлогын хүү 6 хувьд хүрч буурснаар банкнуудын зээлийн хүү буурч, улмаар ББСБ-ын зээлийн хүү буурснаас шалтгаалсан юм. 2022 эцсийн байдлаар Бэрс Финанс ББСБ-ын зээлийн жигнэсэн дундаж хүү 3.1 хувь болж, өмнөх оны мөн үеэс 0.3 нэгж хувиар буурсан үзүүлэлттэй байна.



График 5. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн зээлийн жигнэсэн дундаж хүү, сараар



Эх сурвалж: Бэрс Финанс ББСБ санхүүгийн тайлан

#### 4.2 Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн хувьцаа эзэмшигч болон холбоотой этгээд


Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн 100%-ийн хувьцаа эзэмшигч буюу толгой компани нь Бэрс Капитал ХХК бөгөөд тус Компанийн 100 хувийн хувьцааг С.Отгонбат эзэмшдэг. Тус компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 50,000,000 төгрөг ба нэг бүр нь 500,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 100 ширхэг энгийн хувьцаанаас бүрдэж байна.

Зураг 2. Хувьцаа эзэмшигчдийн бүтэц





"Бэрс Эй Би Эс Плас" ТЗК ХХК



**Боловсрол:**

2003-2008 он Хүмүүнлэгийн Ухааны Их Сургууль – Англи хэлний орчуулагч

**Туршлага:**

2008 – 2009 он Хаан банк – Орлогч захирлын туслах  
2009 – 2010 он Хадгаламж банк – Гадаад харилцааны менежер  
2010 онд Капитал банк – Гадаад төлбөр тооцооны мэргэжилтэн  
2018 оноос одоог хүртэл Эко Кар Центр ХХК – Худалдааны зөвлөх

**ТУЗ-ийн гишүүн Самдан овогтой Дамдинбазар**

**Боловсрол:**

2012-2016 онд Сити дээд сургууль – Үйлдвэрлэлийн менежментийн бакалавр

**Туршлага:**

2003 – 2007 онд Улаанбаатар төмөр зам ХНН – Ахлах менежер  
2010 – 2012 онд Бичил Глобус ХХК – Эрсдэл хариуцсан захирал  
2012 – 2017 онд Бичил Глобус ХХК – Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга  
2017 оноос одоог хүртэл – Хувиараа бизнес эрхлэгч

**ТУЗ-ийн гишүүн Жадамба овогтой Мөнхсөмбө**

**Боловсрол:**

1999-2003 он Худалдаа Үйлдвэрлэлийн Дээд Сургууль – Бизнесийн удирдлагын бакалавр

**Туршлага:**

2003 – 2005 онд Худалдаа Үйлдвэрлэлийн Дээд Сургууль – Бизнесийн зөвлөх төвийн зөвлөх  
2009 – 2011 онд Бичил Глобус ХХК – Салбарын эрхлэгч  
2011 – 2016 онд Хос Шивээт ХХК – Гүйцэтгэх захирал  
2016 оноос одоог хүртэл – Хувиараа бизнес эрхлэгч

**ТУЗ-ийн хараат бус гишүүн Батсуурь овогтой Батсолонго**

**Боловсрол:**

2002-2007 он: ШУТИС Холбоо мэдээллийн технологийн сургууль – Мэдээллийн сүлжээний инженерийн бакалавр  
2007-2009 он: ШУТИС Холбоо мэдээллийн технологийн сургууль – Мэдээллийн сүлжээний инженерийн магистр  
2016 оноос одоог хүртэл: МУБИС – Боловсролын удирдлагын Докторант

**Туршлага:**

2006-2008 он: Улуснэт ХХК – Инженер  
2008-2009 он: Засгийн Газрын хэрэг эрхлэх газар – Шинжээч  
2009-2010 он: ГХБАБГазрын “Үндэсний газрын мэдээллийн систем”-ийн төсөл – Инженер  
2011-2012 он: ЗГХА Төмөр замын газар – Бүртгэлийн техникч  
2012-2013 он: МТШХХГазар – Мэргэжилтэн  
2013 оноос одоог хүртэл: МУБИС – Менежер, албаны дарга





**ТУЗ-ийн хараат бус гишүүн Дашдаваа овогтой Гантулга**

**Боловсрол:**

2008-2012 он: Дархан Дээд Сургууль – Аялал жуулчлал, гадаад хэлний удирдлагын ухааны бакалавр

**Туршлага:**

Гоэн девелопмент ХХК – Гүйцэтгэх захирал

#### 4.3 Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн бүтэц, зохион байгуулалт

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь нийт 6 газар, 80 гаруй ажилтантайгаар үйл ажиллагаа явуулдаг. Үнэт цаас гаргагчийн удирдлагын баг нь банк санхүүгийн салбарт 5-23 жил ажилласан туршлагатай, мэргэжлийн баг хамт олноос бүрддэг.

Бэрс Финанс ББСБ ХХК нь Хорооноос баталсан "Компанийн засаглалын кодекс"-ийг үйл ажиллагаандаа мөрдөж, кодексийн зарчмын дагуу хувьцаа эзэмшигчдийн хурал, түүнийг төлөөлөх Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ), гүйцэтгэх удирдлага, тэдгээрийн эрх үүргийг тодорхойлон олон улсын стандартын дагуу санхүүгийн тайлагналыг бэлтгэн, дотоод болон хөндлөнгийн аудитын хяналт шалгалт, дотоод хяналт, зохицуулагч байгууллагаас шаардах эрсдэлийн удирдлагын зохистой хэм хэмжээг мөрдлөг болгон ажиллахыг зорьж байна. (ТУЗ-ийн 2023 оны 1-р сарын 4-ний өдрийн 23/01а/01 тоот тогтоолоор холбогдох багц журмууд, бодлогын баримт бичгүүдийг баталсан.)


**Кодексийн 1-р зарчмыг** хэрэгжүүлэх хүрээнд "ТУЗ-ийн үйл ажиллагааны журам"-ыг баталсан ба тус журамд ТУЗ-ын бүрэн эрх, ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, тэдгээрт тавигдах шаардлага, хариуцлагыг нарийвчлан, ТУЗ-ын гишүүдийг сонгох, нэр дэвшүүлэх үйл ажиллагааг тус журмаар мөн зохицуулсан ба "Залгамж халааны бодлого"-ын баримт бичигт шаардлагатай зохицуулалтыг тусгасан.

**Кодексийн 2-р зарчим:** "ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагааны журам"-ын 2-р бүлэгт Аудитын хороо; 3-р бүлэгт нэр дэвшүүлэх хороо; 4-р бүлэгт цалин урамшууллын хороо; 5-р бүлэгт Эрсдэлийн удирдлагын хорооны бүтэц бүрэлдэхүүн, чиг үүрэг, гишүүдэд тавигдах шаардлага болон бусад зохицуулалтыг тус тус нарийвчлан тусгаж хороодын хурлыг зохион байгуулах зохицуулалтыг оруулсан.



**Кодексийн 3-р зарчим:** "Компанийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах журам"-д олон нийтэд хүргэх мэдээлэл, санхүүгийн болон санхүүгийн бус тайлан мэдээлэл, мэдээлэх арга хэрэгсэл болон бусад шаардлагатай зохицуулалтуудыг тусгаж, хэрэгжилтэд хяналт тавих зохицуулалтыг оруулсан.

**Кодексийн 4-р зарчим:** Аудит хяналтын тогтолцооны хараат бус үр дүнтэй байдлыг хангах хүрээнд "ТУЗ-ын дэргэдэх хороодын журам"-ын 2-р бүлэгт, "Дотоод хяналт аудитын журам", "Хөндлөнгийн аудитыг сонгох журам"-уудад холбогдох зохицуулалтыг тусгасан.

**Кодексийн 5-р зарчим:** Эрсдэлийн удирдлага, комплайнсын хяналтыг зохистой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, үр дүнд хяналт тавих хүрээнд "Эрсдэлийн удирдлагын бодлого, журам" болон ТУЗ-ын дэргэдэх эрсдэлийн хорооны үйл ажиллагаа, бүтэц бүрэлдэхүүнийг холбогдох журамд тусгасан. Шаардлагатай мэдээллийг үйл ажиллагааны тайланд тусгаж нийтэд мэдээлэхээр төлөвлөсөн.








**Кодексийн 6-р зарчим:** Эрх бүхий албан албан тушаалтны цалин урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод тогтох зарчмыг мөрдлөг болгох үүднээс ТУЗ-ын дэргэдэх хороодын журмын 4-р бүлэг, ТУЗ-ын үйл ажиллагааны журмын 8-р бүлэгт тус тус холбогдох заалтуудыг тусгасан.

**Кодексийн 7-р зарчим:** Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, хамтран ажиллах ажиллах байгууллагын соёлыг "Оролцогч талуудтай хамтран ажиллах журам"-д тодорхойлон тусгаж, үйл ажиллагааны тайланд хамтран ажилласан стратеги, журмын хэрэгжилтийг тайлагнах талаар холбогдох журамд тусгасан.

**Кодексийн 8-р зарчим:** Компанид бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоох зорилгоор хууль ёсны, ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах, аливаа зөрчлийг мэдээлэх тухай "Ёс зүйн дүрэм"; "Шүгэл үлээх журам"-д тусган оруулсан.

**Кодексийн 9-р зарчим:** Хувьцаа эзэмшигчийн эрх ашгийг хүндэтгэн тэгш хандах, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангах хүрээнд компанийн үйл ажиллагаа санхүү, засаглал, гүйцэтгэлийн үр дүнгийн талаар мэдээлэх, мэдээлэл солилцох цахим сувгийг хөгжүүлж, хувьцаа эзэмшигчдийн нийтлэг ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх үйл ажиллагааг "Ил тод байдлын журам"; "Хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргэх журам"; "Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журам"; "Сонирхлын зөрчлийн зохицуулах журам" зэрэг журмуудад холбогдох заалтуудыг тусган баталсан ба журмын хэрэгжүүлэн ажиллах үйл ажиллагааны төлөвлөгөө гаргасан.

Бэрс Финанс ББСБ ХХК-ийн бүтэц, зохион байгуулалт



**Гүйцэтгэх захирал С.Отгонбат**

- Боловсрол:**
- 2006-2010 он: Алтай коллеж – Компьютерын техникийн инженер, бакалавр
  - 2011-2013 он: Монгол Улсын Их Сургууль – Олон Улсын эдийн засгийн харилцаа, магистр
- Туршлага:**
- 2006-2007 он: Оргил Хотхон ХХК – Гүйцэтгэх захирал
  - 2008-2009 он: Номин Холдинг ХХК – Ахлах менежер
  - 2013 оноос одоог хүртэл: Бичил Глобус Финанс ББСБ ХХК-ийн Гүйцэтгэх захирал
  - 2017 оноос одоог хүртэл: Бэрс Финанс ББСБ ХХК-ийн үүсгэн байгуулагч, Гүйцэтгэх захирал



**Дэд захирал Б.Баярчимэг**

**Боловсрол:**

1999-2003 он СЭЗДС – Банк, санхүүгийн бакалавр  
2019-2021 он ХААИС – Бизнесийн удирдлагын магистр

**Туршлага:**

2003-2017 онд Төрийн банк – Хяналт шалгалтын газрын захирал  
2018-2019 онд Голомт Банк – Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын хэлтсийн захирал  
2019 оноос Бэрс Финанс ББСБ – Дэд захирал

**Дотоод хяналтын газрын захирал Г.Юмсүрэн**

**Боловсрол:**

2005-2010 он ХҮДС – Бизнесийн удирдлагын бакалавр  
2018-2020 он СЭЗИС – Бизнесийн удирдлагын магистр

**Туршлага:**

2011 онд Бичил Глобус ХХК – Менежер  
2011-2017 онд Бичил Глобус Групп ХХК – Ахлах менежер, Салбарын захирал, Хяналт эрсдэл хариуцсан захирал  
2017-2019 онд Бичил Глобус ХХК – Зээлийн хэлтсийн захирал  
2019 оноос Бэрс Финанс ББСБ ХХК – Дотоод хяналтын газрын захирал

**Зээлийн газрын захирал Н.Гантулга**

**Боловсрол:**

2001-2005 он ШУТИС – Математик загварчлал  
2011-2012 он Газарчин Их Сургууль – Бизнесийн удирдлагын магистр

**Туршлага:**

2013 –2014 онд Аварга Соёо ХХК – Оффис менежер  
2015-2017 онд Бичил Глобус Групп ХХК – Зээлийн менежер, Салбарын эрхлэгч  
2018 оноос Бэрс Финанс ББСБ ХХК – Салбарын эрхлэгч, Салбарын удирдлагын мэргэжилтэн, Зээлийн газрын захирал

**Санхүү эрхэлсэн захирал Я.Адьяахүү**

**Боловсрол:**

1987-1991 он МУИС-ЭЗС – Банкны эдийн засагч  
1997-1998 он Сайтама Их Сургууль – Төрийн удирдлагын магистр

**Туршлага:**

1992-1997 онд Зах зээл судлалын хүрээлэн – Судлаач  
1998-2009 онд Худалдаа Хөгжлийн Банк – Эдийн засагч, Эрсдэлийн шинжээч, ДХА, Газрын ахлах  
2009-2015 онд Хас Банк – Хэлтсийн захирал, Газрын захирал  
2015-2017 онд Глашиер Ассет ХОМК – Гүйцэтгэх захирал  
2018-2020 онд Нэткапитал ББСБ – Эрсдэлийн захирал, Дэд захирал  
2020 оноос Бэрс Финанс ББСБ – Санхүү бүртгэлийн газрын захирал

**Бизнес хөгжлийн газрын захирал Б.Даваабат**

**Боловсрол:**

2006-2008 он Соёлын коллеж – Компьютерын оператор  
2008-2011 он СУИС – Соёлын арга зүйч

**Туршлага:**

2011 –2012 онд Хийморь Принтинг ХХК – Ахлах дизайнер





2012-2016 онд Креатив Пролайн ХХК – Бренд менежер, Креатив директор  
 2016-2021 онд Бичил Глобус ХХК – Маркетингийн Менежер  
 2021 оноос Бэрс Финанс ББСБ ХХК – Маркетингийн хэлтсийн захирал, Бизнес хөгжлийн газрын захирал

**Мэдээллийн технологийн инженер О.Батжаргал**

**Боловсрол:**  
 1996-1999 он: ШУТИС – Программ хангамжийн инженер  
**Туршлага:**  
 1997-2000 он: Алтан Тариа ХХК - Программист  
 2002-2015 он: Оюуны Өмчийн Газар – Мэргэжилтэн  
 2016-2021 он: Төрийн Банк – Программ зохиогч  
 2021 оноос Бэрс Финанс ББСБ ХХК – Мэдээлэл технологийн инженер

**4.4 Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн хүний нөөц, программ хангамжийн тухай**

Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эрх бүхий албан тушаалтнууд болох Гүйцэтгэх захирал, Санхүү эрхэлсэн захирал, Дотоод хяналтын газрын захирал болон ТУЗ-ийн гишүүд нь 4.3 хэсэгт дурдсаны дагуу санхүүгийн салбарт хангалттай мэдлэг боловсролтой бөгөөд санхүүгийн салбарт нэг ба түүнээс дээш жил ажилласан туршлагатай байна.

Программ хангамжийн хувьд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь олон жилийн туршлагатай программ хангамжийн үйлчилгээ үзүүлэгч Грэйпсити Монгол ХХК-ийн хөгжүүлсэн нягтлан бодох бүртгэлийн "Поларис" үндсэн системийг санхүүгийн болон санхүүгийн бус бүх төрлийн гүйлгээ, бүртгэл хийх, холбогдох тайлангуудад хяналт тавих зэрэгт ашигладаг. Мөн Анхны үүрэг гүйцэтгэгчийн Үнэт цаас гаргагчид худалдах зээлийн багцын данс бүртгэлийг хөтлөх, гүйлгээ хийх, холбогдох тайлан бэлтгэж, хянах үйлдлүүдийг хийх боломжтой "Зээл худалдах систем" модулийг ашиглахаар төлөвлөж байгаа ба тус төслийн удирдагчаар Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн Санхүү эрхэлсэн захирал Я.Адьяахүү ажиллаж байна. Тус программ хангамжийн үйлчилгээ үзүүлэх гэрээний дагуу Грэйпсити Монгол ХХК нь системийн тасралтгүй, найдвартай, аюулгүй ажиллагааг хангаж ажиллах, системийн сайжруулалт, засвар үйлчилгээг үзүүлэх үүрэгтэй.


Иймд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь үнэт цаас гаргах үйл ажиллагаанд шаардлагатай хүний нөөц болон программ, техник хангамжийн нөхцөлөөр бүрэн хангагдсан болно. Дэлгэрэнгүй мэдээллийг хавсралтаас харна уу.

**4.5 Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн санхүүгийн байдал**

**Санхүүгийн байдлын тайлангийн шинжилгээ**

Санхүүгийн байдлын тайлан

(сая төгрөг)	2019 он	2020 он	2021 он	2022 он
Мөнгөн хөрөнгө	1,083.2	587.8	2,802.6	7,010.0
Богино хугацаат хөрөнгө оруулалт /цэврээр/	-	-	-	1,810.0
Зээл /цэвэр/	17,292.8	17,500.0	29,566.5	38,072.0
(Зээлийн эрсдэлийн сан)	109.6	495.5	361.6	-291.0
Бусад авлагууд	309.9	105.4	5.4	
Бусад хөрөнгө	409.6	1,024.0	9,297.7	6,423.0




<b>Эргэлтийн хөрөнгийн нийт дүн</b>	<b>19,095.4</b>	<b>19,217.2</b>	<b>41,672.2</b>	<b>53,024.0</b>
Үндсэн болон биет бус хөрөнгө	470.6	485.3	487.6	726.0
Биет бус хөрөнгө	-	-	-	-
<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>470.6</b>	<b>485.3</b>	<b>487.6</b>	<b>726.0</b>
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>19,566.0</b>	<b>19,702.5</b>	<b>42,159.8</b>	<b>53,750.0</b>
Банк, санхүүгийн байгууллагаас авсан богино хугацаат зээл	-	-	-	9,180.0
Өрийн бичгээрх өглөг	1,360.0	1,116.0	4,200.0	10,000.0
Санхүүгийн түрээсийн өр төлбөр	-	-	-	-
Итгэлцлийн үйлчилгээний өглөг	-	7.9	3,950.9	5,526.0
Орлогын албан татварын өр төлбөр	-	-	-	-
Бусад өр төлбөр	4,415.0	1,238.6	1,459.8	3,421.0
Банк, санхүүгийн байгууллагаас авсан урт хугацаат зээл	4,669.3	630.0	-	-
<b>Нийт өр төлбөрийн дүн</b>	<b>10,444.3</b>	<b>2,992.5</b>	<b>20,301.5</b>	<b>28,127.0</b>
<b>Эзэмшигчдийн өмч</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>
Хувьцаат капиталын дүн	3,000.0	6,090.0	6,090.0	6,090.0
Нэмж төлөгдсөн капитал	-	-	-	-
Эздийн өмчийн бусад хэсэг	-	-	-	-
Хуримтлагдсан ашиг /алдагдал/	6,121.7	10,620.0	15,768.0	19,533.0
<b>Эзэмшигчдийн өмчийн дүн</b>	<b>9,121.7</b>	<b>16,710.0</b>	<b>21,858.0</b>	<b>25,623.0</b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>19,566.0</b>	<b>19,702.5</b>	<b>42,159.5</b>	<b>53,750.0</b>

Эх сурвалж: Бэрс Финанс ББСБ санхүүгийн тайлан

2019-2022 онд Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн нийт хөрөнгө жилд дунджаар 40 хувиар өссөн байна. Үүнд нийт хөрөнгийн 71 хувийг бүрдүүлж буй цэвэр зээл жилд дунджаар 30.1 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.

#### Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн нийт хөрөнгө ба зээлийн багц, сая төгрөгөөр



Эх сурвалж: Бэрс Финанс ББСБ санхүүгийн тайлан

2022 оны 4 дүгээр улирлын байдлаар Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эх үүсвэрийн бүтцийн 52 хувийг өр төлбөр, 48 хувийг өөрийн хөрөнгө бүрдүүлж байна. Нийт өөрийн хөрөнгө 2019 онд 9.1 тэрбум төгрөг байсан бол 2022 онд 25.6 тэрбум төгрөгт хүрч жилд





дунджаар 41 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Банк, ББСБ-уудын хувьд өөрийн хөрөнгийн хэмжээ өндөр байх нь зээл гаргалтыг дэмжиж, улмаар орлого болон ашигт ажиллагаанд эергээр нөлөөлдөг. Бэрс Финанс ББСБ-ын хувьд 2022 оны байдлаар нийт өөрийн хөрөнгө 25.6 тэрбум төгрөг буюу нийт хөрөнгийн 48 хувийг бүрдүүлсэн, өр төлбөр өөрийн хөрөнгийн харьцааг 1.09 буюу хэвийн түвшинд байгаа зэрэг нь тус Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн өрийн дарамт харьцангуй бага, ашигт ажиллагаа нь цаашид өсөх боломжтойг илтгэж байна.

### Эх үүсвэрийн бүтэц, сая төгрөгөөр




### Орлогын тайлангийн шинжилгээ


#### Орлого, үр дүнгийн тайлан

(сая төгрөг)	2019 он	2020 он	2021 он	2022 он
Хүүгийн орлого	7,578.3	8,604.0	9,870.2	15,057.0
Хүүгийн зардал	2,543.8	1,087.5	933.1	4,261.0
<b>Цэвэр хүүгийн орлого</b>	<b>5,034.5</b>	<b>7,516.5</b>	<b>8,937.0</b>	<b>10,796.0</b>
<b>Хүүгийн бус орлого</b>	<b>53.8</b>	<b>83.6</b>	<b>67.6</b>	<b>349.0</b>
Арилжааны цэвэр орлого	-	-	-	-
Ханш болон үнэлгээний тэгшитгэлийн орлого	-	-	-	-
Санхүүгийн үйлчилгээний шимтгэл	53.8	83.6	67.6	206.0
Бусад орлого	-	-	-	143.0
<b>Хүүгийн бус зардал</b>	<b>2,000.0</b>	<b>2,213.9</b>	<b>3,130.9</b>	<b>5,076.0</b>
Арилжаа болон ханшийн тэгшитгэлийн зардал	-	-	-	-
Боловсон хүчний холбогдолтой зардал	1,540.0	1,658.9	2,268.8	3,629.0
Бусад зардал	460.0	555.0	862.1	1,446.0
Валютын ханшийн зөрүүний (гарз) олз	-	-	-	-
<b>ЦЭВЭР ХҮҮГИЙН БУС ОРЛОГО/ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>-1,946.2</b>	<b>-2,130.3</b>	<b>-3,063.4</b>	<b>-4,727.0</b>
<b>Сан байгуулахаас өмнөх ҮА ашиглах/алдагдал</b>	<b>3,088.2</b>	<b>5,386.2</b>	<b>5,873.7</b>	<b>6,069.0</b>
<b>Болзошгүй эрсдэлийн зардал</b>	<b>106.4</b>	<b>402.1</b>	<b>137.7</b>	<b>103.0</b>
Зээлийн эрсдэлийн зардал	106.4	402.1	137.7	103.0
Найдваргүй авлагын нөөцийн зардал	-	-	-	0.0
Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгийн эрсдэлийн зардал	-	-	-	0.0
<b>ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ/АЛДАГДАЛ</b>	<b>2,981.8</b>	<b>4,984.1</b>	<b>5,736.0</b>	<b>5,966.0</b>
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	4.5	-	3.9	-





"Бэрс-Эй Би Эс Плас ХХК"




Үндсэн бус үйл ажиллагааны зардал	14.4	10.0	18.3	4.0
<b>Ердийн үйл ажиллагааны ашиг/алдагдал/</b>	<b>2,972.0</b>	<b>4,974.1</b>	<b>5,721.6</b>	<b>5,962.0</b>
<b>Татварын өмнөх ашиг</b>	<b>2,972.0</b>	<b>4,974.1</b>	<b>5,721.6</b>	<b>5,962.0</b>
Орлогын татварын зардал	298.2	499.9	573.6	597.0
<b>Цэвэр ашиг</b>	<b>2,673.8</b>	<b>4,474.1</b>	<b>5,148.0</b>	<b>5,365.0</b>

Эх сурвалж: Бэрс Финанс ББСБ санхүүгийн тайлан

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч буюу "Бэрс Финанс ББСБ" ХХК-ийн орлого 2019-2022 онд жилд дунджаар 26 хувиар өссөн байна. Харин тус хугацаанд цэвэр хүүгийн орлого жилд дунджаар 29 хувиар өсжээ. Энэ нь тайлант хугацаанд хүүгийн зардал өссөн буюу эх үүсвэрт өрийн санхүүжилтийг ашигладаг болсонтой холбоотой байна. 2022 онд хүүгийн зардал нь нийт хүүгийн орлогын 28.2 хувьтай тэнцэж байна.

**Хүүгийн орлого, зардал ба цэвэр хүүгийн орлого, сая төгрөгөөр**



Эх сурвалж: Бэрс Финанс ББСБ санхүүгийн тайлан

ББСБ-уудын хувьд хүү төлөх чадвар, төлбөрийн чадварыг илэрхийлдэг гол үзүүлэлтийн нэг нь эрсдэлийн сангийн өмнөх ашиг юм. 2022 онд Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эрсдэлийн сангийн өмнөх ашиг 5.96 тэрбум төгрөг байна.

**Эрсдэлийн сангийн зардлын өмнөх орлого, сая төгрөгөөр**



Эх сурвалж: Бэрс Финанс ББСБ санхүүгийн тайлан



Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн цэвэр ашиг 2019-2022 онд жилд дунджаар 26 хувийн өсөлтийг үзүүлсэн байна. 2019-2022 онд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь 4.2 тэрбум төгрөгийн өрийн бичиг гаргаж, банк санхүүгийн байгууллагаас 10.1 тэрбум төгрөгийн зээл авсантай холбоотойгоор хүүгийн зардал өссөн. 2022 оны байдлаар Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн цэвэр ашиг 5.3 тэрбум төгрөгт хүрч цэвэр ахиуц ашиг 36 хувьд хүрч буурсан үзүүлэлттэй байна.

### Цэвэр ашиг , сая төгрөгөөр



Эх сурвалж: Бэрс Финанс ББСБ санхүүгийн тайлан

### Зохистой харьцаа үзүүлэлтийн шинжилгээ

ББСБ-ын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журмын дагуу ББСБ-ын үйл ажиллагааны эрсдэлийг урьдчилан тооцох, үнэлэх, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоож, түүний биелэлтийг хянадаг. ББСБ нь үйл ажиллагааныхаа эрсдэлийг үнэлэх, хянахын тулд Хорооноос тогтоосон зохистой харьцааны шалгуур болон холбогдох хууль тогтоомжийг дотооддоо мөрдөн ажилладаг.

2022 оны байдлаар Үнэт цаас гаргагчийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа 49.7 хувь байгаа нь хөрөнгийн хүрэлцээ сайн байгааг харуулж байна. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцааг СЗХ-ноос 8 хувиас дээш байх гэсэн шалгуурыг тавьдаг. 2022 оны байдлаар Бэрс Финанс ББСБ-ын тус харьцаа 24.9 хувь байгаа нь төлбөр түргэн гүйцэтгэх чадвар сайн байгааг илтгэж байна. Өрийн бичиг/өөрийн хөрөнгө, итгэлцэл/өөрийн хөрөнгө үзүүлэлтүүд нь уг хөрөнгийг үр ашигтай, зохистой удирдаж байгаа эсэхийг харуулдаг ба эрсдэлийг бууруулахад ач холбогдолтой. 2022 оны байдлаар Үнэт цаас гаргагчийн итгэлцлийн үйлчилгээний өглөг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа 21.6 хувь, өрийн бичгийн зохистой харьцаа 39 хувь байна. Энэ нь үнэт цаас гаргагч нь өрийн дарамт багатай бөгөөд төлбөрийн чадварын болон хөрвөх чадварын эрсдэл маш бага болохыг илтгэж байна.



	2019	2020	2021	2022	Шалгуур
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	48.8%	86.9%	54.8%	49.7%	10%<
Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	48.8%	86.9%	54.8%	49.7%	20%<
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа	46.6%	84.8%	51.8%	47.7%	10%<
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	18.8%	24.9%	13.8%	24.9%	8%<
Итгэлцлийн үйлчилгээний өглөг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	0.0%	0.0%	18.1%	21.6%	<80%
Өрийн бичгийн зохистой харьцаа	14.9%	6.7%	19.2%	39%	<50%
Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа	2.4%	2.5%	1.2%	1.3%	<15%

Эх сурвалж: Бэрс Финанс ББСБ санхүүгийн тайлан








БЭРС  
-2 ХБҮЦ

ТАВ. ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ



**БЭРС ФИНАНС**  
БАНК БЭРС САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ

### 5.1 Үнэт цаасжуулах хэлцлийн зураглал Схем: 5 Үнэт цаасжуулах процесс зураглал



УЛСЫН ХӨРӨНГИЙН БИРЖ  
УЛСЫН ХӨРӨНГӨНИЙ АЖИРААГАА  
STOCK EXCHANGE  
2023-04-06  
БҮРТГЭВ-02

"Бэрс Эй Би Эс Плас ТЭК" ХХК



УЛААНБААТАР АОТ  
БЭРС ФИНАНС  
АТАГАА 7 6949886  
99020-0028

БЭРС ФИНАНС  
БАНК БЭРС САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ  
УЛААНБААТАР АОТ  
2023.04.06

СЭХ  
БҮРТГЭВ  
№.01



### Тусгай зориулалтын компани үүсгэн байгуулах

ТЗК нь СЗХ-ноос зөвшөөрөл авсны үндсэн дээр, баталгаат үнэт цаас гаргах бүрд байгуулагддаг тусгай зориулалттай хуулийн этгээд юм. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.4-т заасны дагуу Бэрс Финанс ББСБ ХХК нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах зорилгоор хууль журмын дагуу Бэрс Эй Би Эс Плас ТЗК ХХК-ийг үүсгэн байгуулсан.

### Хууль, журмын хүрээнд шаардлага хангаж буй зээлийг багцлан бүрдүүлэх

Шинээр байгуулагдсан “Бэрс Эй Би Эс Плас ТЗК” ХХК-ийн ТУЗ-өөс үйл ажиллагаа, санхүү, хөрөнгийн удирдлага зэрэг үйл ажиллагаа явуулахтай холбоотой дотоод журмууд батлан гаргасан бөгөөд эдгээр журамд үндэслэн “Бэрс Финанс ББСБ” ХХК-аас шаардлага хангаж буй зээлийн багцыг тодорхойлно. 2023 оны 02 сарын 28-ны өдрөөр тасалбар болгосон зээлийн багцын үнийн дүн 10,005,596,403 /арван тэрбум таван сая таван зуун ерэн зургаан мянга дөрвөн зуун гурав / төгрөг байна.

### Зээлийн багцын хөндлөнгийн дүгнэлт

Тодорхойлогдсон зээлийн багцад үндэслэн Үнэт цаас гаргагчаас тогтоосон хуулийн болон санхүүгийн шалгуурыг хангаж буй эсэхэд хөндлөнгийн хуулийн дүгнэлтийг Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс ХХН, зээлийн шинжилгээг Онч Аудит ХХК боловсруулсан. Ингэхдээ ХБҮЦ-н тухай хууль, СЗХ, Монголын Хөрөнгийн Биржийн журмуудад тусгасан асуудлаар дүн шинжилгээ хийсэн.

### Шинээр байгуулагдсан ТЗК-д зээлийн багцыг шилжүүлэх

Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эзэмшилд буй зээлийн багцыг ТЗК-тай гэрээ байгуулсны үндсэн дээр шилжүүлнэ. Хөрөнгө итгэмжлэн удирдагч Юнайтед Айр Файнэнс ХХК нь ТЗК-тай байгуулсан гэрээний үндсэн дээр хөрөнгө оруулагчид барьцаалуулсан тус хөрөнгийг түүний эрх ашигт нийцүүлэн эзэмшиж удирдана. Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ үнэт цаасны хугацааны эцэст дуусгавар болно. 2023 оны 02 сарын 28-ны өдрөөр тасалбар болгосон шилжүүлэх зээлийн багцын үнийн дүн 10,005,596,403 /арван тэрбум таван сая таван зуун ерэн зургаан мянга дөрвөн зуун гурав / төгрөг байна.


### Эрх бүхий байгууллагуудад бүртгүүлэх

Андеррайтер нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Компанийн тухай хууль, СЗХ-ны “Хөрөнгөөр Баталгаажсан Үнэт Цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам”, МХБ-ийн “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам”-ын дагуу үнэт цаасны танилцуулга, хүсэлтийг боловсруулж, үнэт цаасыг бүртгүүлнэ. Үнэт цаас гаргагч нь ҮЦТХТ-өөр дамжуулж Үнэт цаасыг бүртгүүлж хадгалуулах, хүүгийн төлбөр тооцоо, эрхийг шилжүүлэх зэрэг үүргийг гүйцэтгүүлнэ.


### МХБ-ээр дамжуулан олон нийтэд анх удаа санал болгох

МХБ болон СЗХ-оос зөвшөөрөл авсны үндсэн дээр Андеррайтер нь эрх бүхий байгууллагуудаас гаргасан үнэт цаасыг танилцуулах хууль, дүрэм журмын хүрээнд





"Бэрс Эй Би Эс Плас ТЗК" ХХК



тогтоосон хугацаанд анхдагч зах зээлд олон нийтэд сурталчилж, санал болгон арилжаалж, захиалгыг хүлээн авна. Худалдан авах сонирхолтой хөрөнгө оруулагчид МХБ-ээр дамжуулж Үнэт цаас олон нийтэд санал болгох анхдагч зах зээлийн арилжааны хугацаанд өөрийн ҮЦТХТ-д бүртгэлтэй дансанд захиалгын мөнгийг шилжүүлж, арилжаанд оролцоно. Арилжаа амжилттай явагдсаны дараа Үнэт цаасыг хөрөнгө оруулагчдын дансанд байршуулна. Ингэснээр ХБҮЦ-ны үндсэн төлбөр болон хүүгийн төлбөрийг үнэт цаасны танилцуулгад заасан хугацаанд авах эрх үүснэ. Үнэт цаас гарган татан төвлөрүүлсэн хөрөнгийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид шилжүүлнэ.

### **Хөрөнгө Итгэмжлэн удирдах**

"Бэрс Эй Би Эс Плас ТЗК" ХХК-с гаргасан Хөрөнгө итгэмжлэн удирдах журам, Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний хүрээнд тогтоосон бүрэн эрхийн дагуу Юнайтед Айр Файнэнс ХХК-аар дамжуулж хөрөнгийг итгэмжлэн удирдуулна. Ингэхдээ ХБҮЦ-ны багцтай холбоотой хөрөнгийг бүртгэх, тайлагнах зэрэг үйлчилгээг Хөрөнгө итгэмжлэн удирдах журам, СЗХ, МХБ-н баталсан журамд заасан хугацаанд гүйцэтгэнэ.

### **Тусгай зориулалтын компанийг татан буулгах**

Тусгай зориулалтын компанийг дараах нөхцөлүүдэд татан буулгана. Үүнд:

1. Үнэт цаасны танилцуулга, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тухай шийдвэр, хууль тогтоомж болон холбогдох журамд заасан баталгаат үнэт цаасаар хүлээсэн үүргээ бүрэн гүйцэтгэсэн,
2. Баталгаат үнэт цаасны Хөрөнгийн багцыг анхны үүрэг гүйцэтгүүлэгч, үүсгэн байгуулагч, худалдагчтай тохиролцон багцыг буцаан худалдсан,
3. Баталгаат үнэт цаасны төлбөр төлөх болон үнэт цаасны танилцуулгад заасан үүргээ биелүүлээгүйн улмаас нийт үнэт цаасыг эзэмшиж байгаа хөрөнгө оруулагчдын гуравны хоёроос дээш хувь нь татан буулгахыг шаардсан Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан нөхцөлүүдийн дагуу.

Тусгай зориулалтын компанийг өөрчлөн байгуулах, дахин үүсгэн байгуулах үйл ажиллагаа хийгдэхгүй.

### **Татан буугдсан тусгай зориулалтын компанийн хөрөнгийг хуваарилах**

Татан буугдсан тусгай зориулалтын компанийн хөрөнгийг хуваарилахад дараах дарааллыг баримтална:

- Татан буулгах ажиллагааны зардал;
- Хөрөнгө оруулагчид олгох үнэт цаасны үндсэн болон хүүгийн төлбөр;
- Тусгай зориулалтын компаниас авлагатай анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс бусад бүх этгээдийн шаардлага;
- Авлагатай анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн шаардлага;
- Үлдсэн хөрөнгийг оруулсан хөрөнгийн хэмжээтэй нь хувь тэнцүүлэн хувь нийлүүлэгчдэд олгоно





### 5.2 Үнэт цаасны хүү тогтоосон үндэслэл

2023 оны 1 дүгээр сарын байдлаар арилжааны банкнуудын шинээр татсан жигнэсэн дундаж жилийн төгрөгийн хадгаламжийн хүү 12.3 хувь, инфляцын түвшин 13.2 хувь буюу хадгаламжийн бодит өгөөж -0.9 хувьтай байна.

Үнэт цаас гаргагчийн санал болгож буй Бэрс-2 Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас нь 19.2 хувийн түвшинд буюу бодит өгөөж 6 хувьтай байгаа нь төгрөгийн хадгаламжийн жигнэсэн дундаж хүүтэй харьцуулахад нэрлэсэн хүүгийн түвшинд 1.56 дахин өндөр өгөөжтэй байна.

2023 оны 1 дүгээр сарын системийн топ-5 банкны 12 сарын хугацаатай төгрөгийн хадгаламжийн дундаж хүү 12.3 хувьтай байна. Харин Капитрон Банк нь 12 сарын хугацаатай нөхцөлт төгрөгийн хадгаламж 13.2 хувийн хүүтэй буюу системийн топ банкнууд дотроос хамгийн өндөр хүүг санал болгож байна. Үнэт цаас гаргагчийн санал болгож буй Бэрс-2 Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны өгөөж банкны хадгаламжийн хүүгээс 1.46 дахин өндөр байна.

#### Банкнуудын хугацаатай хадгаламжийн хүү (1 жил)



Эх сурвалж: Банкнуудын цахим хуудас

### 5.3 Үнэт цаасны төлбөрийн хуваарь

Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны төлбөрийн үндсэн төлбөр болон хүүний төлбөрийг 10,005,596,403 төгрөгийн дүн бүхий зээлийн багцын эргэн төлөлтийн мөнгөн урсгалаар төлнө. Тус багц нь одоогоор зээлүүдийн гэрээгээр хүлээсэн үүргийг харуулах боловч хугацааны дундуур зээл урьдчилан төлөгдөх, хугацаа дууссан тохиолдолд анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс шалгуур хангахгүй болсон зээлүүдийг хасаж шалгуур хангасан зээлээр солих, худалдан авах зэргээр мөнгөн урсгалын тооцоололд өөрчлөлт орох боломжтой. Хэрэв зээлийн багцын мөнгөн урсгалаас тухайн улиралд төлөх боломжгүй болсон тохиолдолд Үүссэн төлөлтийн мөнгөн урсгалын эрсдэлийн сангийн эх үүсвэрээр төлбөрийг төлж барагдуулна.

Хөрөнгө оруулагч нь жилийн 19.2 хувийн хүүг ХБҮЦ-ны үлдэгдэл дүнд тооцож авах бөгөөд 9,000 мянган төгрөгийн ХБҮЦ худалдан авсан хөрөнгө оруулагчийн төлбөрийн задаргааг доор хүснэгтээр харууллаа:



	У1	У2	У3	У4	У5	У6	У7	У8
ХБҮЦ	9,000	9,000	9,000	9,000	4,500	4,500	4,500	4,500
Төлөгдөх үндсэн дүн	-	-	-	4,500	-	-	-	4,500
<b>ХБҮЦ үлдэгдэл</b>	<b>9,000</b>	<b>9,000</b>	<b>9,000</b>	<b>4,500</b>	<b>4,500</b>	<b>4,500</b>	<b>4,500</b>	<b>-</b>
Хүү	431	436	436	431	215	218	218	213
Татварын дараах	409	414	414	409	205	207	207	202
<b>Төлөгдөх нийт дүн</b>	<b>409</b>	<b>414</b>	<b>414</b>	<b>4,909</b>	<b>205</b>	<b>207</b>	<b>207</b>	<b>4,702</b>



Эх сурвалж: Андеррайтерийн тооцоолол

**5.4 Баталгаат үнэт цаасны төлбөр хугацаандаа төлөгдөхгүй нөхцөлд авах арга хэмжээ**

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь багцын хөрөнгийг солих, багцын хөрөнгийг нэмэгдүүлэх, анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдах зэргээр багцын хөрөнгөд өөрчлөлт оруулах боломжгүй тохиолдолд барьцаа хөрөнгөөр үүргийн гүйцэтгэл хангуулан ХБҮЦ-ны үндсэн болон хүүгийн төлбөр төлөх үүргийг хэрэгжүүлэх бөгөөд Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь үүргийн гүйцэтгэлийг хангуулахтай холбоотой Үйлчилгээ үзүүлэгчид шүүхэд нэхэмжлэл гаргахыг мэдэгдэж, хэрэгжилтэд хяналт тавина.

Хэрэв Үнэт цаас гаргагч нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны төлбөрийг төлөх чадваргүй болсон тохиолдолд барьцааны зүйлээр үүргийн гүйцэтгэл хангуулах бөгөөд дараах алхмуудыг хэрэгжүүлнэ:

1. Барьцаалуулагч нь Зээлдэгчтэй байгуулсан Зээлийн болон Фидуцийн гэрээний дагуу фидуцийн зүйлээс зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулах арга хэмжээ авах үүрэгтэй. Уг үүргийг ТЗК-тай байгуулсан Төлбөр цуглуулах, үйлчилгээ үзүүлэх гэрээний хүрээнд Үйлчилгээ үзүүлэгч хэрэгжүүлнэ.
2. Хөрөнгө худалдах худалдан авах гэрээний 10-д заасан (Анхны үүрэг гүйцэтгүүлэгч буюу энэхүү гэрээний Барьцаалуулагч үүргээ гүйцэтгэхгүй байх) зөрчлийн улмаас ББСБ нь зээлийн төлбөрийг цуглуулж ТЗК-д шилжүүлэх үүргээ биелүүлж чадахгүй нөхцөл байдал үүссэн үед Барьцааны зүйлээр үүргийн гүйцэтгэлийг хангуулах эрх ТЗК-д үүснэ.
3. Барьцааны зүйлээр үүргийн гүйцэтгэлийг хангуулах эрх ТЗК-д шилжсэнээр тэрээр барьцааны зүйлийг өөрийн өмчлөлд үл маргах журмаар шилжүүлэн авч болно. Энэ тохиолдолд барьцааны зүйлээр үүргийн гүйцэтгэлийг хангуулах арга хэмжээг ТЗК-ийн нэрийн өмнөөс Хөрөнгө итгэмжлэн удирдагч хэрэгжүүлнэ. Барьцаалуулагч



төлбөрийн чадваргүй болж, мэдэгдлийг хүлээн авах боломжгүй болсон нь түүнийг барьцааны үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

Үнэт цаас гаргагч нь Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны үндсэн болон хүүгийн төлбөрийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй байгуулсан "Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ"-ний дагуу худалдан авах, 2023 оны 2 дугаар сарын 28-ны өдрөөр тасалбар болгосон нийт 10,005,596,403 төгрөгийн автомашины фидуци бүхий зээлийн багцаас орох мөнгөн хөрөнгөөр төлөх бөгөөд уг үнэт цаасыг гаргахтай холбоотойгоор гуравдагч этгээдээс баталгаа, батлан даалт гаргуулаагүй, мөн Бэрс-2 ХБҮЦ-ны тухайд эрх бүхий байгууллагаар санхүүжих чадавхын зэрэглэл тогтоолгоогүй болно.

### 5.5 Хөрөнгийн багц, түүнд тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлтүүд

"БЭРС ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК" ХХК-ийн зээлийн хөрөнгөд тавигдах санхүүгийн шалгуур үзүүлэлтүүд:

1.	Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэх хөрөнгийн мэдээлэл нь зээлийн хувийн хэрэг дэх үндсэн баримттай нийцэж байх;
2.	Зээл нь Монгол төгрөгөөр олгогдсон бөгөөд Монгол төгрөгөөр эргэн төлөгдөх зээл байх;
3.	Зээлийн эргэн төлөлтийн хуваарьт зээлдэгчийн сар бүрийн төлөх дүнг (төлж дуусгах хугацаа) тусгасан байх, зээлийн хугацааны эцэст бүрэн төлөгдөж дуусахаар байх;
4.	Фидуцийн гэрээний зүйл нь даатгалд даатгагдсан байх, даатгал нь хүчин төгөлдөр байх(тээврийн хэрэгслийн хувьд жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд даатгагдсан байх, хүчин төгөлдөр байх), харгалзан үзэх;
5.	Тасалбар болгосон өдрийн байдлаар зээл нь хэвийн төлөлттэй байх;
6.	Зээлийг холбогдох журмын дагуу үүсгэсэн байх бөгөөд зээлийн стандарт нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн дотооддоо хэрэгжүүлдэг ерөнхий стандартаас дутуугүй шалгуур хангасан байх:
6.1.	Тасалбар болгосон өдрийн байдлаар зээлдэгчийн өр орлогын харьцаа (ӨОХ) нь татварын өмнөх орлогын 55%-с илүүгүй байх; $ӨОХ = \text{зээлийн сарын төлбөр} / (\text{Өрхийн сарын орлого (татвараас өмнөх)})$
6.2.	Тасалбар болгосон өдрөөрх зээл үнэлгээний харьцаа (ЗҮХ) 75%-с хэтрэхгүй байх. $ЗҮХ = (\text{Тасалбар болгох өдрийн байдлаарх үндсэн зээлийн өрийн үлдэгдэл}) / (\text{Үндсэн барьцаа хөрөнгийн үнэлгээ} + \text{Нэмэлт барьцаа хөрөнгийн үнэлгээ})$
6.3.	Фидуцийн зүйлийн ашиглах/ашигласан хугацааны талаар анхны үүрэг гүйцэтгүүлэгч/үнэт цаас гаргагчийн тогтоосон шалгуур хангасан байх;
6.4.	Үндсэн болон хамтран зээлдэгчид нь 12 сараас багагүй хугацаанд тус тус хөдөлмөрийн гэрээний дагуу ажиллаж байгаа, эсхүл төрийн алба хааж байгаа, хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа бөгөөд сүүлийн дараалсан 6 сарын баталгаажсан орлогоо Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн зөвшөөрөхүйц хэлбэрээр гарган өгсөн байх;

"БЭРС ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК" ХХК-ийн зээлийн хөрөнгөд тавигдах хуулийн шалгуур үзүүлэлтүүд:





1.	Зээлийн хөрөнгө нь хууль зүйн хувьд анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн бүрэн өмчлөлд байх бөгөөд анхны зээлдүүлэгчээс бусад этгээдийн хувьд аливаа байдлаар үүргээс ангид байх,
2.	Зээлийн гэрээ нь зээлдэгч (Үүрэг гүйцэтгэгч)-ийн хувьд хуульд нийцсэн, хүчин төгөлдөр, заавал биелэгдэх үүрэг үүсгэх бөгөөд шаардлагатай тохиолдолд уг зээлийг барьцаа хөрөнгөөс гаргуулан төлүүлэх боломжтой байх;
3.	Зээлтэй холбоотойгоор анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон зээлдэгчийн хооронд байгуулсан фидуцийн гэрээ нь зээлдэгч (Үүрэг гүйцэтгэгч)-ийн хувьд хуульд нийцсэн, хүчин төгөлдөр, заавал биелэгдэх үүрэг үүсгэсэн зээлдэгч үүргээ биелүүлээгүй тохиолдолд анхны үүрэг гүйцэтгүүлэгч өмчлөгчийн эрхээ хэрэгжүүлж, худалдан борлуулж зээл, үүнтэй холбоотой бүх төлбөрийг гаргуулах боломжтой байх;
4.	Зээл нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн хувьд хууль, гэрээ эсхүл бусад байдлаар аливаа үүргээс ангид, фидуцийн гэрээний зүйлийн хамтаар гуравдагч этгээдэд шилжихэд хориглогдоогүй эсхүл хязгаарлагдаагүй байх;
5.	Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид байгаа мэдээллээр, тасалбар болгох өдрийн байдлаар зээлийн гэрээ нь Үүрэг гүйцэтгэгчийн хувьд үүргээ хугацаанаас өмнө дуусгавар болгох/урьдчилан төлөх нөхцөл, хэлцлээс татгалзах, харилцан суутгал хийх замаар үүргийг дуусгавар болгох, сөрөг нэхэмжлэл гаргах, эсхүл үүргээс татгалзах (илт хохиролтой хэлцлийн улмаас үүргээс татгалзах нөхцөлийг хамааруулан) эрх үүсээгүй, эсхүл эрхээ хэрэгжүүлэх хүсэл зориг илэрхийлээгүй байх;
6.	Фидуцийн гэрээ хүчин төгөлдөр болгоход Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн ердийн практикт мөрддөг бүх дүрэм журмыг дагаж мөрдсөн, тухайн үүргийн гүйцэтгэлийг хангуулах аргыг нотолж буй бүх баримт бичиг нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эзэмшил, хадгалалт хамгаалалтад байх.

## 5.6 Хөрөнгийн багцын мэдээлэл

Үнэт цаас гаргагч нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс санал болгосон автомашины фидуци бүхий 2022 оны 11-р сарын 07-ны өдрөөр тасалбар болгосон нийт 2,160 зээлийн гэрээнээс бүрдсэн 13,082,498,702 (арван гурван тэрбум зуун наян хоёр сая дөрвөн зуун ерэн найман мянга долоон зуун хоёр) төгрөгийн үнийн дүн бүхий хөрөнгийн багцыг бүрдүүлсэн.

Бэрс-2 ХБҮЦ-ны хөрөнгийн багц дахь зээлүүд нь хуулийн шалгуур үзүүлэлтүүдийг хангасан эсэхэд "Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН дүн шинжилгээ хийсэн бөгөөд нийт 2,160 зээлийн гэрээнээс 31 зээлийг түүврийн аргаар сонгож дүн шинжилгээ хийхэд тус зээлүүд нь хуулийн шалгуур үзүүлэлтүүдийг хангасан байна. Харин зээлийн шинжилгээ гаргагч "Онч Аудит" ХХК нь 119 зээлийг түүвэрт сонгож дүн шинжилгээ хийсэн бөгөөд хөрөнгийн багц дахь зээлүүд нь санхүүгийн шалгуур үзүүлэлтүүдийг хангасан тухай тайлагнасан байна. Хөрөнгийн багц нь хуулийн болон санхүүгийн шалгуур үзүүлэлтүүдэд нийцсэн талаарх тайлангуудыг хавсралтаас харна уу.

Харин Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үед тус хөрөнгийн багц дахь зээлүүд төлөгдөж 2023 оны 2-р сарын 28-ны өдрөөр тасалбар болгосон 2,318 зээлийн гэрээнээс бүрдсэн






10,005,596,403 (арван тэрбум таван сая таван зуун ерэн зургаан мянга дөрвөн зуун гурав) төгрөгийн үнийн дүн бүхий багц болж өөрчлөгдсөн байна. Хөрөнгийн багцын жагсаалтыг хавсралтаас харна уу.

### Хөрөнгийн багцын үндсэн үзүүлэлт

Хөрөнгийн багцын үндсэн үзүүлэлт	
Зээлийн төрөл	Дүн /төгрөгөөр/
Нийт автомашины зээлийн үлдэгдэл	10,005,596,403
Зээлийн хөрөнгийн барьцааны дүн	39,498,262,949
Зээлийн гэрээний тоо	2,318
Зээлийн дундаж үлдэгдэл	4,316,478
Барьцааны дүн	39,498,262,949
Жигнэсэн дундаж хүү /сар/	3.44%
Жигнэсэн дундаж хугацаа /сар/	32
Жигнэсэн дундаж LTV%	49%
<b>Багцын зээлийн чанар</b>	<b>100% хэвийн зээл</b>

Хөрөнгийн багц бүрдүүлж буй зээл нь автомашины фидуци бүхий зээл бөгөөд зээлдүүлэгч нь автомашины өмчлөлийг шилжүүлэн авч, зээлдэгч зээлийн төлбөрийг төлөхгүй нөхцөлд тус автомашиныг худалдан борлуулах замаар зээлийн үүргийн гүйцэтгэл хангуулах нөхцөлтэй зээл юм. Автомашины зээл нь нийт Хөрөнгийн багцын 100 хувийг бүрдүүлж байна.

### Автомашины фидуци бүхий зээлийн задаргаа /үнийн дүнгээр/




Автомашины фидуци бүхий 2,318 зээлийн багцын үлдэгдлийг үнийн дүнгээр нь задалж харвал 2,044 зээл нь 10 сая төгрөг хүртэлх үлдэгдэлтэй байгаа бол үлдсэн 274 зээл нь 10-50 сая төгрөг хүртэлх үлдэгдэлтэй байна.

### Автомашины фидуци бүхий зээлийн багц анх олгосон хугацаагаар /сая төгрөг/

Анх олгосон хугацаа	Тоо	Үнийн дүн /сая төгрөг/	Багцад эзлэх хувь
0-12 сар	242	481	4.81%
12-24 сар	928	2,286	22.84%
24-36 сар	549	2,652	26.51%
36 сараас дээш	599	4,587	45.84%
<b>Нийт</b>	<b>2,318</b>	<b>10,006</b>	<b>100.00%</b>

Автомашинны зээлийн багцыг хугацаагаар ангилан харуулбал нийт автомашинны фидуци бүхий зээлийн багцын 4.81 хувийг 0-12 сарын хугацаатай зээлүүд, 22.84 хувийг 12-24 сарын хугацаатай зээлүүд, 26.51 хувийг 24-36 сарын хугацаатай зээлүүд, үлдсэн 45.84 хувийг 36-аас дээш сарын хугацаатай зээлүүд эзэлж байна. **Зээлийн багцын үлдэгдэл хугацаанд ногдох жигнэсэн дундаж хугацаа нь 32 сар байна.**

**Зээлийн багцын тархалт**



Нийт зээлийн багцын 57.87 хувийг 10 сая хүртэлх үнийн дүн бүхий зээлүүд, 42.13 хувийг 10-50 сая хүртэлх үнийн дүн бүхий зээлүүд бүрдүүлж байна. **Түүнчлэн нэг гэрээнд ногдох зээлийн дундаж үлдэгдэл 4.3 сая төгрөг байна.**

**Зээлийн төвлөрөл**

Нийт хөрөнгийн багцын 57.87 хувийг 0-10 сая төгрөгийн үнийн дүн бүхий 2,044 зээл, 42.13 хувийг 10-50 сая төгрөгийн үнийн дүн бүхий 274 зээл бүрдүүлж байна.

**Зээлийн төвлөрөл /үнийн дүнгээр/**

Зээлийн үлдэгдэл	Зээлийн тоо	Багцад эзлэх хувь	Зээлийн дүн /сая төгрөгөөр/
0-10 сая	2,044	57.87%	5,790
10-50 сая	274	42.13%	4,216
<b>Нийт</b>	<b>2,318</b>	<b>100.00%</b>	<b>10,006</b>

Хөрөнгийн багцын барьцаа хөрөнгө нь хөрөнгийн багцын үнийн дүнгээс 3.95 дахин өндөр буюу зээлийн багцын жигнэсэн дундаж LTV харьцаа 49 хувьтай тэнцэж байна.

**5.7 Хөрөнгийн багцад өөрчлөлт оруулах тухай**

Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний дагуу багцыг шилжүүлэн авсан зээлийн хөрөнгө нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 9 дүгээр зүйл болон зээлийн багцад тавигдах шалгуур үзүүлэлтийг хангахгүй болсон эсхүл Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2023 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 23/24а/05 тоот тогтоолоор баталсан "Хөрөнгө итгэмжлэн удирдах журам"-д заасан дараах үндэслэл бий болсон тохиолдолд хөрөнгийн багцад өөрчлөлт оруулна.


Хөрөнгийн багцад дараах байдлаар өөрчлөлт оруулна. Үүнд:

- Багцын хөрөнгийг солих;
- Багцын хөрөнгийг нэмэгдүүлэх;
- Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдах.





"Бэрс ЭЙ Би Эс Плас ТЗК" ХХК



Дор дурдсан үндэслэл бий болсон тохиолдолд тухайн хөрөнгийг шаардлага хангахгүй хөрөнгөд тооцож, солих замаар багцаас хасна. Үүнд:

- Зээлдэгчийн хүсэлтээр тухайн зээлийн гэрээнд өөрчлөлт оруулсан нь үнэт цаас эзэмшигчдэд төлөх үнэт цаасны төлбөрийн нөхцөлд нөлөөлөхүйц байна гэж Үнэт цаас гаргагчаас үзсэн;
- Хөрөнгийн багцын шалгуур үзүүлэлттэй холбоотойгоор анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн Хөрөнгө худалдах худалдан авах гэрээнд заасан аль нэг мэдэгдэл, баталгаа зөрчигдсөн.
- Зээлийн эргэн төлөлтийн хугацаа нь 90-ээс дээш хоног хэтэрсэн;
- Зээлийн эргэн төлөлтийн хугацаа нь 30 хоногоос дээш хэтэрсэн бөгөөд цаашид зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болох нь үндэслэл бүхий бол.

Дор дурдсан үндэслэл бий болсон тохиолдолд хөрөнгийн багцад хөрөнгийг нэмэгдүүлнэ. Үүнд:

- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 15.3.1-д заасны дагуу Баталгаат үнэт цаасны хөрөнгийн багцаас орох орлого нь үнэт цаасны төлбөрийн үүргийг гүйцэтгэж хүрэхгүй болсон;
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 15.3.2-д заасны дагуу Үнэт цаас гаргагч нь нээлттэй гаргах нөхцөлийн дагуу нэмэлт үнэт цаас гаргахаар болсон;
- Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь багцын өгөөжийг нэмэгдүүлэх, төлбөрийн тасалдал үүсэхээс урьдчилсан сэргийлэх зорилгоор үнэт цаас эзэмшигчдэд төлөх үнэт цаасны төлбөрөөс бусад сул мөнгөн дүнгээр багц худалдан авах боломжтой гэж үзсэн, зээлийн багц худалдан авах талаар анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй харилцан тохиролцсон.

Дор дурдсан үндэслэл бий болсон тохиолдолд Үнэт цаас гаргагч нь хөрөнгийн багцыг анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдана. Үүнд:

- Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь энэхүү журамд заасны дагуу шаардлага хангахгүй хөрөнгийг бүхэлд нь солих хөрөнгийн жагсаалтыг ТЗК-д гарган өгөх боломжгүй, эсхүл гарган өгсөн жагсаалт нь шаардлага хангахгүй тохиолдолд солих боломжгүй хөрөнгийн багцын хэмжээгээр;
- Хөрөнгийн багцад байгаа хөрөнгийн 20 ба түүнээс дээш хувь нь 90 хоногоос дээш хугацаа хэтэрсэн тохиолдолд;
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.11.5-д заасан нөхцөл байдал үүссэн бөгөөд талууд харилцан тохиролцсон тохиолдолд;

Хөрөнгийн багцыг нэмэгдүүлэхэд багцад ийнхүү нэмэгдсэн хөрөнгө нь баталгаат үнэт цаас гаргах өргөдөл, үнэт цаасны танилцуулгад тусгагдсантай адил онцлог, шинж чанартай байна.

ТЗК-ийн хөрөнгийн багц дахь хөрөнгөөс ХБҮЦ эзэмшигч этгээдээс өөр гуравдагч этгээд нэхэмжлэл гаргах эсхүл шаардах эрх хэрэгжүүлэхгүй.



Үнэт цаасжуулах ажиллагаанаас үүдэлтэй зээлийн хөрөнгийн багцын эргэн төлөлт хийгдэхгүй байх, үнэт цаасны төлбөр төлөгдөхгүй байх эрсдэл, зээлдэгч зээлийг урьдчилж төлснөөр орлого тасалдах эрсдэл бий болж болзошгүй байдаг. Иймд Үнэт цаас гаргагч нь тус эрсдэлийг бууруулах зорилгоор Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2023 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 23/24а/05 тоот тогтоолоор "Эрсдэл сонирхлын зөрчлийг илрүүлэх, үнэлэх, удирдах дотоод хяналтын журам"-ыг баталсан.

Тус журамд ТЗК-ийн ХБҮЦ гаргах, үнэт цаасны төлбөрийг хөрөнгө оруулагч, үнэт цаас эзэмшигчдэд төлөхтэй холбоотой үйл ажиллагааны эрсдэлийг удирдах, түүнтэй холбогдох дотоод хяналтыг хэрэгжүүлэх, эрсдэл бууруулах, сонирхлын зөрчлийг илрүүлэх арга хэмжээ авахтай холбоотой холбогдох хууль журмын хүрээнд зохицуулагч байгууллагууд болон оролцогч талуудтай харилцах харилцааг зохицуулсан байна. Үнэт цаасжуулах үйл ажиллагааны хүрээнд дараах эрсдэлүүд учирч болзошгүй гэж үзэж хэрхэн удирдах арга замын тодорхойлов. Үүнд:

Эрсдэл	Эрсдэлийн тодорхойлолт	Эрсдэлийн удирдлага
Зээлийн эрсдэл	<ul style="list-style-type: none"> <li>Зээлийн эрсдэлд зээлдэгч зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй улмаас үүсэх эрсдэлийг хэлнэ. Үүнд зээлдэгч зээлийн хугацаа хэтрүүлэх, төлбөрийн чадваргүй болох, Зээлдэгч эрх зүйн чадамжгүй болох, нас барах, сураггүй алга болсон нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон байхыг ойлгоно.</li> <li>Хугацаанаас өмнө эргэн төлөгдөх эрсдэлд зээлдэгч зээлээ хугацаанаас нь өмнө төлөх буюу хүлээгдэж байсан хүүгийн орлого буурах, хаагдахыг ойлгоно.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>ТЗК нь зээлтэй холбоотой эрсдэлийг СЗХ-с баталсан "Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулах, зарцуулах журам"-г мөрдөж, зээлийг ангилж, эрсдэлийн сан байгуулж ажиллана.</li> <li>Эрсдэлийн сан байгуулах: ТЗК нь дээрх журмын дагуу зээлийн эрсдэлийн санг тооцож, холбогдох эрсдэлийн сангийн тохируулгыг хийнэ.</li> <li>ТЗК нь хугацаа хэтэрсэн зээл дээр үйлчилгээ үзүүлэгч талаас зээлийг эргэн төлүүлэхтэй холбоотой үйлчилгээ үзүүлэгчийн дотооддоо мөрдөж буй холбогдох заавар журмын хүрээнд үйлчилгээг авч, хяналт тавьж ажиллана. Үүнтэй холбоотой зохицуулалтыг Үйлчилгээ үзүүлэх гэрээнд тусгана.</li> <li>ТЗК нь зээл хугацаагаас өмнө эргэн төлөгдөх эрсдэл үүссэн тохиолдолд Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэг болон ТЗК-ийн Хөрөнгө итгэмжлэн удирдах журамд заасны дагуу хөрөнгийн багцад хөрөнгө нэмэх замаар арга хэмжээ авна</li> <li>Зээлийн гэрээнд өөрчлөлт орсон тохиолдолд Анхны үүрэг гүйцэтгэгч нь Үнэт цаас гаргагч болон Хөрөнгө итгэмжлэн учирдагчид мэдэгдэх бөгөөд тус өөрчлөлт нь шалгуур үзүүлэлтэд нийцэхгүй тохиолдолд зээлүүдийг зээлийн багцаас хасаж, шалгуур хангах зээлээр солих эсхүл буцаан худалдах нөхцөлтэй.</li> </ul>
Хөрөнгийн багцтай холбоотой эрсдэл	<ul style="list-style-type: none"> <li>Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн эргэн төлөлтийн график нь үнэт цаасны төлбөрийн графикаас зөрүүтэй байх эрсдэл</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Үнэт цаас гаргагчтай байгуулсан "Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ"-нд тусгасны дагуу зээлийн багцын эргэн төлөлт болон үнэт цаасны эргэн төлөлтөд хяналт тавьж ажиллана. Шаардлагатай тохиолдолд Хөрөнгийн багц дахь зээлийг нэмэгдүүлэх, шаардлага хангаагүй зээлүүдийг солих арга хэмжээ авна. Энэхүү танилцуулгыг бэлтгэх үеийн байдлаар АҮГ-ийн үнэт</li> </ul>






	<ul style="list-style-type: none"> <li>Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгүүдэд оорчлолт оруулсантай холбоотой Хөрөнгийн багц чанар үйдэх эрсдэл</li> </ul>	<p>цаасжуулаагүй автомашины фидуцийн зээлийн хөрөнгийн багц нь үнэт цаасжуулсан хөрөнгийн багцаас 1.4 дахин их байгаа нь солих, сонгох арга хэмжээг авахад хангалттай хүрэлцэхүйц байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>2022 онд гаргасан Бэрс ХБҮЦ-ны багцын хувьд: 2022 оны 9-р сараас 2023 оны 2-р сарын хугацаанд чанаргүй зээлийн хувь 0.07-0.66 байсан бөгөөд тус зээлүүдийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид тухай бүр буцаан шилжүүлж, шалгуур хангах зээлээр сольж ажиллаж байна. Түүнчлэн тус багц дахь зээлүүдийн хувьд шалгуур хангахгүй нөхцөл үүсээгүй байна.</li> </ul>
<p><b>Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй холбоотой эрсдэл</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>Хөрөнгийн багцыг шилжүүлэхээс өмнө ТЗК-ийн Хөрөнгө итгэмжлэн удирдах журмын 2 дугаар зүйлийн 2.3 дахь хэсэгт заасан зээл шилжүүлэх</li> <li>Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь хөрөнгийн багцыг сольж нэмж чадахгүй болох</li> <li>Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь төлбөрийн чадваргүй болсон, дампуурсан, татан буугдах эрсдэлийг ойлгоно.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Хөрөнгө итгэмжлэн удирдах журмын 2 дугаар зүйлийн 2.3 дахь хэсэгт заасан зээл шилжүүлсэн эрсдэл үүссэн тохиолдолд Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс хөрөнгийн багцыг солихыг шаардах, ТЗК-ийн Хөрөнгө итгэмжлэн удирдах журамд заасны дагуу эрсдэлийг удирдана.</li> <li>Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь сайн дурын үндсэн дээр эсхүл хуульд заасан үндэслэлээр татан буугдах тохиолдолд түүний ТЗК-д шилжүүлсэн Багцын хөрөнгийн үлдэгдлийг зохих журмын дагуу сонгогдсон өөр Үйлчилгээ үзүүлэгчид шилжүүлэх арга хэмжээ авна.</li> <li>ТЗК нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй холбоотой эрсдэлийг бууруулах зорилгоор холбогдох журам, гэрээнд тус бүр эрсдэл бууруулах, мэдээллийг цаг тухай бүр хүргэх, хянах, мэдээлэл солилцох зохицуулалтыг тусгасан.</li> </ul>
<p><b>Үйлчилгээ үзүүлэгчтэй холбоотой эрсдэл</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>Үйлчилгээ үзүүлэгч нь төлбөрийг бүрэн гүйцэд, гэрээгээр хүлээсэн хугацааны дагуу цуглуулан ТЗК-д шилжүүлэхгүй байх</li> <li>Үйлчилгээ үзүүлэгчийн тусгай зөвшөөрлийг хорооноос цуцлах</li> <li>Үйлчилгээ үзүүлэгч нь төлбөрийн чадваргүй, татан буугдсан, дампуурах эрсдэлийг ойлгоно.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Үйлчилгээ үзүүлэгч нь зээлийн эргэн төлөлтийг өөрийн харилцах данс буюу зээлийн эргэн төлөлтийн дансанд цуглуулах ба ТЗК-ийн хөрөнгийн багцад буй зээлүүдийн үндсэн болон хүүгийн төлөлтийг цуглуулан өөрийн бусад хөрөнгөөс ангид байлгана. ТЗК болон Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Үйлчилгээ үзүүлэгчтэй зээлийн эргэн төлөлтийн дансны барьцааны гэрээ байгуулна.</li> <li>Үйлчилгээ үзүүлэгч нь учруулсан хохиролтой тэнцэх хэмжээний мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгийг өөрийн хөрөнгөөр төлж барагдуулна.</li> <li>Үйлчилгээ үзүүлэгч нь зээлийг төлүүлэхдээ ТЗК-тай байгуулсан гэрээний дагуу үйлчилгээ үзүүлэгч байгууллагын дотооддоо мөрдөгдөж буй Зээлийн үйл ажиллагааны журам, Зээл төлүүлэхтэй холбогдсон бусад журмыг дагаж мөрдөнө.</li> <li>Үйлчилгээ үзүүлэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа биелүүлэхгүй, эсхүл Үйлчилгээ үзүүлэгч нь төлбөрийн чадваргүй болсон, татан буугдах, дампуурах эрсдэл үүссэн, төрийн зохицуулах байгууллагаас тусгай зөвшөөрлийг цуцалсан тохиолдолд ТЗК нь тусгаарласан зээлийн багцтай холбоотой авлага цуглуулах, төлбөр гүйцэтгэх үйл ажиллагааг өөр хэвийн үйл ажиллагаатай</li> </ul>



БҮРТГЭВ-02

		<p>үйлчилгээ үзүүлэгчид шилжүүлэх, үйлчилгээ үзүүлэгчийг солих арга хэмжээ авна.</p> <ul style="list-style-type: none"> <li>ТЗК нь үйлчилгээ үзүүлэгчтэй холбоотой эрсдэлийг бууруулах, үүссэн эрсдэлийг шийдвэрлэх зорилгоор холбогдох журам, гэрээнд эрсдэл бууруулах, мэдээллийг цаг тухай бүр хүргэх, хянах, мэдээлэл солилцох зохицуулалтуудыг тусгасан байна.</li> </ul>
<p><b>Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай холбоотой эрсдэл</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь хөрөнгийг гэрээнд зааснаас гадуур, Үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагчид</li> <li>Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн тусгай зөвшөөрлийг СЗХ-с цуцлах</li> <li>Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь татан буугдсан, дампуурах эрсдэлийг ойлгоно.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь багцын удирдлагатай холбоотой тайлан мэдээллийг үнэт цаас гаргагчтай байгуулсан гэрээний дагуу үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагч, холбогдох эрх бүхий байгууллагад тогтмол хүргэх бөгөөд хууль болон гэрээнд зааснаас гадуур, зүй бусаар удирдаж, ашиглах тохиолдолд ТЗК-ийн ТУЗ нь хөрөнгө итгэмжлэн удирдагчийг нэн даруй солих шийдвэр гаргах, эсхүл үйл ажиллагааг залруулах, хохирлыг барагдуулах тодорхой хугацаа өгөх эрхтэй. Мөн зүй бус хөрөнгийн удирдлагатай холбоотой аливаа хохирол учирсан тохиолдолд Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь өөрийн хөрөнгөөр бүрэн төлж барагдуулах талаар гэрээнд тодорхой тусгаж баталгаажуулсан байна.</li> <li>Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн тусгай зөвшөөрлийг төрийн зохицуулах байгууллагаас цуцлах, хөрөнгө итгэмжлэн удирдагч нь төлбөрийн чадваргүй болох, татан буугдах, дампуурах нөхцөл үүссэн тохиолдолд шаардлага хангах хөрөнгө итгэмжлэн удирдагчийг яаралтай шинээр сонгон ажиллуулна.</li> <li>ТЗК нь Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай холбоотой эрсдэлийг бууруулах, үүссэн эрсдэлийг шийдвэрлэх зорилгоор холбогдох журам, гэрээнд эрсдэл бууруулах, мэдээллийг цаг тухай бүр хүргэх, хянах, мэдээлэл солилцох зохицуулалтуудыг тусгасан байна.</li> </ul>
<p><b>Гадаад хүчин зүйлстэй холбоотой эрсдэл</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>ХБҮЦ, ТЗК, оролцогч талуудад тавигдах шаардлагатай холбоотой хууль журам, зохицуулалт өөрчлөгдөх эрсдэлийг ойлгоно.</li> <li>Хүүгийн түвшин өөрчлөгдөхтэй холбоотой эрсдэл</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>ТЗК-ийн ТУЗ-ийн хурал хуралдаж, шаардлагатай гэж үзсэн тохиолдолд эрсдэлийн үнэлгээ, үр нөлөөтэй холбоотой хөндлөнгийн байгууллага, хуулийн фирмийг хөлслөн ажиллуулах, зохицуулагч эрх бүхий байгууллагуудтай тогтмол мэдээлэл солилцох, шийдвэр гаргах замаар эрсдэлийг бууруулж ажиллана.</li> <li>Давагдашгүй хүчин зүйлстэй холбоотой эрсдэлд дараах арга хэмжээг авч ажиллана.</li> <li>Давагдашгүй хүчин зүйл бий болсон тухайгаа Үнэт цаас эзэмшигчдэд тухайн брокерын компаниар дамжуулан бичгээр мэдэгдэх, ТЗК болон Биржийн цахим хуудсаар мэдээлнэ. Тухайн мэдэгдэлд учирсан давагдашгүй хүчин зүйлийг, түүний хор уршгийг бууруулах талаар авсан, эсхүл авах гэж буй арга хэмжээг, давагдашгүй хүчин зүйлийн улмаас үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон хугацааг тус тус тусгасан байна.</li> <li>Давагдашгүй хүчин зүйлийн улмаас ТЗК нь Үнэт цаас эзэмшигчдийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж чадаагүй нь хариуцлагаас бүрэн болон хэсэгчлэн чөлөөлөх ч үндсэн</li> </ul>



БҮРТГЭВ-02

үүргээс чөлөөлөхгүй. Давагдашгүй хүчин зүйлийн үед ТЗК ийн үүрэг биелүүлэх хугацаа нь давагдашгүй хүчин зүйлийн үргэлжлэх хугацаагаар хойшлогдоно.

- Үнэт цаас гаргагчийн үнэт цаасны хүү болон зээлийн хөрөнгийн багцын хүүгийн хэмжээ тогтмол байх ба үнэт цаасны танилцуулга бэлтгэгдэх үед арилжаа банкуудын хадгаламжийн хүүтэй харьцуулахад өндөр байгаа бөгөөд бусад нээлттэй өрийн хэрэгслийн хүүгийн хэмжээтэй өрсөлдөхүйц хэмжээнд байна. Хөрөнгө оруулагчдын хувьд хүүгийн төлбөрийг улирал бүр, үндсэн төлбөрийг жилд 1 удаа хүлээн авах ба эзэмших хугацааны туршид дахин хөрөнгө оруулалт хийж хүүгийн түвшиний эрсдэлийг бууруулах боломжтой байна.

### Эргэн төлөлтийг сайжруулах

ТЗК нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсэгт заасны дагуу эргэн төлөлтийг сайжруулах дараах арга хэмжээг авна.

- Багцын хөрөнгийг сайжруулах, солих.
- Багцын хөрөнгийг нэмэгдүүлнэ.
- Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдана.
- Багцын хөрөнгийн дүнг ХБҮЦ-ны төлбөрийн төлөгдөөгүй дүнгээс багагүй байлгана.
- Эрсдэлийн сан байгуулна.
- Хөрөнгийн багц дахь зээлийн төлбөрүүдийг Үйлчилгээ үзүүлэгчийн бусад хөрөнгөөс тусад нь ангид байлгана.
- Зээлийн эргэн төлөлтийн дансны барьцааны гэрээг Үйлчилгээ үзүүлэгч, ТЗК, Хөрөнгө итгэмжлэн удирдагч нар байгуулна.
- ТЗК-ийн төлбөр гүйцэтгэх дансанд зарлагын хязгаарлалтууд хийгдэх ба Эрсдэл, сонирхлын зөрчлийг илрүүлэх, удирдлага, дотоод хяналтын журмын 3.3.6 дугаар зүйлийн 3.3.6.1 дэх хэсэгт заасны дагуу зохион байгуулна.
- ТЗК-ийн эргэн төлөлтийг сайжруулах арга хэмжээг ТЗК татан буугдах хүртэл хэрэгжүүлнэ.
- ТЗК нь татан буугдах үед зээл, зээлийн эрсдэлийн сан нь Анхны үүрэг гүйцэтгэгчид шилжинэ.





БЭРС  
-2 ХБҮЦ

ЗУРГАА. ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН  
ТУХАЙ



Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт зааснаар үйлчилгээ үзүүлэгч нь үүрэг гүйцэтгэгчтэй харилцаж, хөрөнгөтэй холбоотой төлбөрийг цуглуулан тусгай зориулалтын компанид шилжүүлэх, бүртгэх, тайлагнах болон үйлчилгээ үзүүлэх гэрээнд заасан хөрөнгөтэй холбоотой бусад үйлчилгээ, үйл ажиллагаа эрхлэхээр үнэт цаас гаргагчтай гэрээ байгуулсан хуулийн этгээд байна.

Үнэт цаас гаргагчийн Үйлчилгээ үзүүлэгч буюу Анхны үүрэг гүйцэтгүүлэгч "Бэрс финанс ББСБ" ХХК нь хүний нөөцийн болон нягтлан бодох бүртгэл, тайлан тооцоо гаргах, программ, техник хангамжийн нөхцөлөөр бүрэн хангагдсан, бөгөөд компанийн засаглалын өөрийн үнэлгээ хийж, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Компанийн засаглалын кодекст заасан зарчмуудыг хэрэгжүүлэх хөтөлбөр батлан ажиллаж байна.


Үйлчилгээ үзүүлэгчийн хэрэгжүүлэх арга хэмжээ, үүрэг:

- Төлбөр цуглуулах, үйлчилгээ үзүүлэх гэрээний нөхцөл болон Үнэт цаас гаргагч эсхүл түүний төлөөлөгчөөс бичгээр ирүүлсэн зааварчилгаанд дурдсан нөхцөлийн дагуу үйл ажиллагаа явуулна.
- Хөрөнгийн багцад багтсан зээлийн Зээлдэгч, үүрэг гүйцэтгэгч нартай харилцах, төлбөр цуглуулах, зээл төлүүлэх арга хэмжээг өөрийн холбогдох Зээлийн эрсдэлийг удирдах журамд заасны дагуу хэрэгжүүлэх, зээлдэгчийн өмнө ТЗК-г төлөөлж, зээлийн эргэн төлөлтийг гэрээнд заасан хугацаанд ТЗК-д шилжүүлэх, бүртгэх, тайлагнах;
- Зээлдэгчийн хүсэлтийн дагуу Зээлийн гэрээнд өөрчлөлт оруулж, төлбөрийн хуваарьт өөрчлөлт оруулсан бол Үйлчилгээ үзүүлэгч нь энэ талаарх мэдээллийг Хөрөнгө итгэмжлэн удирдагчид Зээлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулсан сард багтааж мэдэгдэнэ;
- Хөрөнгийн багцад багтсан зээлийн мэдээллийг хадгалах, ТЗК, Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн хууль ёсны шаардлагаар ТЗК-тай холбоотой аливаа дүгнэлт гаргахад шаардагдах мэдээлэл, баримт бичгийг хүргүүлэх, мэдээллээр хангах, өөрийн гаргасан дүгнэлтийг холбогдох баримтыг бүрэн судалж, зохих стандартын дагуу үйл ажиллагаа явуулж, гаргасан дүгнэлтийн хариуцлагыг бие даан хариуцна;
- Үйлчилгээ үзүүлэгч нь өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас ТЗК болон Үнэт цаас эзэмшигчдэд хохирол учруулсан тохиолдолд өөрийн хөрөнгөөр тэдний өмнө хариуцлага хүлээнэ;
- ТЗК-ийн нэрийн өмнөөс зээлийн хүүгийн төлбөрийн нэмэгдсэн өртгийн албан татварын баримтыг зээлдэгчид хүргүүлнэ;
- Үйлчилгээ үзүүлэгч нь хөрөнгөөс олох орлогыг баталгаат үнэт цаасны хөрөнгийн багц тус бүрээр, багцын тодорхой хэсгээр тусдаа дансанд хуримтлуулна.

## 6.2 Үйлчилгээ үзүүлэгчтэй байгуулсан гэрээ

**Төлбөр цуглуулах, үйлчилгээ үзүүлэх гэрээ.**





Компанийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргахтай холбоотой "Бэрс ЭЙ Би Эс Плас ТЗК" ХХК, "Бэрс Финанс ББСБ" ХХК, "Юнайтед Айр Файнэнс" ХХК нарын хооронд 2023 оны 02-р сарын 09-ний өдөр 23/561 тоот "Төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлэх гэрээ" байгуулагдсан байна. Тус гэрээ нь нийт 9 бүлгээс бүрдсэн бөгөөд тус гэрээний дагуу Үйлчилгээ үзүүлэгч нь Үнэт цаас гаргагчаас гаргах хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны төлбөрийг цаг хугацаанд нь цуглуулан, шилжүүлэх, бүртгэлийг хөтлөх, тайлагнах, Зээлийн эрсдэлийг удирдах журмын дагуу зээлийн хяналт тавьж, зээл төлүүлэх ажиллагаа явуулах, Хөрөнгө итгэмжлэн удирдагчаас төлбөр цуглуулах үйл ажиллагаанд хяналт тавих, Үнэт цаас гаргагч нь үйлчилгээний төлбөрийг төлөхтэй холбогдох харилцааг зохицуулсан байна.

**Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ.**

Компанийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргахтай холбоотой "Бэрс Финанс ББСБ" ХХК, "Бэрс ЭЙ Би Эс Плас ТЗК" ХХК нарын хооронд 2023 оны 02-р сарын 09-ний өдөр 23/559 тоот "Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ" байгуулагдсан байна. Тус гэрээ нь нийт 14 бүлгээс бүрдсэн бөгөөд тус гэрээний дагуу Үнэт цаас гаргагч нь зээлийн багц хөрөнгө болон түүнд холбогдох эрхийг худалдан авч, гэрээнд заасан үнийг төлөх, анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь хөрөнгийн багцыг худалдах, зээлийн хөрөнгийг солихтой холбоотой харилцааг зохицуулж байна.

**Захиргааны үйлчилгээ үзүүлэх гэрээ**

Компанийн ХЭХ, ТУЗ-ийн хурлын бэлтгэлийг хангах, албан бичиг хэргийн ажил гүйцэтгэх, Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай хамтран нягтлан бодох бүртгэл хөтлөх, ТЗК-ийн мөнгөн хөрөнгөөс шаардлагатай мөнгөн гүйлгээг ХИУ-ийн хяналт доор хамтран гүйцэтгэх, хүүгийн орлогын албан татвар төлөх, компанийн цахим хуудас хөтлөх зэрэг Үнэт цаас гаргагчийн өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулахтай холбоотойгоор 23/564 тоот "Захиргааны үйлчилгээ үзүүлэх гэрээ"-г Үнэт цаас гаргагч нь "Бэрс Финанс ББСБ" ХХК-тай 2023 оны 02-р сарын 09-ний өдөр байгуулсан байна. Гэрээ нь нийтлэг үндэслэл, үзүүлэх үйлчилгээ, үйлчилгээний хөлс, баталгаа, мэдэгдэл, гэрээ дуусгавар болох, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл, нууц мэдээлэл, маргаан шийдвэрлэх, бусад зүйл гэсэн 9 бүлэг бүхий зохицуулалттай байна.

**6.3 Үйлчилгээ үзүүлэгчтэй байгуулсан гэрээг цуцлах нөхцөл**

Үйлчилгээ үзүүлэгч гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгээгүй тохиолдолд ТЗК нь гэрээг цуцалж, шинэ үйлчилгээ үзүүлэгчийг томилно.

Гэрээг цуцалсан тохиолдолд түүнээс хойш 5 хоногийн дотор дараагийн үйлчилгээ үзүүлэгчийг сонгоно. Шинэ үйлчилгээ үзүүлэгчтэй байгуулсан гэрээ хүчин төгөлдөр болох хүртэл хугацаанд Үйлчилгээ үзүүлэгч Төлбөр цуглуулах үйлчилгээг үргэлжлүүлэн үзүүлэх үүрэгтэй ба ТЗК-аас нэмэлт төлбөр шаардах эрхгүй байна.





**БЭРС**  
**-2 ХБҮЦ**

**ДОЛОО. ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН  
УДИРДАГЧИЙН ТУХАЙ**

**7.1 Ерөнхий танилцуулга**

"Юнайтед Айр Файнэнс" ХХК нь 2005 оны 1 дүгээр сарын 27-нд үүсгэн байгуулагдаж, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2021 оны 10 дугаар сарын 28 өдрийн 473 тоот тогтоолоор Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг ХБҮЦ-ны хөрөнгө итгэмжлэн удирдах чиглэлээр авсан.

Байгууллагын нэр	"Юнайтед Айр Файнэнс" ХХК
Компанийн регистрийн дугаар	2870657
Тусгай зөвшөөрлийн дугаар:	T3 316/18
Гүйцэтгэх захирал	Х.Маргад-Эрдэнэ
Үйл ажиллагааны чиглэл	Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа
Хаяг	Улаанбаатар, Сүхбаатар, 8-р хороо, СТӨ-ний 10 давхарт 1005 тоот


"Юнайтед Айр Файнэнс" ХХК нь ТЗК-ийн санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэлийг хөтлөх, үнэт цаасны баталгаа болж буй хөрөнгийн эргэн төлөлтийг цуглуулж, үнэт цаасны хэлцэлтэй холбоотой төлбөрийг гүйцэтгэх, мөнгөн хөрөнгийг зөвшөөрөгдсөн хөрөнгө оруулалтад байршуулах, хөрөнгө оруулагч болон зохицуулагч байгууллагад тайлан мэдээ гаргах, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах ажлыг гүйцэтгэнэ.

Компани нь Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан нээлттэй гаргасан "Омни Капитал ББСБ" ХХК-ийн зээлийн багц дээр түшиглэсэн "Омни Актив ТЗК" ХХК-ийн 5 тэрбум төгрөгийн үнийн дүнтэй 24 сарын хугацаатай зээлийн багц барьцаалсан ХБҮЦ, "Ашид Капитал ББСБ" ХХК-ийн хэрэглээний зээлийн багц дээр түшиглэсэн "Симпл Ассет ТЗК" ХХК-ийн 50 тэрбум төгрөгийн дүнтэй 18 сарын хугацаатай ХБҮЦ, "Бэрс Финанс ББСБ" ХХК-ийн автомашины зээлийг багцлан "Бэрс Эй Би Эс Актив" ТЗК ХХК-ийн 10 тэрбум төгрөгийн дүнтэй 24 сарын хугацаатай ХБҮЦ, "Нөмөр Кредит ББСБ" ХХК-ийн зээлийн хөрөнгийн багцаас бүрдсэн "Нөмөр Кредит Ассет ТЗК ХХК"-ийн 10 тэрбум төгрөгийн дүнтэй 24 сарын хугацаатай ХБҮЦ-ыг, "ЛэндМН ББСБ" ХХК-ийн зээлийн багцаас бүрдсэн "ЛэндМН Актив ТЗК" ХХК-ийн 4.85 тэрбум төгрөгийн дүнтэй 24 сарын хугацаатай ХБҮЦ болон "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК-ийн автомашины зээлийн хөрөнгийн багцаас бүрдсэн "Бичил Эй Би Эс ТЗК" ХХК-ийн 10 тэрбум төгрөгийн үнийн дүнтэй 24 сарын хугацаатай ХБҮЦ-ыг тус тус амжилттай удирдан ажиллаж байна. Эдгээр нь нээлттэй хүрээнд Монголын Хөрөнгийн Биржээр дамжиж нийтэд санал болгосон, хугацааны дундуур борлуулах, дараагийн хөрөнгө оруулагчдад шилжүүлэх боломжтой хөрвөх чадвар бүхий бүтээгдэхүүнүүд юм.

Компанийн гүйцэтгэх удирдлагын баг нь бүтэцжүүлсэн санхүүжилтийн чиглэлээр 10-аас дээш жил ажилласан туршлагатай. Компанийн засаглалын олон улсын ISO 37000:2021 стандартыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүний хүрээнд санхүүгийн зах зээлд оролцогчдод компанийн засаглалын зөвлөх үйлчилгээг хүргэн ажилладаг. Компани нь компанийн засаглал, санхүүгийн удирдлагаар мэргэшсэн 100 хувь хараат бус төлөөлөн удирдах зөвлөлтэй.







Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн удирдлагын багийн мэдээлэл

Гүйцэтгэх захирал	Х.Маргад-Эрдэнэ	МУИС-ийг Бизнесийн удирдлагын бакалавр зэрэгтэй төгссөн. Багцын удирдлага, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, бүтцийн санхүүжилтийн чиглэлээр 13 жил ажиллаж байна. Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны ерөнхий нарийн бичгийн даргын 2020 оны 6 дугаар сарын 11-ны өдрийн 05 тоот тушаалаар Хөрөнгө оруулалтын чиглэлээр ажил үйлчилгээ явуулах эрх авсан.
Партнер	Ж.Онон	Лондонгийн Эдийн засгийн их сургуулийг банк, санхүүгийн бакалавр зэрэгтэй төгссөн. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, бүтцийн санхүүжилт, компанийн засаглал чиглэлээр 14 жил ажилласан туршлагатай. Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны ерөнхий нарийн бичгийн даргын 2021 оны 11 дугаар сарын 11-ны өдрийн А-07 тоот тушаалаар Хөрөнгө оруулалтын чиглэлээр ажил үйлчилгээ явуулах эрх авсан.
Менежер	Б.Буяннэмэх	МУИС-ийг эдийн засаг бакалавр, бизнесийн удирдлагын чиглэлээр магистр зэрэгтэй төгссөн. Багцын удирдлага, зээлийн шинжилгээ, үнэт цаасны чиглэлээр 10 дахь жилдээ ажиллаж байна. Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны ерөнхий нарийн бичгийн даргын 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 10 тоот тушаалаар Хөрөнгө оруулалтын чиглэлээр ажил үйлчилгээ явуулах эрх авсан.


Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн эрх бүхий албан тушаалтан, хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагааг хариуцан ажиллах мэргэжилтэн нь Хорооноос баталсан тохиромжтой этгээдийн журмын шаардлагыг хангасан, Гүйцэтгэх захирал, ХИУ үйл ажиллагааг хариуцан ажиллах мэргэжилтэн нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил үйлчилгээ явуулах эрх авсан, үйл ажиллагааг эрхлэхэд шаардлагатай хүний нөөцийн болон нягтлан бодох бүртгэл, тайлан тооцоо гаргах, программ, техник хангамжийн нөхцөлөөр хангагдсан болно.

## 7.2 Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай байгуулсан гэрээний тухай

Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь хөрөнгө оруулагчийн эрх ашигт нийцүүлэн хөрөнгийг эзэмших, удирдах үндсэн үүргийн хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Хөрөнгийн багцыг удирдах хяналт тавих;





- Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс ТЗК-д хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний дагуу шилжүүлсэн хөрөнгийн жагсаалтын дагуу компанийн нэрийн өмнөөс өөрийн программ хангамжаар хүлээн авч, багцын бүртгэлийг баталгаажуулах;
- ТЗК-ийн хөрөнгийн багц дахь зээлийн данс бүртгэлийг өөрийн компанийн данс бүртгэл, санхүүгийн тайлан тооцооноос тусад нь бүртгэх;
- Зээлийн данс бүртгэлийг хянаж, алдаа, зөрчил илэрсэн бол түүнийг залруулах арга хэмжээг тухай бүр авах шаардлагыг Үйлчилгээ үзүүлэгчид хүргүүлэх;
- Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний дагуу шилжүүлэн авах хөрөнгө нь ТЗК-ийн ТУЗ-өөс баталсан хуулийн болон санхүүгийн шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхэд хяналт тавих;
- ТЗК-ийн төлбөр цуглуулах дансанд цугларсан төлбөрөөр үнэт цаасны төлбөр болон ТЗК-ийн бусад төлбөрийн үүргийг гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд нэн даруй ТЗК-д мэдэгдэх;
- Зээлийн хөрөнгийн багцын төлбөрийг зөвшөөрөгдсөн хөрөнгө оруулалтад байршуулах;
- Хөрөнгийн ашиглалт, нөөц хөрөнгийн талаар зөрчил гарвал нэн даруй ТЗК-ийн ТУЗ-д мэдэгдэх.

### 7.3 Хөрөнгө итгэмжлэн удирдагчийг солих

Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд заасан зөрчил гаргасан эсхүл гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй, үүргээ биелүүлэх шаардлага хүргүүлсэн боловч гаргасан зөрчлөө арилгаагүй, үүргээ гүйцэтгэхгүй болох нь тогтоогдсон эсхүл гүйцэтгэх чадваргүй болсон, дампуурах байдалд хүрсэн зэргээр хөрөнгө итгэмжлэн удирдагчийг солих шаардлага үүссэн тохиолдолд ТУЗ-ийн шийдвэрээр гэрээг цуцлах тухай санал гаргана .

Үнэт цаас гаргагч нь Хөрөнгө итгэмжлэн удирдагчийг солих тохиолдолд Хөрөнгө итгэмжлэн удирдагчид ажлын 30 өдрийн өмнө мэдэгдэл хүргүүлнэ. Мэдэгдэл хүргүүлсэн өдрөөс хойш ажлын 30 өдөрт багтаан Хөрөнгө итгэмжлэн удирдагчид хадгалагдаж байсан Үнэт цаасны болон Хөрөнгийн багцтай холбоотой баримт бичгийг үнэт цаас гаргагчийн шинээр томилогдсон этгээдэд хүлээлгэн өгөх эрхтэй.

Үнэт цаас гаргагч нь шинэ хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгон, томилж амжаагүй тохиолдолд буюу шинээр хөрөнгө итгэмжлэн удирдагчтай гэрээ байгуулах хүртэл ТЗК-ийн ТУЗ өөрөөр шийдвэрлээгүй бол Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь хууль тогтоомж болон энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ хэвийн, урьдын адил гүйцэтгэх үүрэгтэй.





БЭРС  
-2 ХБҮЦ

НАЙМ. ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН  
ҮНЭТ ЦААСНЫ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

## 8 ХБУЦ-НЫ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

### 8.1 Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааг зохицуулах хууль эрх зүйн орчин

Монгол Улсын Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэгт "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг гаргах, арилжихтай холбогдсон нийтлэг харилцааг энэ хуулиар, нарийвчилсан харилцааг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль тогтоомжийн дагуу зохицуулна" гэж заасны дагуу хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, түүнд хяналт тавих, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийг 2010 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр баталж, 2011 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөхөөр тогтоосон байдаг.

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай, Компанийн тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

Үнэт цаас гаргагч нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргахтай холбоотой үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллахаас гадна дараах хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулна. Үүнд:


- Иргэний хууль;
- Компанийн тухай хууль;
- Татварын ерөнхий хууль;
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль;
- Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль;
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль;
- Үнэт цаасны зах зээлийн тухай хууль;
- Компанийн засаглалын кодекс;
- СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам;
- СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хөрөнгийн багцыг тусгай тэмдэглэл хийж бүртгэх тухай журам;
- СЗХ-ны Тохиромжтой этгээдийг тодорхойлох журам;
- СЗХ-ны Зохицуулалттай этгээд, үнэт цаас гаргагчаас зар сурталчилгаа явуулах журам;
- СЗХ-ны Үнэт цаасны зах зээлд дотоод мэдээллийн жагсаалт, түүнийг мэдээлэх журам;
- МХБ-ийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам;
- МХБ-ийн Арилжааны журам;
- МХБ-ийн Үнэт цаас гаргагчаас олон нийтэд хүргэх мэдээллийн журам;
- Холбогдох эрх бүхий байгууллагын тогтоосон бусад дүрэм, журам болон бусад хууль тогтоомж.







"Бэрс Эй Би Эс Плас ТЗК" ХХЭЗХ



Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасны дагуу Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргагч нь тусгай зориулалтын компани байх ба тус хуульд тусгай зориулалтын компанийн үүсгэн байгуулагчид тавигдах шаардлага, дүрэмд тусгагдах асуудал, хориглох болон зөвшөөрөх үйл ажиллагаа, тэдгээрийг хэрэгжүүлэх субъектийн талаар тусгайлан зохицуулсан байна. Тухайлбал, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасны дагуу тусгай зориулалтын компанид хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр ажилтан авч ажиллуулахыг хориглодог бөгөөд хувьцаа эзэмшигчид нь Хорооны зөвшөөрөлгүйгээр үнэт цаас гаргагчийн хувьцааг бусдад худалдах, шилжүүлэхгүй байх, Хорооны зөвшөөрөлгүйгээр компанийн дүрэмд өөрчлөлт оруулахгүй байх зэрэг зохицуулалтуудыг тусгасан байдаг. Түүнчлэн тус хуулиар хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргагч болон оролцогч этгээдүүдэд тавигдах шаардлага, баталгаат болон барьцаат үнэт цаас гаргах оролцогчдын хоорондын эрх зүйн харилцаа, эрх үүрэг, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах асуудлуудыг тусгайлан зохицуулсан байдаг.

Мөн Хорооны "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам"-аар хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгчид тавигдах шаардлага, ТЗК-н удирдлага, зохион байгуулалтын бүтэц, тэдгээрийн эрх хэмжээ, ХБҮЦ гаргах тусгай зөвшөөрөл олгох, хүсэлтийг хянах, шийдвэрлэх, барьцаат болон баталгаат үнэт цаас гаргахад тавигдах шаардлага, бүрдүүлэх баримт бичиг, үнэт цаасны танилцуулгад тусгах мэдээлэл, түүний агуулга, үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагч, хөрөнгийн багцын бүртгэлийг хянагч, аудит, хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдэд тавигдах шаардлага, бүрэн эрх, үүргийг тодорхойлж, ТЗК-н мэдээлэл хүргүүлэх тухай харилцааг зохицуулж байна. Журмын 3 дугаар зүйлд үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаатай холбоотойгоор түүний үүсгэн байгуулагчид тавигдах шаардлага, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд тавигдах шаардлага, төлөөлөн удирдах зөвлөлийн эрх хэмжээ, зарчим, үйл ажиллагааны тайлан мэдээ хүргүүлэх болон хөндлөнгийн аудит хийлгэх тухай нарийвчлан зохицуулсан байдаг.


МХБ-ийн "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам"-аар ХБҮЦ-ийн хөрөнгийн биржид бүртгэх бэлтгэл ажил, ХБҮЦ бүртгүүлэх хүсэлт гаргах, ХБҮЦ-ны танилцуулгын агуулга, хэлбэр, ХБҮЦ-ийн бүртгэлийн шалгуур, шаардлага, ХБҮЦ гаргагч болон үнэт цаасанд тавигдах шалгуур, шаардлага, шалгуур, шаардлагаас чөлөөлөгдөх, хөнгөлөх үндэслэл, ХБҮЦ бүртгэх, бүртгэхээс татгалзах болон ХБҮЦ гаргагчийн бүртгэлтэй байх хугацаанд биелүүлэх үүргийг тодорхойлж, түүнтэй холбогдох харилцааг зохицуулж байна.

## 8.2 Үнэт цаас гаргах үйл ажиллагааг зохицуулах хууль эрх зүйн орчин

Монгол Улсын хэмжээнд үнэт цаасны зах зээлийн үйл ажиллагаа, зах зээлд оролцогчдод хяналт тавих, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалахтай холбоотой бүхий л харилцаа Үнэт цаасны зах зээлийн тухай хуулиар зохицуулагддаг.

Үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон эдгээр хуультай нийцэн гаргасан бусад хууль тогтоомжоос бүрддэг болно. Үнэт цаас гаргах үйл ажиллагаа нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулиар зохицуулагдахаас





гадна бусад зохицуулагч байгууллагууд буюу Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Бирж болон Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төвийн холбогдох дүрэм, журмаар зохицуулагддаг. Үүнд:


**Хууль, дүрэм журмууд**


Зохицуулагч байгууллага	Хууль дүрэм, журам
Санхүүгийн Зохицуулах Хороо	<ul style="list-style-type: none"> <li>• Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам</li> <li>• Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хөрөнгийн багцыг тусгай тэмдэглэл хийж бүртгэх тухай журам</li> <li>• Үнэт цаасны бүртгэлийн журам</li> <li>• Үнэт цаасанд нэгдсэн дугаар олгох журам</li> </ul>
Монголын Хөрөнгийн Бирж	<ul style="list-style-type: none"> <li>• Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам</li> <li>• Үнэт цаасны бүртгэлийн журам</li> <li>• Арилжааны журам</li> <li>• Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам</li> </ul>
Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв	<ul style="list-style-type: none"> <li>• Үнэт цаасны хадгаламжийн журам</li> <li>• Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг бүртгэх үйл ажиллагааны журам</li> <li>• Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг хадгалах, биржийн бус арилжаагаар өмчлөх эрх бүртгэх журам</li> </ul>

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулиар үнэт цаасыг гаргах үйл ажиллагаатай холбоотойгоор хөрөнгийн багцад тавигдах шаардлага, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаанд зөвшөөрөл олгох, зохицуулах төрийн эрх бүхий байгууллага болон үнэт цаасны арилжаа эрхлэх үйл ажиллагаа явуулагч байгууллагын эрх хэмжээ, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгэхтэй холбоотой үйл ажиллагааг тусгайлан зохицуулсан байдаг.

Хорооны “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам”-д үнэт цаас гаргах үйл ажиллагаатай холбоотойгоор хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгэх, түүнд хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулдаг бөгөөд Хорооны “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 1.5 дахь хэсэгт “Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, хадгаламжийн бичиг гаргах болон бусад үүсмэл санхүүгийн хэрэгслийг бүртгэх харилцаа нь тус тусын үйл ажиллагааг тусгайлан зохицуулсан Хорооны журмаар зохицуулагдана” гэж заасны дагуу ийнхүү тусгайлсан журмаар зохицуулагдаж байна.

Биржийн “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам”-д үнэт цаас гаргах үйл ажиллагаатай холбоотойгоор хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг тус биржийн бүртгэлд бүртгэх, бүртгэлийн шалгуур, шаардлагыг тогтоох, бүртгэлтэй байх хугацаанд үнэт цаас гаргагчийн хүлээх үүрэг, түүнд хяналт тавих, бүртгэлээс хасахтай холбогдсон харилцааг зохицуулдаг бөгөөд Биржийн “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 1.4 дэх хэсэгт “Биржийн бусад дүрэм журамд өөрөөр заагаагүй бол хувьцаа, өрийн хэрэгслээс бусад үнэт цаас, санхүүгийн хэрэгслийг бүртгэхтэй холбоотой харилцааг тусгайлсан





журмаар зохицуулна” хэмээн заасныг ийнхүү тусгайлсан журмаар зохицуулагдаж байна.

### 8.3 Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон хөрөнгийн багцтай холбоотой хууль эрх зүйн орчин

Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн үйл ажиллагаа болон үнэт цаас гаргах үйл ажиллагаанд гүйцэтгэх үүргийг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 18 дугаар зүйлд зааснаар зохицуулж байна. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болох банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа нь Хорооны журам болон бусад холбогдох хууль, дүрэм журмуудаар зохицуулагддаг.


Банк бус санхүүгийн үйл ажиллагааг зохицуулахтай холбогдох дараах хууль, дүрэм журмууд хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Үүнд:

- Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль;
- Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль;
- Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам;
- Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам;
- Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж зарцуулах журам;
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам;
- Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам;
- Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан хяналт шалгалт хийх журам;
- Үл хөдлөх хөрөнгө барьцаалуулагчид мэдээлэл өгөх журам;
- Банк бус санхүүгийн гадаад валютын арилжааны үйл ажиллагааг зохицуулах, түүнд хяналт тавих журам;
- Банк бус санхүүгийн байгууллагаас гаргах хаалттай өрийн бичгийг бүртгэх, түүнд хяналт тавих журам;
- Гүйлгээнээс илэрсэн хуурамч мөнгөн тэмдэгтийг хүргүүлэх, бүртгэх, хадгалах, устгах журам;
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам;
- Бусад.

### 8.4 ТЗК-ийн ХБҮЦ-тай холбоотой үйл ажиллагааны зохицуулалт:

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргахтай холбоотой үйл ажиллагаанд мөрдөх дараах журмуудыг Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь 2023 оны 2 дугаар сарын 09-ний өдөр 23/24а/05 тоот тогтоолоор баталсан.


**Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам**







"Бэрс Эй Би Эс Плас ТЗК" ХХК



Тус журамд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, холбогдох хууль тогтоомж, зохицуулалтын байгууллагаас баталсан дүрэм, журам, стандартуудыг дагаж мөрдөх, үүсэж болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх харилцааг зохицуулсан.

#### **Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлэх журам**

Тус журамд хөрөнгө оруулагч, үнэт цаас эзэмшигчид Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны талаар болон хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг тогтмол хүргэх, уг мэдээллийн төрөл, хэлбэр, давтамж, мэдээллийн ил тод байдлыг хангах, нийтэд хүргэх, нэгдсэн нэг мэдээллийн урсгалтай байх, түүнийг хэрэгжүүлэх, хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулсан.

#### **Хөндлөнгийн аудитор, үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох, солих журам**

Тус журамд холбогдох этгээдүүдэд тавигдах шаардлага, шалгуур, гэрээ байгуулах, тэдгээрийг солих болон гэрээ цуцлахтай холбоотой харилцааг зохицуулсан.

#### **Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам**

Тус журамд хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргахтай холбоотойгоор үүсгэн байгуулагдсан төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг зохицуулсан.

#### **Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх тухай журам**

Тус журамд ТЗК-аас гаргах хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны хөрөнгийн багц дахь зээлүүдийн төлбөрийг цуглуулах, үнэт цаас эзэмшигчдэд үнэт цаасны төлбөр төлөхтэй холбоотойгоор ТЗК, Үйлчилгээ үзүүлэгч, Хөрөнгө итгэмжлэн удирдагч болон бусад холбогдох этгээдийн хооронд үүсэх харилцааг зохицуулсан.

#### **Хөрөнгө итгэмжлэн удирдах журам**

Тус журамд компанийн гаргаж буй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны баталгаа болох зээлийн хөрөнгийн багцад буй хөрөнгийг солих, нэмэх, хасах замаар багцад өөрчлөлт оруулахтай холбоотойгоор Үнэт цаас гаргагчийн Анхны үүрэг гүйцэтгүүлэгч, Хөрөнгө итгэмжлэн удирдагч болон бусад оролцогчтой холбоотой харилцааг зохицуулсан.

#### **Эрсдэл сонирхлын зөрчлийг илрүүлэх, үнэлэх, удирдах, дотоод хяналтын журам**

Тус журамд ТЗК-ийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, үнэт цаасны төлбөрийг хөрөнгө оруулагч, үнэт цаас эзэмшигчдэд төлөхтэй холбоотой үйл ажиллагааны эрсдэлийг удирдах, түүнтэй холбогдсон дотоод хяналтыг хэрэгжүүлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээ авахтай холбоотой холбогдох хууль, журмын хүрээнд зохицуулагч байгууллагууд болон оролцогч талуудтай харилцах харилцааг зохицуулсан.







**БЭРС**  
**-2 ХБҮЦ**

ЕС. ҮНЭТ ЦААСНЫ АНХДАГЧ АРИЛЖААГ  
АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАХ

## 9 ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААГ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАХ


### 9.1 Үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулах

Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа нь МХБ-ийн ТУЗ-ийн 2020 оны 2-р сарын 07-ны өдрийн 2020/06 дугаар тогтоолоор баталсан Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам, СЗХ-ны 2022 оны 6-р сарын 22-ны өдрийн 360 дугаар тогтоолоор батлагдсан Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журам, МХБ-ийн ТУЗ-ийн 2018 оны 10-р сарын 26-ны өдрийн 15 тоот тогтоолоор баталсан Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам болон 2012 оны 02-р сарын 10-ны өдрийн 02 тоот тогтоолоор баталсан Арилжааны журмын дагуу явагдана.

Үнэт цаас гаргагчийн 2023 оны 02 сарын 09-ний өдрийн ТУЗ-ийн 23/24а/02 тоот тогтоолын дагуу 90,000 ширхэг Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасыг нийтэд санал болгохоор шийдвэрлэсэн.

Үнэт цаас гаргагчийн олон нийтэд санал болгож буй Бэрс-2 Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасыг олон нийтэд танилцуулах үйл ажиллагааг МХБ болон СЗХ үнэт цаасыг бүртгэсэн өдрөөс хойш ажлын 10 хоногийн дотор, анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг ажлын 5 хоногийн дотор хүлээн авна.

#### Схем 3. Анхдагч зах зээлийн арилжааны төлөвлөгөө



#### Үнэт цаасыг бүртгүүлж, холбогдох зөвшөөрөл авах

Үнэт цаас гаргагч нь нийтэд санал болгох үнэт цаасыг бүртгэлд бүртгүүлэх хүсэлтийг СЗХ болон МХБ-д гаргах бөгөөд эдгээр эрх бүхий байгууллагуудаас үнэт цаасыг бүртгэхийг зөвшөөрснөөр үнэт цаасыг нийтэд санал болгон арилжаалах боломжтой болно.


#### Олон нийтэд танилцуулах

Үнэт цаасыг анхдагч зах зээлд санал болгох тухай мэдэгдлийг СЗХ-нд хүргүүлснээс хойш 3-аас доошгүй өдрийн дараа үнэт цаасыг нийтэд санал болгон танилцуулах аяныг зохион байгуулна. Үүнд хөрөнгийн зах зээлийн





"Бэрс Эй Би Эс Плес ТЗК" ХХК




Мэргэжлийн оролцогч, олон нийт болон стратегийн хөрөнгө оруулагчдад зориулсан танилцуулга уулзалт болон олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр үнэт цаасыг танилцуулах мэдээ мэдээлэл зэрэг нь багтана.

### Анхдагч зах зээлийн арилжааны захиалга хүлээн авах

Үнэт цаас гаргагч нь анхдагч зах зээлийн захиалга авч эхлэхээс ажлын 3-с доошгүй хоногийн өмнө анхдагч зах зээлийн арилжааг эхлүүлэх мэдэгдлийг СЗХ-нд хүргүүлснээр анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг хүлээн авах болно. Анхдагч зах зээлийн захиалгыг Биржийн гишүүн бүх үнэт цаасны компаниар дамжуулан авна.

## 9.2 Үнэт цаасны арилжаанд оролцох, захиалга авах заавар

Схем 4. Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаанд оролцох заавар



Үнэт цаас худалдан авах сонирхолтой хөрөнгө оруулагч нь анхдагч зах зээлийн арилжаанд дараах зааврын дагуу оролцоно.

### Мөнгөн хөрөнгө байршуулах заавар

Үнэт цаас худалдан авах хүсэлтэй хөрөнгө оруулагч нь өөрийн хүссэн Үнэт цаасны компанийн номинал дансанд мөнгө байршуулна.

Дансны нэр:	ҮЦК-ийн нэр
Дансны дугаар:	ҮЦК-ийн номинал дансны дугаар /Брокероос авах/
Банкны нэр:	Брокероос авах
Гүйлгээний утга:	Нэр, Регистр, Бэрс-2 ХБҮЦ

### Арилжааны шимтгэл

Үнэт цаасанд хөрөнгө оруулагч нь гүйлгээний үнийн дүнгийн тодорхой хувиар тооцсон үйлчилгээний хөлс буюу шимтгэлийг өөрийн сонгосон үнэт цаасны компанид төлөх ба уг шимтгэлд зохицуулагч байгууллагуудын болон үнэт цаасны компаниудын шимтгэлийн нийт дүн багтсан байна. Үнэт цаасны компаниудын шимтгэл нь харилцан адилгүй болохыг анхаарна уу.

## 9.3 Албан татвар

Үнэт цаасанд хөрөнгө оруулагч буюу Монгол Улсад байрладаг хувь хүн нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 16.1.4-т заасан орлого (хүүгийн орлого)-ын нийт дүнгээс тус хуулийн 21.5-т заасан 5 хувийн хэмжээгээр татвар суутгана.





"Бэрс Эй Би Эс Плас ТЗК" ХХК СЗХ



Үнэт цаасанд хөрөнгө оруулагч Монгол Улсад байрладаг хуулийн этгээд буюу аж ахуйн нэгж нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 18.6.3-т заасан (хүүгийн орлого) нийт дүнгээс тус хуулийн 20.2.5-т заасан 5 хувийн хэмжээгээр татвар суутгана.

Гадаад улсын иргэн, хуулийн этгээд нь холбогдох хууль тогтоомжид заасны дагуу татвар төлөх үүрэг хүлээх бөгөөд тухайн харьяаллын улстай давхар татварын гэрээ байгуулсан эсэх болон гэрээний нөхцөлийг судлан үзсэний үндсэн дээр хөрөнгө оруулахыг зөвлөж байна.

#### 9.4 Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа

Үнэт цаасыг анх удаа нийтэд санал болгох ажиллагаа амжилттай болсон тохиолдолд МХБ-ийн журмын дагуу СЗХ-ны зөвшөөрлөөр үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлнэ. Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээр хувьцааг анхдагч зах зээлээс худалдан авсан хөрөнгө оруулагчид хувьцаагаа бусдад худалдаалах эрх нээлттэй болно.

#### 9.5 Үнэт цаасны арилжаа, хүүгийн төлбөр

Үнэт цаасны эргэн төлөлтийн эх үүсвэр нь ТЗК-д шилжсэн 9.0 тэрбум төгрөг хүртэлх үнийн дүн бүхий автомашины фидуци бүхий зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийн эргэн төлөлтөөс бүрдэнэ.

#### 9.6 Үнэт цаас эзэмшигчийн эрх, үүрэг

Үнэт цаас эзэмшигч нь дараах эрхтэй байна:

- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг МХБ-ийн арилжааны журмын дагуу худалдан авснаар үнэт цаасыг эзэмшилдээ шилжүүлэн авах, түүнийг шаардах эрхтэй;
- Эзэмшиж буй үнэт цаасыг чөлөөтэй арилжих, захиран зарцуулах;
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хүү болон үндсэн төлбөрийг хуваарийн дагуу хүлээн авах, төлбөрийг хуваарийн дагуу төлөхийг үнэт цаас гаргагчаас шаардах;
- Үнэт цаас эзэмших эрхээ чөлөөтэй арилжаалах, захиран зарцуулах;
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас эзэмшиж буй хугацаанд Үнэт цаас гаргагчийн санхүүгийн болон үйл ажиллагааны мэдээллийг хүлээн авах, шаардах, танилцах;
- Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны танилцуулгад тусгасан үүргээ зохих ёсоор биелүүлээгүй бол биелүүлэхийг шаардах;
- Үнэт цаасны танилцуулга болон холбогдох хууль тогтоомжид заасан үндэслэлээр хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасыг буцаан худалдах санал гаргах;
- Хууль тогтоомжид заасан бусад.


#### 9.7 Үнэт цаас гаргагчийн эрх, үүрэг

Үнэт цаас гаргагч нь дараах эрх үүрэгтэй байна.


- Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан хүү болон үндсэн төлөлтийн график, схемийн дагуу төлбөрийг хуваарийн дагуу төлөлт хийж барагдуулах;







"Бэрс Эй Би Эс Плат ТЗК" ХХК



- Үнэт цаас гаргагч нь зохицуулах байгууллагуудын тогтоосон хүүгийн орлогын татварыг зохих хуулийн дагуу суутган үнэт цаас худалдан авагчид шилжүүлж, татварын төлбөрийг төсөвт төлөх;
- Үнэт цаасны танилцуулга болон хууль, журмыг зөрчиж Үнэт цаас эзэмшигчид учруулсан аливаа хохирлыг Үнэт цаас гаргагч нь үл маргах журмаар нөхөн барагдуулах;
- Үнэт цаас гаргагч нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой аливаа үйл явцын мэдээллийг ТЗК-н баталсан хууль журмын дагуу Үнэт цаас эзэмшигчдэд болон эрх бүхий байгууллагад мэдээлэх;
- Хууль тогтоомж, энэхүү үнэт цаасны танилцуулгад заасан үндэслэлээр хөрөнгийн багцыг анхны үүрэг гүйцэтгүүлэгч, үүсгэн байгуулагч, худалдагчтай тохиролцон буцаан худалдах;
- Бусад хууль тогтоомж, гэрээнд тусгагдсан эрх, үүргийг хүлээнэ.





БЭРС  
-2 ХБҮЦ

АРАВ.ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДАД  
ТАЙЛАГНАХ

**10 ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДАД ТАЙЛАГНАХ**

**10.1 Хөрөнгө оруулагчдад танилцуулах мэдээллүүд, тэдгээрийн тайлангийн хугацаа**

Үнэт цаас гаргагч нь хөрөнгө оруулагч болон бусад оролцогч талуудад мэдээлэл хүргэхдээ Үнэт цаас гаргагчийн Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлэх журмыг баримтлах бөгөөд тус журам нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Санхүүгийн Зохицуулах Хороо болон МХБ-ээс гаргасан Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журамд нийцсэн байна.

**Үнэт цаас эзэмшигчдэд тайлан мэдээлэл түгээх нь**

Давтамж	Тайлагнах хугацаа	Тайлагнах мэдээлэл
Мэдээлэлд өөрчлөлт орсон бол	Дараа сарын 10-ны дотор хүргүүлнэ. Ингэхдээ СЗХ болон үнэт цаас эзэмшигчдэд цахим хэлбэрээр мэдээлнэ.	Төлбөр, зарлага, хөрөнгө оруулагчдад төлөх үнэт цаасны эргэн төлөлтөөс бусад хөрөнгө, хөрөнгө оруулалтаас олсон орлогын зарцуулалт, хөрөнгийн багцын мэдээлэл, тэдгээрийн шинж байдал, хөрөнгийн багцад нэмэгдсэн, хасагдсан хөрөнгө, нэмэх хасах болсон үндэслэл, шалтгаан, үнэт цаасны жигнэсэн дундаж хүү, эргэн төлөгдөх нөхцөл, үлдэгдэл хөрөнгийн тоо хэмжээ, төлөгдөөгүй хөрөнгийн үлдэгдэл болон зээлийн харьцаа, төлөгдсөн үндсэн зээл, үндсэн төлбөр, баталгаат үнэт цаасны үлдэгдэл, бэлэн мөнгөний төвлөрсөн хэмжээ, түүний ашиглалт, санхүүгийн үзүүлэлт, тоо баримтууд, улирлын санхүүгийн тайлан, хууль тогтоомж, энэ журам, ТЗК-ийн дүрэм, гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу мэдээлэх бусад.
Улирал тутам	Улирал бүрийн эхний сарын 20-ны өдрийн дотор хүргүүлнэ. Ингэхдээ СЗХ болон МХБ-д цахимаар, болон олон нийтэд биржийн цахим хуудсаар дамжуулан хүргэх бөгөөд компанийн цахим хуудсанд мөн тайлагнана.	Багцын хөрөнгө, мөнгөн урсгалын хөдөлгөөн, үнэт цаасны төлбөр, тооцоотой холбоотой Хороо болон хөрөнгө оруулагчдад хүргүүлсэн улирал тутмын тайлан, мэдээлэл зэрэг хамаарна.
Хагас жил тутам	СЗХ болон МХБ-д 7 сарын 20-ны дотор тайлагнана. Ингэхдээ МХБ, СЗХ-д бичгээр болон олон нийтэд биржийн хуудсанд дээр мөн компанийн цахим хуудсанд тайлагнана.	Хөрөнгийн багцын мэдээлэл, хагас жилийн санхүүгийн тайлан, төлбөр зарлага, хөрөнгө оруулалтын орлогын зарцуулалтын тайлан, хөрөнгө оруулагчид төлөх үнэт цаасны эргэн төлөлтөөс бусад хөрөнгө зэрэг орно
Жил тутам	СЗХ болон МХБ-д 4 дүгээр сарын 30-ны өдрийн дотор бичгээр болон цахимаар, олон нийтэд биржийн цахим хуудсаар дамжуулан хүргэх	Жилийн үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, ҮЦТ-д заасан хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэгч хөрөнгө итгэмжлэн удирдагчийн тайлан, хөрөнгийн багцад бүртгэгдсэн хөрөнгийн 5-аас дээш хувьтай тэнцэх хэмжээний үүрэг хүлээсэн үүрэг гүйцэтгэгч, зээлийн баталгаа гаргагчийн сүүлийн тайлангаас гарсан баталгаат үнэт цаас болон үүсгэн

<p>Тухай бүр тайлагнах</p>	<p>бөгөөд компанийн цахим хуудсанд түгээх үүрэгтэй.</p> <p>Холбогдох шийдвэр, өөрчлөлт гарсан, тухай үйл явдал болсноос хойш 3 хоногийн дотор СЗХ болон МХБ-д бичгээр олон нийтэд биржийн хуудсан дээр мөн компанийн цахим хуудсанд тайлагнана.</p> <p>ТЗК нь дараах мэдээллийг дараа улирлын 20-ны өдрийн дотор, өөрчлөлт орсон бол ажлын 3 хоногийн дотор тухай бүр Хороо болон хөрөнгө оруулагчид цахим хэлбэрээр мэдээлэх бөгөөд хагас жилийн болон жилийн эцсийн мэдээллийг Хороонд бичгээр ирүүлнэ</p> <p>Биржийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 9.7.2-д заасан мэдээлэлд өөрчлөлт орсон бол Биржид тус тус өөрчлөгдсөн тухай бүр ажлын 3 хоногт багтаан мэдэгдэнэ.</p>	<p>байгуулагчид мэдэгдсэн мэдэгдэл, санхүүгийн баримтын талаарх мэдээлэл.</p> <p>Үнэт цаасны үндсэн болон хүүгийн төлбөрийн мэдээлэл, төлбөрийн гүйцэтгэлд сөргөөр нөлөөлөх нөхцөл байдал үүсэх, хүүгийн төлбөрийг хугацаанд нь төлөөгүй тохиолдолд түүний шалтгаан, авах арга хэмжээний тухай;</p> <p>Хөрөнгийн багц, барьцааны зүйлийн нийт үнийн дүнгийн 10 хувь буюу түүнээс дээш хэмжээтэй өөрчлөлт орох;</p> <p>Бүртгэлтэй үнэт цаастай холбоотой аливаа өөрчлөлт (ХБҮЦ-ны нөхцөл, төлбөрийн хуваарь өөрчлөгдөх, гаргасан ХБҮЦ-ыг хугацаанаас нь өмнө буцаан дуудах, нэмэлт үнэт цаас гаргах гэх мэт)-ийн талаарх мэдээлэл;</p> <p>Бүртгэлтэй ХБҮЦ-ны 10 хувиас дээш үнийн дүн бүхий буцаан дуудсан, эргүүлэн худалдаж авсан үнэт цаасны мэдээлэл, цаашид 5 хувиар өөрчлөгдөх тутамд;</p> <p>ХБҮЦ гаргагчийн үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт, дүрэм, журам, хяналтын багц эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан, холбоо барих хаяг, байршил, утас зэрэгт өөрчлөлт орох;</p> <p>Үнэт цаас эзэмшигчдийн эрхэд өөрчлөлт оруулах, компанийн дүрэм, холбогдох гэрээ, журамд тэдгээрийн эрх ашигт нөлөөлөх нэмэлт өөрчлөлтийг тусгах;</p> <p>Үнэт цаас эзэмшигчдийн хурал зохион байгуулахаар шийдвэрлэсэн тохиолдолд хурал хуралдуулах тухай шийдвэр, хурлын мэдэгдэл, хурлаас гарсан шийдвэр;</p> <p>ХБҮЦ-ны харилцаанд оролцогч этгээд солигдох, бүтэц зохион байгуулалт өөрчлөгдөх, түүнтэй байгуулсан гэрээнд өөрчлөлт орох;</p> <p>Төлбөрийн чадваргүй болох, эсхүл бусад байдлаар шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа эхэлсэнтэй холбоотой мэдээлэл;</p> <p>Эрх бүхий байгууллагаас ХБҮЦ гаргагчид авсан арга хэмжээний тухай;</p> <p>Үнэт цаас эзэмшигчид, хөрөнгө оруулагчдын шийдвэр, ХБҮЦ гаргагчийн үйл ажиллагаа, үнэт цаасны үнэ ханшид нөлөөлөх, зах зээлийг урвуулан ашиглах, дотоод мэдээлэлд хамаарах бусад мэдээллүүд.</p>
----------------------------	---	---







**10.2. Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлэх журмын тухай**

“Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлэх журам”-д заасны дагуу Үнэт цаас гаргагч нь мэдээлэл хүргэхдээ Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны “Үнэт цаас гарагчийн мэдээллийн ил тод байдлын журам”, Монголын хөрөнгийн биржийн “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам” болон тус журамд заасны дагуу мэдээллийг цаг тухайд нь үнэн зөв, агуулгын хувьд хоёрдмол утгагүй, бүрэн гүйцэт мэдээлэх үүрэгтэй гэж заасан. Түүнчлэн Үнэт цаас гаргагч нь энэхүү Журамд заасан мэдээллийг Монгол хэл дээр хүргэх ба мэдээллийг олон нийт болон хөрөнгө оруулагч, үнэт цаас эзэмшигчид өөрийн болон Биржийн цахим хуудсаар хүргэнэ. Шаардлагатай гэж үзвэл гадаад хэл дээр мэдээллийг давхар хүргэж болно. “Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлэх журам”-ыг хавсралтаас дэлгэрэнгүй үзнэ үү.






БЭРС

-2 ХБҮЦ

АРВАН НЭГ. ҮНЭТ ЦААС ГАРГАХАД  
ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУД



### 11 ҮНЭТ ЦААС ГАРГАХАД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУД

#### Үнэт цаас гаргах үйл ажиллагаанд оролцогч байгууллагуудыг томилох тухай

Үнэт цаас гаргагч нь 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 22/24а/05 тоот ТУЗ-ийн тогтоолын дагуу үнэт цаас гаргах үйл ажиллагаанд оролцогч байгууллагуудыг томилсон байна. Тус тогтоолын дагуу Хуулийн зөвлөгөө үзүүлэгч байгууллагаар "Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН-ийг, Зээлийн шинжилгээ гаргагч байгууллагаар "Онч Аудит" ХХК-ийг, Хэлцлийн зөвлөх болон Хөрөнгө Итгэмжлэн Удирдагч байгууллагаар "Юнайтед Айр Файнэнс" ХХК-ийг, Хөндлөнгийн аудитораар "Ниямазон Аудит" ХХК-ийг тус тус сонгосон байна. ТУЗ-ийн тогтоолыг хавсралтаас харна уу.

#### 11.1 Андеррайтер



#### Голомт Капитал ҮЦК

Улсын бүртгэлийн дугаар	9011287134
Регистрийн дугаар	5481589
Үүсгэн байгуулагдсан огноо	2011.05.19
Үйл ажиллагааны чиглэл	Брокер, Дилер, Андеррайтер, Хөрөнгө оруулалтын зөвлөх, Номинал дансаар дамжуулан харилцагчдад үйлчилгээ үзүүлэх, Хөрөнгө оруулалтын зөвлөх, Үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө 24, Парк плэйс оффис, 403 тоот;
Хаяг	7012-1530
Утас	<a href="http://www.golomtcapital.com">www.golomtcapital.com</a>
Веб хуудас	<a href="mailto:info@golomtcapital.com">info@golomtcapital.com</a>
Цахим хаяг	С.Ган-Эрдэнэ
Гүйцэтгэх захирал	
ХБҮЦ дээр ажилласан туршлага	Нөмөр Кредит Ассет ХБҮЦ


Андеррайтертай байгуулсан гэрээ:

Голомт Капитал ҮЦК нь 2023 оны 02 сарын 09-ны өдөр 23/558 тоот Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээг Үнэт цаас гаргагчтай байгуулсан. Тус андеррайтерийн гэрээний хүрээнд Андеррайтер нь Үнэт Цаас Гаргагчид МХБ-с 9.0 тэрбум төгрөг хүртэлх хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасыг олон нийтэд санал болгох, худалдах ажлыг удирдан зохион байгуулах, хөрөнгийн зах зээлээс санхүүжилт татан төвлөрүүлэхэд шаардлагатай магадлан шинжилгээ, тооцоолол, судалгаа, бэлтгэл ажлуудыг гүйцэтгэх, боломжит хөрөнгө оруулагчдад Үнэт цаасыг танилцуулах, санал болгох, арилжих үйлчилгээг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн үзүүлэх зорилготой.





"Бэрс Эй Би Эр Плат ТЗК" ХХК-ийн зар өдөр



ТЗК нь үнэт цаас гаргах, түүний танилцуулга бэлтгэх, олон нийтэд хувьцааг санал болгох, хөрөнгө оруулагч татах үйл ажиллагааг мэргэжлийн өндөр түвшинд хэрэгжүүлэхийг Андеррайтераас шаардах эрхтэй. Мөн түүнчлэн үйл ажиллагааны явцын талаар бүрэн мэдээлэл авч, үр дүнд өөрийн зүгээс санал өгөх, Андеррайтераас санал болгосон хөрөнгө оруулагчтай гэрээ байгуулах, мөн тухайн хөрөнгө оруулалтыг хүлээн авахаас татгалзах боломжтой. Гэрээний бүрэн эхийг хавсралтаас үзэж танилцана уу.

### 11.2 Зээлийн шинжилгээ гаргагч



Онч Аудит ХХК

Улсын бүртгэлийн дугаар	9018001003
Регистрийн дугаар	2810743
Үүсгэн байгуулагдсан огноо	2006.06.28
Үйл ажиллагааны чиглэл	Аудитын үйл ажиллагаа, Улаанбаатар, Сүхбаатар, 1-р хороо, Ай Си Си цамхаг 15 давхар
Хаяг	7012-0450
Утас	<a href="http://www.onch.mn">www.onch.mn</a>
Веб хуудас	<a href="mailto:info@onch.mn">info@onch.mn</a>
Цахим хаяг	Д.Ончинсүрэн
Ерөнхий захирал	Бэрс ХБҮЦ
ХБҮЦ дээр ажилласан туршлага	Бичил Глобус ХБҮЦ


Зээлийн шинжилгээ гаргагчтай байгуулсан гэрээ:

Үнэт цаас гаргагчийн үнэт цаас гаргах, олон нийтэд санал болгох үнэт цаасны танилцуулгад тусгагдсан санхүүгийн мэдээлэл нь үнэн зөв эсэх, сонгогдсон зээлийн дансдууд санхүүгийн шалгуур үзүүлэлт хангасан эсэх талаарх дүгнэлт гаргуулахаар "Онч аудит" ХХК-тай Хамтран ажиллах гэрээг 2022 оны 11-р сарын 07-ны өдөр байгуулсан байна. Энэхүү гэрээгээр ажлын хамрах хүрээ, зээлийн шалгуур, хязгаарлалт, ажлын баг, цаг хугацаа болон үйлчилгээний хөлс, бизнес үйл ажиллагааны ерөнхий нөхцөл буюу талуудын хүлээх хариуцлага, үйлчилгээний төлбөр зэрэг бусад харилцааг зохицуулсан байна.

Онч Аудит ХХК нь 2022 оны 12-р сарын 26-ны өдрийн Сонгогдсон зээлүүдэд гүйцэтгэх харилцан тохиролцсон ажил үйлчилгээний үр дүнгийн тайланг гаргасан. Тайланг хавсралтаас үзнэ үү.







**Өмгөөллийн Эм Ди Эс Энд Хаанлекс ХНН**


Регистрийн дугаар	5495997
Үүсгэн байгуулагдсан огноо	2011.07.06
Үйл ажиллагааны чиглэл	Хууль зүйн зөвлөгөө өгөх
Хаяг	Улаанбаатар, Сүхбаатар, 8-р хороо, Сүхбаатарын талбай 2 Сэнтрал тауэр 13 давхар 1301
Утас	330048
Веб хуудас	<a href="https://mdskhanlex.com">https://mdskhanlex.com</a>
Цахим хаяг	<a href="mailto:info@mdsa.mn">info@mdsa.mn</a>
Удирдах гишүүн	Д.Дүгэржав
ХБҮЦ дээр ажилласан туршлага	ЛэндМН актив ХБҮЦ Бэрс ХБҮЦ Инвескор Актив ХБҮЦ МИК актив 1-13, 21, 23, 24, 28, 29

**Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээ:**

Үнэт цаас гаргагчийн ХБҮЦ гаргах, Монголын Хөрөнгийн Биржээр нийтэд санал болгох үнэт цаасны танилцуулгад тусгагдсан хууль зүйн мэдээлэл нь үнэн зөв эсэх, сонгогдсон зээлийн дансдууд хуулийн шалгуур үзүүлэлт хангасан эсэх талаар хууль зүйн дүгнэлт гаргуулахаар “Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс” ХНН-тэй Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээг 2022 оны 11-р сарын 08-ны өдөр байгуулсан байна. Гэрээ нь нийтлэг үндэслэл, гэрээт ажил, гэрээний хугацаа, хуулийн зөвлөхийн эрх, үүрэг, үйлчлүүлэгчийн эрх, үүрэг, харилцах хүмүүс, хариуцлагын хязгаарлалт, гэрээг дуусгавар болгох, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл, бусад зүйл гэсэн 11 бүлгээс бүрдэх зохицуулалттай байна.

“Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс” ХНН нь 2023 оны 2-р сарын 05-ны өдрийн Д-23/27 тоот Автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас (ХБҮЦ) олон нийтэд нээлттэй санал болгох хүрээнд сонгогдсон зээлийн дансдын хуулийн шалгуур үзүүлэлтэд нийцсэн эсэх талаарх хуулийн хөндлөнгийн дүн шинжилгээний тайлан, 2023 оны 2-р сарын 13-ны өдрийн Д-23/28 тоот “Бэрс Эй Би Эс Плас ТЗК” ХХК-аас автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас (ХБҮЦ) гарган нийтэд санал болгохтой холбогдуулан бэлтгэсэн Хууль зүйн дүгнэлтийг тус тус гаргасан. Тайлан, дүгнэлтийг хавсралтаас үзнэ үү.





### 11.4 Хөрөнгө итгэмжлэн удирдагч



### "ЮНАЙТЕД АЙР ФАЙНЭНС" ХХК

Регистрийн дугаар	2870657
Үүсгэн байгуулагдсан огноо	2021.09.16
Үйл ажиллагааны чиглэл	Хөрөнгө итгэмжлэн удирдах
Хаяг	Улаанбаатар, Сүхбаатар, 8-р хороо, СТӨ-ний 10 давхарт 1005 тоот
Утас	7012-2346
Веб хуудас	<a href="http://www.uaf.mn">www.uaf.mn</a>
Цахим хаяг	<a href="mailto:info@uaf.mn">info@uaf.mn</a>
Гүйцэтгэх захирал	Х.Маргад-Эрдэнэ
ХБҮЦ дээр ажилласан туршлага	Омни актив ХБҮЦ Симпл ассет ХБҮЦ Бэрс ХБҮЦ Нөмөр кредит ассет ХБҮЦ ЛэндМН актив ХБҮЦ Бичил Глобус ХБҮЦ

Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай байгуулсан гэрээ:

"Бэрс Эй Би Эс Плас ТЗК" ХХК, "Юнайтед Айр Файнэнс" ХХК нарын хооронд 2023 оны 02-р сарын 09-ний өдөр 23/563 тоот "Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ" байгуулагдсан байна. Тус гэрээ нь гэрээний тусгай нөхцөл, гэрээний ерөнхий нөхцөл, хавсралтаас бүрдсэн байна. Гэрээний дагуу Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т заасан үйлчилгээ үзүүлэх буюу Үнэт цаас гаргагчийн Хөрөнгийн багцыг итгэмжлэн удирдах, Үнэт цаас эзэмшигчдэд төлбөр төлөх, Үнэт цаас гаргагч нь Хөрөнгө итгэмжлэн удирдагчид үйлчилгээний хөлс төлөх холбоотой харилцааг зохицуулсан байна.

Хөрөнгө итгэмжлэн удирдагч компани нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон Үнэт цаас гаргагч компаниудтай ашиг сонирхлын зөрчилгүй болно. Түүнчлэн ХБҮЦ нь олон тооны бага дүнтэй зээлээс бүрдсэн тул зээлийн багцын орох урсгал болон үнэт цаасны төлөлтийн хяналтыг Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь программ ашиглан өдөр тутам хэрэгжүүлнэ.

Түүнчлэн Талууд 2023 оны 03-р сарын 02-ны өдрийн 23/535-01 тоот "Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай гэрээ"-гээр Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний 3.1.6 дахь заалтыг өөрчилсөн бөгөөд энэхүү өөрчлөлт нь хөрөнгө оруулагчдын эрх ашигт нийцэж байгаа болно.

Мөн Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь СЗХ-ноос баталсан тохиромжтой этгээдийн журмын шаардлагыг хангасан байна. Холбогдох баримт бичгийг хавсралтаас харна уу.



**11.5 Оролцогч байгууллагууд нь нэгдмэл сонирхол, бизнесийн холбоо хамааралтай эсэх талаарх мэдээлэл**











Үнэт цаас гаргах үйл ажиллагаанд оролцож буй доор дурдсан байгууллагууд нь холбогдох хууль, журам болон талуудын хооронд байгуулагдсан гэрээ, хэлцлийн хүрээнд Үнэт цаас гаргагч "Бэрс Эй Би Эс Плас ТЭК" ХХК болон үүсгэн байгуулагч "Бэрс Финанс ББСБ" ХХК нарт холбогдох мэргэжлийн үйлчилгээ үзүүлж буй бөгөөд эдгээр байгууллага нь Үнэт цаас гаргагч "Бэрс Эй Би Эс Плас ТЭК" ХХК болон үүсгэн байгуулагч "Бэрс Финанс ББСБ" ХХК нартай аливаа байдлаар нэгдмэл сонирхолгүй, энд дурдсанаас өөрөөр бизнесийн холбоо хамааралгүй болно. Үүнд:

1. Хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээ үзүүлэгч "Юнайтед Айр Файнэнс" ХХК
2. Зээлийн шинжилгээ гаргагч "Онч Аудит" ХХК
3. Хөндлөнгийн хуулийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч "Өмгөөллийн Эм Ди Эс Энд Хаанлекс" ХХН
4. Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэгч "Голомт Капитал ҮЦК" ХХК

Оролцогч байгууллагууд нь бизнесийн нэгдмэл сонирхол, холбоо хамааралгүй талаарх албан бичгүүдийг хавсралтаас харна уу.



Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан мэдээлэл үнэн зөв болохыг батлав:

<p>Овог нэр: <b>Б.Болор-Эрдэнэ</b></p> <p>Албан тушаал: Үнэт цаас гаргагч "Бэрс Эй Би Эс Плас ТЗК" ХХК -ийн ТУЗ-ийн дарга</p> <p>Гарын үсэг: </p> <p>          (Тамга/Тэмдэг)</p>	<p>Овог нэр: <b>Я.Оюумаа</b></p> <p>Албан тушаал: Үүгэн байгуулагч "Бэрс финанс ББСБ" ХХК -ийн ТУЗ-ийн дарга</p> <p>Гарын үсэг: </p> <p>          (Тамга/Тэмдэг)</p>
<p>Овог нэр: <b>Д.Ганхүрэл</b></p> <p>Албан тушаал: Үнэт цаас гаргагч "Бэрс Эй Би Эс Плас ТЗК" ХХК -ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн</p> <p>Гарын үсэг: </p> <p>          (Тамга/Тэмдэг)</p>	<p>Овог нэр: <b>С.Ган-Эрдэнэ</b></p> <p>Албан тушаал: "Голомт Капитал ҮЦК" ХХК -ийн Гүйцэтгэх захирал</p> <p>Гарын үсэг: </p> <p>          (Тамга/Тэмдэг)</p>
<p>Овог нэр: <b>С.Отгонбат</b></p> <p>Албан тушаал: Үнэт цаас гаргагч "Бэрс Эй Би Эс Плас ТЗК" ХХК -ийн ТУЗ-ийн гишүүн</p> <p>Гарын үсэг: </p> <p>          (Тамга/Тэмдэг)</p>	<p><i>(This cell is crossed out with a large diagonal line)</i></p>







БЭРС

-2 ХБҮЦ

ХАВСРАЛТ



№ 23/24а/02

### Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76-р зүйлийн 76.1.5 дахь заалт, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 10-р зүйлийн 10.1 дэх заалт, 11-р зүйлийн 11.1 дэх заалт, 12-р зүйлийн 12.11.2 дахь заалт, “Бэрс Эй Би Эс Плас ТЗК” ХХК (РД:6949886) (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 4-р зүйлийн 4.4.4.11 дэх заалтыг тус тус үндэслэн Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. “Бэрс Эй Би Эс Плас ТЗК” ХХК нь 9,000,000,000 (есөн тэрбум) төгрөг хүртэл нийт дүнтэй, нэг бүр нь 100,000 (нэг зуун мянга) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 90,000 (ерэн мянга) ширхэг хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасыг Монголын хөрөнгийн бирж дээр нийтэд санал болгон гаргасугай.

2. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны ерөнхий нөхцөлийг Хавсралт 1-р, Автомашинны фидуци бүхий хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны хөрөнгийн багцын зээлийн данслын мэдээлэл, жагсаалтыг Хавсралт 2-р, Зээлийн хөрөнгийн багцад тавигдах хуулийн шалгуурыг Хавсралт 3-р, Зээлийн хөрөнгийн багцад тавигдах санхүүгийн шалгуурын Хавсралт 4-р тус тус баталсугай.

3. Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасыг Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид бүртгүүлэх, үнэт цаасыг бүртгэсний дараа Багцын хөрөнгийн барьцааны болон Зээлийн төлбөр хүлээн авах дансны барьцааны гэрээг хөдлөх эд хөрөнгийн барьцааны цахим санд бүртгүүлэх зэргээр энэхүү тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулахыг Үйлчилгээ үзүүлэгч буюу “Бэрс финанс ББСБ” ХХК (С.Отгонбат)-д, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг “Бэрс Эй Би Эс Плас ТЗК” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.

### ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД:

ТУЗ-ИЙН ДАРГА


ТУЗ-ИЙН ГИШҮҮН

ТУЗ-ИЙН ГИШҮҮН


Б.БОЛОР-ЭРДЭНЭ

С.ОТГОНБАТ

Д.ГАНХҮРЭЛ



**"БЭРС ЭЙ БИ ЭС ПЛАС ТЭК" ХХК-ИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**



2023 оны 02 дугаар сарын 09-ний өдөр Дугаар 01

Улаанбаатар хот

"Бэрс Эй Би Эс Плас ТЭК" ХХК (шашил "Компани" гэх)-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал 2023 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 09:00 цагт Сүхбаатар дүүрэг, 11-р хороо, 7-р хороолол, Ногоон нуур, 101 барилга, 706 тоот хаягт 100 хувийн ирштэй хуралдав.

**Хуралд оролцсон:**

- |                           |                |
БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 11-р хороо,  
7-р хороолол, Ногоон нуурын гудамж, Прован офис,  
7 давхарт 706 тоот. Утас: +976 7000-2020  
www.bichilglobus.mn | info@bichilglobus.mn

2023.03.03 № 17/107

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

СЭХ  
БҮРТГЭВ  
№ 1

### САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНД

Галбаатарын Юмсүрэн (РД:ДО87051814) нь 2011 оны 07-р сарын 16-ны өдрөөс тус компанид Эдийн засагч, 2013 оны 01-р сарын 02-ны өдрөөс Ахлах эдийн засагч, 2013 оны 01-р сарын 17-ны өдрөөс Салбарын эрхлэгч, 2015 оны 10-р сарын 06-ны өдрөөс Хяналт, эрсдэл хариуцсан захирал, 2017 оны 05-р сарын 01-ний өдрөөс Зээлийн хэлтсийн захирал, 2019 оны 12-р сарын 11-ний өдрөөс Дотоод хяналтын газрын захирал албан тушаалд тус тус томилогдон өнөөдрийг хүртэл тогтвор суурьшилтай жиллаж байна.

Хүндэтгэсэн,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



С.ОТГОНБАТ

№ А5 170179

ТӨРИЙН МЭДЭЭЛЛИЙН САНГААС ГАРАХ  
ЛАВЛАГАА, ТОДОРХОЙЛОЛТЫН  
НЭГДСЭН МАЯГТ



2023 оны 3-р сарын 2-ны өдөр

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Даргын 2019  
оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн 84 дүгээр  
тушаалаар батлагдсан журмын 3 дугаар хавсралт

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР  
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ ТӨЛӨЛТИЙН ТАЛААРХ  
ТОДОРХОЙЛОЛТ

ДААТГУУЛАГЧ

Овог: Галбаатар Нэр: ЮМСҮРЭН Регистр: Д087051814

#	Хэлтсийн нэр	Ажил олгогчийн код	Ажил олгогчийн нэр	Он	Сар	Даатгуулагчийн цалин	Даатгуулагчийн төлөх шимтгэл	Ажил олгогч шимтгэл төлсөн эсэх
1	Хан-Уул дүүрэг	260021524	БЭРС ФИНАНС ББСБ ХХК	2022	1	28,094,455.00	3,994,806.88	Төлсөн
2	Хан-Уул дүүрэг	260021524	БЭРС ФИНАНС ББСБ ХХК	2022	2	2,800,000.00	672,000.00	Төлсөн
3	Хан-Уул дүүрэг	260021524	БЭРС ФИНАНС ББСБ ХХК	2022	3	3,050,000.00	732,000.00	Төлсөн
4	Хан-Уул дүүрэг	260021524	БЭРС ФИНАНС ББСБ ХХК	2022	4	3,050,000.00	732,000.00	Төлсөн
5	Хан-Уул дүүрэг	260021524	БЭРС ФИНАНС ББСБ ХХК	2022	5	2,911,364.00	698,727.36	Төлсөн
6	Хан-Уул дүүрэг	260021524	БЭРС ФИНАНС ББСБ ХХК	2022	6	8,039,013.00	1,487,876.63	Төлсөн
7	Хан-Уул дүүрэг	260021524	БЭРС ФИНАНС ББСБ ХХК	2022	7	1,390,441.00	333,705.85	Төлсөн
8	Хан-Уул дүүрэг	260021524	БЭРС ФИНАНС ББСБ ХХК	2022	8	3,050,000.00	732,000.00	Төлсөн
9	Хан-Уул дүүрэг	260021524	БЭРС ФИНАНС ББСБ ХХК	2022	9	2,911,364.00	698,727.36	Төлсөн
10	Хан-Уул дүүрэг	260021524	БЭРС ФИНАНС ББСБ ХХК	2022	10	1,663,636.00	399,272.64	Төлсөн
11	Хан-Уул дүүрэг	260021524	БЭРС ФИНАНС ББСБ ХХК	2022	11	3,013,690.00	723,285.60	Төлсөн
12	Хан-Уул дүүрэг	260021524	БЭРС ФИНАНС ББСБ ХХК	2022	12	4,050,000.00	972,000.00	Төлсөн
13	Хан-Уул дүүрэг	260021524	БЭРС ФИНАНС ББСБ ХХК	2023	1	3,050,000.00	732,000.00	Төлөөгүй





6КТУ-652Н-  
LQAX-ZWNM

Тодорхойлолтын хүчинтэй хугацаа: 2023-04-01 (30 хоног)  
Хүсэлт гаргасан хэлбэр: Төрийн үйлчилгээний цахим систем

ХҮР Төрийн мэдээллийн системийн үйлчилгээний систем

Энэхүү тодорхойлолт дахь мэдээллийн үнэн зөв эсэхийг <https://e-mongolia.mn>  
холбоосоор эрх бүхий ятгээд наавтран орж шалгах боломжтой.



**БЭРС ФИНАНС**

БАНК БҮС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 11-р хороо,  
7-р хороолол, Ногоон нуурын гудамж, Прован офис,  
7 давхарт 706 тоот. Утас: +976 7000-2020  
www.bichilglobus.mn | info@bichilglobus.mn

2023.03.03 № 17/108

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**САНХҮҮГИЙН  
ЗОХИЦУУЛАХ ХОРООНД**

Бямбаагийн Тамир (РД:НЙ88111704) нь 2015 оны 05-р сарын 26-ны өдрөөс тус компанид Кассын нярав, 2015 оны 10-р сарын 16-ны өдрөөс Нягтлан бодогч, 2019 оны 12-р сарын 06-ны өдрөөс Ахлах нягтлан бодогч, 2021 оны 03-р сарын 01-ний өдрөөс Ерөнхий нягтлан бодогч албан тушаалд тус тус томилогдон өнөөдрийг хүртэл тогтвор суурьшилтай ажиллаж байна.

Хүндэтгэсэн,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



С.ОТГОНБАТ

№ А5 170180



ТӨРИЙН МЭДЭЭЛЛИЙН САНГААС ГАРАХ  
ЛАВЛАГАА, ТОДОРХОЙЛОЛТЫН  
НЭГДСЭН МАЯГТ

2023 оны 3-р сарын 2-ны өдөр

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2019  
оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн 84 дүгээр  
тушаалаар батлагдсан журмын 3 дугаар хавсралт

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР  
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ ТӨЛӨЛТИЙН ТАЛААРХ  
ТОДОРХОЙЛОЛТ

ДААТГУУЛАГЧ

Овог: Бямбаа Нэр: ТАМИР Регистр: НЙ88111704

№	Хэлтсийн нэр	Ажил олгогчийн код	Ажил олгогчийн нэр	Он	Сар	Даатгуулагчийн цалин	Даатгуулагчийн төлөх шимтгэл	Ажил олгогч шимтгэл төлсөн эсэх
1	Хан-Уул дүүрэг	260021524	БЭРС ФИНАНС ББСБ ХХК	2022	1	12,676,602.00	2,067,575.25	Төлсөн
2	Хан-Уул дүүрэг	260021524	БЭРС ФИНАНС ББСБ ХХК	2022	2	2,638,044.00	633,130.56	Төлсөн
3	Хан-Уул дүүрэг	260021524	БЭРС ФИНАНС ББСБ ХХК	2022	3	2,723,716.00	653,691.84	Төлсөн
4	Хан-Уул дүүрэг	260021524	БЭРС ФИНАНС ББСБ ХХК	2022	4	2,549,922.00	611,981.28	Төлсөн
5	Хан-Уул дүүрэг	260021524	БЭРС ФИНАНС ББСБ ХХК	2022	5	4,576,526.00	1,055,065.75	Төлсөн
6	Хан-Уул дүүрэг	260021524	БЭРС ФИНАНС ББСБ ХХК	2022	6	2,429,211.00	583,010.65	Төлсөн
7	Хан-Уул дүүрэг	260021524	БЭРС ФИНАНС ББСБ ХХК	2022	7	3,257,384.00	781,772.16	Төлсөн
8	Хан-Уул дүүрэг	260021524	БЭРС ФИНАНС ББСБ ХХК	2022	8	1,867,725.00	448,254.01	Төлсөн
9	Хан-Уул дүүрэг	260021524	БЭРС ФИНАНС ББСБ ХХК	2022	9	2,711,964.00	650,871.36	Төлсөн
10	Хан-Уул дүүрэг	260021524	БЭРС ФИНАНС ББСБ ХХК	2022	10	2,746,982.00	659,278.68	Төлсөн
11	Хан-Уул дүүрэг	260021524	БЭРС ФИНАНС ББСБ ХХК	2022	11	3,129,600.00	751,104.00	Төлсөн
12	Хан-Уул дүүрэг	260021524	БЭРС ФИНАНС ББСБ ХХК	2022	12	3,622,667.00	869,440.09	Төлсөн



NLST-64AD-  
LQR0-KUX

Тодорхойлолтын хүчинтэй хугацаа: 2023-04-01 (30 хоног)  
Хүсэлт гаргасан хэлбэр: Төрийн үйлчилгээний цахим систем

ХҮР ТӨРИЙН МЭДЭЭЛЛИЙН  
ОЛГОЛГОМЖИЙН СИСТЕМ

Энэхүү тодорхойлолт дахь мэдээллийн үнэн зөв эсэхийг <https://e-mongolia.mn>  
холбоосоор эрх бүхий этгээд нэвтрэн орж шалгах боломжтой.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ  
MONGOLIAN STOCK EXCHANGE  
2023-04-06  
БҮРТГЭЭ-02



**БЭРС ФИНАНС**  
БАНК БҮГ САНХҮҮГИЙН БАЙГУУЛАГА

Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 11-р хороо,  
7-р хороолол, Ногоон нуурын гудамж, Прован офис,  
7 давхарт 706 тоот. Утас: +976 7000-2020  
www.bichiglobus.mn | Info@bichiglobus.mn

2023.03.03 № 17/109  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

СЭЖ  
БҮРТГЭЭ  
№ 01

**САНХҮҮГИЙН  
ЗОХИЦУУЛАХ ХОРООНД**



Доржбалын Урангоо (РД:ЕС83011907) нь 2016 оны 12-р сарын 05-ны өдрөөс тус компанид Хянагч нягтлан бодогч, 2017 оны 11-р сарын 12-ны өдрөөс Санхүүгийн хэлтэст Мэргэжилтэн, 2020 оны 07-р сарын 03-ны өдрөөс Санхүү бүртгэлийн газарт Нягтлан бодогч албан тушаалд тус тус томилогдон өнөөдрийг хүртэл тогтвор суурьшилтай ажиллаж байна.

Хүндэтгэсэн,  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



С.ОТГОНБАТ

№ А5 170178



# ТӨРИЙН МЭДЭЭЛЛИЙН САНГААС ГАРАХ ДАВЛАГАА, ТОДОРХОЙЛОЛТЫН НЭГДСЭН МАЯГТ

2023 оны 3-р сарын 2-ны өдөр

Зэвсгийн газрын Хэрэг эрхлэх газрын Даргын 2019  
оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн 84 дүгээр  
тушаалаар батлагдсан журмын 3 дугаар хавсралт

## НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ ТӨЛӨЛТИЙН ТАЛААРХ ТОДОРХОЙЛОЛТ

### ДААТГУУЛАГЧ

Овог: Доржбал Нэр: УРАНГОО Регистр: EC83011907

#	Халтсын нэр	Ажил олгогчийн код	Ажил олгогчийн нэр	Он	Сар	Даатгуулагчийн цалин	Даатгуулагчийн төлөх шимтгэл	Ажил олгогч шимтгэл төлсөн эсэх
1	Хан-Уул дүүрэг	260021524	БЭРС ФИНАНС ББСБ ХХК	2022	1	11,751,818.00	1,951,977.25	Төлсөн
2	Хан-Уул дүүрэг	260021524	БЭРС ФИНАНС ББСБ ХХК	2022	2	1,759,722.00	422,333.28	Төлсөн
3	Хан-Уул дүүрэг	260021524	БЭРС ФИНАНС ББСБ ХХК	2022	3	1,714,737.00	411,536.89	Төлсөн
4	Хан-Уул дүүрэг	260021524	БЭРС ФИНАНС ББСБ ХХК	2022	4	1,775,571.00	426,137.05	Төлсөн
5	Хан-Уул дүүрэг	260021524	БЭРС ФИНАНС ББСБ ХХК	2022	5	4,509,815.00	1,046,726.88	Төлсөн
6	Хан-Уул дүүрэг	260021524	БЭРС ФИНАНС ББСБ ХХК	2022	6	1,242,039.00	298,089.37	Төлсөн
7	Хан-Уул дүүрэг	260021524	БЭРС ФИНАНС ББСБ ХХК	2022	7	2,388,235.00	573,176.41	Төлсөн
8	Хан-Уул дүүрэг	260021524	БЭРС ФИНАНС ББСБ ХХК	2022	8	1,334,091.00	320,181.85	Төлсөн
9	Хан-Уул дүүрэг	260021524	БЭРС ФИНАНС ББСБ ХХК	2022	9	1,257,955.00	301,909.21	Төлсөн
10	Хан-Уул дүүрэг	260021524	БЭРС ФИНАНС ББСБ ХХК	2022	10	2,044,176.00	490,602.24	Төлсөн
11	Хан-Уул дүүрэг	260021524	БЭРС ФИНАНС ББСБ ХХК	2022	11	2,096,131.00	503,071.45	Төлсөн
12	Хан-Уул дүүрэг	260021524	БЭРС ФИНАНС ББСБ ХХК	2022	12	2,708,333.00	649,999.93	Төлсөн
13	Хан-Уул дүүрэг	260021524	БЭРС ФИНАНС ББСБ ХХК	2023	1	2,548,800.00	611,712.00	Төлөөгүй



GBAK-7RM3-  
TGEX-KV1P

Тодорхойлолтын хүчинтэй хугацаа: 2023-04-01 (30 хоног)  
Хүсэлт гаргасан хэлбэр: Төрийн үйлчилгээний цахим систем

ХҮР ТӨРИЙН МЭДЭЭЛЛИЙН  
СОЛБООСООР СИСТЕМ

Энэхүү тодорхойлолт дахь мэдээллийн үнэн зөв эсэхийг <https://e-mongolia.mn>  
холбоосоор эрх бүхий этгээд нэвтрэн орж шалгах боломжтой.



Санхүүгийн зохицуулах хорооны  
Компанийн засаглалын шинэ кодексыг хэрэгжүүлэхтэй  
холбоотой холбогдох журмуудыг батлах тухай

Компанийн тухай хуулийн 76.1.13 дахь заалтыг удирдлага болгон “Бэрс финанс  
ББСБ” ХХК (цаашид “Компани” гэх)-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит бус хурлаас  
ТОГТООХ НЬ:

1. Санхүүгийн Зохицуулах Хорооны 145-р тогтоолоор 2022 оны 03-р сарын 23-ны өдөр  
шинэчлэн баталсан “Компанийн засаглалын кодекс”-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд  
мөрдөх дараах бодлогын бичиг баримт, журмуудыг хавсралтаар тус тус баталсугай. Үүнд:


- 1.1. ТУЗ-ийн үйл ажиллагааны журмыг энэ тогтоолын хавсралт 1-р;
- 1.2. ТУЗ-ийн дэргэдэх Хороодын журмыг энэ тогтоолын хавсралт 2-р;
- 1.3. Дотоод хяналт, аудитын журмыг энэ тогтоолын хавсралт 3-р;
- 1.4. Эрсдэлийн удирдлагын журмыг энэ тогтоолын хавсралт 4-р;
- 1.5. Аудиторыг сонгох журмыг энэ тогтоолын хавсралт 5-р;
- 1.6. Залгамж халааны бодлогыг энэ тогтоолын хавсралт 6-р;
- 1.7. Ил тод байдлын журмыг энэ тогтоолын хавсралт 7-р;
- 1.8. Оролцогч талуудтай хамтран ажиллах журмыг энэ тогтоолын хавсралт 8-р;
- 1.9. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журмыг энэ тогтоолын хавсралт 9-р;
- 1.10. Сонирхлын зөрчилтэй хэлцлийг зохицуулах журмыг энэ тогтоолын хавсралт  
10-р;
- 1.11. Хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргэх журмыг энэ тогтоолын хавсралт 11-р;
- 1.12. Шүгэл үлээх журмыг энэ тогтоолын хавсралт 12-р;
- 1.13. Ёс зүйн дүрмийг энэ тогтоолын хавсралт 13-р тус тус баталсугай.

2. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан шаардлагатай арга хэмжээ авч  
ажиллах эрхийг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга (Я.Оюумаа)-д олгосугай.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Компанийн Төлөөлөн  
Удирдах Зөвлөлд даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

  
Я. ОЮУМАА



“Бэрс Финанс ББСБ” ХХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 01-р сарын  
04- ний өдрийн 23/01а/01 тоот тогтоолын Хансралт I

**“БЭРС ФИНАНС ББСБ” ХХК-НИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ  
АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ**




**Нэг. Ерөнхий зүйл**

1.1. Энэхүү журмын зорилго нь компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн /цаашид ТУЗ/ бүрэн эрх, гүүний бүрэлдэхүүн, гишүүдэд тавигдах шаардлага, сонгох, хугацаанаас өмнө чөлөөлөх журам, дарга, гишүүд, нарийн бичгийн даргын эрх үүрэг, хариуцлага, ТУЗ-ийн хуралд бэлдэх, зарлах, хуралдуулах, үйл ажиллагаанд дүгнэлт огох зэрэг харицааг зохицуулахад оршино.

**Хоёр. ТУЗ-ийн бүрэн эрх**

- 2.1 Компанийн ТУЗ нь Компанийн тухай хууль, Монголын компанийн засаглалын кодекст заасны дагуу дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
- 2.1.1 Компанийн гүйцэтгэх захирлыг сонгох, өөрчлөх
  - 2.1.2 Гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээний нөхцөл, бүрэн эрх, олгох шагнал, урамшуулал, хариуцлагын хэмжээг тогтоох;
  - 2.1.3 Гүйцэтгэх удирдлагын бүтэц, зохион байгуулалт, орон тоог батлах
  - 2.1.4 Гүйцэтгэх удирдлагын багаас боловсруулсан төслийг үндэслэн компанийн стратеги, дунд, богино хугацааны бизнес төлөвлөгөө, төсвийг батлах;
  - 2.1.5 Компанийн ажиллагсдын цалин хөлс, урамшуулал, ажиллагсдын нийгмийн асуудлыг зохицуулах журмыг хэлэлцэж батлах
  - 2.1.6 Компанийн улирал, хагас жил, жилийн үйл ажиллагааны тайланг хэлэлцэх, Гүйцэтгэх захиралд үүрэг даалгавар, чиглэл өгөх
  - 2.1.7 Аудитын байгууллагыг сонгох, гэрээ байгуулах
  - 2.1.8 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах, эчнээ санал хураалт явуулах шийдвэр гаргах;
  - 2.1.9 **Дараах асуудлуудыг хэлэлцэн зөвшөөрсөн тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулан хэлэлцүүлнэ:**
    - 2.1.9.1 Компанийг өөрчлөн байгуулах санал, төсөл;
    - 2.1.9.2 Компанийг татан буулгах, татан буулгах комисс байгуулах болон татан буулгахтай холбогдох бусад асуудал;
    - 2.1.9.3 Жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх гүйцэтгэх захирлын тайланг хэлэлцэж, дүгнэлт гаргах;
    - 2.1.9.4 Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх төсөл;
    - 2.1.9.5 Хувьцааг хуваах нэгтгэх, төсөл;
    - 2.1.9.6 Нийт гишүүд нь тухайн хэлцэлд ашиг сонирхлын зөрчилтэй байх, эсхүл тухайн хэлцэлийн хувьд сонирхлын зөрчилгүй гишүүдийн дотор хараат бус гишүүн байхгүй байгаагийн улмаас сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах боломжгүй болсон үед тухайн хэлцлийг батлах эсэхийг шийдвэрлүүлэх;
    - 2.1.9.7 Их хэмжээний хэлцэл хийх тухай шийдвэрийг ТУЗ-ийн бүх гишүүд санал нэгтгэй шийдвэрлэж чадаагүй бол уг хэлцлийг батлах эсэхийг шийдвэрлүүлэх;
    - 2.1.9.8 ХЭХ-ын журмын төсөл;
    - 2.1.9.9 ТУЗ-ийн гишүүдийн цалин хөлс, урамшууллыг шийдвэрлүүлэх;

**2.2 Компанийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:**



- 2.2.1 Компанийн бизнес төлөвлөгөө, төсвийг батлах;
- 2.2.2 Энэ журмын 2.1.4-д заасан төлөвлөгөө төсвийн хэрэгжилтийг хянах тогтолцоо бүрдүүлж, хэрэгжилтийн талаар жил бүр хэлэлцэж, холбогдох арга хэмжээ авч байх;
- 2.2.3 Энэ журмын 2.1.4-д заасан төлөвлөгөөнд шинэ төсөл хөтөлбөр, шинэ бүтээгдэхүүнд хоронго оруулахаар тусгасан бол тэдгээрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах;
- 2.2.4 Компанийн үнэт цаасыг нийтэд санал болгон нээлттэй, тодорхой этгээдэд санал болгон хаалттай хүрээнд гаргах, зээл авах, гадаад дотоодын хоронго оруулагчтай хамтарсан компани байгуулах зэрэг асуудлаар шийдвэр гаргах
- 2.2.5 Компанийн эрсдэлийн удирдлагын бодлогыг тодорхойлох, эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааг зохицуулах дүрэм журмыг батлах

**2.3 Компанийн эд хоронго, үнэт цаас, нэгдэл ашигтай холбоотой дараах шийдвэрийг гаргана:**

- 2.3.1 Зарласан хувьцааны тоо, төрөлд багтаан хувьцааг гүйлгээнд гаргах шийдвэр гаргах;
- 2.3.2 Компанийн дүрэмд заасан тохиолдолд бонд, опцион зэрэг үнэт цаасыг гаргах тухай шийдвэр гаргах;
- 2.3.3 Компанийн тухай хуулийн 56 дугаар зүйлд заасны дагуу эд хөрөнгийн болон эд хоронгийн эрхийн тухайлбал, хувьцааг гаргах үнэ зэрэг зах зээлийн үнийг тогтоох;
- 2.3.4 Өөрийн гаргасан хувьцаа болон бусад үнэт цаасыг эргүүлэн худалдаж авах шийдвэр гаргах;

**2.4 Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааг чиглүүлэх талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:**

- 2.4.1 ТУЗ-ийн байнгын болон тодорхой чиг үүргийг хэрэгжүүлэх түр хороодыг байгуулах, тэдгээрийн эрх үүргийг тогтоох;
- 2.4.2 Санхүүгийн болон бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар гүйцэтгэх захирлын тайланг жил, хагас жилээр тогтмол хэлэлцэж, тасалдал гарсан бол түүний шалтгаан цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар шийдвэр гаргах;
- 2.4.3 Гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээний нөхцөлийг тодорхойлж, гэрээ байгуулах эрх олгох;
- 2.4.4 Компанийн эрх бүхий албан тушаалтнуудаас тодорхой асуудлаар мэдээлэл авах, тайлан, дүгнэлт гаргуулах, хэлэлцэх;
- 2.4.5 Компанийн ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх талаар гүйцэтгэх захирлын эрх хэмжээнд хамаарахаас бусад асуудлыг шийдвэрлэх;
- 2.4.6 ТУЗ нь гүйцэтгэх удирдлага чиг үүргээ зохих ёсоор хэрэгжүүлж чадахгүй байна гэж дүгнэсэн бол ажлаас нь чөлөөлөх, шинэ удирдлагыг сонгох арга хэмжээ авна.

**2.5 Хяналтын тогтолцоо бүрдүүлэх талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:**

- 2.5.1 Компанийн эрсдэлийн удирдлага, комплайнс болон дотоод хяналтын тогтолцоог оновчтой зохион байгуулах, санхүүгийн үйл ажиллагаа, бизнесийн төлөвлөгөө, төсвийн гүйцэтгэлд мониторинг хийх тогтолцоо бүрдүүлэх;
- 2.5.2 Дотоод хяналтын тогтолцоог дараах чиглэлээр тасралтгүй иж бүрэн хяналт тавьдаг байхаар зохион байгуулах:
  - Компанийн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн үнэн зөв, бүрэн бүтэн байдлыг хангах, нягтлан бодох бүртгэл, аудитгийн олон улсын стандартыг нэвтрүүлэх;
  - Компанийн үйл ажиллагааг үр дүнтэй, зохистой зохион байгуулан явуулах;
  - Компанийн үйл ажиллагаа явуулж буй салбарт мөрдөгдөх хууль тогтоомж, дүрэм журмыг тасралтгүй мөрдөж хэвшүүлэх буюу комплайнс;
  - Компанийн эрсдэлийн удирдлагын тогтолцооны үр дүнтэй, зохистой байдлыг хангах;
  - Компанийн засаглалын дотоод журмуудын хэрэгжилтийг хангах.






- 2.5.3 Компанийн нийтэд хүргэх мэдээлэл нээлттэй байх, үйл ажиллагааны ил тод байдалд хяналт тавих;
- 2.5.3.1 Компанийн дотоод аудитор /дотоод аудитын алба/-ыг томилж, цалин урамшууллын хэмжээг тогтоох, гэрээний нөхцөлийг тодорхойлж, гэрээ байгуулах эрх олгох;
- 2.5.3.2 Хувьцаа эзэмшигчид болон ТУЗ-ийн зүгээс гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд хэт нөлөөлөхгүй байх зарчмыг мөрдүүлэх;
- 2.5.3.3 Компани санхүү, төлбөрийн чадварын болон зохистой харьцааны үзүүлэлтэд байнгын хяналт тавьж, төлбөрийн чадваргүй болохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах.
- 2.5.3.4 Хөндлөнгийн аудитын байгууллага болон зөвлөх этгээдийг сонгож, уг байгууллагатай байгуулах гэрээний нөхцөлийг тодорхойлж, гэрээ байгуулах эрх олгох;
- 2.5.3.5 Компанийн санхүү, аж ахуйн үйл ажиллагаа, тодорхой төсөл, хөгөлбөрийн хэрэгжилтийн чиглэлээр аудитыг томилж, аудитын шалгалт хийлгэх эсвэл зөвлөх экспертийн дүгнэлт гаргуулах.

#### Гурав. ТУЗ-ийн бүрэлдэхүүн гишүүдэд тавих шаардлага

- 3.1 Компанийн ТУЗ 5 гишүүнтэй байна. ТУЗ-ийн гишүүдийн 3 нь хувьцаа эзэмшигчдийг төлөөлсөн ердийн гишүүд, 2 нь хараат бус гишүүн байна.
- 3.2 Ердийн гишүүдийг нэр дэвшүүлэх этгээд нь нийт гаргасан хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчид байна.
- 3.3 Хараат бус гишүүнд нэр дэвшүүлэх ажиллагааг ТУЗ-ийн Нэр дэвшүүлэх хороо хариуцан зохион байгуулах бөгөөд энэхүү журмаар тогтоосон шалгуур шаардлагыг хангасан этгээдийг нийтэд нээлттэй зарлах замаар сонгон шалгаруулна.
- 3.4 Энэ журмын 3.2.1-д заасан эрх бүхий этгээдээс нэрийг нь дэвшүүлсэн этгээд нь ТУЗ-ийн ердийн гишүүн байх бөгөөд дараах шаардлага, шалгуурыг хангасан байна:
  - 3.4.1 Зээл, батлан даалт, баталгааны гэрээгээр хугацаа хэтэрсэн аливаа өргүй;
  - 3.4.2 Ял шийтгэлгүй;
  - 3.4.3 Ёс зүйн болон ажил хэргийн нэр хүнд нь компанийг удирдахад харшлахгүй;
  - 3.4.4 Дээд боловсролтой;
  - 3.4.5 5-аас доошгүй жил удирдах албан тушаал эрхэлсэн туршлагатай;
  - 3.4.6 Дампуурсан, төлбөрийн чадваргүй болсон хуулийн этгээдийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан байгаагүй;
  - 3.4.7 Өмнө нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуулиар тогтоосон хугацаанд хуралдуулаагүйгээс бүрэн эрх нь дуусгавар болсон компанийн ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх захирал байгаагүй;
  - 3.4.8 Өмнө нь компанийн ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байсан бол ТУЗ-ийн гишүүний үүргээ "хангалттай биелүүлсэн" гэсэн үнэлгээг Нэр дэвшүүлэх хорооноос өгсөн, компанийн нэр хүндэд болон санхүүгийн чадварт хохирол учруулах үйлдэл, эс үйлдэл гаргаж байгаагүй;
  - 3.4.9 Өөр банк санхүүгийн байгууллагад эрх бүхий албан тушаал хашдаггүй;
  - 3.4.10 Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон төхиромжтой этгээдийн шалгуурыг хангасан.
- 3.5 ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигч нь энэ журмын 3.3-т зааснаас гадна дараах шалгуур, шаардлагыг хангасан байна:
  - 3.5.1 Өөрөө эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч биш компанийн нэгдлийн аль нэг байгууллагад эрх бүхий албан тушаал хашдаггүй;
  - 3.5.2 Компанийн ТУЗ-ийн бусад гишүүн, гүйцэтгэх удирдлагын эрх бүхий албан тушаалтны холбогдох этгээд биш; *(Холбогдох этгээд гэдгийг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.30-д заасны дагуу тодорхойлно).*
  - 3.5.3 Өөрөө эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь компанийн нэгдлийн бусад компанид сүүлийн 3 жилийн хугацаанд эрх бүхий албан тушаалтан байгаагүй;





- 3.5.4 Компанийн нолоо бүхий бизнесийн түншүүдийн хамаардаг компанийн нэгдлийн аль нэг оролцогч хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан, нолоо бүхий хувьцаа эзэмшигч биш;
- 3.5.5 Санхүү, хоронго оруулалтын менежмент, аудит, бизнесийн эрх зүйн чиглэлээр мэргэшсэн
- 3.5.6 Өөрөө болон нэгдмэл сонирхолтой этгээд нь улс төрийн намын удирдах албан тушаал хашдаггүй;
- 3.5.7 Төрийн үйлчилгээнийхээс бусад төрийн албан хаагч биш;
- 3.5.8 Компанитай бизнесийн аливаа холбоогүй;
- 3.5.9 Компанийн ТУЗ-д сонгогдсон хүмүүс дахин нэр дэвшин сонгогдож болно.
- 3.5.10 Компанийн ТУЗ-д 10-аас дээш жил ажилласан хүнийг хараат бус гэж үзэхгүй.
- 3.5.11 ТУЗ-ийн гишүүд нь 3-аас илүү компанийн эрх бүхий албан тушаалд ажилладаггүй байна. Энэ нь компанийн ТУЗ-ийн гишүүний хувьд чиг үүргээ зохих ёсоор цаг зарцуулан ажиллах боломжийг хангахад чиглэнэ.
- 3.5.12 Эдний засгийн гэмт хэрэг үйлдсэн, төрийн болон орон нутгийн Засаг захиргааны эсрэг гэмт хэрэг үйлдсэн, бизнес, санхүү, татвар, хоронго оруулалтын үйл ажиллагаатай холбоотой зөрчил гаргаж, захиргааны шийтгэл хүлээсэн этгээдийг ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэхгүй.
- 3.5.13 ТУЗ-ийн Нарийн бичгийн даргаар ажиллаж байгаа хүнийг ТУЗ-ийн гишүүнээр сонгохгүй.

#### **Дорөв. ТУЗ-ийн бүрэн эрхийн хугацаа**

- 4.1 ТУЗ-ийн бүрэн эрхийн хугацаа 3 жил байна.
- 4.2 Жил бүрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-ийн үйл ажиллагааны болон өөрийн үнэлгээний тайланг заавал хэлэлцэнэ.
- 4.3 ТУЗ-ийн сонгууль явуулах хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын өмнө Нэр дэвшүүлэх хороо нь ТУЗ-ийн гишүүн нэг бүрийн үйл ажиллагаанд энэ журмын дагуу үнэлэлт дүгнэлт өгөх бөгөөд энэ дүгнэлтээр “хангалтгүй” үнэлгээ авсан гишүүнийг ТУЗ-д дахин нэр дэвшүүлэхгүй. Дэвшүүлсэн тохиолдолд Нэр дэвшүүлэх хороо уг хүний нэрийг “Санал хураах хуудас”-нд оруулахгүй.
- 4.4 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Компанийн тухай хуульд заасны дагуу жил бүрийн 5 дугаар сарын 1-ний дотор хуралдуулаагүй тохиолдолд дараагийн ТУЗ-ийг сонгох хувьцаа эзэмшигчдийн хуралд бэлдэх, түүнийг зарлах зохион байгуулахаас бусад бүрэн эрх дуусгавар болно.
- 4.5 Жил бүрийн ТУЗ-ийн үйл ажиллагааны дүгнэлтээр “хангалтгүй” үнэлгээ авсан, Компанийн дүрэм болон энэ журмаар тогтоосон үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, компанийн бизнесийн нэр хүнд, санхүүгийн чадварт хор хохирол учруулахаар үйлдэл, эс үйлдэл гаргасан, ТУЗ-өөс гаргаж буй шийдвэрт сонирхогч этгээд болохоо мэдэгдээгүй зэргээр зөрчил гаргасан ТУЗ-ийн гишүүнийг чөлөөлөх шийдвэрийг хувьцаа эзэмшигчдийн хурал хэднйд ч гаргах эрхтэй бөгөөд энэ шалтгаанаар ТУЗ-ийн гишүүдийн тоо 5-аас цөөн болсон тохиолдолд ТУЗ-ийн сонгох хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулна. ТУЗ-ийн 2-оос илүүгүй гишүүнийг энд заасан шалтгаанаар гишүүнээс чөлөөлөх болсон тохиолдолд дараагийн ээлжит хурал хүртэл хугацаагаар ТУЗ-ийн гишүүнээс чөлөөлөх асуудлыг ТУЗ өөрөө шийдвэрлэх эрхтэй бөгөөд энэ талаар Компанийн тухай хуулийн 77.5 болон 77.6-д заасныг баримтлана.
- 4.6 Удаан хугацаагаар үүргээ биелүүлэх боломжгүй болсон, ТУЗ-өөс чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан, нас барсан зэргээр ТУЗ-ийн гишүүний орон тоо гарсан бол энэ журмын 4.6-д заасны нэгэн адил нохон сонгоно.

#### **Тав. ТУЗ-ийн гишүүнийг сонгох журам**




- 5.1 ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшиж, жагсаалтад бүртгэгдсэн хүний нэрийг “Саналын хуудас”-нд оруулах бөгөөд энэ журмын 2-р хавсралтаар баталсан анкетыг хувьцаа эзэмшигчдийн хуралд зориулсан мэдээлэлд хавсаргана.
- 5.2 ТУЗ-ийн гишүүдийг санал хураах энгийн аргаар сонгоно. Энэ аргаар сонгууль явуулахад хувьцаа эзэмшигч бүр өөрийн эзэмшиж буй хувьцааны тоотой тэнцэх хэмжээний саналын эрхтэй байх бөгөөд саналын эрхээ өөрийн сонгохыг хүссэн 5-аас доошгүй, үүний дотор 2-оос доошгүй тооны хараат бус гишүүнд өгнө.
- 5.3 Санал хураалтаар 2-оос цөөнгүй хараат бус гишүүнийг сонгож чадаагүй бол ТУЗ нь бүрэн эрхээ хэрэгжүүлэх эрх зүйн чадваргүйд тооцогдох болно.
- 5.4 Энэ журмын 5.3-т заасан тохиолдолд ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдсанаас хойш ажлын таван өдөрт багтаан дараагийн хувьцаа эзэмшигчдийн хурлын товыг тогтоож, ТУЗ-ийн гишүүдийг сонгох асуудлыг дахин хэлэлцүүлнэ.

#### Зургаа. ТУЗ-ийн гишүүдийн үүрэг хариуцлага

- 6.1 ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшиж байгаа этгээд энэхүү журам, компанийн дүрмийг сайтар судалсан байх бөгөөд ТУЗ-ийн гишүүний хувьд үүргээ бүрэн биелүүлэх цаг, боломжтой эсэхээ сайтар тунгаан зөвшөөрөл олгоно.
- 6.2 ТУЗ-ийн гишүүнээр сонгогдсон тохиолдолд өөрийн үүргээ хариуцлагатай биелүүлэхийн тулд энэхүү журам, Компанийн дүрмээр тогтоосон үүргийг хэрэгжүүлэх талаар хүчин чармайлт гаргаж ажиллана гэдгээ бичгээр илэрхийлсэн байна.
- 6.3 ТУЗ-ийн болон ТУЗ-ийн хороодын хуралдаанд биеэр юмуу хэлэлцэх асуудал бүрт тодорхой санал тайлбартай бичгээр саналаа өгөх замаар оролцоно. Гадаадад болон орон нутагт ажиллаж, амарч эзгүй байгаа тохиолдолд ч хурлын материалыг цахим шуудангаар хүлээн авч дэлгэрэнгүй санал, тайлбартай хариу өгөх, хуралдааны явцад утсаар саналаа өгөх, zoom, google meet гэх мэт цахим сүлжээг ашиглан интернетээр оролцох ёстой. Хурлаар урьдчилан товлоогүй асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх шаардлага тулгарах учир боломжтой тохиолдолд биеэр оролцоход анхаарна.
- 6.4 ТУЗ-ийн гишүүн нь өөрийн цахим шуудангийн хаягийг ТУЗ-ийн нарийн бичгийн даргад албан ёсоор мэдэгдэж, хүргүүлсэн мэдээллийг хаягаараа тогтмол хүлээн авч, хариу өгдөг байна. Тодорхой бус ойлгомжгүй асуудлын талаар лавлагаа, тодруулгыг тухай бүр авч байна.
- 6.5 ТУЗ-ийн гишүүд сонирхлын зөрчлийг зохицуулах талаар хуулиар хүлээсэн үүргээ дараах байдлаар хэрэгжүүлнэ:
  - 6.5.1 Компанийн үйл ажиллагааны явцад хийж буй гэрээ хэлцэлд өөрөө болон холбогдох этгээд нь хэлцлийн нөгөө тал болж байгаа, төлөөлөгч, зуучлагчаар оролцож байгаа бол энэ тухайгаа ТУЗ-д мэдэгдэн уг хэлцлийг хийх тухай шийдвэр гаргахад оролцохгүй бөгөөд ингэхдээ дараах журмыг баримтлана:
    - 6.5.1.1 Тухайн асуудлаар сонирхлын зөрчилтэй болох тухайгаа болон сонирхлын зөрчил үүсч буй шалтгаанаа ТУЗ-ийн даргад хурал эхлэхээс өмнө бичгээр мэдэгдэх бөгөөд ТУЗ-ийн дарга мэдээллийг гишүүдэд уншиж танилцуулна.
    - 6.5.1.2 Асуудлыг хэлэлцэж эхлэх үед хуралдааны танхимыг орхиж гарах бөгөөд санал хурааж дууссаны дараа орж ирнэ.
    - 6.5.1.3 Хурлаар хэлэлцэж буй асуудлаар сонирхлын зөрчил бүхний гишүүн оролцох боломжгүй ч сонирхлын зөрчилтэй болох тухайгаа болон сонирхлын зөрчил үүсч буй шалтгаанаа ТУЗ-ийн даргад бичгээр мэдэгдсэн байна.
    - 6.5.1.4 Сонирхлын зөрчилтэй асуудлаа шийдвэрлүүлэх зорилгоор бусад гишүүдэд нөлөөлөх ямар нэг үйлдэл хийхийг хориглоно.
  - 6.5.2 ТУЗ-ийн гишүүний хувьд гаргасан шийдвэр, үйл ажиллагааны төлөө аливаа этгээдээс ямар нэг шагнал, шагналд тооцогдохоор үйлчилгээ, урамшуулал, хөнгөлөлт авахгүй. Харин нийтээр хүлээн зөвшөөрсөн зан заншлын хэм хэмжээний дагуу талархал илэрхийлсэн, сарын







- үндсэн цалингаас бага үнэ цэнэ бүхий бэлэг дурсгалын үйл солилцсоныг энэ заалтыг зорчсон гэж үзэхгүй;
- 6.5.3 Гишүүний хувьд олж мэдсэн нууц болон албан мэдээллийг ажиллах хугацаандаа болон өөрчлөгдсөнөөс хойш 5 жилийн хугацаанд ашиг олох зорилгоор ашиглахгүй, бусдад задруулахгүй;
  - 6.5.4 Компанийн нууц болон дотоод мэдээллийн аюулгүй байдлыг хангах журмыг хатуу мөрдөж ажиллах.
  - 6.6 ТУЗ-ийн хараат бус гишүүд хараат бус байдалд нь нолоолох аливаа үйл ажиллагаанаас татгалзана. Нөхцөл байдал өөрчлөгдсөний улмаас хараат бус байх шалгуурыг хангахаа больсон бол ийнхүү нөхцөл байдал нь өөрчлөгдсөн гарцаагүй болсноос хойш 1 сарын дотор энэ тухай ТУЗ-д мэдэгдэнэ.
  - 6.7 Чинг үүргээ хэрэгжүүлэх явцад олж тогтоосон хууль болон Компанийн дүрэм, энэ журмаар тогтоосон хэм хэмжээ зорчигдож болохуйц нөхцөл байдал үүссэнээс компанийн бизнест эрсдэл учруулж болно гэж үзсэн бол энэ тухайгаа ТУЗ-д мэдэгдэх бөгөөд үүний шалтгаан, арилгах талаар арга хэмжээ авах саналаа тусгасан байна.
  - 6.8 Энэ журмын 6.5-д заасныг зорчсонөөс компанид хохирол учруулсан бол өөрийн хөрөнгөөр нөхөн төлөх үүрэгтэй.
  - 6.9 Энэ журмын 6.5-д заасныг зөрчиж гаргасан шийдвэр нь компанид алдагдал учруулах үр дагаварт хүргэсэн бөгөөд энэ шийдвэр нь хамтын шийдвэр байсан бол хамтын хариуцлага хүлээж, хохирлыг хувь тэнцүүлэн хувааж хариуцна.
  - 6.10 Компанид алдагдал учруулах шийдвэрийн эсрэг саналтай байсан гишүүн хамтын хариуцлагаас чөлөөлөгдөнө.
  - 6.11 ТУЗ-ийн болон Хороодын нийт хуралдааны 30-аас дээш хувьд нь аль нэг хэлбэрээр оролцож чадаагүй бол уг гишүүнийг ТУЗ-д дахин нэр дэвшүүлэхийг хориглоно.
  - 6.12 ТУЗ-өөс гаргаж буй шийдвэр мэдээлэл дээр үндэслэсэн, бодитой, компанийн үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, сайн засаглалыг хэвшүүлэх, зээлдэгчид, итгэмжлэлийн гэрээ байгуулсан этгээд бусад харилцагчид хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийн тэнцвэрийг хангасан байхын тулд ТУЗ-ийн гишүүдэд шийдвэр гаргах үндэслэл болсон мэдээллийг бүрэн хүргүүлсэн байх бөгөөд гишүүд эдгээр мэдээллийг сайтар судалсан байх ёстой.
  - 6.13 ТУЗ-ийн гишүүдэд мэдээлэл хүргэх асуудлыг ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга хариуцна. ТУЗ-ийн гишүүд мэдээлэл аваагүй, дутуу юмуу хугацаа хожимдож авсан асуудлаар ТУЗ-ийн даргад гомдол гаргах бөгөөд ТУЗ-ийн дарга буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх, ач холбогдлоо алдаагүй мэдээллийг нөхөн хүргүүлэх арга хэмжээ авна.

#### Долоо. ТУЗ-ийн хараат бус гишүүдийн үүрэг хариуцлага

- 7.1 ТУЗ-ийн хараат бус гишүүд нь энэ журмын 6 дугаар зүйлд зааснаас гадна дараах чинг үүргтэй байна:
  - 7.1.1 ТУЗ-ийн болон гүйцэтгэх удирдлагын гаргаж буй шийдвэр ялангуяа их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх тухай шийдвэр нь компанийн ашиг сонирхол болон хууль тогтоомж дүрэм журамд нийцэж байгаа эсэхэд хяналт тавих, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх;
  - 7.1.2 Хувьцаа эзэмшигчид болон бусад эрх бүхий сонирхогч талуудыг мэдээллээр хангах үүргээ гүйцэтгэх удирдлага хэрхэн хэрэгжүүлж байгаад хяналт тавих;
  - 7.1.3 Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын зохистой тогтолцоо бүрдсэн эсэхэд хяналт тавих;
  - 7.1.4 ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын шийдвэр компанийн эрх ашигт сөргөөр нөлөөлөхөөр байна гэж үзвэл энэ талаар бичгээр дүгнэлт хүргүүлэх, дүгнэлтийн талаар үндэслэл бүхий тайлбар ирүүлээгүй, ирүүлсэн ч тайлбар, үндэслэл нь бодит байдалд нийцэхгүй гэж үзвэл залруулахыг шаардах;




- 7.1.5 2-оос доошгүй хараат бус гишүүн хамтран Компанийн тухай хуулийн 61 дүгээр зүйлд заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн хурал зарлан хуралдуулахыг шаардах, ТУЗ уг шаардлагыг үндэслэлгүйгээр хүлээн аваагүй тохиолдолд оорсдоо хурал зарлан хуралдуулах;
- 7.2 Хараат бус гишүүдийн нэг нь ТУЗ-ийн Аудитын хороог даргална.
- 7.3 Их хэмжээний болон сонирхлын зорилтэй хэлцэл хийх тухай ТУЗ-ийн шийдвэрийг ТУЗ-ийн хараат бус бүх гишүүдийн зөвшөөрөлтэй гаргах бөгөөд уг хэлцлийн хэрэгжилтэд хяналт тавина.
- 7.4 Хувьцаа эзэмшигчдийг мэдээллээр хэрхэн хангаж байгаа, олон нийгэд болон Санхүүгийн зохицуулах хороо, Үндэсний статистикийн Хороонд хүргэхээр хууль, журам болон Монголын компанийн засаглалын кодекст заасан мэдээллийг хэрхэн хүргэж байгаа байдалд хяналт тавих үүргийг ТУЗ-ийн Аудитын хороо хэрэгжүүлнэ.
- 7.5 “Компанийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах журам”-ын хэрэгжилтийн тайланг хагас жил тутамд ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга гаргаж, Аудитын хорооны дарга хянана.
- 7.6 Компанийн үйл ажиллагааны ил тод байдлыг ханган ажиллаж чадаагүй байна гэж Аудитын хороо үзвэл холбогдох эрх бүхий албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх болон цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх саналаа ТУЗ-д оруулан хэлэлцүүлнэ.

#### **Найм. ТУЗ-ийн гишүүдийн үйл ажиллагаанд дүгнэлт өгөх**

- 8.1. ТУЗ-ийн гишүүдийн үйл ажиллагаанд Нэр дэвшүүлэх хороо дүгнэлт өгнө.
- 8.2. Нэр дэвшүүлэх Хороо нь ТУЗ-ийн гишүүний хувьд ТУЗ-ийн болон Хорооны хуралд оролцсон байдал, ТУЗ-өөс болон холбогдох Хорооноос өгсөн үүрэг даалгаврыг хэрхэн биелүүлсэн зэрэг үзүүлэлтийг харгалзан дүгнэлт өгөх бөгөөд “ТУЗ-ийн гишүүдийн үйл ажиллагаанд дүгнэлт өгөх хуудас”-ыг боловсруулан ашиглана.
- 8.3. ТУЗ-ийн гишүүн бүрээр ТУЗ-ийн Нарийн бичгийн даргын гаргаж өгсөн бүртгэл, Хороодын дарга нарын гаргасан тодорхойлолтыг үндэслэн гаргасан дүгнэлтийг жил бүрийн 1-р сарын хуралд танилцуулж байна.
- 8.4. ТУЗ-ийн гишүүнд “хангалтгүй ажилласан” гэсэн дүгнэлт өгсөн бол үндэслэлээ бичгээр тайлбарлаж, тухайн гишүүний тайлбарыг авсан байна.
- 8.5. “Хангалтгүй” гэсэн үнэлэлт авсан гишүүний нэрийг дахин ТУЗ-д дэвшүүлэхгүй байх тухай болон “хангалтгүй” үнэлэлт авсан үндэслэлийг тайлбарласан албан тоотыг тухайн гишүүнийг нэр дэвшүүлсэн этгээдэд хүргүүлнэ.


#### **Ес. ТУЗ-ийн Нарийн бичгийн даргын үүрэг, хариуцлага**

- 9.1 Компанийн ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга нь тухайн компанийн засаглалын болон бусад оролцогч талуудтай харилцах харилцааны асуудлыг хариуцах эрх бүхий албан тушаалтан байна.
- 9.2 Нарийн бичгийн даргыг компанийн ТУЗ-ийн даргын санал болгосноор ТУЗ-ийн нийт гишүүдийн олонхийн саналаар томилно.
- 9.3 Нарийн бичгийн даргад нэр дэвшингч дараах шаардлагыг хангасан байна:
  - 9.3.1 Дээд боловсролтой;
  - 9.3.2 Санхүү, бизнес, төрийн удирдлагын чиглэлээр 5-аас доошгүй жил ажилласан туршлага болон мэргэжлийн ур чадвартай байх;
  - 9.3.3 Компанийн тухай хуулийн 75.8-д заасан шаардлагыг хангасан байх;
- 9.4 ТУЗ-ийн гишүүдэд нарийн бичгийн даргад нэр дэвшингчтэй холбоотой дараах мэдээллийг хүргэнэ:
  - 9.4.1 Боловсрол, өнгөрсөн 3 жилд хашиж байсан ажлын туршлага;
  - 9.4.2 Компанийн эрх бүхий албан тушаалтантай нэгдмэл сонирхолтой этгээд эзэх;
- 9.5 Нарийн бичгийн даргатай хийх хөдөлмөрийн гэрээний нөхцөлийг ТУЗ батлах бөгөөд ТУЗ-ийг толоож, ТУЗ-ийн дарга гарын үсэг зурна.
- 9.6 Нарийн бичгийн дарга нь өөр компани, байгууллагад ажил, албан тушаал хавсран эрхлэхийг хориглоно.



- 9.7 ТУЗ-ийн дарга нь Нарийн бичгийн даргын эзгүйд түүнийг орон ажиллах этгээдийг томилно.
- 9.8 ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөний болон гүйцэтгэлийн тайлангийн төсөл бэлдэхээс гадна дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:
- 9.8.1 **Компанийн засаглалын бодлогын чиглэлээр:**
- 9.8.1.1 Олон улсын болон дотоодод хэрэгжиж буй компанийн засаглалын кодекс болон түүнтэй холбоотой шинэчлэл, оорчлолтийг судлах;
- 9.8.1.2 Шинэчлэл, оорчлолтийн талаар ТУЗ болон гүйцэтгэх удирдлагыг мэдээлээр хангах, хэрэгжүүлэх арга боломжийг судлах, санал боловсруулан ТУЗ, гүйцэтгэх удирдлагад танилцуулах;
- 9.8.1.3 Компанийн засаглалын бодлого болон үйл ажиллагаанд оорчлолт оруулах санал, засаглалыг сайжруулах төлөвлөгөө, журмын төсөл боловсруулж ТУЗ-д оруулах;
- 9.8.1.4 Компанийн дотоод журмыг боловсруулахад компанийн гүйцэтгэх удирдлага болон бусад холбогдох албан тушаалтанд зөвлөх;
- 9.8.1.5 Шинээр сонгогдсон зөвлөлийн гишүүн болон компанийн бусад эрх бүхий албан тушаалтан, дотоод хяналтын ажилтанд компанийн дүрэмж журам, үйл ажиллагааны стратеги, засаглалын бодлого, журмыг танилцуулах сургалтыг зохион байгуулах.
- 9.8.2 **Оролцогч талуудтай харилцах, ил тод байдлыг хангах чиглэлээр:**
- 9.8.2.1 Компанийн хуулийн хэлтэстэй хамтарч ажиллах, мэдээлэл солилцох;
- 9.8.2.2 Компанийн талаарх мэдээлэл, тайлангуудыг холбогдох дүрэм журмын дагуу төрний эрх бүхий байгууллагад хүргэж байгаа эсэхэд хяналт тавих;
- 9.8.2.3 Олон нийтэд ил болгох компанийн мэдээллийг хуульд заасан арга хэрэгслээр хүргэх асуудлыг хариуцах;
- 9.8.2.4 Хувьцаа эзэмшигч, болон эрх бүхий бусад харилцагчийн хүсэлтээр шаардлагатай мэдээллийг цаг алдалгүй хүргэх асуудлыг хариуцах;
- 9.8.2.5 Компанийн хувьцаа эзэмшигч, ТУЗ, түүний дэргэдэх хороод, гүйцэтгэх удирдлага, бусад салбар хэлтэс хоорондын мэдээлэл солилцооны үр дүнтэй байдлыг хангах;
- 9.8.2.6 Компанийн нууц мэдээллийн аюулгүй байдлыг хангаж, мэдээлэлд зөвхөн эрх бүхий этгээд зохих журмын дагуу нэвтэрч байгаа эсэхэд хяналт тавих;
- 9.8.2.7 Нарийн бичгийн дарга нь чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотойгоор компанийн бүх алба хэлтэс, ажилтнаас мэдээлэл авах эрхтэй.
- 9.8.3 **Хувьцаа эзэмшигчдийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг зохион байгуулах чиглэлээр;**
- 9.8.3.1 Хувьцаа эзэмшигчдийн хурал болон ТУЗ-ийн хурлыг зарлан хуралдуулах, зохион байгуулахдаа Компанийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос батлан гаргасан журам болон компанийн “Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах журам”-ыг чанд мөрдөж, хурлыг, эсвэл гаргасан аливаа шийдвэрийг хүчингүйд тооцох эрсдэл гаргахаас сэргийлэх, нийм үр дагаварт хүргэсэн тохиолдолд харнуцлага хүлээх;
- 9.8.3.2 Хувьцаа эзэмшигчдийн хурал зохион байгуулах болон Тооллогын комиссын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, хяналт тавих;
- 9.8.3.3 Хувьцаа эзэмшигчдийн хурлын товыг ТУЗ-ийн даргатай хэлэлцэн товлж, ТУЗ-ийн гишүүдэд мэдэгдэх;
- 9.8.3.4 Хувьцаа эзэмшигчид болон ТУЗ-ийн гишүүд, бусад эрх бүхий этгээдэд хурлын зарыг хүргүүлэх;
- 9.8.3.5 Компанийн гүйцэтгэх удирдлагын эрх бүхий албан тушаалтнууд болон компанийн гэрээт аудит, зөвлөх байгууллага, дотоод хяналтын ажилтанд хурлын зарын талаар мэдээлэх;
- 9.8.3.6 Хувьцаа эзэмшигчдийн хурлын зарын хамт хурлаар хэлэлцэх асуудлууд, түүнд холбогдох мэдээлэл, баримт бичгүүд, хурлаас гаргах шийдвэрийн төсөл, саналын хуудас зэргийг бэлтгэх, хуралд оролцогчид хурлын өмнө танилцах боломж нөхцөлийг хангах;






- 9.8.3.7 Хурлаас өмнө хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн саналын хуудсыг хүлээн авч битүүмжлэн тооллогын комисст шилжүүлэх ба зөвлөлийн гишүүдийн бөглөсөн саналын хуудсыг зөвлөлийн даргад шилжүүлэх;
- 9.8.3.8 Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл хотлох, албажуулсан тэмдэглэл, шийдвэрийн хадгалалт хамгаалалтыг хариуцах;
- 9.8.3.9 Хувьцаа эзэмшигчид болон ТУЗ-ийн гишүүдэд хурлын тэмдэглэл, шийдвэрийг танилцуулах, тэмдэглэлийн хувийг хүргүүлэх;
- 9.8.3.10 Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулж явуулах дэг журам, холбогдох дүрэм журмын талаар зөвлөгөө өгөх, оролцогчдын асуултанд хариулах;
- 9.8.3.11 Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах, удирдан явуулах явцад үүссэн маргаан, үл ойлголцлыг шийдвэрлэх талаар арга хэмжээ авах;
- 9.8.4 Хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилтийг хангах чиглэлээр**
- 9.8.4.1 Компанийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;
- 9.8.4.2 Компанийн албан тушаалтан, ажилтнууд компанийн засаглалын бодлого, дүрэм журмыг зөрчсөн тохиолдолд ТУЗ-ийн даргад нэн даруй мэдэгдэх. ТУЗ-ийн дарга, гишүүд компанийн засаглалын дүрэм журмыг зөрчвөл Хувьцаа эзэмшигчдийн хурал дээр зөрчлийг мэдэгдэх;
- 9.8.4.3 ТУЗ-д компанийн засаглалын бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх, дүн шинжилгээ хийх болон сайжруулах зэрэгт дэмжлэг үзүүлэх;
- 9.8.4.4 Компанийн удирдлага ба хувьцаа эзэмшигчдийн хооронд болон ТУЗ-ийн гишүүдийн хооронд үүссэн сонирхлын зөрчлийг шийдвэрлэхэд туслах, зуучлах үүрэг гүйцэтгэх;
- 9.8.4.5 Компанийн бичиг баримтыг хадгалах, эрх бүхий албан тушаалтны шаардлагаар танилцуулах, хадгалах хугацаа нь дууссан баримт бичгийг архивт шилжүүлэх ажлыг хариуцахаас гадна хуулбарыг зохих этгээдэд хүсэлтийн дагуу гаргаж өгөх;
- 9.8.4.6 Компанийн хувьцаа эзэмшигчид, ТУЗ-ийн гишүүдээс ирсэн санал, харилцагчдаас ТУЗ-ийн нэр дээр ирсэн гомдлыг хүлээн авч, бүртгэл хөтлөх, холбогдох газар хэлтэс, ажилтан хүлээлгэн өгч, хүлээн авсан этгээд уг гомдол, саналыг цаг хугацаанд нь барагдуулж, харну өгч байгаа эсэхэд хяналт тавих.

#### Арав. ТУЗ-ийн даргын эрх, үүрэг, хариуцлага


- 10.1 ТУЗ-ийн даргыг ТУЗ-ийн гишүүд дотроосоо олонхийн саналаар сонгоно.
- 10.2 ТУЗ-ийн дарга нь дараах эрх, үүрэгтэй байна:
- 10.2.1 Компанийн үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөний биелэлтийг хангахад байнгын анхаарал хандуулан ажиллах;
- 10.2.2 ТУЗ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахад удирдамжаар хангаж, төлөвлөгөөнд компанийг стратегийн удирдлагаар хангах, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын зохистой тогтолцоо бүрдүүлэхтэй холбоотой чухал асуудал бүрэн тусгагдсан эсэхийг хянаж, шаардлагатай тохиолдолд төлөвлөгөөнд нэмэлт оруулах санал боловсруулах, ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланд төлөвлөгөөний биелэлтийг бүрэн тусгах, төлөвлөгөө, тайланг ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлж, батлуулах;
- 10.2.3 ТУЗ-ийн үйл ажиллагааны тайлан болон гишүүдийн ажлын үр дүнг хэлэлцэн батлахад шийдвэрлэх санал гаргах, гишүүдийн санал тэнцсэн тохиолдолд ТУЗ-ийн даргын саналаар шийдвэрлэх;
- 10.2.4 Гишүүдэд компанийн үйл ажиллагааны үр дүнгээр шагнал урамшуулал олгох санал боловсруулж, ТУЗ-ийн хуралд оруулах;
- 10.2.5 ТУЗ-ийн хурлыг төлөвлөгөөнд тусгагдсан цаг тухайд нь хуралдуулах, бэлтгэлийг бүрэн хангуулах, гишүүдийг мэдээллээр хангах, удирдах, өөрөө оролцох боломжгүй бол хурал удирдах этгээдийг томилох зэргээр хурлын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах. ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга энэ шаардлагыг ханган ажиллаж чдахгүй байгаа тохиолдолд хариуцлага хүлээлгэх, өөрчлөх арга хэмжээг цаг алдалгүй авах;



- 10.2.6 Гишүүдийг компанийн засаглалын талаар сургалт семинарт хамруулах, хэлэлцүүлэг зохион байгуулах зэрэг компанийн сайн засаглалын зарчмуудын талаарх мэдлэгийг дээшлүүлэх, мэдээлэл олгох, ТУЗ-ийн болон Хороодын ажиллагаанд гишүүдийн үр дүнтэй оролцоог хангахад анхаарал хандуулан ажиллах;
- 10.2.7 ТУЗ-ийн үйл ажиллагааны үр дүн, төлөвлөгөөний биелэлтийг хариуцах;
- 10.3 ТУЗ-ийн дарга нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуулиар тогтоосон хугацаанд буюу жил бүрийн 5 дугаар сарын 1-ний дотор бүрэн бэлтгэлтэй хуралдуулж, жилийн үйл ажиллагааны тайланг хэлэлцүүлэх, гарсан шийдвэрийн хэрэгжилтийг хангах асуудлыг биечлэн зохион байгуулж, хянах онцгой үүрэг хүлээнэ.

#### Арваннэг. ТУЗ-ийн хурал

- 11.1 ТУЗ-ийн ээлжит хурлыг улиралд нэгээс доошгүй удаа хуралдуулна.
- 11.2 ТУЗ-ийн ээлжит хурал болох огноо, газар, эхлэх цаг, хэлэлцэх асуудлын талаарх мэдэгдэл, хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой болон хуралд бэлтгэхэд шаардлагатай мэдээллийг ТУЗ-ийн гишүүн бүрт хурал хуралдахаас 3-аас доошгүй хоногийн өмнө ТУЗ-ийн Нарийн бичгийн даргад бүртгэлтэй байгаа цахим хаягаар нь хүргүүлнэ. ТУЗ-ийн гишүүн зарыг хүлээн авсан тухайгаа заавал харну ирүүлнэ.
- 11.3 Шинээр сонгогдсон ТУЗ-ийн анхны хурлыг ТУЗ-ийг сонгосноос хойш ажлын 3 хоногийн дотор ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хариуцан зарлаж, хуралдуулах бөгөөд хурлаар ТУЗ-ийн даргыг сонгох, ТУЗ-ийн хороодыг байгуулах, хороодын гишүүдийг сонгох, Гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээний нөхцөлийг тогтоох, гүйцэтгэх захирлыг сонгох зэрэг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ.
- 11.4 Шаардлагатай тохиолдолд ТУЗ-ийн нэмэлт хуралдааныг доор дурьсан этгээдийн санал, шаардлагаар хэнийд ч зарлан хуралдуулж болно.
  - 11.4.1 ТУЗ-ийн дарга;
  - 11.4.2 ТУЗ-ийн 2-оос доошгүй гишүүн;
  - 11.4.3 Гүйцэтгэх захирал;
  - 11.4.4 Дотоод аудитын асуудал хариуцсан албан тушаалтан;
  - 11.4.5 Санхүүгийн тайланд аудит хийж, дүгнэлт гаргасан хөндлөнгийн аудитын байгууллага.
- 11.5 ТУЗ-ийн хурал хуралдуулах саналыг ТУЗ-ийн дарга болон ТУЗ-ийн Нарийн бичгийн даргад бичгээр эсхүл цахим шуудангаар хүргүүлэх бөгөөд ТУЗ-ийн бусад гишүүдэд хувийг хүргүүлсэн байна. Санал хүргүүлсэн огноог ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга хүсэлтийг хүлээн авсан тухайгаа мэдэгдсэн өдрөөр тогтооно.
- 11.6 Хурал хуралдуулах саналд дараах асуудлыг тусгана:
  - 11.6.1 Хурлаар хэлэлцүүлэхээр санал гаргаж буй хүний нэр, албан тушаал;
  - 11.6.2 Хэлэлцүүлэхээр санал болгож буй асуудал, шийдвэр гаргахад шаардлагатай мэдээлэл, өөрт нь байгаа мэдээлэл шийдвэр гаргахад хангалттай бус гэж үзэж байгаа бол ямар мэдээллийг хэрхэн толилуулах талаарх санал.
- 11.7 Хүсэлтийг хүлээн авснаас хойш зохих бэлтгэлийг хангасны дараа, 10 хоногийн дотор ТУЗ-ийн дарга хурлыг зарлан хуралдуулна.
- 11.8 ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэхээр санал болгож буй асуудал нь ТУЗ-ийн бүрэн эрхэд хамаарахгүй асуудал бол энэ тухай тайлбар, хэрхэн шийдвэрлэх зүйтэй болох тухай зөвлөмжийн хамт санал гаргасан этгээдэд хариу хүргүүлнэ.
- 11.9 ТУЗ-ийн дарга хурал хуралдуулахаас үндэслэлгүй татгалзсан бол ТУЗ-ийн аль нэг гишүүн, хүндэтгэн үзэх шалтгааны улмаас үүргээ гүйцэтгэх боломжгүй байгаа бол ТУЗ-ийн даргыг орлож буй гишүүн хурлыг зарлан хуралдуулах талаар энэ журмын 11.7-д заасан үүргийг хэрэгжүүлнэ.
- 11.10 ТУЗ-ийн хурлыг ТУЗ-ийн дарга, түүний эзгүйд түүний томилсон ТУЗ-ийн гишүүн, уг гишүүн хуралд оролцох боломжгүй болсон бол хуралд оролцож буй хамгийн ахмад гишүүн удирдан явуулна.



- 11.11 Хуралд ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олонх (гурван) биеэр, саналын хуудсаар, угсаар болон интернетээр оролцсон тохиолдолд хүчин төгөлдөр болох ирц бүрдэнэ.
- 11.12 ТУЗ-ийн хурал зарлан хуралдуулахаар төвлөсөн хугацаанаас 60 (жаран) минут онгорсон ч ирц бүрдээгүй бол хурлын товыг гишүүд харилцан тохиролцож, хуралдах өдрийг товлон хойшлуулна. Хуралд 2-оос дээш удаа хожимдож хурлыг хойшлуулахад хүргэсэн гишүүнийг ТУЗ-оос чөлөөлж, орлох гишүүнийг хувьцаа эзэмшигчийн дараагийн хурал хүртэл хугацаагаар ТУЗ сонгоно.
- 11.13 Хурлын явцад тэмдэглэл хөтлөнө.
- 11.14 Хурал дээр хэлэлцэж буй асуудлаар санал хураахад гишүүн бүр нэг саналын эрх эдэлнэ.
- 11.15 Хуралд санал өгөх эрхээ бусад гишүүнд болон өөр этгээдэд итгэмжлэх замаар хэрэгжүүлэхийг хориглоно.
- 11.16 ТУЗ-ийн хурлын шийдвэр нь хуралд оролцсон гишүүдийн дийлэнх олонхийн (2/3) саналаар хүчин төгөлдөр болох бөгөөд шийдвэр нь тогтоол хэлбэртэй байна. Тогтоолд хурал даргалсан ТУЗ-ийн гишүүн гарын үсэг зурж баталгаажуулна. Их хэмжээний хэлцэл хийх шийдвэр гаргаж байгаа бол ТУЗ-ийн бүх 5 гишүүн зөвшөөрсөн тохиолдолд шийдвэр гарна.
- 11.17 Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх асуудлыг шийдвэрлэж байгаа бол уг хэлцлээс ямар нэг хэлбэрээр орлого хүртэх боломжтой эсхүл өөрөө болон нэгдмэл сонирхолтой этгээд нь хэлцлийн нөгөө тал болж байгаа, эсхүл хэлцэл зуучлагч, төлөөлөгчөөр оролцож байгаа ТУЗ-ийн гишүүн уг асуудлаар болон хэлцлийн зүйлийн үнийг тогтоох асуудлаар санал өгөх эрхгүй байна. Энэ тохиолдолд шийдвэрийг саналын эрхтэй гишүүдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ.
- 11.18 ТУЗ нь тодорхой 2-оос илүүгүй асуудлаар эчнээ санал хураалт явуулах замаар шийдвэр гаргаж болно. Энэ тохиолдолд шийдвэрлэх асуудлын томъёолол, түүнтэй холбогдох бүрэн мэдээлэл, танилцуулгыг ТУЗ-ийн гишүүдэд бичгээр /цаасаар юмуу цахим шуудангаар/ хүргүүлэх бөгөөд хүргүүлсэнээс хойш 5-аас доошгүй хоногийн дараа ТУЗ-ийн гишүүдийн саналыг авахаар заасан байна. Эчнээ санал хураалтаар шийдвэрлэх асуудлаар ТУЗ-ийн гишүүд бичгээр /цаасаар юмуу цахим шуудангаар/ саналаа ирүүлэх бөгөөд ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олонх нь саналаа ирүүлсэн, тэдгээрийн дийлэнх олонх нь уг асуудлаар гарах шийдвэрийн төслийг зөвшөөрсөн бол эчнээ санал хураалтаар тухайн асуудлыг шийдвэрлэсэнд тооцож, ТУЗ-ийн тогтоол гарган, ТУЗ-ийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна. ТУЗ-ийн дараагийн хуралд эчнээ санал хураалтаар гаргасан шийдвэрийн албажуулсан хувийг гишүүдэд танилцуулах үүргийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хүлээнэ.
- 11.19 ТУЗ-ийн хурлын тэмдэглэлд дараах асуудлыг заавал тусгасан байна:
  - 11.19.1 Хурал хуралдсан газар, өдөр, цаг;
  - 11.19.2 Хуралд оролцсон гишүүд болон бусад этгээдийн нэр, албан тушаал
  - 11.19.3 Хурлаар хэлэлцсэн асуудал;
  - 11.19.4 Хурлын явцад гишүүдээс асуусан асуулт өгсөн харнулт, хурлын явцад гишүүдээс гаргасан саналын дэлгэрэнгүй байдлаар тусгах,
  - 11.19.5 Санал хураалтаар шийдвэрлэсэн асуудал болон саналын хураалтын дүн;
  - 11.19.6 Тухайн асуудлаар эсрэг саналтай байсан гишүүдийн нэр, эсрэг саналтай байсан үндэслэл;
  - 11.19.7 Гаргасан шийдвэр.
- 11.20 ТУЗ-ийн хурлын тэмдэглэлд оролцсон гишүүд гарын үсэг зурах бөгөөд тэмдэглэлийн үнэн зөвийг тухайн хурлын дарга хариуцна.
- 11.21 ТУЗ-ийн аль нэг гишүүн хурлын тэмдэглэлд гарын үсэг зурахаас татгалзсан бол энэ тухай бичгээр тайлбар гаргах бөгөөд уг тайлбарыг хурлын тэмдэглэлд хавсарган хадгална.
- 11.22 ТУЗ-ийн хурлын тэмдэглэлийг буруу хөтөлсөн нь уг хурлын шийдвэрийг хүчингүйд тооцох үндэслэл болохгүй.



**Арван хоёр. Хариуцлага**



МОНГОЛЫН УРГАХААНИЙН ҮЙЛЭГ  
МОНГОЛЫН УРГАХААНИЙН ҮЙЛЭГ  
2023-04-06  
БҮРТГЭВ-02

СЭХ  
ок сар өдөр  
БҮРТГЭВ  
№ 01

- 12.1 ТУЗ-ийн гишүүн Компанийн тухай хууль, Компанийн дүрэм болон энэ журмаар тогтоосон үүргээ биелүүлээгүй, эрхээ хэтрүүлсэн тохиолдолд түүнд хариуцлага хүлээлгэх асуудлыг хувьцаа эзэмшигчийн хурлын болон Нэр дэвшүүлэх хорооны дүгнэлтийг үндэслэн ТУЗ-ийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэнэ.
- 12.2 ТУЗ-ийн гишүүнд дараах харуцлага хүлээлгэнэ:
- 12.3 Энэ журмаар тогтоосон үүргээ биелүүлээгүй, эрхээ хэтрүүлсэнээс компанийн ашиг сонирхолд ноцтой хохирол учруулаагүй гэж үзвэл анхааруулна.
- 12.4 Дээрх зөрчлийн улмаас компанид хохирол учруулсан бол ТУЗ-ийн гишүүнээс чөлөөлж, хохирлыг нөхөн төлүүлэх талаар хугацаатай үүрэг өгч, хэрэгжүүлээгүй тохиолдолд хууль хяналтын байгууллагад шилжүүлнэ.



"ТУЗ-ийн үйл ажиллагааны журам"-ын  
Хавсралт № 1



**"БЭРС ФИНАНС ББСБ" ХХК-ийн ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИЙН  
ЗӨВШӨӨРӨЛ, БАТЛАМЖ**

20... оны ... дугаар  
сарын ...-ний өдөр



Монгол улсын иргэн ..... регистрийн дугаартай .....овогтой .....  
миний бие "Бэрс финанс ББСБ" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн /ердийн/хараат бус  
гишүүнээр сонгогдохоор нэрээ дэвшүүлж /миний нэрийг дэвшүүлэхийг зөвшөөрч/ байна.

Миний бие Компанийн эрхэм зорилго, үйл ажиллагааны үндсэн чиглэл, хэтийн зорилтыг  
сайтар ойлгож байгаа бөгөөд өөрийн нэрийг ТУЗ-ийн гишүүнд дэвшүүлж байгаатай холбогдуулан:

1. Компанийн дүрэм, "Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам" болон холбогдох бусад журмуудтай сайтар таанилцсан болохоо;
2. Монгол Улсын Компанийн тухай хууль, Компанийн дүрэм, "Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам"-ын 3.3 болон (хараат бус гишүүний хувьд 3.4-т заасан) Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд тавигдах шалгуур, шаардлагыг бүрэн хангаж холбогдох баримт бичгүүдийг энэхүү баталгаанд хавсаргасан болохоо;
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийн анкетнийг үнэн зөв бөглөсөн болохоо;
4. Монгол Улсын компанийн тухай хуулийн 99.1-д заасан нэгдмэл сонирхолтой этгээдийн мэдээллийг үнэн зөв гаргаж өгсөн болохоо;
5. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгогдсон тохиолдолд компанийн болон хувь хүний нууцыг чандлан хадгалж, зөвхөн компани болон нийслэлийн иргэдийн эрх ашгийг эрхэмлэн, үнэнч шударгаар, тууштай ажиллахаа, ажиллах боломжтой болохоо;
6. Энэхүү баталгааг хууран мэхлэх замаар болон хуурамч бичиг баримт бүрдүүлэн гаргасан бол хуулийн хариуцлага хүлээхээ, тус тус баталж байна.

**ЗӨВШӨӨРӨЛ, БАТЛАМЖ ГАРГАСАН  
ТУЗ-ИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧ**

.....



"ТУЗ-ийн үйл ажиллагааны журам"-ын  
Хавсралт № 2



**"БЭРС ФИНАНС ББСБ" ХХК-ийн ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИЙН  
АНКЕТ**

1. Овог .....

2. Нэр .....

3. Ургийн овог

Зураг

4. Эрэгтэй эмэгтэй (зурах)

5. Төрсөн .... он .. дүгээр сар ...-ны өдөр

6. Төрсөн аймаг/хот/....., Төрсөн газар .....

7. Одоогийн захиргаа .....

10. Ам бүлийн байдал (зөвхөн ам бүлд байгаа хүмүүсийг бичнэ)


№	Таны юу болох (эцэг, эх, ах дүү, хүүхэд, гэр бүл)	Овог нэр (хэний хэн)	Хаана ямар ажилтай	Төрсөн он
1				
2				
3				
4				

11. Төгссөн сургууль

№	Хаана ямар сургууль,	Элссэн, төгссөн он	Эзэмшсэн мэргэжил	Диплом №
1				
2				
3				

12. Ажилласан байдал





№	Хаана ямар байгууллага,	Орсон, гарсан он	Албан тушаал	Ажлаас гарсан шалтгаан

13. ТУЗ-ийн гишүүнээр ажилласан байдал

№	Хаана ямар компанид	Сонгогдсон, гарсан он	Ердийн олон хараат бус гишүүн алин болох	Тайлбар

14. Мэргэжил дээшлүүлсэн байдал


№	Хаана ямар байгууллага	Хэдийд ямар хугацаатай	Мэргэжил дээшлүүлсэн чиглэл

15. Ур чадвар:

	Сайн	Дунд	Анхан шатны
Компьютерийн өргөн хэрэглээний програмууд			
Гадаад хэл:			
1			
2			



18. "Бэрс финанс ББСБ" ХХК-ийн хамаарч буй компанийн нэгдлийн аль нэг гишүүн компани болон компанитай бизнесийн хамааралтай аливаа байгууллагад өөрөө болон нэгдмэл сонирхолтой этгээд нь эрх бүхий албан тушаал хашдаг эсэх, хашдаг бол:

- 18.1. Байгууллагын нэр .....
- 18.2. Овог нэр.....
- 18.3. Албан тушаал.....
- 18.4. Нэгдмэл сонирхолтой этгээд бол Тангай ямар хамааралтай.....



- 19. Гавьяа, шагнал: .....
- 20. Өөрийн иргэний үнэмлэх, регистрийн дугаар, оршин суугаа хаяг, ажлын ба гэрийн утасны дугаар
  - 20.1.Регистрийн дугаар: .....
  - 20.2 Оршин суугаа хаяг: .....
  - 20.3 Гэрийн утасны дугаар: .....
  - 20.4 Гар утасны дугаар: .....
- 21. Онц яаралтай тохиолдолд танд мэдээ дамжуулах , холбоо барих хоёр хүний овог нэр, гэрийн хаяг, утасны дугаар (таны юу болох)
  - 21.1 Овог нэр: .....
  - 21.2 Таны хэл болох: .....
  - 21.3 Гэрийн хаяг: .....
  - 21.4 Утасны дугаар: .....

АНКЕТАА ҮНЭН ЗӨВ БИЧСЭН..... /



“Бэрс финанс ББСБ-ын ТУЗ-ийн 2023 оны 01-р сарын 04- ний өдрийн 23/01а/01 тоот тогтоолын Хавсралт 2”

**“БЭРС ФИНАНС ББСБ” ХХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ХОРООДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ**

**Нэг. Ерөнхий зүйл**

- 1.1 Энэхүү журмаар ТУЗ-ийн дэргдэх хороодын бүтэц бүрэлдэхүүн чиг үүргийг тогтооно.
- 1.2 Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлд заасны дагуу компанийн ТУЗ нь аудит, эрдэлийн, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын гэсэн орон тооны бус 3 хороотой байна.

**Хоёр. ТУЗ-ийн Аудитын хорооны бүтэц бүрэлдэхүүн, чиг үүрэг**

- 2.1 ТУЗ-ийн аудитын хороо нь 3 гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн 2 нь хараат бус гишүүн байна.
- 2.2 Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн хараат бус гишүүн байна.
- 2.3 Аудитын хороо нь дараах чиг үүрэгтэй байна:

**2.3.1 Дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх талаар:**



- 2.3.1.1 Компанийн дотоод хяналтын тогтолцоог сайжруулах, цар хүрээг өргөжүүлэх асуудлаар зөвлөмж гаргах;
- 2.3.1.2 Компанийн дотоод аудит болон хөндлөнгийн аудит, эксперт, зөвлөхийн өгсөн зөвлөмжийг хэрхэн хэрэгжүүлж байгааг хянаж, хэлэлцэн, үнэлэлт өгөх;
- 2.3.1.3 Компанийн мэдээллийн системийн аюулгүй байдал, мэдээллийн тогтолцооны үр шигтэй байдлыг хянаж, зөвлөмж удирдлагаар хангах;

**2.3.2 Санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлангийн талаар:**

- 2.3.2.1 Компанийн нягтлан бодох бүртгэлийн тогтолцоо, санхүүгийн мэдээллийн үнэн зөв, нл тод байдлыг хангуулах;
- 2.3.2.2 Гүйцэтгэх удирдлагын зүгээс жил, улирлын санхүүгийн тайланг бэлтгэх явцад хяналт тавих;
- 2.3.2.3 Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хянаж, зөвлөмж гаргах;
- 2.3.2.4 Компанийн жилийн ажлын тайланг батлахын өмнө зөвлөмж бэлтгэн ТУЗ-д оруулах бөгөөд үүнд санхүүгийн тайлан, түүний тайлбар, тодруулга, түүнтэй холбоотой менежментийн хэлэлцүүлэг, дүн шинжилгээ (MD&A)-г хамруулсан байна.
- 2.3.2.5 Компани хуримтлагдсан ашгаас тусгай сан байгуулахаар шийдвэрлэсэн бол уг сангийн бүрдүүлэлт, хөрөнгө зарцуулалтын тайланг хянаж, дүгнэлт гаргах
- 2.3.2.6 Хороо нь компанийн хийхээр төлөвлөж буй их хэмжээний болон сонирхлын зорчилтэй хэлцлийн талаар дүгнэлт гаргаж ТУЗ-д оруулна.

**2.3.3 Дотоод хяналтын чиглэлээр:**





- 2.3.3.1 Дотоод хяналт шалгалтын асуудал хариуцсан дотоод аудиторыг сонгох цалин урамшууллыг тогтоох, түүний хараат бус байдлыг хангах асуудлаар зөвлөмж гаргана.
- 2.3.3.2 Дотоод аудитортой тусгайлан уулзалт зохион байгуулах ба компанийн санхүү, нягтлан бодох бүртгэл, эдийн засгийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар хамтарсан зөвлөмж боловсруулан гаргах түүнчлэн шаардлагатай тохиолдолд дотоод аудитор хороотой чөлөөтэй харилцах нөхцөл бүрдүүлнэ.
- 2.3.3.3 Дотоод аудиторын үйл ажиллагаанд зорилго, эрх, үүрэг, үйл ажиллагааны тайлагнал, дараа жилийн аудитын төлөвлөгөө, дотоод аудитын үр дүн, дотоод аудитын үйл ажиллагааг сайжруулах талаарх зөвлөмж үнэлгээ өгнө.
- 2.3.3.4 Дотоодын аудиторын ажлын тайланг хянаж, цаашид хийх төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус аудитын ажилд зөвлөмж өгнө.



#### 2.3.4 Хууль, журам хэрэгжилтийг хянах буюу комлайнсийн талаар:

- 2.3.4.1 Компанийн тухай болон компанийн үйл ажиллагаа явуулж салбар болох банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааг зохицуулж буй хууль тогтоомж, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан банк бус санхүүгийн үйл ажиллагааны багц журмын жагсаалт, хэрэгжилтийг хариуцан зохион байгуулах, хянах чиг үүрэг бүхий этгээд, тэдгээрийн чиг үүргийг багтаасан дотоод журмыг хуулийн хэлтэс /хуулийн зөвлөх/-ээр боловсруулж, батлуулах хэрэгжилтийг жилд нэгээс доошгүй удаа сонсож холбогдох арга хэмжээ авах, ТУЗ-д танилцуулах
- 2.3.4.2 Дотоод хяналт шалгалтын явц, нягтлан бодох бүртгэл, тайлан, хөндлөнгийн аудиттай холбоотой асуудлаар компанид ирүүлсэн гомдол, санал, Санхүүгийн зохицуулах хороо болон бусад төрийн эрх бүхий байгууллагаас хийсэн хяналт шалгалтын дүн, анхааруулга сануулга зэргийн хэрэгжилтийг хянах журмыг боловсруулан мөрдөнө.
- 2.3.4.3 Ажиллагсад нэргүй санал, гомдол гаргах нөхцөлийг бүрдүүлэх ба тэдгээр гомдол, түүн дотор хяналт шалгалтын үйл ажиллагаанд чухал үүрэг гүйцэтгэдэг гүйцэтгэх удирдлага болон бусад менежер, ажилтантай холбоотой залилан, хууль бус, ёс суртахуунд нийцээгүй үйлдэл, эс үйлдлийн талаар ирүүлсэн мэдээллийн мөрөөр хяналт шалгалт хийх журам тогтоож, хэрэгжилтэд хяналт тавина.


#### Гурав. Нэр дэвшүүлэх хорооны бүтэц бүрэлдэхүүн, чиг үүрэг

##### 3.1 ТУЗ-ийн гишүүн, удирдах ажилтанд нэр дэвшүүлэх

- 3.1.1 ТУЗ-ийн гишүүн, ерөнхий захирал зэрэг эрх бүхий албан тушаалд нэр дэвшигчдийг сонгон шалгаруулахад тавигдах шалгуур, үзүүлэлтийг тогтоох зөвлөмжийг боловсруулна.
- 3.1.2 ТУЗ-ийн гишүүн, ерөнхий захиралд нэр дэвшигчдэд урьдчилсан үнэлгээ өгнө.
- 3.1.3 ТУЗ-ийн, ерөнхий захирлын ажил үүргийн тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээний нөхцөлийг хянаж, дүгнэлт өгнө.



- 3.1.4 ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчийг бүртгэх, энэхүү журмаар тогтоосон шаардлагыг хангаж байгаа эсэхийг хянах, нэр дэвшигчийг жагсаалтад бүртгэх эсэхийг шийдвэрлэх асуудлыг ТУЗ-ийн гишүүдийн дотроос сонгогдсон 3 гишүүн бүхий Нэр дэвшүүлэх хороо хариуцан хэрэгжүүлнэ.
- 3.1.5 ТУЗ-ийн гишүүнд дараах журмаар дэвшүүлнэ:
- 3.1.5.1 Нийт гаргасан хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа этгээд ТУЗ-ийн сонгууль явуулах жилийн 3 дугаар сарын 1-ний дотор энэ журмаар тогтоосон шалгуур шаардлагыг хангасан этгээдийн нэрийг Нэр дэвшүүлэх хороонд ирүүлнэ.
- 3.1.5.2 ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчийг дараах журмаар жагсаалтад бүртгэнэ:
- 3.1.5.3 Эрх бүхий этгээдээс ирүүлсэн нэр дэвшүүлэх санал, хавсаргасан баримтуудыг ТУЗ-ийн Нэр дэвшүүлэх хорооны Нарийн бичгийн дарга хүлээн авч, бүрдлийг шалгаад бүрэн бүрдсэн нэр дэвшигчийн материалыг дараах ажлын өдөр Хорооны даргад танилцуулна.
- 3.1.5.4 Хорооны дарга ирүүлсэн бичиг баримт, нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалт зэргийг Нэр дэвшүүлэх Хорооны хуралд ажлын 3 хоногийн дотор танилцуулна. Хорооны хурлаар нэр дэвшигч бүрийн асуудлыг хэлэлцэж, гишүүдийн олонхийн саналаар нэр дэвшигчийн нэрийг жагсаалтад бүртгэх эсэх тухай шийдвэр гаргана. Жагсаалтад бүртгэхээс татгалзсан тохиолдолд үндэслэлээ нэр дэвшүүлсэн этгээдэд бичгээр мэдэгдэнэ. Жагсаалтад бүртгэхээс татгалзсан нь үндэслэлгүй гэж үзвэл бичгээр мэдэгдэл хүлээн авснаас хойш ажлын 3 хоногийн дотор ТУЗ-ийн даргад гомдол гаргах эрхтэй. ТУЗ-ийн дарга гомдлыг хүлээн авснаас хойш ажлын 3 хоногт багтаан асуудлыг ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэр гаргана. ТУЗ-ийн шийдвэр эцсийн шийдвэр байна.
- 3.1.6 Нэр дэвшигчийг жагсаалтад бүртгэхээс дараах үндэслэлээр татгалзаж болно.
- 3.1.6.1 Нэр дэвшигч нь энэ журмын 3 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаагүй
- 3.1.6.2 Нэр дэвшигч нь өмнө нь компанийн ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байхдаа “хангалтгүй ажилласан” гэсэн дүгнэлт авснаас хойш 5 жил өнгөрөөгүй.
- 3.1.7 Хараат бус гишүүнд нэр дэвшүүлэхдээ дараах журмыг баримтлана. Үүнд:
- 3.1.7.1 ТУЗ-ийн сонгууль болох жилийн 3 дугаар сарын 1-ний дотор олон нийтийн мэдээллийн хэрэгсэлээр ТУЗ-ийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах зарыг нийтэд мэдээлнэ.
- 3.1.7.2 Нийтэд түгээсэн зарын дагуу хараат бус гишүүнд нэр дэвшигчдийн баримт бичгийг нэр дэвшүүлэх хорооны гишүүдэд хүргүүлэх бөгөөд Нэр дэвшүүлэх хорооны хурлаар хэлэлцээд шалгуур шаардлага хангасан хүмүүсийн нэрийг “Саналын хуудас”-д оруулахаар шийдвэрлэнэ.
- 3.1.8 Энэ журмаар тодорхойлсон ТУЗ-ийн гишүүний хараат бус байдлыг тодорхойлох шалгуурыг хянан үзэх, хараат бус эсэх (эсвэл хараат байдлын) талаар дүгнэлт гаргаж, хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэх үүрэгтэй.
- 3.1.9 Шинээр сонгогдсон гишүүдэд ТУЗ-ийн гишүүний үүрэг хариуцлагын талаар тодорхой мэдээлэл өгч, удирдамж, зааварчилгаагаар хангаж, сураглт зохион байгуулах ажлыг хариуцан хэрэгжүүлнэ.
- 3.1.10 Компанийн эрх бүхий албан тушаалтны залгамж халааг бэлдэх төлөвлөгөө, хэрэгжүүлэх бодлогыг хянаж, зөвлөмж өгнө.



- 3.1.11 Гүйцэтгэх захиралд нэр дэвшүүлэхдээ ТУЗ-ийн даргын саналыг юуны өмнө хүлээн авч, Нэр дэвшүүлэх хорооны хуралаар хэлэлцүүлнэ. Нэр дэвшүүлэх хороо тухайн хүнийг гүйцэтгэх захирал тавих шалгуур шаардлагыг хангахгүй гэж үзсэн тохиолдолд олон шийтэд зар түгээх, ТУЗ-ийн гишүүдээс санал авах зэрэг аль тохиромжтой гэж үзсэн аргаар нэр дэвшигчийг сонгон шалгаруулж, Хорооны хурлаар хэлэлцээд ТУЗ-ийн хуралд оруулж хэлэлцүүлнэ.
- 3.1.12 Гүйцэтгэх захирлаас бусад эрх бүхий албын тушаалтныг сонгон шалгаруулах асуудлыг гүйцэтгэх захирал шийдвэрлэнэ.



**3.2 Төлөвлөн удирдах зөвлөл болон удирдах албан тушаалтны ажлыг үнэлэхдээ:**

- 3.2.1 Ерөнхий захирал, гүйцэтгэх удирдлагын эрх бүхий албан тушаал бүрээр ажлын байрны тодорхойлолт боловсруулах, тэдгээр ажлын байр бүрээр ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуур, дүрэм журмыг боловсруулах талаар чиглэл удирдамжаар хангах.
- 3.2.2 ТУЗ-ийн гишүүнийг дахин сонгохоос өмнө тухайн гишүүний жилийн ажлыг үнэлэх шалгуурууд, дүрэм журмыг боловсруулна.
- 3.2.3 Ерөнхий захирлын ажлыг үнэлэх шалгуурын дагуу үнэлэх, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн болон компанийн бусад хэсэг, нэгжийн даргын ажлыг үнэлэх шалгуурын дагуу ерөнхий захирлаас өгсөн үнэлгээний тайланг сонсож, дүгнэлт өгөх;
- 3.2.4 ТУЗ-ийн жилийн ажлын өөрийн үнэлгээний аргачлалыг боловсруулж ТУЗ-өөр батлуулан, аргачлалын дагуу үнэлэх, эсхүл гуравдагч этгээдээр үнэлгээг хийлгэнэ.
- 3.2.5 ТУЗ-ийн хурлаар өөрийгөө үнэлсэн болон хөндлөнгийн байгууллагын үнэлгээний үр дүнг танилцуулж, хэлэлцүүлнэ.
- 3.2.6 ТУЗ-ийн үйл ажиллагааг сайжруулах зорилгоор үнэлгээний үр дүнд дүгнэлт хийж, зөвлөмж боловсруулна.
- 3.2.7 Шаардлагатай тохиолдолд ТУЗ-ийн гишүүдэд зориулсан сургалт зохион байгуулна.
- 3.2.8 ТУЗ-ийн гишүүдийн үнэлгээний үр дүнг зөвлөмжийн хамт Хувьцаа эзэмшигчдийн хурлаас өмнө хувьцаа эзэмшигч нарт хүргэнэ.
- 3.2.9 Үр дүн, зөвлөмжийн тоймыг компанийн жилийн тайланд тусгана.

**Дөрөв. ТУЗ-ийн цалин урамшууллын хорооны бүтэц бүрэлдэхүүн, дараах чиг үүрэг**

- 4.1 ТУЗ, удирдах ажилтан болон бусад эрх бүхий ажилтан, түүний дотор эрсдэл хүлээхтэй холбоотой чиг үүрэг хэрэгжүүлдэг ажилтанд олгох цалин хөлс болон урамшууллын бодлогыг тухайн ажилтны ажил үүргийн хэрэгжилт, стратегийн зорилтыг биелүүлэхэд чиглэсэн үйлдэл, оруулсан хувь нэмэр болон ТУЗ-аас баталсан зорилго, зорилтыг хэрхэн биелүүлсэн байдлыг харгалзах, урамшуулах үзүүлэлт нь компанийн эрсдэлийг нэмэгдүүлэхэд хүргэхээргүй байх зарчмыг баримтлан боловсруулж, түүнд хяналт тавих;
- 4.2 ТУЗ-ийн дарга, хорооны гишүүн болон бусад зөвлөлийн гишүүдэд компаниас олгох цалин урамшууллын шалгуурыг гишүүдийн хараат бус байдал нөлөөлөхгүй, өрсөлдөх чадвартай байлгахаар боловсруулах;
- 4.3 Хорооноос гүйцэтгэх захирал, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүдийн жилийн үндсэн цалингийн дээд хэмжээ, ажлын гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлтэд суурилсан урамшууллын систем, менежерүүдийн ашиг сонирхлыг компанийн бизнес төлөвлөгөөний болон тухайн ажлын байрны зорилгын хэрэгжилттэй уялдуулах урт хугацааны урамшууллын систем мөн хувьцаа эзэмшүүлэх болон тэтгэвэр, тэтгэмж болон бусад нэмэлт орлогыг тогтоож, тогтмол хянах;






- 4.4 Компанийн цалин урамшууллын шалгуурыг компанийн хөгжлийн стратеги, бизнес тогловгоононй болон компанийн зорилго, зорилттой уялдуулах нөхцөл байдал болон ходолморийн зах зээлийн давамгай хандлага зэрэгт үндэслэн тохиромжтой эсэхийг тогтмол хянах;
- 4.5 Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарсан захирал, удирдах албан тушаалтны цалин урамшуулалтай холбоотой шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих;
- 4.6 Ажилчдын цалин урамшууллын бодлого боловсруулах чиглэлээр компанийн удирдлага болон хүний нөөцийн боловсруулсан төсөлд санал өгөх,

#### **Тав. Эрсдэлийн удирдлагын хорооны бүтэц бүрэлдэхүүн, чиг үүрэг**

- 5.1 Компанийн гүйцэтгэх удирдлагын зүгээс үндсэн үйл ажиллагаа, санхүү, хууль эрх зүйн үндсэн эрсдлүүдийг тодорхойлох, үнэлэх, бууруулах, хянах талаар баримталж буй бодлогыг хянаж, дүгнэлт өгөх, сайжруулах удирдамжаар хангах;
- 5.2 Эрсдэлийн удирдлагын бодлогын баримт бичгийг хянаж, ТУЗ-өөр батлуулан үйл ажиллагаандаа удирдлага болгон ажиллана

#### **Зургаа. Хороодын хурлыг зохион байгуулах**

- 6.1 ТУЗ-ийн Хороодын хурлыг зохион байгуулахдаа дараах журмыг баримтлана. Үүнд:
  - 6.1.1 Хорооны ажлын төлөвлөгөөнд тусгагдсан эсвэл Хорооны хурлаар хэлэлцүүлэхээр эрх бүхий этгээдээс санал ирүүлсэн тохиолдолд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Хорооны хурлын товыг бэлдэн Хорооны даргаар батлуулж, хорооны гишүүдэд мэдээлэл хүргүүлнэ.
  - 6.1.2 Хорооны гишүүн Хорооны хурлын товыг хүлээн авсан тухайгаа заавал харну мэдэгдэнэ.
  - 6.1.3 Хорооны хурлыг товлосон өдөр цагт, товлосон байранд хуралдуулна.
  - 6.1.4 Хорооны хурлыг Хорооны дарга удирдан явуулна. Хорооны даргын эзгүйд түүний томилсон этгээд, ийм этгээд байхгүй бол хуралд оролцож буй хамгийн ахмад гишүүн удирдан явуулна.
  - 6.1.5 Хурал удирдаж буй гишүүн хурлаар хэлэлцэх асуудлын талаар мэдээлэл огно. Хэрвээ хорооны гишүүн биш этгээд хэлэлцэх асуудлыг танилцуулж байгаа бол уг этгээд асуудлыг танилцуулна.
  - 6.1.6 Асуудал танилцуулсны дараа гишүүд уг асуудлыг сайтар хэлэлцэн дүгнэлт гаргах талаар саналаа танилцуулна.
  - 6.1.7 Хорооны гишүүд саналаа танилцуулж дууссаны дараа хэлэлцэж буй асуудлаар гаргах дүгнэлтийг хурал удирдаж буй гишүүн томъёолж, гишүүдэд уншиж танилцуулан, санал хураах замаар Хорооны хурлаас гаргах дүгнэлтийг батална.
  - 6.1.8 Хорооны хурлаас гаргах дүгнэлтийг Хорооны хурлын тогтоол хэлбэрээр батална.
  - 6.1.9 Хороодын хурлаас гарсан дүгнэлтийг ТУЗ-ийн хуралд оруулан танилцуулна.



“Бэрс финанс ББСБ” ХХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 01- сарын 04-ны өдрийн 23/01а/01 тоот тогтоолын Хавсралт 3

## “БЭРС ФИНАНС ББСБ” ХК-ИЙН ДОТООД ХЯНАЛТ, АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Компанийн тухай хууль, “Бэрс финанс ББСБ” ХХК-ийн дүрмийн хүрээнд компанийн Дотоод хяналт, аудитын үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.
- 1.2 Компанид дотоод хяналтын болон эрсдлийн удирдлагын зохистой тогтолцоо бүрдүүлэх нь гүйцэтгэх захирлын үүрэг байх бөгөөд энэхүү тогтолцоо нь хууль тогтоомж, дүрэм журам, стандарт, тогтоосон горимын мөрдөлт, компанийн үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөний болон компанийн хэрэгжүүлж буй төслийн явц биелэлт, санхүүгийн болон бусад тайлан мэдээллийн бодит байдлыг хангах зорилгод хэр нийцэж байгааг хянаж, дүгнэлт гаргах, тавих нь компанийн ТУЗ-ийн Аудитын хорооны үүрэг байна.

### ХОЁР. ДОТООД ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО БҮРДҮҮЛЭХ ЧИГЛЭЛ

#### 2.1 Дотоод хяналтын тогтолцоог дараах 4 чиглэлийг хамруулан бүрдүүлнэ:


##### 2.2 Эрсдэлийн удирдлагын талаар:

- 2.2.1.1 Компанийн үйл ажиллагааны явцад хэрэгжих процесс /ажилбар/-ыг жагсаан процесс тус бүртэй холбогдсон техник технологи, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, санхүү, хууль эрх зүйн болон бусад эрсдлийг тодорхойлж, үнэлээд, эрсдэл тус бүрийн хувьд шилжүүлэх, хуваалцах, бууруулах зэргээр тохирох аргаар удирдах, хянах талаар баримтлах бодлогыг тодорхойлж, хэрэгжилтийг хянах;
- 2.2.1.2 Компанийн дотоод аудитын болон хөндлөнгийн аудитын өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хянах;
- 2.2.1.3 Компанийн мэдээллийн системийн аюулгүй байдал, мэдээллийн тогтолцооны үр ашигтай байдлыг хянах.

##### 2.3 Санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлангийн талаар:

- 2.3.1 Компанийн нягтлан бодох бүртгэлийн тогтолцоо, санхүүгийн мэдээллийн үнэн зөв, ил тод байдлыг хангуулах;
- 2.3.2 Гүйцэтгэх удирдлагын зүгээс жил улирлын санхүүгийн тайланг бэлтгэх явцыг хянах;
- 2.3.3 Компанийн аж ахуй санхүүгийн үйл ажиллагаанд бүртгэлээр хяналт тавих бодлогын хэрэгжилтийг хянах;
- 2.3.4 Компанийн хийхээр төлөвлөж буй их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг хянах;
- 2.3.5 Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал болон ТУЗ-ийн шийдвэрээр болон төрийн эрх бүхий хяналт шалгалтын байгууллагаас хийсэн аливаа шалгалтын үр дүн, шалгалтын ажлын хэсгээс өгсөн үүрэг даалгаварын хэрэгжилтийг хянах.

##### 2.4 Хөндлөнгийн аудитортой хамтран ажиллах чиглэлээр:





- 2.4.1 Компанийн санхүүгийн тайланд аудит хийх хөндлөнгийн аудиторыг сонгох талаар хууль болон компанийн дүрэмд заасан журмыг хэрхэн баримталж байгаад хяналт тавих: Үүнд аудиторын мэргэжлийн ур чадвар, хараат бус байдал, ашиг сонирхлын зорчил үүсч болох эсэх асуудал мөн түүнчлэн аудитын үйлчилгээний холс, толорхой асуудлаар дүгнэлт гаргуулах шаардлага байгаа эсэх, байгаа бол аудитын үйлчилгээний гэрээнд нэмэлт даалгавар болгон тусгах тухай асуудалд;
- 2.4.2 Хөндлөнгийн аудитын томилгоотой холбогдуулан хөндлөнгийн аудитын үйл ажиллагааг дүгнэсэн, сонгон шалгаруулсан байдлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулдаг журам тогтоох, хэрэгжилтийг хангах;
- 2.4.3 Хөндлөнгийн аудиторын үйлчилгээний чанарыг жилийн эцэст үнэлж дүгнэх, хөндлөнгийн аудиторыг дахин үргэлжлүүлэн сонгох эсвэл гэрээг цуцлах асуудлаар санал зөвлөмж бэлтгэн ТУЗ-ийн Аудитын хорооны хуралд оруулдаг журам тогтоон хэрэгжилтийг хангах;
- 2.4.4 Гүйцэтгэх удирдлага, дотоод аудитор хамтран тухайн жилийн аудитын ажлын төлөвлөгөөг боловсруулах бөгөөд үүнд компанийн тухайн үеийн нөхцөл байдал, хууль тогтоомжоор болон гэрээгээр хүлээсэн үүрэг болон тэдгээрт орсон нэмэлт, өөрчлөлт, хөндлөнгийн аудиторын зөвлөмжийг харгалзан үздэг байх;
- 2.4.5 Аудитын ажиллагаанд хязгаарлалт тавих, мэдээлэлд чөлөөтэй нэвтрэх боломжийг хязгаарлах, шаардлагатай мэдээллийг гаргаж өгөхгүй байх зэргээр аудиторын хэвийн үйл ажиллагаанд ямар нэг саад бэрхшээл учирсан тохиолдолд түүнийг шийдвэрлүүлдэг тогтолцоо бүрдүүлэх;
- 2.4.6 Хөндлөнгийн аудитын шалгалтын явцад илэрсэн зөрчил, түүнийг засч залруулах талаар гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлдэг тогтолцоо бүрдүүлэх;
- 2.4.7 Хувьцаа эзэмшигчдийн хурлын үеэр хөндлөнгийн аудиторт асуулт, тодруулга тавьж хариулт өгөх боломжийг хангах;
- 2.4.8 Компанийн санхүүгийн тайланг СТОУС, компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого зэрэгт нийцүүлэн бэлтгэх нөхцлийг хангах ба компанийн НБББодлого болон хэвшсэн практик нь СТОУС-д хэр нийцтэй байгаа талаар үнэлэлт дүгнэлт хийсэн хөндлөнгийн аудитын дүгнэлтийг анхаарч, холбогдох арга хэмжээ авдаг байх;
- 2.4.9 Хөндлөнгийн аудитороор аудитын бус үйлчилгээ, даалгавар гүйцэтгүүлэхэд компаннаас баримтлах бодлогыг боловсруулах ба шаардлагатай тохиолдолд бусад баталгаажуулах ажил гүйцэтгүүлэх ,аудитын бус үйлчилгээ авахаар бол урьдчилан ТУЗ-өөс зөвшөөрөл авда гбайх тогтолцоог бий болгох;
- 2.4.10 Хөндлөнгийн аудитын зүгээс компанид бусад үйлчилгээ үзүүлэх, аудитын байгууллагыг заавал сольдог байх талаар АОУС болон Аудитын тухай хууль тогтоомжид заасан шаардлагыг хэрэгжүүлэх нөхцлийг хангах.

## 2.5 Комплаинсийн талаар:

- 2.5.1 Компанийн хэмжээнд зайлшгүй дагаж мөрдөх хууль журам, стандарт, дотоод дүрэм журмын жагсаалт гарган хэрэгжилтийг хянах
- 2.5.2 Энэ журамд заасан хууль журам, стандарт, дотоод дүрэм журмын хэрэгжилтийг хянах тогтолцоог бүрдүүлэх талаар компанийн гүйцэтгэх захирлаас хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа болон дүрэм журмын хэрэгжилтийг хянах чиг үүрэг бүхий этгээдийн үйл ажиллагааг хянах.







2.5.3 Дотоод хяналт шалгалт болон хөндлөнгийн аудиттай холбоотой асуудлаар гомдол, санал хүдээн авах, хянаж шийдвэрлэх журам боловсруулан мөрдөх.

2.5.4 Ажилтнууд болон харилцагчид нарыг нэргүй санал, гомдол гаргах /шүгэл үлээх/ нохицлоор хангах ба тэдгээр гомдол, түүн дотор хяналт шалгалтын үйлэжиллагаанд ихээхэн үүрэг гүйцэтгэдэг гүйцэтгэх удирдлага болон бусад менежер, ажилтантай холбоотой залилан, хууль бус, ёс зүйд нийцээгүй үйлдэл, эс үйлдлийн талаар ирүүлсэн мэдээллийг хянаж шалгах.

### ДӨРӨВ. КОМПАНИЙН ДОТООД АУДИТОРЫН ЭРХ ҮҮРЭГ


- 4.1 Компани нь ТУЗ-ийн шийдвэрээр дотоод аудиторыг томилон ажиллуулах бөгөөд аудитор нь нь дараах эрх, үүрэгтэй байна:
- 4.1.1 Компанийн эрх бүхий албан тушаалтан, ажилтнуудаас шаардлагатай баримт бичиг, тайлбар мэдээлэл шаардаж, гаргуулах, тухайн асуудлыг хэлэлцэх ТУЗ-ийн хуралд оролцуулан тайлбар, мэдээлэл гаргуулах.
  - 4.1.2 Аудитын үйл ажиллагааны төлөвлөгөөг ТУЗ-ийн хуралд оруулж батлуулах, батлагдсан төлөвлөгөөг компанийн гүйцэтгэх захиралд хүргүүлэх;
  - 4.1.3 ТУЗ-өөс баталсан удирдамжийн дагуу гүйцэтгэсэн шалгалтын үр дүнг хэлэлцэх зөвлөмж гаргаж холбогдох нэгжийн удирдлагад хүргүүлэх, шийдвэр гаргуулах шаардлагатай гэж үзвэл ТУЗ-ын хуралд оруулан хэлэлцүүлэх;
  - 4.1.4 Аудитын жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явцын талаар ТУЗ-д хагас жилд нэгээс доошгүй удаа танилцуулах;
  - 4.1.5 Хөндлөнгийн болон дотоод аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлтийн явцтай танилцаж цаашид анхаарах, авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал, зөвлөмж гаргах, шаардлагатай гэж үзвэл ТУЗ-ийн хуралд оруулан хэлэлцүүлж, үүрэг даалгавар өгөх шийдвэр гаргуулах;
  - 4.1.6 Дотоод аудитор нь ажил үүргээ хараат бусаар аливаа нөлөөлөлд автахгүйгээр гүйцэтгэхэд ТУЗ-ийн зүгээс шаардлагатай дэмжлэг хүсэх, шаардлагатай сургалтанд хамрагдах хүсэлт гаргах;
  - 4.1.7 Дотоод аудиттай холбоотой асуудлаар албан тушаалтнуудын хооронд зөрчил, маргаан үүсвэл түүнийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хянан, шийдвэрлүүлэхээр ТУЗ-д оруулах;
  - 4.1.8 Тухайлсан асуудлаар шалгалт явуулахаар ТУЗ-өөс өгсөн үүрэг, удирдамжийн дагуу шалгалтыг зохион байгуулах, энэхүү шалгалтад компаниас холбогдох албан тушаалтан, ажилтныг татан оруулах талаар ТУЗ-ийн даргад санал хүргүүлэх;
  - 4.1.9 Шалгалт явуулах асуудлаар компанийн гүйцэтгэх захиралтай зөвшилцөж, шалгалтын төлөвлөгөөг боловсруулах;
  - 4.1.10 Шаардлагатай тохиолдолд хөндлөнгийн зөвлөх, аудит, шинжээчийн туслалцаа авах асуудлыг ТУЗ-д тавьж шийдвэрлүүлэх;
  - 4.1.11 Өөрийн ажил үүргийн дагуу олж авсан компанийн дотоод мэдээллийн нууцыг чандлан хадгалах;
  - 4.1.12 Чиг үүргээ хэрэгжүүлэхдээ сонирхлын зөрчил үүсэхээс сэргийлж, үүссэн тохиолдолд энэ талаар ТУЗ-ийн хуралдаанд мэдээлэн, шалгалтын ажлын хэсэгт оролцохоос татгалзах;
  - 4.1.13 Үйлчлүүлэгч, харилцагчдын ирүүлсэн мэдээлэл, санал, хүсэлт гомдлын мөрөөр болон ТУЗ, гүйцэтгэх захирлын өгсөн үүрэг даалгаварын дагуу гэнэтийн байдлаар хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэх;
  - 4.1.14 Шалгалтын ажлыг ТУЗ-ийн аудитын хорооны даргын баталсан удирдамжид заасан хугацаанд чанартай хийж гүйцэтгэх;



- 4.1.15 Монгол Улсад мөрдөгдөж буй хууль тогтоомж, Олон улсын Дотоод аудиторуудын институтээс гаргасан дотоод аудиторын ёс зүйн дүрэм, дотоод аудитын мэргэжил, практикын олон улсын стандартуудыг баримтлан ажиллах;
- 4.1.16 Хяналт тавих шалгалт хийхтэй холбогдон шаардлагатай бүхий л мэдээлэл, баримтыг эрх бүхий албан тушаалтнууд болон ажилтнуудаас гаргуулан авах, шалгалтын явцад олж авсан мэдээллийн нууцыг хадгалах;
- 4.1.17 Шалгалтын явцад танилцсан, олж авсан бүхий л бүртгэл, баримт бичиг, мэдээллийг зөвхөн дотоод аудитын үйл ажиллагаанд ашиглах;
- 4.1.18 Мэргэжлийн мэдлэг, чадвараа тасралтгүй хөгжүүлэх;
- 4.1.19 Хяналт, шалгалтын чиг үүргээ хэрэгжүүлэхдээ аливаад шударга, бодитоор хандах ба мэргэжлийн эсвэл хувийн ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллах;
- 4.1.20 Хууль тогтоомж, дүрэм журам болон баримт нотолгоонд үндэслэн шалгалтын дүгнэлт хийж, зөвлөмж өгөх;
- 4.1.21 Дотоод аудитор нь шалгалтын явцад бүрдүүлсэн ажлын баримтанд хувийн дугаар бүхий тэмдэг дарж, гарын үсэг зурах бөгөөд эдгээр баримт нь шалгалтын дүгнэлт бодитой, үнэн зөв болохыг баталгаажуулах үндэслэл болно.
- 4.1.22 Дотоод аудиторт дараах тохиолдолд ТУЗ-ийн шийдвэрээр хариуцлага хүлээлгэнэ:
- 4.1.22.1 Энэ дүрмээр тогтоосон үүргээ зөрчсөн, хэрэгжүүлээгүй, эрхээ хэтрүүлэн юмуу урвуулан ашигласан нь тогтоогдсон;
- 4.1.22.2 Аудитын хяналт, шалгалтын ажлын төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг цаг хугацаанд хэрэгжүүлээгүй;
- 4.1.22.3 Хяналт, шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг нуун дарагдуулсан, шудрага бус байдлаар хандаж, компанийн нууц задруулсан.
- 4.1.22.4 Дотоод аудитор нь энэ журмын 4.1.22-т заасан зөрчлийг гаргасан гэж үзвэл холбогдох албан тушаалтан ТУЗ-д мэдээлэл хүргүүлнэ.
- 4.1.22.5 УЗ нь энэхүү мэдээллийн дагуу шалгалт явуулах этгээдийг томилон ажиллуулж, аудитор зөрчил гаргасан эсэхийг тогтооно.
- 4.2 Аудиторын зөрчилтэй холбоотой асуудлыг хэлэлцэхдээ тухайн аудиторыг өөрийг нь байлцуулж, тайлбар өгөх боломжийг хангана.
- 4.3 Аудитор зөрчил гаргасан нь тогтоогдвол аудитын тухай болон хөдөлмөрийн хууль тогтоомж, компанийн дотоод журамд заасан хариуцлага хүлээлгэнэ.

#### ТАВ. ДОТООД АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ УДИРДАХ ТУЗ-ИЙН БҮРЭН ЭРХ

- 5.1 Дотоод Аудиторын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх талаар ТУЗ нь Аудитын хороогоор дамжуулан дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
- 5.1.1 Компанийн дотоод аудиторыг сонгон шалгаруулах, үйл ажиллагааны төсвийг хянаж, батлах
- 5.1.2 Аудиторын зорилго, эрх, үүргийг тогтоох,
- 5.1.3 Аудитын үйл ажиллагааны тайланг хэлэлцэж, дараа жилийн хяналт, шалгалтын төлөвлөгөөг хянаж батлан, үйл ажиллагааг сайжруулах талаар удирдамж зөвлөмжөөр хангана.
- 5.1.4 Аудиторын үйл ажиллагаанд дүгнэлт өгч, урамшууллын асуудлаар шийдвэр гаргах,



- 5.1.5 Тодорхой чиглэл асуудлаар хийх шалгалтын удирдамжийг хэлэлцэн баталж, тайланг сонсож, хяналт шалгалтын мөроор авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар ТУЗ-д танилцуулан шийдвэр гаргуулна.
- 5.2 ТУЗ нь дотоод аудитортой тусгайлан уулзалт зохион байгуулах журамтай байх ба компанийн санхүү, эдийн засгийн болон бусад үйл ажиллагаатай холбоотой асуудлаар албанаас боловсруулсан зөвлөмжийг хэлэлцэн, эцэслэн гаргана.


### ЗУРГАА. АУДИТОРЫН ХАРААТ БУС БАЙДАЛ

- 6.1 Дотоод аудитын үйл ажиллагаа нь бие даасан, хараат бус байдлаар явагдана. Дараах нөхцөл байдлаар хараат бус байдлыг тодорхойлно:
- 6.1.1 Аудитор нь компанийн эрх бүхий албан тушаалтан, ажилтнуудаас ажил төрлийн болон хувийн харилцаа, садан төрлийн холбооны хувьд, мөн түүнчлэн аудитын үйлчилгээ үзүүлж байгаатай холбогдсон нөхцөл байдлын хувьд хараат бус байна.
- 6.1.2 Аудитор нь ажил төрлийн болон хувийн харилцаа холбооны хувьд хараат бус байх шаардлагыг хангахын тулд дараах нөхцөл бүрдсэн байна:
- 6.1.3 Аудиторын цалин хөлс, шагнал урамшууллыг зөвхөн түүний хариуцан гүйцэтгэх ажлын хэмжээ болон ур чадвар дадлага туршлагад суурилж тогтоох бөгөөд байгууллагын үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлт, санхүүгийн байдлаас мөн түүнчлэн аудитын шалгалтын үр дүнд хийсэн дүгнэлтийн шинж чанараас хамааруулан тогтоогоогүй байх;
- 6.1.3.1 Компанийн эрх бүхий албан тушаалтнуудтай Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.30-д заасны дагуу тодорхойлсон холбогдох этгээд биш;
- 6.1.3.2 Аудитороор ажиллаж эхлэхээс өмнөх 24 сарын хугацаанд компанитай материаллаг хэмжээтэй гэж тооцогдохуйц гэрээ хэлцэл хийгээгүй;
- 6.1.3.3 Тухайн компанид аливаа хэлбэрээр хөрөнгө оруулалт хийгээгүй.
- 6.1.4 Аудитор нь үндсэн ажил үүрэгтэй холбогдсон нөхцөл байдлын хувьд хараат бус байх шаардлагыг хангахын тулд дараах шаардлагыг хангасан байна:
- 6.1.4.1 Тухайн компанийн үйл ажиллагааны болон нягтлан бодох бүртгэлийн онцлогийг сайн мэддэг, энэ чиглэлээр дадлага туршлагатай;
- 6.1.4.2 Тухайн компанийн үйл ажиллагааны онцлогт тохирсон аудитын үйл ажиллагааны горим, дотоод хяналтын журмыг бие даан боловсруулах чадвартай;
- 6.2 Дотоод аудитор нь шалгалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд нөлөөлсөн аливаа дарамт, шахалт, зохимжгүй нөлөөллийн талаар ТУЗ-ийн Аудитын хороонд мэдээлнэ.
- 6.3 Дотоод аудитор нь хяналтын ажил үүргээ хараат бусаар, аливаа нөлөөлөлд автахгүйгээр гүйцэтгэхэд ТУЗ бүх талаар дэмжлэг үзүүлнэ.

### ДОЛОО. ХӨНДЛӨНГИЙН АУДИТТАЙ ХАРИЛЦАХ

- 7.1 Дотоод аудитор нь ТУЗ-ийн дэмжлэгтэйгээр Хөндлөнгийн аудитын байгууллагатай дараах хүрээнд хамтран ажиллана:
- 7.1.1 Жилийн болон шалгалтын тоолологоо, тайлангаа харилцан мэдээлэх;
- 7.1.2 Хөндлөнгийн аудитын гаргасан дүгнэлтийн талаар тайлбар авах хүсэлт хүргүүлэх.
- 7.1.3 Хамтарсан сургалт зохион байгуулах, арга зүй, туршлагаа хуваалцах;
- 7.1.4 Харилцан мэдээлэл солилцох;







7.1.5 Хөндлөнгийн аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх асуудлаар арга зүйн туслалцаа авах, сургалт зохион байгуулах зардал төсвийг батлуулан, хөндлөнгийн аудитын байгууллагын ажилтнуудаар сургалт явуулах.

### **НАЙМ. ДОТООД АУДИТОРТОЙ ХАМТРАН АЖИЛЛАХ ТАЛААР КОМПАНИЙН УДИРДЛАГА, АЖИЛТНУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ**

- 8.1 Дотоод аудитын үйл ажиллагаа нь компанийн удирдлагын зүгээс Дотоод хяналт, Эрсдлийн удирдлага болон сайн засаглалын тогтолцоог бий болгох, түүнийг хэрэгжүүлэх, цаашид сайжруулахад тулах үндсэн үүрэгтэй.
- 8.2 Дотоод аудитор нь хяналт, шалгалтын үйл ажиллагаа явуулах зорилгоор шаардсан мэдээ, материалыг хугацаанд гаргаж өгөх, хүсэлт гаргасан үед ярилцлага, лавлагаа, тайлбар өгөх, шалгалт хийж байгаа үед ажлын байр, техник хэрэгсэл зэрэг зайлшгүй шаардлагатай зүйлсээр хангах нь компанийн бүх шатны менежерүүд, ажилтны үүрэг байна.
- 8.3 Компанийн гүйцэтгэх захирал, менежерүүд, бусад эрх бүхий албан тушаалтан нь Дотоод аудиторуудын хяналт шалгалтын удирдамжтай, шалгалт дууссан үед тэдгээрийн тайлантай танилцах, гаргасан дүгнэлтийн талаар тайлбар, тодруулга хүсэх, тэдгээрийн үндэслэл болсон ажлын баримттай танилцах, гаргасан дүгнэлттэй санал нийлээгүй бол энэ тухайгаа шалгалтын удирдамжийг баталсан этгээдэд бичгээр тайлбар хүргүүлэх, шалгалтын тайланг хэлэлцэхэд биечлэн оролцох эрхтэй.
- 8.4 Дотоод аудитор нь хийсэн хяналт шалгалтын мөрөөр илэрсэн зөрчил доголдыг арилгах, дотоод хяналтын, эрсдэлийн удирдлагын тогтолцоо болон засаглалыг сайжруулах, компанид учруулсан хохирлыг нөхөн төлөх талаар гүйцэтгэх захирал болон бусад эрх бүхий албан тушаалтанд хугацаатай үүрэг даалгавар, зөвлөмж хүргүүлэх эрх эдлэх бөгөөд гүйцэтгэх захирал нь дотоод аудитын даалгавар, зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган шалгалт хийсэн аудиторт танилцуулж, ТУЗ-д танилцуулан батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулах, ТУЗ-д тайлагнах үүрэг хүлээнэ.
- 8.5 Компанийн үндсэн үйл ажиллагаа болон зохион байгуулан хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд учирч болох эрсдэл, сэжиг бүхий үйл ажиллагаа, холбогдох хууль, дүрэм, заавар зөрчигдож байгаа асуудлаар компанийн ажилтан ажиллагсад дотоод аудиторт мэдээлэл өгөх үүрэгтэй бөгөөд дутагдал, зөрчлийг мэдсээр байж түүнтэй эвлэрч нуун дарагдуулахаас зайлсхийх үүрэг хүлээнэ. Энэ талаар бүх ажилтууд, менежерүүдийн "Ажлын байрны тодорхойлолт"-д тусгасан байна.
- 8.6 Дотоод аудитороос энэ журмын 8.4-т заасан шаардлагыг хүлээж авсан албан тушаалтан заасан хугацаанд хохирлыг нөхөн төлүүлэх арга хэмжээ авч энэ тухайгаа аудиторт бичгээр мэдэгдэнэ. Хэрэв шаардлагыг хүлээж авахаас татгалзсан буюу тогтоосон хугацаанд хохирлыг нөхөн төлүүлэх арга хэмжээ аваагүй бол буруутай албан тушаалтанд компанийн дотоод журамд заасны дагуу хариуцлага тооцуулахаар ТУЗ-д саналаа хүргүүлнэ. Асуудлыг компанийн хүрээнд шийдвэрлэж чадаагүй бол ТУЗ-ийн шийдвэрээр уг асуудлыг хууль хяналтын байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.

### **ЕС. ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫГ ТӨЛӨВЛӨХ**




- 9.1 Дотоод аудитын хяналт, шалгалт нь компанийн дотоод хяналтын, эрсдэлийн удирдлагын болон засаглалын тогтолцоонд мониторинг хийх замаар үнээлт өгөх, тодорхой чиглэлийн асуудлаар аудит хийх замаар баталгаажуулах, энэхүү үйл ажиллагааны үр дүнд удирдлагад зөвлөмж өгөхөд чиглэнэ.
- 9.2 Дотоод аудитын төлөвлөгөөг боловсруулахад дараах зарчмыг баримтална:
- 9.2.1 Дотоод аудитын төлөвлөгөө нь компанийн зорилго зорилттой уялдсан, эрсдэл суурилсан байна.
- 9.2.2 Дотоод аудитын төлөвлөгөө нь компанийн дотоод аудитын тогтолцоог бүрдүүлж буй хэсгүүд болон хувыцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-ийн даалгавараар хэрэгжүүлж буй хяналт шалгалтын ажилтай уялдуулах, нооц боломжийг оновчтой ашиглахад чиглэсэн байна.
- 9.2.3 Төлөвлөгөө боловсруулах үндэслэл болсон мэдээлэл нь үнэн зөв, бодитой судалгаа, шинжилгээнд суурилсан, тухайн асуудалд хамааралтай байна.
- 9.2.4 Гэнэтийн шалгалт хийх удирдамж төлөвлөгөө, жилийн төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулахдаа үндэслэл бүхий мэдээлэл, судалгаа шинжилгээ, эрх бүхий этгээдийн хүсэлтэд үндэслэсэн байна.
- 9.3 Аудитын жилийн төлөвлөгөөний төслийг өмнөх оны 11 дүгээр сард багтаан энэ журмын 9.2-т заасан зарчмын дагуу боловсруулж, компанийн гүйцэтгэх захиралд хүргүүлэх бөгөөд захирал нь дотоод аудитортой хамтран төлөвлөгөөний төслийг хэлэлцээд, өөрсдийн дотоод хяналтын ажлын төлөвлөгөөний төсөл, дотоод аудитын төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулан, дотоод аудиторт 12 дугаар сарын 10-ны дотор хүргүүлнэ.
- 9.4 Дотоод аудитор нь төлөвлөгөөний төслүүдийг хянаад, төсөлд нэмэлт өөрчлөлт оруулах нь зүйтэй гэж үзвэл нэмэлт оруулах зэргээр дотоод аудитын төлөвлөгөөг эцэслэн боловсруулж, ТУЗ-ийн Аудитын хороонд батлуулахаар оруулна. Эцэслэн батлагдсан төлөвлөгөөг компанийн гүйцэтгэх захиралд хүргүүлнэ.
- 9.5 Энэ журмын 9.4-т заасан уялдуулан боловсруулсан компанийн хэмжээний дотоод аудитын төлөвлөгөө нь компанийн дотоод хяналтын төлөвлөгөө, хяналт шалгалтын төлөвлөгөө гэсэн бүрэлдэхүүнтэй байх бөгөөд эдгээрийг хэрэгжүүлэх нь дотоод аудитын алба болон гүйцэтгэх захирлын үүрэг байна.

## АРАВ. ДОТООД АУДИТЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫГ

### ХЭРЭГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛ

- 10.1 Дотоод аудитын мониторинг буюу аудитын хяналтыг компанийн үйл ажиллагааны бүхий л чиглэлийг хамруулан хэрэгжүүлэх бөгөөд ажиглах, мэдээлэл, судалгаа авах, ярилцлага хийх, тайлбар гаргуулах, мэдээллийг зэрэгцүүлэх, үйл ажиллагааны мэдээллийг хууль, дүрэм журам, стандарт, батлагдсан горим болон төлөвлөгөөг үзүүлэлтгүй тулган шалгах, гадаад эх сурвалжаас /харилцагч банк, бэлтгэн нийлүүлэгч, гэрээ гүйцэтгэгч, худалдан авагч, хөндлөнгүйн аудитор болон бусад/ мэдээлэл авч зэрэгцүүлэх, дүн шинжилгээ хийх, ажлын байранд зураг авалт, бичлэг хийх зэрэг болон хяналтын бусад аргуудыг ашиглан хэрэгжүүлнэ. Хяналтын арга тус бүрийг хэрхэн хэрэгжүүлэх талаар Дотоод аудитор зөвлөмж боловсруулж мөрдүүлнэ.



10.2 Дотоод аудитор нь компанийн үйл ажиллагаанд учирч болзошгүй үйл ажиллагааны болон санхүүгийн эрхдээс урьдчилан сэргийлэх, илэрсэн зорчил дутагдлыг арилгуулах, дотоод хяналтын тогтолцоог боловсронгуй болгох, шинэ санаачилга, үр ашигтай байдал, амжилттай талыг дэмжихийн зэрэгцээ шалгалтын явцад холбогдох ажилтнуудад мэргэжлийн туслалцаа, зөвлөмж өгөх, үйл ажиллагааны хүрээнд үнэлгээ гаргах, мэдээлэл боловсруулах, удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангах үүрэгтэй бөгөөд дор дурьдсан чиглэлийг баримтална.

10.2.1 *Хууль дүрэм журам, ТУЗ, Гүйцэтгэх захирлын гаргасан тогтоол, тушаал, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж буй дотоод хяналтын тогтолцоог үнэлж, дүгнэлт өгөх чиглэлээр:*

10.2.1.1 ТУЗ, Гүйцэтгэх захирлын гаргасан тогтоол, тушаал, шийдвэр компанийн ажилтнууд, тус бүрт хэрхэн хэрэгжиж байгааг хянаж, илэрсэн зорчил дутагдлын талаар дүгнэлт гарган, илэрсэн зорчил дутагдлыг арилгах талаар зөвлөмж боловсруулан удирдлагад хүргүүлэх, хэрэгжилтийг хянах;

10.2.1.2 Төрийн эрх бүхий байгууллага, Нийгмийн даатгал, Татвар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, бусад эрх бүхий байгууллагын удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтэд хяналт тавьж буй дотоод хяналтын тогтолцоог үнэлэхийн тулд шалгалт хийж, зорчил дутагдлыг илрүүлж, арилгуулах талаар шаардлагатай арга хэмжээг авах санал боловсруулж удирдлагад хүргүүлэх;

10.2.1.3 Компани, алба, удирдлагын болон бүртгэлийн зорилгоор бэлтгэгдсэн тайлан мэдээлэл хангалттай, зохистой, найдвартай эсэхэд аудит хийж баталгаажуулна.

10.2.1.4 Компанийн үйл ажиллагаанд хамаарах хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянаж буй байдалд мониторинг хийж зөвлөмж гаргана.

10.2.2 *Компанийн ажилтнуудын ёс зүйн хэм хэмжээ, бичиг хэргийн хөтлөлт, тушаал шийдвэрийн биелэлт, өргөдөл санал гомдол барагдуулалтад хяналт тавих тогтолцоог үнэлж, дүгнэлт өгөх чиг үүргийн хүрээнд:*



10.2.2.1 Компанийн гэрээ, гүйцэтгэх захирлын тушаал, албан бичиг хэргийн хөтлөлт, архив, бүрэн бүтэн, аюулгүй байдал, үүрэг даалгаврын хэрэгжилтийг хянаж, дүгнэлт гарган, сайжруулах талаар зөвлөмж боловсруулан удирдлагад хүргүүлэх;

10.2.2.2 Ажилтнуудын ёс зүйн дүрмийн хэрэгжилт болон сахилга дэг, журам, ажлын цаг ашиглалт зэрэг хөдөлмөрийн дотоод журам, ажлын байрны тодорхойлолтод заасан ажил үүргийн хэрэгжилтэд хяналт, шалгалт хийх ба зорчил дутагдлыг илрүүлж арилгуулах, шаардлагатай арга хэмжээг авах;



10.2.2.3 Компанийн ажил, үйлчилгээ, ажилтантай холбоотой компани дотроос эсвэл удирдаж буй сангууд, харилцагчийн ирүүлсэн санал, хүсэлт, гомдлын мөрөөр ажиллаж, холбогдох дүгнэлтийг гарган, хэрхэн шийдвэрлэх талаар компанийн нэгжүүдэд зөвлөмж өгөх, гаднаас ирсэн санал гомдлын барагдуулалтад хяналт тавих, шаардлагатай тохиолдолд дээд удирдлагад мэдэгдэж арга хэмжээ авах;

10.3 Компанийн үйл ажиллагааг хянах дотоод хяналтын болон эрдэлийн удирдлагын тогтолцоог үнэлэх зорилгоор дараах чиглэлээр хяналт тавьж, шалгалт явуулна.





- 10.3.1 Компаниас хөрөнгө оруулсан төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажиллагаа нь байгаль орчинд хор нөлөөлөл үзүүлж байгаа эсэх;
  - 10.3.2 Төсөл хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт, ажиллагсдын тогтвор суурьшил, хүний нөөцийн бодлого;
  - 10.3.3 Ажиллагсдын цалин хөлс урамшуулалт;
  - 10.3.4 Хөрөнгө оруулсан төслийн үр өгөөж;
  - 10.3.5 Компьютер, тоног төхөөрөмжийн ашиглалт, арчилгаа;
  - 10.3.6 Төсөл хөтөлбөрийн явцад бий болж буй үр дүн, төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж буй тогтолцоо ;
  - 10.3.7 Хууль бус байдал гаргахаас сэргийлэх;
- 10.4 Байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого боловсруулалт, бүртгэл хөтлөлт, санхүүгийн тайлан гаргалт нь СТОУС-д хэр нийцэж байгаа зэрэгт болон хөндлөнгийн аудитын зөвлөмжийн хэрэгжилтэд тавьж буй дотоод хяналтын талаар дараах чиглэлээр шалгалт явуулж, дүгнэлт гаргана.
- 10.4.1 Анхан шатны баримт бүрдүүлэлт /и-баримт/;
  - 10.4.2 Анхан шатны баримтыг үндэслэн ажил гүйлгээг өдөр тутам журналд зөв бүртгэсэн эсэх;
  - 10.4.3 Дэлгэрэнгүй болон хураангуй бүртгэл хөтлөлт бүрэн зөв хийгдсэн эсэх;
  - 10.4.4 СТОУС-д нийцүүлэн Сангийн яамнаас батлагдсан маягт, зааврын дагуу санхүүгийн тайланг гаргаж, хуулийн хугацаанд хөндлөнгийн аудитын байгууллагаар хянуулж баталгаажуулж байгаа эсэх;
  - 10.4.5 Зээл олголт болон хүүгийн тооцоолол үнэн зөв эсэх;
  - 10.4.6 Мөнгөн хөрөнгө, бэлэн бүтээгдэхүүн, эд хөрөнгийн хөдөлгөөнд бүртгэлээр тавьж буй хяналт, хадгалалт хамгаалалт;
  - 10.4.7 Касс харилцахын мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын гүйлгээ;
  - 10.4.8 Найдваргүй авлага үүсэхээс урьдчилан сэргийлсэн арга хэмжээ, авлага өглөгийн бүртгэл, насжилт, төлөлт;
  - 10.4.9 Бараа материал худалдан авах тухай гэрээ хэлцэл байгуулсан үндэслэл, тооцоо судалгаа, энэхүү гэрээний гүйцэтгэл;
  - 10.4.10 Дараа тооцооны өглөгийн төлөлт, тайлан тооцоо;
  - 10.4.11 Ажилтнуудын нийгмийн даатгал, хувь хүний орлогын албан татвар суутгал, төсөвт бүрэн төлсөн эсэх, илүү дутуу суутгал байгаа эсэх;
  - 10.4.12 Ажилтнуудын хөдөлмөрийн гэрээ, тушаал шийдвэрт үндэслэн ээлжийн амралтын цалин олголт, нэмэгдэл цалин, урамшуулалт цалин бодолтын хэрэгжилт;
  - 10.4.13 Банкны зээл болон бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн ашиглалт, эргэн төлөлт, хүү бодолт, гэрээний бүрдүүлэлт, хяналт, дүгнэлт;
  - 10.4.14 Удирдлагын болон бусад зардлын батлагдсан төсөв, лимитын хэтрэлт хэмнэлт;
  - 10.4.15 Урсгал болон их засварын зардлын төсөв, гүйцэтгэл;
  - 10.4.16 Дотоод гадаад томилолтын тооцоо зарцуулалтын тайлан;
  - 10.4.17 Суурь бүртгэлийн системд ажил гүйлгээ зөвшөөрөгдсөн төсөв, төлөвлөгөөний дагуу гарч байгаа эсэхийг хянах зөв тогтолцоо бүрдсэн эсэх;
  - 10.4.18 Хөрөнгө оруулалт, нөөц сангийн эх үүсвэр зардлын гүйцэтгэл;



**10.5 Хүний нөөц, нийгмийн бодлого, ажиллагсдын эрх ашгийг хамгаалах талаар хийгдээс буй ажил, үр дүнд тавих дотоод хяналтын тогтолцоог үнэлэж дүгнэх чиглэлээр:**

- 10.5.1 Хөдөлмөрийн дотоод похцол, ХАБЭА-н шаардлага, хөдөлмөрийн дотоод журмын биелэлт;
- 10.5.2 Компанийн нууцын зэрэглэл болон өдөр тумын үйл ажиллагааны талаарх мэдээллийг хэн хэнд ямар зорилгоор хэрхэн дамжуулсан;
- 10.5.3 Хамт олныг хутган гуйвуулах, ажилтнуудын нэр хүндийг унагаах үйл ажиллагаа явуулсан тохиолдол байгаа эсэх, байгаа гэсэн мэдээлэл хүлээн авсан бол түүнийг тогтоох, ямар арга хэмжээ авч болох талаар санал боловсруулах.

**10.6 Компанийн үндсэн зорилгод харшилсан буюу алдагдалд хүрэхүйц үйл ажиллагаа яагдаж байгаа эсэх, эрх бүхий ажилтнууд сонирхлын зөрчилд орохуйц гэрээ, хэлцэл хийсэн эсэхэд хяналт тавих чиг үүргийн хүрээнд:**

- 10.6.1 Компанид шалгалт хийх явцад эсвэл гуравдагч этгээдийн үндэслэл, баталгаатай мэдээллийн мөрөөр тухайн газар, алба, ажилтан нь компанийн ашиг сонирхолд харшилсан буюу алдагдалд хүрэхүйц үйл ажиллагаа явуулж буй эсэхэд хяналт тавих ба ийм тохиолдолд илэрсэн дутагдлыг даруй таслан зогсоох, шаардлагатай арга хэмжээ авах (саналын хуудас, хавсралтуудыг бүрдүүлж удирдлагад танилцуулах);
  - 10.6.2 Компанийн эрх бүхий ажилтнууд их хэмжээний болон сонирхлын зөрчилд орохуйц гэрээ, хэлцэл хийсэн шийдвэр гаргасан эсэхэд хяналт тавих ба ийм тохиолдолд илэрсэн зөрчил, дутагдлыг даруй таслан зогсоох, шаардлагатай арга хэмжээг авах (саналын хуудас, хавсралтуудыг бүрдүүлж удирдлагад танилцуулах);
- 10.7 Компанийн дүрэм, Төлөөлөн удирдах зөвлөлөөс шаардлагатай гэж үзсэн бусад асуудалд хяналт тавих, шалгалт хийх зэрэг ажиллагаа явуулж, дүгнэлт зөвлөмж өгөх.

**АРВАН НЭГ. ШАЛГАЛТ ХИЙХ, ШАЛГАЛТЫН ТАЙЛАН ГАРГАЖ  
ТОЛИЛУУЛАХ**

- 11.1 Шалгалтыг жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан асуудлаар төлөвлөсөн хугацаанд эсхүл мэдээллийн дагуу эсхүл ТУЗ-ийн шийдвэрээр гэнэтийн байдлаар хийх бөгөөд компанийн яар нэгж, аль төсөл хөтөлбөрийг шалгаж байгаагаас хамаараад ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг тогтооно.
- 11.2 Шалгасан ажлын хэсгийн ахлах (аудитор) шалгасан асуудлаар шалгуулсан нэгж, албан тушаалтны үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгч, илэрсэн зөрчил дутагдлын шалтгаан, үр дагаварыг тогтоон, түүнийг арилгах талаар авах арга хэмжээний талаар болон шаардлагатай бол зохих хариуцлага хүлээлгэх тухай саналаа тусгасан тайлан бэлдэнэ.
- 11.3 Дотоод аудитын газраас хийх шалгалтыг дараах байдлаар зохион байгуулна.




- 11.3.1 Шалгалт нь эрсдэл суурилна. Эрсдийн тодорхойлолт нь бүрэн бөгөөд зохистой эсэхийг аудитор үнэлж, хамгийн өндөр эрсдэлтэй үйл ажиллагааг сонгон шалгалтад хамруулахаар шалгалтын төлөвлөгөөг боловруулна.
- 11.3.2 Дотоод аудитораас хэрэгжүүлэх ээлжит шалгалтыг жилийн төлөвлөгөөнд заасны дагуу хэрэгжүүлэх бөгөөд Дотоод аудитороос хийх шалгалтын удирдамжийг ТУЗ-ийн Аудитын хорооны дарга батална.
- 11.3.3 Шалгалтыг удирдамжийн дагуу явуулсны дараа шалгалтын тайланг шалгалтын ажлын хэсгийг ахалсан аудитор бэлтгэн, шалгагдсан нэгжийн дарга, удирдлагад танилцуулж, гарын үсэг зуруулсны дараа ТУЗ-д танилцуулна.
- 11.3.4 Дотоод аудитын шалгалтаар аливаа зөрчил доголдол илэрсэн тохиолдолд уг зөрчил дутагдлын талаар тайланд тусгахдаа дараах 5 чиглэлээр асуудлыг тусгана.
- Ямар зөрчил доголдол, асуудал илэрсэн;
  - Ямар хууль тогтоомж, дүрэм журам, стандарт, төсөв, төлөвлөгөө зөрчигдсөн /Стандарт гэдэгт компанийн бодлогын баримт бичиг эсхүл бусад ямар нэг дотоод журам, дүрэм байж болно/;
  - Ийм зөрчил гарсан, асуудал үүссэн шалтгаан;
  - Тухайн асуудлаас улбаалан ямар сөрөг үр дагавар, эрсдэл учирч болох;
  - Үүнийг засахын тулд тухайн компанийн болон салбар нэгжийн удирдлагаас ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай болох талаар шалгалтын ажлын хэсгийн санал дүгнэлт, энэхүү санал дүгнэлтийг тухайн компани, салбар нэгжийн удирдлага зөвшөөрсөн эсэх, зөвшөөрөөгүй бол тэдний тайлбар санал, зөвшөөрсөн бол хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, хугацаа.
- 11.3.5 Дотоод аудитороос хийсэн шалгалтын тайланг ТУЗ-д танилцуулан холбогдох дүгнэлт, зөвлөмж, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталгаажуулна.
- 11.3.6 Дотоод аудитор нь хийж гүйцэтгэсэн шалгалт, бусад хэлбэрээр хяналт тавьж өгсөн зөвлөмж, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний гүйцэтгэлд улрал тутам хяналт тавьж ажиллана.

## **АРВАН ХОЁР. БАТАЛГААЖУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

### **ЯВУУЛАХ ҮНДЭСЛЭЛ**

- 12.1 Тодорхой төсөв, төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа, тодорхой төслийн хэрэгжилт, улирлын санхүүгийн тайлан болон бусад тайланг хянаж баталгаажуулахын тулд дотоод аудитор баталгаажуулах зорилготой аудит хийнэ.
- 12.2 Аудитын үйл ажиллагааг төлөвлөх, удирдамж гаргах, хэрэгжүүлэх, тайлан дүгнэлт гаргахдаа Олон улсын дотоод аудиторуудын институтын баталсан Мэргэжлийн үйл ажиллагаа болон дотоод аудитын стандартыг баримтлана.
- 12.3 Энэ журмын 12.1-д заасан чиглэлээр баталгаажуулах зорилгоор аудит хийх шийдвэрийг ТУЗ гаргаж, удирдамжийг батлан, шалгалтын ажлын хэсгийг томилно.
- 12.4 Ажлын хэсэг нь баталгаажуулах зорилготой аудитын ажиллагааг удирдамжийн дагуу хэрэгжүүлж, тайлан гаргана. Тайланд аудитлагдсан тайлан нь материаллаг зүйлсийн хувьд бодит байдалд нийцсэн эсэх талаар дүгнэлт өгсөн байна.
- 12.5 Аудитор нь энэ журмын 12.4-г заасан дүгнэлтээ гадна зөвлөмж гаргана.






**АРВАН ГУРАВ. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН**


**ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТАЙЛАГНАХ**

- 13.1 Дотоод аудитор нь доорх асуудлыг ТУЗ-д улирал бүр тайлагнана:
  - 13.1.1 Гүйцэтгэсэн хяналт, шалгалтын үйл ажиллагаа;
  - 13.1.2 Дотоод аудитын жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явц;
  - 13.1.3 Дотоод болон Хөндлөнгүйн аудитын зөвлөмжийн хэрэгжилтийн явц;
  - 13.1.4 Дотоод болон хөндлөнгүйн аудитын зөвлөмжийг хангалтгүй биелүүлсэн нэгж, түүний эрх бүхий албан тушаалтанд харууцлага тооцох тухай санал;

oooOooo



“Бэрс финанс ББСБ” ХХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 01-сарын 04-ны өдрийн 23/01а/01 тоот тогтоолын Хавсралт 4



## “БЭРС ФИНАНС ББСБ” ХХК-ИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГО, ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл



- 1.1. Эрсдэлийн удирдлагын бодлого /цаашид “бодлого” гэх/-ын зорилго нь компанийн эрсдэлийн удирдлагын зорилго, баримтлах зарчим, эрсдэлийн ангилалыг тодорхойлох, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх үе шатыг тогтоох, эрсдэлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлэх, эрсдэлийг удирдахтай холбогдон ажилтан, албан тушаалтан бүрийн эрх, үүргийг тодорхойлох, хянахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Энэхүү бодлого, журмыг хэрэгжүүлэх нь компанийн нийт ажилтан, албан тушаалтны хамтын хариуцлага байх бөгөөд холбогдох этгээд нь эрсдэлийн удирдлагын асуудал хариуцсан нэгжийг шаардлагатай мэдээллээр тухай бүр хангах үүрэгтэй.

### Хоёр. Эрсдэлийн удирдлагын бодлогын зорилго

- 2.1. Энэхүү бодлогыг дараах зорилгоор хэрэгжүүлнэ. Үүнд:
  - 2.1.1. Компанийн үйл ажиллагаанд учирч болох эрсдэл, өгөөжийн оновчтой түвшинг хангах тогтолцоог бүрдүүлэх;
  - 2.1.2. Компанийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг удирдах үе шатыг тодорхойлох;
  - 2.1.3. Эрсдэлийн удирдлагын тохиромжтой арга хэрэгслийг ашиглах замаар тухайн үйл ажиллагааны эрсдэлийг зөвшөөрөгдсөн түвшинд хадгалах.

### Гурав. Эрсдэлийн удирдлагын зарчим

- 3.1. Энэхүү бодлогыг дараах зарчмыг баримтлан хэрэгжүүлнэ:
  - 3.1.1. Хараат бус байх – эрсдэлийн удирдлагын асуудал хариуцсан ажилтнуудын үйл ажиллагаа, түүний дүгнэлт, тайлан боловсруулах үйл явц хараат бус, бие даасан байх;
  - 3.1.2. Хэмжигдэхүйц байх – эрсдэлийг тоон болон чанарын шинжилгээний аргаар хэмжих ба тоон шинжилгээг суурь арга болгодог байх;
  - 3.1.3. Хамтын шийдвэр гаргадаг байх – шийдвэр гаргах эрх мэдлийг нэг албан тушаалтан эсхүл нэг нэгжид олгохоос зайлсхийх;
  - 3.1.4. Тайлагнадаг байх – эрсдэлийн дүгнэлт, тайланг зөвхөн холбогдох эрх бүхний этгээдэд тайлагнадаг, танилцуулдаг байх;
  - 3.1.5. Бүрэн хамрах - эрсдэлийг бүрэн илрүүлэхийг эрмэлзэх, тэдгээрийн шалтгаан үр дагаврыг бодитой үнэлэх, албан тушаалтан бүр оорийн үйл ажиллагааны бүх үе шатанд эрсдэлээ хамгаалах суурь зарчмыг харгалздаг, мөрддөг байх;



- 3.1.6. Зохистой байх – эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь олон улсын холбогдох стандарт, зарчмын болон зохицуулагч байгууллагаас батлан гаргасан дүрэм, журамд нийцсэн байх;
- 3.1.7. Шинэчлэгддэг байх – компанийн үйл ажиллагааны чиглэл өөрчлөгдсөн, шинэ тосол хэрэгжүүлэх болсон, салбарын хууль тогтоомж, эрх бүхий байгууллагын бодлого, стратеги өөрчлөгдсөн тохиолдолд тэдгээрт хамаарах эрсдэлийн удирдлагын журам болон тогтолцоонд зохих өөрчлөлтийг тухай бүр хийдэг байх;

#### **Доров. Эрсдэлийн удирдлагын хамрах хүрээ**

- 4.1 Компанийн үйл ажиллагааны хамрах хүрээ, онцлогоос хамааруулан эрсдэлийг дараах байдлаар ангилна:
  - 4.1.1 Системийн эрсдэл – улс төр, зохицуулалтын орчин, эрх зүй, макро эдийн засаг, зах зээл болон татвар, ханшийн өөрчлөлт зэрэг гадаад орчны хүчин зүйлээс хамаарч компани санхүүгийн алдагдал хүлээх, хэвийн үйл ажиллагаа алдагдахыг ойлгоно;
  - 4.1.2 Үйл ажиллагааны эрсдэл – бизнесийн нэр хүнд, хүний нөөц, техник програм хангамж, санхүүгийн үйл ажиллагаа, нийцлийн үйл ажиллагаа зэргээс хамаарч компанийн өдөр тутмын хэвийн үйл ажиллагаа алдагдах;
  - 4.1.3 Зээлийн эрсдэл – зээлдэгчийг судлах, зээлийн барьцаа хөрөнгө үнэлэх, зээлийн шийдвэр гаргах, зээл олгох, зээлдэгч нь зээлээ төлөх зэрэг бүхий л үе шаттай холбоотой эрсдэл хамаарах ба тухайлбал, зээлдэгчийн ажил эрхлэлт, бизнесийн үйл ажиллагаа, барьцаа хөрөнгө, зээлийн эргэн төлөлт гэх мэт ажиллагааг үүнд хамруулж ойлгоно.



#### **Тав. Эрсдэлийн удирдлагын бодлого**

- 5.1. Системийн эрсдэлийг удирдах үйл ажиллагаанд: *Хэтийг харсан бодлого баримтална.* Гадаад орчны тандалт, судалгааны тусламжтайгаар эрсдэлийг урьдчилан илрүүлж түүнээс зайлсхийх, бууруулах, хүлээн зөвшөөрөх зэрэг зохих арга хэмжээ авах бодлого баримтална.
- 5.2. Үйл ажиллагааны эрсдэлийг удирдах үйл ажиллагаанд: Эрсдэлийн хамгаалалтын 3 шугамыг ашиглах бодлого баримтлах бөгөөд эрсдэлийг боломжит хамгийн бага түвшинд байлгахыг зорих ба компанийн ажилтан тус бүрийн ажлын байрны тодорхойлолтод тэдгээрийн тусгайлан хариуцах, хянах эрсдэлийг тусгана.
- 5.3. Зээлийн эрсдэлийг удирдах үйл ажиллагаанд зээлдэгч тус бүрийн эрсдэлийг тодорхойлох, эрсдэлийг зохистой, зөвшөөрөгдсөн түвшинг хадгалах бодлого баримтална.

#### **Зургаа. Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх үе шат**

- 6.1 Эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа дараах үе шаттай байна:
  - 6.1.1 Эрсдэлийг илрүүлэх буюу эрсдэлийг урьдчилан тодорхойлох;







- 6.1.2 Эрсдэлийг үнэлэх буюу компанийн эрсдэлийн удирдлагын нарийвчилсан журам, эрсдэлийн дүгнэлт боловсруулах үнэлгээний аргачлал болон бусад холбогдох баримт бичигт нийцүүлэн тохиолдож болох эрсдэлийг тооцоолох;
- 6.1.3 Тохирсон арга хэмжээ авах буюу энэ бодлогын 6.1.2-г зааснаар үнэлэгдсэн эрсдэлд тохирсон арга хэмжээ авах;
- 6.1.4 Эрсдэлийг хянах үе шат гэж энэ бодлогын 4.1-д заасан бүх торлийн эрсдэлд тохирсон арга хэмжээ авсан аливаа шийдвэрийн хэрэгжилтийг хянах үйл ажиллагаа;
- 6.1.5 Тайлагнах, мэдээлэх үе шат нь компанийн гүйцэтгэх удирдлага, ТУЗ болон хувьцаа эзэмшигчдийг тогтоосон хугацаанд үнэн зөв, бодит мэдээллээр хангах үйл ажиллагаа зэрэг байна.

#### **Долоо. Эрсдэлийн удирдлагын арга хэрэгслүүд**


- 7.1. Энэхүү бодлогын баримт бичиг болон компанийн эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааг зохицуулах журам, эрсдэлийн үнэлгээний аргачлал, засаглалын зарчим тогтолцоо, компанийн хэвийн үйл ажиллагааг зохицуулах дүрэм, журам, дотоод болон хөндлөнгүйн хяналтын тогтолцоо зэрэг нь эрсдэлийн удирдлагын арга хэрэгсэл байна.

#### **Найм. Эрсдэлийн удирдлагын тогтолцоо бүрдүүлэх**

- 8.1. Энэ журмын дагуу эрсдэлийн удирдлагын тогтолцоо бүрдүүлэхдээ дараах хүчин зүйлсийг харгалзан үзнэ:
  - 8.1.1. Компанийн соёл нь компанийн эрсдэлийн удирдлагын тогтолцооны суурь нөхцөл болно. Ажилтны зан төлөв, нөхөрсөг хамтач харилцаа, ажилдаа чин сэтгэлээсээ бүтээлчээр хандах хандлага зэргийг нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд нийцүүлэн зөв бүрдүүлж, төлөвшүүлэх нь компанийн үйл ажиллагаанд учирч болох эрсдэлийг бууруулах үндсэн нөхцөл болно. Компанийн соёлын хэм хэмжээг тогтоож хэвшүүлэх нь компанийн ТУЗ, гүйцэтгэх удирдлага болон нийт ажилтан, албан хаагчдын хамтын ажиллагааны үр дүн байна.
  - 8.1.2. Компанийн ажилтан, салбар нэгж бүрийн өдөр тутмын үйл ажиллагаанд учирч болох эрсдэлийг ажилбар нэг бүрээр нарийвчлан тодорхойлох, үнэлэх, бууруулах арга хэмжээг төлөвлөн тогтоож, дүрэм журмыг хэрэгжүүлэх, үүрэг даалгавар өгөх, дүгнэх зэрэг нь эрсдэлийн хамгаалалтын 1 дүгээр шугам болно.
  - 8.1.3. Эрсдэлийн хамгаалалтын 2 дугаар шугамыг төв албаны газар нэгжийн удирдлага, менежер хэрэгжүүлэх бөгөөд тухайн газар нэгжийн үйл ажиллагаанд учирч болох эрсдэлийг тодорхойлох, сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээ хэрэгжүүлэх талаар гүйцэтгэх удирдлагад саналаа танилцуулах, хэрэгжүүлэх чиг үүрэгтэй байна. Гүйцэтгэх удирдлага нь эрсдэлийн удирдлагын бодлого, журмыг зөв тодорхойлсон эсэх, хэрхэн хэрэгжүүлж байгаад хяналт тавьж, чиглүүлэх нь эрсдэлээс хамгаалах нэг хэрэгсэл болно.
  - 8.1.4. Эрсдэлийн хамгаалалтын 3 дугаар шугам нь эрсдэлийн удирдлагын талаар хараат бус дүгнэлт гаргах, шаардлагатай тохиолдолд эрсдэлийн удирдлагын талаар зөвлөмж боловсруулж, гүйцэтгэх удирдлага болон Төлөөлөн удирдах зөвлөл /цаашид "ТУЗ" гэх/-д танилцуулах үүрэг бүхий дотоод аудитын асуудал хариуцсан нэгж байна.



- 8.2. Компанийн эрсдэлийн удирдлагыг дараах чиглэлээр ангилна:
- 8.2.1. Удирдлагын;
  - 8.2.2. Санхүүгийн;
  - 8.2.3. Үндсэн үйл ажиллагааны;
- 8.3. Өдөр тутмын үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь компанийн үйл ажиллагаанд мордогдож буй дотоод бодлого, дүрэм, журам, зааврын хүрээнд гүйцэтгэх, хянах, заавар зөвлөмжөөр хангах зэрэг тохирсон арга хэмжээг хэрэгжүүлэх цогц харилцааг ойлгоно.
- 8.4. Өдөр тутмын үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх этгээдийн чиг үүргийн хуваарь дараах хүрээг хамарна:
- 8.4.1. ТУЗ: Компанийн эрсдэлийн удирдлагын бодлого, журам, шаардлагатай тохнолдолд эрсдэлийн дүгнэлт боловсруулах аргачлалыг батлах, эрсдэлийн удирдлагын болон дотоод хяналтын тогтолцоог зохион байгуулах, компанийн санхүүгийн үйл ажиллагаа, зээлдэгчийн хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн гүйцэтгэлд хяналт тавих тогтолцоо бүрдүүлэх;
  - 8.4.2. Дотоод аудитор: Эрсдэлийн удирдлагын тогтолцоонд үнэлэлт, дүгнэлт өгөх, ТУЗ болон ТУЗ-ийн даргаас өгсөн удирдамж, чиглэлийн хүрээнд компанийн үйл ажиллагаанд хяналт тавих, шалгалт хийх, тайлагнах;
  - 8.4.3. Гүйцэтгэх захирал: Эрсдэлийн удирдлагын тогтолцооны хэвийн үйл ажиллагааг хангах, эрсдэлийн удирдлагын нэгжийг шаардлагатай арга зүйн удирдамжаар хангах, холбогдох шийдвэрийг гаргаж мөрдүүлэх, компанийн нэгжүүдийн үйл ажиллагааны уялдаа холбоог хангах;
  - 8.4.4. Төв албаны газар нэгжийн захирал болон салбарын захирал: Удирдаж буй салбар болон газар нэгжийн үйл ажиллагааг хянах, үүсч болзошгүй эрсдэлийг урьдчилан илрүүлэхийг эрмэлзэх, эрсдэлийг удирдах, зохистой арга хэмжээ авах, шийдвэрлэх талаар санал боловсруулж холбогдох дээд удирдлагад танилцуулах, холбогдох этгээдийг мэдээллээр хангах; Эрсдэлийн удирдлагын бодлого болон энэхүү журмын хэрэгжилтийг хангах, эрсдэлийг удирдах, албаны үйл ажиллагаанд учирч болох эрсдэлийн дүгнэлтийг холбогдох аргачлал зааврын дагуу гаргах, нийцлийн хяналтыг хэрэгжүүлэх зэрэг ажлыг хараат бусаар гүйцэтгэнэ;
  - 8.4.5. Бүх түвшний ажилтан: Эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, эрсдэл учирсан, эсвэл учирч болзошгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд эрсдэлийн удирдлагын асуудал хариуцсан нэгжид мэдэгдэх, эрсдэлийн түвшингээс хамаарч холбогдох арга хэмжээг авах талаарх саналаа эрх бүхий этгээдэд гаргах.
- 8.5. Зээлийн үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын тогтолцоо гэдэгт салбар нэгжээр дамжуулан олгох зээлийн үйл ажиллагааны эрсдэлийг үнэлэх, тооцох, эрсдэлийг бууруулах, хянах, шийдвэрлүүлэх цогц харилцааг ойлгоно.
- 8.6. Зээл олгох шийдвэр гаргах, хянахдаа зээлийн шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтан эрсдэлийн үнэлгээг тооцож, дүгнэнэ. Хэрэв нарийвчилсан судалгаа



шаардлагатай гэж үзвэл төв албаны холбогдох газар нэгжээс мэргэжлийн заавар зөвлөмж авч ажиллана.



#### Ес. Эрсдэлийг удирдах үе шат

- 9.1. Нэгж, ажилтан бүр өөрийн чиг үүрэгт хамаарах асуудлаар үүссэн болон ирээдүйд үүсэх магадлалтай эрсдэлийг илрүүлдэг байна.
- 9.2. Учирч болох өндөр магадлалтай, их хэмжээний хохирол учруулах магадлалтай эрсдэлийг илрүүлсэн тохиолдолд Гүйцэтгэх захиралд яаралтай мэдэгдэнэ.
- 9.3. Ажилтан нь өөрийн үйл ажиллагааны хамрах хүрээтэй уялдуулан салбарын гадаад болон дотоод зах зээлийн, макро эдийн засгийн, эрх зүйн салбарын, санхүүгийн мөнгөний зах зээлийн судалгаа зэргийг тогтмол хийж эрсдэлийг урьдчилж илрүүлдэг байна.
- 9.4. Эрсдэл түүний үүсэх нөхцөл бүрдэх, үйл ажиллагааны хэвийн, тогтвортой байдал алдагдах, компанийн санхүүгийн гүйцэтгэл, зорилтот түвшинд хүрэх боломжгүй болох, их хэмжээний гарз хохирол гарах болон бусад үүсэх боломжтой сөрөг нөлөөг илрүүлж, Гүйцэтгэх захиралд мэдээлдэг байна.

#### Арав. Эрсдэлийг үнэлэх

- 10.1. Эрсдэлийг түүний үүсэх магадлал болон түүнээс үүсэх хохирлын хэмжээгээр нь үнэлнэ.
- 10.2. Эрсдэлийг техник шинжилгээнд үндэслэн тоон үзүүлэлтээр үнэлэх бөгөөд ийнхүү үнэлэх боломжгүй тохиолдолд субъектив аргаар үнэлнэ.
- 10.3. Ихэнх тохиолдолд эрсдэлийг нарийн тоон утгаар илэрхийлэх боломжгүй байдаг. Иймд эрсдэлүүдийг харьцуулахын тулд магадлал ба нөлөөллийн энгийн матрицыг ашиглана. Үүнд эрсдэлийн шалгуурыг тогтоож, эрсдэлийн түвшинг магадлал ба нөлөөллийн үржвэрээр гаргана. Энэ нь эрсдэлийн тоон болон чанарын аргуудыг хослуулсан энгийн арга юм. Эрсдэлийн матриц нь олон тооны тодорхойлсон эрсдэлүүдийг харьцуулах, шигших боломжийг олгох бөгөөд аль эрсдэлүүдийг онцолж, цаашид дэлгэрэнгүй судлах шаардлагатайг харуулна. /Хавсралт/
- 10.4. Эрсдэлийн матрицын аргыг ашиглахад компанийн үйл ажиллагааны онцлогоос хамааруулан боломжит үр дагавар/нөлөөлөл болон магадлал/давтамжийг хэмжих шалгуурыг тогтооно. Хэр олон, ялгаатай төвшний эрсдэлүүд байгаагаас хамаараад матрицыг 3,5, эсвэл 7 хүртэл түвшинтэйгээр (3x3, 5x5, 7x7 гэх мэт) тогтооно.
- 10.5. Тохиолдох магадлалыг түвшний тооноос хамаараад “байнга тохиолддог”, “түгээмэл тохиолддог”, “заримдаа тохиолддог”, “хааяа тохиолддог”, “маш ховор тохиолддог” гэж ангилах боломжтой ба тухайн түвшний тохиолдлын давтамжийг тодорхойлно. Жишээ нь байнга тохиолддог – өдөр бүр, түгээмэл тохиолддог – долоо хоног бүр, заримдаа тохиолддог – сар бүр, хааяа тохиолддог – улирал бүр, маш ховор тохиолддог – жилд нэг удаа гэх мэт.
- 10.6. Мөн түүнчлэн эрсдэлийн нөлөөллийг хэмжихдээ маш их, их, дунд, бага, маш бага гэж ангилж болох бөгөөд тухайн ангилал дахь нөхцөлүүдийг компанийн тухайн үеийн үйл ажиллагааны цар хүрээ, борлуулалтын хэмжээ зэргээс хамааруулан тодорхойлно. Нөлөөллийг санхүүгийн, эрх зүйн, нэр хүндийн, эрүүл ахуйн, байгаль орчны, харилцагчдын, үйл ажиллагааны гэж ангилж болно.





10.7. Шаардлагатай тохиолдолд зовшоорогдсон эрсдэлийн түвшинд компанийн одор тутмын үйл ажиллагааны эрсдэлийг үнэлэхгүйгээр тохирсон арга хэмжээг авч болно.

**Арван нэг. Эрсдэлд тохирсон арга хэмжээг авах**

11.1. Эрсдэлийн субъектив үнэлгээний зэрэглэлээс хамаарч тухайн эрсдэлийн шинж чанар, хамрах хүрээг харгалзан дараах этгээд шийдвэр гаргана:

№	Шийдвэр гаргах түвшин	Эрсдэлийн зэрэглэл
1	ТУЗ-ийн шийдвэр	Өндөр /10-20 оноо/
2	Гүйцэтгэх захирлын тушаал	Дундаж болон бага/3-9 оноо/
3	Газар нэгжийн удирдлагын шийдвэр	Бага /1-2 оноо/

11.2. Системийн эрсдэлийн хүрээнд улс төрийн нөхцөл байдал, хууль тогтоомжийн өөрчлөлт, макро эдийн засаг, хөрөнгө оруулсан салбарын чиглэлээр мэдээлэл цуглуулах, тэдгээрт үндэслэн тухайн эрсдэлийг урьдчилан илрүүлэх, хохирлыг бууруулах, зайлсхийх арга хэмжээ авна.

11.3. Үйл ажиллагааны эрсдэлийн хүрээнд:

11.3.1. Компанийн эрсдэлийн удирдлагын болон бусад нэгжийн ажилтнуудыг эрсдэлийн чиглэлээр мэргэшүүлэх, давтан сургах арга хэмжээг хүний нөөцийн бодлого, төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлдэг байна.

11.3.2. Техник, програм хангамж нь шаардлагад нийцсэн, найдвартай, аюулгүй байх боломжийг бүрдүүлэн, байнгын хяналт тавина;

11.3.3. Компанийн үйл ажиллагааг зохицуулж буй бодлого, дүрэм, журам нь хууль тогтоомжид нийцсэн байна;

11.3.4. Бие даасан дотоод хяналтын тогтолцоо бүрдүүлэх, зохистой ажиллагааг хангасан байна;

11.3.5. Комплаенсийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх тогтолцоог бүрдүүлэх, түүнд хяналт тавьдаг байна;


11.3.6. Мэргэжлийн ёс зүйн дүрэмтэй байх, түүний хэрэгжилтийг хянаж дүгнэдэг байх;

11.3.7. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай стандарт шаардлагыг хангаж ажилладаг байх.

11.4. Компаниас зээл олгох үйл ажиллагааны эрсдэлийг удирдах үйл ажиллагааны хүрээнд:

11.4.1. Зээлдэгчийн зээлээ төлөх боломжтой эсэхийг тооцох зорилгоор төлбөрийн чадварыг судлах болон зээлийн баталгаа, барьцааг үнэлэх, хянах, зээлийн бүх үе шатанд эрсдэлийг хянадаг байх;

11.4.2. Хөрөнгө оруулсан төслийн хувьд идэвхтэй эзэмшлийн бодлого хэрэгжүүлж хянах, үүнд санхүүжигчийн үйл ажиллагаанд хяналт тавихдаа компанийн үйл ажиллагааны үр дүн, компанийн үнэ цэнэ, эрсдэлд нөлөөлж болзошгүй гадаад, дотоод хүчин зүйлс, компанийн удирдлага, засаглалын тогтолцооны талаар мэдээлэл цуглуулж, засаглал, хяналтын тогтолцоо нь үр дүнтэй эсэх, санхүүгийн тайлангийн үнэн зөв байгаа эсэхэд дүгнэлт гаргаж,



- санхүүжигчийн хувьцааны нөлөө бүхий багцыг эзэмшиж байгаа тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хуралд идэвхтэй оролцох зэрэг бодлого барина;
- 11.4.3. Хөрөнгө оруулалтын төсөл нь Монгол Улсын хууль тогтоомж болон хөрөнгө оруулалтын бодлого, компанийн зорилго зорилгод нийцэж байгаа эсэхийг нягтлах;
  - 11.4.4. Төсөл нь техник, эдийн засгийн хувьд хэрэгжих боломжтой, төслийн огоожийн зоншоорогдсон түвшинд хүрсэн эсэхийг шалгах;
  - 11.4.5. Төвийн холбогдох газар нэгж төслийн эрсдэлийг үнэлж, шийдвэр гаргах;
  - 11.4.6. Магадлан шинжилгээ: Санхүүжүүлсэн компани болон төслийн үйл ажиллагаанд компанийн эрх бүхий этгээдийн баталсан удирдамж, зааврын дагуу нарийвчилсан судалгаа тогтмол хийнэ. Зайлшгүй шаардлагатай тохиолдолд хөндлөнгийн хараат бус мэргэжлийн этгээдээр дүгнэлт гаргуулж болно;
  - 11.4.7. Санхүүжигчийн эрсдэлийн удирдлагыг үнэлэх: санхүүжигчийн эрсдэлийн удирдлагыг үнэлэх замаар хөрөнгө оруулалтын эрсдэлээ хянах тогтолцоо бүрдүүлсэн байна;
  - 11.4.8. Санхүүгийн хөшүүрэг ашиглахдаа хүүгийн зардал нь хүлээгдэж буй огоожөөс хэтрэхгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн байгаа эсэхийг хянадаг байна.


#### Арван хоёр. Эрсдэлийн удирдлагын тайлан

- 12.1. Эрсдэлийн удирдлагыг үйл ажиллагааны тайлан цаг хугацааны хувьд байнгын болон цаг үеийн гэсэн төрөлтэй байна.
- 12.2. Эрсдэлийн удирдлагын нэгж нь компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд үүссэн асуудлыг тоймлон эрсдэлийн дүгнэлт хийж жилийн эцсийн тайланд тусгаж компанийн Гүйцэтгэх захиралд хүргүүлнэ.
- 12.3. Компанид их хэмжээний эрсдэлтэй гэнэтийн зүйл тохиолдсон нөхцөлд холбогдох газар нэгжийн удирдлага ТУЗ болон компанийн гүйцэтгэх удирдлагад яаралтай мэдэгдэх зорилгоор тайлан бэлтгэн хүргүүлж болно.
- 12.4. Эрсдэлийн удирдлагын тайланд эрсдэл үүссэн шалтгаан, үйл явц, учруулсан болон учруулах боломжтой хохирлын хэмжээ, үзүүлэх нөлөөллийн талаар тодорхой тусгана.


#### Арван гурав. Хариуцлага

- 13.1. Энэхүү журмыг зөрчсөн ажилтанд Хөдөлмөрийн дотоод журам болон холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

—ooOoo—



“Бэрс финанс ББСБ” ХХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 01-р сарын 04-ний өдрийн 23/01а/01 тоот тогтоолын Хайрралт 5



## ХӨНДЛӨНГИЙН ХАРААТ БУС АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫГ СОНГОХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Хөндлөнгийн хараат бус аудитын байгууллагыг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, үйл ажиллагаанд нь үнэлэлт өгөх, аудитын байгууллагын өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.
- 1.2 Компани нь “Аудитын тухай” хуулийн 10.1.1 болон 10.1.4-т заасны дагуу жилийн санхүүгийн тайландаа заавал аудит хийлгэх үүрэг хүлээсэн учраас жилийн санхүүгийн тайланд аудит хийх хараат бус аудитын байгууллагыг сонгохдоо энэхүү журмыг баримтална.


### Хоёр. Хөндлөнгийн аудиторыг сонгох

- 2.1 Хөндлөнгийн аудиторыг сонгохдоо дараах нөхцөл байдлыг харгалзан үзнэ. Үүнд:
  - 2.1.1 Тухайн аудитын байгууллагын эрх бүхий албан тушаалтан болон аудитор нь компанийн эрх бүхий албан тушаалтан болон санхүүгийн ажилтантай холбогдох этгээд биш байх;
  - 2.1.2 Тухайн аудитын байгууллага нь банк бус санхүүгийн үйлчилгээ эрхлэх компанийн нягтлан бодох бүртгэл, холбогдох СТОУС-ын талаар мэдлэг, туршлагатай аудиторуудтай байх;
  - 2.1.3 Тухайн аудитын байгууллага нь компанид өмнө нь өөр үйлчилгээ үзүүлээгүй байх;
- 2.2 Хараат бус аудитын байгууллагыг сонгохдоо дараах журмыг баримтална. Үүнд:
  - 2.2.1 Санхүүгийн зохицуулах хорооноос эрх авсан аудитын байгууллагуудын жагсаалт, жагсаалтад орсон компани тус бүрийн танилцуулгатай догоод аудитор болон холбогдох газар нэгжийн удирдлага танилцаад, сонгож болох аудитын байгууллагын удирдах албан тушаалтантай биечлэн уулзаж, энэ журмын 2.1-д заасан нөхцөл байдлыг хангаж буй аудитын байгууллагын талаар санал дүгнэлт бэлдэж, гэдгээрээс ирүүлсэн үйлчилгээ үзүүлэх талаарх албан захидлын /үнийн саналыг тусгасан/ хамтаар ТУЗ-ийн аудитын хороонд хүргүүлнэ.
  - 2.2.2 ТУЗ-ийн аудитын хороо нь аудитын байгууллагыг сонгох саналаа ТУЗ-ийн хуралдаанд танилцуулах бөгөөд ТУЗ-ийн хурлаас хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгох шийдвэр гаргаж, түүнтэй байгуулах гэрээний төслийг батална.
- 2.3 Хөндлөнгийн аудитын байгууллагатай байгуулах гэрээнд аудитын үйл ажиллагаатай холбогдууааж харилцан хүлээх үүрэг, харнуцлага, ажлын хүрээ, гүйцэтгэх хугацаа, хөлс, үр дүнг хүлээлгэн өгөх, гэрээг дуусгавар болгох журмыг заасан байна.

### Гурав. Аудитын байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх

- 3.1 Аудитын үйлчилгээний тухай гэрээ байгуулсны дараа дараах байдлаар аудитын байгууллагын үйл ажиллагаанд бүх талаар дэмжлэг үзүүлнэ. Үүнд:







- 3.1.1 Холбогдох олон улсын стандартад нийцүүлэн гаргасан санхүүгийн тайланг аудиторт шалгуулахаар хүлээлгэн өгөх;
- 3.1.2 Аудитын үйл ажиллагаа явуулах нөхцөл бололцоогоор хангах;
- 3.1.3 Аудиторын шаардсан баримт, мэдээллийг хугацаанд нь гаргаж өгөх;
- 3.1.4 Байгууллагын аж ахуй, санхүүгийн үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэл, тайланд стандартын дагуу зөв тусгасан тухай, мөн эдгээртэй холбогдох баримт, материал, тайлбарыг бүрэн танилцуулсан, энэ талаар үүсч болох хариуцлагыг хүлээх тухайгаа нотолсон тодорхойлолтыг аудиторт гаргаж өгөх.
- 3.1.5 Аудиторын хүссэн шаардлагатай нотлох баримтыг гуравдагч этгээдээс гаргуулж өгөх.
- 3.2 Энэ журмын 3.1-д заасныг хэрэгжүүлэхийн тулд компанийн эрх бүхий албан тушаалтан болон бусад бүх ажилтнууд аудиторын шаардсан бүхий л баримт мэдээллийг тухай бүр гаргаж толилуулах үүрэг хүлээнэ.
- 3.3 Компанийн ЭБАТ болон ажилтнууд энэ журмын 3.1-д заасныг хэрэгжүүлэлгүй аудитын үйл ажиллагаанд саад учруулсан тохиолдолд аудитор нь дотоод аудиторт гомдол гаргах эрхтэй.
- 3.4 Энэ журмын 3.3-г заасны дагуу аудитороос гомдол гаргасан бол дотоод аудитор тухайн мэдээлэл баримт бичгийг биечлэн хариуцаж гарган, толилуулах үүрэг хүлээнэ.

#### **Дөрөв. Аудиторын дүгнэлтийг хүлээн авах**

- 4.1 Аудитын ажил дууссаны дараа аудитор санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлт болон ТУЗ-д зориулан бэлдсэн зөвлөмжийн хамт хүлээлгэн өгнө.
- 4.2 Дүгнэлт зөвлөмжтэй дотоод аудитор болон холбогдох газар нэгжийн удирдлага танилцаж, өөрийн саналыг бэлдээд гүйцэтгэх захиралд танилцуулна.
- 4.3 Гүйцэтгэх захирал нь аудитын дүгнэлтийн талаар тайлбар өгөхийг шаардах эрхтэй.
- 4.4 Аудитын дүгнэлтийг зөвшөөрөхгүй бол Сангийн яам, ММНБИ-д гомдол гаргах эрхтэй.
- 4.5 Аудитын дүгнэлт зөвлөмжийг хүлээн зөвшөөрсөн бол зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган, хэрэгжүүлнэ.

#### **Тав. Хөндлөнгийн аудитын үйлчилгээтэй холбогдон дотоод аудиторын гүйцэтгэх үүрэг**

- 5.1 Дотоод аудитор нь хөндлөнгийн аудитын үйлчилгээний чанарыг шалгалт дууссаны эцэст үнэлж дүгнэх, хөндлөнгийн аудиторыг дахин үргэлжлүүлэн сонгох эсвэл гэрээг цуцлах асуудлаар санал зөвлөмж бэлтгэн ТУЗ-ийн Аудитын хорооны хуралд оруулдаг байх;
- 5.2 Гүйцэтгэх удирдлага, дотоод аудитор хамтран тухайн жилийн аудитын ажлын төлөвлөгөөг боловсруулах бөгөөд үүнд компанийн тухайн үеийн нөхцөл байдал, хууль тогтоомжоор болон гэрээгээр хүлээсэн үүрэг болон тэдгээрт орсон нэмэлт, оорчлолт, хөндлөнгийн аудиторын зөвлөмжийг харгалзан үздэг байх;
- 5.3 Аудитын ажиллагаанд хязгаарлалт тавих, мэдээлэлд чөлөөтэй нэвтрэх боломжийг хязгаарлах, шаардлагатай мэдээллийг гаргаж өгөхгүй байх зэргээр аудиторын хэвийн үйл ажиллагаанд ямар нэг саад бэрхшээл учирсан тохиолдолд түүнийг шийдвэрлэх тогтолцоо бүрдүүлэх;
- 5.4 Хөндлөнгийн аудитын шалгалтын явцад илэрсэн зөрчил, түүнийг засч залруулах талаар гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлэх тогтолцоо бүрдүүлэх;



- 5.5 Хувьцаа эзэмшигчдийн хурлын үеэр хөндлөнгийн аудиторт асуулт тавьж, хариулт авах боломжийг хангах;
- 5.6 Компанийн санхүүгийн тайланг СТОУС, Санхүүгийн зохицуулах хорооноос батлан гаргасан журам, компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого зэрэгт нийцүүлэн бэлтгэх нөхцөлийг хангах ба компанийн Нягтлан бодох бүртгэлийн бодлого болон хэвшсэн практик нь СТОУС-д хэр нийцтэй байгаа талаар үнэлэлт дүгнэлт хийсэн хөндлөнгийн аудитын дүгнэлтийг анхаарч, холбогдох арга хэмжээ авдаг байх;
- 5.7 Хөндлөнгийн аудитороор аудитын бус үйлчилгээ, даалгавар гүйцэтгүүлэхэд компаниас баримтлах бодлогыг боловсруулах ба шаардлагатай тохиолдолд бусад баталгаажуулах ажил гүйцэтгүүлэх, аудитын бус үйлчилгээ авахаар бол урьдчилан ТУЗ-өөс зөвшөөрөл авдаг байх тогтолцоог бий болгох;
- 5.8 Хөндлөнгийн аудитын зүгээс компанид бусад үйлчилгээ үзүүлэх, аудитын байгууллагыг заавал сольдог байх талаар АОУС болон Аудитын тухай хууль тогтоомжид заасан шаардлагыг хэрэгжүүлэх нөхцөлийг хангах.

#### 6. Хариуцлага

- 6.1 Энэ журамд заасны дагуу аудитын байгууллагыг сонгоогүй тохиолдолд компанийн эрх бүхий албан тушаалтан Зөрчлийн тухай хуулийн 11.1.3-т заасан хариуцлага хүлээнэ.



"Бэрс финанс ББСБ" ХХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 01-р сарын 04-ний өдрийн 23/01а/01 тоот тогтоолын Хавералт 6"

**"БЭРС ФИНАНС ББСБ" ХХК-ИЙН  
ЗАЛГАМЖ ХАЛААНЫ БОДЛОГО**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1 Энэхүү журмын зорилго нь "Бэрс финанс ББСБ" ХХК (цаашид "компани" гэх)-ийн ТУЗ-ийн гишүүд болон гүйцэтгэх дээд удирдлагын багийн гишүүдийн залгамж халааг бэлдэх үйл ажиллагааг зохицуулахад оршино.

**Хоёр. Залгамж халааны тухай ойлголт**

2.1 ТУЗ-ийн гишүүд болон гүйцэтгэх дээд удирдлагын залгамж халаа гэдэг нь ТУЗ-ийн гишүүд болон гүйцэтгэх дээд удирдлагын орон тоо гарсан тохиолдолд тэдний оронд сонгох хүний нөөцийг ойлгоно.

**Гурав. Залгамж халааг бэлдэх бодлого**



3.1 ТУЗ-ийн гишүүдийн залгамж халааг бэлдэхдээ дараах чиглэлүүдээр ажиллана. Үүнд:

- 3.1.1 Салбарын шилдэг мэргэжилтнүүд, салбарын чиглэлээр мэргэшсэн хуульчид, мэргэшсэн нягтлан бодогчдын судалгааг гаргаж, тэдэнтэй ажил хэргийн холбоо харилцаа тогтоох, энэхүү судалгааг байнга шинэчлэж байх;
- 3.1.2 Жил тутамд уламжлал болгон харилцагчид, хөрөнгө оруулагчид, хамтран ажилладаг түнш байгууллагууд зэрэгтэй уулзалт зохион байгуулж, салбарын шилдэг мэргэжилтнүүдийг урьж оролцуулах замаар тэдэнд компанийн үйл ажиллагааг танилцуулж байх;
- 3.1.3 Салбарын хэмжээнд зохион байгуулагддаг олон нийтийн арга хэмжээ, эвент, танилцуулга уулзалт зэрэгт байнга оролцож, нэтворкинг хийх;
- 3.1.4 Хүний нөөцийн бүрдүүлэлт хийдэг мэргэжлийн компаниудтай харилцаа холбоо тогтоож, тэдгээрээр дамжуулан нооцоо бүрдүүлэх;
- 3.1.5 Компанид ажилладаг шилдэг мэргэжилтнүүд дотроос цаашид ТУЗ-д ажиллуулах боломжтой хүмүүсийн судалгаа гаргаж, тэднийг сургах, дадлагажуулах бодлого баримтлах;
- 3.1.6 Тухайн салбартаа үйл ажиллагаагаараа шилдэг, олны танил, нэр хүнд сайтай, этгик ёс зүйтэй мэргэжилтнийг урьж ажиллуулах боломжтой.

3.2 Гүйцэтгэх дээд удирдлагын залгамж халааг бэлдэхдээ дараах чиглэлүүдээр ажиллана. Үүнд:

- 3.2.1 Компанийн ажилтнуудаас дэвшүүлэн ажиллуулах боломжтой түлхүүр ажилтнуудын судалгаа гаргаж тэднийг сургах, дадлагажуулах тусгай хөтөлбөр гарган бэлдэх;





- 3.2.2 Банк, санхүүгийн салбарт ажиллаж байсан туршлагатай мэргэжилтэн, эксперттийг шууд урьж ажиллуулах;
- 3.2.3 Компанийн үйл ажиллагааны чиглэлээр мэргэжилтэн бэлддэг их дээд сургуультай харилцаа холбоо тогтоон тэдний шилдэг суралцагсдаас сонгон, компани дээр дадлага хийлгэх, компанийн дотоод сургалтын хөтөлбөрийн дагуу компанийн үйл ажиллагаатай танилцуулж, бэлтгэх бодлого баримтлах;
- 3.2.4 Энэ журмын 3.1.1-д заасан судалгаанд үндэслэн компанийн гүйцэтгэх дээд удирлагад ажиллах боломжтой мэргэжилтний судалгаа гаргаж, ажил хэргийн холбоо харилцаа тогтоох

#### **Дөрөв. Залгамж халааг компани дээр бэлдэх хөтөлбөр хэрэгжүүлэх**

- 4.1 Компани дээр залгамж халааг бэлдэх хөтөлбөртэй байна.
- 4.2 Энэ журмын 4.1-д заасан хөтөлбөрт дараах асуудлыг тусган хэрэгжүүлнэ. Үүнд:
  - 4.2.1 Компанийн үйл ажиллагааны онцлог, стратеги тактик;
  - 4.2.2 Компанийн үйл ажиллагаа явуулж буй салбарт олон улсын хэмжээнд гарч буй шилдэг туршлага, шинэ хандлага;
  - 4.2.3 ТУЗ-ийн үйл ажиллагааны чиглэл, ТУЗ-ийн гишүүнд тавих шаардлага;
  - 4.2.4 Компанийн удирдах ажилтанд тавих шаардлага
- 4.3 Гадаад, дотоодод шаардлагатай чиглэлээр явагдаж буй сургалтад хамруулах.

#### **Тав. Албан тушаал дэвшүүлэн ажиллуулах**

- 5.1 ТУЗ-ийн гишүүдийг шинээр сонгох шаардлага гарсан тохиолдолд энэ журмын 3.1.1-д заасан судалгаанд хамрагдсан мэргэжилтнүүдийн дотор тухайн орон тоонд хамгийн тохиромжтой гэсэн хүмүүст ТУЗ-д ажиллах урилга хүргүүлнэ.
- 5.2 Урилга хүлээн авсан этгээд ТУЗ-д ажиллахаар зөвшөөрсөн тохиолдолд түүний нэрийг ТУЗ-ийн гишүүнээр сонгуулахааар хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулан сонгуулах бодлого баримтална.
- 5.3 Гүйцэтгэх удирдагын дээд албан тушаалтны орон тоо гарсан тохиолдолд эхний ээлжинд компанид ажиллагсдаас дэвшүүлэн ажиллуулах бодлого баримтална.
- 5.4 Компанид ажиллагсдаас тохиромжтой этгээд байхгүй байгаа тохиолдолд энэ журмын 3.1.1-д заасан судалгаанд хамрагдсан мэргэжилтнүүдээс тохиромжтой этгээдийг сонгон урилга хүргүүлэх замаар сонгон ТУЗ-ийн хуралдаад танилцуулж сонгох зарчим баримтална.

#### **Зургаа. Бодлогын хэрэгжилтийг хангах**

- 6.1 Энэхүү бодлогын хэрэгжилтийг хангах ажиллагааг ТУЗ-ийн нэр дэвшүүлэх хорооны удирдлага чиглэлийн дагуу компанийн хүний нөөцийн асуудал харниусан нэгж хэрэгжүүлнэ.



"Бэрс финанс ББСБ" ХХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 01-р сарын 04-ний өдрийн 23/01а/01 тоот тогтоолын Хавсралт 7"





## **"БЭРС ФИНАНС ББСБ" ХХК-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ ЖУРАМ**

### **Нэг. Ерөнхий зүйл.**

- 1.1 Энэхүү журмаар компаниас хувьцаа эзэмшигчид хөрөнгө оруулагчдад болон нийтэд хүргэх мэдээллийн жагсаалт, нийтэд хүргэх арга хэрэгслэл /нэвтрүүлэх, нийтлүүлэх мэдээллийн хэрэгслэл, давтамж/, хариуцах албан тушаалтан зэргийг тогтооно.
- 1.2 Компанийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг цаг тухайд нь нийтийн хүртээл болгох замаар компанийн үйл ажиллагааг ил тод нээлттэй байлгаж, хөрөнгө оруулагчид болон оролцогч талуудын итгэлийг нэмэгдүүлэх, дотоод буюу нийтийн хүртээл болоогүй мэдээллийг шударга бусаар ашиглахаас сэргийлэх нь компанийн гүйцэтгэх удирдлагын үүрэг байна. Харин энэ үйл ажиллагаанд компанийн ТУЗ нь Аудитын хороогоор дамжуулан хяналт тавина.
- 1.3 Компанийн гүйцэтгэх захирал нь хууль, зохицуулах байгууллагаас тогтоосон журамд заасан болон бусад чухал ач холбогдол бүхий мэдээллийг цаг тухай бүр нийтэд хүргэх ажлыг биечлэн хариуцаж, зохион байгуулах бөгөөд энэ мэдээллийн хувийг тухай бүр ТУЗ-ийн нарийн бичгийн даргад хүргүүлнэ.
- 1.4 Мэдээллийг нээлттэй болгох үйл ажиллагаанд дараах зарчмыг удирдлага болгоно.
  - ✓ тогтмол байх
  - ✓ цаг хугацаандаа байх
  - ✓ компанийн хувьцаа эзэмшигчид болон сонирхогч бусад этгээдэд бүгдэд нь тэгш хүртээмжтэй байх
  - ✓ үнэн зөв байх
  - ✓ агуулгын хувьд бүрэн байх
  - ✓ компанийн бизнесийн эрх ашиг, нээлттэй байх зарчим хоёрын зохистой тэнцвэрийг хангах
  - ✓ өөрийн үйл ажиллагааны доголдол, дутагдлыг нууж хаах, гоёчлон харуулах зорилго агуулаагүй

### **Хоёр. Нийтэд хүргэх мэдээлэл**

- 2.1 Компанийн ТУЗ-ийн гишүүд болон гүйцэтгэх удирдлагын эрх бүхий албан тушаалтнуудын тухай болон тэдгээр нь өөрчлөгдсөн тухай мэдээлэл;
- 2.2 Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүдийн тухай мэдээлэл;



- 2.3 Компанийн байршил, холбоо барих хаяг, утасны дугаар, хэрэв эдгээр нь оорчлогдсон бол тухай бүр мэдээлэх;
- 2.4 Компани салбар, тэдгээрийн байршил, холбоо барих хаяг, утасны дугаар, хэрэв эдгээр нь оорчлогдсон бол тухай бүр мэдээлэх;
- 2.5 Санхүүгийн зохицуулах хорооноос нийтийн хүртээл болгохоор тогтоосон бусад мэдээлэл орно.

### **ГУРАВ. КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖИЛИЙН ТАЙЛАНД ЗААВАЛ ТУСГАГДАХ МЭДЭЭЛЭЛ**

3.1 ББСБ-ын санхүүгийн жилийн үйл ажиллагааны тайлагналын мэдээлэл нь доорх 9 төрлийн цогц мэдээллээс бүрдэнэ.

3.1.1 ББСБ-ын тайлант хугацааны санхүүгийн мэдээлэл:

3.1.1.1 Жилийн санхүүгийн тайлан тэнцэл, тодруулга;

3.1.1.2 Аудитын үйлчилгээ үзүүлсэн компани нь санхүүгийн тайланд орсон мэдээлэл нь үнэн зөв, олон улсын стандартын дагуу тайлагнасныг баталж, үйлчилгээ үзүүлсэн этгээдтэй сонирхлын зөрчил үүсгээгүй, хараат бусаар ажилласан талаарх баталгаат захидал;

3.1.1.3 Санхүүгийн жилд авсан нийт өр төлбөр, тэдгээрийн эргэн төлөлт болон барьцаа, баталгааны талаарх мэдээлэл;

3.1.1.4 Жилийн санхүүгийн тайлангийн мэдээлэлд хөрөнгө оруулагч болон хувьцаа эзэмшигч хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад шаардлагатай санхүүгийн нөхцөл байдал, төлбөрийн ба хөрвөх чадвар болон зохистой харьцааг тодорхойлоход шаардлагатай мэдээллийг агуулна.

3.1.2 ББСБ-ын удирдлагаас гаргах тайлангийн мэдээлэл:

3.1.2.1 ББСБ нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, нягтлан бодох бүртгэлийн бодлогод орсон өөрчлөлт, удирдлагаас өгсөн үнэлгээ, компанийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэл, бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлэх, ашигт ажиллагааг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээ зэрэг мэдээллийг тусгасан тайланг дараах агуулгын хүрээнд гаргана.

3.1.2.2 Үйл ажиллагааны үр дүнгийн мэдээлэл:



3.1.2.3 Тайлант жилд ББСБ-ын орлогод нөлөөлсөн гадаад, дотоод орчны нөлөөллийг тусгасан дүгнэлт, мэдээлэл;

3.1.2.4 Хөрвөх чадварын болон санхүүгийн нооц, боломжийн мэдээлэл;

3.1.2.5 ББСБ-ын богино, дунд, урт хугацааны төлбөрийн чадварын болон зохистой харьцааны үзүүлэлтүүд, өөрийн санхүүгийн нооцөөр бизнесийн үйл ажиллагаанаас бий болсон ор төлбөрийг бүрэн хариуцах боломж, шаардлагатай тохнолдолд гадаад, дотоод санхүүжилтийн эх үүсвэрээс санхүүжилт татах боломжтой эсэх дүгнэлт, мэдээлэл;

3.1.2.6 ББСБ-ын үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, банк бус санхүүгийн салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний шинэчлэл.





торолжилт, дээрх өөрчлөлтөд байгууллагын зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл;

**3.1.3 Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл:**

**3.1.3.1** Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, хараат, хараат бус гишүүд, гүйцэтгэх удирдлагын мэдээлэл, үнэт цаас гаргагчийн удирдлагын бүтэц, бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт, төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын чиг үүрэг, хариуцлага, гишүүдийн нэр, боловсрол, ажлын туршлага, ёс зүйн кодекс, эрсдэлийн удирдлагын хэрэгжилт, мөн төлөөлөн удирдах зөвлөл болон түүний дэргэдэх хороодын ажлын тайланг хэлэлцсэн хувьцаа эзэмшигчдийн хурлын дүгнэлт, гүйцэтгэх удирдлагын ажлын тайланг хэлэлцсэн төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт, дотоод аудитын ажлын тайланг хэлэлцсэн төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт, мэдээлэл.

**3.1.3.2** ББСБ-аас шаардлагатай тохиолдолд Хорооноос баталсан үнэлгээний аргачлалын дагуу өөрийн компанийн засаглалыг үнэлсэн үнэлгээний тайлан.

**3.1.4 Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл:**



ББСБ нь зах зээлийн эрсдэлийг удирдах чиглэлээр гаргасан үүсмэл санхүүгийн болон бусад хэрэгслийн мэдээлэл, зах зээлийн эрсдэлийг тооцдог арга аргачлал, эрсдэлийг удирдах стратегийн талаарх мэдээлэл;

**3.1.5 Нийгмийн хариуцлага:**

ББСБ-аас тайлант хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлан, мэдээлэл.

**ДӨРӨВ. ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ӨМНӨ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД ЗААВАЛ ТОЛИЛУУЛАХ МЭДЭЭЛЭЛ**

- 4.1 Компанийн үйл ажиллагааны жилийн тайлан /энэ журмын Гуравдугаар хэсэгт заасан мэдээллийг агуулсан/
- 4.2 Жилийн санхүүгийн тайлан холбогдох тайлбар, тодруулга, аудитын байгууллагын дүгнэлтийн хамт;
- 4.3 Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэр, хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн бол үндэслэл;
- 4.4 Төлөөлөн удирдах зөвлөлд нэр дэвшигчдийн тухай танилцуулга;
- 4.5 Хэрвээ ээлжит хурлаар компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай асуудал хэлэлцэх бол нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, үндэслэл, тайлбарын хамт;
- 4.6 Компанийг өөрчлөн байгуулах асуудал хэлэлцэх бол өөрчлөн байгуулах хэлбэр, үндэслэл, өөрчлөн байгуулах журам, үүнтэй холбогдсон хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлэх журам зэргийг тусгасан өөрчлөн байгуулах төсөл, бусад холбогдох баримт бичиг;
- 4.7 Нэмж хувьцаа гаргах асуудал хэлэлцэх бол түүний борлуулалтаас олсон орлогыг хэрхэн зарцуулах тухай танилцуулга, эдийн засгийн үр ашгийн тооцоо, хувьцаа




- эзэмшигчид хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах давуу эрхээ хэрэгжүүлэх журам;
- 4.8 Өрийн бичиг бусад үнэт цаас гаргах тухай асуудал хэлэлцэх бол бол түүний борлуулалтаас олсон орлогыг хэрхэн зарцуулах тухай танилцуулга, эдийн засгийн үр ашгийн тооцоо;
- 4.9 Компанийн засаглалын тайлан, ТУЗ-ийн гишүүдийн үйл ажиллагаанд өгсөн үнэлэлт дүгнэлт
- 4.10 Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах бусад асуудлыг хэлэлцэхэд хувьцаа эзэмшигчдэд ямар бичиг баримт танилцуулахыг хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай ТУЗ-ийн шийдвэрт заасан байна.

#### **ТАВ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙГ МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ**

- 5.1 Хууль, зохицуулах байгууллагын журам, компанийн дүрэм болон энэхүү журмаар тогтоосон мэдээллийг нээлттэй болгохоос гадна хувьцаа эзэмшигчдийн хүсэлтээр цаг тухайд нь саадгүй гаргаж өгнө.
- 5.2 Компанийн жилийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, компанийн нэгдмэл сонирхолтой этгээдийн нэр, тэдгээрийн эзэмшилд байгаа хувьцааны төрөл, тоо, Санхүүгийн зохицуулах хороо болон хөрөнгийн биржийн дүрэм журмаар тогтоосон болон энэхүү журмын хоёрдугаар хэсэгт заасан мэдээллийг компанийн хувьцаа эзэмшигчдийн хүсэлтээр танилцуулна.
- 5.3 Компанийн анхан шатны болон нягтлан бодох бүртгэл, гүйцэтгэх удирдлагын хурлын тэмдэглэл, тушаал, шийдвэр болон хууль тогтоомжоор нийтэд мэдээлэхийг хориглосноос бусад бичиг баримттай танилцах, төлбөртэй хуулбарлан авах боломжийг хувьцаа эзэмшигчдэд олгох нь ТУЗ-ийн нарийн бичгийн даргын үүрэг байна.
- 5.4 Мэдээлэл хүсэж байгаа хувьцаа эзэмшигч хүсэлтдээ өөрийн болон эцэг /эх/ -ийн нэр, хаяг /шуудангийн болон и-мэйл/, холбоо барих утас, эзэмшиж байгаа хувьцааны тоо, төрөл, авахыг хүсэж байгаа мэдээлэл, мэдээлэл авах хэлбэр /биечлэн, бичгээр, и-мэйлээр/ зэргийг заасан байна.
- 5.5 Уг хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногийн дотор /мэдээлэл ач холбогдлоо алдахаар бол боломжит богино хугацаанд/ ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хариуцан мэдээллийг боломжит хэлбэрээр хүргүүлнэ.
- 5.6 Хувьцаа эзэмшигчийн хүссэн мэдээлэл нь хууль тогтоомж болон компанийн дотоод бичиг баримтаар тогтоосон нээлттэй болгох мэдээллийн жагсаалтад багтаагүй бөгөөд компанийн бизнесийн нууцад хамаарахаар мэдээлэл бол энэ тухай үндэслэл бүхий тайлбарыг хүргүүлнэ.

#### **ЗУРГАА. ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГАД ТУХАЙ БҮР ХҮРГЭХ МЭДЭЭЛЭЛ**




- 6.1 Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 210 дугаар тогтоолоор баталсан “Банк бус санхүүгийн байгууллагын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-ын 1-17 дугаар хавсралтаар баталсны дагуу дараах мэдээллийг тухай бүр журамд заасан хугацаанд Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлнэ. Үүнд:
- 6.1.1 Банк бус санхүүгийн байгууллага нь дараах зохистой харьцааны тайланг улирал бүр гаргаж, дараа улирлын эхний сарын 10-ны өдрийн дотор Хороонд бичгээр болон цахимаар ирүүлнэ.
  - 6.1.2 Өөрийн хөрөнгө, нийт эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцааны тайлан хавсралт 1/;
  - 6.1.3 Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын тайлан /хавсралт 2/;
  - 6.1.4 Гадаад валютын ханшийн эрсдэлийн тайлан /хавсралт 3/;
  - 6.1.5 Активын эрсдэлийн сангийн хүрэлцээ, хангамжийн судалгааны тайлан/хавсралт 4/;
  - 6.1.6 40 том зээлдэгчид олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгийн байлан /хавсралт 5/;
  - 6.1.7 Хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх захирал, ажилтанд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгийн тайлан /хавсралт 6/;
  - 6.1.8 Ипотекийн зээлийн тайлан /хавсралт 7/;
  - 6.1.9 Үнэт цаасны төвлөрлийн тайлан /хавсралт 8/;
  - 6.1.10 Банк, санхүүгийн байгууллага, төсөл хөтөлбөр, бусад эх үүсвэрээс татсан зээлийн тайлан /хавсралт 9/;
  - 6.1.11 Өрийн бичгийн тайлан /хавсралт 10/;
  - 6.1.12 Хөрөнгө, эх үүсвэрийн эргэн төлөгдөх хугацааны тайлан /хавсралт 11/;
  - 6.1.13 Тэнцлийн гадуур бүртгэлтэй хүлээж болзошгүй үүрэг, толборийн баталгааны судалгааны тайлан /хавсралт 12/;
  - 6.1.14 Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн нэгдсэн тайлан /хавсралт 13/.
- 6.2 Банк бус санхүүгийн байгууллага нь дараах мэдээг сар бүр гаргаж, дараа сарын 10-ны өдрийн дотор Хороонд цахимаар ирүүлнэ.
- 6.2.1 Зээл олголт, эргэн төлөлт, зээлийн зориулалт, хүүгийн судалгааны мэдээ /хавсралт 14/;
  - 6.2.2 Итгэлцлийн үйлчилгээний төвлөрлийн мэдээ /хавсралт 15/;
  - 6.2.3 Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээний мэдээ /хавсралт 16/;
  - 6.2.4 Сар тутмын валют арилжааны мэдээ /хавсралт 17/.
- 6.3 Энэ журмын 6.1, 6.2-т заасан тайлан мэдээг санхүүгийн тайлангийн жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлж 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгож, өссөн дүнгээр тайлагнана



2023-04-06

БҮРТГЭВ-02



6.4 Монгол банкны Ерөнхийлөгчийн 2019 огны 1 дүгээр сарын 21-ний өдрийн А-26 тоот тушаалаар баталсан “Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллаганы журам”-ын 18.1-д заасны дагуу 20 сая төгрөг түүнээс дээш үнийн длүнтэй бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээний тухай мэдээллийг гүйлшгээ хийгдсэнээс хойш ажлын 5 өдрийн дотор батлагдсан маягтын дагуу СМА-д мэдээлэх үүрэг хүлээнэ.

#### ДОЛОО. ХАРИУЦЛАГА

- 7.1 Компанийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо, компанийн дүрэм болон энэхүү журмаар тогтоосон мэдээллийг нийтийн хүртээл болгох, эрх бүхий зохицуулах байгууллагад хүргүүлэх, хувьцаа эзэмшигчийг мэдээллээр цаг хугацаанд нь бүрэн хангах үүргээ хэрэгжүүлээгүй албан тушаалтны талаар Аудитын хороо, ТУЗ-ийн хуралдаанд танилцуулна.
- 7.2 Аль нэг албан тушаалтны буруутай үйл ажиллагааны улмаас Компанийн тухай болон бусад холбогдох хуулийн дагуу компанид захиргааны хариуцлага хүлээлгэсэн бол холбогдох буруутай этгээдээр нөхөн төлүүлэх асуудлыг ТУЗ шийдвэрлэнэ.
- 7.3 Эрх бүхий албан тушаалтан нь мэдээллийг нийтийн хүртээл болгох, хувьцаа эзэмшигчид эрх бүхий этгээдэд мэдээлэл өгөх үүргээ удаа дараа биелүүлээгүй, эсхүл удаа дараа хугацаа хожимдуулсан, хуурамч бодитой бус мэдээлэл өгсөн бол энэ нь албан тушаалаас нь чөлөөлөх үндэслэл болно.

2023-04-06

БҮРТГЭВ-02

СЭХ

2023 оны 04 сар 06 өдөр

БҮРТГЭВ

№ 01

“Бэрс финанс ББСБ” ХХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 01-р сарын  
04-ний өдрийн 23/01а/21 тоот тогтоолын Хавсралт 8”

БЭРС ФИНАНС

БЭРС ФИНАНС

БЭРС ФИНАНС

БЭРС ФИНАНС

## “БЭРС ФИНАНС ББСБ” ХХК-ИЙН



### ОРОЛЦОГЧ ТАЛУУДАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ БОДЛОГО

#### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү бодлогын зорилго нь “Бэрс финанс ББСБ” ХХК (цаашид “компани” гэх)-ийн үйл ажиллагаанд оролцогч талууд болох гэрээ гүйцэтгэгчид, түншүүд, харилцагчид, зээлдэгчид болон ажилтнуудтай хамтран ажиллах бодлого чиглэл, зарчмыг тогтооход оршино.

#### Хоёр. Оролцогч талуудтай хамтран ажиллах

- 2.1 Хамтран ажиллаж буй бүхий л төрлийн ажил үйлчилгээ үзүүлдэг, үүнд бүх төрлийн гэрээт компани /хувь хүн/, аудитын компани, банк, санхүүгийн байгууллага, өмгөөллийн зөвлөх үйлчилгээний компани, үнэт цаасны компани, зар сурталчилгааны компани, хөрөнгө итгэмжлэн удирдагч компани, зохицуулах байгууллага, төрийн үйлчилгээний байгууллага зэрэг байна.
- 2.2 Оролцогч талуудын хамтын ажиллагааг тэдгээртэй байгуулсан гэрээгээр зохицуулах бөгөөд уг гэрээнд дараах асуудлыг заавал тусгасан байна. Үүнд:
  - 2.2.1 Гэрээний үнийн дүн, үргэлжлэх хугацаа гэх мэт үндсэн нөхцлүүд
  - 2.2.2 Талуудын хүлээх үүрэг хариуцлага
  - 2.2.3 Талуудын эрх, үүрэг
  - 2.2.4 Гэрээг дүгнэх
  - 2.2.5 Гэрээг зөрчсөн тохиолдолд хүлээх хариуцлага
- 2.3 Талуудтай байгуулсан гэрээг улирлаар юмуу жилээр /гэрээнд заасны дагуу/ заавал дүгнэж, “Гэрээ дүгнэсэн акт” үйлдэж хэвших бөгөөд гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлэггүй, чанаргүй, дутуу биелүүлсэн зэргээр гэрээг зөрчсөн тохиолдолд гэрээг цуцалж, өөр этгээдтэй гэрээ байгуулан ажиллах зарчим баримтлана.




- 2.4 Компанийн зүгээс гэрээгээр хүлээсэн үүргээ чанд биелүүлэн ажиллах бодлого баримтлах бөгөөд тодорхой гэрээний хэрэгжилтийг хариуцан ажиллах ажилтны чиг үүрэг тодорхой байх зарчмыг мөрдлого болгон ажиллала.
- 2.5 Гэрээ дүгнэсэн акт үйлдэх үед компанийн буруугаар гэрээ зорчсон нь тогтоогдвол гэрээгээр тогтоосон хариуцлагаа хүлээгээд, гэм буруутай ажилтанд зохих хариуцлага хүлээлгэнэ.
- 2.6 Гэрээг зөрчсөнөөр компанид болон гэрээ гүйцэтгэгчид ноцтой хохирол учруулсан, гэрээ зөрчсөн үйлдэл нь сонирхлын зөрчлөөс шалтгаалсан зэрэг тохиололд ажилтанд материалын хариуцлага хүлээгэхээс гадна ажлаас халах, хуулийн байгууллагад шилжүүлэх хүртэл арга хэмжээ авна.

#### Гурав. Ажилтнуудтай хамтран ажиллах

- 3.1 Ажилтнуудтай харилцах харилцаанд дараах суурь зарчмыг баримтална:
- 3.1.1 Үл ялгаварлан гадуурхах;
  - 3.1.2 Хөдөлмөрлөх эрх чөлөөг баталгаажуулах, ажил, мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангагдах, цалин хөлс авах, амрах;
  - 3.1.3 Дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтыг хориглох;
  - 3.1.4 Албадан хөдөлмөрлүүлэхийг хориглох;
  - 3.1.5 Барьцаа хэрэглэхгүй байх;
  - 3.1.6 Эвлэлдэн нэгдэх, хамтын гэрээ, хамтын хэлэлцээр байгуулах, ажилтан, ажил олгогч, тэдгээрийн төлөөлөгчдийн хоорондын харилцааг зохицуулах эрхийг хангах;
  - 3.1.7 Шударга бус үйлдлийг хориглох;
  - 3.1.8 Нийгмийн түншлэлийг хангах;
- 3.2 Ажилтныг ажилд авахдаа “Хөдөлмөрийн гэрээ”-г байгуулна.
- 3.3 Хөдөлмөрийн гэрээ нь дараах шаардлагыг хангасан байна:
- 3.3.1 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын хууль тогтоомжид бүрэн нийцсэн байх, хууль тогтоомжоор ажилтанд олгосон эрхийн баталгааг түвшин, суурь хэм хэмжээг бууруулаагүй байх, харилцан тохиролцох замаар ажилтны хувьд сайжруулсан байх;
  - 3.3.2 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын хууль тогтоомжоос бусад хууль тогтоомжтой зорчилдоогүй байх;
  - 3.3.3 Хөдөлмөрийн гэрээнд дараах гол нөхцөлийг тусгана:
    - 3.3.4 Ажлын байрны нэр, ажлын байрны тодорхойлолтод заасан гүйцэтгэх ажил үүрэг;
    - 3.3.5 Ажил үүрэг гүйцэтгэх байршил;
    - 3.3.6 Цалин хөлсний хэмжээ;
    - 3.3.7 Хөдөлмөрийн нөхцөл.
    - 3.3.8 Ажил, амралтын цаг;
    - 3.3.9 Цалин хөлс олгох журам;
    - 3.3.10 Хөдөлмөрийн гэрээг цуцлах, дуусгавар болгох үндэслэл;
    - 3.3.11 Хөдөлмөрийн сахилга, гомдол гаргах журам;







- 3.3.12 Ажлын байранд тавигдах ур чадвар, чадамжийн шаардлага;
- 3.4 Энэ журмын 3.3-г зааснаас гадна ажил үүргийн онцлогтой нь холбоотойгоор эд хөрөнгийн харнуцлагын, нууцын, сургалтын, үл өрсөлдөх зэрэг нэмэлт нөхцөлийг харилцан тохиролцож хөдөлмөрийн гэрээнд тусгах, эсхүл эдгээр асуудлаар хөдөлмөрийн гэрээнд дагалдах тусгайлсан гэрээ байгуулж болно.
- 3.5 Шинээр ажилд авсан ажилтныг туршлагатай ажилтныг дагалдуулах, шинэ ажилтны сургалтад хамруулах, ажлын байран дээрх зэргээр ажилдаа дадлагажин суралцах боломжоор хангана.
- 3.6 Шинэ ажилтны сургалтын явцад компанийн дүрэм, үйл ажиллагаанд мөрдөж буй бүх журам, компанийн стратеги, алсын хараа, эрхэм зорилго, дунд болон богино хугацааны зорилго зорилт, төлөвлөгөө зэрэгтэй танилцуулна.
- 3.7 Ажилтнуудыг тасралтгүй сургалтад хамруулах төлөвлөгөөтэй байх бөгөөд тасралтгүй сургалтыг дотооддоо тусгай хөтөлбөрийн дагуу зохион байгуулахын зэрэгцээ, гадаад дотооддоо зохион байгуулагдаж буй тодорхой хөтөлбөрийн сургалтад тогтмол хамруулдаг байна.
- 3.8 Жил бүрийн эцэст “Хөдөлмөрийн гэрээ”-г дүгнэж, ажилтнуудад шагнал урамшуулал олгох асуудлыг шийдвэрлэдэг байна.
- 3.9 Компанийн дотоод дүрэм журмын зорчсон ажилтанд Хөдөлмөрийн дотоод журмаар тогтоосон харнуцлага ногдуулдаг байна.

#### **Дөрөв. Харилцагч, зээлдэгч нартай хамтран ажиллах**

- 4.1 Харилцагч зээлдэгч нартай харилцах харилцааг “Зээлийн үйл ажиллагааны ерөнхий журам”-ын хүрээнд зохицуулалтыг хийж ажиллана.



"Бэрс финанс ББСБ" ХХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 01-р сарын  
04-ний өдрийн 23/01а/01 тоот тогтоолын Хавсралт 9"



## **"БЭРС ФИНАНС ББСБ" ХХК-ИЙН СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ ХИЙХ ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**


2.1 Энэхүү журмаар компанийн хэмжээнд сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхтэй холбоотой харилцааг зохицуулна.

### **Хоёр. Сонирхлын зөрчилтэй хэлцлийн тухай ойлголт, хэлцэл хийх журам**

- 2.1 Компани аливаа сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх шийдвэр гаргах, шийдвэр гаргахад оролцох эрх бүхий этгээдийн хэлцэл хийх шийдвэр гаргахад оролцох үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.
- 2.2 Хэлцэл хийх шийдвэр гаргах, шийдвэр гаргахад оролцох эрх бүхий этгээд, түүний холбогдох этгээд нь компанитай хийх хэлцлийн нөгөө тал болж байгаа эсвэл тухайн талыг төлөөлж байгаа, хэлцэлд зуучилж байгаа тохиолдолд уг хэлцлийг сонирхлын зөрчилтэй хэлцэл гэж үзнэ.
- 2.3 Сонирхлын зөрчилтэй хэлцэл нь гүйцэтгэх захирлын эрх хэмжээний хэлцэл байсан тохиолдолд гүйцэтгэх захирал уг хэлцлийг хийх тухай асуудлыг ТУЗ-д оруулан хэлэлцүүлнэ.
- 2.4 Сонирхлын зөрчилтэй хэлцлийг хийхнийг зөвшөөрөх тухай шийдвэрийг уг хэлцлийг хийх талаар сонирхлын зөрчилгүй төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн олонхийн саналаар гаргана.
- 2.5 Сонирхлын зөрчилтэй хэлцлээр худалдах, худалдан авах, захиран зарцуулах эд хөрөнгө, эд хөрөнгийн болон мөнгөөр үнэлж болох бусад эрхийн зах зээлийн үнэ, үйлчилгээний хөлсний хэмжээг Компанийн тухай хуулийн 55 дугаар зүйлд заасан журмын дагуу төлөөлөн удирдах зөвлөл тогтооно.
- 2.6 ТУЗ-ийн бүх гишүүд бүгд сонирхлын зөрчилтэй байгаа тохиолдолд сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх тухай асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хурал шийдвэрлэнэ.

### **Гурав. Сонирхлын зөрчилтэй этгээдэд тавих шаардлага**

- 3.1 Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээд нь Төлөөлөн удирдах зөвлөл болон дотоод аудиторт дараах зүйлийг мэдээлэх үүрэгтэй:
  - 3.1.1 Компанийн хийхээр төлөвлөж байгаа хэлцэлд сонирхол бүхий этгээд болох тухайгаа;
  - 3.1.2 Энэ хэлцэлд оороо бус холбогдох этгээд нь оролцож байгаа тохиолдолд тухайн этгээдтэй ямар холбоо хамааралтай болох тухайгаа.



- 3.1.3 Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээд нь уг хэлцлийн талаар шийдвэр гаргахад оролцох эрхгүй.

**Доров. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журам зорчсоний үр дагавар**

- 4.1 Энэ журмын 2.2-т заасан этгээд нь энэ журмын 3.1 болон 3.2 дах заалтын шаардлага, журам зорчсоний улмаас компани буюу түүний хараат болон охин компанид учруулсан хохирлын хэмжээгээр, эсхүл хэлцлийн үр дүнд авсан зүйлээс олсон ашгийн хэмжээгээр хариуцлага хүлээнэ.
- 4.2 Компанийн тухай хуулийн 89.1-д заасан этгээдтэй байгуулсан хэлцлийг шүүх хүчин төгөлдөр бус гэж тооцож болно.


**Тав. Сонирхлын зөрчилтэй хэлцлийн улмаас үүсэх хохирлыг арилгах**

- 5.1 Сонирхлын зөрчилтэй хэлцлийн улмаас компани, түүний хараат болон охин компанид учирсан хохирлыг гэм буруутай этгээд өөрийн хөрөнгөөр нөхөн төлнө.
- 5.2 Компанийн энгийн хувьцаа эзэмшигч болон компанийг төлөөлөх эрх бүхий албан тушаалтан Компанийн тухай хуулийн 90.1-д заасан хариуцлага хүлээлгэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.

**Зургаа. Хариуцлага**

- 6.1 Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийсэн компанийн эрх бүхий албан тушаалтан Компанийн тухай хуулийн 85, 90 дүгээр зүйлд заасны дагуу хариуцлага хүлээнэ.
- 6.2 Компанийн тухай хуулийн 89.1-д заасан этгээд нь мөн хуулийн 91, 92 дугаар зүйлийн шаардлага, журам зөрчсөн, эсхүл компанитай хэлцэл байгуулсан хуулийн этгээдийн бүх хувьцааг уг этгээд дангаараа эзэмшдэг нөхцөлд компани нь учирсан хохирлыг тухайн хуулийн этгээдээр нөхөн төлүүлэх буюу энэ хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж тооцуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.
- 6.3 Компанийн энгийн хувьцаа эзэмшигч, эсхүл компани нь Компанийн тухай хуулийн 89.1-д заасан этгээд, эсхүл уг этгээдийн дангаараа бүх хувьцааг эзэмшдэг хуулийн этгээдээр компанид учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхээр итгэмжлэлгүйгээр шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.





“Бэрс финанс ББСБ” ХХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 01-р сарын 04-ний өдрийн 23/01а/01 тоот тогтоолын Хавсралт 10”

## МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБОГДОХ СОНИРХЛЫН ЗӨРЧЛИЙГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Компанийн үндсэн үйл ажиллагаа болох зээлийн болон итгэлцлийн үйл ажиллагаатай холбогдон компани, ажилтнууд болон компани хөрөнгө оруулагчид, зээлдэгчдийн хооронд үүсч болох сонирхлын зөрчлийг бууруулах, үүссэн үед ил тод тайлагнах замаар хөрөнгө оруулагчид, зээлдэгчдийн эрх ашгийг хамгаалахад чиглэсэн ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.
- 1.2 Зээл олгохтой холбоотой аливаа шийдвэр гаргах, хэрэгжүүлэх үед энэхүү шийдвэрийн улмаас үүсч болох сонирхлын зөрчлийн тухай асуудлыг ямагт анхааран үздэг байх нь компанийн ТУЗ, Гүйцэтгэх захирал, газар нэгж, салбарын захирлууд болон бүх түвшний ажилтны үүрэг байна.


### Хоёр. Сонирхлын зөрчлийн ангилал

- 2.1 Банк бус санхүүгийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад үүсч болох сонирхлын зөрчлийг дараах байдлаар ангилна. Үүнд:
  - 2.1.1 Компани болон ажилтны ашиг сонирхлын ялгаатай байдлаас үүсэх сонирхлын зөрчил;
  - 2.1.2 Компанийн ажилтнуудын ашиг сонирхлын ялгаатай байлаас үүсэх сонирхлын зөрчил;
  - 2.1.3 Компани болон хөрөнгө оруулагчдын ашиг сонирхлын ялгаатай байдлаас үүсэх сонирхлын зөрчил;
  - 2.1.4 Компанийн ажилтнууд болон хөрөнгө оруулагчдын ашиг сонирхлын ялгаатай байдлаас үүсэх сонирхлын зөрчил;
  - 2.1.5 Хөрөнгө оруулагчдын ашиг сонирхлын ялгаатай байдлаас үүсэх сонирхлын зөрчил

### Гурав. Сонирхлын зөрчлийг зохицуулах

- 3.1 Компанийн хэмжээнд сонирхлын зөрчлийг зохицуулж, хянахын тулд дор дурьдсан асуудлыг журмаар зохицуулсан байна. Үүнд:
  - 3.1.1 Ажилтнуудыг сургах ажлыг жилийн төлөвлөгөөнд тусган тогтмол хэрэгжүүлдэг байх
  - 3.1.2 Ажил үүргийн хуваарилалтыг толорхой болгох
  - 3.1.3 Ажил гүйлгээ болон үйл явцыг тогтмол баримтжуулж бүртгэдэг байх
  - 3.1.4 Дотоод хяналтын зохистой тогтолцоо бүрдүүлэн байнга хэрэгжүүлж, мониторинг хийдэг байх

### Дөрөв. Сонирхлын зөрчил үүсэх нөхцөл




- 4.1 Харилцагчдад үйлчлэх явцад компанийн ажилтнууд хувьдаа ашиг олох эсвэл хүлээж болох алдагдлаа бууруулах тулд харилцагчдад хохирол учруулж болохуйц гүйлгээ хийх замаар сонирхлын зөрчил үүсгэх
- 4.2 Компанийн үйл ажиллагааны явцад хувьдаа ашиг хүртэх зорилгоор компанийн эрх ашигт сөргөөр нөлөөлөх гүйлгээ хийх замаар сонирхлын зөрчил үүсгэх
- 4.3 Компанийн ашиг орлогыг нэмэгдүүлэх алдагдлыг бууруулах зорилгоор хөрөнгө оруулагчдад хохирол учруулахуйц ажил гүйлгээ хийх замаар сонирхлын зөрчил үүсгэх
- 4.4 Зарим нэг хөрөнгө оруулагчийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор тэдэнтэй хуйвалдан бусад хөрөнгө оруулагчдад хохирол учруулахуйц ажил гүйлгээ хийх замаар сонирхлын зөрчил үүсгэх
- 4.5 Гуравдагч этгээдийн ашиг сонирхлын төлөө тэднээс бэлэг сэлт, шан харамж авах замаар компанид болон харилцагч хөрөнгө оруулагчдад хориол учруулах ажил гүйлгээ хийх замаар сонирхлын зөрчил үүсгэх

#### **Тав. Сонирхлын зөрчлөөс сэргийлэх**


- 5.1 Сонирхлын зөрчил үүсгэх замаар компанид болон зээлдэгч, хөрөнгө оруулагчдад хохирол учруулах үйлдэл нь ихэнх тохиолдолд тодорхой ажил гүйлгээтэй холбоотой учраас ажил гүйлгээнд тавих хяналтыг зүй зохистой зохион байгуулах замаар сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлнэ.
- 5.2 Сонирхлын зөрчил үүсгэх хэлцэл хийгээгүй ч гэсэн хийх гэсэн оролдлого болон сэдэл нь компанийн бизнесийн нэр хүндэд хохирол учруулж, харилцагч хөрөнгө оруулагчдын итгэлийг алдахад хүргэх учраас энэ асуудалд онцгой анхаарал хандуулан ажилтнуудаа энэ асуудалд онцгой анхаарал хандуулан ажиллах, хэвшүүлэх талаар сургалт семинар, хэлэлцүүлгийг байнга зохион байгуулна.
- 5.3 Сонирхлын зөрчил үүсэх боломжийг хаахын тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.  
Үүнд:
  - 5.3.1 Ажилтнуудын ажил үүргийн хуваарийг зөв тогтоох
  - 5.3.2 Дотоод хяналтын зохистой тогтолцоо бүрдүүлэх замаар ажил гүйлгээ бүрийг хийхээс өмнө хянадаг, холбогдох эрх бүхий этгээд зөвшөөрдөг тогтолцоо бүрдүүлэх
  - 5.3.3 Ажилтнууд өөрийн хувийн болон холбогдох этгээдийн дансаар гүйлгээ хийх тохиолдолд мөрдөх журмыг тусгайлан болосруулж мөрдүүлэх, хувийн гүйлгээ хийсэн тохиолдолд бүрт дотоод хяналтын ажилтанд мэдээлдэг байх.

#### **Зургаа. Харилцагч**

- 6.1 Сонирхлын аливаа зөрчил гаргасан, гаргахаар завдсан ажилтанд анхны удаад сануулах арга хэмжээ авна.
- 6.2 Дээрх зөрчил давтагдсан эсвэл харилцагч болон компанид ноцтой хохирол учруулсан тохиолдолд хохирлыг нөхөн төлүүлэх арга хэмжээ авч ажлаас хална.
- 6.3 Хохирлыг нөхөн төлүүлэх боломжгүй тохиолдолд хуулийн байгууллагад шилжүүлэх арга хэмжээ авна.



“Бэрс финанс ББСБ” ХХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 01-р сарын  
04-ний өдрийн 23/01а/01 тоот тогтоолын Хавсралт II”



## “БЭРС ФИНАНС ББСБ” ХХК-ИЙН

### ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД МЭДЭЭЛЭЛ ХҮРГЭХ ЖУРАМ

#### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмын зорилго нь “Бэрс финанс ББСБ” ХХК (цаашид “компани” гэх)-ийн хувьцаа эзэмшигчид болон бусад хөрөнгө оруулагчидтай хамтран ажиллах, тэд нарт мэдээлэл хүргэх чиглэл, зарчмыг тогтооход оршино.



#### Хоёр. Хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдад хүргэх мэдээллийн төрөл

- 2.1 Компани нь Компанийн тухай хуульд заасны дагуу дараах баримт бичгийг хадгалж, хууль болон компанийн дүрэм, журмаар тогтоосон эрх бүхий этгээд болон хувьцаа эзэмшигчид болон хөрөнгө оруулагчдын шаардлагаар танилцуулах үүрэгтэй:
  - 2.1.1 Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэл, шийдвэр;
  - 2.1.2 Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн баримт;
  - 2.1.3 Төрийн эрх бүхий хяналт зохицуулалтын байгууллагад хүргүүлсэн мэдээ, тайлан.
  - 2.1.4 Компанийн үйл ажиллагааг зохицуулах бүхий л дүрэм журмууд
  - 2.1.5 Компанийн үйл ажиллагаатай холбогдох бусад баримт материалууд
  - 2.1.6 Нягтлан бодох бүртгэлд тусгагдсан эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийг нотлох баримт бичиг;


#### Гурав. Хувьцаа эзэмшигчид мэдээлэл хүргэх

- 3.1 Компанийн үйл ажиллагааны талаар мэдээлэл авахыг хүссэн хувьцаа эзэмшигч нь ТУЗ-ийн нарийн бичгийн даргад хүсэлтээ хүргүүлнэ.
- 3.2 Энэ журмын 2.2-т заасан хүсэлтэд ямар мэдээллийг, ямар хэлбэрээр, хэдийд авах хүсэлтэй байгаагаа заасан байна.
- 3.3 Хувьцаа эзэмшигчийн хүсэлтийг хүлээн авсан ТУЗ-ийн нарийн бичгийн дарга уг мэдээллийг хариуцан толилуулах боломжтой ажилтанд мэдээллийг хувьцаа эзэмшигчдийн хүссэн хэлбэрээр, хүссэн хугацаанд нь гаргаж өгөхийг үүрэг болгоод биелэлтэд нь хяналт тавина.
- 3.4 Хувьцаа эзэмшигчдийн хурлын өмнө хувьцаа эзэмшигчдэд дараах мэдээллийг хүргүүлнэ. Үүнд:
  - 3.4.1 Компанийн үйл ажиллагааны жилийн тайлан /Компанийн үйл ажиллагааны ил тод байдлын журмын Гуравдугаар хэсэгт заасан мэдээллийг агуулсан/;






- 3.4.2 Жилийн санхүүгийн тайлан холбогдох тайлбар, тодруулга, аудитын байгууллагын дүгнэлтийн хамт;
- 3.4.3 Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэр, хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн бол үндэслэл;
- 3.4.4 Төлөөлөн удирдах зөвлөлд нэр дэвшигчдийн тухай танилцуулга;
- 3.4.5 Тайлангийн жилд хийсэн сонирхлын зорчилтэй хэлцлийн жагсаалт, эдгээр хэлцлийг Компанийн тухай хуулийн 12 дугаар бүлэгт заасан журмын дагуу хийсэн эсэх тухай аудиторын дүгнэлт;
- 3.4.6 Компанийн болон хяналтын багц хувьцаа эзэмшигчдийн нэгдмэл сонирхолтой этгээдийн тухай мэдээлэл /хэрэв тэдгээр нь компанийн хувьцааг эзэмшдэг бол/;
- 3.4.7 Компанийн ТУЗ-ийн гишүүд гүйцэтгэх удирдлагын зардал, цалин, урамшуулал;
- 3.4.8 Хэрвээ ээлжит хурлаар компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай асуудал хэлэлцэх бол нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, үндэслэл, тайлбарын хамт;
- 3.4.9 Компанийг өөрчлөн байгуулах асуудал хэлэлцэх бол өөрчлөн байгуулах хэлбэр, үндэслэл, өөрчлөн байгуулах журам, үүнтэй холбогдсон хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлэх журам зэргийг тусгасан өөрчлөн байгуулах төсөл, бусад холбогдох баримт бичиг;
- 3.4.10 Нэмж хувьцаа гаргах асуудал хэлэлцэх бол түүний борлуулалтаас олсон орлогыг хэрхэн зарцуулах тухай танилцуулга, эдийн засгийн үр ашгийн тооцоо, хувьцаа эзэмшигчид хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах давуу эрхээ хэрэгжүүлэх журам;
- 3.4.11 Өрийн бичиг бусад үнэт цаас гаргах тухай асуудал хэлэлцэх бол бол түүний борлуулалтаас олсон орлогыг хэрхэн зарцуулах тухай танилцуулга, эдийн засгийн үр ашгийн тооцоо;
- 3.4.12 Компанийн засаглалын тайлан
- 3.4.13 ТУЗ-ийн гишүүдийн үйл ажиллагаанд өгсөн үнэлэлт дүгнэлт
- 3.5 Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах бусад асуудлыг хэлэлцэхэд хувьцаа эзэмшигчдэд ямар бичиг баримт танилцуулахыг хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай ТУЗ-ийн шийдвэрт заасан байна.



“Бэрс финанс ББСБ” ХХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 01-р сарын 04-ний өдрийн 23/01а/01 тоот тогтоолын Хавсралт 12”



## ШҮГЭЛ ҮЛЭЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл


- 1.1 Энэхүү журмаар компанийн хэмжээнд шүгэл үлээх бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохицуулна.
- 1.2 “Шүгэл үлээх үйл ажиллагаа” гэж компанийн болон харилцагчид, ажилтан албан хаагчдын нийтлэг ашиг сонирхлыг хохироосон, хохироож болзошгүй нөхцөл байдал, үйлдлийн талаар эрх бүхий этгээдэд мэдээлэл өгөх, гомдол гаргах, тайлбар өгөх үйл ажиллагааг ойлгоно.

### Хоёр. Шүгэл үлээх нөхцөлийг бүрдүүлэх

- 2.1 Компанийн хэмжээнд шүгэл үлээх мэдээллийг хүлээн авах эрхтэй этгээд нь гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн дарга, ТУЗ-ийн Аудитын хорооны дарга, дотоод аудитын баг байна.
- 2.2 Эдгээр хүмүүст мэдээлэл өгөхдөө бичгээр, биечлэн уулзаж болон утсаар мэдээлэл өгөх боломжтой байна.
- 2.3 Эдгээр хүмүүсийн “гарт нь” гэсэн дугтуйтай бичгийг бусад ажилтнууд нээж үзэх эрхгүй байна.
- 2.4 Эдгээр хүмүүст утсаар мэдээлэл өгөх боломжийг бүрдүүлэхийн тулд утасны дугаарыг нь нийтэд нээлттэй хэлбэрээр байршуулах үүргийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хүлээнэ.

### Гурав. Шүгэл үлээх ажиллагааг хэрэгжүүлэх

- 3.1 Шүгэл үлээхийг хүссэн этгээд нь мэдээллийг хэнд хүргэх, ямар хэлбэрээр хүргэх, өөрийн нэрийг нууцлах эсэхээ өөрөөр шийднэ.
- 3.2 Шүгэл үлээхийг хүссэн этгээд нь өгөх мэдээллээ сонгосон этгээддээ сонгосон хэлбэрээр хүргэнэ.
- 3.3 Шүгэл үлээх журмаар хүргэсэн мэдээллийг хүлээн авсан этгээд нь уг мэдээлэлтэй танилцаад дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:
  - 3.3.1 Шүгэл үлээх журмаар хүлээн авсан мэдээллийн мөрөөр шалгалт хийх эсэх, шалгалт хийх бол ямар хэлбэрээр шалгалт хийхээ шийдвэрлэнэ.
  - 3.3.2 Ямар шалгалт хийхээ шийдвэрлэсний дараа шалгалтын ажлын хэсгийг томилж, удирдамжийг батална.



- 3.3.3 Шалгалт дуусаж, дүгнэлтийг хүлээн авсны дараа ямар арга хэмжээ авахаа шийдвэрлэнэ.
- 3.3.4 Шалгалт хийлгүй асуудлыг шийдвэрлэх боломжтой гэж үзсэн тохиолдолд холбогдох арга хэмжээг авч шүгэл үлээгчид хариу мэдэгдэнэ.
- 3.3.5 Шалгалтын мөрөөр арга хэмжээ авсан тохиолдолд асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн талаар шүгэл үлээгчид хариу мэдэгдэнэ.



#### **Дөрөв. Шүгэл үлээсэн мэдээллийн мөрөөр авах арга хэмжээ**

- 4.1 Шүгэл үлээх журмаар авсан мэдээллийн мөрөөр авах арга хэмжээ нь хүлээж авсан мэдээлэл хэр зэрэг ноцтой мэдээлэл байснаас шалтгаална.
- 4.2 Шүгэл үлээх журмаар хүлээн авсан мэдээлэл нь нотцой гэмт хэргийн чанартай үйлдлийн талаарх мэдээлэл байсан тохиолдолд хуулийн байгууллагад шилжүүлэн шалгуулах арга хэмжээ авна.
- 4.3 Компани дотроо шийдвэрлэх боломжтой асуудлын талаарх мэдээлэл байсан тохиолдолд энэ журмын 3.3.3-т заасны дагуу дүгнэлтийг хүлээн авсны дараа холбогдох арга хэмжээ авна. Үүнд:
  - 4.3.1 Гүйцэтгэх захирал тушаал шийдвэр гаргах замаар асуудлыг шийдвэрлэх
  - 4.3.2 ТУЗ-ийн хурлаар асуудлыг хэлэлцүүлэн шийдвэрлэх
  - 4.3.3 Холбогдох буруутай этгээдэд шийтгэл ногдуулж учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх замаар шийдвэрлэх
  - 4.3.4 Холбогдох дүрэм журамд нэмэлт өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэх
  - 4.3.5 Бусад холбогдох арга хэмжээ авах
- 4.4 Шүгэл үлээгч өгсөн мэдээллийн мөрөөр ямар нэг арга хэмжээ аваагүй тохиолдолд шүгэл үлээгч мэдээллээ дээд шатны албан тушаалтанд, эсхүл хянах зохицуулах эрх бүхий байгууллагад мэдээлэл өгөх эрхтэй байна.

#### **Тав. Хариуцлага**

- 5.1 Энэ журмыг зөрчиж шүгэл үлээх замаар хүлээн авсан мэдээллийн мөрөөр арга хэмжээ аваагүй, шүгэл үлээгч мэдээллээ нууцлахыг хүссэн тохиолдолд түүний нууцлахыг хүссэн мэдээлэл тухайлбал, шүгэл үлээгчийн хувийн мэдээллийг задалсан зэргээр энэхүү журмыг зөрчсөн албан тушаалтанд ажлаас нь чөлөөлөх хүртэл арга хэмжээ авна.





“Бэрс финанс ББСБ” ХХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 01-р сарын 04-ний өдрийн 23/01а/01 тоот тогтоолын Хавсралт 13”

## “БЭРС ФИНАНС ББСБ” ХХК-ИЙН ЁС ЗҮЙН ДҮРЭМ

### Нэг. Нийтлэг үндэслэл



- 1.1. Энэхүү журмын зорилго нь “Бэрс финанс ББСБ” ХХК (цаашид “компани” гэх)-ийн ТУЗ-ийн гишүүд болон бүх ажилтнуудын баримтлах ёс зүйн зарчим, дүрмийг тогтооход оршино.

### Хоёр. ТУЗ-ийн гишүүдийн баримтлах ёс зүйн зарчим

- 2.1 Монгол улсын хууль тогтоомж, компанийн дотоод дүрэм журам, “ТУЗ-ийн үйл ажиллагааны журам”-д заасан өөрийн үүргээ нэр төртэй биелүүлэн ажиллах;
- 2.2 ТУЗ-ийн гишүүний хувьд аливаа асуудлаар шийдвэр гаргахдаа компанитай болон харилцагчид, бусад оролцогч талуудтай сонирхлын зөрчил үүсгэхээс сэргийлж, үүссэн тохиолдолд зохих журмын дагуу ТУЗ-ийн дарга болон холбогдох бусад этгээдэд мэдэгдэж, шийдвэр гаргахад оролцдоггүй байх журмыг чанд баримтлан ажиллах;
- 2.3 Шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцохдоо бусдын нөлөөнд авталгүй хараат бусаар ажиллах;
- 2.4 Мэргэжлийн мэдлэг, ялангуяа компанийн сайн засаглалын зарчмын талаар мэдлэг, тэдгээрийг практикт нэвтрүүлэх талаар ур чадвараа цаг ямагт дээшлүүлэх, шударга ажиллах;

### Гурав. Ажилтнуудын баримтлах ёс зүйн зарчим

- 3.1 Компанийн ТУЗ-ийн гишүүдээс эхлээд бүх түвшний ажилтнууд нь үйл ажиллагаандаа дараах зарчмыг тасралтгүй мөрдөн ажиллана. Үүнд:
  - 3.1.1 Мэргэжлийн ёс зүйтэй байх;
  - 3.1.2 Монгол улсын хууль тогтоомж, компанийн дотоод дүрэм журам, түүнтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасан өөрийн үүргээ нэр төртэй биелүүлэн ажиллах;
  - 3.1.3 Өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэн явуулахдаа компани болон харилцагчид, бусад оролцогч талуудтай сонирхлын зөрчил үүсгэхээс сэргийлж, үүссэн тохиолдолд зохих журмын дагуу холбогдох этгээдэд мэдэгддэг байх журмыг чанд баримтлан ажиллах;
  - 3.1.4 Үйл ажиллагаа явуулахдаа харилцагч, зээлдэгчийн эрх ашгийг тэргүүн ээлжид тавих зарчмыг ямагт мөрдөн ажиллах;
  - 3.1.5 Үйл ажиллагаа явуулахдаа бусдын нөлөөнд авталгүй хараат бусаар ажиллах;



- 3.1.6 Мэргэжлийн ур чадвараа цаг ямагт дээшлүүлэх, шударга ажиллах;
- 3.1.7 Харилцагч, зээлдэгчдийг үнэн зөв мэдээллээр бүрэн хангахыг ямагт чармайн ажиллах.

#### **Доров. Ажилтнуудын ёс зүйн дүрэм**

4.1 Ажилтнууд нь үйл ажиллагаандаа дор дурьдсан ёс зүйн дүрмийг баримтлан ажиллана.  
Үүнд:

- 4.1.1 Эрх бүхий байгууллагаас баталсан болон компанийн дотоодод баримтлах ёс зүйн дүрмийг сайтар судлан, дагаж мөрдөн ажиллах үүрэг хүлээх бөгөөд энэ тухайгаа бичгээр баталгаа гаргаж өгнө.
- 4.1.2 Ажил үүргийнхээ дагуу харилцагч, зээлдэгчээс авсан мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг чанд хадгалан зөвхөн ажил үүргээ гүйцэтгэхдээ ашиглана.
- 4.1.3 Энэхүү дүрмийн 3.1.2 дах заалт нь хууль журмаар хүлээсэн үүргийнхээ дагуу харилцагч, зээлдэгчийн хууль бус үйлдлийн талаар холбогдох байгууллагад мэдээлэх үүрэг, шүгэл үлээх болон мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг хууль тогтоомжийн дагуу мэдээлэл өгөх үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.
- 4.1.4 Ажилтан нь өөрийн компанийн болон харилцагч, зээлдэгчийн үйл ажиллагаатай холбоотой олон нийтийн хүртээл болоогүй байгаа дотоод мэдээлэл ашиглан гүйлгээ хийх, бусдад дамжуулах зэрэг үйл ажиллагаанд оролцохыг хориглоно.
- 4.1.5 Ажилтан нь аливаа үйл ажиллагаа явуулахдаа бүх харилцагчиддаа ижил тэгш хандах зарчмыг чанд баримтлан ажиллана.
- 4.1.6 Харилцагч, зээлдэгчийн ашиг сонирхлыг өөрийн хувийн ашиг сонирхлоос тэргүүнд тавих зарчмыг баримтлан ажиллана.
- 4.1.7 Ажилтан өөрийн болон компанийн нэрийн өмнөөс гүйлгээ хийхдээ харилцагч, зээлдэгчийн ашиг сонирхлыг зөрчиж болзошгүй гүйлгээ хийхийг хориглоно.
- 4.1.8 Өөрийн бие даасан хараат бус, шударга байдалд нөлөөлж болох бизнесийн харилцаанд оролцох, бэлэг шагнал төлбөр, түүнтэй адилтгах зүйлсийг аливаа иргэн хуулийн этгээдээс авахыг хориглоно.

#### **Тав. Ажилтан үндсэн үйл ажиллагаа гүйцэтгэхдээ баримтлах зарчим**

- 5.1 Салбарын ажилтан нь зээл олгох шийдвэр гаргах үндэслэл болсон мэдээллийг бэлдэхдээ мэргэжлийн өндөр ур чадвар гарган, нухацтай хандаж, холбогдох хууль, байгууллагын журам, арга аргачлалыг дагаж мөрдөнө.
- 5.2 Зээл олгох шийдвэр гаргахдаа эрсдэлийг зөв үнэлэн, бие даасан, хараат бусаар шийдвэр гаргана.


#### **Зургаа. Харнуцлага**

- 6.1 Компанийн ажилтны энэхүү дүрмийг зорчсон үйлдэлд эрүүгийн харнуцлага хүлээлгэхээргүй байвал хөдөлмөрийн гэрээнд заасан харнуцлага хүлээлгэнэ.

**“БЭРС ФИНАНС ББСБ” ХХК-ИЙН “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН  
ХЭРЭГЖИЛГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2023.01.13

	Үнэлгээ	Тайлбар
<p><b>НЭГДҮГЭЭР ЗАРЧИМ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ</b> Төлөөлөн удирдах зөвлөл нь олон талт ур чалвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна</p>		
1		<p>1.1. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмаар төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулна.</p>
2		<p>1.2. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилж асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх журим, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна.</p>
3		<p>1.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн бүрийн ажлын туршилага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц зэргэ мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд дэлгэрэнгүйгээр тусгаж, өөрийн цахим хуудсанд байрцуулна.</p>



4	1.4. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлийн болон түүний дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүний бодлогын баримт бичигтэй байх ба уг баримт бичигт гишүүний боловсрол, мэргэжил, ур чадвар, туршилтад тавигдах шаардлага болон хүйсийн тэнцвэр зэрэг асуудлыг тусгана.	ТУЗ-ийн дэргэдэх Хороодын журам Үнэлгээний тайланд хавсаргав. /ТУЗ-ийн тогтоолын Хавсралт 2/.
5	1.5. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг анх томилогдоход чиглүүлэх сургалтыг зохион байгуулах ба ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг, мэдээллийг олгох, шинэчлэх сургалтад тогтмол хамруулна.	Сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, тайлан ирүүлэх ТУЗ-ийн гишүүдийн бүрэлдэхүүнийг шинэчилсний дараа сургалтын төлөвлөгөө гарна. /2023.09 сар/
6	1.6. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг зохицотой явуулах асуудлаар төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар дамжуулан харууцлага хүлээнэ.	Томилсон шийдвэрийг ирүүлэх ТУЗ гишүүдийн сонгон шалгаруулалтын дараа /2023.06/
<b>ХОЁРДУГААР ЗАРЧИМ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ</b>		
Төлөөлөн удирдах зөвлөл нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хармуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн харууцлагыг хүлээнэ		
7	2.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга болоод төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн олонх нь хариат бус гишүүн байхыг зоринo.	
8	2.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хороо нь үйл ажиллагааны эсрэм аудитын бодлогын баримт бичигтэй байна. Аудитын хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус байна. Аудитын хорооны хурал компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү тус хорооны хүсэлтээр оролцоно.	Аудитын хорооны тухай ТУЗ-ийн дэргэдэх Хороодын журмын Хоёрдугаар бүлэгт оруулж өгсөн. Үнэлгээний тайланд журмыг нь хавсаргав /ТУЗ-ийн тогтоолын Хавсралт 2/.
9	2.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх цалин урамшууллын хороо нь цалин, урамшууллын үйл ажиллагааны эсрэмтэй байна. Цалин урамшууллын хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус, мөн хариат бус гишүүн байна. Цалин урамшууллын хорооны хурал гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү хорооны хүсэлтээр оролцоно.	Цалин урамшууллын хорооны тухай ТУЗ-ийн дэргэдэх Хороодын журмын Дөрөвдүгээр бүлэгт оруулж өгсөн.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ  
 2023-09-06

СХХ  
 БҮРГЭГЭЭ  
 №11



		Үнэлгээний тайланд журмыг нь хавсаргав /ГУЗ-ийн тогтоолын Хавсралт 2/.
		Залгамж халааны бодлогын журам Үнэлгээний тайланд хавсаргав. /ГУЗ-ийн тогтоолын Хавсралт 6/.
10	2.4. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь үйл ажиллагааны журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна.	
11	2.5. Төлөөлөн удирдах зөвлөл нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулж болно. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод бусад үйл ажиллагааны журам, заавартай, чиг үүрэг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, ажлын туршлага бүхий бүрэлдэхүүнтэй байна. ГУРАВДУГААР ЗАРЧИМ. ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ	
12	3.1. Төлөөлөн удирдах зөвлөл нь санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	Мэдээллийн ил тод байдал, тайлагналын журам ирүүлэх Үнэлгээний тайланд хавсаргав. /ГУЗ-ийн тогтоолын Хавсралт 7/.
13	3.2. Төлөөлөн удирдах зөвлөл нь энэхүү кодекс заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэнэ.	2023 оны 1-р улиралд багтаан байршуулна
14	3.3. Санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал нь тэнцвэртэй, тодорхой, бодит байна. Санхүүгийн бус тайлан нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтууддаа хүрсэн эсэхийг үнэлсэн мэдээлэл байна.	2023 оны 2-р улиралд байршуулна
<b>ДӨРӨВДҮГЭЭР ЗАРЧИМ. АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО</b>		
15	Төлөөлөн удирдах зөвлөл нь аудит, хяналтын тогтоолцооны хараат бус, үр дүнтэй байдал, хангана 4.1. Төлөөлөн удирдах зөвлөл нь аудитын хорооны үйл ажиллагааны журамд хөндлөнгийн аудитортой харьцах, хөндлөнгийн аудиторыг хуульд заасан чиг үүрэгээ саагүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах талаар тусгаж, журмын хэрэгжилтэд хяналт тавина.	Аудитын хорооны тухай ГУЗ-ийн дэргэдэх Хороодын журмын 2-р бүлэгт орсон. Мөн Дотоод хяналт, аудитын журам, Хөндлөнгийн

		аудиторыг сонгох журамд заалтууд орсон. Үнэлгээний тайланд хавсаргав. /ГУЗ-ийн тогтоолын Хавсралт 3 болон Хавсралт 5/.		
16	4.2. Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг байна.	Дотоод хяналт, аудитын журам-ын 2.4.7, Хөндлөнгийн аудиторыг сонгох журамд 4-р бүлэгт заалтууд орсон.		2023.06.30-нд багтаж байршуулна
17	4.3. Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийн талаарх мэдээллийг компанийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлж тэдгээрт орсон өөрчлөлтийг тухай бүр мэдэгдэнэ.			
<b>ТАВДУГААР ЗАРЧИМ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА</b>				
Төлөөлөн удирдах зөвлөл нь эрсдэлийн удирдлага болон компанийн хяналтыг зохистой байдлаар, харааг бусаар зохнон байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавина				
18	5.1. Компани нь эрсдэлийн удирдлагын заавар болон бүтэцтэй байх ба эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн, хараат бус байдалд төлөөлөн удирдах зөвлөл хяналт тавина.			Эрсдэлийн удирдлагын журам Үнэлгээний тайланд хавсаргав. /ГУЗ-ийн тогтоолын Хавсралт 4/
19	5.2. Төлөөлөн удирдах зөвлөл нь дэргэдээ эрсдэлийн удирдлага харцуцан хороотой байхыг зорих ба уг хороо нь гурваас доошгүй тооны гишүүнтэй, дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг компанийн эсгийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж, тус хорооны хурлын ирц, хуралдсан асуудал, давтамжийн талаар тогтмол тайлагнана.			ГУЗ-ийн дэргэдэх Хороодын журмын 5-р бүлэгт тусгасан
20	5.3. Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн харуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэн нийтэд мэдээлж, тэдгээр эрсдэлийг хэрхэн удирдаж буйгаа тайлбарлана.			Байгаль орчин, нийгмийн харуцлага, эрүүл мэндийн чиглэлээр хийсэн ажлуудаа сайт дээр байнга байршуулж явдаг. Компанийн үйл ажиллагааны тайланд

			тусгаж, нийтэд мэдээлэг болно.
21	5.4. Компани нь компанийн хяналтын заавар болон бүтэцтэй байх ба компанийн хяналтын хэрэгжилтийн үр дүн, хариант бус байдалд төлөөлөн удирдах зөвлөл хяналт тавина.		Дотоод хяналт, аудитын журамд тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр журмын 2.5-д Компанийн хяналтын талаар орсон. Тусад нь заавар боловсруулна. /2023 оны 6 сар гэхэд хургуулэх/
	<b>ЗУРГААДУГААР ЗАРЧИМ. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ</b>		
	Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шуларга, ил төл байна		
22	6.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчийн хурлаар ил тод хэлэлцэж батална.		ТУЗ-ийн дэргэдэх Хороодын журмын 4-р бүлэгт заалтууд орсон.
23	6.2. Компани цалин, урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг цалин, урамшууллын бодлогын баримт бичигт тусгана.		ТУЗ-ийн дэргэдэх Хороодын журмын 4-р бүлэг, ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын 8-р бүлэгт заалтууд орсон.
24	6.3. Компанийн эслийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг тусгана.		ТУЗ-ийн дэргэдэх Хороодын журмын 4-р бүлэг Цалин урамшууллын хорооны чиг үүрэгт орсон
	<b>ДОЛООДУГААР ЗАРЧИМ. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ</b>		
	Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлнэ		
25	7.1. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичигтэй байна. Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.		Оролцогч талуудтай хамтран ажиллах жураг. Үнэлгээний тайланд журмыг нь хавсаргав /ТУЗ-ийн тогтоолын Хавсралт 8/.
26	7.2. Компанийн эслийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар тусгана.		Үйл ажиллагааны ил тод байдлыг хангах журам Үнэлгээний тайланд журмыг нь хавсаргав /ТУЗ-ийн тогтоолын Хавсралт 2/.



27	7.3. Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцах зорилгоор компанийн цахим хуудсыг үр дүнтэйгээр ажиллуулна.	2023 оны 6 сараас оруулж эхэлнэ
28	7.4. Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх дотоод журам, нийгмийн асуудлыг шийдэх, мэрэгжил дэмжлүүлэх дотоод журам, ажлын төлөвлөгөөтэй байна.	Ажлын төлөвлөгөөг ирүүлэх 2023 оын суртал хөгжлийн төлөвлөгөө арай батлагдаагүй байна 2023 оны 3-р сард хургуулэх//
<b>НАЙМДУГААР ЗАРЧИМ. КОМПАНИЙН СОЁЛ</b>		
Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд компанид бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажлалтуудад мөрдлөг болгоно		
29	8.1. Компанийн үнэт зүйлс, алсын харааг оновчтой тодорхойлж, хууль ёсны, ёс зүйтэй, харилцагатай үйл ажиллагаа явуулах зорилгоор төлөөлөн удирдах зөвлөл нь ёс зүйн дүрмийг батлан, нийтэд мэдээлж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	Ёс зүйн дүрэм Үнэлгээний тайланд дүрмийг нь хавсаргав /ГУЗ-ийн тогтоолын Хавсралт 13/.
30	8.2. Аливаа хууль бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг төлөөлөн удирдах зөвлөл, эсвэл түүний дэргэдэх холбогдох хороонд мэдээлэх “иүгэл үлээгчийн” тогтолцоотой байна.	Шүгэл үлээх журам Үнэлгээний тайланд журмыг нь хавсаргав /ГУЗ-ийн тогтоолын Хавсралт 12/.
31	8.3. Ёс зүйн дүрмээр авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих, /дэмжихгүй байх/ хандив өргөх /өргөхгүй байх/ талаар зохицуулна.	Шүгэл үлээх журамд заалтууд оруулсан
<b>ЕСДҮГЭЭР ЗАРЧИМ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ</b>		
Компани болон төлөөлөн удирдах зөвлөл нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана		
32	9.1. Компани хөрөнгө оруулагч болон бусад оролцогч талуудад зориулан өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, засаглалын зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа дамжуулан тухай бүр хүргэнэ.	2023 оны 03-р сарын 30-нд багтаж цахим хуудас сайтад мэдээлэл байршуулна
33	9.2. Компани хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөртэй байх ба хөрөнгө оруулагчидтай харилцах, мэдээлэл солилцох цахим сувгийг хөгжүүлнэ.	Ил тод байдлын журам болон оролцогч талуудтай хамтран ажиллах журмыг сайтад байршуулна, мөн



ХӨВЧЭЛЭГ  
 ХӨВЧЭЛЭГ  
 STOCK EXCHANGE  
 2023-04-06  
 БҮРТГЭВ-02

СЭХ  
 01 сар 01 өдөр  
 БҮРТГЭВ  
 № 01

			харилцах цахим сувгийн хөгжүүлэлт хийнэ.
34	9.3. Компани хувьцаа эзэмшигчдийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо, нөхцөлийг бүрдүүлнэ.		Хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлэх журам /ТУЗ-ийн тогтоолын Хавсралт 11/.
35	9.4. Компанийн үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн бүтэцтэй холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдийн санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь онцгойлон анхаарна.		Хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлэх журам /ТУЗ-ийн тогтоолын Хавсралт 11/.
36	9.5. Компани болон хувьцаа эзэмшигчдийн нийтлэг ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх зорилгоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамтай байх ба түүнийг хэрэгжилтийг нийтэд мэдээлнэ.		Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журам, Сонирхлын зөрчлийг зохицуулах журамтай болсон. /ТУЗ-ийн тогтоолын Хавсралт 9 болон Хавсралт 10/.

МОН УӨРӨНГИЙН БИРЖ  
MONGOLIAN STOCK EXCHANGE  
2023-04-06  
БҮРТГЭВ-02

СЗХ  
2023 он 02 сар 08 өдөр  
БҮРТГЭВ  
№ 1

**БЭРС ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК ХХК  
БА  
ГРЭЙПСИТИ МОНГОЛ ХХК  
ПРОГРАМ ХАНГАМЖ ТҮРЭЭСЭЭР  
АШИГЛАХ ГЭРЭЭ**

Дугаар: ЛА-23/ 16

Огноо: 2023 он 02 сар 08 өдөр

Товч нэр: POLARISRent\_BersPlus

Улаанбаатар хот



POLARISRent\_BersPlus төслийн гэрээ  
Бөрс Эн Би Эс Плас ТЗК ХХК ба ГрэйпСити Монгол ХХК

### Агуулга

1. НЭР ТОМЪЁО .....	2
2. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ .....	2
3. ГЭРЭЭГЭЭР ХИЙХ АЖИЛ .....	2
4. ТЕХНИКИЙН ШААРДЛАГА .....	3
5. ТӨСЛИЙН ҮЕ ШАТ БА ХУГАЦАА .....	3
6. ТӨСЛИЙН ХЯНАЛТ БА ХЭРЭГЖИЛТ .....	3
7. ГЭРЭЭНИЙ ҮНЭ .....	4
8. ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ .....	5
9. НЭВТРҮҮЛЭЛТИЙН ДАРААХ ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ .....	5
10. ТӨСЛИЙН БАГ .....	5
11. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА .....	6
12. ГСМ-Н ЭРХ, ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА .....	7
13. МЭДЭЭЛЛИЙН НУУЦЛАЛ .....	7
14. ОЮУНЫ ӨМЧ БА ЗОХИОГЧИЙН ЭРХ .....	8
15. ХЭВЛЭН НИЙТЛЭХ .....	8
16. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛС .....	9
17. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ БА МӨРДӨХ ХУУЛЬ .....	9
18. ГЭРЭЭГ ДУУСГАВАР БОЛГОХ, ЦУЦЛАХ .....	9
19. БУСАД ЗҮЙЛ .....	10

ГрэйпСити Монгол ХХК-ийн Бизнесийн газрын захирал:

С. Тулга

2023.04.06

2013-01-06

СХК  
БҮГДЭГ  
1991.04

ПОЛАРИС Pent\_BersPlus төслийн гэрээ  
Бэрс Эй Би Эс Плас ТЗК ХХК ба ГрэйпСити Монгол ХХК

Нэг талаас Монгол Улсын бүртгэлд 6949886 регистрийн дугаартай Сүхбаатар дүүрэг, 11-р хороо, 7-р хороолол, Ногоон нүүр, 101 барилга, 7 давхар, 706 тоот хаягт байрлах Бэрс Эй Би Эс Плас ТЗК ХХК (цаашид Захиалагч гэх)-г төлөөлж ТУЗ-ын дарга Б. Болор-Эрдэнэ,

Нөгөө талаас Монгол Улсын бүртгэлд 2598574 регистрийн дугаартай Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Оюутны гудамж-22 хаягт байрлах ГрэйпСити Монгол ХХК (цаашид ГСМ гэх)-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал Б. Мөнхцэцэг нар (цаашид хамтад нь Талууд гэх) дараах нөхцөлөөр харилцан тэхиролцож энэхүү гэрээг байгуулав.

### 1. Нэр томъёо

Систем гэдэгт гэрээний дагуу Захиалагчид түрээсээр ашиглах ГСМ-н өмчийн програм хангамжийн бүтээгдэхүүнийг ойлгоно.

Хэрэглэгч гэдэгт системд хандан ажиллах Захиалагчийн эрх бүхий ажилтан(ууд)-г авч үзнэ.

Баримт бичиг гэдэгт системтэй холбоотой Захиалагчид хүргэх хэвлэмэл болон цахим хэлбэртэй бүхий л баримт бичгийг авч үзнэ.

Төсөл гэдэгт Захиалагч нь системийг үйл ажиллагаандаа түрээсээр ашиглах нөхцөлийг хангахад шаардлагатай хэрэглэгчийн сургалт, хэрэглэгчийн туршилт, нэвтрүүлэлт болон ашиглалганд хүлээн авах ажлыг нийтэд нь ойлгоно.

**ПОЛАРИС суурь систем** нь Харилцагч, Харилцагчийн данс, Хугацаат хадгаламж, Барьцаа хөрөнгө, Зээл, Монголбанкны ЗМС руу мэдээлэл илгээх, Дотоодын данс, Балансын гадуурх данс, Ерөнхий дэвтэр, МОСТ платформын интерфэйс системүүдээс бүрдэнэ.

**Зээл худалдах систем** нь бичил санхүүгийн байгууллага өөрийн олгосон зээлээ Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргагч компанид худалдахтай холбоотой бүртгэл, тооцоолол болон гүйлгээг автоматжуулах зориулалттай.

### 2. Ерөнхий зүйл

ГСМ нь ПОЛАРИС суурь системтэй хоршин ажиллах Зээл худалдах системийг Захиалагчид түрээсээр ашиглуулах, тэдтэй холбогдон гарах нэвтрүүлэлтийн ажил, дагалдах засвар үйлчилгээг хүргэх болон мэдээллийн нүүцлэл, төлбөр тооцоотой холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү гэрээний зорилго оршино.

### 3. Гэрээгээр хийх ажил

ГСМ нь ПОЛАРИС суурь системтэй хоршин ажиллах Зээл худалдах системийг Захиалагчийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх төсөл хэрэгжүүлж, гэрээг дуусгавар болох хүртэл системийг түрээсээр ашиглуулна.

Зээл худалдах систем нь Захиалагч өөрийн олгосон зээлээ Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргагч компанид худалдахтай холбоотой бүртгэл, тооцоолол болон гүйлгээг автоматжуулах зориулалттай.

Систем дараах боломжтой. Үүнд:

- Худалдсан зээлийн үүрэг харилцаагчид үлдээх эсэхээс ханаарч үүрэгтэй эсвэл үүрэггүй худалдах боломжтой;
- Зээл худалдах үеийн төлөгдөөгүй хүүний авлагыг Захиалагчид үлдээх эсвэл худалдан авч буй байгууллагад шилжүүлэх боломжтой;
- Зээлийн багцыг одоо байгаа хүүгээр худалдах эсвэл өөр хүүгээр худалдах боломжтой ба хүүний маржин төвцсөлнө.

ГрэйпСити Монгол ХХК ийн Бизнесийн газрын Зөвлөл

С.Элсэг





PCI ARISRent\_BersPlus төслийн гэрээ  
Бүрс Эи Би Эс Илэс ТЭХ ХХК ба ГрэйпСити Монгол ХХК

Хэд хэдэн зээлийг багцлан худалдах болсонжтой бөгөөд дараах гүйлгээнүүд байна.  
Үүнд:

- Худалдсан багцаас зээл солих
- Худалдсан багцаас буцаан татах
- Худалдсан багцад зээл нэмэх
- Худалдсан зээлийн эргэн төлөлтийг хуваарилах

#### 4. Техникийн шаардлага

Зээл худалдах системийг ашиглах Захиалагчийн хэрэглэгчийн компьютерт тавигдах сүлжээ, интернетийн хурд болон хавсарга програм хангамжийн шаардлагыг Хүснэгт №1-т үзүүлэв.

Хүснэгт №1. Сүлжээ болон техникийн шаардлага

Сүлжээний хурдны шаардлага		
Name	Requirement	
Интернетийн хурд	Minimum	1Mbps
	Recommended	2Mbps
Компьютерт тавигдах техникийн болон програм хангамжийн шаардлага		
Requirement (Recommended)		
CPU	1GHz	
RAM	512MB	
DISK	4GB	
LAN Card	100Mbps LAN card	
Software	Google chrome browser 76. * or later	

#### 5. Төслийн үе шат ба хугацаа

5.1. Зээл худалдах систем нэвтрүүлэх төслийг 2023.02.13-ны өдрөөс эхлэн Хүснэгт №2-т тусгасан үе шатны дагуу ажлын 12 хоногийн дотор хэрэгжүүлнэ.

Хүснэгт №2. Төслийн төлөвлөгөө

Төслийн үе шат	Ажлын өдөр		
	1	10	1
<b>ГСМ-ын хийж гүйцэтгэх ажил</b>			
1 Сүргэлт			
2 Нэвтрүүлэх, тохируулга, параметр бүртгэх			
<b>Захиалагчийн хийж гүйцэтгэх ажил</b>			
3 Сүргэлт			
4 Нэвтрүүлэх, тохируулга, параметр бүртгэх			
5 Ашиглалтанд хүлээн авах			

Тайлбар:

- Нэвтрүүлэлтийн ажлыг онлайнаар хийнэ.
- Нэвтрүүлэлтийн ажлыг төлөвлөсөн хугацаанаас өмнө амжилттай хэрэгжүүлж болох ба энэ тохиолдолд үлдсэн хоногийг нөхөх шаардлагагүй болно.

#### 6. Төслийн хяналт ба хэрэгжилт

ГрэйпСити Монгол ХХК-ийн Билэгийн газрын захирал

С. Цэцэг

Ч.Элэн

4000000000

УЛАСЫН ХӨГӨӨНГӨЙН БИРХЖ  
 ИЛЧЛЭГЭЭНИЙ САРЫН ХУРААМЖ  
 2023-07-06  
 Бүртгэгч-2

СХХ  
 ӨН САР ӨЛН  
 БҮРТГЭВ  
 № 01

УХААНИЙ ДЭГЭЙЛЭС ТӨСЛИЙН ГЭРЭЭ  
 Өвөрхангай аймаг 17К ХХК-ий ГэрэлСити Монгол ХХК

- 6.1 Хүснэгт №2-т дурдсан ажил үзүүрүүс хүртэл Талуудын төслийн удирдагч нар долоо хоног бүрийн Дотоо гарагт төслийн гүйцэтгэлийн явцын тухай илтгэх хуудас бичиж, 10 дугаар заалт дахь гэрээний болон төслийн удирдагч нарт илгээгээр хүргүүлнэ. Илтгэх хуудсанд төслийн үе шатны ажил тус бүрийн гүйцэтгэлийг хувь (%) -нар зааж тэмдэглэсэн байх ба хэрэв төслийн ажил тогтоосон хугацаанд хэрэгжих боломжгүй бол учир шалтгааныг нь тусгана.
- 6.2 Шаардлагатай тохиолдолд аль нэг талын санаачилгаар хоёр талын уулзалт хийж, төслийн ажлын тулгамдсан асуудлуудыг хэлэлцэж, шийдвэр гаргана. Хэлэлцсэн асуудал, шийдвэрийг тэмдэглэсэн протокол үйлдэнэ.
- 6.3 Гэрээний болон төслийн удирдагч нарын шатанд шийдвэрлэх боломжгүй асуудал үүссэн тохиолдолд Талуудын удирдлагад асуудлыг тавина.

**7. Гэрээний үнэ**


Гэрээний үнийг Хүснэгт №3-т тусгав.

*Хүснэгт №3. Гэрээний үнэ*

Зориулалт	Лицензийн тоо хэмжээ	Нийт үнэ T
<b>А. Элсэлтийн хураамж /Зээлийн дансны тоо 1,000-с дээш/</b>		
Зээл худалдах систем	1 компани	15,000,000
Нэвтрүүлэх ажил		3,000,000
	Пилотын хөнгөлөлт-20%	(3,600,000)
	НВАТ - 10%	1,440,000
	<b>Элсэлтийн хураамжийн дүн:</b>	<b>15,840,000</b>
<b>В. Үйлчилгээний сарын хураамж /Активын хэмжээ 100 тэрбум хүртэл/</b>		
Зээл худалдах систем	1 компани	1,500,000
	Тусгай хөнгөлөлт(6 сар)-50%	(750,000)
	НВАТ - 10%	75,000
	<b>Үйлчилгээний сарын хураамжийн дүн:</b>	<b>825,000</b>

- 7.1 Элсэлтийн хураамж нь Захиалагчаас ГСМ-д нэг удаа төлөгдөх төлбөр бөгөөд системийг нэвтрүүлэх, нэвтрүүлэлтийн хүрээнд нэг удаад хийх сүргэлт, суурилуулалтын ажлын хөлс бүгд багтсан болно.
- 7.2 Үйлчилгээний сарын хураамж нь системийг ашиглах хугацаанд сар бүр тогтмол төлөх төлбөр бөгөөд үүнд систем, сервер тоног төхөөрөмжийн тасралтгүй хэвийн найдвартай ажиллагааг хангаж, мэдээллийн баазын арчилгааг хийх, систем ашиглалтын заавар зөвлөгөөгөөр хангаж ажиллах ГСМ-н ажлын хөлс бүгд багтсан болно.
  - 7.2.1 Хүснэгт №3(В)-д тусгасан үйлчилгээний сарын хураамжийг төслийг актаар хүлээн авсан өдрөөс хойш нөрдөж, сар бүрийн эхний 7 хоногт төлнө.
  - 7.2.2 Систем ашиглах явцад Захиалагчийн активын хэмжээ нэмэгдвэл активын ангиллын дагуу тухайн үед нөрдөж буй үнэ тарифыг мөрдлөг болгож үйлчилгээний сарын хураамжийг нэмэгдүүлнэ. Хүснэгт №3-т тусгасан үнэ тариф 2023.12.31-ний өдөр хүртэл хүчинтэй.
  - 7.2.3 Үйлчилгээний сарын хураамжид үзүүлж буй тусгай хөнгөлөлтийг системийг актаар хүлээн авсан өдрөөс эхлэн 5 сарын турш мөрдөх ба 7 дахь сараас эхлэн тухайн үед нөрдөж буй үнэ тарифыг баримтална.

ГэрэлСити Монгол ХХК-ийн Бирхжгийн гэрлийн захираалт  
 С.Түвшин  
 2023.07.06



FOIARISKent EatsPlus төслийн газар  
Борс Эй Би Эс Тээвэр ТЗК УХК ба ГрэйпСити Монгол УХК

7.2.4 Захиалагчийн хүсэлтээр системд нэмэлт өөрчлөлт оруулах бол ГСМ-той зөвшилцсөний үндсэн дээр үнэ төлбөртэйгээр хийж гүйцэтгэх ба тусдаа нэмэлт гэрээгээр зохицуулна. Энэхүү нэмэлт өөрчлөлт нь системийн аливаа бүртгэл, гүйлгээ гэх мэт суурь боломжийг хандэх функционал нэмэлт өөрчлөлт бол тухайн ажлын үнээс 4%-иар тооцсон дүнгээр үйлчилгээний сарын хураамжийг нэмэгдүүлнэ. Нэмэгдүүлэх хувь нь 2023.12.31-ний өдөр хүртэл хүчинтэй.

### 8. Төлбөрийн нөхцөл

Энэхүү гэрээний төлбөрийг дараах нөхцөлийг баримталж, ГСМ-н ирүүлсэн нэхэнжлэхийг үндэслэн Худалдаа Хөгжлийн Банкн дахь 453009869 тоот дансанд шилжүүлнэ. Үүнд:

- 8.1 **Элсэлтийн хураамжийн төлбөр:** Энэхүү гэрээг баталгаажуулсан даруйд элсэлтийн хураамжийн 50%, төсөл дуусч Талууд ажлыг актаар хүлээлцсэний дараа үлдэгдэл 50%-ийн төлбөрийг ажлын 3 хоногт багтаан тус тус төлнө.
- 8.2 **Үйлчилгээний сарын хураамжийн төлбөр:** Нэвтрүүлэлтийн ажил хийгдэж дуусмагц гэрээний Хүснэгт №3-т заасан үйлчилгээний сарын хураамжийн дүнг үндэслэн сар бүрийн эхний 7 хоногт багтаан төлнө.

### 9. Нэвтрүүлэлтийн дараах засвар үйлчилгээ

- 9.1. Нэвтрүүлэлтийн ажил хийгдэж дууссаны дараа үйлчилгээний сарын хураамжийг тасралтгүй төлсөн нөхцөлд ГСМ-н харилцагчийн үйлчилгээний газар Захиалагчийн санал, гомдлыг тогтмол хүлээн авч, системийн шинэчлэлт сайжруулалтыг хийх, мэдээллийн баазын арчилгааг хийх, заавар зөвлөгөө өгөх, алдаа засах үйлчилгээг үзүүлнэ.
- 9.2. Үйлчилгээний сарын хураамжийг тасралтгүй төлсөн 13 дахь сараас эхлэн дараах томъёоллын дагуу жил тутам үнийн тохируулга хийж, ҮСХ-ийн дүнг шинэчилж тооцно.

Тухайн жилийн мөрдөх ҮСХ = Өмнөх жилийн ҮСХ + Өмнөх жилийн ҮСХ + Тохируулах хувь

Тохируулах хувь	Тухайн жилийн инфляци / Монголбанкны албан мэдээг баримтална /
0%	1-ээс бага
5%	1 = < 10
10%	10 = < 15
12%	15 болон түүнээс их

### 10. Төслийн баг

#### Захиалагчийн төслийн баг:

Гэрээний болон төслийн удирдагч: СБГ захирал Я. Адъяахүү  
Төслийн багийн гишүүд: Хөгжүүлэлтийн инженер О. Батжаргал  
Нягтлан бодогч Д. Урангоо

#### ГСМ-н төслийн баг:

Гэрээний удирдагч: Маркетинг, борлуулалтын менежер А. Анармөрөн  
Төслийн удирдагч: Конфигурэйшн менежер Б. Батцогт  
Төслийн багийн гишүүд: Байгууллага хариуцсан зөвлөх Б. Энхтуяа

ГрэйпСити Монгол УХК-ийн Боловсрол гэрээний захирагч

Г. Түвшин



ЭБСАНСИОНТ / Securities таслийн гэрээ  
Бүртгэсэн / Registered / 158 ХХК ба ТрайлСити Монгол ХХК

#### 11. Захиалагчийн эрх, үүрэг, хариуцлага


- 11.1 Системийг ажиллуулах сөрөөр, тоног төхөөрөмж, мэдээллийн баазын арчилгаа, систем ашиглах заавар зөвлөмж, зөвлөгөө авах болон түүний арчилгааг ГСМ-с шаардах эрхтэй.
- 11.2 Захиалагч нь системд гарсан алдааг засахыг ГСМ-с шаардах эрхтэй.
- 11.3 Захиалагчийн системийг түрээсээр ашиглах эрх нь гэрээ дуусгавар болох хүртэл хүчинтэй ба энэхүү эрхийг 3-дагч этгээдэд үл шилжүүлэх болон дамжуулахгүй байх үүрэг хүлээнэ.
- 11.4 Захиалагч нь системийн лицензийг худалдаж авах эрхтэй бөгөөд энэхүү эрхийн хүрээнд үүсэх харилцааг тусад нь програм хангамж нийлүүлэх гэрээгээр зохицуулна.
- 11.6 Захиалагч нь гэрээний төлбөрийг 8-р зүйлд заасны дагуу цаг тухайд нь төлөх үүрэгтэй.
- 11.7 Гэрээний 12.2-р зүйлд заасны дагуу систем зогсож, Захиалагч нь систем үргэлжлүүлэн ашиглах тохиолдолд ашиглаагүй хугацааны төлбөрийг нөхөж төлөхөөс гадна, гэрээний 11.17-р зүйлд заасны дагуу торгууль төлнө.
- 11.8 Захиалагч нь Хүснэгт №2-т тусгасан сургалт үе шатны ажил хийгдсэний дараа ГСМ-д нэгэнт төлсөн төлбөрийг буцаан шаардах, гэрээгээр тохирсон төлбөрийн хэмжээг бууруулах болон төлбөрийн нөхцөлийг зөрчих эрхгүй.
- 11.9 Захиалагч нь Хүснэгт №2-т тусгасан сургалт үе шатанд холбогдох ажилтнуудаа бүрэн хамруулаагүйн улмаас нэвтрүүлэлтийн ажил үргэлжлэх болонжгүй болох тохиолдолд талуудын хоорондын гэрээг 18.2.4-р зүйлд заасан нөхцөлөөр цуцална. Дахин сургалтанд хамрагдаж, нэвтрүүлэлт хийх тохиолдолд талууд гэрээг шинэчлэн байгуулна. Захиалагчийн зохих ажилтнууд сургалтанд бүрэн хамрагдсан эсэхийг ГСМ-н сургагч багш нар ирцийн бүртгэлээр баталгаажуулна.
- 11.10 Захиалагч нь Хүснэгт №2-т тусгасан сургалт үе шатанд холбогдох ажилтнуудаа бүрэн хамруулаагүй, сургалтанд хамрагдсан ажилтан ажлаас чөлөөлөгдсөний улмаас ашиглалтын үед гарах аливаа асуудлыг ГСМ хариуцахгүй бөгөөд дахин сургалтанд хамрагдах шаардлага гарвал ГСМ нь сургалтыг төлбөртэй хийж гүйцэтгэнэ.
- 11.11 Системийг ашиглахтай холбогдсон хаасарга програм хангамж (Microsoft office, Adobe PDF)-ийн ашиглах эрхийн лицензийг албан ёсны эрх бүхий байгууллагаас хүлээн авах буюу худалдан авсан байх үүрэгтэй. Энэхүү шаардлагыг хангаагүй шалтгааны улмаас гэрээгээр ашиглуулж буй системд илэрсэн доголдол, гэмтэл саатлыг ГСМ хариуцахгүй.
- 11.12 Төсөл эхлэхээс өмнө гэрээний 4-р зүйлд тусгасан хэрэглэгчийн компьютерт тавигдах техник хангамжийг бэлэн болгоно.
- 11.13 Захиалагч нь Хүснэгт №2-т тусгасан "Нэвтрүүлэх ба ашиглалтанд хүлээн авах" шатны ажлуудыг заасан хугацаанд ГСМ-н тусламжтай хийж гүйцэтгэх үүрэгтэй.
- 11.14 Захиалагч нь Хүснэгт №2-т заасан хугацаанд системийг ашиглалтанд хүлээн авах үүрэгтэй ба энэ тухай хамтарсан акт үйлдэж, төслийг хаана. Хэрэв ГСМ нь системийг нэвтрүүлж дууссаны дараа Хүснэгт №2-т тусгасан "Нэвтрүүлэлт", "Ашиглалтанд хүлээн авах" шатны ажил Захиалагчаас ханааран ажлын 10 хоногоос хэтэрсэн тохиолдолд системийг хүлээн авсанд тооцож, элсэлтийн хураамжийн үлдэгдэл төлбөрийг төлж барагдуулах үүрэгтэй.
- 11.15 Системийг ашиглалтанд хүлээн авснаас хойш Захиалагч нь бусад салбар, нэгжүүдэд нэвтрүүлэх болон сургалт хийх ажлыг бие даан гүйцэтгэх үүрэгтэй бөгөөд хэрэв ГСМ-с тусламжаа авах бол ГСМ-той зөвшилцсөний үндсэн дээр үнэ төлбөртэй хийж гүйцэтгэх ба тусдаа төслөөр шийдвэрлэнэ.
- 11.16 Захиалагч нь үйлчилгээ авах хүсэлтээ ГСМ-д тавих ба хариу мэдээллийг ГСМ-д хурдан шуурхай өгөх үүрэгтэй.

ТрайлСити Монгол ХХК-ийн Бизнесийн гэрээний захирал:

С. Ганзориг

Хүснэгт 10





PCIA RTB Kent, BancPlus төслийн гэрэл  
Бэрх Зай Бн Эс Плюс ТБХ ХХК ба ГрэйпСити Монгол ХХК

11.17 Захиалагч нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутанд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.1 хувийн алдангийг нөгөө талдаа төлнө. Энэхүү дүн нь гэрээний нийт үнийн дүнгийн тав (5)-н хувиас хэтрэхгүй байна.

## 12. ГСМ-н эрх, үүрэг, хариуцлага

- 12.1 ГСМ нь Захиалагчаас төлбөрөө хугацаанд төлж барагдуулахыг шаардах эрхтэй.
- 12.2 Захиалагч нь үйлчилгээний сарын хураамжийг гэрээний 8.2-р зүйлд заасны дагуу төлөлгүй хуанлийн 5 хоног хэтэрсэн тохиолдолд ГСМ нь Захиалагчид систем ашиглалтыг зогсоох тухай мэдэгдэнэ. Энэхүү мэдэгдлийн дагуу Захиалагч нь төлбөр барагдуулалгүй 5 хоног болсон тохиолдолд ГСМ нь систем ашиглалтыг зогсоох эрхтэй ба үүнтэй холбоотой гарсан аливаа асуудлыг ГСМ хариуцахгүй болно.
- 12.3 ГСМ нь ПОЛАРИС системийн тусламжтай Захиалагч нь активын аль ангилалд хамаарахыг тодорхойлох эрхтэй.
- 12.4 ГСМ нь Зээлийн худалдах системийн үнэ тарифыг өөрчлөх эрхтэй.
- 12.5 ГСМ нь Захиалагчаас төслийн ажлыг хугацаанд нь хийж гүйцэтгэхийг сануулах болон шаардах эрхтэй.
- 12.6 Энэхүү гэрээний 3-р зүйлд дурдсан системийг ажиллуулах сервер, тоног төхөөрөмж, мэдээллийн баазын арчилгаа, систем ашиглах заавар зөвлөмж, зөвлөгөө өгөх болон түүний арчилгааг ГСМ хариуцаж ажиллах үүрэгтэй.
- 12.7 Системийг нэвтрүүлснээс хойшхи түүний тасралтгүй, найдвартай, аюулгүй ажиллагааг ханган ажиллах үүрэгтэй.
- 12.8 ГСМ нь системд хийгдсэн шинэчлэлт сайжруулалтыг суурилуулахдаа системийг зогсоох шаардлага үүсвэл Захиалагчид урьдчилж мэдэгдэх үүрэгтэй.
- 12.9 Хүснэгт №2-т тусгасан "Нэвтрүүлэлт, Ашиглалтанд хүлээн авах" шатны хүрээнд ГСМ нь онлайнгаар систем нэвтрүүлэх ажлыг хийж гүйцэтгэх үүрэгтэй.
  - 12.9.1 Нэвтрүүлэх ба ашиглалтанд хүлээн авах – Системийг Хүснэгт №2-т заасан хугацаанд багтаан нэвтрүүлэх ба энэ хугацаанд системийн ажиллагаа бүрэн зүгшрэх бололцоотой юм. Системийг бодит орчинд нэвтрүүлсний дараа ашиглалтанд хүлээлгэн өгсөн буюу авсан тухай хантарсан акт үйлдэж, төслийг хаана.
- 12.10 ГСМ нь гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу Захиалагчаас тавьсан хүсэлтийг хурдан шуурхай шийдвэрлэж, шаардлагатай бол хэрэгжилтийг тайлагнах үүрэгтэй.
- 12.11 ГСМ нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутанд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.1 хувийн алдангийг нөгөө талдаа төлнө. Энэхүү дүн нь гэрээний нийт үнийн дүнгийн тав (5)-н хувиас хэтрэхгүй байна.


## 13. Мэдээллийн нүүцлал

- 13.1 Талууд хамтын ажиллагааны хүрээнд хийсэн аливаа зөвшилцөл болон хэлэлцээрийн явцад шууд болон шууд бусаар талуудын бие биенээсээ олж авсан мэдээлэл нүүцэн зэрэглэлтэй бөгөөд үүнд Захиалагчийн мэдээллийн бааз дахь өгөгдөл, оюуны өмчид хамаарах бүхий л мэдээлэл, програм хангамж, технологи ба нөү-хау(know-how), талуудын болон тэдгээрийн бэлтгэн нийлүүлэгч, бүтээгдэхүүн үйлчилгээ болон салбар компанитай холбоотой арилжааны болон бизнесийн мэдээллүүдийг багтааж үзэх ба эдгээрт бүх төрлийн судалгаа, бүтээгдэхүүн, үйлчилгээ, систем, сервер, серверийн байршил, портын дугаар, данжуулж байгаа протокол, хөгжүүлэлт, нээлт, үйл явц, алгоритм, техникийн даалгавар, модуль, програм хангамжийн дизайн, тоног төхөөрөмж, бүтээгдэхүүний демо, шинжилгээ,

ГрэйпСити Монгол ХХК-ийн Санхүүгийн газрын захирал

С. Галс

Хуульч Т.Оч



GLOBALSCREENT, BaitPlus төслийн гэрээ  
Нэгдсэн Байр Олос PLC ХХК ба ГрийнСити Монгол ХХК

- компьютерийн програм, бичлэг, өгөгдөл, техник аргачлал, тэмдэглэл, схем зураг, инженерийн, маркетингийн, харилцагчийн, санхүүгийн болон үнийн мэдээлэл, төсөл төлөвлөгөө зэрэг өгөгдөл, мэдээллүүд орох ба үүгээр хязгаарлагдахгүй.
- 13.2 Талууд нөгөө талын албан ёсны зөвшөөрөлгүйгээр гэрээний 13.1-т дурдсан зүйлсийг бусдад задруулахгүй байх үүргийг харилцан хугацаагүйгээр хүлээнэ.
  - 13.3 ГСМ нь Төр засгийн болон хууль хяналтын байгууллагын шаардлагаар мэдээллийг дэлгэх үүрэг хариуцлагаас зайлсхийх боломжгүй бөгөөд энэхүү шалтгааны улмаас нууц мэдээллийг дэлгэх зайлшгүй шаардлага үүсвэл Захиалагчийн эрхийг хамгаалах үүрэгтэй холбоотойгоор дараах шат дараатай арга хэмжээг авч, ажиллана. Үүнд:
    - 13.3.1 Тухайн хууль хяналтын байгууллагад мэдээллийн нууцлалыг хангах зайлшгүй нөхцөл байдлыг тайлбарлаж, ойлгуулах;
    - 13.3.2 Хууль хяналтын байгууллагаас нууцад хамаарах мэдээллийг дэлгэх тухай хүсэлт, захирамж, тушаал зэргийг хүлээн авсан даруйд Захиалагчид мэдэгдэх, мэдээлэх;
    - 13.3.3 Хуулийн дагуу, тушаал захирамжаар шаардлагатай мэдээллийг өгөх;
- 14. Оюуны өмч ба зохиогчийн эрх**
- 14.1 Гэрээний 3-р зүйлд дурдсан систем нь ГСМ-н өмч байх ба ПХ-н зохиогчийн эрх нь түүнд хамааралтай барааны тэмдэг болон нууцлалын адил мөн ГСМ-н өмч байна.
  - 14.2 Захиалагч нь системийг гэрээнд зааснаас бусад зорилгоор ашиглах, хуулбарлахгүй байх, ГСМ-н эрхийг хангах зорилгоор системийг хамгаалах үүрэгтэй ба өөрийн ажилтнуудын дунд эдгээр үүргийг чандлан сахих тал дээр анхаарч ажиллана.
  - 14.3 Гэрээний 3-р зүйлд дурдсан системтэй холбоотой бүхий л мэдээлэл нь арилжааны нууцад хамаарах ба ГСМ-н өмч байна. ГСМ нь системийн ашиглалтыг дэмжих зорилгоор Захиалагчид тэрхүү нууц мэдээллийг ашиглах эрхийг олгож байгаа ба мэдээллийг бусдад дамжуулахыг хориглоно. Захиалагч нь нууц мэдээллийг хадгалах, хамгаалах болон гэрээний 13-р зүйлд заасан "Мэдээллийн нууцлал"-ыг хангах үүргийг хүлээнэ. Мөн нууц мэдээллийг хувилах, засварлах, зориулалтын бусаар ашиглах, мэдээлэлд заасан зүйлийг зөрчихийг түс түс хориглоно.
  - 14.4 ГСМ нь гэрээгээр Захиалагчид системийг дагалдуулж түүнийг өмчлөх, эзэмших эрхийг олгоогүй, шилжүүлээгүй болно. Захиалагч нь гэрээний дагуу ашиглаж буй систем болон дагалдах баримт бичигт тусгасан зохиогчийн эрхийн лого, барааны тэмдэг, тэмдэглэгээг байгаа зориулалтаар нь ашиглах ба хасах, устгахыг хориглоно.
  - 14.5 Захиалагч нь ГСМ-н зөвшөөрөлгүйгээр системийг болон түүний аль нэг бүрэлдэхүүн хэсгийг дараах зориулалтаар авч ашиглахыг хориглоно. Үүнд:
    - 14.5.1 Гэрээнд зааснаас бусад зорилгоор систем болон дагалдах баримт бичгийг ашиглах болон ашиглахыг зөвшөөрөх;
    - 14.5.2 Систем болон дагалдах баримт бичгийг аливаа нэгэн гуравдагч этгээдэд дамжуулах, нийлүүлэх, худалдах, шилжүүлэх болон тээвэрлэх;
    - 14.5.3 Системийг засварлах болон хөрвүүлэх буюу өөр хэлбэрт хувиргах;
    - 14.5.4 Систем болон дагалдах баримт бичгийг нөөцлөх зориулалтаар олшруулах.
- 15. Хэвлэн нийтлэх**
- Захиалагч нь системийн зэрэглэгчийн хувилар ГСМ-д дараах нөхцөл бололцоогоор ханган, тусламжаа үзүүлж болно. Үүнд:

ГрийнСити Монгол ХХК-ийн Бүтээлийн газрын захирал:  
С. Туга 



POLARISRent\_BasisPlus төсвийн гэрээ  
Баяж 88 8н 3с Плас ТЭХ ХХК ба ГрейпСити Монгол ХХК

- 15.1 ГСМ-д Захиалагчийн нэрийг системийн хэрэглэгчийн жагсаалтад тусган өөрийн вэбсайт болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтлэхийг зөвшөөрөх;
- 15.2 Захиалагчийг 3-дагч этгээдэд системийн хэрэглэгч байдлаар танилцуулах, Захиалагчийн системийн ашиглалтын талаар лавлах боломжтой ажилтны холбоо барих мэдээллийг өгөх, мөн системийг сонирхогч этгээдэд Захиалагчийн ажлын байранд урьдчилж хүсэлт тавьсны үндсэн дээр цаг тохирон, системийн ашиглалтын байдалтай танилцах боломжоор хангах;
- 15.3 Хэрэв татгалзахгүй бол Захиалагч нь системийг ашиглагчийн хувиар ГСМ-н нэр, логог өөрийн вэбсайтад байршуулах.

**16. Давагдашгүй хүчин зүйлс**

- 16.1 Давагдашгүй хүчин зүйл гэдэгт хоёр талын урьдаас таамаглаагүй, мэдээгүй бөгөөд түүнийг шийдвэрлэхэд нэн бэрхшээлтэй нөхцөл байдлыг ойлгож үзнэ. Давагдашгүй хүчин зүйлд байгалийн гай гамшиг, дайн байлдаан, Засгийн газрын тогтоол, журам, нийгмийн зөрчил мөргөлдөөн, дайралт халдлага орох ба эдгээр зүйлээр хязгаарлагдахгүй байна. Аль ч тал нь нөгөө талаасаа ямар нэгэн хэлбэрээр гарсан давагдашгүй хүчин зүйлээс шалтгаалж үүргээ биелүүлэхэд учирсан саадтай холбоотойгоор алданги, торгууль шаардах эрхгүй.
- 16.2 Давагдашгүй хүчин зүйлд өртсөн аль нэг тал нөгөө талдаа хуанлийн долоо (7) хоногийн дотор үүссэн нөхцөл байдал, хэвийн байдалд ороход шаардагдах хугацааны талаар бичгээр мэдэгдэнэ. Давагдашгүй хүчин зүйл үүссэн хугацаанд тухайн талын гэрээгээр хүлээсэн үүргийг зогсоох ба энэхүү хугацаагаар гэрээг сунгана.
- 16.3 Давагдашгүй хүчин зүйл үүссэн тохиолдолд тухайн орны Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаас нотолсон баримтыг гаргуулж авна.

**17. Маргаан шийдвэрлэх ба мөрдөх хууль**

- 17.1 Энэхүү гэрээг хэрэгжүүлэх явцад гарах аливаа санал зөрөлдөөн, маргааныг Талууд юуны түрүүнд зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.
- 17.2 Хэрэв талууд гуч (30) хоногийн дотор гарсан маргаан, зөрөлдөөнийг шийдвэрлэж чадахгүй бол Монгол Улсад мөрдөж буй хууль тогтоомжийн дагуу холбогдох шүүхээр шийдвэрлүүлнэ.

**18. Гэрээг дуусгавар болгох, цуцлах**


- 18.1 Гэрээ нь Талуудын бүрэн эрхт төлөөлөгчид гарын үсэг зурж, баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 18.2 Гэрээг дараах нөхцөл байдал үүссэн тохиолдолд Талуудын аль нэг нь нөгөө талдаа бичгээр хүсэлт гаргасны үндсэн дээр цуцалж, дуусгавар болгоно.
  - 18.2.1 Захиалагчаас системийн ашиглалтыг зогсоох хүсэлт гаргасан тохиолдолд;
  - 18.2.2 Аль нэг тал үүргээ ноцтой зөрчсөн, эсвэл аль нэг тал дампуурсан, татан буугдсан, төлбөрийн чадваргүй болсон тохиолдолд;
  - 18.2.3 Захиалагч нь гэрээний 12.2-р зүйлд заасны дагуу системийг зогсоосноос хойш төлбөр төлөхгүй хуанлийн 45 хоног болсон тохиолдолд;
  - 18.2.4 Захиалагч нь хариуцсан ажлаа заасан хугацаанд хийж гүйцэтгээгүй тохиолдолд гэрээг цуцална. Ийнхүү гэрээг цуцлах тохиолдолд Захиалагчаас төлсөн төлбөрийг буцаан олгохгүй болно.

ГрейпСити Монгол ХХК-ийн бичиг баримтын гэрээг захиаралт

С.Түвшин

Бүртгэгч

Хуудал 1/150




REGISTRATION\_VentPlus тослийн гэрээ  
Бэрс Эй Би Эс Плас ТЭХ ХХК ба ГрэйпСити Монгол ХХК

- 18.3 Уг гэрээ нь дуусгавар болон/эсвэл захиалагч нь системийн түрээсийн ашиглалтыг нэн даруй зогсооно. Системийн ашиглалт зогсоход:
  - 18.3.1 Захиалагч нь системийн дагалдах баримт бичгүүдийг (хуулбаруудын хант) ГСМ-д буцаан өгөх ба буцаан өгсөн тухайгаа бичгээр баримтжуулна.
  - 18.3.2 Захиалагч нь гэрээ дуусгавар болох хүртэлх үйлчилгээний сарын хураангжийг бүрэн төлж барагдуулна.
- 19. **Бусад зүйл**
  - 19.1 Энэхүү гэрээ нь талуудын толгой болон охин компаниуд эсвэл салбар компанид үл хамаарна.
  - 19.2 Гэрээ дуусгавар болох хүртэл аль нэг талд Талуудын урьдчилан таамаглаагүй бөгөөд гэрээний хэрэгжилт, гэрээний үнэд нөлөөлөхүйц асуудал, бэрхшээл тулгарвал энэ тухай нөгөө талдаа бичгээр мэдэгдэж, талууд асуудлыг шийдвэрлэх тал дээр хамтарч ажиллана. Урьдчилан таамаглаагүй нөхцөл байдлыг шийдвэрлэхдээ талуудын төлөөлөл үүссэн нөхцөл байдлыг судалж үзээд харилцан тохиролцож, хэрэв шаардлагатай гэж үзвэл гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэнэ.
  - 19.3 Талууд гэрээний хүчинтэй хугацаанд болон гэрээ дуусгавар болсноос хойш 1 жилийн хугацаанд нөгөө талд ажиллаж буй ажилтныг өөрийн үндсэн ажилтнаар, түр буюу гэрээт ажилтнаар ажиллуулахгүй бөгөөд бусад аливаа ажил үйлчилгээг гүйцэтгүүлэхгүй байна.
  - 19.4 Алданги төлсөн нь үүргээ биелүүлээгүйгээс нөгөө талдаа бодитой учирсан хохирол, зардлаас чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.
  - 19.5 Энэхүү гэрээг хоёр (2) хувь үйлдэж, талууд тус бүр нэг хувийг хадгалсан нь хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.
  - 19.6 Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах болон Гэрээтэй холбоотой аливаа мэдэгдэл, санал, хүсэлт, гомдол, шаардлагыг нөгөө талдаа хуанлийн долоо (7)-с доошгүй хоногийн өмнө бичгээр мэдэгдэнэ.

**БАТЛАВ.**

Захиалагчийг төлөөлж:  
Бэрс Эй Би Эс Плас ТЭХ ХХК-ийн  
ТУЗ-ийн дарга  
Э.Б.Б. ЭС  
П.Л.С  
Б. Болор-Эрдэнэ



ГСМ-г төлөөлж:  
ГрэйпСити Монгол ХХК-ийн  
Гүйцэтгэх захирал  
Г.МОНГОЛ  
МОНГОЛ  
Б. Мөнхцэцэг




ГрэйпСити Монгол ХХК-ийн Баталсан/Гэрээний доош талд  
Г. Мөнхцэцэг





МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ  
MONGOLIAN STOCK EXCHANGE  
[ 2023-04-06 ]  
БҮРТГЭВ-02

СЗХ  
2023.04.06 өдөр  
БҮРТГЭВ  
№ 01




**Бэрс Эй Би Эс Плас ТЗК ХХК-ийн нэмэлт баримт бичиг**



- 1.4.4. “Зээлийн эргэн төлөлт” гэж ТЗК-ийн гаргасан ХБҮЦ-ны хөрөнгийн багцад багтсан Зээлийн төлөлт-буюу Зээлдэгчээс Зээлийн гэрээний дагуу Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид төлөх мөнгөн төлбөрийг;
- 1.4.5. “Зээлийн данс бүртгэл” гэж Зээлдэгч тус бүрийн Зээлийн эргэн төлөлт, үлдэгдэл, хүү, нэмэгдүүлсэн хүүг тооцоолж, эргэн төлөлтийг хугацаатай нь бүртгэсэн мэдээллийг;
- 1.4.6. “Төлбөр цуглуулах данс” гэж ТЗК-ийн Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх журмын 2.2.1-д заасан бөгөөд цуглуулсан төлбөрийг хүлээн авах Голомт банканд нээсэн 3305138149 тоот дансыг;
- 1.4.7. “Багцын эргэн төлөлт” гэж Үйлчилгээ үзүүлэгчээс ТЗК-д Үйлчилгээ үзүүлэх тухай гэрээний дагуу шилжүүлж буй Зээлийн эргэн төлөлтийг;
- 1.4.8. “Үнэт цаас эзэмшигч” гэж Компанийн гаргасан ХБҮЦ-ыг худалдан авч, эзэмшиж буй этгээдийг;
- 1.4.9. “Хөрөнгө” гэж Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх хэсэгт заасныг буюу ТЗК-ийн гаргах ХБҮЦ-ны хөрөнгийн багцад багтсан зээлийг.

### ХОЁР. ҮНЭТ ЦААСНЫ ТӨЛБӨР ЦУГЛУУЛАХ АЖИЛЛАГАА

- 2.1. Төлбөр цуглуулах үйл ажиллагаа нь төлбөр буюу Зээлийн эргэн төлөлтийг цуглуулах, ТЗК-д Багцын эргэн төлөлтийг шилжүүлэх гэсэн 2 үе шаттай байна.
- 2.2. Багцын эргэн төлөлтийг цуглуулахдаа Зээлийн эргэн төлөлтийн графикийг үндэслэх бөгөөд Үйлчилгээ үзүүлэгч нь ТЗК-д энэхүү гэрээ хүчин төгөлдөр болсон өдөр багц дахь зээлүүдийн эргэн төлөлтийн хуваарийг гаргаж өгнө.
- 2.3. Үйлчилгээ үзүүлэгч нь ТЗК-ийн хөрөнгийн багцыг бүрдүүлж буй Зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийн эргэн төлөлтийг өөрийн харилцах данс буюу Зээлийн эргэн төлөлтийн дансанд цуглуулна. Үйлчилгээ үзүүлэгч нь хуримтлагдсан Зээлийн эргэн төлөлт болох Багцын эргэн төлөлтийг дараа сарын 25-ны өдрийн дотор Төлбөр цуглуулах дансанд шилжүүлнэ. Хэрэв Багцын эргэн төлөлтийг шилжүүлэх өдөр нь амралтын өдөр таарвал дараагийн ажлын өдрийн дотор шилжүүлнэ.
- 2.4. Зээлийн эргэн төлөлтийн данс, түүний мөнгөн хөрөнгийг Үнэт цаас гаргагч, Хөрөнгө итгэмжлэн удирдагчид бие даасан гэрээний дагуу барьцаалуулна.
- 2.5. Үйлчилгээ үзүүлэгч нь багцын эргэн төлбөрийг шилжүүлэхдээ гэрээний 3.2-д заасны дагуу үйлчилгээний хөлсийг хасаж тооцож, төлбөрийг шилжүүлэх ба ТЗК-ийн Хөрөнгө итгэмжлэн удирдах журмын 2.4.1-д заасан үндэслэлээр анхны үүрэг гүйцэтгүүлэгч хөрөнгийн багцыг хуулийн шаардлагад нийцүүлэн нэмэгдүүлж, авлага үүсгэсэн тохиолдолд уг төлбөрийг хасаж, үлдэгдлийг тооцон дараа сарын төлбөрт шилжүүлнэ.
- 2.6. Гэрээний 2.4-д заасны дагуу шилжүүлэг хийхэд Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль болон ТЗК-ийн Хөрөнгө итгэмжлэн удирдах журмыг баримтална.
- 2.7. Үйлчилгээ үзүүлэгч нь шилжүүлсэн Багцын эргэн төлөлтийг тооцоолсон Зээлийн данс бүртгэлийг тухай бүр хөтөлж, зээлийн болон төлбөрийн мэдээллийг дараагийн ажлын 3 хоногт багтаан ТЗК болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчид хүргүүлнэ.
- 2.8. Холбогдох данс, бүртгэлд зөрүү гарсан бол зөрүүг илрүүлсэн өдрөөс хойш ажлын 1 өдрийн дотор Үйлчилгээ үзүүлэгч нь Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай тооцоо нийлж, алдааг засах арга хэмжээ авна.
- 2.9. Үйлчилгээ үзүүлэгч нь зээлийн данс бүртгэлийн тайланг сар бүрийн сүүлд нэгтгэн гаргаж, сар эхэлснээс хойш ажлын 3 өдрийн дотор Үнэт цаас гаргагч болон хөрөнгө итгэмжлэн удирдагчид

2023-04-06

хүргүүлнэ.

БҮРТГЭВ-02

СЭХ  
ОНГОЛЫН САР, ЭДЭР  
БҮРТГЭВ  
№-01

2.10. Үйлчилгээ үзүүлэгч нь ТЗК болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай харилцах албан тушаалтныг томилон ажиллуулна.

2.11. Хөрөнгийн багцтай холбоотой баримт бичиг, мэдээллийг Үйлчилгээ үзүүлэгч хадгална.

2.12. Үйлчилгээ үзүүлэгч нь Зээлүүдтэй холбоотой мэдээллийг хадгалах программ хангамжтай байна.

2.13. ТЗК нь дараах чиг үүрэгтэй байна. Үүнд:

2.13.1. ТЗК нь Төлбөр цуглуулах дансыг харилцагч банкинд нээлгэж, Багцын эргэн төлөлтийг хүлээн авахтай холбоотой бэлтгэл ажлыг хангах;

2.13.2. Үйлчилгээ үзүүлэгчтэй байгуулсан гэрээний дагуу Багцын эргэн төлөлтийг хүлээн авах;

2.13.3. Энэхүү гэрээний 3.1-д заасан үйлчилгээний хөлсийг төлөх;

2.13.4. Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай байгуулсан гэрээний үндсэн дээр түүгээр дамжуулан Үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаанд хяналт тавих болон үйл ажиллагааны нөхцөлийг бичгээр зааварчлан чиглүүлэх чиг үүрэгтэйгээр оролцох;

2.13.5. Хууль тогтоомжид заасан бусад.

2.14. Үйлчилгээ үзүүлэгч нь дараах чиг үүрэгтэй байна. Үүнд:

2.14.1. Үйлчилгээ үзүүлэгч нь энэхүү гэрээний нөхцөл болон ТЗК, эсхүл Хөрөнгө итгэмжлэн удирдагчаас түүнд бичгээр өгсөн зааварчилгаанд дурдсан нөхцөлийн дагуу үйлчилгээг үзүүлнэ;

2.14.2. Үйлчилгээ үзүүлэгч нь хөрөнгийн багцад багтсан зээлийн Зээлдэгч, үүрэг гүйцэтгэгч нартай харилцах, төлбөр цуглуулах, зээл төлүүлэх арга хэмжээг өөрийн холбогдох Зээлийн эрсдэлийг удирдах журамд заасны дагуу хэрэгжүүлэх, зээлдэгчийн өмнө ТЗК-г төлөөлж, зээлийн эргэн төлөлтийг гэрээнд заасан хугацаанд ТЗК-д шилжүүлэх, бүртгэх, тайлагнах;

2.14.3. Зээлдэгчийн хүсэлтийн дагуу Зээлийн гэрээнд өөрчлөлт оруулж, төлбөрийн хуваарьт өөрчлөлт оруулсан бол Үйлчилгээ үзүүлэгч нь энэ талаарх мэдээллийг Хөрөнгө итгэмжлэн удирдагчид Зээлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулсан сард багтааж мэдэгдэнэ. Зээлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт орсноор Хөрөнгөд багтсан Зээлийн багцын шалгуур үзүүлэлтийг хангахгүй болсон тохиолдолд ТЗК-ийн Хөрөнгө итгэмжлэн удирдах журамд заасны дагуу арга хэмжээ авна;

2.14.4. Үйлчилгээ үзүүлэгч нь хөрөнгийн багцад багтсан зээлийн мэдээллийг хадгалах, ТЗК, Хөрөнгө итгэмжлэгдсэн удирдагчийн хууль ёсны шаардлагаар ТЗК-тай холбоотой аливаа дүгнэлт гаргахад шаардагдах мэдээлэл, баримт бичгийг хүргүүлэх, мэдээллээр хангах, өөрийн гаргасан дүгнэлтийг холбогдох баримтыг бүрэн судалж, зохих стандартын дагуу үйл ажиллагаа явуулж, гаргасан дүгнэлтийн хариуцлагыг бие даан хариуцна;

2.14.5. Үйлчилгээ үзүүлэгч нь өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас ТЗК болон Үнэт цаас эзэмшигчдэд хохирол учруулсан тохиолдолд өөрийн хөрөнгөөр тэдний өмнө хариуцлага хүлээнэ;

2.14.6. ТЗК-ийн нэрийн өмнөөс зээлийн хүүгийн төлбөрийн нэмэгдсэн өртгийн албан татварын баримтыг зээлдэгчид хүргүүлнэ;

2.14.7. Хууль тогтоомжид заасан бусад.

2.15. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь дараах чиг үүрэгтэй байна. Үүнд:

2.15.1. Багцын эргэн төлөлтийг хянана;


2.15.2. ТЗК болон Үйлчилгээ үзүүлэгчтэй харилцах ажилтныг томилох бөгөөд түүнтэй холбоо барих мэдээлэл, түүний эрх үүрэг болон бусад шаардлагатай мэдээллийг ТЗК болон Үйлчилгээ үзүүлэгчид хүргүүлнэ.



2023-04-06

БҮРТГЭВ-02

## ГУРАВ. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛС



- 3.1. Энэхүү гэрээний дагуу Үйлчилгээ үзүүлэгчид сар бүр төлөх үйлчилгээний хөлс нь Зээлдэгчээс зээлийн эргэн төлөлтийг цуглуулан, ТЗК-д шилжүүлсэн Зээлийн эргэн төлөлтийн дүнгийн 2.5 хувьтай тэнцүү байхаар талууд тохиролцов.
- 3.2. Энэ гэрээний дагуу тухайн сард гүйцэтгэсэн үйлчилгээний хөлсийг Үйлчилгээ үзүүлэгч болон ТЗК нар нь тооцоо нийлсэн актад үндэслэн дараа сарын 25-ны өдөрт багтаан ТЗК-д шилжүүлэх Багцын эргэн төлөлтийн дүнгээс суутган, үлдэгдэл төлбөрийг ТЗК-д шилжүүлнэ. ТЗК нь ийнхүү үйлчилгээний төлбөрийг суутган авахыг энэхүү гэрээгээр зөвшөөрөл олгосон болно.
- 3.3. Энэхүү үйлчилгээний хөлсөнд Үйлчилгээ үзүүлэгчийн зээлийн төлбөр цуглуулахтай холбоотой ажиллах хүчний зардал, хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдлыг хангах зардал, материалын зардал, тээвэр, татвар хураамж, дотоодын урсгал зардал, зээлтэй холбоотой зээлийн хяналт, маргаан, түүнийг шийдвэрлэх явцын зардал, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа болон бусад ажлыг хийхэд шаардлагатай бүхий л зардлууд багтсан болно.
- 3.4. Зайлшгүй шаардлагаар гэрээний дагуу үзүүлэх үйлчилгээний хэмжээ өөрчлөгдсөн тохиолдолд гэрээний үнэд өөрчлөлт орж болно. Энэ тохиолдолд гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно. Төлбөрийг Үнэт цаас эзэмшигчдэд төлөхөд хүндрэл үүсгэхээр нэмэлт, өөрчлөлтийг энэхүү гэрээнд оруулж болохгүй.

## ДӨРӨВ. БАТАЛГАА МЭДЭГДЭЛ

- 4.1. Үйлчилгээ үзүүлэгч нь энэхүү гэрээний үүргийг гүйцэтгэх бүрэн чадамжтайгаа илэрхийлэн ТЗК-д дараах баталгааг гаргаж байна. Үүнд:
  - 4.1.1. Банк, санхүүгийн зах зээлд тасралтгүй 3-аас дээш жил үйл ажиллагаа явуулсан туршлагатай байна;
  - 4.1.2. Үйлчилгээг эрхлэхэд шаардлагатай хүний нөөцийн болон нягтлан бодох бүртгэл, тайлан тооцоо гаргах, програм, техник хангамжийн нөхцөлөөр бүрэн хангагдсан;
  - 4.1.3. Хорооноос баталсан компанийн засаглалын кодексыг үйл ажиллагаандаа мөрдөж, холбогдох дүрэм, журамдаа энэ талаар тусгасан байна;
  - 4.1.4. 3-аас доошгүй ТУЗ-ийн гишүүнтэй, тэдгээрийн 1/3 нь хараат бус гишүүн байх, тэдгээрийн болон компанийн үйл ажиллагааг олон нийтэд ил тод, нээлттэй тайлагнадаг байна;
  - 4.1.5. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай зэрэг хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагаа явуулдаг буюу явуулна;
  - 4.1.6. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль болон СЗХ-ны “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам”-аар тогтоосон Үйлчилгээ үзүүлэгчид тавигдах бусад бүхий л шаардлагыг хангасан болно;
  - 4.1.7. ТУЗ-ийн дарга, гишүүд, гүйцэтгэх захирал, ТЗК-д үйлчилгээ үзүүлж буй хоёроос доошгүй мэргэжилтнүүд нь санхүүгийн зах зээл дээр тасралтгүй 1 ба түүнээс дээш жил үйл ажиллагаа явуулсан туршлагатай;
  - 4.1.8. Хувь нийлүүлсэн хөрөнгийг мөнгөн хөрөнгөөр бүрдүүлсэн бөгөөд түүний доод хэмжээ нь СЗХ-оос тогтоосон хэмжээг хангасан;
  - 4.1.9. Тусгай зөвшөөрөлтэй этгээд бол төрийн эрх бүхий байгууллагаас баталсан зохистой харьцааны шалгуурыг хангаж ажилласан, засаглал, мэдээлэл тайлагналын ил тод байдлыг хангасан.
- 4.2. Үйлчилгээ үзүүлэгч нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль болон ТЗК-тай байгуулсан гэрээнд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ ямагт ТЗК болон хөрөнгө оруулагчийн эрх ашигт нийцсэн үйл ажиллагаа явуулна.

2023-04-06

БҮРТГЭВ-02

## ТАВ. ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛГОХ

- 5.1. Энэхүү Гэрээг талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулсан бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооноос ХБҮЦ-ыг олон нийтэд санал болгон арилжаалах зөвшөөрөл олгосноор хүчин төгөлдөр болно.
- 5.2. Энэхүү Гэрээ нь Гэрээний 5.1-д заасны дагуу хүчин төгөлдөр болсон үеэс эхлэн талууд Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж дуусгавар болох хүртэл буюу ХБҮЦ-ны төлбөрийг хөрөнгө оруулагчдад төлж дуусган, Үнэт цаас гаргагчийг татан буугдах өдөр хүртэл хүчин төгөлдөр байна.
- 5.3. Үйлчилгээ үзүүлэгч уг Гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгээгүй буюу зохих ёсоор, бүрэн гүйцэтгээгүй бол ТЗК нь Гэрээг цуцалж, шинэ үйлчилгээ үзүүлэгчтэй гэрээ байгуулах эрхтэй.
- 5.4. Гэрээг цуцалсан тохиолдолд түүнээс хойш 5 хоногийн дотор дараагийн үйлчилгээ үзүүлэгчийг сонгоно. Шинэ үйлчилгээ үзүүлэгчтэй байгуулсан гэрээ хүчин төгөлдөр болох хүртэл хугацаанд Үйлчилгээ үзүүлэгч Төлбөр цуглуулах үйлчилгээг үргэлжлүүлэн үзүүлэх үүрэгтэй ба ТЗК-аас нэмэлт төлбөр шаардах эрхгүй байна.

## ЗУРГАА. ГЭНЭТИЙН БОЛОН ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

- 6.1. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой (дайн, гал түймэр, үер, газар хөдлөлт, ажил хаялт, гоц халдварт өвчин зэрэг) нөхцөл байдал нь гэрээний үүргийн биелэлтэд шууд нөлөөлсөн нь нотлогдсон бол талууд энэхүү Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйн хариуцлагаас бүрэн болон хэсэгчлэн чөлөөлөгдөнө. Энэ үед гэрээний үүрэг биелүүлэх хугацаа нь давагдашгүй хүчин зүйлийн үргэлжлэх хугацаагаар хойшлогдсонд тооцно.
- 6.2. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд талууд нь энэ нөхцөл байдал болон үүссэн шалтгааны талаар нөгөө талдаа нэн даруй бичгээр мэдэгдэж, гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тухайгаа нотлох үүрэг хүлээнэ.
- 6.3. Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн талаар тухайн цаг үед нь нөгөө талдаа мэдэгдээгүй бол ирээдүйд уг нөхцөл байдлыг үндэслэл болгох эрхгүй.

## ДОЛОО. НУУЦ МЭДЭЭЛЭЛ

- 7.1. ХБҮЦ гаргах ажиллагаа, Хөрөнгийн багц болон түүний зээл, барьцаатай холбоотой Зээлдэгч болон шаардлага гаргах эрхтэй гуравдагч этгээдтэй холбоотой аливаа мэдээлэл, Үнэт цаас гарагчийн гуравдагч этгээдтэй байгуулсан гэрээ, хэлцэл, тохиролцоо болон тэдгээрээс авч буй үйлчилгээтэй холбоотой аливаа мэдээлэл, Үйлчилгээ үзүүлэгчийн санхүүгийн нөхцөл байдлын тухай аливаа мэдээлэл, санхүүгийн тайлан, зах зээлийн судалгаа, журам, заавар, бодлого, гэрээ хэлцэл эдгээрт заасан нөхцөл, мэдээлэл, тоон үзүүлэлт, зураг график зэргийг нууц мэдээлэлд тооцно.
- 7.2. Дээр дурдсан нууц мэдээлэл гэдэгт нийтэд ил болсон, эсхүл ХБҮЦ гаргах ажиллагааны хүрээнд Үнэт цаасны танилцуулгад тусгаж олон нийтэд танилцуулсан мэдээлэл хамаарахгүй болно.
- 7.3. Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны танилцуулга, Биржид хүргүүлсэн бичиг баримт, хөндлөнгийн шинжээчдийн дүгнэлт зэрэг үнэт цаас бүртгүүлэхтэй холбоотой бүхий л бичиг баримтыг Биржийн бүртгэлд бүртгэх тухай шийдвэр гарснаас хойш арван жилийн хугацаанд хадгална.
- 7.4. Талууд хууль тогтоомжийн дагуу төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтан шаардсанаас бусад тохиолдолд нууц мэдээллийг бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр аливаа этгээдэд задруулах, эсвэл өөр бусад зорилгоор ашиглахыг хориглох бөгөөд ийнхүү задруулснаас үүдэн

2023-04-06

нөгөө талдаа учирсан хохирлыг нөхөн төлөх үүрэг хүлээнэ.

**БҮРТГЭВ-02**

### НАЙМ. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

- 8.1 Үйлчилгээ үзүүлэгч нь Үнэт цаас гаргагч энэ гэрээний үүргээ зөрчсөнөөс бусад тохиолдолд аливаа байдлаар Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх шүүх, арбитр болон төрийн байгууллагад гомдол, нэхэмжлэл гаргах болон бусад арга хэмжээ авахгүй байх, төлбөр нэхэмжлэхгүй байх үүрэг хүлээнэ.
- 8.2 Энэ гэрээтэй холбоотой аливаа маргааныг талууд зөвшилцөх аргаар шийдвэрлэнэ. Хэрэв зөвшилцөх аргаар маргааныг шийдвэрлэж чадахгүй бол Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

### ЕС. БУСАД ЗҮЙЛ

- 9.1. Энэхүү Гэрээ нь талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болох бөгөөд талууд Гэрээнд заасан үүргээ бүрэн биелүүлснээр дуусгавар болно.
- 9.2. Гэрээ, түүнд холбогдох баримт бичиг нь Монгол хэл дээр байна.
- 9.3. Энэхүү Гэрээг ойлгох, тайлбарлах, хэрэглэхдээ Монгол Улсын хууль тогтоомжийг баримтална.
- 9.4. Талуудын аль нэг нь гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах саналаа нөгөө талдаа ажлын 10-аас доошгүй өдрийн өмнө мэдэгдэх бөгөөд нэмэлт, өөрчлөлтийг зөвхөн бичгээр үйлдэж, талууд гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.
- 9.5. Гэрээний нэмэлт, өөрчлөлт нь энэхүү Гэрээний салшгүй хэсэг бөгөөд гэрээний нэгэн адил үйлчилнэ.
- 9.6. Гэрээг зургаан хувь үйлдэх бөгөөд эдгээр нь хууль зүйн хувьд ижил хүчинтэй байна. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нэг хувь, Үнэт цаас гаргагч хоёр хувь, Хөрөнгө итгэмжлэн удирдагчид нэг хувийг тус тус хадгална. Холбогдох хуулийн дагуу энэхүү Гэрээний аливаа заалт хууль бус, хүчингүй, хэрэгжүүлэх боломжгүйд тооцогдвол Гэрээний бусад заалтад нөлөөлөхгүй.

### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

#### ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ:

“БЭРС ФИНАНС ББСБ” ХХК  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
С.ОТГОНБАТ



#### ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ:

“БЭРС ЭЙ БИ ЭС ПЛАС  
ТЗК” ХХК ТУЗ ДАРГА  
Б.БОЛОР-ЭРДЭНЭ



#### ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УДИРДАГЧ:

“ЮНАЙТЕД АЙР  
ФАЙНЭНС” ХХК  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
Х.МАРГАД-ЭРДЭНЭ






МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ  
MONGOLIAN STOCK EXCHANGE  
2023-04-06  
БҮРТГЭВ-02

СЗХ  
он сар өдөр  
БҮРТГЭВ  
№ 01

100.0



ОГНОО:

2023 оны 04-р сарын 09 өдөр

**“БЭРС ФИНАНС ББСБ” ХХК**  
“Барьцаалуулагч”

болон

**“БЭРС ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК” ХХК**  
“Үнэт цаас гаргагч”

**“ЮНАЙТЕД АЙР ФАЙНЭНС” ХХК**  
“Үүргийн гүйцэтгэлийг хангуулагч”

нарын хооронд байгуулсан

---

**ЗЭЭЛИЙН ЭРГЭН ТӨЛӨЛТИЙН ДАНСНЫ  
БАРЬЦААНЫ ГЭРЭЭ**

Дугаар: 23/562

---

ЭНЭХҮҮ ГЭРЭЭГ Монгол улсын Иргэний хуулийн 13-р бүлэг, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн засагчдын хөрөнгийн барьцааны тухай хуулийг үндэслэн 2023 оны 02 дугаар сарын 09 ны өдөр дор ГЭВ дурдсан талуудын хооронд байгуулав:

**ТАЛУУД:**

- (1) “БЭРС ФИНАНС ББСБ” ХХК (цаашид “Барьцаалуулагч” эсхүл “ББСБ” эсхүл “Үйлчилгээ үзүүлэгч” гэх);
  - (2) “БЭРС ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК” ХХК (цаашид “ТЗК” эсхүл “Үнэт цаас гаргагч” гэх);
  - (3) “ЮНАЙТЕД АЙР ФАЙНЭНС” ХХК Санхүүгийн Зохицуулах Хорооны 2021 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн №473 дугаар тогтоолын дагуу авсан Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй, Автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас (цаашид “ХБҮЦ” гэх)-ны Үүргийн гүйцэтгэлийг хангуулагч (цаашид “Үүргийн гүйцэтгэлийг хангуулагч” эсхүл “Барьцаалагч” гэх).
1. Энэхүү гэрээний зорилго нь ТЗК болон Үйлчилгээ үзүүлэгч нарын хооронд байгуулсан Төлбөр цуглуулах, үйлчилгээ үзүүлэх гэрээний 2.3-т заасан Зээлийн эргэн төлөлтийн данс, уг дансанд цуглаарах зээлийн төлбөрийн орлогыг барьцаалах, ТЗК-ийн ХБҮЦ-ны төлбөрийг төлөх зорилгоор Зээлийн эргэн төлөлтийн данснаас ТЗК-ийн Төлбөр цуглуулах дансанд Гэрээ буюу журмаар тогтоосон хугацаанд үл маргах журмаар шилжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.
  2. Барьцаалуулагч нь Зээлийн эргэн төлөлтийн дансыг эзэмших бөгөөд уг дансанд Зээлийн хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний дагуу худалдсан зээлүүдийн төлбөрүүдийг цуглуулан барьцаалах зөвшөөрлийг зохих журмын дагуу авсан болох, үүнээс өмнө өөр үүргийн барьцаанд тавиагүй ба бусад ямар нэг байдлаар аливаа маргаанд холбогдолгүй бөгөөд энэхүү Зээлийн эргэн төлөлтийн дансанд аливаа гуравдагч этгээдийн эдлэх эрх байхгүй болохыг үүгээр гэрчилж байна.
  3. Барьцаалуулагч нь энэхүү гэрээний 3.1, 3.2-т заасан тохиолдолд гүйлгээ хийх зөвшөөрлийг банкинд олгосон болохоо үүгээр баталж байна.
  4. Барьцааны зүйлийн талаар аливаа гуравдагч этгээдтэй холбоотой маргаан гарсан тохиолдолд Барьцаалагч нь Иргэний хуулийн 154-р зүйлд зааснаар гуравдагч этгээдээс давуу эрхтэй болохыг хүлээн зөвшөөрөв.
  5. Зээлийн эргэн төлөлтийн данс, түүнд цугларсан хөрөнгө нь Барьцаалуулагчийн бусад хөрөнгөөс тусгаарлагдсан, Барьцаалуулагчийн бусдын өмнө хүлээсэн аливаа үүрэг, төлбөрийн чадваргүй байдал, дампуурал, татан буулгах ажиллагаанаас ангид байна.


**1. НЭР ТОМЬЁО БА ТАЙЛБАР**

- 1.1. ТЗК болон ББСБ нарын хооронд байгуулсан Төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлэх гэрээ, Зээлийн хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ, Үнэт цаас гаргагч болон Хөрөнгө итгэмжлэн удирдагч нарын хооронд байгуулсан Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд тус тус тодорхойлсон үг болон томъёоллыг энэхүү гэрээнд адил утгаар хэрэглэнэ.
- 1.2. “Баталгаажсан өр төлбөр” гэдэгт ХБҮЦ-ны хэлцлийн дагуу Үнэт цаас гаргагчийн хүлээх, учрах, төлөх (бодитой учирсан, эсхүл учирч болзошгүй) бүх мөнгө, аливаа хэлбэрийн үүрэг, хариуцлага болон энэ гэрээнд төлөхөөр тохирсон бусад бүх мөнгийг тус тус ойлгоно.
- 1.3. “Үүргийн гүйцэтгэлийг хангах эд хөрөнгө” гэж Хөрөнгийн багц түүний эргэн төлөлт, Зөвшөөрөгдсөн хөрөнгө оруулалт, мөн тэдгээрт заасан болон тэдгээрийн дагуу үүссэн Үнэт цаас гаргагчийн аливаа эрх, эд хөрөнгийн эрх, ашиг сонирхол, үр ашгийг ойлгоно.



2023-04-06

1.4. “Үнэт цаас гаргалтын баримт бичиг” гэж ТЗК-ийн ХБҮЦ гаргах үйл ажиллагаатай холбоотой баталсан дүрэм, журам, бусад этгээдүүдтэй байгуулсан гэрээг ойлгоно.



## 2. БАРЬЦААНЫ ЗҮЙЛ

- 2.1. Барьцаалуулагч нь ТЗК-ийн Үйлчилгээ үзүүлэгчийн хувьд ТЗК-ийн хууль ёсны өмчлөлийн зээлийн хөрөнгийн багцаас төлөгдсөн зээлийн аливаа төлбөрийг Зээлийн эргэн төлөлтийн данс буюу Хавсралт №1-т заасан өөрийн эзэмшлийн дансад цуглуулах бөгөөд Үйлчилгээ үзүүлэгчийн гэрээгээр хүлээсэн үүргийн хүрээнд эдгээр дансан дахь дараах хөрөнгийг Үүргийн гүйцэтгэл хангуулагчид барьцаалуулж байна.
  - (i) Зээлийн хөрөнгийн багцын бүхий л төлбөр, түүнээс олох орлого;
  - (ii) Хөрөнгийн багцын үүргийн гүйцэтгэлийг хангуулах аргыг хэрэгжүүлсэнтэй холбоотой аливаа орлого.
- 2.2. Үйлчилгээ үзүүлэгч татан буугдах, дампуурах, төлбөрийн чадваргүй болох зэрэг бусдын өмнө үүрэг хүлээх аливаа тохиолдолд Зээлийн эргэн төлөлтийн данс, уг данс дахь мөнгөн хөрөнгө нь эдгээр тохиолдлоос ангид байх бөгөөд Барьцаалагч, Үнэт цаас гаргагчийн шаардлагаа хангуулах эрх хэвээр хадгалагдана.
- 2.3. Барьцааны зүйлийн үнэлгээг сар бүрийн Үйлчилгээ үзүүлэгчийн тайланд тусгасан тухайн сард төлөгдсөн төлбөрүүдийн дүнгээр тодорхойлно.
- 2.4. Барьцааны зүйлийн үнэлгээ нь энэхүү гэрээний 2.1-ийн (i), (ii)-д заасан орлогын дүнгээс хэтрэхгүй байна.
- 2.5. Барьцаалсан хөрөнгийн дүн нь барьцааны зүйлийн үнэлгээнээс бага байх тохиолдолд Барьцаалуулагч нь үнэлгээнээс дутсан үүргийг 1 өдрийн дотор нөхөж төлөх үүрэгтэй.


## 3. ҮҮРГИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

- 3.1. Барьцаагаар хангагдах шаардлага үүссэн тохиолдолд Барьцаалагч (Үүргийн гүйцэтгэл хангуулагч) нь Үйлчилгээ үзүүлэгч болон Зээлийн эргэн төлөлтийн данс байрлах банканд энэ тухай мэдэгдлийг бичгээр хүргүүлж, үүргийн гүйцэтгэлийг үл маргах журмаар хангуулна.
- 3.2. Үйлчилгээ үзүүлэгч нь Энэхүү гэрээний 3.1.-д заасан мэдэгдлийг хүлээн авмагц банканд бичгээр мэдэгдэл хүргүүлж мэдэгдэлд дурдсан мөнгөн хөрөнгийг Барьцаалуулагчийн харилцах данснаас Үүргийн гүйцэтгэл хангуулагчийн мэдэгдэлд дурдсан “Бэрс Эй Би Эс Плас ТЗК” ХХК-ийн Голомт банкны 3305138149 тоот харилцах дансанд ажлын 8 цагийн дотор шилжүүлэхэд онцгойлон анхаарч ажиллана.
- 3.3. Үүргийн гүйцэтгэл хангуулагч нь Банкнд энэхүү гэрээний 3.1.-д дурдсан мэдэгдлийг хүргүүлэхдээ дараах зүйлсийг тодорхой тусгана. Үүнд:
  - 3.3.1. Барьцаалуулагчийн төлөх баталгаажсан өр төлбөрийн дүн,
  - 3.3.2. “Бэрс Эй Би Эс Плас ТЗК” ХХК-ийн төлбөр хүлээн авах дансны мэдээлэл
- 3.4. Үүргийн гүйцэтгэлийг хангуулагчийн бүрэн эрх.
  - 3.4.1. Албадан хэрэгжүүлэх үүргийн гүйцэтгэлийг хангуулах арга: Зөрчлийн тохиолдол бий болоход, энэхүү гэрээгээр үүссэн үүргийн гүйцэтгэлийг хангуулах аргыг албадан хэрэгжүүлнэ.
  - 3.4.2. Үүргийн гүйцэтгэлийг хангуулагчийн бүрэн эрх: Хэрэв үүргийн гүйцэтгэлийг хангуулах аргыг албадан хэрэгжүүлэх бол Үүргийн гүйцэтгэлийг хангуулагч энэхүү гэрээний дагуу зохимжтой гэж үзсэн аливаа зүйлээр Баталгаажсан өр төлбөрт ногдох эрхийг шилжүүлэх, төлбөр авах, төлбөрөөс чөлөөлөхөд зарцуулж болно.
  - 3.4.3. Үүргийн гүйцэтгэлийг хангуулагч болон Үнэт цаас эзэмшигчийн аль нь ч Эрхийг нь шилжүүлсэн гэрээг албадан хэрэгжүүлсэнтэй холбогдуулан учирч болох аливаа төрлийн алдагдлыг хариуцахгүй.

2023-04-06

БҮРТГЭВ-02

3.4.4. Зөрчлийн тохиолдол бий болсны дараа Баталгаажсан өр төлбөрийг Үүргийн гүйцэтгэлийг хангуулагч, эсхүл Үнэт цаас эзэмшигч хүлээн авсан эсэхээс үл хамааран энэхүү гэрээг хэрэгжүүлж болно.



#### 4. ЭРХ ОЛГОХ

4.1. Энэхүү гэрээний 3.1.-д дурдсаны дагуу барьцаагаар хангах шаардлага үүссэн тохиолдолд Үйлчилгээ үзүүлэгчээс энэхүү гэрээний 2.1-д дурдсан мөнгөн хөрөнгийг Үүргийн гүйцэтгэл хангуулагчийн мэдэгдлийн дагуу захиран зарцуулах эрхийг олгож байна.

#### 5. ӨРТӨГ, ХУРААМЖ БОЛОН ЗАРДАЛ

5.1. Үүргийн гүйцэтгэлийг хангуулагч нь энэ гэрээний дагуу эрх, бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд гарсан бүх төлбөр болон зардлыг хойшлуулалгүйгээр Үнэт цаас гаргагч, Барьцаалуулагч эсхүл түүний эрх залгамжлагч, бенефициар өмчлөгчөөс нэхэмжлэн авна.

#### 6. ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН БАТАЛГАА

6.1. Үүргийн гүйцэтгэлийг хангуулагч өөр байдлаар бичгээр тохиролцоогүй тохиолдолд Үйлчилгээ үзүүлэгч нь энэ гэрээний дагуу Үүргийн гүйцэтгэлийг хангуулагчид дараах зүйлийг баталж байна:

6.1.1. Захиран зарцуулахгүй: Төлбөр цуглуулах, үйлчилгээ үзүүлэх гэрээний 2.3-т зааснаас бусад байдлаар Зээлийн эргэн төлөлтийн дансан дахь мөнгийг бүхэлд нь буюу хэсэгчлэн захиран зарцуулахгүй, зарлагын гүйлгээ хийхгүй байх;

6.1.2. Эрхийн доголдол: Энэхүү гэрээний зүйл болж буй аливаа хөрөнгө ба Зээлийн эргэн төлөлтийн дансанд нөлөөлөх аливаа эрхийн доголдол үүсгэхгүй буюу үүсгэх оролдлого хийхгүй;

6.1.3. Мэдээлэл: Зээлийн эргэн төлөлтийн дансны гүйлгээний тухайн үеийн тайлан, орлого, зарлагын талаарх мэдээллийг шаардлагатай тохиолдолд Үүргийн гүйцэтгэлийг хангуулагчид гарган өгөх;

6.1.4. Хаагдахгүй байх: Баталгаажсан өр төлбөр бүрэн төлөгдөх хүртэл Зээлийн эргэн төлөлтийн данс хаагдахгүй байх талаар арга хэмжээ авах;

6.1.5. Хохирол учруулахгүй байх: Энэхүү гэрээний дагуу Үүргийн гүйцэтгэлийг хангуулагчийн эрх, бүрэн эрх, эрхээ хангуулахад сөргөөр нөлөөлөх, эсхүл түүгээр Хөрөнгийн барьцааны (фидуцийн) зүйл, хөрөнгийн багц, эсхүл Үүргийн гүйцэтгэлийг хангах эд хөрөнгөд нөлөөлж болох аливаа зүйлийг хийхгүй байх, эс үйлдэх, түүнээс сэргийлэх арга хэмжээ авна.


#### 7. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

7.1. Энэхүү гэрээнд заасан, эсрэгээр илэрхийлснийг үл харгалзан, Үнэт цаас гаргагч нь Зээлийн эргэн төлөлтийн данстай холбоотой бүх эрх, үүргийг хэрэгжүүлэх бөгөөд Үүргийн гүйцэтгэлийг хангуулагч нь тус данстай холбоотой Үнэт цаас гаргагчийн үүргийг хүлээхгүй бөгөөд Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд заасан аливаа төлбөрийг гүйцэтгэхгүй.

#### 8. ҮҮРГИЙН ГҮЙЦЭТГЭЛ ХАНГУУЛАГЧИЙН ХАРИУЦЛАГА

8.1. Үүргийн гүйцэтгэлийг хангуулагчийн хариуцлага: Үүргийн гүйцэтгэлийг хангуулагч нь аливаа төлбөр хүлээн авах эрх бүхий этгээдүүдийн өмнө ХБҮЦ-ны мөнгөн хөрөнгийн эх үүсвэрээс өөр аливаа бусад хөрөнгөөр хариуцлага хүлээхгүй.

8.2. Үүргийн гүйцэтгэлийг хангуулагчийн эрхийг албадан хэрэгжүүлэх: Энэ гэрээний дагуу Үүргийн гүйцэтгэлийг хангуулагчийн эрхийг албадан хэрэгжүүлэх зорилгоор Үүргийн гүйцэтгэлийг хангуулагч, эсхүл Эрх хүлээн авагчаас тухай бүр гүйцэтгэхийг



шаардаж болох бүхий л зүйлийг Үнэт цаас гаргагч хийж гүйцэтгэх, эсхүл гүйцэтгүүлэхийг зөвшөөрөх ба тухайн зорилгоор Үүргийн гүйцэтгэлийг хангуулагчаас шаардсан үед Үнэт цаас гаргагчийн нэрийг ашиглахыг зөвшөөрнө.

**9. ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛОХ**

- 9.3. Үүргийн гүйцэтгэлийг хангуулагч энэ гэрээгээр байгуулсан үйл ажиллагаа бүрэн дууссан гэж үзвэл энэ гэрээгээр бий болгосон үүргийн гүйцэтгэлийг хангах аргыг чөлөөлнө.
- 9.4. Энэхүү гэрээ нь байгуулагдсан үеэс эхлэн талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж дуусгавар болох хүртэл буюу ХБҮЦ-ны төлбөрийг хөрөнгө оруулагчдад төлж дуусган Үнэт цаас гаргагчийг татан буугдах өдөр хүртэл хүчин төгөлдөр байна.

**10. ГЭНЭТИЙН БОЛОН ДАВАГДАШГҮЙ ХҮЧНИЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ**

- 10.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн улмаас тухайлбал (дайн, гал түймэр, үер, газар хөдлөлт, ажил хаялт, гоц халдварт өвчин, хөл хорио гэх мэт) зэрэг нөхцөл байдал нь гэрээний үүргийн биелэлтэд шууд нөлөөлсөн нотлогдсон бол талууд энэхүү Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйн хариуцлагаас бүрэн болон хэсэгчлэн чөлөөлөгдөнө. Энэ үед гэрээний үүрэг биелүүлэх хугацаа нь давагдашгүй хүчин зүйлийн үргэлжлэх хугацаагаар хойшлогдоно.
- 10.2. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал үүссэн тохиолдолд талууд нь энэ нөхцөл байдал болон үүссэн шалтгааны талаар нөгөө талдаа нэн даруй бичгээр мэдэгдэж, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл тохиолдсон ба үүний улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тухайгаа нотлох үүрэг хүлээнэ.
- 10.3. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн талаар тухайн цаг үед нь нөгөө талдаа мэдэгдээгүй бол ирээдүйд уг нөхцөл байдлыг үндэслэл болгох эрхгүй.

**11. ГЭРЭЭНД АШИГЛАХ ХЭЛ**

- 11.1. Энэхүү гэрээнд Монгол хэлийг ашиглана. Гэрээ түүнд холбогдох баримт бичиг, харилцах баримт бичиг нь энэ хэл дээр байна.

**12. ГЭРЭЭНД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ**

- 12.1 Талуудын аль нэг нь гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах саналаа нөгөө талдаа ажлын 10-аас доошгүй өдрийн өмнө мэдэгдэж, харилцан зөвшилцөнө.
- 12.2 Талууд харилцан зөвшилцсөн гэрээний нэмэлт өөрчлөлтийг Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэн холбогдох зөвшөөрөл авснаар нэмэлт өөрчлөлтийг зөвхөн бичгээр байгуулж, талууд гарын үсэг зурж тамга тэмдгээр баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.
- 12.3 Гэрээний нэмэлт өөрчлөлт нь энэхүү гэрээний салшгүй хэсэг бөгөөд Гэрээний нэгэн адил үйлчилнэ.


**13. ДАГАЖ МӨРДӨХ ХУУЛЬ ТОГТООМЖ**

- 13.1 Энэ гэрээ болон түүнд дурдсан талуудын эрх, үүргийг Монгол Улсын хуулийн дагуу тайлбарлана.
- 13.2 Энэ гэрээнд холбогдуулан, эсхүл түүнээс үүдэн гарах аливаа хууль зүйн ажиллагааг Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлэх, тэдгээр шүүхийн харьяаллаар хэрэг шийдвэрлүүлэхийг эргэж буцалтгүй зөвшөөрч байна.





**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН**



**ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ:**

**“БЭРС ФИНАНС ББСБ” ХХК  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
С.ОТГОНБАТ**


**ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ:**

**“БЭРС ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК”  
ХХК ТУЗ ДАРГА  
Б.БОЛОР-ЭРДЭНЭ**

**БАРЬЦААЛАГЧ, ҮҮРГИЙН  
ГҮЙЦЭТГЭЛИЙГ  
ХАНГУУЛАГЧ:**

**“ЮНАЙТЕД АЙР  
ФАЙНЭС” ХХК  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
Х.МАРГАД-ЭРДЭНЭ**





**БАРЬЦААНЫ ЗҮЙЛ БОЛОХ ЗЭЭЛИЙН ЭРГЭН ТӨЛӨЛТИЙН ДАНСНЫ ЖАГСААЛТ**

№	Эргэн төлөлтийн данс байршиж буй банкны нэр	Эргэн төлөлтийн дансны дугаар
1.	Хаан банк	5034924552
2.		5034924904
3.		5034924868
4.		5034925012
5.		5034924563
6.		5034925045
7.		5034924664
8.		5034924697
9.		5034924642
10.		5034924596
11.		5034924802
12.		5034924824
13.		5034924959
14.		5034924541
15.		5034924948
16.		5034924926
17.		5034924846
18.		5034924915
19.		5034924835
20.		5628026293
21.		5034925056

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ  
MONGOLIAN STOCK EXCHANGE  
2023-04-06  
БҮРТГЭВ-02

CSX  
ОН ОЯР ОДОО  
БҮРТГЭВ  
№ 01



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ  
MONGOLIAN STOCK EXCHANGE

2023-04-06

БҮРТГЭВ-02

БАТЛАВ:

“БЭРС ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК” ХХК

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН

ДАРГА

БЭРС  
ЭЙ БИ ЭС  
ПЛАС  
ТЗК ХХК

Б.БОЛОР-ЭРДЭНЭ

СЗХ  
сн 04 сар 06 өдөр  
БҮРТГЭВ  
№ 01

БАТЛАВ:

“ЮНАЙТЕД АЙР ФАЙНЭНС”  
ХХК

ГҮЙЦЭГЭХ ЗАХИРАЛ

Х.МАРГАД-ЭРДЭНЭ

**ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УДИРДАХ ГЭРЭЭ**

2023 оны 04-р сарын 09-ны өдөр

“БЭРС ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК” ХХК

болон

“ЮНАЙТЕД АЙР ФАЙНЭНС” ХХК

Гэрээний дугаар: 24/563


УЛААНБААТАР

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ  
MONGOLIAN STOCK EXCHANGE  
2023 -04- 06  
БҮРТГЭВ-02

СЗХ -  
БҮРТГЭВ  
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ  
MONGOLIAN STOCK EXCHANGE  
БҮРТГЭВ  
№ 01

2023-04-06



Энэхүү ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УДИРДАХ ГЭРЭЭ (цаашид “Гэрээ” гэх)-г Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйл, Монгол Улсын Иргэний хуулийн 359-368 дугаар зүйлүүдийг тус тус удиртгал болгон сайн дурын үндсэн дээр 2023 оны 02 дугаар сарын 09 өдөр дор дурдсан талууд

Нэг талаас: Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу үүсгэн Монгол Улс, Улаанбаатар хот, СБД, 11-р хороо, 7-р хороолол, Ногоон нуурын гудамж 101 барилга 706 тоот албан ёсны хаягт байрлах регистрийн 6949886 дугаартай Санхүүгийн Зохицуулах Хорооны 2023 оны 01 сарын 25-ны өдрийн №28 дугаар тогтоолын дагуу авсан Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй “Бэрс Эй Би Эс Плас ТЗК” ХХК (цаашид “Үнэт цаас гаргагч” эсхүл “ТЗК” гэх), түүнийг төлөөлж Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга Б.Болор-эрдэнэ

Нөгөө талаас: Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдсан Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Соёлын төв өргөө 10 давхар, 1005 тоот албан ёсны хаягт байрлах регистрийн 2870657 дугаартай Санхүүгийн Зохицуулах Хорооны 2021 оны 10 сарын 28-ны өдөр № 473 дугаар тогтоолын дагуу авсан Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй “Юнайтед Айр Файнэвс” ХХК (цаашид “Хөрөнгө итгэмжлэн удирдагч” гэх), түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал Х.Маргад-Эрдэнэ

дараах нөхцөлийг харилцан тохиролцож байгуулав.


1. Энэхүү гэрээний зорилго нь ТЗК Автомашинны фидуци бүхий зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас (цаашид “ХБҮЦ” гэх) гаргах үйл ажиллагаатай холбоотой Хөрөнгө итгэмжлэн удирдагчаас үзүүлэх үйлчилгээ, үйлчилгээний хөлс төлөх болон гэрээний дагуу хамтран ажиллах зарчим, талуудын эрх үүргийг тодорхойлоход оршино.
2. Талууд Гэрээгээр хүлээсэн үүргээ үнэнч шударгаар биелүүлж, үнэт цаас эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалж, харилцан бие биеийн ашиг сонирхлыг хүндэтгэх, Гэрээгээр тохиролцсон анхны тохиролцоог тууштай хадгалах, шуурхай, бүтээлчээр хамтран ажиллана.
3. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь хөрөнгийг хууль болон гэрээнд зааснаас гадуур, зүй бусаар захиран зарцуулах, ашиглахгүй бөгөөд гагцхүү гэрээгээр тодорхойлсон эрх хэмжээний хүрэндажиллах зарчмыг баримтална.
4. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь өөрийн үйл ажиллагаанд энэхүү гэрээ болон ТЗК-ийн батлан мөрдөж буй дараах журмуудын холбогдох зохицуулалтыг энэхүү гэрээнд нийцүүлэн даган мөрдөнө. Үүнд:
  - 4.1. Хөрөнгө итгэмжлэн удирдагч, Үйлчилгээ үзүүлэгч, Хөндлөнгийн аудиторыг сонгох солих журам;
  - 4.2. Хөрөнгө итгэмжлэн удирдах журам;
  - 4.3. Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх журам;
  - 4.4. Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлэх журам;
  - 4.5. Эрсдэл, сонирхлын зөрчлийг илрүүлэх, үнэлэх, удирдах, дотоод хяналтын журам;
  - 4.6. Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам.
5. Энэхүү Гэрээний үндсэн зорилгыг хэрэгжүүлэхэд Талууд өөрөөс шалтгаалах бүхий л хүчин чармайлтыг гаргаж ажиллана.
6. Хэрэв Гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дараах дарааллын дагуу, ач



2023-04-06

холбогдол өгч шийдвэрлэнэ.

БҮРТГЭВ-02



- 6.1. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль;
  - 6.2. Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох журам;
  - 6.3. Монголын Хөрөнгийн биржийн журам;
  - 6.4. Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ;
  - 6.5. ТЗК-аас баталсан бүх дүрэм, журмууд.
7. Гэрээтэй холбоотой асуудлаар талууд албан бичгээр болон шуудан, и-мэйл, утсаар харилцана.

Үнэт цаас гаргагчийг төлөөлж:


Хөрөнгө итгэмжлэн удирдагчийг  
төлөөлж:

“БЭРС ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК”  
ХХК-ийн




“ЮНАЙТЕД АЙР ФАЙНЭНС” ХХК-  
ийн





## ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ





- 1.1. Энэхүү гэрээнд хэрэглэсэн дараах нэр томъёо нь дараах утгыг илэрхийлнэ. Үүнд:
- 1.1.1. “Анхны үүрэг гүйцэтгүүлэгч” гэж Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт тодорхойлсон этгээд байх ба “Бэрс Эй Би Эс Плас ТЗК” ХХК-ийн хувьд “Бэрс Финнас ББСБ” ХХК байна.
  - 1.1.2. “Үйлчилгээ үзүүлэгч” гэж Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт тодорхойлсон этгээд байх ба “Бэрс Эй Би Эс Плас ТЗК” ХХК-ийн хувьд “Бэрс Финанс ББСБ” ХХК байна.
  - 1.1.3. “Зээлдэгч” гэж Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй зээлийн гэрээ байгуулж, зээлийн хүү болон үндсэн төлбөрийг зээлийн гэрээний дагуу буцаан төлөх үүргийг хүлээсэн иргэн, хуулийн этгээдийг;
  - 1.1.4. “Зээл” гэж Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс Зээлдэгчид зээлийн гэрээний дагуу зээл олгохыг;
  - 1.1.5. “Зээлийн данс бүртгэл” гэж Зээлдэгч тус бүрийн Зээлийн эргэн төлөлт, үлдэгдэл, хүү, нэмэгдүүлсэн хүүг тооцоолж, эргэн төлөлтийг хугацаатай нь бүртгэсэн мэдээллийг;
  - 1.1.6. “Багцын хөрөнгөд өөрчлөлт оруулах” Багцын хөрөнгийг солих, нэмэгдүүлэх, буцаан худалдахыг;
  - 1.1.7. “Зээлийн эргэн төлөлт” гэж Зээлдэгчийн зээлийн гэрээнд заасан хуваарьт үндсэн болон хүүгийн төлбөрийг;
  - 1.1.8. “Төлбөр цуглуулах данс” гэж ТЗК-ийн “Үнэт цаасны төлбөр цуглуулах, үнэт цаас эзэмшигчдэд төлбөр төлөх журам”-ын 2.2.1-д заасан данс болох бөгөөд Цугларсан төлбөрийг хүлээн авах Голомт банканд нээсэн 3305138149 дансыг;
  - 1.1.9. “Тасалбар болох огноо” гэж “Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх журам” 4.4.1 дэх хэсэгт заасан ХБҮЦ-ны төлбөр хүлээн авах эзэмшигчдийн жагсаалтыг авсан өдрийг;
  - 1.1.10. “Багцын эргэн төлөлт” гэж Үйлчилгээ үзүүлэгчээс Үнэт цаас гаргагч руу шилжүүлж буй зээлийн эргэн төлөлтийг;
  - 1.1.11. “Цугларсан төлбөр” гэж Төлбөр цуглуулах дансанд цугларсан мөнгөн дүнг;
  - 1.1.12. “ҮЦТХТ” гэж Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийг.
2. Хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээ
- 2.1. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т заасан үйлчилгээг үзүүлнэ.
  - 2.2. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь энэхүү гэрээнд заасан үйлчилгээ үзүүлэх хүний нөөцтэй байх бөгөөд хариуцах мэргэжилтнийг томилно.
3. Хөрөнгө оруулагчийн эрх ашигт нийцүүлэн хөрөнгийг эзэмших, удирдах
- 3.1. Хөрөнгийн багцыг удирдах, хяналт тавих:
    - 3.1.1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс ТЗК-д Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний дагуу шилжүүлсэн хөрөнгийг жагсаалтын дагуу компанийн нэрийн өмнөөс өөрийн программ хангамжаар хүлээн авч, багцын бүртгэлийг баталгаажуулах;
    - 3.1.2. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь ТЗК-ийн хөрөнгийн багц дахь зээлийн данс

2023-04-06

БҮРТГЭВ-02

- бүртгэлийг өөрийн компанийн данс бүртгэл, санхүүгийн тайлан тооцооноос тусад нь бүртгэх;
- 3.1.3. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний дагуу шилжүүлэн авах хөрөнгө нь ТЗК-ийн ТУЗ-өөс баталсан хуулийн болон санхүүгийн шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхэд хяналт тавьж ажиллана;
- 3.1.4. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь зээлийн данс бүртгэлийг хянаж, алдаа, зөрчил илэрсэн бол түүнийг залруулах арга хэмжээг тухай бүр авах, Үйлчилгээ үзүүлэгчид шаардлага хүргүүлэх;
- 3.1.5. Зээлийн багцтай холбоотой бичиг баримт, мэдээллийг анхны үүрэг гүйцэтгүүлэгч, үйлчилгээ үзүүлэгч нараас шаардан авах эрхтэй;
- 3.1.6. ТЗК-ийн төлбөр цуглуулах дансанд цугларсан төлбөрөөр ХБҮЦ-ны төлбөр болон ТЗК-ийн бусад төлбөрийн үүргүүдийг гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд нэн даруй ТЗК-д мэдэгдэх.
- 3.2. Багцын хөрөнгөд дараах байдлаар өөрчлөлт оруулна.
- 3.2.1. Багцын хөрөнгийг солих;
- 3.2.2. Багцын хөрөнгийг нэмэгдүүлэх;
- 3.2.3. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдах.
- 3.3. Багц дахь хөрөнгөд дор дурдсан үндэслэл бий болсон тохиолдолд Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь шаардлага хангахгүй хөрөнгөд тооцож хөрөнгийг солино. Үүнд:
- 3.3.1. Зээлдэгчийн хүсэлтээр тухайн зээлийн гэрээнд өөрчлөлт оруулсан нь үнэт цаас эзэмшигчдэд төлөх ХБҮЦ-ны төлбөрийн нөхцөлд нөлөөлөхүйц байна гэж Компаниас үзсэн;
- 3.3.2. Хөрөнгийн багцын шалгуур үзүүлэлттэй холбоотойгоор анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн “Хөрөнгө худалдах худалдан авах гэрээ”-нд заасан аль нэг мэдэгдэл, баталгаа зөрчигдсөн;
- 3.3.3. Зээлдэгч зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй 90-ээс дээш хоног хэтэрсэн;
- 3.3.4. Зээлийн эргэн төлөлтийн хугацаа нь 30 хоногоос дээш хэтэрсэн бөгөөд цаашид зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон.
- 3.4. Багц дахь хөрөнгөд дор дурдсан үндэслэл бий болсон тохиолдолд Хөрөнгө итгэмжлэн удирдагч багцын хөрөнгийг нэмэгдүүлнэ. Үүнд:
- 3.4.1. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 15.3.1-д заасны дагуу ХБҮЦ-ны хөрөнгийн багцаас орох орлого нь ХБҮЦ-ны төлбөрийн үүргийг гүйцэтгэж хүрэхгүй болсон;
- 3.4.2. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 15.3.2-д заасны дагуу Компани нь нээлттэй гаргах нөхцөлийн дагуу нэмэлт ХБҮЦ гаргахаар болсон;
- 3.4.3. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь багцын өгөөжийг нэмэгдүүлэх, төлбөрийн тасалдал үүсэхээс урьдчилсан сэргийлэх зорилгоор үнэт цаас эзэмшигчдэд төлөх ХБҮЦ-ны төлбөрөөс бусад сул мөнгөн дүнгээр багц худалдан авах боломжтой гэж үзсэн, зээлийн багц худалдан авах талаар анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй харилцан тохиролцсон.
- 3.5. Багц дахь хөрөнгөд дор дурдсан үндэслэл бий болсон тохиолдолд Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь хөрөнгийн багцыг анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдана.
- 3.5.1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь энэхүү гэрээнд заасны дагуу шаардлага






хангахгүй хөрөнгийг бүхэлд нь солих хөрөнгийн жагсаалтыг ТЗК-д гарган өгөх боломжгүй, эсхүл гарган өгсөн жагсаалт нь шаардлага хангахгүй тохиолдолд солих боломжгүй хөрөнгийн багцын хэмжээгээр;

- 3.5.2. Хөрөнгийн багцад байгаа хөрөнгийн 20 ба түүнээс дээш хувьд зээлийн эргэн төлөлтийн хугацаа 90-ээс дээш хоногхэтэрсэн, эсхүл 30 хоногоос дээш хэтэрсэн бөгөөд цаашид зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд;
- 3.5.3. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.11.5-д заасан нөхцөл байдал үүссэн бөгөөд талууд харилцан тохиролцсон тохиолдолд.
- 3.6. Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн зүгээс багц дахь зээлийн эргэн төлөлт болон Үйлчилгээ үзүүлэгчийн сарын тайланд үндэслэн хянан баталгаажуулалт хийж энэхүү гэрээний 3.3 дахь хэсэгт заасан нөхцөл үүссэн тохиолдолд хөрөнгийг солихтой холбоотойгоор дараах үйл ажиллагааг гүйцэтгэнэ.
  - 3.6.1. Анхны үүрэг гүйцэтгэгчээс харилцан тохиролцсон орлуулах хөрөнгийг Хөрөнгө итгэмжлэгдсэн удирдагчийн программд оруулж холбогдох актыг үйлдсэнээр хөрөнгийг сольж бүртгэсэнд тооцно.
  - 3.6.2. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс ТЗК-д шилжүүлсэн орлуулах хөрөнгийн зээлийн үндсэн төлбөрийн үлдэгдлийн нийлбэр хэмжээ нь шаардлага хангахгүй хөрөнгийн үндсэн төлбөр болон хуримтлагдсан хүүгийн дүнгийн нийлбэр дүнгээс зөрүүтэй тохиолдолд авлага, өглөгийг тооцоо нийлсэн актад тусгаж, барагдуулна.
- 3.7. Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн зүгээс хянан баталгаажуулалт хийсний үндсэн дээр энэхүү гэрээний 3.4 дэх хэсэгт заасан нөхцөл үүссэн талаар мэдээллийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид дараах байдлаар мэдээлж, хөрөнгийг нэмэгдүүлэх ажиллагааг гүйцэтгэнэ.
  - 3.7.1. Багц дахь зээлүүдийн төлөлтийн мэдээлэлд үндэслэн сард 1 удаа багцын хөрөнгийг нэмэгдүүлэх дүнг гаргаж, Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс “нэмэгдүүлэх хөрөнгийн жагсаалт”-ыг авч харилцан тохирно.
  - 3.7.2. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс харилцан тохиролцсон нэмэгдүүлэх хөрөнгийг хөрөнгө итгэмжлэн удирдагчийн программд оруулж холбогдох актыг үйлдэж, тооцоог хийснээр хөрөнгийн багцыг нэмэгдүүлж бүртгэсэнд тооцно.
- 3.8. Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн зүгээс хянан баталгаажуулалт хийсний үндсэн дээр энэхүү гэрээний 3.5 дахь хэсэгт заасан нөхцөл үүссэн талаар мэдээллийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид дараах байдлаар мэдээлж, багцыг буцаан худалдах ажиллагааг гүйцэтгэнэ.
  - 3.8.1. Гэрээний 3.5.1-т заасан нөхцөл үүссэн тохиолдолд Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй зээлийн хөрөнгийг буцаан худалдах актыг үйлдэж, Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь буцаан худалдсан зээлийн холбогдох төлбөрийг ТЗК-д шилжүүлнэ.
  - 3.8.2. Гэрээний 3.5.2, 3.5.3-д заасан нөхцөл үүссэн тохиолдолд Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Үйлчилгээ үзүүлэгчийн тайланд үндэслэн багцын хөрөнгийн үлдэгдлийг гаргаж ТЗК-ийн ТУЗ-д танилцуулж буцаан худалдах эсэхийг шийдвэрлүүлнэ.
  - 3.8.3. Гэрээний 3.8.2-д заасны дагуу багцыг буцаан худалдахаар шийдвэрлэсэн тохиолдолд ТЗК нь буцаан худалдах мэдэгдлийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид хүргүүлнэ.
  - 3.8.4. Гэрээний 3.8.3-т заасан мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногт багтаан Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь ТЗК-тай Хөрөнгийн багцыг буцаан

2023-04-06

худалдах гэрээг байгуулж, холбогдох төлбөрийг төлнө.



**3.9.** Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь энэ гэрээний 3.2-д заасан нөхцлийг хэрэгжүүлэх боломжгүй-тохиолдолд барьцаа хөрөнгөөр үүргийн гүйцэтгэл хангуулан ХБҮЦ-ны үндсэн болон хүүгийн төлбөр төлөх үүргийг гүйцэтгүүлэх бөгөөд Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь үүргийн гүйцэтгэлийг хангуулахтай холбоотой Үйлчилгээ үзүүлэгчид шүүхэд нэхэмжлэл гаргахыг мэдэгдэж, хэрэгжилтэд хяналт тавина.

3.10. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь энэхүү гэрээнд заасан багцад өөрчлөлт оруулахтай холбоотой баримт бичгийн бүрдлийг хангаж ажиллана.

3.11. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Санхүүгийн зохицуулах хорооны “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журам”-ын 11.3, 11.4-д заасан мэдээлэл, тайланг тус журамд заасан хугацаанд хүргүүлнэ.

#### 4. Үнэт цаас эзэмшигчдэд төлбөр төлөх

4.1. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь энэхүү Гэрээнд заасны дагуу төлбөр цуглуулах дансны хуулга авах, үлдэгдэл шалгах эрхтэй бөгөөд Үйлчилгээ үзүүлэгчээс төлбөр цуглуулах дансанд шилжүүлсэн Хөрөнгийн багцын эргэн төлөлтийн дүнг Зээлийн данс бүртгэлтэй тулган бүртгэж, баталгаажуулна.

4.2. ТЗК-н төлбөр цуглуулах дансанд цугларсан төлбөрөөс зарлага гаргахтай холбоотой эрхийг ТЗК болон Захиргааны үйлчилгээ үзүүлэх этгээдтэй байгуулсан гэрээгээр зохицуулах ба Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь гүйлгээнд зөвшөөрөл олгох, төлбөр цуглуулах дансны зарлагын гүйлгээнд хяналт тавина.

4.3. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь “Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх журам”-д заасны дагуу Үнэт цаас гаргагчийг төлөөлөн ХБҮЦ-ны төлбөр хүлээн авах бөгөөд Үнэт цаас эзэмшигчдийн жагсаалтыг ҮЦТХТ-өөс авч, ХБҮЦ-ны төлбөрийн тооцооллыг хийж ҮЦТХТ-д хүргүүлнэ.

4.4. ТЗК нь ҮЦТХТ-тэй ХБҮЦ хадгалуулах, ХБҮЦ-ны төлбөрийн үүргийг гүйцэтгэх зорилгоор гэрээ байгуулах бөгөөд “Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх журам”-д заасны дагуу тухай бүр холбогдох төлбөрийг ҮЦТХТ-ийн дансанд байршуулна.


4.5. ТЗК нь ҮЦТХТ-өөс үүсгэн байгуулагчийн дансанд ХБҮЦ борлуулсны орлого орж ирсэн өдрөөс Хүүгийн төлбөрийг улирал тутамд, үндсэн төлбөрийг жил тутамд төлнө.

4.6. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь ХБҮЦ-ны төлбөрийн тооцоог гаргахдаа татварын өмнөх болон дараах байдлаар гаргах бөгөөд ТЗК нь татварыг хассан дүнгээр ҮЦТХТ-д шилжүүлж, ТЗК нь үнэт цаас эзэмшигчийн нэрээр холбогдох татварыг суутган тайлагнана.

4.7. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь ХБҮЦ-ны төлбөр төлөгдөх хуваарь, үнийн дүнгийн тооцооллыг алдсан, үнэт цаас эзэмшигчийн мэдээллийг буруу бичсэн зэрэг төлбөр тооцоотой алдаа гарсан бол нэн даруй алдааг засах арга хэмжээ авна. Хэрэв хөрөнгө итгэмжлэн удирдагчийн гаргасан алдаанаас болж үнэт цаас эзэмшигч, компани болон бусад этгээдэд хохирол учирсан бол хохирлыг Хөрөнгө итгэмжлэн удирдагч хариуцна.

4.8. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь ХБҮЦ-ны төлбөр төлөгдсөн өдрөөс хойш 3 хоногийн дотор “Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлэх журам”-д заасны дагуу ХБҮЦ-ны төлбөртөлсөн тухай мэдээллийг хүргэнэ.

4.9. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь ХБҮЦ-ны төлбөр төлөгдсөн өдрөөс хойш 3 хоногийн дотор ХБҮЦ эзэмшигчдийн жагсаалт, эзэмшиж буй нэгж ХБҮЦ-ны тоо, ХБҮЦ



Эзэмшигчид төлөгдсөн төлбөр, татварт төлсөн дүн зэрэг мэдээллийг танилцуулна.

## 5. Зөвшөөрөгдсөн хөрөнгө оруулалт

- 5.1. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Толбор цуглуулах дансан дахь үндсэн төлбөрийн болон хүүгийн хэсгийн үлдэгдэл хэсгээр дараах зовшоорогдсон хороонго оруулалтыг төгрөгөөрхийж болно. Үүнд:
  - 5.1.1. Арилжааны банкны хадгаламжид байршуулах;
  - 5.1.2. Монгол Улсын Засгийн газар, Монголбанкаас гаргасан үнэт цаасыг худалдан авах;
  - 5.1.3. Зохицуулагч байгууллагаас хориглоогүй аливаа хэлбэрээр хөрөнгө оруулах.
- 5.2. Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн шийдвэрийн дагуу 5.1-т заасан зөвшөөрөгдсөн хөрөнгө оруулалтын гүйлгээг ТЗК хийнэ. Тус хөрөнгө оруулалттай холбоотой эрсдэлийг Хөрөнгө итгэмжлэн удирдагч хариуцна.
- 5.3. Зөвшөөрөгдсөн хөрөнгө оруулалт хийх үед эрсдэл үүсэхээр бол зөвшөөрөгдсөн хөрөнгө оруулалт хийхийг хориглоно.
- 5.4. ХБҮЦ-ны төлбөрийг хугацаандаа төлөх боломжийг хангах зорилгоор зөвшөөрөгдсөн хөрөнгө оруулалтын дуусах хугацааг ХБҮЦ-ны төлбөр төлөх хуваарьт өдрөөс ажлын хоёр (2)-оос доошгүй өдрийн өмнө дууссан байхаар тохируулсан байна.

## 6. Баталгаа

- 6.1. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь гэрээний хугацаанд дараах баталгааг ТЗК болон ХБҮЦ эзэмшигч нарт гаргаж байна. Үүнд:
  - 6.1.1. ХБҮЦ эзэмшигчийн эрх ашгийг тэргүүн ээлжид хамгаалж ажиллах;
  - 6.1.2. Хөрөнгийн багцыг зохистой удирдах болон энэхүү гэрээнд заасан үйлчилгээ үзүүлэхээс өөрөөр итгэмжилсэн хөрөнгийг ашиглахгүй, мэдээллийг тухай бүр үнэн зөвөөр ХБҮЦ эзэмшигчид, эрх бүхий байгууллага болон ТЗК-ийн ТУЗ-д тайлагнаж ажиллах;
  - 6.1.3. Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ байгуулах, түүнийг хэрэгжүүлэх холбогдох зөвшөөрлийг авсан болно;
  - 6.1.4. ТЗК-ийн хөрөнгийг өөрийн компанийн хөрөнгөөс тусад нь бүртгэх;
  - 6.1.5. ТЗК-д энэхүү гэрээнд заасан үйлчилгээ үзүүлэх хүний нөөцийг бүрдүүлсэн бөгөөд харилцан ажиллах мэргэжлийн, ёс зүйтэй мэргэжилтнийг томилон ажиллуулах;
  - 6.1.6. ТЗК болон ХБҮЦ эзэмшигчийн эрх ашигт харш, тэдгээрийг хохироосон аливаа үйлдэл, эс үйлдэхүй гаргахгүй байх;
  - 6.1.7. Хөрөнгө итгэмжлэн удирдагч эсхүл түүнээс томилсон ажилтны буруутай үйлдлийн улмаас ТЗК, ХБҮЦ эзэмшигч нарт шууд болон шууд бус хохирол учруулсан бол хохирлыг өөрийн хөрөнгөөр барагдуулна.

## 7. Үйлчилгээний хөлс

- 7.1. ТЗК нь Хөрөнгө итгэмжлэн удирдагчаас ирүүлсэн нэхэмжлэхэд үндэслэн энэхүү гэрээний хавсралт №1-д заасан хуваарийн дагуу Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн Худалдаа хөгжлийн банкны 499358818 тоот дансанд төлнө. Төлбөр төлөх өдөр нь амралтын өдөр таарсан тохиолдолд дараагийн ажлын өдөрт багтаан шилжүүлнэ.
- 7.2. Үйлчилгээний хөлсөнд аж ахуйн нэгжийн орлогын албан татвар багтсан бөгөөд хуульд заасны дагуу Хөрөнгө итгэмжлэн удирдагч тайлагнана.



7.3. ТЗК нь Гэрээний 7.1-т заасан хугацаанд үйлчилгээний хөлсийг төлөөгүй тохиолдолд гүйцэтгээгүй үүргийн дүнгээс хоногийн 0.1 хувийн алданги тооцно.

7.4. ТЗК нь үнэт-цаасны төлбөрийг хөрөнгө оруулагчдад үнэт цаасны хугацаанаас өмнө урьдчилан төлж дуусгасан эсхүл Гэрээний тусгай нөхцөлийн 2.1-т заасан нөхцөл үүсээгүй байхад Үнэт цаас гаргагчийн саналаар гэрээг үндэслэлгүйгээр цуцалсан тохиолдолд үлдэх хугацаанд хамаарах гэрээний Хавсралт №1-т тусгасан үйлчилгээний хөлсийг Хөрөнгө итгэмжлэн удирдагчид 1 (нэг) удаа бөөн дүнгээр төлнө.

#### 8. Гэрээ хүчин төгөлдөр болох

- 8.1. Энэхүү гэрээ нь Санхүүгийн зохицуулах хорооноос ХБҮЦ-ыг олон нийтэд санал болгон арилжаалах зөвшөөрөл олгосноор талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.
- 8.2. Гэрээг 6 хувь үйлдэх бөгөөд эдгээр нь хууль зүйн хувьд ижил хүчинтэй байна. Үнэт цаас гаргагч, Хөрөнгө итгэмжлэн удирдагч, СЗХ, МХБирж, Андеррайтерт хадгалуулна.

#### 9. Гэрээний хугацаа

- 9.1. Энэхүү гэрээ нь байгуулагдсан үеэс эхлэн талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж дуусгавар болох хүртэл буюу ХБҮЦ-ны төлбөрийг хөрөнгө оруулагчдад төлж дуусган Үнэт цаас гаргагчийг татан буугдах өдөр хүртэл хүчин төгөлдөр байна.
- 9.2. ХБҮЦ-ны хугацаа дуусахаас өмнө Анхны үүрэг гүйцэтгүүлэгч ХБҮЦ-ыг буцаан худалдан авсан тохиолдолд хугацаанаас өмнө гэрээг дуусгавар болгож болно.

#### 10. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал

- 10.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн улмаас тухайлбал (дайн, гал түймэр, үер, газар хөдлөлт, ажил хаялт, гоц халдварт өвчин, хөл хорио гэх мэт) зэрэг нөхцөл байдал нь гэрээний үүргийн биелэлтэд шууд нөлөөлсөн нотлогдсон бол талууд энэхүү Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйн хариуцлагаас бүрэн болон хэсэгчлэн чөлөөлөгдөнө. Энэ үед гэрээний үүрэг биелүүлэх хугацаа нь давагдашгүй хүчин зүйлийн үргэлжлэх хугацаагаар хойшлогдоно.
- 10.2. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал үүссэн тохиолдолд талууд нь энэ нөхцөл байдал болон үүссэн шалтгааны талаар нөгөө талдаа нэн даруй бичгээр мэдэгдэж, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл тохиолдсон ба үүний улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тухайгаа нотлох үүрэг хүлээнэ.
- 10.3. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн талаар тухайн цаг үед нь нөгөө талдаа мэдэгдээгүй бол ирээдүйд уг нөхцөл байдлыг үндэслэл болгох эрхгүй.

#### 11. Гэрээнд ашиглах хэл

- 11.1. Энэхүү гэрээнд Монгол хэлийг ашиглана. Гэрээ түүнд холбогдох баримт бичиг, харилцах баримт бичиг нь энэ хэл дээр байна.

#### 12. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах

- 12.1. Талуудын аль нэг нь гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах саналаа нөгөө талдаа ажлын 10-аас доошгүй өдрийн өмнө мэдэгдэж, харилцан зөвшилцөнө.
- 12.2. Талууд харилцан зөвшилцсөн гэрээний нэмэлт өөрчлөлтийг Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэн холбогдох зөвшөөрөл авснаар нэмэлт өөрчлөлтийг зөвхөн бичгээр байгуулж, талууд гарын үсэг зурж тамга тэмдгээр баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.
- 12.3. Гэрээний нэмэлт өөрчлөлт нь энэхүү гэрээний салшгүй хэсэг бөгөөд Гэрээний нэгэн

2023-04-06  
адилүйчилнэ.

**13. Эрх залгамжлах болон гэрээний үүргийг шилжүүлэх**

13.1. Энэхүү Гэрээ нь Талуудын холбогдох эрх залгамжлагчид мөн адил үйлчилнэ.

13.2. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасан “эрх хүлээн авагч” нь хөрөнгө болон хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалахад шаардлагатай бүх арга хэмжээ авч, тусгай зориулалтын компанийн нийт хөрөнгө, санхүүгийн тайлан, тэнцэл, баримт бичиг, албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдгийг зэргийг хүлээн авч Үнэт цаас гаргагчийн эрх залгамжлагчаар тооцогдоно.

13.3. Хууль ёсны эрх залгамжлагчдаас бусад этгээдэд үүргийг шилжүүлэхийг хориглоно.

13.4. Дээрх тохиолдолд энэхүү гэрээг хэрэгжүүлэхээр байгуулсан бусад гэрээнүүд хүчин төгөлдөр байна.

**14. Гэрээний нууцлал**

14.1. Нийтэд ил болгосон, эсхүл ХБҮЦ гаргах ажиллагааны хүрээнд Үнэт цаасны танилцуулгад тусгаж олон нийтэд танилцуулагдах болон холбогдох хууль журмын дагуу тодорхой этгээдүүдэд танилцуулах мэдээллээс бусад мэдээллийг нууц мэдээлэл гэнэ.

14.2. Талууд хууль тогтоомж төрийн эрх бүхий байгууллага шаардсанаас бусад нууц мэдээллийг бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр аливаа этгээдэд задруулах хэрэглэх эсвэлөөр бусад зорилгоор ашиглахыг хориглоно.

14.3. Нууц мэдээллийг талууд гэрээ цуцлагдсан эсхүл дуусгавар болсон өдрөөс хойш 10 жилийн хугацаанд хадгална.

14.4. Дээрх тохиолдолд нууц мэдээллийг задруулсан тал нөгөө талдаа яаралтай мэдэгдэх үүрэг хүлээнэ.

**15. Хүчингүй заалтууд**

15.1. Холбогдох хуулийн дагуу энэхүү Гэрээний аливаа заалт хууль бус, хүчингүй, хэрэгжүүлэх боломжгүйд тооцогдвол:


15.1.1. Тус заалт нь бүрэн салгах боломжтой;



15.1.2. Тус хууль бус, хүчингүй болон хэрэгжих боломжгүй заалт нь өмнө энэхүү гэрээний заалт байгаагүйд тооцогдох;

15.1.3. Гэрээний бусад заалтууд хүчинтэй хэвээр байх бөгөөд тус хүчингүй, хууль бус болон хэрэгжих боломжгүй заалт нь ямар нэг байдлаар гэрээний бусад заалтад нөлөөлөхгүй.

**16. Гэрээний нэгдмэл байдал**

16.1. Талуудын хооронд энэхүү Гэрээний зүйлтэй холбоотой асуудлаар өмнө нь хэлэлцэгдэж байсан хэлцэл, харилцан ойлголцлын санамж бичиг, урьдчилсан нөхцөлүүд, Гэрээ болон бусад хэлэлцээр (Бичгээр болон амаар хийгдсэнээс үл хамааран бүх харилцаа холбоог үүнд хамааруулна) байгаа бол тэдгээрийг энэхүү Гэрээ бусад хэлэлцээрийн баримтбичгийн хамт орлох бөгөөд энэхүү Гэрээ нь (аливаа нэмэлт өөрчлөлт болон бусад Хэлэлцээрийн баримт бичгийн хамт) үүний дагуу зохицуулагдаж буй асуудлын хувьд талуудын хооронд хийгдсэн цорын ганц нэгдмэл гэрээнд тооцогдоно.





## ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ


### 1. Хөрөнгө итгэмжлэн удирдагчийг солих

- 1.1. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь гэрээнд заасан зөрчил гаргасан эсхүл гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй, үүргээ биелүүлэх шаардлага хүргүүлсэн боловч гаргасан зөрчлөө арилгаагүй, үүргээ гүйцэтгэхгүй нь тодорхой, хөрөнгө итгэмжлэн удирдагчийг солих шаардлага үүссэн тохиолдолд Гэрээг ТУЗ-ийн шийдвэрээр цуцлах санал гаргана.
- 1.2. Үнэт цаас гаргагч нь Хөрөнгө итгэмжлэн удирдагчийг энэхүү гэрээ болон хуульд заасан үндэслэлээр солих тохиолдолд Хөрөнгө итгэмжлэн удирдагчид ажлын 30 өдрийн өмнө мэдэгдэл хүргүүлнэ. Мэдэгдэл хүргүүлсэн өдрөөс хойш ажлын 30 өдөрт багтаан Хөрөнгө итгэмжлэн удирдагчид хадгалагдаж байсан ХБҮЦ-ны болон Хөрөнгийн багцтай холбоотой баримт бичгийг Үнэт цаас гаргагчийн шинээр томилогдсон этгээдэд хүлээлгэнөгөх эрхтэй.
- 1.3. Үнэт цаас гаргагч нь шинэ хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгон, томилж амжаагүй тохиолдолд тийнхүү шинээр томилогдох хүртэл хугацаанд Хөрөнгө итгэмжлэн удирдагчнь хууль тогтоомж болон энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ хэвийн, урьдын адил гүйцэтгэх үүрэгтэй.
- 1.4. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь шинээр томилогдсон Хөрөнгө итгэмжлэн удирдагчид ажил хүлээлцэх актын дагуу ТЗК-тай холбоотой эзэмшиж байсан бүхий л мэдээлэл, бичигбаримтыг баримтаар хүлээлгэн өгснөөр гэрээ цуцлагдсанд тооцно.

### 2. Гэрээний үүрэг зөрчсөнд тооцох

- 2.1. Хөрөнгө итгэмжлэн удирдагчийг дараах тохиолдолд зөрчил гаргасанд тооцож, гэрээг цуцлах арга хэмжээг хэрэгжүүлнэ.
  - 2.1.1. Энэхүү гэрээнд заасан Хөрөнгө итгэмжлэн удирдагчаас үзүүлэх үйлчилгээг гэрээнд зааснаар гүйцэтгээгүй, гүйцэтгэхийг шаардсан хэдий ч зөрчлөө заасан хугацаанд арилгаагүй;
  - 2.1.2. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн гүйцэт, зохих ёсны дагуу гүйцэтгээгүйн улмаас ХБҮЦ эзэмшигчид болон ТЗК-д шууд болон шууд бус хохирол учирсан;
  - 2.1.3. Хөрөнгийн багцыг буруу удирдсан буюу хөрөнгийн багцад зохих өөрчлөлт оруулаагүйгээс ХБҮЦ-ны төлбөр хүрэлцэхгүй болсон, ХБҮЦ эзэмшигчид хугацаандаа төлбөр хүлээн авах боломжгүй нөхцөлийг бий болгосон;
  - 2.1.4. ХБҮЦ эзэмшигчид, эрх бүхий этгээдэд хүргэх мэдээллийг “Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлэх журам”-д заасан хугацаанд удаа дараа мэдээлээгүй.
- 2.2. ТЗК-ийг дараах тохиолдолд зөрчил гаргасанд тооцож, гэрээг цуцлах арга хэмжээг Хөрөнгө итгэмжлэн удирдагч хэрэгжүүлнэ.
  - 2.2.1. Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн үйлчилгээний хөлсийг төлбөр төлөх өдрөөс 10 ба түүнээс дээш хоногоор хэтрүүлсэн.
- 2.3. Гэрээний үүрэг зөрчсөний хариуцлага.
  - 2.3.1. Зөрчил гаргасан тал нь уг зөрчилтэй холбоотой нөгөө талд учирсан хохирлыг





шууд болон шууд бус хохирлыг төлөх үүргийг хүлээнэ.

2.3.2. Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн буруутай үйл ажиллагаанаас хамааран ХБҮЦ-ны төлбөрийг хоцроосон бол хоцроосон одроор тооцон ХБҮЦ эзэмшигчид холбогдох хүүг нэмж толох үүргийг Хөрөнгө итгэмжлэн удирдагч хариуцна.

**3. Эрх шилжүүлэх**

- 3.1. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэхдээ шаардлагатай туслалцаа авах зорилгоор туслах этгээдийг томилон ажиллуулахболомжтой. Энэ тохиолдолд туслах этгээдийн мэдээлэл, гүйцэтгүүлэх ажлыг урьдчилан ТЗК-д мэдэгдсэн байна.
- 3.2. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь өөрийн үзүүлэх үйлчилгээтэй холбоотой туслах этгээд ажиллуулахтай холбоотой зардлыг дангаараа хариуцна.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

**“БЭРС ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК” ХХК-ИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

УЛААНБААТАР ХОТ  
Нэр: Б.Болор-Эрдэнэ  
Албан тушаал: ТУЗ-ийн дарга  
Гарын үсэг:



**“ЮНАЙТЕД АЙР ФАЙНЭНС” ХХК-ИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

Нэр: Х.Маргад-Эрдэнэ  
Албан тушаал: Гүйцэтгэх захирал  
Гарын үсэг:



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ  
MONGOLIAN STOCK EXCHANGE

2023-04-06

БҮРТГЭВ-02


СХ  
2023-04-06  
БҮРТГЭВ  
№ 11

Уг баримт  
2023-04-06  
ХТ-02

Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн үйлчилгээний хөлс

№	Төлбөр төлөх огноо	Төлөх төлбөрийн дүн (төгрөг)
1	2023/04/25	3,000,000.00
2	2023/05/25	3,000,000.00
3	2023/06/26	3,000,000.00
4	2023/07/25	3,000,000.00
5	2023/08/25	3,000,000.00
6	2023/09/25	3,000,000.00
7	2023/10/25	3,000,000.00
8	2023/11/27	3,000,000.00
9	2023/12/25	3,000,000.00
10	2024/01/25	3,000,000.00
11	2024/02/26	3,000,000.00
12	2024/03/25	3,000,000.00
13	2024/04/25	3,000,000.00
14	2024/05/24	3,000,000.00
15	2024/06/25	3,000,000.00
16	2024/07/25	3,000,000.00
17	2024/08/26	3,000,000.00
18	2024/09/25	3,000,000.00
19	2024/10/25	3,000,000.00
20	2024/11/25	3,000,000.00
21	2024/12/25	3,000,000.00
22	2025/01/24	3,000,000.00
23	2025/02/25	3,000,000.00
24	2025/03/25	3,000,000.00





2023 оны 3 дугаар сарын 02-ны өдөр

**ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УДИРДАХ ГЭРЭЭНД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ГЭРЭЭ**

Дугаар: 23/563-01



Улаанбаатар хот

Энэхүү ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УДИРДАХ ГЭРЭЭНД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ГЭРЭЭ (цаашид “Нэмэлт гэрээ” гэх)-г Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйл, Монгол Улсын Иргэний хуулийн 359-368 дугаар зүйлүүдийг тус тус удиртгал болгон сайн дурын үндсэн дээр дор дурдсан талууд

**Нэг талаас:** Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу үүсгэн Монгол Улс, Улаанбаатар хот, СБД, 11-р хороо, 7-р хороолол, Ногоон нуурын гудамж 101 барилга 706 тоот албан ёсны хаягт байрлах регистрийн 6949886 дугаартай “**Бэрс Эй Би Эс Плас ТЗК**” ХХК (цаашид “**Үнэт цаас гаргагч**” эсхүл “ТЗК” гэх), түүнийг төлөөлж Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга Б.Болор-эрдэнэ

**Нөгөө талаас:** Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдсан Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Соёлын төв өргөө 10 давхар, 1005 тоот албан ёсны хаягт байрлах регистрийн 2870657 дугаартай “**Юнайтед Айр Файнэнс**” ХХК (цаашид “**Хөрөнгө итгэмжлэн удирдагч**” гэх), түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал Х.Маргад-Эрдэнэ

- 2023 оны 2-р сарын 09-ний өдрийн 23/563 тоот “Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ” (цаашид “**Үндсэн гэрээ**” гэх)-ний 3.1.6 дахь дараах заалтыг дор дурдсанаар өөрчлөхөөр Талууд тохиролцов:

"3.1.6 ТЗК-ийн төлбөр цуглуулах дансанд цугларсан төлбөрөөр ХБҮЦ-ны төлбөр болон ТЗК-ийн бусад төлбөрийн үүргүүдийг гүйцэтгэх боломжгүй болсон эсхүл, Хөрөнгийн ашиглалт, нөөц хөрөнгийн талаар зөрчил гарвал энэ тухай нэн даруй ТЗК-д буюу ТЗК-ийн ТУЗ-д мэдэгдэх" гэж өөрчлөв.

- Энэхүү Нэмэлт гэрээ нь Үндсэн гэрээний салшгүй хэсэг болно.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

**Үнэт цаас гаргагчийг төлөөлж:**

**Хөрөнгө итгэмжлэн удирдагчийг төлөөлж:**

**“БЭРС ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК” ХХК-ИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ДАРГА  
Б.БОЛОР-ЭРДЭНЭ**

**“ЮНАЙТЕД АЙР ФАЙНЭНС” ХХК-ИЙН**

**ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
Х.МАРГАД-ЭРДЭНЭ**



МОНГОЛЫН ХАРЭНГИЙН БИРЖ  
MONGOLIAN STOCK EXCHANGE

2023-04-06

БҮРТГЭВ-02

СЗХ  
2023 он, 04 сар, 06 өдөр  
БҮРТГЭВ  
№ 01

**ЗАХИРГААНЫ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭ**

2023 оны <sup>06</sup>...-р сарын <sup>09</sup>...-ны өдөр

**“БЭРС ФИНАНС ББСБ” ХХК**

болон

**“БЭРС ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК” ХХК**

Гэрээний дугаар: *20/564*

**УЛААНБААТАР**

Энэхүү ЗАХИРГААНЫ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭ (цаашид “Гэрээ” гэх) -г Монгол Улсын Иргэний хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн холбогдох зүйл заалтыг удиртгай 1 болгон сайн дурын үндсэн дээр 2023 оны 02 дугаар сарын 09-ны өдөр дор дурдсан талууд

Нэг талаас: Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдсан Монгол Улс, Улаанбаатар хот, СБД, 11-р хороо, 7-р хороолол, Ногоон нуурын гудамж 101 барилга 706 тоот албан ёсны хаягт байрлах регистрийн 6186858 дугаартай “Бэрс Финанс ББСБ” ХХК (цаашид “Захиргааны үйлчилгээ үзүүлэгч” эсхүл “ББСБ” гэх), түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал С.ОТГОНБАТ;

Нөгөө талаас: Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдсан Монгол Улс, Улаанбаатар хот, СБД, 11-р хороо, 7-р хороолол, Ногоон нуурын гудамж 101 барилга 706 тоот албан ёсны хаягт байрлах регистрийн 6949886 дугаартай “Бэрс Эй Би Эс Плас ТЗК” ХХК (цаашид “Үнэт цаас гаргагч” эсхүл “ТЗК” гэх), түүнийг төлөөлж Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга Б.БОЛОР-ЭРДЭНЭ нар

дараахь нөхцлийг харилцан тохиролцож байгуулав.

## 1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү Захиргааны үйлчилгээ үзүүлэх гэрээний зорилго нь “Бэрс Эй Би Эс Плас ТЗК” ХХК-ийн өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулахтай холбоотой Захиргааны үйлчилгээ үзүүлэх ажлыг Захиргааны үйлчилгээ үзүүлэгч хийж гүйцэтгэх ТЗК нь ажлын хөлсийг төлөхтэй холбоотой харилцаанд талуудын эдлэх эрх, хүлээх үүргийг тодорхойлоход оршино.

## 2. ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ

- 2.1. Захиргааны үйлчилгээ үзүүлэх гэрээний хүрээнд Захиргааны үйлчилгээ үзүүлэгч нь дараах үйлчилгээг ТЗК-д үзүүлнэ.
- 2.1.1. ТЗК-ийн Хувьцаа эзэмшигчийн хурал болон Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын бэлтгэлийг хангах, ТУЗ-ийн нарийн бичгийн даргын ажил үүргийг гүйцэтгэх;
  - 2.1.2. ТЗК-ийн бичиг хэргийн хөтлөлт буюу албан бичиг хүлээж авах, илгээх;
  - 2.1.3. ТЗК-ийн мөнгөн хөрөнгөөс шаардлагатай мөнгөн гүйлгээг хийж гүйцэтгэхэд ХИУ-д хяналт тавих, шаардлагатай тохиолдолд хамтран ажиллах;
  - 2.1.4. ТЗК-ийн Нягтлан бодох бүртгэлийн хөтлөлтийг холбогдох стандарт, журам, зааврын дагуу хийх, санхүү, татвар, нийгмийн даатгал болон холбогдох бүх тайлан мэдээг хуульд нийцсэн хугацаанд тайлагнаж, хүргүүлэхэд ХИУ-д хяналт тавих, шаардлагатай тохиолдолд хамтран гүйцэтгэх;
  - 2.1.5. Үнэт цаас эзэмшигчийн нэрээр хүүгийн орлогын албан татварыг тайлагнаж;
  - 2.1.6. ТЗК-ийн нэрийн өмнөөс зээлийн хүүгийн төлбөрийн нэмэгдсэн өртгийн албан татварын баримтыг зээлдэгчид хүргүүлэх;
  - 2.1.7. Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаанд шаардлагатай мэдээ мэдээллийг Хөрөнгө итгэмжлэн удирдагчид /цаашид “ХИУ” гэх/ тухай бүр хүргүүлэх;
  - 2.1.8. ТЗК-ийн олон нийтэд хандсан цахим хуудасны хөгжүүлэлт, хөтлөлтийн ажлыг хариуцах;
  - 2.1.9. ТЗК-ийн жилийн үйл ажиллагааны тайлангийн аудитад бэлтгэх, талуудаас баримт бичиг цуглуулж, хөндлөнгийн аудитад хүлээлгэн өгөх, буцаан авах, хөндлөнгийн аудитын дүгнэлтийг хүлээн авч ТУЗ болон ХИУ-д хүргүүлэх;
  - 2.1.10. Жил бүрийн үйл ажиллагааны төсвийн төслийг бэлтгэж ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн батлуулах;
  - 2.1.11. ХБҮЦ-ны хэлцлийн гэрээ болон журамд өөрчлөлт оруулах тохиолдолд тэдгээрийн төслийг бэлтгэн, нэгтгэн баталгаажуулах, ХИУ-д хүлээлгэн өгөх;
  - 2.1.12. ХБҮЦ-ийн багц дахь зээлийн хөрөнгийн буюу хөдлөх хөрөнгийн барьцааны бүртгэлийг хууль тогтоомжийн дагуу эрх бүхий байгууллагад бүртгүүлэх, бүртгэлд өөрчлөлт оруулах, дуусгавар болгох ажлыг зохион байгуулах;
  - 2.1.13. ТЗК-ийн хагас жилийн болон жилийн үйл ажиллагааны тайлангийн мэдээллийг нэгтгэж, ХИУ-д хүргүүлэх;
  - 2.1.14. Зээлдэгчийн зээлийн үүрэг, барьцаа хөрөнгөөр үүргийн гүйцэтгэлийг хангуулахтай холбоотой асуудлаар ТЗК-ийг төлөөлөх;



2023-04-06

2.1.15. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль болон холбогдох бусад журмаар ТЗК-ийн ТУЗ-ийн эрх хэмжээнд хамааруулсан гэрээ болон журмаар зохицуулагдаагүй бусад ажлууд.

- 2.2. ТЗК-ийн байгууллагын тэмдэг, улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм, Тусгай зөвшөөрөл санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан зэрэг баримт бичгийг Захиргааны үйлчилгээ үзүүлэгч оорийн ажлын байранд хадгалах бөгөөд аюулгүй байдал, мэдээллийн нууцлалыг хадгалах үүргийг хүлээж энэ талаар ХИУ, ТУЗ-д баталгаа гаргана.

### 3. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛС

- 3.1 Гэрээгээр үзүүлэх үйлчилгээний хөлсийг сарын 1,500,000 төгрөг байхаар талууд харилцан тохиролцов.
- 3.2 Үйлчилгээний хөлсийг Захиргааны үйлчилгээ үзүүлэгчийн нэхэмжлэхэд үндэслэн Хаан банкны 5028728307 тоот Бэрс Финанс ББСБ нэртэй дансанд сар бүрийн 30 -нд багтаан, уг өдөр амралтын өдөр таарвал дараагийн ажлын өдөрт багтаан шилжүүлнэ.
- 3.3 Энэхүү үйлчилгээний хөлсөнд ажиллах хүчний зардал, Хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдлыг хангах зардал, материалын зардал, тээвэр, татвар хураамж, дотоодын урсгал зардал болон уг ажлыг хийхэд шаардлагатай бүхий л зардлууд багтсан болно.
- 3.4 Талууд харилцан тохиролцож гэрээний хүрээнд үзүүлэх үйлчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд тухайн өөрчлөлт нь ХИУ-ийн үйл ажиллагаанд аливаа хүндрэл үүсгэхгүй байх талаар анхаарна.

### 4. БАТАЛГАА МЭДЭДЭЛ

- 4.1. Захиргааны үйлчилгээ үзүүлэгч нь энэхүү гэрээний үүргийг гүйцэтгэх бүрэн чадамжтайгаа илэрхийлэн ТЗК-д дараах баталгааг гаргаж байна. Үүнд:
- 4.1.1. Үйлчилгээг эрхлэхэд шаардлагатай хүний нөөцийн болон техникийн нөхцөлөөр бүрэн хангагдсан.
- 4.1.2. Байгууллагын зүй зохист удирдлагын зарчим буюу компанийн засаглалын зарчмуудыг үйл ажиллагаандаа мөрддөг, дотоод дүрэм, журмуудад энэ талаар тусгасан;
- 4.1.3. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хорооны “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам”-аар тогтоосон Захиргааны үйлчилгээ үзүүлэгчид тавигдах бусад бүхий л шаардлагыг хангасан болно.
- 4.2. Захиргааны үйлчилгээ үзүүлэгч нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль болон ТЗК-тай байгуулсан гэрээнд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ ямагт ТЗК болон хөрөнгө оруулагчийн эрх ашигт нийцсэн үйл ажиллагаа явуулна.

### 5. ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛГОХ

- 5.1. Захиргааны үйлчилгээ үзүүлэгч гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүй бол тусгай зориулалтын компани нь гэрээг цуцалж, шинэ Захиргааны үйлчилгээ үзүүлэгчтэй гэрээ байгуулах эрхтэй.
- 5.2. Гэрээг цуцалсан тохиолдолд түүнээс хойш 5 хоногийн дотор дараагийн этгээдийг сонгоно. Энэ хугацаанд Захиргааны үйлчилгээ үзүүлэгч үйлчилгээг үргэлжлүүлэн үзүүлнэ.
- 5.3. Захиргааны үйлчилгээ үзүүлэгч нь өөрийн үйл ажиллагааны улмаас ТЗК болон хөрөнгө оруулагчид хохирол учруулсан тохиолдолд өөрийн хөрөнгөөр тэдний өмнө хариуцлага хүлээнэ.

### 6. ГЭНЭТИЙН БОЛОН ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

- 6.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн улмаас тухайлбал (дайн, гал түймэр, үер, газар хөдлөлт, ажил хаялт, гоц халдварт өвчин) зэрэг нөхцөл байдал нь гэрээний үүргийн биелэлтэд шууд нөлөөлсөн нотлогдсон бол талууд энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйн хариуцлагаас бүрэн болон хэсэгчлэн чөлөөлөгдөнө. Энэ үед гэрээний үүрэг биелүүлэх хугацаа нь давагдашгүй хүчин зүйлийн үргэлжлэх хугацаагаар хойшлогдоно.
- 6.2. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал үүссэн тохиолдолд талууд нь энэ нөхцөл байдал болон үүссэн шалтгааны талаар нөгөө талдаа нэн даруй бичгээр мэдэгдэж, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл тохиолдсон ба үүний улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тухайгаа нотлох үүрэг хүлээнэ.

6.3. Гэрээний болон давагдашгүй хүчин зүйлийн талаар тухайн цаг үед нь нөгөө талдаа мэдэгдээгүй бол ирээдүйд уг нөхцөл байдлыг үндэслэл болгох эрхгүй.

БҮРТГЭВ-02

## 7. НУУЦ МЭДЭЭЛЭЛ



- 7.1. Үнэт цаас гаргах ажиллагаа болон Хөрөнгө шилжүүлэх үйл ажиллагаатай холбоотой аливаа мэдээлэл, хөрөнгийн багц болон түүний зээл, барьцаатай холбоотой зээлдэгч болон шаардлага гаргах эрхтэй гуравдагч этгээд, ТЗК, ББСБ-тай холбоотой аливаа мэдээдэл, Үнэт цаас гаргагчийн гуравдагч этгээдтэй байгуулсан гэрээ хэлцэл, тохиролцооо болон тэдгээрээс авч буй үйлчилгээтэй хобоотой аливаа мэдээлэл, Санхүүгийн нөхцөл байдлын тухай аливаа мэдээлэл, санхүүгийн тайлан, зах зээлийн судалгаа, хуулийн этгээдийн бүртгэл болон үүсгэн байгуулах үндсэн баримт бичиг, дүрэм журам, заавар, бодлого, гэрээ хэлцэл этгээрт заасан нөхцөл, мэдээлэл, тоон үзүүлэлт, зураг график зэргийг нууц мэдээлэлд тооцно.
- 7.2. Дээр дурьдсан нууц мэдээлэл гэдэгт нийтэд ил болгосон, эсхүл үнэт цаас гаргах ажиллагааны хүрээнд Үнэт цаасны танилцуулгад тусгаж олон нийтэд танилцуулагдах болон холбогдох хууль журмын дагуу тодорхой этгээдүүдэд танилцуулах мэдээлэл хамаарахгүй болно.
- 7.3. Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны танилцуулга, Биржид хүргүүлсэн бичиг баримт, хөндлөнгийн шинжээчдийн дүгнэлт зэрэг үнэт цаас бүртгүүлэхтэй холбоотой бүхий л бичиг баримтыг Биржийн бүртгэлд бүртгэх тухай шийдвэр гарснаас хойш арван жилийн хугацаанд хадгална.
- 7.4. Талууд хууль тогтоомж төрийн эрх бүхий байгууллага шаардсанаас бусад нууц мэдээллийг бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр аливаа этгээдэд задруулах хэрэглэх эсвэл өөр бусад зорилгоор ашиглахыг хориглох бөгөөд ийнхүү задруулсанаас үүдэн нөгөө талдаа уирсан хохирлыг нөхөн төлөх үүрэг хүлээнэ.

## 8. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

- 8.1. Энэхүү гэрээ байгуулагдах үндсэн зорилго болон үнэт цаас гаргах үйл ажиллагаатай холбоотойгоор Хөрөнгө оруулагчдын эрх ашиг хамгаалах зорилгоор Захиргааны үйлчилгээ үзүүлэгч нь Үнэт цаас гаргагчийн гэрээний үүргийн зөрчилтэй холбоотойгоос бусад тохиолдолд аливаа байдлаар Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх шүүх болон холбогдох төрийн байгууллагад гомдол нэхэмжлэл гаргах болон бусад арга хэмжээ авахгүй байх, төлбөр нэхэмжлэхгүй байх үүрэг хүлээнэ.
- 8.2. Талууд хууль болон бусад дүрэм журмыг дагаж мөрдөөгүйгээс үүссэн хохирол, төлбөр цуглуулах үйлчилгээтэй холбоотой гарсан аливаа маргааныг талууд зөвшилцөх аргаар шийдвэрлэнэ. Хэрэв зөвшилцөх аргаар маргааныг шийдвэрлэж чадахгүй бол Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

## 9. БУСАД ЗҮЙЛ

- 9.1. Энэхүү гэрээг Монгол хэл дээр 4 хувь үйлдэх бөгөөд Захиргааны үйлчилгээ үзүүлэгчид нэг хувь, Үнэт цаас гаргагчид хоёр хувь, Хөрөнгө итгэмжлэн удирдагчид нэг хувийг тус тус хадгалуулна.
- 9.2. Гэрээг талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.
- 9.3. Талуудын аль нэг нь гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах саналаа нөгөө талдаа ажлын 5 өдрийн өмнө мэдэгдэх бөгөөд нэмэлт өөрчлөлтийг зөвхөн бичгээр оруулж талууд гарын үсэг зурж тамга тэмдгээр баталгаажуулсанаар хүчин төгөлдөр болно.
- 9.4. Гэрээний нэмэлт өөрчлөлт нь энэхүү гэрээний салшгүй хэсэг бөгөөд гэрээний нэгэн адил үйлчилнэ.

## ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

“БЭРС ФИНАНС ББСБ” ХХК-ИЙГ  
ТӨЛӨӨЛЖ:

Нэр: С.ОТГОНБАТ

Албан тушаал: Гүйцэтгэх захирал

Гарын үсэг:



“БЭРС ЭЙ БИ ЭС ИЛАС ТЗК” ХХК-  
ИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Нэр: Б.БОЛОР-ОРДЭНЭ

Албан тушаал: ГЗЗ-ийн дарга

Гарын үсэг:



2023-04-06

БЭРС ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК ХХК  
БҮРТГЭВ-02

2023 оны 02 сарын 09 өдөр

СЗХ

сон сар өдөр

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

№ 28/242/05

Улаанбаатар хот


Журам батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76-р зүйлийн 76.1.18 дахь заалт, “Бэрс Эй Би Эс Плас ТЗК” ХХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 4-р зүйлийн 4.3, 4.4.4.11 дэх заалт, “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК-ийн “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 3.2.12-т заасныг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Компанийн үйл ажиллагаанд мөрдөгдөх “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ыг энэхүү тогтоолын Хавсралт 1-ийн дагуу, “Хөндлөнгийн аудитор, үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох, солих журам”-ыг энэхүү тогтоолын Хавсралт 2-ын дагуу, “Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлэх журам”-ыг энэхүү тогтоолын Хавсралт 3-ын дагуу, “Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх журам”-ыг энэхүү тогтоолын Хавсралт 4-ийн дагуу, “Эрсдэл, сонирхлын зөрчлийг илрүүлэх, үнэлэх, удирдах дотоод хяналтын журам”-ыг энэхүү тогтоолын Хавсралт 5-ын дагуу, “Хөрөнгө итгэмжлэн удирдах журам”-ыг энэхүү тогтоолын Хавсралт 6-ын дагуу, “Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам”-ыг энэхүү тогтоолын Хавсралт 7-ын дагуу тус тус баталсугай.

2. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга Б.Болор-Эрдэнэд даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Б.БОЛОР-ЭРДЭНЭ



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ  
MONGOLIAN STOCK EXCHANGE  
2023-04-06  
БҮРТГЭВ-02

2023-04-06  
БҮРТГЭВ  
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЭЖ  
MONGOLIAN STOCK EXCHANGE

2023-04-06

БҮРТГЭВ-02

"Бэрс Эй Би Эс Плас ТЗК" ХХК-ийн  
Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны 4 дугаар  
сарын 28-ны өдрийн 28/..... дугаар тогтоолын 1 хавсралаар  
/24/05



**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ**

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 “Бэрс Эй Би Эс Плас ТЗК” ХХК (цаашид “Компани” гэх)-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам (цаашид “Журам” гэх)-ын зорилго нь Автомашинь фидуци бүхий зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас (цаашид “ХБҮЦ” гэх) гаргахтай холбоотойгоор байгуулагдсан төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн үйл ажиллагааг зохицуулахад оршино.
- 1.2 Энэхүү Журам нь Монгол Улсын Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн Зохицуулах Хороо (цаашид “СЗХ” гэх)-оос баталсан “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам”, Монголын хөрөнгийн биржээс баталсан “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам”, Компанийн дүрэм болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцсэн байна.
- 1.3 Энэхүү Журмаар зохицуулагдаагүй Компанийн үйл ажиллагаатай холбоотой харилцааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн байгуулсан гэрээгээр нарийвчлан зохицуулна.
- 1.4 Энэхүү журмыг тусгай зориулалтын компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх) батлах бөгөөд батлагдсан өдрөөс эхлэн ТУЗ нь үйл ажиллагаандаа дагаж мөрдөнө.

### ХОЁР. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮН

- 2.1 ТУЗ нь 3 гишүүнтэй байх ба нийт гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна.
- 2.2 ТУЗ нь ТУЗ-ийн дарга болон гишүүдээс бүрдэнэ.
- 2.3 ТУЗ-ийн даргыг хуралд оролцож буй бусад гишүүдийн олонхын саналаар сонгоно.
- 2.4 Нарийн бичгийн даргын ажлыг гэрээний үндсэн дээр ТЗК-ийн үүсгэн байгуулагч гүйцэтгэнэ.
- 2.5 ТУЗ-ийн гишүүн нь дор дурдсан шалгуур үзүүлэлтийг хангасан байна. Үүнд:
  - 2.5.1 Компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан;
  - 2.5.2 Эдийн засаг, эрх зүй, нягтлан бодох бүртгэл, банк, санхүү, хөрөнгийн зах зээлийн аль нэг чиглэлээр мэргэжил эзэмшсэн, тухайн салбарт 5-аас доошгүй жил ажилласан туршлагатай;
  - 2.5.3 Санхүүгийн салбартаа эрх бүхий албан тушаалтнаар эсхүл Гүйцэтгэх удирдлагын багт 3 жил ажилласан;
  - 2.5.4 Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан тохиромжтой этгээдийг тодорхойлох журамд заасан шаардлагыг хангасан байх.
- 2.6 ТУЗ-ийн хараат бус гишүүн нь Компанийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1 дэх хэсэгт заасан шалгуурыг хангасан байна.
- 2.7 ТУЗ-ийн гишүүнийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар сонгох бөгөөд нэр дэвшигчийг санал хураалтын ердийн аргаар сонгоно.
- 2.8 ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигч этгээд нь дараах баримт бичгийг бүрдүүлсэн байна. Үүнд:
  - 2.8.1 Анкет;
  - 2.8.2 Боловсрол эзэмшсэн байдлын гэрчилгээ, дипломын хуулбар;
  - 2.8.3 Иргэний үнэмлэхийн хуулбар;
  - 2.8.4 Компанийн засаглалын сургалтад хамрагдсан гэрчилгээний хуулбар;
  - 2.8.5 Бусад шаардлагатай баримт бичиг.
- 2.9 ТУЗ-ийн гишүүнээр сонгогдсон этгээдтэй Нууц хадгалах гэрээг байгуулна.
- 2.10 ТУЗ-ийн гишүүнийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаас Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль болон Компанийн дүрэмд заасан үндэслэлээр компани татан буугдах хүртэл хугацаатай томилно. ТУЗ-ийн гишүүн болон хувьцаа эзэмшигчдийн бичгээр гаргасан саналыг



үндэслэн дараах тохиолдолд ТУЗ-ийн гишүүний бүрэн эрхийг хугацаанаас өмнө дуусгавар болгоно. Үүнд:

- 2.10.1 Хөрөн болон түүнээс дээш сарын хугацаагаар үүргээ гүйцэтгэх боломжгүй тухай гишүүний бичгээр өгсөн санал, эрүүл мэндийн шалтгаанаар ажил үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон;
  - 2.10.2 Гишүүн өөрөө хүсэлт гаргасан;
  - 2.10.3 Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ТУЗ-ийн хуралд дараалан 3 удаа оролцоогүй, эсхүл нэг жилд хуралдсан нийт хурлын 1/3 болон түүнээс дээш тоогоор оролцоогүй болохыг хувьцаа эзэмшигчдийн хурлаас тогтоосон;
  - 2.10.4 ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байх хугацаандаа эдийн засаг, албан тушаалын, санхүү, татвар, үнэт цаасны зах зээлийн үйл ажиллагаатай холбоотой эрүүгийн болон захиргааны шийтгэл хүлээсэн болох нь тогтоогдсон;
  - 2.10.5 Хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхлын зөрчилтэй байгууллагад давхар ажил эрхлэн болон гэрээт үүрэг гүйцэтгэгч болсон нь тогтоогдсон.
  - 2.10.6 Бусад
- 2.11 ТУЗ-ийн гишүүнийг чөлөөлсөн буюу түүний бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө хувьцаа эзэмшигчдийн хурлаас дуусгавар болгосон тохиолдолд энэ Журамд заасны дагуу нэр дэвшүүлж шинэ гишүүнийг хувьцаа эзэмшигчдийн хурлаас сонгож батална.

#### **ГУРАВ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭН ЭРХ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**


- 3.1 **Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах асуудлаар ТУЗ нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:**
  - 3.1.1 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах,
  - 3.1.2 Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг батлах;
- 3.2 Компанийн дүрэмд заасны дагуу ТУЗ нь Компанийн үйл ажиллагаанд хяналт тавина. ТУЗ-ийн үйл ажиллагааны хэлбэр нь хурал хэлбэртэй байна.
- 3.3 **ТУЗ нь Компанийн үйл ажиллагааг удирдах, хянах ажлын хүрээнд дараах журмыг батална. Үүнд**
  - 3.3.1 ХБҮЦ-ны хөрөнгийн багцыг сонгох шалгуур үзүүлэлтийг батлах;
  - 3.3.2 Хөндлөнгийн аудитор, Үйлчилгээ үзүүлэгч, Хөрөнгө итгэмжлэгдсэн удирдагчийг сонгох, солих тухай журам;
  - 3.3.3 Хөрөнгө итгэмжлэн удирдах журам;
  - 3.3.4 Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлэх тухай журам;
  - 3.3.5 Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлөх журам;
  - 3.3.6 Эрсдэл сонирхлын зөрчлийг илрүүлэх, үнэлэх, удирдах, дотоод, хяналтын журам;
  - 3.3.7 Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам.
- 3.4 **ТУЗ нь Компанийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх гуравдагч этгээдтэй дараах гэрээг байгуулна. Үүнд:**
  - 3.4.1 Хөрөнгө худалдан авахтай холбоотой гэрээг анхны үүрэг гүйцэтгэгчтэй байгуулах;
  - 3.4.2 ХБҮЦ гаргах ажиллагааны хамтран оролцогч болох Андеррайтер, Хуулийн нөхөрлөл, Зээлийн шинжилгээ гаргах аудит, Хөрөнгө итгэмжлэгдэн удирдагч нартай хамтран ажиллах гэрээ байгуулах;
  - 3.4.3 Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж, ҮЦТХТ болон бусад байгууллагын өмнө компанийг төлөөлөн өргөдөл, хүсэлт, гаргах, шаардлагатай гэрээ байгуулах;
  - 3.4.4 Компанийн нэрийн данс нээлгэх, холбогдох гэрээ байгуулах;

2023-04-06

3.4.5 Хууль болон компанийн дүрмээр хориглоогүй, шаардлагатай бусад гэрээ хэлцэл хийх;

БҮРТГЭВ-02

3.5 ХБҮЦ гаргахтай холбоотой асуудлаар ТУЗ нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:



- 3.5.1 ХБҮЦ гарган татан төвлөрүүлсэн эх үүсвэрийн зарцуулалттай танилцах, эх үүсвэрийг үнэт цаасны танилцуулгад тусгасны дагуу зарцуулахыг шаардах;
- 3.5.2 Хөрөнгө оруулагч харилцагчдын эрх ашгийг хамгаалах, хөрөнгийн бүртгэлийг хянах;
- 3.5.3 Хөрөнгө итгэмжлэгдэн удирдагч нь хөрөнгийн ашиглалт, нөөц хөрөнгийн талаар зөрчил гаргасан тохиолдолд шаардлагатай холбогдох арга хэмжээг авах үүнтэй холбоотой шийдвэр гаргах;
- 3.5.4 Үйлчилгээ үзүүлэгч, Хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох, хөндлөнгийн аудитыг сонгох;
- 3.5.5 Хөрөнгө итгэмжлэгдэн удирдагчтай байгуулсан гэрээний дагуу тогтмол тайлан хүлээх авах, тэдгээрийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавих;
- 3.5.6 ХБҮЦ гаргах ажиллагаа болон оролцогчидтой холбоотой бусад арга хэмжээ, үүнтэй холбоотой шийдвэр гаргах;
- 3.5.7 СЗХ-д хүргүүлэх Үнэт цаасны танилцуулгад ТУЗ-ийн дарга, гишүүд гарын үсэг зурж, мэдээллийн үнэн зөвийг баталгаажуулах, Компанийн худалдан авсан зээлийн хөрөнгөд үйлчилгээ үзүүлж буй этгээдийн гүйцэтгэлийг хянах, үйлчилгээ үзүүлэгчтэй байгуулсан, эсхүл эрх бүхий байгууллагаас үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааг түдгэлзүүлсэн, хязгаарласан тохиолдолд тэдгээрийг солих;
- 3.5.8 Хөрөнгийг бүртгэлээс хасах, нэмэх;
- 3.5.9 Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргах, хөрөнгө оруулагчдад хүргэх мэдээлэл тайлангийн үнэн зөв байдалд хяналт тавих;
- 3.5.10 Компанийн дүрэм, ХБҮЦ гаргах өргөдөл, баталгаат Үнэт цаасны танилцуулгад заасан шаардлагын биелэлтийг хангуулах;
- 3.5.11 Компанийн нэр дээр банкны данс нээлгэх, аудит болон санхүүгийн тайлантай танилцах, хэлэлцэх болон Компанийн зардлын төсвийг батлах;
- 3.5.12 Хөрөнгө оруулагчдаас болон эрх бүхий зохицуулах төрийн байгууллагаас хүсэлт ирүүлсэн даруйд холбогдох мэдээллийг тэдгээрт цаг тухайд нь хүргэх.

3.6 ТУЗ нь дараах үүргийг хүлээнэ. Үүнд:


- 3.6.1 Компанийн дүрмийн хэрэгжилтийг хангах, хангуулах;
- 3.6.2 Компанийн дүрэм, Үнэт цаасны танилцуулга, ХБҮЦ гаргах, компани байгуулагдсан гэдэгт баталгаа гаргах;
- 3.6.3 Компанийн хөрөнгийг хадгалж хамгаалах;
- 3.6.4 Хөрөнгө оруулагч болон бусад эрх бүхий этгээдэд мэдээллийг тогтмол цаг тухайд нь хүргэх;
- 3.6.5 Үнэт цаасны танилцуулгад тусгасан шаардлагын биелэлтийг хангах;
- 3.6.6 Хууль, журам болон энэхүү дүрэмд заасан бусад үүрэг;

3.7 ТУЗ-ийн дарга дараах эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ. Үүнд:

- 3.7.1 ТУЗ-ийн ажлыг зохион байгуулж, ТУЗ-ийн хурлаар хэлэлцэх асуудлаар гишүүд үзэл бодлоо чөлөөтэй солилцох, нээлттэй хэлэлцэх нөхцөлийг бүрдүүлэх;
- 3.7.2 ТУЗ-ийн хурлыг даргалах, санал хураалтыг явуулах, хурлаар хэлэлцэх асуудал бүрээр шийдвэр гаргах ажлыг зохион байгуулах;
- 3.7.3 Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд оруулах ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланг бэлтгэх ажлыг зохион байгуулан хэрэгжүүлэх;

2023-04-06

3.7.4 Хууль болон энэ журамд заасан эрх, үүргийг бусад гишүүдийн адил эдлэх;  
3.7.5 ТУЗ-ийн даргыг түр эзгүйд түүний үүргийг ТУЗ-ийн даргын, эсхүл ТУЗ-ийн гишүүн гүйцэтгэнэ.




- 3.8 ТУЗ-ийн гишүүн дараах эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ. Үүнд:**
- 3.8.1 Аливаа шийдвэр гаргахаас өмнө шаардлагатай мэдээлэлтэй танилцах;
  - 3.8.2 ТУЗ-ийн хурлын үйл ажиллагаанд тогтмол, идэвхтэй оролцох;
  - 3.8.3 ТУЗ-ийн хурлаар хэлэлцэх асуудлаар өөрийн авсан мэдээлэл, мэдлэг боловсрол, ажлын туршлагад тулгуурлан үндэслэл бүхий санал өгөх;
  - 3.8.4 ТУЗ-ийн хуралд биечлэн оролцох бөгөөд хүндэтгэн үзэх шалтгааны улмаас биечлэн оролцох боломжгүй, эсхүл хоцорч оролцох тохиолдолд энэ талаар ТУЗ-ийн дарга болон нарийн бичгийн даргад урьдчилан мэдэгдэх;
  - 3.8.5 Ашиг сонирхлын зөрчил илэрсэн тохиолдолд энэ талаараа нэн даруй мэдэгдэх,
  - 3.8.6 ТУЗ-ийн дарга болон гишүүд нь нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалтыг Компанид гаргаж өгөх;
  - 3.8.7 ТУЗ-ийн гишүүд нь хурлын тогтоол болон тэмдэглэлд компанийн байранд хүрэлцэн ирж гарын үсэг зурж, баталгаажуулах үүрэгтэй.
- 3.9 ТУЗ-ийн хараат бус гишүүн нь энэ Журмын 3.8 дахь хэсэгт зааснаас гадна дараах эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ. Үүнд:**
- 3.9.1 Компанийн дүрэм, журамд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хяналт тавьж, ТУЗ-ийн зарим үйл ажиллагааг хараат бусаар баталгаажуулах;
  - 3.9.2 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд хүсэлт гаргах замаар биечлэн оролцож, ТУЗ-ийн зарим шийдвэрийн талаар зарчмын зөрүүтэй байр суурьтай байсан тухайгаа мэдээлэх, Хувьцаа эзэмшигчдээс асуусан асуултад хариу өгөх, тайлбар хийх;
- 3.10 ТУЗ-ийн хараат бус гишүүн нь Компанийн үйл ажиллагаанд ТУЗ-ийн зүгээс тавих хяналтыг үр ашигтай байлгах, гарч болзошгүй сонирхлын зөрчлийг зөв зохистой шударга шийдвэрлэх, хувьцаа эзэмшигчдээс хараат бус байж, шаардлагатай тохиолдолд тэдэнд зөвлөмж, зөвлөгөө өгнө.
  - 3.11 ТУЗ-ийн гишүүд хурлаар хэлэлцэх асуудлаар шийдвэр гаргахад шаардагдах бүх мэдээллийг авах эрхтэй бөгөөд шаардлагатай тохиолдолд хөндлөнгийн мэргэжилтэн, шинжээчийн дүгнэлт, зөвлөмж, саналыг Компанийн зардлаар гаргуулан авна.
  - 3.12 **ТУЗ-ийн үйл ажиллагааны үндсэн зохион байгуулалтын хэлбэр нь хурал байна.** ТУЗ-ийн хуралнь ээлжит болон ээлжит бус байна.
  - 3.13 ТУЗ нь Компанийн дүрмийн 4.4.5-д заасны дагуу хуралдах хурлын хуваарийг батална.
  - 3.14 ТУЗ-ийн ээлжит хурлыг улирал тутамд нэгээс доошгүй удаа хуралдуулах бөгөөд шаардлагатай тохиолдолд ТУЗ-ийн дарга, Анхны үүрэг гүйцэтгэгч, Хөрөнгө итгэмжлэн удирдагч эсхүл ТУЗ-ийн гишүүдийн олонхын саналаар ээлжит бус хурлыг хуралдуулж болно.
  - 3.15 ТУЗ-ийн хурлыг биечилсэн болон цахим хэлбэрээр хуралдуулна.
  - 3.16 ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн биечлэн хуралдах хурлын зарыг ажлын 3 хоногийн өмнө тухайн хурлаар хэлэлцэх асуудал, холбогдох мэдээлэл, материалын хамт ТУЗ-ийн гишүүдийн ТЗК-ийн цахим шуудан /цаашид “албаны и-мэйл” гэх/-ийн хаягаар хүргүүлнэ.
  - 3.17 ТУЗ-ийн хурлыг Монгол хэлээр явуулна. Хурлын тэмдэглэлийг Монгол хэлээр хөтөлж баталгаажуулна.
  - 3.18 ТУЗ-ийн хурлаар аливаа асуудлыг шийдвэрлэхэд гишүүн бүр саналын нэг эрхтэй байна.
  - 3.19 ТУЗ-ийн хурал гишүүдийн дийлэнх олонх нь оролцсоноор хүчин төгөлдөр болох бөгөөд ТУЗ-ийн шийдвэр нь хуралд оролцсон гишүүд санал нэгтэй дэмжсэнээр хүчин төгөлдөр болно.
  - 3.20 Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас ТУЗ-ийн хуралд биечлэн оролцоогүй гишүүдийн ТУЗ-ийн хурал эхлэхээс өмнө бичгээр эсхүл цахимаар ирүүлсэн саналыг үндэслэн хурлын ирц бүрдүүлэх, санал хураалтын үр дүнг тооцож болно.
  - 3.21 ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олонх нь хуралд биечлэн оролцох боломжгүй болсон хэдий ч тэдгээр нь хурал эхлэхээс өмнө саналаа ирүүлсэн байх тохиолдолд ТУЗ-ийн үлдсэн гишүүний



2023-04-06


саналаар ТУЗ-ийн хурлыг хуралдуулж болно.



- 3.22 ТУЗ-ийн гишүүд хуралд биечлэн оролцох боломжгүй тохиолдолд хурлыг цахим хэлбэрээр хуралдуулж болно. Цахим хурлыг дараах байдлаар явуулна:
- 3.22.1 Нарийн бичгийн дарга нь энэхүү Журмын 3.14 дэх хэсэгт заасан эггээдийн хүсэлтийн дагуу ТУЗ-ийн даргын зөвшөөрлөөр ТУЗ-ийн цахим хурлыг зарлаж, хурлын материал, шийдвэрийн төсөл, санал өгөх хугацааг ТУЗ-ийн гишүүдийн албаны и-мэйл хаягаар хүргүүлнэ. ТУЗ-ийн дарга цахим хурлыг хуралдуулахаас татгалзсан тохиолдолд биечилсэн хурлаар асуудлыг шийдвэрлэнэ.
  - 3.22.2 Цахим хурлаар хэлэлцэж буй асуудлын хүрээнд ТУЗ-ийн гишүүд хурлын зар хүргүүлснээс хойш ажлын 3 хоногийн дотор “зөвшөөрсөн”, “татгалзсан”, “түдгэлзсэн” гэх агуулгыг илэрхийлсэн саналыг ирүүлж, шийдвэр гаргалтад оролцоно.
  - 3.22.3 Нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн гишүүдийн цахимаар ирүүлсэн саналыг нэгтгэн, ТУЗ-ийн гишүүдийн ирүүлсэн саналын дагуу ТУЗ-ийн цахим хурлын шийдвэрийг бэлтгэн, албажуулна.
  - 3.22.4 ТУЗ-ийн цахим хурлын шийдвэрийг хурлын тэмдэглэлийн хамт хурлын материалд хавсаргана.
  - 3.22.5 Цахим хурлын тэмдэглэлд хурал зарласан огноо, санал хураалт дуусах огноо, хурлаар хэлэлцсэн асуудал, гишүүдийн ирүүлсэн саналын агуулга, гишүүд саналаа өөрийн албаны и-мэйл хаягаас явуулсан гэдгийг нотлох баримт болон гаргасан шийдвэрийг тусгана.
  - 3.22.6 Цахим хурлын тэмдэглэлийг хурлын тэмдэглэлтэй нэгэн адил үзнэ.
- 3.23 ТУЗ нь эчнээ санал хураалтаар шийдвэр гаргаж болох бөгөөд ТУЗ-ийн хурлыг эчнээ санал хураалтаар явуулах тохиолдолд хурлын мэдэгдэл, хэлэлцэх асуудал болон холбогдох материалыг саналын хуудасны хамтаар хурал хуралдахаас ажлын 3-аас доошгүй хоногийн өмнө хүргүүлнэ.
- ТУЗ-ийн гишүүд эчнээ санал хураалтын мэдэгдэл болон саналын хуудсыг хүлээж авснаас хойш ажлын 3 хоногийн дотор саналаа ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар дамжуулан ТУЗ-ийн даргад хүргүүлнэ. Саналын хуудсыг цахим хэлбэрээр хүргүүлж болно. Хэрэв ТУЗ-ийн гишүүн энэ хугацаанд багтаан саналаа ирүүлээгүй тохиолдолд түүнийг тухайн асуудлаар зөвшөөрсөн санал ирүүлсэнд тооцно.
- 3.24 ТУЗ-ийн хурлын шийдвэр нь Тогтоол хэлбэртэй байх бөгөөд хуралд оролцсон ТУЗ-ийн гишүүд гарын үсэг зурж баталгаажуулна.
  - 3.25 ТУЗ-ийн хурлын тэмдэглэл нь хураангуй байх бөгөөд нарийн бичгийн дарга зөвхөн хурлаар хэлэлцсэн асуудлаар хөтөлнө. Хурлын тэмдэглэлийг хурал хийснээс хойш ажлын 5 өдрийн дотор бэлэн болгож хуралд оролцсон гишүүд нь хүрэлцэн ирж тэмдэглэлд гарын үсэг зурна.
  - 3.26 ТУЗ-ийн хурлын дарга тэмдэглэлийн үнэн зөвийг хариуцах бөгөөд ТУЗ-ийн гишүүдийн бичгээр ирүүлсэн саналыг хурлын тэмдэглэлд хавсаргана.
  - 3.27 ТУЗ-ийн хурлын тэмдэглэлд дараах зүйлийг тусгана:
    - 3.27.1 хурал хуралдсан газар, өдөр, цаг,
    - 3.27.2 хуралд оролцсон гишүүд,
    - 3.27.3 хурлаар хэлэлцсэн асуудал,
    - 3.27.4 санал хураалтаар шийдвэрлэсэн асуудал болон санал хураалтын дүн,
    - 3.27.5 гаргасан шийдвэр.
  - 3.28 ТУЗ-ийн хурлын тэмдэглэлийг буруу хөтөлсөн нь тухайн хурлаас гаргасан шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл болохгүй.
  - 3.29 ТУЗ-ийн дарга болон гишүүд нь Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлд заасны дагуу эрх бүхий албан тушаалтанд тооцогдох бөгөөд мөн хуулийн 85 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээнэ.
- 3.30 Компани нь хөдөлмөрийн гэрээгээр ажилтан авч ажиллуулахгүй ба ХБҮЦ гаргахтай холбоотой

2023-04-06  
БҮРТГЭВ-02

үйлчилгээг гэрээний үндсэн дээр үүсгэн байгуулагч болон бусад гуравдагч этгээдээр гүйцэтгүүлнэ. ТУЗ нь Компанийг төлөөлж гэрээ байгуулна.



### **ДӨРӨВ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНИЙ АЖЛЫН НӨХЦӨЛ, ХАНГАМЖ**

- 4.1 Компани нь компанийн хувьцаа эзэмшигчийн ажлын байранд үйл ажиллагаа явуулах бөгөөд албан ёсны хаяг нь Бэрс финанс ББСБ ХХК-ийн үндсэн үйл ажиллагаа явуулж байгаа хаяг байна.
- 4.2 ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн гишүүнээс урьдчилан мэдэгдсэн тохиолдолд хурлын материал, шаардлагатай мэдээ, мэдээлэлтэй танилцах боломжтой ажлын байр гаргаж өгөх үүрэгтэй.
- 4.3 Үүсгэн байгуулагч нь ТУЗ-ийн гишүүн бүрд цахим шуудангийн хаяг нээж өгөх бөгөөд тухайн албан ёсны хаягаар харилцаж ажиллана.
- 4.4 Компанийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм, журам, татварын гэрчилгээ, тусгай зөвшөөрөл, санхүүгийн болон хууль зүйн баримт бичиг болон холбогдох бусад бүхий л баримт бичиг, Компанийн тамга тэмдэг, Компанид хамааралтай бусад эд хөрөнгө, зүйл, хогшил нь хувьцаа эзэмшигчийн ажлын байранд зохих бүртгэлтэйгээр хадгалагдана.
- 4.5 ТУЗ-ийн гишүүдийн цалинг улирал бүр ТУЗ-ийн хуралд оролцсон эсэхийг харгалзан тооцож олгож болох бөгөөд олгох тохиолдолд Компанийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.4-т заасны дагуу холбогдох төсвийг Компанийн зардалд тусгаж ХЭХ-аас батална. Цалин, урамшууллын нийт төсвийн зарцуулалтад ХЭХ-аас хяналт тавина.
- 4.6 ТУЗ-ийн үйл ажиллагаатай холбоотой зардлыг Компани хариуцах бөгөөд ХЭХ-аас баталснаас бусад зардлыг Компанийн ТУЗ-ийн гишүүн өөрөө хариуцна.

#### **ТАВ. БУСАД**

- 5.1 Энэхүү журам Компанийн ТУЗ-өөс баталсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 5.2 Энэхүү журамд нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд уг нэмэлт, өөрчлөлт нь Компанийн ТУЗ-өөс баталсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

\_\_\_оо\_\_\_

МОНГОЛЫН ДӨРӨНГИЙН БИРЖ  
MONGOLIAN STOCK EXCHANGE  
2023-04-06  
БҮРТГЭВ-02

СЭХ  
он сар өдөр  
БҮРТГЭВ  
№ 01





"Бэрс Эй Би Эс Плас ТЭК" ХХК-ийн  
Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны 04 дүрвэн 06  
өдрийн 03/ дугаар тогтоолын 2 хавсралт  
/24/05

**ХӨНДЛӨНГИЙН АУДИТОР, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ,  
ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УДИРДАГЧИЙГ СОНГОХ,  
СОЛИХ ТУХАЙ ЖУРАМ**

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ


- 1.1. “Бэрс Эй Би Эс Плас ТЗК” ХХК (цаашид “Компани” гэх)-ийн Хөндлөнгийн аудитор, Үйлчилгээ үзүүлэгч, Хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох, солих тухай журам (цаашид “Журам” гэх)-ын зорилго нь холбогдох этгээдүүдэд тавигдах шаардлага, шалгуур, гэрээ байгуулах, тэдгээрийг солих болон гэрээ цуцлахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Компани нь хөндлөнгийн аудитор, үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох, солих, тэдгээртэй гэрээ байгуулах болон холбогдох бусад үйл ажиллагаанд Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам, Монголын хөрөнгийн биржийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам болон Компанийн Дүрэмд заасныг тус тус баримтлан ажиллана.

### ХОЁР. ХӨНДЛӨНГИЙН АУДИТОРТ ТАВИГДАХ ШААРДЛАГА

- 2.1. Хөндлөнгийн аудитор нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэгт заасны дагуу ХБҮЦ гаргагчийн үйл ажиллагаанд хөндлөнгийн аудит хийх эрхтэй байх бөгөөд дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
  - 2.1.1. Аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байх;
  - 2.1.2. Аудитын компанийн хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан нь Компанитай нэгдмэл сонирхолтой этгээд биш байх;
  - 2.1.3. Аудитын үйл ажиллагааг тасралтгүй 3 болон түүнээс дээш жил эрхэлсэн байх;
  - 2.1.4. Аудитын тухай хуулийн 17 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан 5-аас доошгүй орон тооны аудитортой байх;
  - 2.1.5. Банк, санхүү, үнэт цаасны зах зээл, компанийн засаглал, санхүүгийн байгууллагад хийх аудитын тодорхой түвшний сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан 3 ба түүнээс дээш орон тооны аудитортой байх;
  - 2.1.6. Аудиторууд нь мэргэжлийн ёс зүйн алдаа дутагдал гаргаж байгаагүй;
  - 2.1.7. Хорооноос шаардлагатай гэж үзсэн бусад.

### ГУРАВ. ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- 3.1. Үйлчилгээ үзүүлэгч нь анхны үүрэг гүйцэтгүүлэгч байж болно.
- 3.2. Үйлчилгээ үзүүлэгч нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт заасан этгээд байх бөгөөд дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
  - 3.2.1. Банк, банк бус санхүүгийн байгууллага, орон сууцны санхүүжилтийн компани болон Хорооноос зөвшөөрсөн бусад санхүүгийн байгууллага байх;
  - 3.2.2. Үйлчилгээ үзүүлэгч хуулийн этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ нь 1 тэрбум төгрөг байх;
  - 3.2.3. Банк, санхүүгийн зах зээл дээр тасралтгүй 3 болон түүнээс дээш жил үйл ажиллагаа явуулсан туршлагатай байх;
  - 3.2.4. Үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай хүний нөөцийн болон нягтлан бодох бүртгэл, тайлан тооцоо гаргах техникийн нөхцөлөөр хангагдсан байх;
  - 3.2.5. Хорооноос баталсан компанийн засаглалын кодексыг үйл ажиллагаандаа мөрддөг,



- дотоод дүрэм журмуудад энэ талаар тусгасан байх;
- 3.2.6. Гурваас доошгүй гишүүдээс бүрдсэн ТУЗ-тэй байх бөгөөд тэдгээрийн гуравны нэг нь хараат бус гишүүн байх, компанийн үйл ажиллагааг олон нийтэд ил тод, нээлттэй тайлагнадаг байх;
  - 3.2.7. ТУЗ-ийн дарга, гүйцэтгэх захирал, Компанид үйлчилгээ үзүүлэх хоёроос доошгүй мэргэжилтнүүд нь санхүүгийн зах зээл дээр тасралтгүй нэг ба түүнээс дээш жил үйл ажиллагаа явуулсан туршлагатай байх;
  - 3.2.8. Тусгай зөвшөөрөлтэй этгээд бол төрийн эрх бүхий байгууллагаас баталсан зохистой харьцааны шалгуурыг хангаж ажилласан, засаглал, мэдээлэл тайлагналын ил тод байдлыг хангасан этгээд байх.
- 3.3. Үйлчилгээ үзүүлэгч нь өөрийн үйл ажиллагааны улмаас Компанид болон хөрөнгө оруулагч нарт хохирол учруулсан бол өөрийн хөрөнгөөр хариуцлага хүлээх бөгөөд Компанитай сонирхлын зөрчил үүсгэхгүй байна.

#### **ДӨРӨВ. ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УДИРДАГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА**


- 4.1 Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь хөрөнгө итгэмжлэн удирдагч байхыг хориглоно.
- 4.2 Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 20 дугаарзүйлийн 20.1, 20.2 дахь хэсэгт заасан этгээд байх бөгөөд дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
  - 4.2.1 Хөрөнгө итгэмжлэн удирдах тусгай зөвшөөрөл авсан байх;
  - 4.2.2 Банк, санхүүгийн зах зээлд гурваас доошгүй жил үйл ажиллагаа явуулсан туршлагатай байх;
  - 4.2.3 Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагааг явуулахад шаардлагатай хүний нөөцийн болон нягтлан бодох бүртгэл, тайлантооцоо гаргах, программ, техник хангамжийн нөхцөлөөр хангагдсан байх;
  - 4.2.4 Эрх бүхий албан тушаалтан, ХИУ үйл ажиллагааг хариуцах мэргэжилтэн нь Хорооноос баталсан тохиромжтой этгээдийн журмын шаардлагыг хангасан байх;
  - 4.2.5 Гүйцэтгэх захирал, ХИУ үйл ажиллагааг хариуцсан мэргэжилтэн нь үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил үйлчилгээ явуулах эрх авсан байх.

#### **ТАВ. ХӨНДЛӨНГИЙН АУДИТОР, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ, ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УДИРДАГЧИЙГ СОНГОХ**

- 5.1. Энэхүү Журамд заасан Хөндлөнгийн аудитор, Үйлчилгээ үзүүлэгч, Хөрөнгө итгэмжлэн удирдагчид тавигдсан шаардлагыг хангаж буй этгээдийг сонгох эсэхийг ТУЗ-ийн хурлаар шийдвэрлэнэ. Энд дурдсан хуулийн этгээдийг сонгох шийдвэр гаргахад ТУЗ-ийн үйл ажиллагааны журмыг баримтална.
- 5.2. ТУЗ нь Журмын 5.1 дэх хэсэгт заасан этгээдийг сонгохдоо хууль, журам болон энэхүү Журамд заасан шаардлагыг хангаж буй эсэхэд хяналт тавьж, хараат бусаар шийдвэр гаргана.
- 5.3. Журмын 5.1 дэх хэсэгт заасан этгээдтэй байгуулах гэрээнд Компанийг төлөөлж ТУЗ-ийн дарга гарынүсэг зурна.
- 5.4. Компанид үйлчилгээ үзүүлэхээр сонгогдсон Хөндлөнгийн аудитор, Үйлчилгээ үзүүлэгч, Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн талаар Хороонд мэдэгдэнэ.



- 6.1. Хөндлөнгийн аудитортай байгуулах гэрээнд дараах агуулгыг заавал тусгасан байна. Үүнд:
- 6.1.1. Компанийн үйл ажиллагаанд жилд нэгээс доошгүй удаа аудит хийх;
  - 6.1.2. Аудитын шалгалт хийх цар хүрээ нь Хорооны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журмын 10.3 дахь хэсэгт заасныг хамарсан байх тухай;
  - 6.1.3. Үйлчилгээний хөлс;
  - 6.1.4. Талуудын эрх үүрэг;
  - 6.1.5. Талуудын хариуцлага;
  - 6.1.6. Гүйцэтгэх хугацаа;
  - 6.1.7. Үр дүнг хүлээлгэн өгөх;
  - 6.1.8. Гэрээ цуцлах үндэслэл, дуусгавар болгох журам;
  - 6.1.9. Давагдашгүй хүчин зүйлд авах талуудын авах арга хэмжээ;
  - 6.1.10. Гэрээнд хэрэглэх хэл, хэрэглэх хууль, маргаан шийдвэрлэх харьяалал.
- 6.2. Үйлчилгээ үзүүлэгчтэй байгуулах гэрээнд дараах агуулгыг заавал тусгасан байна. Үүнд:
- 6.2.1. Талуудын эрх үүрэг;
    - 6.2.1.1. Компани нь дүгнэлт гаргахад шаардагдах мэдээлэл, бичиг баримтыг бүрэн ирүүлэхүүрэгтэй болохыг;
    - 6.2.1.2. Үйлчилгээ үзүүлэгч нь хөрөнгийн багцад багтсан зээлийн зээлдэгч нартай харилцах, төлбөр цуглуулах, зээлдэгчийн өмнө Компанийг төлөөлөх үүрэгтэй болохыг;
    - 6.2.1.3. Үйлчилгээ үзүүлэгч нь зээлийн бүртгэл, дансанд хяналт хийж, компанид тайлагнах, тулгах үүрэгтэй болохыг;
    - 6.2.1.4. Үйлчилгээ үзүүлэгч нь хөрөнгийн багцад багтсан зээлийн мэдээллийг хадгалах үүрэгтэй болохыг;
    - 6.2.1.5. Үйлчилгээ үзүүлж буй этгээд нь дүгнэлт гаргахын тулд холбогдох бичиг баримтыг бүрэн судалж, зохих стандартын дагуу үйл ажиллагаа явуулах, гаргасан дүгнэлтийнхээ хариуцлагыг бүрэн хүлээх тухай;
    - 6.2.1.6. Үйлчилгээ үзүүлэгч нь өөрийн үйл ажиллагааны улмаас Компанид болон хөрөнгө оруулагч нарт хохирол учруулсан бол өөрийн хөрөнгөөр хариуцлага хүлээх бөгөөд Компанитай сонирхлын зөрчил үүсгэхгүй байна.
  - 6.2.2. Цуглуулсан төлбөрийг компанид шилжүүлэх зарчим;
  - 6.2.3. Үйлчилгээний хөлс;
  - 6.2.4. Талуудын хариуцлага;
  - 6.2.5. Гэрээ цуцлах үндэслэл, журам;
  - 6.2.6. Давагдашгүй хүчин зүйлд авах талуудын авах арга хэмжээ;
  - 6.2.7. Гэрээнд хэрэглэх хэл, хэрэглэх хууль, маргаан шийдвэрлэх харьяалал.
- 6.3. Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай байгуулах гэрээнд дараах агуулгыг заавал тусгасан байна. Үүнд:
- 6.3.1. Үйлчилгээний хөлс;
  - 6.3.2. Хөрөнгийн барьцаа, баталгаагаар хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, барьцаа хөрөнгөөр үүргийн гүйцэтгэлийг хангуулах чиглэлээр үйлчилгээ үзүүлэгчийг шүүхэд нэхэмжлэл гаргахыг мэдэгдэж, хэрэгжилтэд хяналт тавих болон бусад авах шаардлагатай авах арга хэмжээний тухай;
  - 6.3.3. Үүрэг гүйцэтгэгч хууль тогтоомж болон гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн тохиолдолд хөрөнгө оруулагч болон компанийн эрхийг баталгаажуулах арга хэмжээ авах тухай;



- 6.3.4. Хөрөнгийн ашиглалт, нөөц хөрөнгийн талаар зөрчил гарвал энэ тухай нэн даруй ТЗКийн ТУЗ-д мэдэгдэх зохицуулалт;
- 6.3.5. Талуудын эрх үүрэг;
- 6.3.6. Хөрөнгийн ашиглалт, нөөц хөрөнгийн талаар зөрчил гарвал энэ тухай ТУЗ-д мэдэгдэх талаар;
- 6.3.7. Талуудын хариуцлага;
- 6.3.8. Гэрээ цуцлах үндэслэл, журам;
- 6.3.9. Давагдашгүй хүчин зүйл тохиолдсон үед талуудын авах арга хэмжээ;
- 6.3.10. Гэрээнд хэрэглэх хэл, хэрэглэх хууль, маргаан шийдвэрлэх харьяалал.

### **ДОЛОО. ХӨНДЛӨНГИЙН АУДИТОР, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ, ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УДИРДАГЧИЙГ СОЛИХ**

- 7.1. Энэхүү Журамд заасан Хөндлөнгийн аудитор, Үйлчилгээ үзүүлэгч, Хөрөнгө итгэмжлэн удирдагчид тавигдах шалгуурыг хангахгүй болсон, гэрээ цуцлах үндэслэл бий болсон, тохиолдолд тус тусын гэрээнд заасан журмын дагуу гэрээг цуцална.
- 7.2. Компани нь гэрээ цуцлах үндэслэл бий болсон гэж үзэж байгаа тохиолдолд цуцлах санал гаргах эсэх талаар ТУЗ-ийн хурлаар шийдвэрлэнэ. Гэрээ цуцлах эсэхэд шийдвэр гаргахад ТУЗ-ийн үйл ажиллагааны журмыг баримтална.
- 7.3. Холбогдох этгээдтэй гэрээ цуцлан, дараагийн этгээдийг сонгож гэрээ байгуулахаас өмнө тухайн этгээд нь шаардлага хангаж байгаа талаарх нотлох баримтыг Хороонд хүргүүлэн зөвшөөрөл авсан байна.
- 7.4. ТУЗ нь үйлчилгээ үзүүлэх дараагийн этгээдийг сонгохдоо энэхүү Журмыг баримтална.
- 7.5. Компанийн ТУЗ нь холбогдох этгээдтэй гэрээ цуцалж байгаа тохиолдолд шинээр сонгогдсон этгээдийг ажлаа хүлээн авах хүртэл хугацаанд хуучин этгээдээс үйлчилгээг авах бөгөөд Компанийн үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангана.

### **НАЙМ. БУСАД**

- 8.1. Компани нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл авч, улсын бүртгэлийн байгууллагад бүртгэл хийлгэсэн өдрөөс эхлэн энэхүү Журмыг мөрдөж эхэлнэ.
- 8.2. Энэхүү журмын нэмэлт өөрчлөлтийг ТУЗ-ийн хурлаар хэлэлцэн баталснаар хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлнэ.

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ  
MONGOLIAN STOCK EXCHANGE  
2023-04-06  
БҮРТГЭВ-02

СЗХ  
ОН СЗХ ЭЦЭВ  
БҮРТГЭВ  
№ 01





"Бэрс Эй Би Эс Плас ТЗК" ХХК-ийн  
Таливчин удирдах зөвлөлийн 2023 оны 02 сарын 29-ны  
өдрийн 28/.. дугаар тогтоолын 3-хавсралт  
/24/05



ҮНЭТ ЦААС ЭЗЭМШИГЧДЭД МЭДЭЭЛЭЛ  
ХҮРГҮҮЛЭХ ЖУРАМ

2023-04-06

БҮРТГЭВ  
БҮРТГЭВ

СЭХ  
2023.04.06 өдөр  
БҮРТГЭВ  
№ 01

## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. “Бэрс Эй Би Эс Плас ТЗК” ХХК (цаашид “Компани” гэх)-ийн Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлэх журам (цаашид “Журам” гэх)-ын зорилго нь хөрөнгө оруулагч, Үнэт цаас эзэмшигчид Компанийн үйл ажиллагааны талаар болон хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг тогтмол хүргэх, уг мэдээллийн төрөл, хэлбэр, давтамж, мэдээллийн ил тод байдлыг хангах, нийтэд хүргэх, нэгдсэн нэг мэдээллийн урсгалтай байх, түүнийг хэрэгжүүлэх, хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Компани нь мэдээлэл хүргэхдээ Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны “Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам”, Монголын хөрөнгийн биржийн “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам” болон энэхүү журамд заасны дагуу мэдээллийг цаг тухайд нь үнэн зөв, агуулгын хувьд хоёрдмол утгагүй, бүрэн гүйцэт мэдээлэх үүрэгтэй.
- 1.3. Компани нь энэхүү Журамд заасан мэдээллийг Монгол хэл дээр хүргэх ба мэдээллийг олон нийт болон хөрөнгө оруулагч, үнэт цаас эзэмшигчид өөрийн болон Биржийн цахим хуудсаар хүргэнэ. Компани шаардлагатай гэж үзвэл гадаад хэл дээр мэдээллийг давхар хүргэж болно.
- 1.4. Мэдээ, мэдээллийг үнэн зөв олон нийтэд хүргэх, үнэт цаас эзэмшигчид, эрх бүхий байгууллагын өмнө хүлээсэн үүргийн хэрэгжилтийг гэрээний үндсэн дээр хөрөнгө итгэмжлэн удирдагчаар гүйцэтгүүлнэ. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь мэдээллийг үнэн зөв, цаг хугацаанд нь хөрөнгө оруулагч, үнэт цаас эзэмшигчид хүргэхийг хариуцан ажиллах ба Компанийн төлөөлөн удирдах зөвлөл хөрөнгө итгэмжлэн удирдагчтай байгуулсан гэрээний хэрэгжилтийг хянана.
- 1.5. Энэхүү журамд хэрэглэсэн нэр томъёог дараах утгаар ойлгон, хэрэглэнэ.
  - 1.5.1. “Бирж” гэж үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага буюу “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК;
  - 1.5.2. “Хороо” гэж Санхүүгийн зохицуулах хороо;
  - 1.5.3. “Мэдээллийг нийтэд хүргэх” гэж компани нь холбогдох хууль тогтоомж болон энэ Журамд заасан мэдээллийг Компанийн болон Биржийн цахим хуудсаар дамжуулан хөрөнгөөруулагч, үнэт цаас эзэмшигч нарт хүргэхийг;
  - 1.5.4. “Тогтмол мэдээлэх” Компаниас үнэт цаас эзэмшигчид болон нийтэд мэдээлэл хүргэх зорилгоор энэ журамд заасан өөрийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг бүрэн агуулсан, тодорхой хугацааны давтамжтай тайлагнах үүрэг бүхий мэдээллийг;
  - 1.5.5. “Тухай бүр мэдээлэх” гэж үйл явдал болсон өдрөөс хойш даруй энэхүү Журам, хууль тогтоомж, дүрэм журамд заасан хугацааны дотор мэдээлэхийг;
  - 1.5.6. “Дотоод мэдээлэл эзэмшигч” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсэгт заасан этгээдийг хэлнэ.

## ХОЁР. МЭДЭЭЛЭЛ ХҮРГЭХ ЖУРАМ

- 2.1. Компани нь хөрөнгө оруулагч, үнэт цаас эзэмшигчид мэдээллийг тогтмол, цаг тухайд нь хүргэх үүрэгтэй.
- 2.2. Компани нь хөрөнгө оруулагч, үнэт цаас эзэмшигчид мэдээллээр хангах тал дээр ижил, тэгш хандах, үйл ажиллагаандаа нээлттэй, ил тод байх зарчмыг баримтлах ба хөрөнгө оруулагч, үнэт цаас эзэмшигчтэй харилцах, хууль тогтоомжийн дагуу тогтмол мэдээ, мэдээллийг хүргэх нөхцөлийг бүрэн хангаж ажиллана.
- 2.3. Компани нь дараах мэдээллийг дор дурдсан хугацаанд холбогдох этгээдэд мэдээлэх

2023-04-06

БҮРТГЭВ-02



үүрэгтэй. Үүнд

- 2.3.1. Хорооны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журмын 11.3-т заасан мэдээллийг Хороо болон хөрөнгө оруулагч, үнэт цаас эзэмшигчдэд дараа сарын 10-ны дотор цахим хэлбэрээр хүргүүлнэ.
- 2.3.2. Биржийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 9.7.1.3-д заасан мэдээллийг Биржид дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор мэдээлнэ.
- 2.3.3. Хорооны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журмын 11.4 болон Биржийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 9.7.1.1-д заасан жилийн үйл ажиллагааны тайланг дараа жилийн 4 дүгээр сарын 30-ны дотор, хагас жилийн тайланг дараа сарын 20-ны өдрийн дотор цахим болон хэвлэмэл хэлбэрээр Хороо болон хөрөнгө оруулагч, үнэт цаас эзэмшигчид, Биржид тус тус мэдээлнэ.
- 2.3.4. Биржийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 9.7.1.2-д заасан мэдээллийг дараа оны 4 дүгээр сарын 30-ны дотор Биржид мэдээлнэ.
- 2.3.5. Биржийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 9.7.2-д заасан мэдээлэлд өөрчлөлт орсон бол Биржид тус тус өөрчлөгдсөн тухай бүр ажлын 3 хоногт багтаан мэдэгдэнэ.
- 2.3.6. Үнэт цаас гаргагч нь улирлын шинж чанартай тайланг Хороо болон Биржид цахимаар мэдэгдэх бөгөөд хагас жил тутмын болон жилийн тайланг хэвлэмэлээр мэдэгдэнэ.

#### **ГУРАВ. МЭДЭЭЛЛИЙН АРХИВЫГ БҮРДҮҮЛЭХ, ХАДГАЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

- 3.1. Компани нь олон нийтэд хүргэх мэдээллийг нэгэн зэрэг сонирхогч бүх этгээдэд Биржийн болон Компанийн цахим хуудсаар дамжуулан тогтоосон хугацаанд мэдээлнэ. Компанийн цахим хуудсанд нийтэд тогтмол мэдээлэл хүргэх хэсэг байрших бөгөөд тус хэсгийн мэдээлэл нь Компани татан буугдах хүртэл хугацаанд байршина.
- 3.2. Компанийн бүхий л баримт бичгийг татан буугдах хүртэл хугацаагаар хадгалах бөгөөд хөрөнгө итгэмжлэн удирдагч нь гэрээний үндсэн дээр энэхүү хугацаанд баримт бичгийг архивлан хадгалах ажлыг хариуцна.
- 3.3. Компани татан буугдах үед холбогдох бүхий л баримт, материалыг Компанийн үүсгэн байгуулагчид хүлээлгэн өгөх бөгөөд үүсгэн байгуулагч хүлээн авсан материалыг 5 жил хадгалсны дараа архивд хүлээлгэн өгнө.

#### **ДӨРӨВ. БУСАД**

- 4.1 Компани нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл авч, улсын бүртгэлийн байгууллагад бүртгэл хийлгэсэн өдрөөс эхлэн энэхүү Журмыг мөрдөж эхэлнэ.
- 4.2 Энэхүү журмын нэмэлт өөрчлөлтийг ТУЗ-ийн хурлаар хэлэлцэн баталснаар хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлнэ.

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЭХ  
MONGOLIAN STOCK EXCHANGE

2023 -04- 06

БҮРТГЭВ-02

СЭХ

өн сар адоо

БҮРТГЭВ

№ 01



“Бэрс Эй Би Эс Плас ТЗК” ХХК-ийн  
Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 04 сарын 06  
одрийн 23/071а/05 дугаар тогтоолын 2 хураартай




**ҮНЭТ ЦААСНЫ ТӨЛБӨР ЦУГЛУУЛАХ,  
ТӨЛБӨР ТӨЛӨХ ТУХАЙ ЖУРАМ**

**ҮНЭТ ЦААСНЫ ТӨЛБӨР ЦУГЛУУЛАХ, ТӨЛБӨР ТӨЛӨХ ТУХАЙ ЖУРАМ**

**НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

- 1.1 “Бэрс Эй Би Эс Плас ТЗК” ХХК (цаашид “ТЗК” гэх)-ийн Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх энэхүү журам (цаашид “Журам” гэх)-ын зорилго нь ТЗК-аас гаргах Автомашини фидуци бүхий зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас (цаашид “ХБҮЦ” гэх)-ны хөрөнгийн багц дахь зээлүүдийн төлбөрийг цуглуулах, үнэт цаас эзэмшигчдэд ХБҮЦ-ны төлбөр төлөхтэй холбоотойгоор ТЗК, Үйлчилгээ үзүүлэгч, Хөрөнгө итгэмжлэн удирдагч болон бусад холбогдох этгээдийнхооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Төлбөр цуглуулах, төлбөр төлөх үйл ажиллагаанд Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны №360 тогтоолын хавсралтаар батлагдсан “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам”, Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 2020/06 тоот тогтоолын хавсралтаар батлагдсан “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам”, ТЗК-ийн дүрэм болон энэхүү журмыг баримтална.
- 1.3 Энэхүү Журамд дурдсан нэр томъёонуудыг дараах утгаар ойлгоно. Үүнд:
- |                                |  |
|--------------------------------|--|
| “Анхны үүрэг гүйцэтгүүлэгч”    | гэж Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт тодорхойлсон этгээд буюу “Бэрс Финанс ББСБ” ХХК-ийг;                                      |
| “Үйлчилгээ үзүүлэгч”           | гэж Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт тодорхойлсон этгээд буюу ТЗК-д үйлчилгээ үзүүлэх этгээд болох “Бэрс Финанс ББСБ” ХХК-ийг; |
| “Зээлдэгч”                     | гэж Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс харилцан тохиролцсон нөхцөлийн дагуу хүүгийн хамт эргүүлэн төлөх төлбөрийн үүрэг хүлээсэн этгээдийг;  |
| “Зээл”                         | гэж Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс Зээлдэгчид зээлийн гэрээний дагуу зээл олгохыг;   |
| “Зээлийн данс бүртгэл”         | гэж Зээлдэгч тус бүрийн Зээлийн эргэн төлөлт, үлдэгдэл, хүү, нэмэгдүүлсэн хүүг тооцоолж, эргэн төлөлтийг хугацаатай нь бүртгэсэн мэдээллийг;                                     |
| “Зээлийн эргэн төлөлт”         | гэж ХБҮЦ-ны хөрөнгийн багцад багтсан Зээлийн төлөлт буюу Зээлдэгчээс Зээлийнгэрээний дагуу Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид төлөх мөнгөн төлбөрийг;                                   |
| “Зээлийн эргэн төлөлтийн данс” | гэж Зээлийн эргэн төлөлтийг цуглуулах зорилгоор Үйлчилгээ үзүүлэгчээс банканд нээсэн, энэ Журмын 2.3.1 дахь хэсэгт заасан дансыг;  |
| “Төлбөр цуглуулах данс”        | гэж энэхүү Журмын 2.2.1 дэх хэсэгт заасны дагуу Зээлийн эргэн төлөлтийн мөнгийг хүлээн авах зорилгоор банканд тусгайлан нээсэн ТЗК-ийн дансыг;                                   |






“Багцын эргэн төлөлт”	гэж Үйлчилгээ үзүүлэгчээс ТЗК-д Үйлчилгээ үзүүлэх тухай гэрээний дагуу шилжүүлж буй Зээлийн эргэн төлөлтийг;
“ҮЦТХТ”	гэж “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ийг;
“Зээлийн гэрээ”	гэж Зээлдэгч, Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нарын хооронд байгуулсан зээлийн гэрээг;
“Хөрөнгө итгэмжлэн удирдагч”	гэж “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт тодорхойлсон этгээд буюу “Юнайтед Айр Файнэнс” ХХК-ийг;
“Үнэт цаас эзэмшигч”	гэж ТЗК-ийн гаргасан ХБҮЦ-ыг худалдан авч, эзэмшиж буй этгээдийг.

### ХОЁР. ҮНЭТ ЦААСНЫ ТӨЛБӨР ЦУГЛУУЛАХ АЖИЛЛАГАА

- 2.1 ХБҮЦ-ны төлбөр цуглуулах ажиллагаанд ажил гүйцэтгэх гэрээний дагуу дараах этгээд оролцоно.
  - 2.1.1. ТЗК;
  - 2.1.2. Үйлчилгээ үзүүлэгч;
  - 2.1.3. Хөрөнгө итгэмжлэн удирдагч;
- 2.2 Төлбөр цуглуулахад ТЗК нь дараах ажлыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:
  - 2.2.1. ТЗК нь Үйлчилгээ үзүүлэгчийн Зээлийн эргэн төлөлтийн дансанд цугларсан мөнгийг хүлээн авах, ХБҮЦ-ны төлбөр төлөх зорилгоор Төлбөр цуглуулах дансыг банканд тусгайлан нээлгэж, төлбөр хүлээн авах бэлэн байдлыг хангана.
  - 2.2.2. ТЗК нь ХБҮЦ-ны төлбөр цуглуулах ажиллагаанд оролцох Үйлчилгээ үзүүлэгч, Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай холбогдох гэрээг байгуулж, төлбөр цуглуулах, төлбөр хүлээн авах ажиллагааг хэрэгжүүлэх боломжийг хангасан байна.
- 2.3 Төлбөр цуглуулахад Үйлчилгээ үзүүлэгч нь дараах ажлыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:
  - 2.3.1 Үйлчилгээ үзүүлэгч нь Зээлийн эргэн төлөлтийг өөрийн харилцах данс буюу Зээлийн эргэн төлөлтийн дансад цуглуулах ба ТЗК-ийн хөрөнгийн багцад буй Зээлийн үндсэн болон хүүгийн төлөлтийг бусад хөрөнгөөс ангид бүртгэнэ.
  - 2.3.2 Үйлчилгээ үзүүлэгч нь Зээлийн эргэн төлөлтийн дансанд тухай бүр орж ирсэн мөнгийг уг дансанд төвлөрүүлж дараа сарын 25-ны өдөрт багтаан холбогдох авлагыг суутган Төлбөр цуглуулах данс руу шилжүүлсэн байна.
  - 2.3.3 Зээлдэгчийн хүсэлтийн дагуу Зээлийн гэрээ болон мэдээлэлд өөрчлөлт оруулж, төлбөрийн хуваарь өөрчлөгдсөн бол Үйлчилгээ үзүүлэгч нь энэ талаарх мэдээллийг Хөрөнгө итгэмжлэн удирдагчид Зээлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулсан өдөрт багтаан мэдэгдэнэ. Зээлийн гэрээнд өөрчлөлт орсон нь Зээлийн багц дахь шалгуур үзүүлэлтийг хангахгүй болсон тохиолдолд ТЗК-ийн “Хөрөнгө итгэмжлэн удирдах журам”-д заасны дагуу арга хэмжээ авна.
  - 2.3.4 Үйлчилгээ үзүүлэгч нь Зээлийн эргэн төлөлтийг тооцоолсон Зээлийн данс бүртгэлийг хөтөлж, зээлийн болон төлбөрийн мэдээллийг ажлын 5 өдөрт багтаан ТЗК болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчид хүргүүлэн, тайлагнана.
  - 2.3.5 Үйлчилгээ үзүүлэгч нь Зээлдэгч Зээлийн эргэн төлөлтийн хугацааг хэтрүүлсэн болон төлбөл зохих хуваарьт төлбөрөөс давуулан илүү төлсөн тохиолдолд тухай

2023-04-06



бүр бүртгэж, Хөрөнгө итгэмжлэн удирдагчид нэн даруй мэдээлэх ба Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан "Активыг ангилах, активын эрдэлийн сан байгуулж, зарцуулах журам"-ын баримталта.

- 2.3.6 Үйлчилгээ үзүүлэгч нь ТЗК болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай харилцах ажилтныг тусгайлан томилох бөгөөд түүнтэй холбоо барих мэдээлэл, түүний эрх, үүрэг болон бусад шаардлагатай мэдээллийг ТЗК болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчид хүргүүлнэ.
- 2.4 Төлбөр цуглуулахад Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь дараах ажлыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:
  - 2.4.1 Програмаар зээлийн төлбөрийг хянана.
  - 2.4.2 Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь ТЗК болон Үйлчилгээ үзүүлэгчтэй харилцах өөрийн ажилтныг тусгайлан томилох бөгөөд түүнтэй холбоо барих мэдээлэл, түүний эрх, үүрэг болон бусад шаардлагатай мэдээллийг ТЗК болон Үйлчилгээ үзүүлэгчид хүргүүлнэ.
  - 2.4.3 Энэхүү журмын 3.2 дахь хэсэгт заасан гүйлгээг хийж гүйцэтгэнэ.

### ГУРАВ. ҮНЭТ ЦААСНЫ ТӨЛБӨРИЙГ ТӨЛӨХ, ТӨЛБӨРИЙН ЗАРЦУУЛАЛТ

- 3.1. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь төлбөр цуглуулах данснаас зөвхөн энэхүү Журмын 3.2 дахь хэсэгт заасан зарцуулалтыг хийх талаарх арга хэмжээг авч, Үнэт цаас эзэмшигчдэд төлөгдөх төлбөрийг зориулалтын бусаар захиран зарцуулахаас сэргийлнэ.
- 3.2. ТЗК-ийн Төлбөр цуглуулах дансанд цугларсан Багцын эргэн төлөлтөөс зөвхөн дараах гүйлгээг гүйцэтгэнэ. Үүнд:
  - 3.2.1. Үнэт цаас эзэмшигчдэд төлөгдөх төлбөрийг ҮЦТХТ-ийн данс руушилжүүлэх;
  - 3.2.2. Үнэт цаасны хүүгийн орлогын татвар;
  - 3.2.3. Хөрөнгийн багцад хөрөнгө нэмж худалдан авах, солих, нэмэгдүүлэх;
  - 3.2.4. Зөвшөөрөгдсөн хөрөнгө оруулалтад байршуулах;
  - 3.2.5. ТЗК-ийн төлөөлөн удирдах зөвлөл (цаашид "ТУЗ" гэх)-өөс баталсан төсвийн дагуу ТЗК-ийн үйл ажиллагаатай холбоотой ерөнхий ба удирдлагын зардал.
- 3.3. Энэхүү Журмын 3.2.5-т заасан төлбөрийг дараах зардалд зарцуулна. Үүнд:
  - 3.3.1. Татвар;
  - 3.3.2. Төрийн болон бусад эрх бүхий байгууллагад төлөгдөх зардал;
  - 3.3.3. ХБҮЦ гаргах, хадгалалттай холбоотой зардал;
  - 3.3.4. Банктай холбоотой зардал;
  - 3.3.5. Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн төлбөр;
  - 3.3.6. Үйлчилгээ үзүүлэгчийн төлбөр;
  - 3.3.7. Хөндлөнгийн аудит болон бусад мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийн төлбөр;
  - 3.3.8. ТЗК-ийн үйл ажиллагаатай холбоотой ерөнхий болон удирдлагын цалин урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэл, татвар, үйл ажиллагааны зардал (вэб сайттай холбоотой зардал, санхүүгийн программтай холбоотой зардал, мэдээлэл хүргэхтэй холбоотой зардал, бичиг хэргийн зардал).
- 3.4. ТЗК-ийн ТУЗ нь энэхүү Журмын 3.3 дахь хэсэгт заасан зардлын төсвийг баталж, Хөрөнгө итгэмжлэн удирдагчид мэдэгдэнэ.
- 3.5. ТЗК нь энэхүү Журмын 3.2 болон 3.3 дахь хэсэгт зааснаас бусад зардал гаргахгүй бөгөөд эрх бүхий байгууллагын шийдвэр, давагдашгүй хүчин зүйлийн нөлөө болон ХБҮЦ-ны төлбөрийг төлөхөд зайлшгүй зардал гаргах шаардлага үүсвэл ТУЗ-ийн хурлаар уг

2023-04-06

асуудлыг хэлэлцэж, зөвшөөрсөн тохиолдолд ТУЗ-ийн тогтоолд заасан хэмжээгээр зардлыг нэмж гаргана.



**ДӨРӨВ. ҮНЭГ ЦААС ЭЗЭМШИГЧДЭД ХБҮЦ-НЫ ТОЛБОР ТОЛОХ**

- 4.1. ТЗК нь ҮЦТХТ-тэй ХБҮЦ хадгалуулах, ХБҮЦ-ны төлбөрийн үүргийг гүйцэтгэх зорилгоор гэрээ байгуулна.
- 4.2. Анхдагч зах зээлийн арилжаа явагдаж, хоёрдогч зах зээлийн арилжаа эхлэх өдрөөс эхлэн хүүг тооцож эхэлнэ. Хүүгийн төлбөрийг 360 хоногоор тооцож улирал бүр, үндсэн төлбөрийг жилд 1 удаа төлнө.
- 4.3. ХБҮЦ-ны үндсэн болон хүүг дараах байдлаар тооцож төлнө. Үүнд:

ХБҮЦ-ны нэрлэсэн үнэ	100,000₮
ХБҮЦ-ны хүүгийн төлбөр төлөх давтамж	Улирал тутамд
ХБҮЦ-ны хүүгийн жилийн хувь	19.2%
ХБҮЦ-ны хүүгийн төлбөр /татварын өмнөх/	(Тоо ширхэг * Нэрлэсэн үнэ * Хүүгийн жилийн хувь) / Хүүгийн төлбөр төлөх давтамж
ХБҮЦ-ны хүүгийн төлбөр /татварын дараах/	Татварын өмнөх хүүгийн төлбөр * (1-Татварын хувь хэмжээ)
ХБҮЦ-ны үндсэн төлбөр	Жил тутамд 50%

- 4.4 Үнэт цаас эзэмшигчдэд ХБҮЦ-ны төлбөрийг дараах дарааллын дагуу төлнө. Үүнд:
  - 4.4.1 Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь ХБҮЦ-ны төлбөр хүлээн авах Үнэт цаас эзэмшигчдийн жагсаалтыг төлбөр төлөх өдрөөс ажлын 2 хоногийн өмнө ҮЦТХТ-өөс авна.
  - 4.4.2 ХБҮЦ-ны төлбөрийг ҮЦТХТ-өөс ирсэн Үнэт цаас эзэмшигчдийн нэрсийн дагуу Хөрөнгө итгэмжлэн удирдагч тооцооллыг хийсний дагуу ТЗК нь шилжүүлэх бөгөөд 4.4.1-д заасан хугацаанаас хойш Үнэт цаас эзэмшигч солигдсон бол төлбөрийг өмнөх Үнэт цаас эзэмшигч авна.
  - 4.4.3 Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь журмын 4.4.1 дэх хэсэгт заасан хугацаагаар Үнэт цаас эзэмшигчийн жагсаалт, эзэмшиж буй ХБҮЦ-ны тоо, төлбөрийн хуваарийн тооцоолол хийж, Үнэт цаас эзэмшигч тус бүрээр төлөгдөх төлбөрийн тооцоог гаргана. Баталгаажуулсан тооцоог ҮЦТХТ-д тус тус хүргүүлнэ.
  - 4.4.4 Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь тооцоо гаргахдаа татварын өмнөх болон дараах байдлаар гаргах бөгөөд ТЗК нь татварыг хассан дүнгээр ҮЦТХТ рүү шилжүүлж, үнэт цаас эзэмшигчийн нэрээр холбогдох татварыг суутган тайлагнана.
  - 4.4.5 ТЗК нь ХБҮЦ-ны төлбөрийг ҮЦТХТ дэх ТЗК-ийн үнэт цаасны дансанд төлбөр төлөх өдрөөс ажлын 1 хоногийн өмнө байршуулж, ҮЦТХТ-өөс тооцоололд заасны дагуу Үнэт цаас эзэмшигч нарт хуваарьт өдөр төлбөрийг шилжүүлнэ.
  - 4.4.6 Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь ХБҮЦ-ны төлбөр төлөгдөх хуваарь, үнийн дүнгийн тооцооллыг алдсан, Үнэт цаас эзэмшигчийн мэдээллийг буруу бичсэн зэрэг төлбөр тооцоотой холбоотой алдаа гарсан бол нэн даруй алдааг засах арга хэмжээ авна. Хэрэв Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн гаргасан алдаанаас болж Үнэт цаас эзэмшигч, ТЗК болон бусад этгээдэд хохирол учирсан бол хохирлыг Хөрөнгө итгэмжлэн удирдагч хариуцна.

**ТАВ. ТӨЛБӨР ТӨЛӨХ ДАРААЛАЛ**

- 5.1. ХБҮЦ-ны болон ТЗК-аас гарах бусад зардлыг дараах дарааллын дагуу төлнө. Үүнд:
  - 5.5.1. ТЗК-ийн татварын төлбөр;
  - 5.5.2. ХБҮЦ-ны хүүгийн орлогын татвар;



2023 -04- 06

5.5.3. Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн төлбөр, үүргийн гүйцэтгэлийн хангуулахтай холбоотой зардал;

5.5.4. Үйлчилгээ үзүүлэгчийн шимтгэл, зардал;

5.5.5. Аудитын зэрэг бусад мэргэжлийн оролцогчид, үйлчилгээ үзүүлсэн этгээдийн үйлчилгээний төлбөр;

5.5.6. ТУЗ-ийн гишүүд, нарийн бичгийн цалин;

5.5.7. ХБҮЦ-ны хүүгийн төлбөр;

5.5.8. ХБҮЦ-ны үндсэн төлбөр;

5.5.9. Журамд заасан бусад зардал.

5.2. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь ХБҮЦ-ны төлбөр төлөгдсөн өдрөөс 3 хоногийн дотор ТЗК-ийн “Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлэх журам”-д заасны дагуу ХБҮЦ-ны төлбөр төлсөн тухай мэдээллийг хүргэнэ.

5.3. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь ХБҮЦ-ны төлбөр төлөгдсөн өдрөөс хойш 3 хоногийн дотор Үнэт цаас эзэмшигчдийн жагсаалт, эзэмшиж буй ХБҮЦ-ны тоо, Үнэт цаас эзэмшигчдэд төлөгдсөн төлбөр, татварын дүн зэргийг ТЗК-ийн ТУЗ-д мэдээлнэ.

#### ЗУРГАА.ХАРИУЦЛАГА

6.1. Энэхүү журмыг зөрчсөнөөс үүсэх хохирлыг буруутай ажилтан, албан тушаалтан болон журмыг хэрэгжүүлэхтэй холбоотой гэрээнд заасан тохиолдолд тухайн оролцогч байгууллага болох ТЗК, Хөрөнгө итгэмжлэн удирдагч, Үйлчилгээ үзүүлэгч барагдуулна.

6.2. Зөрчил гаргасан этгээдийн үйлдэл нь гэмт хэргийн шинжтэй гэж үзвэл ТЗК эрх бүхий байгууллагад гомдол гарган, шалгуулан, шийдвэрлүүлнэ.

#### ДОЛОО. БУСАД

7.1. Энэхүү журам ТУЗ-өөс баталсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох бөгөөд ТЗК ХБҮЦ гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

7.2. Энэхүү журамд оруулах нэмэлт, өөрчлөлтийг ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасны дагуу ТУЗ-ийн хурлаар хэлэлцэн батална.

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_



"Бэрс Эй Би Эс Плаз ТЗК" ХХК-ийн  
Толоолон Удирдах Зөвлөлийн 2023 оны 02 сарын 02  
өдрийн 26/... дугаар тогтоолын 5 хавсгалийн



**ЭРСДЭЛ, СОНИРХЛЫН ЗӨРЧЛИЙГ ИЛРҮҮЛЭХ,  
ҮНЭЛЭХ, УДИРДАХ ДОТООД ХЯНАЛТЫН ЖУРАМ**

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. “Бэрс Эй Би Эс Плас ТЗК” ХХК (цаашид “ТЗК” гэх)-ийн Эрсдэл, сонирхлын зөрчлийг илрүүлэх, үнэлэх, удирдах дотоод хяналтын журам (цаашид “Журам” гэх)-ын зорилго нь ТЗК-ийн Автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас (цаашид “ХБҮЦ” гэх) гаргах, ХБҮЦ-ны төлбөрийг хөрөнгө оруулагч, Үнэт цаас эзэмшигчдэд төлөхтэй холбоотой үйл ажиллагааны эрсдэлийг удирдах, түүнтэй холбогдсон дотоод хяналтыг хэрэгжүүлэх, эрсдэл бууруулах арга хэмжээ авахтай холбоотой холбогдох хууль, журмын хүрээнд зохицуулагчбайгууллагууд болон оролцогч талуудтай харилцах харилцааг зохицуулахад оршино.


1.2. Энэхүү Журамд дурдсан нэр томьёонуудыг дараах утгаар ойлгоно. Үүнд:

“Хороо”	гэж Санхүүгийн зохицуулах хороог;
“Бирж”	гэж Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийг;
“Оролцогч талууд”	Гэж ТЗК-тай гэрээ байгуулсан Хөрөнгө итгэмжлэн удирдагч, хөндлөнгийн аудит, Үйлчилгээ үзүүлэгч, Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нарыг хамтад нь;
“Зээлдэгч”	гэж Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс харилцан тохиролцсон нөхцөлийн дагуу зээл авч, хүүний хамт эргүүлэн төлөх төлбөрийн үүрэг хүлээсэн этгээдийг;
“Хөрөнгө итгэмжлэн удирдагч”	гэж Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт заасан этгээдийг;
“Үйлчилгээ үзүүлэгч”	гэж Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт заасан этгээдийг;
“Анхны үүрэг гүйцэтгүүлэгч”	гэж Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт заасан этгээдийг;
“Үнэт цаас эзэмшигч”	гэж ТЗК-ийн гаргасан ХБҮЦ-ыг худалдан авч хөрөнгө оруулсан буюу эзэмшиж буй этгээдийг;
“Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв”	гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.9 дэх хэсэгт заасан этгээд буюу “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ийг;
“Ашиг сонирхлын зөрчил”	гэж энэхүү журмын 5.1-д тодорхойлсныг;

### ХОЁР. ЭРСДЭЛИЙН АНГИЛАЛ

- 2.1. ХБҮЦ-ны төлбөр төлөхтэй холбоотой учирч болох эрсдэлийг дараах 3 байдлаар ангилна.
- 2.1.1. Зээлтэй холбоотой эрсдэл;
  - 2.1.2. ХБҮЦ гаргах үйл ажиллагаанд оролцогч талуудтай холбоотой эрсдэл;
    - 2.1.2.1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч;
    - 2.1.2.2. Үйлчилгээ үзүүлэгч;
    - 2.1.2.3. Хөрөнгө итгэмжлэн удирдагч;





- 2.1.3. Бусад гадны хүчин зүйлстэй холбоотой эрсдэл;
  - 2.1.3.1. Хууль, журам, зохицуулалт;
  - 2.1.3.2. Давагдангүй хүчин зүйлс.

### **ГУРАВ. ЭРСДЭЛИЙГ УДИРДАХ АРГА ХЭМЖЭЭ**

- 3.1. Зээлтэй холбоотой эрсдэл.
  - 3.1.1. Зээлийн эрсдэл гэдэг нь зээлдэгч зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй улмаас үүсэх эрсдэлийг хэлнэ. Үүнд зээлдэгч зээлийн хугацаа хэтрүүлэх, төлбөрийн чадваргүй болох, Зээлдэгч эрх зүйн чадамжгүй болох, нас барах, сураггүй алга болсон нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон байхыг ойлгоно.
  - 3.1.2. Хугацаанаас өмнө эргэн төлөгдөх эрсдэл гэдэг нь зээлдэгч зээлээ хугацаанаас нь өмнө төлөх буюу хүлээгдэж байсан хүүгийн орлого буурах, хаагдахыг ойлгоно.
- 3.2. Зээлтэй холбоотой эрсдэлийг дараах байдлаар удирдана. Үүнд:
  - 3.2.1 ТЗК нь зээлтэй холбоотой эрсдэлийг Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Активыг ангилал, активын эрсдэлийн сан байгуулах, зарцуулах журмыг мөрдөж, зээлийг ангилж, эрсдэлийн сан байгуулж ажиллана.
  - 3.2.2 Эрсдэлийн сан байгуулах ТЗК нь дээрх журмын дагуу зээлийн эрсдэлийн санг тооцож, холбогдох эрсдэлийн сангийн тохируулгыг хийнэ.
  - 3.2.3 ТЗК нь хугацаа хэтэрсэн зээл дээр үйлчилгээ үзүүлэгч талаас зээлийг эргэн төлүүлэхтэй холбоотой үйлчилгээ үзүүлэгчийн дотооддоо мөрдөж буй холбогдох заавар журмын хүрээнд үйлчилгээг авч, хяналт тавьж ажиллана. Үүнтэй холбоотой зохицуулалтыг Үйлчилгээ үзүүлэх гэрээнд тусгана.
  - 3.2.4 ТЗК нь зээл хугацаанаас өмнө эргэн төлөгдөх эрсдэл үүссэн тохиолдолд Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэг болон ТЗК-ийн Хөрөнгө итгэмжлэн удирдах журамд заасны дагуу хөрөнгийн багцад хөрөнгө нэмэх замаар арга хэмжээ авна.
- 3.3. Оролцогч талуудтай холбоотой эрсдэл.
  - 3.3.1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй холбоотой эрсдэл.
    - 3.3.1.1. ТЗК-ийн Хөрөнгө итгэмжлэн удирдах журмын 2 дугаар зүйлийн 2.3 дахь хэсэгт заасан зээл шилжүүлсэн;
    - 3.3.1.2. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь хөрөнгийн багцыг сольж нэмж чадахгүй болсон;
    - 3.3.1.3. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь төлбөрийн чадваргүй болсон, дампуурсан, татан буугдсан.
  - 3.3.2. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй холбоотой эрсдэлийг дараах байдлаар удирдана. Үүнд:
    - 3.3.2.1. Энэхүү Журмын 3.3.1.1 дэх хэсэгт заасан эрсдэл үүсэх тохиолдолд Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс хөрөнгийн багцыг солихыг шаардах, ТЗК-ийн Хөрөнгө итгэмжлэн удирдах журамд заасны дагуу эрсдэлийг удирдана.
    - 3.3.2.2. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь сайн дурын үндсэн дээр эсхүл хуульд заасан үндэслэлээр татан буугдах тохиолдолд түүний ТЗК-д шилжүүлсэн Багцын хөрөнгийн үлдэгдлийг зохих журмын дагуу сонгогдсон өөр Үйлчилгээ үзүүлэгчид шилжүүлэх арга хэмжээ авна.
    - 3.3.2.3. ТЗК нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй холбоотой эрсдэлийг бууруулах зорилгоор холбогдох журам, гэрээнд тус бүр эрсдэл бууруулах, мэдээллийг цаг тухай бүр хүргэх, хянах, мэдээлэл солилцох зохицуулалтуудыг тусгасан байна.

2023-04-06

3.3.3. Үйлчилгээ үзүүлэгчтэй холбоотой эрсдэл.

3.3.3.1. Үйлчилгээ үзүүлэгч нь төлбөрийг бүрэн гүйцэд, гэрээгээр хуугаанаа дагуу цуглуулан ТЗК-д шилжүүлэхгүй байх;

3.3.3.2. Үйлчилгээ үзүүлэгчийн тусгай зовшоорлийг Хорооноос цуцлах;

3.3.3.1. Үйлчилгээ үзүүлэгч нь төлбөрийн чадваргүй болсон, татан буугдсан, дампуурсан.

3.3.4. Үйлчилгээ үзүүлэгчтэй холбоотой эрсдэлийг дараах байдлаар удирдана. Үүнд:

3.3.4.1. Үйлчилгээ үзүүлэгч нь зээлийн эргэн төлөлтийг өөрийн харилцах дансанд цуглуулах ба ТЗК-ийн хөрөнгийн багцад буй зээлүүдийн үндсэн болон хүүгийн төлөлтийг уг дансанд цуглуулан өөрийн бусад хөрөнгөөс ангид байлгана. Үйлчилгээ үзүүлэгч нь учруулсан хохиролтой тэнцэх хэмжээний мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгийг өөрийн хөрөнгөөр төлж барагдуулна.

3.3.4.2. Үйлчилгээ үзүүлэгч нь зээлийг төлүүлэхдээ ТЗК-тай байгуулсан гэрээний дагуу үйлчилгээ үзүүлэгч байгууллагын дотооддоо мөрдөгдөж буй Зээлийн үйл ажиллагааны журам, Зээл төлүүлэхтэй холбогдсон бусад журмыг дагаж мөрдөнө.

3.3.4.3. Үйлчилгээ үзүүлэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа биелүүлэхгүй, эсхүл Үйлчилгээ үзүүлэгч нь төлбөрийн чадваргүй болсон, татан буугдах, дампуурах эрсдэл үүссэн, төрийн зохицуулах байгууллагаас тусгай зөвшөөрлийг цуцалсан тохиолдолд ТЗК нь тусгаарласан зээлийн багцтай холбоотой авлага цуглуулах, төлбөр гүйцэтгэх үйл ажиллагааг зохих журмын дагуу сонгогдсон, өөр хэвийн үйл ажиллагаатай үйлчилгээ үзүүлэгчид шилжүүлэх, үйлчилгээ үзүүлэгчийг солих арга хэмжээ авна.

3.3.4.4. ТЗК нь үйлчилгээ үзүүлэгчтэй холбоотой эрсдэлийг бууруулах, үүссэн эрсдэлийг шийдвэрлэх зорилгоор холбогдох журам, гэрээнд эрсдэл бууруулах, мэдээллийг цаг тухай бүр хүргэх, хянах, мэдээлэл солилцох зохицуулалтуудыг тусгасан байна.

3.3.5. Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай холбоотой эрсдэл.

3.3.5.1. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь хөрөнгийг гэрээнд зааснаас гадуур, Үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагчид хохиролтойгоор зүй бусаар удирдах, ашиглах;

3.3.5.2. Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн тусгай зөвшөөрлийг Хорооноос цуцалсан;

3.3.5.3. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь татан буугдсан, дампуурсан.

3.3.6. Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай холбоотой эрсдэлийг дараах байдлаар удирдана. Үүнд:

3.3.6.1. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь багцын удирдлагатай холбоотой тайлан мэдээллийг Үнэт цаас гаргагчтай байгуулсан гэрээний дагуу Үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагч, холбогдох эрх бүхий байгууллагад тогтмол хүргэх бөгөөд хууль болон гэрээнд зааснаас гадуур, зүй бусаар удирдаж, ашиглах тохиолдолд ТЗК-ийн ТУЗ нь хөрөнгө итгэмжлэн удирдагчийг нэн даруй солих шийдвэр гаргах, эсхүл үйл ажиллагааг залруулах, хохирлыг барагдуулах тодорхой хугацаа өгөх эрхтэй. Мөн зүй бус хөрөнгийн удирдлагатай холбоотой аливаа хохирол учирсан тохиолдолд Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь өөрийн хөрөнгөөр бүрэн төлж барагдуулах талаар гэрээнд тодорхой тусгаж баталгаажуулсан байна.

- Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн тусгай зөвшөөрлийг төрийн зохицуулах байгууллагаас цуцлах, хөрөнгө итгэмжлэн удирдагч нь төлбөрийн чадваргүй болох, татан буугдах, дампуурах нөхцөл үүссэн тохиолдолд шаардлага хангах хөрөнгө итгэмжлэн удирдагчийг яаралтай шинээр сонгон ажиллуулна.
- 3.3.6.3. ТЗК нь Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай холбоотой эрсдэлийг бууруулах, үүссэн эрсдэлийг шийдвэрлэх зорилгоор холбогдох журам, гэрээнд эрсдэл бууруулах, мэдээллийг цаг тухай бүр хүргэх, хянах, мэдээлэл солилцох зохицуулалтуудыг тусгасан байна.
- 3.3.7. Хөрөнгөөр баталгаажсан Үнэт цаас гаргагч нь уг үйл ажиллагаанд оролцогч аудит, хуулийн үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагчтай сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлж, зохих мэдэгдэл баталгаа гаргуулах, сонирхлын зөрчил үүсч болохоор нөхцөл байдал үүссэн тохиолдолд эрсдэлийн үнэлгээ хийж, хөрөнгө оруулагчдыг мэдээллээр хангах зэрэг холбогдох арга хэмжээ авна.
- 3.4. Гадаад хүчин зүйлстэй холбоотой эрсдэл
- 3.4.1. ХБҮЦ, ТЗК, оролцогч талуудад тавигдах шаардлагатай холбоотой хууль журам, зохицуулалт өөрчлөгдөх эрсдэл.
- 3.5. Гадаад хүчин зүйлстэй холбоотой эрсдэлийг дараах байдлаар удирдана. Үүнд:
- 3.5.1. Энэ журмын 3.4 дүгээр зүйлийн 3.4.1-д заасан эрсдэлтэй холбогдуулан ТЗК-ийн ТУЗ-ийн хурал хуралдаж, шаардлагатай гэж үзсэн тохиолдолд эрсдэлийн үнэлгээ, үр нөлөөтэй холбоотой хөндлөнгийн байгууллага, хуулийн фирмийг хөлслөн ажиллуулах, зохицуулагч эрх бүхий байгууллагуудтай тогтмол мэдээлэл солилцох, шийдвэр гаргах замаар эрсдэлийг бууруулж ажиллана.
- 3.5.2. Давагдашгүй хүчин зүйлстэй холбоотой эрсдэлд дараах арга хэмжээг авч ажиллана. Үүнд:
- 3.5.2.1. Давагдашгүй хүчин зүйл бий болсон тухайгаа Үнэт цаас эзэмшигчдэд тухайн брокерын компаниар дамжуулан бичгээр мэдэгдэх, ТЗК болон Биржийн цахим хуудсаар мэдээлнэ. Тухайн мэдэгдэлд ямар байдлаар давагдашгүй хүчин зүйл үүссэн, түүний хор уршгийг бууруулах талаар авсан, эсхүл авах гэж буй арга хэмжээ, давагдашгүй хүчин зүйлийн улмаас үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон хугацааг тус тус тусгасан байна.
- 3.5.2.2. Давагдашгүй хүчин зүйлийн улмаас ТЗК нь Үнэт цаас эзэмшигчдийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж чадаагүй нь үндсэн үүргээс чөлөөлөхгүй бөгөөд давагдашгүй хүчин зүйлийн үед ТЗК-ийн үүрэг биелүүлэх хугацаа нь давагдашгүй хүчин зүйлийн үргэлжлэх хугацаагаар хойшлогдоно.

#### **ДӨРӨВ. ЭРГЭН ТӨЛӨЛТИЙГ САЙЖРУУЛАХ**

- 4.1. ТЗК нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсэгт заасны дагуу эргэн төлөлтийг сайжруулах дараах арга хэмжээг авна.
- 4.1.1. Хөрөнгийн багцыг сайжруулах, солих;
- 4.1.2. Хөрөнгийн багцыг нэмэгдүүлэх;
- 4.1.3. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдах;
- 4.1.4. Хөрөнгийн багцын дүнг ХБҮЦ-ны төлбөрийн төлөгдөөгүй дүнгээс багагүй байлгах;
- 4.1.5. Эрсдэлийн сан байгуулах;
- 4.2. Хөрөнгийн багц дахь зээлийн төлбөрүүдийг Үйлчилгээ үзүүлэгчийн бусад хөрөнгөөс тусад

2023-04-06

БҮРТГЭВ-02

ньангид байлгах.



- 4.3. ТЗК-ийн төлбөр гүйцэтгэх дансанд зарлагын хязгаарлалтууд хийгдэх ба энэхүү Журмын 3.3.бдугаар зүйлийн 3.3.6.1 дэх хэсэгт заасны дагуу зохион байгуулна.
- 4.4. ТЗК-ийн эргэн төлөлтийг сайжруулах арга хэмжээг ТЗК татан буугдах хүртэл хэрэгжүүлнэ.
- 4.5. ТЗК нь татан буугдах үед хөрөнгө оруулагчдын өмнө хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсний дараа үлдсэн зээл, зээлийн эрсдэлийн сан нь Анхны үүрэг гүйцэтгэгч буюу ТЗК-ийн үүсгэн байгуулагч- хувьцаа эзэмшигчид шилжинэ.

#### **ТАВ. СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ, ТЭДГЭЭРИЙГ МЭДЭГДЭХ**

- 5.1. Хөрөнгө итгэмжлэн удирдагч, хөндлөнгийн аудит, Үйлчилгээ үзүүлэгч нь ТЗК-тай сонирхлын зөрчил үүсэхээс сэргийлж ажиллана.
- 5.2. Үнэт цаас гаргах ажиллагаанд ашиг сонирхлын зөрчил үүсэхээс сэргийлж, дараах үйлдлийг хориглоно:
  - 5.2.1. Оролцогч талуудын болон хөрөнгө оруулагчдын нууц мэдээллийг задруулах,
  - 5.2.2. Аливаа гуравдагч этгээдэд үйл ажиллагааны үр дүнгийн талаар амлалт өгөх,
  - 5.2.3. Үнэт цаас эзэмшигчид үнэт цаас, түүний эргэн төлөх ажиллагааны талаар буруу ойлголт өгөх, бодит байдлыг нуун дарагдуулах,
  - 5.2.4. Хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх ашиг, хүсэл сонирхлын эсрэг ажиллах,
  - 5.2.5. Хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгүүдийг санаатайгаар буруу хэрэглэх, тайлбарлах,
  - 5.2.6. Бусад оролцогч талуудын үйл ажиллагаанд санаатайгаар саад учруулах
- 5.3. ТЗК нь ХБҮЦ гаргахдаа оролцогч талуудаас ашиг сонирхлын зөрчилгүй талаарх тодорхойлолтыг авсан байна.
- 5.4. Оролцогч талуудын зүгээс холбогдох гэрээний дагуу мэргэжлийн ажил үйлчилгээ үзүүлэх үед ашиг сонирхлын зөрчил үүссэн эсхүл үүсч болзошгүй нөхцөлд энэ талаар ТЗК-д мэдэгдэж, тухайн ажил үйлчилгээг гүйцэтгэхээс татгалзах эрхтэй.
- 5.5. Үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч, эсхүл тэдээрийн ажилтнууд нь сонирхлын зөрчилтэй харилцаа үүсгэсэн, үүсгэж болзошгүй бол ТЗК болон холбогдох талуудад мэдэгдэж, мэдээлэлтэй зөвшөөрөл авч болно.

#### **ЗУРГАА. ХАРИУЦЛАГА**

- 6.1. Энэхүү журмыг зөрчсөнөөс холбогдон үүсэх хохирлыг буруутай ажилтан, албан тушаалтан болон оролцогч байгууллагууд барагдуулна.
- 6.2. Зөрчил гаргасан этгээдийн үйлдэл нь эрүүгийн гэмт хэргийн шинжтэй гэж үзвэл ТЗК эрх бүхийбайгууллагад гомдол гарган шалган шийдвэрлүүлнэ.

#### **ДОЛОО. БУСАД**

- 7.1. Энэхүү Журам нь ТЗК-ийн ТУЗ-аас баталсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох бөгөөд ТЗК нь тусгай зориулалтын компанийн тусгай зөвшөөрөл авсан өдрөөс хойш дагаж мөрдөнө.
- 7.2. Энэхүү Журамд нэмэлт өөрчлөлт оруулахад ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасны дагуу ТУЗ-ийн хурлаар хэлэлцэн батална.

oOo




МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ  
MONGOLIAN STOCK EXCHANGE  
2023-04-06  
БҮРТГЭВ-02

СЭХ  
Тон Сэр өлөр  
УЛААНБААТАР ХОТ  
№ 01  
ATA9554-1 6949886  
9023020416

"Бэрс Эй Би Эс Лимс ТЗК" ХХК-ийн  
Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 04 сарын 06 ны  
өдрийн 20/24/05 дугаар тогтоолын 6 хавсралт

**ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УДИРДАХ ЖУРАМ**





## ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УДИРДАХ ЖУРАМ

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. “Бэрс Эй Би Эс Плас ТЗК” ХХК (цаашид “Компани” гэх) -ийн Хөрөнгийн багцад өөрчлөлт оруулах журам (цаашид “Журам” гэх)-ын зорилго нь Компанийн гаргаж буй Автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас (цаашид “ХБҮЦ” гэх)-ны баталгаа болох зээлийн хөрөнгийн багцад буй хөрөнгийг солих, нэмэх, хасах замаар багцад өөрчлөлт оруулахтай холбоотойгоор Компанийн Анхны үүрэг гүйцэтгүүлэгч, Хөрөнгө итгэмжлэн удирдагч болон бусад оролцогчтой холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Компани нь үйл ажиллагаандаа Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам, Монголын хөрөнгийн биржийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам болон энэхүү журамд заасныг тус тус баримтлан ажиллана.

### ХОЁР. ХӨРӨНГИЙН БАГЦАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ


- 2.1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний дагуу багцыг шилжүүлэн авсан зээлийн хөрөнгө нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 9 дүгээр зүйл болон зээлийн багцад тавигдах шалгуур үзүүлэлтийг хангахгүй болсон эсхүл Журамд заасан үндэслэл бий болсон тохиолдолд хөрөнгийн багцад өөрчлөлт оруулна.
- 2.2. Хөрөнгийн багцад дараах байдлаар өөрчлөлт оруулна. Үүнд:
  - 2.2.1. Багцын хөрөнгийг солих;
  - 2.2.2. Багцын хөрөнгийг нэмэгдүүлэх;
  - 2.2.3. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдах.
- 2.3. Дор дурдсан үндэслэл бий болсон тохиолдолд шаардлага хангахгүй хөрөнгөд тооцож, хөрөнгийн багцад байгаа хөрөнгийг багцаас хасаж солино. Үүнд:
  - 2.3.1. Зээлдэгчийн хүсэлтээр тухайн зээлийн гэрээнд өөрчлөлт оруулсан нь Үнэт цаас эзэмшигчдэд төлөх ХБҮЦ-ны төлбөрийн нөхцөлд нөлөөлөхүйц байна гэж Компаниас үзсэн;
  - 2.3.2. Хөрөнгийн багцын шалгуур үзүүлэлтэй холбоотойгоор анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн “Хөрөнгө худалдах худалдан авах гэрээ”-нд заасан аль нэг мэдэгдэл, баталгаа зөрчигдсөн;
  - 2.3.3. Зээлдэгч зээлийн гэрээгээр хүлээсэн зээл эргэн төлөх үүргээ биелүүлээгүй 90-ээс дээш хоног хэтэрсэн эсхүл;
  - 2.3.4. Зээлийн эргэн төлөлтийн хугацаа нь 30 хоногоос дээш хэтэрсэн бөгөөд цаашид зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болох нь үндэслэл бүхий бол.
- 2.4. Дор дурдсан үндэслэл бий болсон тохиолдолд хөрөнгийн багцад хөрөнгийг нэмэгдүүлнэ. Үүнд:
  - 2.4.1. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 15.3.1-д заасны дагуу ХБҮЦ-ны хөрөнгийн багцаас орох орлого нь ХБҮЦ-ны төлбөрийн үүргийг гүйцэтгэж хүрэхгүй болсон;
  - 2.4.2. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 15.3.2-д заасны дагуу Компани нь нээлттэй гаргах нөхцөлийн дагуу нэмэлт үнэт цаас гаргахаар болсон;



- 2.4.3. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь багцын өгөөжийг нэмэгдүүлэх, төлбөрийн тасалдал үүсэхээс урьдчилсан сэргийлэх зорилгоор Үнэт цаас эзэмшигчдэд төлөх ХБҮЦ-ны төлбөрөөс бусад сул мөнгөн дүнгээр багц худалдан авах боломжтой гэж үзсэн, зээлийн багц худалдан авах талаар анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй харилцан тохиролцсон.
- 2.5. Дор дурдсан үндэслэл бий болсон тохиолдолд Компани нь хөрөнгийн багцыг анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдана. Үүнд:
- 2.5.1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь энэхүү журамд заасны дагуу шаардлага хангахгүй хөрөнгийг бүхэлд нь солих хөрөнгийн жагсаалтыг ТЗК-д гарган өгөх боломжгүй, эсхүл гарган өгсөн жагсаалт нь шаардлага хангахгүй тохиолдолд солих боломжгүй хөрөнгийн багцын хэмжээгээр;
- 2.5.2. Хөрөнгийн багцад байгаа хөрөнгийн 20 ба түүнээс дээш хувь нь 90 хоногоос дээш хугацаа хэтэрсэн тохиолдолд;
- 2.5.3. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.11.5-д заасан нөхцөл байдал үүссэн бөгөөд талууд харилцан тохиролцсон тохиолдолд.
- 2.6. Хөрөнгийн багцыг нэмэгдүүлэхэд багцад ийнхүү нэмэгдсэн хөрөнгө нь ХБҮЦ гаргах өргөдөл, Үнэт цаасны танилцуулгад тусгагдсантай адил онцлог, шинж чанартай байна.

#### **ГУРАВ. ХӨРӨНГИЙН БАГЦАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ДАРААЛАЛ**

- 3.1. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 20.2.1 болон 20.2.5-д тус тус заасны дагуу хөрөнгө итгэмжлэн удирдагч нь хөрөнгийн багцад хяналт тавих ажлыг Компанитай байгуулсан Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд заасны дагуу гүйцэтгэнэ.
- 3.2. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Үйлчилгээ үзүүлэгчээс өдөр бүр ирүүлсэн зээлийн эргэн төлөлтийн мэдээлэл болон Үйлчилгээ үзүүлэгчээс Компанийн төлбөр цуглуулах дансанд хуримтлуулсан хөрөнгийн үлдэгдэлд үндэслэн хөрөнгийн багцад хяналт тавина.
- 3.3. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь багц дахь зээлүүдийн эргэн төлөлт болон үйлчилгээ үзүүлэгчийн сарын тайланд үндэслэн энэхүү журмын 2.3 дахь хэсэгт заасан нөхцөл үүссэн тохиолдолд хөрөнгийг солиход дараах арга хэмжээг авна. Үүнд:
- 3.3.1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй байгуулсан Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээнд заасан шалгуур хангасан “орлуулах хөрөнгийн жагсаалт”-аар солино.
- 3.3.2. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс харилцан тохиролцсон орлуулах хөрөнгийг Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн программд оруулж холбогдох актыг үйлдсэнээр хөрөнгийг сольж бүртгэсэнд тооцно.
- 3.3.3. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс Компанид шилжүүлсэн орлуулах хөрөнгийн зээлийн үндсэн төлбөрийн үлдэгдлийн нийлбэр хэмжээ, нь шаардлага хангахгүй хөрөнгийн үндсэн өрийн үлдэгдэл болон хуримтлагдсан хүүгийн дүнгийн нийлбэрээс зөрүүтэй тохиолдолд авлага, өглөгийг тооцоо нийлсэн актад тусгаж барагдуулна.
- 3.4. Энэхүү журмын 2.4 дэх хэсэгт заасан нөхцөл үүссэн тохиолдолд хөрөнгийг нэмэгдүүлэх дараах арга хэмжээг авна. Үүнд:
- 3.4.1. Багц дахь зээлүүдийн эргэн төлөлт хийгдсэн мэдээлэл агуулсан үйлчилгээ үзүүлэгчийн тайланд үндэслэн багцын хөрөнгийг нэмэгдүүлэх дүнг 1 сар тутамд, шаардлагатай тохиолдолд анхны үүрэг гүйцэтгэгчээс шалгуур хангасан “нэмэгдүүлэх хөрөнгийн жагсаалт”-аар нэмэгдүүлнэ.
- 3.4.2. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс харилцан тохиролцсон нэмэгдүүлэх хөрөнгийг хөрөнгө итгэмжлэн удирдагчийн программд оруулж холбогдох актыг үйлдсэнээр хөрөнгийг нэмэгдүүлж бүртгэсэнд тооцно.



- 3.5. Энэхүү Журмын 2.5 дахь хэсэгт заасан нөхцөл үүссэн тохиолдолд Хөрөнгийг анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдах дараах арга хэмжээг авна. Үүнд:
- 3.5.1. Журмын 2.5.1-т заасан нөхцөл үүссэн тохиолдолд Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй зээлийн хөрөнгийг буцаан худалдах актыг үйлдэж, Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь буцаан худалдсан зээлийн холбогдох төлбөрийг ТЗК-д шилжүүлнэ.
- 3.5.2. Журмын 2.5.2, 2.5.3-д заасан нөхцөл үүссэн тохиолдолд Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Үйлчилгээ үзүүлэгчийн тайланд үндэслэн багцын хөрөнгийн үлдэгдлийг гаргаж ТЗК-ийн ТУЗ-д танилцуулж буцаан худалдах эсэхийг шийдвэрлүүлнэ.
- 3.5.3. Журмын 3.5.2-т заасны дагуу багцыг буцаан худалдахаар шийдвэрлэсэн тохиолдолд ТЗК нь буцаан худалдах мэдэгдлийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид хүргүүлнэ.
- 3.5.4. Журмын 3.5.3-т заасан мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногт багтаан Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь ТЗК-тай Хөрөнгийн багцыг буцаан худалдах гэрээг байгуулж, холбогдох төлбөрийг төлнө.
- 3.6. Компани нь дараах мэдээлэлд өөрчлөлт орсон бол дараа сарын 10-ны өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороо болон хөрөнгө оруулагчид цахим хэлбэрээр мэдээлнэ. Үүнд:
- 3.6.1. Хөрөнгийн багцын нарийвчилсан мэдээлэл, тэдгээрийн байдал;
- 3.6.2. Хөрөнгийн багцад нэмэгдсэн, хасагдсан хөрөнгө, нэмэх хасах болсон үндэслэл, шалтгаан, ХБҮЦ-ны жигнэсэн дундаж шимтгэл, хүү, эргэн төлөгдөх нөхцөл, үлдэгдэл хөрөнгийн тоо хэмжээ;
- 3.6.3. Төлөгдөөгүй хөрөнгийн үлдэгдэл болон зээлийн харьцаа, төлөгдсөн үндсэн зээл, үндсэн төлбөр, баталгаат үнэт цаасны үлдэгдэл, бэлэн мөнгөний төвлөрсөн хэмжээ, түүний ашиглалт.

#### **ДӨРӨВ. СУЛ ЧӨЛӨӨТЭЙ ЭХ ҮҮСВЭРИЙН УДИРДЛАГА**

- 4.1. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Төлбөр цуглуулах дансан дахь үндсэн төлбөрийн болон хүүгийн хэсгийн үлдэгдэл хэсгээр ТЗК-ийн дүрэмд заасны дагуу хөрөнгө оруулалтын хэрэгслийн эрсдэл, өгөөж болон ХБҮЦ-ны холбогдох үүргийг гүйцэтгэхэд аливаа хүндрэл учрахгүй байх бүхий л бололцоог харгалзан тооцоо судалгаа хийсний үндсэн дээр дараах хөрөнгө оруулалтын хэрэгслүүдэд байршуулна.
- 4.1.1. Банкны хадгаламж;
- 4.1.2. Засгийн газар болон Монголбанкаас гаргасан үнэт цаас ;
- 4.1.3. Зохицуулах байгууллагаас хүлээн зөвшөөрсөн бусад.
- 4.2. ХБҮЦ-ны төлбөрийг хугацаандаа төлөх боломжийг хангах зорилгоор дээр дурдсан хөрөнгө оруулалтын дуусах хугацааг ХБҮЦ-ны төлбөр төлөх хуваарьт өдрөөс ажлын хоёр (2)-аас доошгүй өдрийн өмнө дууссан байхаар тохируулсан байна.


#### **ТАВ. ХАРИУЦЛАГА**

- 5.1. Энэхүү журмыг зөрчсөнөөс холбогдон үүсэх хохирлыг буруутай ажилтан, албан тушаалтан болон оролцогч байгууллагууд барагдуулна.
- 5.2. Зөрчил гаргасан этгээдийн үйлдэл нь эрүүгийн гэмт хэргийн шинжтэй гэж үзвэл Компани нь эрх бүхий байгууллагад гомдол гарган шалган шийдвэрлүүлнэ.

#### **ЗУРГАА. БУСАД**

- 6.1. Компани нь ХБҮЦ гаргах үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл авч, улсын бүртгэлийн





байгууллагад бүртгэл хийлгэсэн өдрөөс эхлэн энэхүү Журмыг мөрдөж эхэлнэ.

- 6.2. Энэхүү журмын нэмэлт өөрчлөлтийг ТУЗ-ийн хурлаар хэлэлцэн баталснаар хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлнэ.
- 6.3. Журмын хавсралт: Хавсралт №1 Хөрөнгө буцаан худалдах тухай мэдэгдэл.

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_



## ХАВСРАЛТ 1

### ХӨРӨНГӨ БУЦААН ХУДАЛДАХ ТУХАЙ МЭДЭГДЭЛ

Хэнд: Анхны үүрэг гүйцэтгүүлэгч

#### Тодорхойлсон нэр томъёо болон тайлбар

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч  болон Худалдан авагч  нарын хооронд  өдөр байгуулсан Худалдах, худалдан авах гэрээнд тодорхойлсон үг ба илэрхийлэл нь энэ журамд хэрэглэгдэхдээ ижил утгатай байх бөгөөд худалдах, худалдан авах гэрээний тайлбарын талаарх бүх зүйлүүд нь энэ баримт бичигт адил хамаарна.

#### Санал болон хүлээн зөвшөөрөлт

Худалдах, худалдан авах гэрээний дагуу Худалдан авагч нь үүгээр Анхны үүрэг гүйцэтгүүлэгч  болон Худалдан авагч  нарын хооронд  өдөр байгуулсан Худалдах, худалдан авах гэрээнд дурдсан хөрөнгийг буцаан худалдан авахыг шаардаж, мэдэгдлийг хүргүүлж байна:

Буцаан худалдан авах гэрээг хэрэгжүүлэх хугацаа, нөхцөл:

Буцаан худалдан авах гэрээний огноо:

[Буцаан худалдан авах өдөр/Эргэн төлөлтийн өдөр]:

Буцаан худалдан авах дүн/зах зээлийн бодит үнэ:

Төлөөлж

Гарын үсэг зурсан

Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга

[ ]

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ  
MONGOLIAN STOCK EXCHANGE

2023-04-06

БҮРТГЭВ-02

СЗХ

2023-03-01 өдөр  
БҮРТГЭВ

№ 11



“Бэрс Эй Би Эс Плас” ТЗН-ийн ХХК-ийн  
Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны 04 сарын 06 өдөр  
өдрийн 02/24/23-р тогтоолын 7. хавсралт

**МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ  
ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ**




1. “Бэрс Эй Би Эс Плас ТЗК” ХХК (цаашид “Компани” гэх)-ийн Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх журам (цаашид “Журам” гэх)-ын зорилго нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, холбогдох хууль тогтоомж, зохицуулалтын байгууллагаас баталсан дүрэм, журам, стандартуудыг дагаж мөрдөх, үүсэж болох эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд оршино.
2. Компани нь Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 14.3-т зааснаар “Бэрс Финанс ББСБ” ХХК-ийн охин компани болохын хувьд “Бэрс Финанс ББСБ” ХХК-ийн мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх дотоод хяналтын хөтөлбөр болон мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх холбогдох дүрэм, журам, зааврыг мөрдөн ажиллана.
3. Компани нь Автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас (цаашид “ХБҮЦ” гэх) гаргах үйл ажиллагаатай холбоотойгоор үнэт цаасны зах зээлд оролцогчийн хувьд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дараах байдлаар хэрэгжүүлнэ. Үүнд:
  - 3.1. ХБҮЦ гаргах ажиллагаанд оролцогч талуудаас Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг дагаж мөрдөж ажиллахыг шаардах;
  - 3.2. Шаардлагатай тохиолдолд ХБҮЦ гаргах ажиллагаанд оролцогч талуудаас мэдээлэл, тайлан, баталгаа гаргуулан авах.
4. Компани нь энэхүү Журмын 3-т заасан чиг үүргээ хэрэгжүүлэхдээ Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-өөр дамжуулан хэрэгжүүлэх бөгөөд ТУЗ нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд дараах чиг үүрэгтэй оролцоно. Үүнд:
  - 4.1. Бодлогын баримт бичиг, дотоод дүрэм, журмыг батлах;
  - 4.2. Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн түвшинтэй уялдуулан дотоод хяналтын хөтөлбөрийг шинэчлэх;
9.2 Интернет нь найдваргүйд тооцогддог учраас мэдээлэл задрах, харилцаа холбоо тасалдах эрсдэлтэй ба өөр харилцаа холбооны аргыг сонгож болно. Түүнчлэн электрон харилцаа холбоо нь вируст өртгөмтгий байдаг. Талууд хуулиар байж болох хэмжээнд нь өөрсдийн эрх ашгаа хамгаалах үүрэгтэй ба интернет ашигласнаас эсвэл Аудиторын ажилтан Харилцагчийн сүлжээ, хэрэглээний программ болон бусад системд нэвтрэн орсноос үүдэх алдагдал, хохирлыг Талууд тус тусдаа хариуцна.

#### **10. Гэрээ. Гэрээний Өөрчлөлт болон Үйлчлэх Хүрээ**

10.1 Энэхүү гэрээнд тусгайлан заагаагүй бол энэхүү гэрээг байгуулахаас өмнө хэлэлцсэн зүйлс энэхүү гэрээний хэсэг болохгүй. Энэхүү гэрээ байгуулагдсанаар өмнөх гэрээ, түүнтэй холбогдох аман болон бичгийн харилцаа, ойлголтууд хүчингүй болно. Талууд гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулахад хоёр талын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж бичгээр баримтжуулснаар хүчин төгөлдөр болно. Энэхүү гэрээнд өөрчлөлт оруулахдаа гэрээнд оролцогч Тал нөгөө Талдаа бичгээр хүсэлт гаргаж /электрон шуудан эсвэл факсаар/, харилцан тохиролцсоны үндсэн дээр нэмэлт өөрчлөлтийг оруулах бөгөөд энэхүү нэмэлт өөрчлөлт нь гэрээний салшгүй хэсэг болно.

#### **11. Баталгааны Хязгаарлалт**

11.1 Энэ бол үйлчилгээний гэрээ. Аудитор нь энэхүү үйлчилгээгээ Харилцагчийн шаардлагад нийцүүлэн холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн үнэнч шударгаар, мэргэжлийн түвшинд хийж гүйцэтгэхээ баталж байна. Аудитор ямар нэгэн албан болон хууль ёсны бусад бүх баталгаа өгөхгүй.

#### **12. Бусад Харилцагчид**

12.1 Аудитор харилцагчийн аливаа мэдээлэл болон уг гэрээний дагуу гүйцэтгэсэн ажлын талаарх мэдээллийг өөр харилцагч, гуравдагч тал болон Харилцагчийн өрсөлдөгч болон бусад компаниудад задруулах эсвэл эдгээр өрсөлдөгчдийн үр ашгийн төлөө хэрэглэх ёсгүй.

#### **13. Боловсон Хүчин**

13.1 Энэхүү гэрээ байгуулагдахаас өмнө ажилтантай тохиролцохоос бусад тохиолдолд, үйлчилгээ үзүүлж эхэлснээс хойш 12 сарын хугацаанд Аудитор болон Харилцагч нь аль аль талын ажилтанд шууд ба шууд бус байдлаар ажил олгохгүй, ажлын санал тавихгүй.

#### **14. Ажлын Баримтын Устгалт**

14.1 Үйлчилгээ үзүүлж дууссаны дараа Аудиторт үлдсэн ажлын баримтыг (хуулийн дагуу Харилцагчид хамаарах баримт) Аудиторын хэрэглэгдэж буй бодлогын дагуу устгана.

#### **15. Харилцагчийн Нэрийг Ашиглах**

15.1 Аудитор нь Харилцагчийн зөвшөөрөлтэйгөөр түүний нэр ба үзүүлсэн үйлчилгээнийхээ талаар маркетинг, сурталчилгаандаа өөрийн туршлагаа харуулах зорилгоор болон дотоод мэдээллийн сандаа ашиглаж болно.

#### **16. Давагдашгүй Хүчин Зүйл**

16.1 Олон Улсын Худалдааны Танхимын давагдашгүй хүчин зүйлийн зүйл анги (ICC Publication № 421 E) нь энэхүү Гэрээний нэг хэсэг болно. Давагдашгүй хүчин зүйлийн талаар уг үйл явдал болсноос хойш ажлын 5 хоногийн дотор бичгээр мэдэгдсэн байна. Хэрэв давагдашгүй хүчин зүйл 2 сараас дээш хугацаагаар үргэлжилсэн тохиолдолд аль ч Тал бичгээр мэдэгдэн Гэрээг цуцлах эрхтэй. Гэрээ нь уг мэдэгдлийг хүлээж авсан өдрөөс цуцлагдсанд тооцогдоно.

#### **17. Гэрээний Хугацаа ба Цуцлалт**



17.1 Энэхүү Гэрээ нь Талууд гарын үсэг зурсан өдрөөс хүчин төгөлдөр болох бөгөөд талууд гэрээнд заасан үүргүүдээ биелүүлж дуусах хүртэл эсвэл энэхүү 17-р зүйлд заасны дагуу цуцлагдах хүртэл хүчин төгөлдөр байна.

17.2 Энэхүү гэрээний дагуу гүйцэтгэх ажлын ерөнхий төлөвлөгөө, хугацаа

№	Гүйцэтгэх ажил	Цаг хугацааны төлөвлөгөө:
2	Гэрээ байгуулах	2022/11/09
3	Нууцын гэрээ байгуулах	2022/11/09
4	Зээлийн хөрөнгийн багцын болон түүврээр сонгогдсон зээлийн мэдээллийг солилцох	2022/11/11
5	Дүн шинжилгээ хийх, тайлан гаргах	2022/11/14-2022/11/29
6	Дүн шинжилгээний тайлан хүлээн авах	2022/12/02
7	Дүн шинжилгээний тайланг хэлэлцэх	2022/12/05
8	Ажлыг дүгнэх	“Бэрс Финанс ББСБ” ХХК болон “Бэрс Эй Би Эс Плас” ХХК-ийн ТУЗ-д тайланг танилцуулсанаас хойш тохиролцсон хугацаанд танилцуулах

17.3 Аудитор нь энэхүү гэрээний дагуу үйлчилгээ үзүүлэхдээ 17.2-д заасан хугацааг нарийн баримтлан ажиллах бөгөөд харилцагч нь хугацаа хожимдсон үүргийн гүйцэтгэлийг хүлээн авах үүрэггүй.

17.4 Аль ч Тал нөгөө Талдаа албан бичгээр мэдэгдэл хүргүүлснээр гэрээг цуцлах боломжтой. Уг мэдэгдэл нь Гэрээг цуцлах өдрийг (цаашид Дуусгавар болгох Өдөр гэх) заасан байх бөгөөд Гэрээ цуцлагдахаас дор хаяж 20 (ажлын) хоногийн өмнө хүргэгдсэн байна. Гэрээ нь мэдэгдэлд заасан Дуусгавар болгох өдөр дуусгавар болсонд тооцогдох бөгөөд хэрэв мэдэгдэл нь Гэрээг цуцлах өдрөөс 20-иос бага хоногийн өмнө ирсэн бол мэдэгдлийг хүлээж авснаас хойш 20 хоногийн дараа гэрээний хугацааг дуусгавар болгосонд тооцно.



17.5 Хэрэв Аудитор нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй гэсэн шалтгаанаас өөр шалтгаанаар энэхүү Гэрээг Харилцагч 17.4-р зүйлд заасны дагуу цуцалбал, эсхүл Гэрээгээр хүлээсэн үүргээ Харилцагч биелүүлээгүй гэсэн шалтгаанаар Аудитор гэрээг цуцлах тохиолдолд Харилцагч нь Аудиторын гүйцэтгэсэн бодитой үйлчилгээнд тохирсон хөлсийг төлөх үүрэгтэй.

17.6 Аудитор нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй (аудитораас үл хамаарах шалтгаанаар хугацаа хэтрүүлснийг хамаарахгүй) хугацаа хэтрүүлсэн тохиолдолд Харилцагч нь 3 хоногийн нэмэлт хугацаа тогтоож өгөх бөгөөд уг хугацаанд үүргийг гүйцэтгээгүй тохиолдолд гэрээг цуцлах эрхтэй. Энэхүү шалтгаанаар гэрээг цуцлах тохиолдолд Аудитор нь гэрээний үнийн дүнгийн 20 хувьтай тэнцэх хэмжээний торгуулийг Харилцагчид төлөх бөгөөд Харилцагч нь Аудитор төлсөн төлбөрөө буцаан шаардах, үлдэгдэл төлбөрийг төлөхөөс татгалзах эрхтэй.

17.7 Гэрээний 6.1-6.9 болон 8.4 заалтууд нь гэрээ цуцлагдсан эсэхээс үл хамааран хүчин төгөлдөр хэвээр байна.

## 18. Хууль ба Маргаан Шийдвэрлэлт

18.1 Энэхүү Гэрээний хүчин төгөлдөр байдал, тайлбар болон гүйцэтгэлийг Монгол Улсын хуулиар зохицуулна.



18.2 Хэрэв Талууд үүссэн ямарваа маргааныг өөрсдийн хэлэлцээрээр шийдвэрлэх боломжгүй болсон тохиолдолд Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

#### 19. Эцсийн Зүйлүүд

19.1 Өмнө нь бичгээр хязгаарлалт хийн мэдэгдээгүй тохиолдолд Харилцагчийн эрх бүхий этгээдээс аман болон бичгэн хэлбэрээр өгсөн аливаа зааврыг Аудитор нь дагах эрхтэй.

19.2 Харилцагч нь зөвхөн Аудиторын урьдчилан өгсөн бичгэн зөвшөөрлийг үндэслэн өөрийн энэхүү гэрээгээр хүлээсэн эрхээ бүхэлд нь эсвэл зарим хэсгийг нь бусдад шилжүүлж болно.

19.3 Энэхүү Гэрээ нь Талуудын өмнө нь энэхүү Гэрээгээр зохицуулсан зүйлтэй холбогдуулан байгуулсан аливаа гэрээ, хэлцэл зэргийг хүчингүй болгоно. Үүнд Энэхүү Гэрээ байгуулсны дараа хүчингүй болох Мэдээллийн нууцлалын гэрээгээр хязгаарлагдахгүй

19.4 Энэхүү Гэрээний бүх нэмэлт, өөрчлөлтүүд нь бичгээр үйлдэгдэх бөгөөд Гэрээний салшгүй нэг хэсэг болно.

УБ-2

2023-04-06

Монгол Улсын Засгийн газрын  
2004 оны 20 дугаар тогтоолоор батлал.



# МОНГОЛ УЛС

## УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

0000086027

2011.07.06

/ Бүртгэсэн он, сар, өдөр /

9022001010

/ Улсын бүртгэлийн дугаар /

5495997

/ Регистрийн дугаар /

Өмгөөллийн Эм Ди Эс энд хаанлекс ХХН

Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл

/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Гэрээ

/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

Тогтоол

01

2011.06.30

/ шийдвэрийн нэр /

/ дугаар /

/ он, сар, өдөр /

6910

/ код /

Хууль зүйн зөвлөгөө өгөх

/ Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

/ код /

/ Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

Хугацаагүй

6

1,500.00

/ хугацаа /

/ гүйцүүлийн тоо /

/ берийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /

Улаанбаатар, Сүхбаатар, 5-р хороо, 5 хөрсөлөл, 22, 24 тоот, Утас1: 91913905, Утас2: 99999678, Факс:

/ хуулийн этгээдийн глбан ёсны хаяг /

Улсын бүртгэлийн ерөнхий  
газрын Бүртгэлийн газар

/ бүртгэсэн байгууллагын нэр /

2014.08.07

Гэрчилгээ дахин олгосон 2014 он 8 сар 7 өдөр



2023-04-06

Харилцах дансны бүртгэл

СХХ

04 02Р 0100

Харилцагч банкны нэр	Дансны төрөл	Дансны дугаар	Бүртгэсэн ажилтан тэмдэг
Голомт банк	Валютын	1410003014	Г.Өлзийбаяр
Голомт банк	Валютын	1105091644	У.Даваасүрэн
Голомт банк	Төгрөгийн	1105088619	У.Даваасүрэн
Голомт банк	Валютын	1105079896	В.Хандсүрэн
Голомт банк	Төгрөгийн	1105079891	В.Хандсүрэн
Голомт банк	Төгрөгийн	1105079895	В.Хандсүрэн
Голомт банк	Валютын	1105079882	В.Хандсүрэн

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

Д/д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн:	
		Огноо	Ажилтан тэмдэг
1	Жанчивдорж овогтой Майзори-г Захирал-р томилсныг бүртгэв.	2011.07.07	Г.Өлзийбаяр
2	Дахин гэрчилгээ олгов.	2014.08.07	У.Даваасүрэн
5	Голомт төв банк банкны 1105088620 тоот төгрөгийн дансыг бүртгэв. Голомт төв банк банкны 1105088622 тоот валютын дансыг бүртгэв. Голомт төв банк банкны 1105088623 тоот валютын дансыг бүртгэв. Голомт төв банк банкны 1105091643 тоот төгрөгийн дансыг бүртгэв. Голомт төв банк банкны 1105091645 тоот төгрөгийн дансыг бүртгэв. Голомт төв банк банкны 1105091646 тоот валютын дансыг бүртгэв.	2014.08.07	У.Даваасүрэн
7	Голомт төв банк банкны 1410003013 тоот төгрөгийн дансыг бүртгэв. Голомт төв банк банкны 1105079887 тоот төгрөгийн дансыг бүртгэв. Голомт төв банк банкны 1105079889 тоот төгрөгийн дансыг бүртгэв. Голомт төв банк банкны 1105079893 тоот төгрөгийн дансыг бүртгэв. Голомт төв банк банкны 1105079894 тоот валютын дансыг бүртгэв. Голомт төв банк банкны 1105079888 тоот валютын дансыг бүртгэв. Голомт төв банк банкны 1105079890 тоот валютын дансыг бүртгэв.	2011.07.07	Г.Өлзийбаяр
9	ХААН банк банкны 5007965794 тоот төгрөгийн дансыг бүртгэв. ХААН банк банкны 5007965807 тоот валютын дансыг бүртгэв.	2015.06.04	Б.Энхбаяр
10	Хувь нийлүүлэгчээс 1 хасагдаж үүсгэн байгуулагчийн тоо нийт 7 болж өөрчлөгдсөнийг бүртгэв.	2018.01.22	Б.Лхагвасүрэн
11	Хувь нийлүүлэгчээс 1 хасагдаж үүсгэн байгуулагчийн тоо нийт 6 болж өөрчлөгдсөнийг бүртгэв.	2018.01.22	Б.Лхагвасүрэн
12	Өөрийн хөрөнгийн хэмжээ 250 мян.төг-р хасагдаж нийт 1250 мян.төг болсон өөрчлөлтийг бүртгэв.	2018.01.22	Б.Лхагвасүрэн
13	Хувь нийлүүлэгчээс 1 нэмэгдэж, 1 хасагдаж үүсгэн байгуулагчийн тоо нийт 6 болж өөрчлөгдсөнийг бүртгэв.	2018.09.21	С.Манхсанчир
14	Хувь нийлүүлэгчээс 1 хасагдаж үүсгэн байгуулагчийн тоо нийт 5 болж өөрчлөгдсөнийг бүртгэв.	2018.10.01	Ж.Окумаа
15	Өөрийн хөрөнгийн хэмжээ 125 мян.төг-р хасагдаж нийт 1125 мян.төг болсон өөрчлөлтийг бүртгэв.	2018.10.01	Ж.Окумаа
16	Өөрийн хөрөнгийн хэмжээ 250 мян.төг-р хасагдаж нийт 875 мян.төг болсон өөрчлөлтийг бүртгэв.	2019.06.17	Э.Эрдэнэбилэг
17	Хувь нийлүүлэгчээс 1 хасагдаж үүсгэн байгуулагчийн тоо нийт 4 болж өөрчлөгдсөнийг бүртгэв.	2019.06.17	Э.Эрдэнэбилэг
18	Улаанбаатар, Сүхбаатар, 8-р хороо, Сүхбаатарын талбай 2 Сэнтрал пазур 13 давхар 1301 тоот, Утас1 91913905, Утас2 99999678, Факс хаягийг	2019.06.17	Э.Эрдэнэбилэг
24	Эцсийн өөрчлөгч 4 иргэн бүртгэв.	2020.08.14	С.Манхсанчир

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.





САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2016 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 42

Улаанбаатар хот

"Эм Ди Эс энд ХаанЛекс" ХХН-ийг  
үнэт цаасны зах зээлд хууль зүйн зөвлөгөө үзүүлэх  
хуулийн этгээдээр бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24.1.15, 24.3, Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 451 дугаар тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдийг бүртгэх тухай журам"-ын 4.2, 4.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Өмгөөллийн "Эм Ди Эс энд ХаанЛекс" ХХН-ийг үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдээр бүртгэсүгэй.
2. Өмгөөллийн "Хаанлекс" ХХН, Өмгөөллийн "Эм Ди Эс энд Ассошэйтс" ХХН нар нь нэгдэж "Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН болсон тул "Хаанлекс" ХХН, "Эм Ди Эс энд Ассошэйтс" ХХН нарыг үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдийн бүртгэлээс хассугай.
3. Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг Өмгөөллийн "Эм Ди Эс энд ХаанЛекс" ХХН /Ж.Майзориг/-д үүрэг болгосугай.
4. Тогтоолыг олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /П.Алтан-Од/-т, Хорооны нэгдсэн бүртгэлд бүртгэхийг Бүртгэл, зөвшөөрлийн газар /Ю.Нэргүй/-т үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар /Б.Оюунцацрал/-т тус тус даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ГҮЙЦӨТГЭГЧ,  
ДЭД ДАРГА  БАТБОЛД



000000




2023-04-06

БҮРТГЭВ-02

2022 оны // дүгээр  
сарын 08-ны өдөр

ХУУЛЬ ЗҮЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ

Дугаар Д-С 1272230



Энэхүү Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээ (цаашид "Гэрээ" гэх)-г Монгол Улсын Иргэний хуулийн 343-358 дугаар зүйлүүд болон холбогдох бусад хууль тогтоомжийг үндэслэн,

**Нэг талаас:** Монгол Улсын хуулийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулж буй Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сүхбаатарын талбай, Сэнтрал Тауэр, 13 давхар, 1301 тоот хаягт орших "Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН (Регистрийн дугаар: 5495997, цаашид "Хуулийн зөвлөх" гэх)-ийг төлөөлж, Нөхөрлөлийн гишүүн, хуульч Д.Дүгэржав;

**Нөгөө талаас:** Монгол Улсын хуулийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулж буй Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 11-р хороо, 7 хороолол, Ногоон нуур, 101 барилга, 706 тоот хаягт орших "Бэрс финанс ББСБ" ХХК (цаашид "Үйлчлүүлэгч" гэх)-ийг төлөөлж, Гүйцэтгэх захирал С.Отгонбат (Регистрийн дугаар: 6186858, цаашид тус бүрт нь "Тал", хамтад нь "Талууд" гэх) харилцан тохиролцсоны дагуу энэхүү Гэрээг дор дурдсан нөхцөлөөр байгуулав.


**1. НИЙТЛЭГ ЗҮЙЛ**

- 1.1. Гэрээний зорилго нь Хуулийн зөвлөх нь Гэрээгээр тохиролцсон хуулийн хөндлөнгийн шинжээч, зөвлөхийн үйлчилгээг Үйлчлүүлэгчид үзүүлэх, Үйлчлүүлэгч нь тохиролцсон хөлсийг Хуулийн зөвлөхөд төлөхтэй холбоотойгоор Талуудын харилцан хүлээх эрх, үүрэг, хариуцлагатай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзсэн нөхцөлд зөвхөн Талууд зөвшилцөн тохиролцсоны үндсэн дээр бичгээр үйлдэж талууд тамга тэмдэг, гарын үсгээр баталгаажуулан Гэрээний эх хувьд хавсаргаж болно.
- 1.3. Энэхүү Гэрээ нь энэ Гэрээ болон түүний хавсралтаас бүрдэнэ. Гэрээ, түүний хавсралтад оруулсан нэмэлт, өөрчлөлт нь гэрээний салшгүй хэсэг байх бөгөөд Гэрээний хамт хүчин төгөлдөр байна.
- 1.4. Талуудын аль нэг нь нөгөө талын зөвшөөрөлгүйгээр Гэрээний эрх, үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

**2. ГЭРЭЭТ АЖИЛ**

- 2.1. Хуулийн зөвлөх нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох бусад хууль, эрх бүхий байгууллагаас баталсан журмын дагуу Үйлчлүүлэгчээс Автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас (цаашид "ХБҮЦ" гэх) гаргаж, Монголын хөрөнгийн биржээр нийтэд санал болгох (цаашид "Төсөл" гэх) хүрээнд Монгол Улсын хуулийн дагуу Төслийн бүтэц, оролцогч талууд, тэдгээрийн хооронд үүсэх харилцаа, хөрөнгөд тавигдах шаардлага зэргийг тодорхойлох, хөрөнгийн багцад шинжилгээ хийж тайлан гаргах, Төслийн хүрээнд оролцогчдын хооронд байгуулах гэрээ/гэрээний төсөл хүчин төгөлдөр, хуульд нийцсэн эсэх, Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан мэдээлэл үнэн зөв, хуульд нийцсэн эсэх талаар хууль зүйн дүгнэлт гаргах, үнэт цаасыг МХБ-д бүртгүүлэх, Санхүүгийн зохицуулах хорооноос холбогдох тусгай зөвшөөрөл авахтай холбогдсон асуудлаар хууль зүйн зөвлөх үйлчилгээ (цаашид "Зөвлөх үйлчилгээ" гэх)-г энэхүү Гэрээнд заасан Зөвлөх үйлчилгээний цар хүрээ, даалгавар, үнэ, хугацаа, нөхцөлөөр хийж гүйцэтгэх ба Үйлчлүүлэгч ажлын хөлсийг Гэрээний нөхцөл, ажлын гүйцэтгэлтэй уялдуулан тохирсон хугацаанд төлнө.
- 2.2. Хуулийн зөвлөхийн "Зөвлөх үйлчилгээний ажлын даалгавар"-ыг Гэрээний салшгүй хэсэг болох Хавсралтаар тохиролцсон бөгөөд талууд хийж гүйцэтгэх ажлын нарийвчилсан





дэлгэрэнгүй хуваарийг Үйлчлүүлэгчийн Төслийн бэлтгэл, хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй уялдуулан харилцан тохиролцоно.

- 2.3. Гэрээний дагуу үзүүлсэн Зөвлөх үйлчилгээ нь Гэрээнд заасан ажлыг бүрэн гүйцэтгэж дууссанаар дуусгавар болно.

### 3. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

- 3.1. Гэрээ нь Талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болох бөгөөд Талууд Гэрээг цуцлах, Гэрээний хугацаа дуусгавар болох хүртэл хугацаанд хүчин төгөлдөр байна.
- 3.2. Энэхүү Гэрээний дагуу Зөвлөх үйлчилгээг 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдрөөс эхлүүлэн Гэрээний үүрэг бүрэн дуусгавар болох хүртэл хугацаанд үзүүлнэ.
- 3.3. Гэрээний дагуу Зөвлөх үйлчилгээний ажлыг бүрэн гүйцэтгэж дууссанаар Гэрээ дуусгавар болно.

### 4. ГЭРЭЭТ АЖЛЫН ХӨЛС, ЗАРДАЛ, ТӨЛБӨР ТООЦОО

- 4.1. Гэрээгээр тохиролцсон Зөвлөх үйлчилгээний нийт хөлс [REDACTED] төгрөг байна. Ажлын гүйцэтгэлийн төлбөрт НӨАТ багтаагүй болно.
- 4.2. Үйлчлүүлэгч нь төлбөрийг дараах нөхцөлөөр 2 хувааж төлөхөөр тохиролцов. Үүнд:
- 4.2.1. Гэрээ байгуулагдсан өдрөөс хойш ажлын 3 (гурав) өдөрт багтаан урьдчилгаа төлбөр болох [REDACTED] төгрөгийг 10 хувийн НӨАТ-ын хамт;
- 4.2.2. Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид ХБҮЦ гаргахтай холбоотой бүх баримт бичгийг хүлээлгэн өгсөн өдрөөс хойш ажлын 3 (гурав) өдрийн дотор үлдсэн төлбөр болох [REDACTED] тогрогийг 10 хувийн НӨАТ-ын хамт тус тус төлнө.
- 4.3. Төлбөрийг дор заасан дансанд төлнө:  
Төлбөр хүлээн авагч: Өмгөөллийн “Эм Ди Эс Энд Хаанлекс” ХХН  
Төлбөр хүлээн авагчийн банк: Голомт банк  
Төлбөр төлөх дансны дугаар: 1105079893  
Валют: Төгрөгийн.
- 4.4. Зөвлөх үйлчилгээний хөлсөнд төрийн байгууллагаас лавлагаа гаргуулах, нотариатын хөлс, тэмдэгтийн хураамж, орчуулгын зардал зэрэг Зөвлөх үйлчилгээ үзүүлэхтэй холбоотойгоор Хуулийн зөвлөхийн гаргасан зардал багтаагүй бөгөөд холбогдох баримтыг үндэслэн Үйлчлүүлэгчээс нэхэмжлэн авах эрхтэй бөгөөд бичиг хэрэг, тээвэр, шуудан хүргэлтийн зардлыг Хуулийн зөвлөх хариуцна.

### 5. ХУУЛИЙН ЗӨВЛӨХИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 5.1. Хуулийн зөвлөх нь дараах эрх эдэлнэ.
- 5.1.1. Гэрээнд заасан үүргээ гүйцэтгэхийг Үйлчлүүлэгчээс шаардах;
- 5.1.2. Гэрээний төлбөрөө Гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэхийг шаардах;
- 5.1.3. Үйлчлүүлэгч нь Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд Гэрээг цуцлах;
- 5.1.4. Гэрээнд заасан Зөвлөх үйлчилгээг гүйцэтгэхтэй холбоотойгоор тухай бүрт шаардлагатай мэдээ мэдээлэл, баримт бичгийг Үйлчлүүлэгчээс шаардан авах.
- 5.2. Хуулийн зөвлөх нь дараах үүрэг хүлээнэ. Үүнд:
- 5.2.1. Хуулийн зөвлөх нь Гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор, Гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэх;
- 5.2.2. Хуулийн зөвлөх нь шаардлагатай тохиолдолд өөрийн гаргасан хөндлөнгийн шинжилгээний тайлан, хуулийн дүгнэлтийн талаар хөрөнгө оруулагч, зохицуулагч байгууллага болон бусад этгээдийн өмнө шалгасан материалын хүрээнд тайлбар, тодруулга огох, ташилцуулга хийх;
- 5.2.3. Гэрээнд заасны дагуу үйлчилгээ үзүүлэхдээ үнэн бодит мэдээллээр хангах, үйлчилгээ үзүүлсэн талаар бүртгэл хөтлөх, тайлан гаргах, Үйлчлүүлэгчийн нууцыг чандлан хадгалах.

### 6. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 6.1. Үйлчлүүлэгч нь дараах эрх эдэлнэ. Үүнд:

2023-04-06

БҮРТГЭВ



- 6.1.1. Гэрээний дагуу тохиролцсон ажлын гүйцэтгэлийг Гэрээнд заасан хугацаанд Хуулийн зөвлөхөөс шаардах;
- 6.1.2. Хуулийн зөвлөхөд үйлчилгээний талаар шаардлага тавих, санал гаргах;
- 6.1.3. Хуулийн зөвлөх нь Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд Гэрээг цуцлах;
- 6.1.4. Үйлчлүүлэгч нь Зөвлөх үйлчилгээг үзүүлэх хугацаанд тухай бүр дотоод шаардлагатай мэдээллийг солилцоходоо энэ Гэрээний 7 дугаар зүйлд заасан этгээдээр дамжуулан харьцана.
- 6.2. Үйлчлүүлэгч нь дараах үүрэг хүлээнэ. Үүнд:
- 6.2.1. Гэрээний дагуу гүйцэтгэж буй ажил үйлчилгээтэй холбоотой бүхий л мэдээ мэдээлэл, баримт бичгээр Хуулийн зөвлөхийг хангах, шаардлагатай тохиолдолд хамтран ажиллах байраар хангах;
- 6.2.2. Гэрээнд заасны дагуу үнэн бодит мэдээллээр хангах;
- 6.2.3. Хуулийн зөвлөхийн нууцыг чандлан хадгалах;
- 6.2.4. Гэрээгээр харилцан тохирсон хугацаанд ажлын хөлсийг саадгүй төлөх үүрэгтэй.

## 7. ХАРИЛЦАХ ХҮМҮҮС

### 7.1. Хуулийн зөвлөхийг төлөөлж:

Нэр: Д.Дүгэржав  
Албан тушаал: Нөхөрлөлийн гишүүн, хуульч  
Утас: 99119181  
Цахим шуудан: [dugerjav@mdsa.mn](mailto:dugerjav@mdsa.mn)

Нэр: М.Ариунзул  
Албан тушаал: Ассошейт  
Утас: 88978811  
Цахим шуудан: [ariunzul@mdsa.mn](mailto:ariunzul@mdsa.mn)

Нэр: Н.Номин  
Албан тушаал: Ахлах ассошейт  
Утас: 95524595  
Цахим шуудан: [nomin@mdsa.mn](mailto:nomin@mdsa.mn)


Нэр: Т.Мөнгөнцэцэг  
Албан тушаал: Ассошейт  
Утас: 89466688  
Цахим шуудан: [munguntsetseg@mdsa.mn](mailto:munguntsetseg@mdsa.mn)

### 7.2. Үйлчлүүлэгчийг төлөөлж:

Нэр: С.Отгонбат  
Албан тушаал: Гүйцэтгэх захирал  
Утас: 99119632  
Цахим шуудан: [otgonbat@bichilglobus.mn](mailto:otgonbat@bichilglobus.mn)

Нэр: Б.Баярчимэг  
Албан тушаал: Дэд захирал  
Утас: 99100957  
Цахим шуудан: [bayarchimeg.b@bichilglobus.mn](mailto:bayarchimeg.b@bichilglobus.mn)

Нэр: Я.Адъяахүү  
Албан тушаал: Санхүү бүртгэлийн газрын захирал  
Утас: 88117328  
Цахим шуудан: [adiyakhuu@bichilglobus.mn](mailto:adiyakhuu@bichilglobus.mn)



Нэр: Д.Энхчимэг  
Албан тушаал: Санхүүгийн шинжээч  
Утас: 88105354  
Цахим шуудан: [enkhchimcg@bichilglobus.mn](mailto:enkhchimcg@bichilglobus.mn)

#### 8. ХАРИУЦЛАГЫН ХЯЗГААРЛАЛТ

- 8.1. Үйлчлүүлэгч нь Хуулийн зөвлөхөд Зөвлөх үйлчилгээтэй холбоотой байж болох аливаа бүх мэдээллийг бүрэн бөгөөд үнэн зөвөөр өгөх үүрэгтэй. Энэ зүйлд заасан “Мэдээлэл” гэдэгт бичгийн, аман, дуу, дүрс, ам дамжсан яриа, бодит таамаг гэх мэт үйлчилгээ авах асуудалтай холбоотой бүх хэлбэр, төрлийн мэдээ, мэдээлэл, мэдүүлэг зэрэг үйлчилгээ үзүүлэхэд ач холбогдолтой болон ач холбогдолтой байж болох Үйлчлүүлэгч, түүний ажилтан, албан хаагч, төлөөлөгч, Холбоотой этгээдийн мэдэж байгаа аливаа зүйлийг ойлгоно.
- 8.2. Үйлчлүүлэгч Гэрээний 8.1-д заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд үүсэх хариуцлагаас Хуулийн зөвлөх чөлөөлөгдөнө.

#### 9. ГЭРЭЭГ ДУУСГАВАР БОЛГОХ

- 9.1. Энэхүү Гэрээ нь Талуудын эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тэмдэг (тамга) дарж баталгаажуулж, Гэрээний нөхцөл бүрэн биелэгдсэнээр, эсхүл Гэрээ хугацаанаасаа өмнө цуцлагдсанаар дуусгавар болно.
- 9.2. Үйлчлүүлэгч нь энэхүү Гэрээг хэдийд ч цуцлах, дуусгавар болгох эрхтэй. Ийнхүү Гэрээг дуусгавар болгох тохиолдолд энэ тухай Хуулийн зөвлөхөд хуанлийн 14 хоногийн өмнө бичгээр мэдэгдэнэ.

#### 10. ГЭНЭТИЙН БОЛОН ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

- 10.1. Дайн, иргэний бослого, түймэр, үер, халдварт өвчин, газар хөдлөлт, хорио цээр, тээврийн хориг, Төрийн эрх бүхий байгууллагын хориглосон, хязгаарласан шийдвэр, Цахилгааны болон сүлжээний доголдол, хязгаарлалт болон талуудын хүсэл зоригоос үл хамаарах бусад гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал үүссэнээс Үйлчлүүлэгч, эсхүл Хуулийн зөвлөхийн Гэрээний үүргийн гүйцэтгэл хугацаа хоцорсон бол Талууд тохиролцож гүйцэтгэх хугацааг сунгана.
- 10.2. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал үүссэн тохиолдолд Хуулийн зөвлөх нь энэ нөхцөл байдал болон үүссэн шалтгааны талаар Үйлчлүүлэгчид нэн даруй бичгээр мэдэгдэнэ. Үйлчлүүлэгч бичгээр өөрөөр зааварлаагүй бол Хуулийн зөвлөх Гэрээний үүргээ боломжтой хэмжээнд үргэлжлүүлэн гүйцэтгэж, гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлаас үл шалтгаалан гэрээг хэрэгжүүлэх боломжит арга замыг хайна.
- 10.3. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллөөр аль нэг Тал нь Гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүй тохиолдолд тухайн Талыг Гэрээний үүрэг зөрчсөн гэж үзэхгүй.

#### 11. БУСАД ЗҮЙЛ

- 11.1. Талуудаас Гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотойгоор ашиглагдсан мэдээлэл, баримт материал, мэдээлэл, баримтууд нь тухайн талын эзэмшил, өмчлөлд хэвээр үлдэнэ.
- 11.2. Талууд харилцан тохиролцож бичгээр гэрээ байгуулах хэлбэрээр Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болно.
- 11.3. Энэхүү Гэрээ нь Монгол Улсын хуулиар зохицуулагдах бөгөөд маргаан, зөрчилдөөн үүссэн нөхцөлд эв зүйгээр зохицуулахыг эрмэлзэх бөгөөд боломжгүй нөхцөлд Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.
- 11.4. Энэхүү гэрээг хоёр эх хувь үйлдсэн ба хувь тус бүр нь хууль зүйн бүрэн хүчин төгөлдөр баримт болно.




МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ  
MONGOLIAN STOCK EXCHANGE

2023-04-06

Талууд энэхүү Гэрээнд заасан нөхцөл, заалтуудыг хүлээн зөвшөөрч байгаагаа нотлон гарын үсэг зурж, баталгаажуулав.

БҮРТГЭВ-02



Хуулийн зөвлөх:

Өмгөөллийн Эм Ди Эс энд ХаанЛекс ХХН,  
түүнийг төлөөлж Нөхөрлөлийн гишүүн,  
хуульч

Д.ДУГЭРЖАВ

(Гарын үсэг, тамга)

Огноо:



Үйлчлүүлэгч тал:

“Бэрс финанс ББСБ” ХХК, түүнийг төлөөлж  
Гүйцэтгэх захирал

С.ОТГОНБАТ

(Гарын үсэг, тамга)

Огноо:



2023-04-06  
БҮРТГЭВ-02



СХ  
2023-04-06  
БҮРТГЭВ  
№ 01

### ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ДААЛГАВАР

Хуулийн зөвлөх нь дараах ажлын даалгаврын хүрээнд Зөвлөх үйлчилгээг үзүүлнэ:

1. Үйлчлүүлэгч нь анх удаа ХБҮЦ гаргаж МХБ-ээр олон нийтэд санал болгохоор төлөвлөж байгаа тул уг Төслийн үйл ажиллагааны загвар бүтэц, оролцогч талууд, тэдгээрийн хооронд үүсэх харилцаа, байгуулах гэрээний агуулгын талаар Үйлчлүүлэгчтэй хамтран ажиллаж тодорхойлоход оролцох;
2. ХБҮЦ гаргах хэлцлийн нэгдсэн хөрөнгийн багцад тавигдах хууль зүйн шаардлагыг Үйлчлүүлэгчтэй хамтран тодорхойлох, бусад шаардлага(санамсаргүй түүврийн аргаар сонголт хийхэд тавигдах шаардлага, хэлцлийн нэгдсэн хөрөнгийн багцад тавигдах санхүүгийн шаардлага)-ыг тодорхойлох талаар Үйлчлүүлэгчид зөвлөх;
3. ХБҮЦ гаргах ажиллагааны оролцогч талуудын хооронд үүсэх харилцаа, тэдгээрийн хооронд байгуулагдах гэрээний төрөл, тэдгээрийн агуулгын талаар Үйлчлүүлэгчид зөвлөх, Үйлчлүүлэгчийн бэлтгэсэн гэрээний төслүүдийг хянах;
4. Нэгдсэн хөрөнгийн багцын нийт үнийн дүнгийн 5%-тай тэнцэх хэмжээний зээлийн багцаас санамсаргүй түүврийн аргаар 95%-ийн итгэлцлийн түвшин, 5%-ийн хүлээгдэж буй алдааны хязгаартайгаар сонгож, хуулийн шалгуур үзүүлэлт, хууль, журмын хэрэгжилтийг хангуулсан эсэхэд хуулийн хөндлөнгийн шинжилгээ гүйцэтгэн тайлан бэлтгэж Үйлчлүүлэгчид хүлээлгэн өгөх, шаардлагатай бол танилцуулга хийх. Үүнд:
  - 4.1.1. ХБҮЦ гаргах хэлцлийн Нэгдсэн хөрөнгийн багцаас санамсаргүй түүврийн аргаар сонгосон зээлийн дансдын хувийн хэрэг, зээлийн мэдээлэлд тогтоосон шалгуур үзүүлэлтийн дагуу шинжилж, алдаа зөрчил илэрсэн, эсхүл илрээгүй талаар Үйлчлүүлэгч болон түүний үүсгэн байгуулагч нарт танилцуулах, тайлбар, тодруулга хүргүүлэх;
  - 4.1.2. Нэгдсэн хөрөнгийн багцаас түүвэрлэгдэн сонгогдсон зээлийн дансдын хувийн хэрэгтэй танилцаж хуулийн шалгуур үзүүлэлт, хууль, журмын хэрэгжилтийг хэрхэн хангуулсан эсэхэд газар дээрх судалгаа шинжилгээ гүйцэтгэх;
  - 4.1.3. Гүйцэтгэсэн судалгаа, шинжилгээний ажлын үр дүнд тулгуурлан Хөндлөнгийн шинжээчийн тайлан бэлтгэж, Үйлчлүүлэгчид хүлээлгэн өгөх;
  - 4.1.4. Хөндлөнгийн шинжилгээний ажлын хүрээнд хийгдсэн судалгаа, шинжилгээ, хууль зүйн дүгнэлтэд тулгуурлан шаардлагатай бол санал зөвлөмж боловсруулан үнэт цаас гаргагчид хүргүүлэх.
5. Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржээс баталсан Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргахтай холбоотой журамд заасны дагуу дараах асуудлаар хууль зүйн дүгнэлт гаргах Үүнд:
  - 5.1. ТЗК-ийг үүсгэн байгуулах ажиллагаа болон түүнийг хуулийн этгээдийн бүртгэлд бүртгүүлсэн байдал нь хууль тогтоомжийн хүрээнд хийгдсэн, холбогдох шийдвэр, гэрчилгээ, дүрэм зэрэг нь хүчин тоголдор эсэх
  - 5.2. ХБҮЦ гаргах тухай шийдвэр нь хууль тогтоомжид нийцсэн эсэх;
  - 5.3. ТЗК-ийн дүрэм, үндсэн үйд ажиллагаанд ашиглагдах журам, зааврууд нь хууль тогтоомжид нийцсэн эсэх
  - 5.4. Баталгааг үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч этгээд буюу анхны үүрэг гүйцэтгүүлэгч, худалдагчтай байгуулсан хөрөнгө шилжүүлэх, худалдах, худалдан авах, үйлчилгээ үзүүлэх, хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ, хэлцэл зэрэг нь хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх, үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагавар байгаа эсэх;





- 5.5. багцын хөрөнгөөс үүргийн гүйцэтгэлийг хангуулахтай холбогдох гэрээ, хэлцэл нь хууль тогтоомжид нийцсэн эсэх, гэрээ, хэлцэлд Үүргийн гүйцэтгэлийн зүйлтэй холбоотой аливаа шаардах эрхийг шилжүүлэхгүй болон хэрэгжүүлэхгүй байхыг үүрэг болгосон, эсхүл шилжүүлэхийг хориглосон, хязгаарласан нөхцөл тусгасан эсэх.
- 5.6. ХБҮЦ гаргагч нь үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч бусад этгээдүүдтэй ашиг сонирхлын зөрчилтэй эсэх
- 5.7. Үнэт цаасны танилцуулга, түүнд тусгах мэдээлэл нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, бусад холбогдох хууль журамд нийцэж буй эсэх, үнэн зөв, хүчин төгөлдөр эсэх


Талууд энэхүү Хавсралтад заасан нөхцөл, заалтуудыг хүлээн зөвшөөрч байгаагаа нотлон гарын үсэг зурж, баталгаажуулав.

**Хуулийн зөвлөх:**

**Үйлчлүүлэгч тал:**

“Өмгөөллийн Эм Ди Эс энд ХаанЛекс”  
ХХН, түүнийг төлөөлж, Нөхөрлөлийн  
гишүүн, хуульч  
Д.ДҮГЭРЖАВ  
(Гарын үсэг, тамга)  
Улаанбаатар хот  
Огноо: 2022.11.03

“Бэрс финанс ББСБ” ХХК, түүнийг төлөөлж  
Гүйцэтгэх захирал  
С.ОТГОНБАТ  
(Гарын үсэг, тамга)  
Огноо: 2022.11.03



2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 8-027 230 тоот  
Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээний Хавсралт №2

### ХЭЛЦЛИЙН ХҮРЭЭНД ХУДАЛДАН АВАХ ХӨРӨНГИЙН БАГЦАД ТАВИГДАХ ХУУЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Хэлцлийн хүрээнд худалдан авах хөрөнгийн багцыг Үнэт цаас гаргагчаас боловсруулсан дор дурдсан шалгуур үзүүлэлтийг хангасан зээлийн дансаас бүрдүүлсэн. Хуулийн шалгуур үзүүлэлтийг харуулбал:


1. Зээлийн хөрөнгө нь хууль зүйн хувьд аны үүрэг гүйцэтгүүлэгчийн бүрэн өмчлөлд байх бөгөөд анхны зээлдүүлэгчээс бусад этгээдийн хувьд аливаа байдлаар үүргээс ангид байх;
2. Зээлийн гэрээ нь зээлдэгч (Үүрэг гүйцэтгэгч)-ийн хувьд хуульд нийцсэн, хүчин төгөлдөр, заавал биелэгдэх үүрэг үүсгэх бөгөөд шаардлагатай тохиолдолд уг зээлийг барьцаа хөрөнгөөс гаргуулан төлүүлэх боломжтой байх;
3. Зээлтэй холбоотойгоор анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон зээлдэгчийн хооронд байгуулсан фидуцийн гэрээ нь зээлдэгч (Үүрэг гүйцэтгэгч)-ийн хувьд хуульд нийцсэн, хүчин төгөлдөр, заавал биелэгдэх үүрэг үүсгэсэн зээлдэгч үүргээ биелүүлээгүй тохиолдолд анхны үүрэг гүйцэтгүүлэгч өмчлөгчийн эрхээ хэрэгжүүлж, худалдан борлуулж зээл, үүнтэй холбоотой бүх төлбөрийг гаргуулах боломжтой байх;
4. Зээл нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн хувьд хууль, гэрээ эсхүл бусад байдлаар аливаа үүргээс ангид, фидуцийн гэрээний зүйлийн хамтаар гуравдагч этгээдэд шилжихэд хориглогдоогүй эсхүл хязгаарлагдаагүй байх;
5. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид байгаа мэдээллээр, тасалбар болгох өдрийн байдлаар зээлийн гэрээ нь Үүрэг гүйцэтгэгчийн хувьд үүргээ хугацаанаас өмнө дуусгавар болгох/урьдчилан төлөх нөхцөл, хэлцлээс татгалзах, харилцан суутгал хийх замаар үүргийг дуусгавар болгох, сөрөг нэхэмжлэл гаргах, эсхүл үүргээс татгалзах (илт хохиролтой хэлцлийн улмаас үүргээс татгалзах нөхцөлийг хамааруулан) эрх үүсээгүй, эсхүл эрхээ хэрэгжүүлэх хүсэл зориг илэрхийлээгүй байх;
6. Фидуцийн гэрээ хүчин төгөлдөр болгоход Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн ердийн практикт мөрддөг бүх дүрэм журмыг дагаж мөрдсөн, тухайн үүргийн гүйцэтгэлийг хангуулах аргыг нотолж буй бүх баримт бичиг нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эзэмшил, хадгалалт хамгаалалтад байх.

---oO---

МОНГОЛЫН АРВИАНДИЙН БИРЖ  
MONGOLIAN EXCHANGE  
2023-04-06  
БҮРТГЭВ-02

БҮРТГЭВ  
№-01





2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн Д-01272230 тоот  
Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээний Хавсралт №3

**Автомашинны фидуци бүхий зээлийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас (ХБҮЦ) гарган нийтэд санал болгоход анхаарах ялгаатай шийдвэрлэгдсэн асуудлуудын жагсаалт**

Нэг. Хөндлөнгийн хуулийн дүн шинжилгээний явцад анхаарах асуудлууд нь Захиалагч букуу “Бэрс Финанс ББСБ” ХХК (цаашид “анхны үүрэг гүйцэтгэгч” гэх)-ийн өгсөн ажлын даалгаврын салшгүй хэсэгт тооцогдоно.

Хоёр. Хөндлөнгийн хуулийн дүн шинжилгээний явцад эдгээр харилцан тохиролцож шийдвэрлэсэн асуудлууд үүссэн нөхцөлд тухайн дансыг хуулийн шаардлага хангасан (зөвхөн энэхүү харилцан тохиролцсон асуудлын хувьд) гэж тооцно.

Гурав.

Дөрөв. Ялгаатай шийдвэрлэгдсэн асуудлуудын дэлгэрэнгүй тайлбар, жагсаалт

ӨРӨНГИЙН БИРЖ  
STOCK EXCHANGE  
2023-04-06  
БҮРТГЭВ-02

СЭХ  
750.000.000.000  
БҮРТГЭВ  
№ 01

2013.05.08  
БҮРТГЭС-02

Хууль зүйн сайдын 2016 оны  
А/204 дүгээр тушаалаар бат



МОНГОЛ УЛС  
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН  
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

000189287

2011.05.19

/ Бүртгэсэн он, сар, өдөр /

9011287134

/ Хувийн хэргийн дугаар /

5481589

/ Регистрийн дугаар /

Голомт капитал ҮЦК

Хязгаарлагдмал хариуцлагатай компани

/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм

/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

Шийдвэр

/ шийдвэрийн нэр /

01

/ дугаар /

2011.05.17

/ он, сар, өдөр /

6612

/ код /

Харилцагчийн нэрийн өмнөөс түүний даалгавараар гүйцэтгэх хөрөнгө оруулалтын бусад ажил, үйлчилгээ

/ Үндсэн зрхлэх үйл ажиллагааны чиглэл /

6630

6649

Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа

Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйл ажиллагаа

/ код /

/ Туслах зрхлэх үйл ажиллагааны чиглэл /

Хугацаагүй

/ хугацаа /

1

/ гишүүдийн тоо /

1,130,400.0

/ өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /

Улаанбаатар, Сүхбаатар, 1-р хороо, чингисийн өргөн чөлөө, 24, Парк Плэйс оффисын барилга, 4 давхар, 403,404, Утас1: 311971, Утас2: , Факс: 70110549

/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /



Улсын бүртгэлийн ерөнхий газар  
Хуулийн этгээдийн улсын  
бүртгэлийн газар

/ бүртгэсэн байгууллагын нэр /

Гэрчилгээ дахин олгосон 2019 он 8 сар 21 өдөр



2023-06-06

БҮРТГЭЭ

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

Д/д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		Огноо	Ажилтан тэмдэг
1	Отгон овогтой Мөнхжаргал-е Гүйцэтгэх захирал-р томилсныг бүртгэв.	2019.08.21	С.Цогмон
2	Дахин аэрчилгээ олгов.	2019.08.21	С.Цогмон
1	Өөрийн хөрөнгийн хэмжээ 199609.8 мян.төг-р нэмэгдэж нийт 1330009.8 мян.төг болсон өөрчлөлтийг бүртгэв.	2019.09.05	Д.Гангамөрөн
2	6492 Үнэт цавсны дилерийн үйл ажиллагаа эрхлэх үйл ажиллагаа шинээр бүртгэв.	2019.09.05	Д.Гангамөрөн
(5)	Улаанбаатар Хан-Уул 11-р хороо зайсан дунжингарав Энтертайнмент үйлчилгээний төвийн 1-р давхар, А-3 тоот-д байрлах салбар нэгжийг улсын бүртгэлээс хассаныг бүртгэв.	2020-02-21	М.Монголжин
6	64200 Номинал дансаар дамжуулан харилцагчдад мөнгөн хөрөнгийн оролого, зарлагын гүйлгээний үйлчилгээ үйл ажиллагаа шинээр бүртгэв.	2020.03.11	М.Монголжин
7	Санжхуяг овогтой Ганэрдэнэ-г Гүйцэтгэх захирал -р сонгосон(томилсон)-ыг бүртгэв.	2021.06.28	Д.Гангамөрөн
10	Нүлтэм овогтой Мөнхцэцэг-г ТУЗ-ийн дарга-р сонгосон(томилсон)-ыг бүртгэв.	2021.07.29	С.Мөнхсанчир
11	Гишүүн 3 нэмэгдэж 3 хасагдаж ТУЗ-н гишүүн тоо нийт 3 болж өөрчлөгдсөнийг бүртгэв.	2021.07.29	С.Мөнхсанчир
12	Шинэчилсэн дүрэм бүртгэв.	2022.08.17	Н.Энхтуяа
13	Гишүүн 1 нэмэгдэж Гишүүний тоо нийт 4 болж өөрчлөгдсөнийг бүртгэв.	2022.08.17	Н.Энхтуяа

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу харилцаагчид хүлээгдэж Улсын бүртгэлийн гэрчилгээ шааргай бол хуучингүй.



\* 0 0 0 1 8 9 2 8 7 \*



06  
ТГЭВ-02



МОНГОЛ УЛСЫН  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

# ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

Дугаар ТЗ 301/97

2011 оны 11 сарын 02 өдөр

Монгол улсын “Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль”, “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль”, бусад холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 11 сарын 02 өдрийн 317 дугаар тогтоолоор  
**"ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК" ХХК**  
-д  
ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛД ЗОХИЦУУЛАЛТТАЙ

үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрч, энэхүү гэрчилгээг олгов.

ДАРГА  
“тамга”



Д.БАЯРСАЙХАН

Энэхүү гэрчилгээ нь  
хавсралтын хамт  
хүчинтэй























2020 оны 03 сарын 04-ний өдрийн  
20/01 тоот ХХХ-ийн шийдвэрийн хавсралт

## "ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК" ХЯЗГААРЛАГДАМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН ДҮРЭМ

### Нэг. Нийтлэг зүйл

- 1.1. "Голомт капитал ҮЦК" ХХК нь (цаашид "Компани" гэх) Монгол Улсын хуулийн дагуу байгуулагдсан, өөрийн нэрийн өмнөөс эрх эдэлж, үүрэг хүлээдэг ашгийн төлөө хуулийн этгээд бөгөөд хувьцаа эзэмшигчдийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж түүнийг захиран зарцуулах эрх нь энэ дүрэмээр хязгаарлагдах хязгаарлагдмал хариуцлагатай компани мөн.
- 1.2. Компанийн оноосон нэр:  
А. Монголоор "Голомт капитал үнэт цаасны компани" хязгаарлагдмал хариуцлагатай компани.  
Б. Товчилсон нэр "Голомт капитал ҮЦК" ХХК  
В. Англиар "Golomt Capital" LLC
- 1.3. Компанийн оршин байгаа албан ёсны хаяг:  
Монгол улс, Улаанбаатар хог, Сүхбаатар дүүргийн 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө-24 хаягт байрлах "Парк Плэйс" оффисын барилгын 4 давхрын 403, 404 тоот
- 1.4. Компани нь дараах үйл ажиллагааг Санхүүгийн зохицуулах хорооны тусгай зөвшөөрөлтэйгээр эрхэлнэ:
  - 1.4.1. Харилцагчийн нэрийн өмнөөс түүний даалгвараар гүйцэтгэх хөрөнгө оруулалтын бусад ажил үйлчилгээ;
  - 1.4.2. Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа;
  - 1.4.3. Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдан, худалдан авахад зуучлах үйл ажиллагаа;
  - 1.4.4. Брокер, Дилер, Андеррайтерийн үйл ажиллагаа;
  - 1.4.5. Номинал дансаар дамжуулан харилцагчдад монгол хөрөнгийн орлого, зарлагын гүйлгээний үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа;



### Хоёр. Хувь нийлүүлсэн хөрөнгөд үйлдвэр өөрчлөлт оруулах, хувьцаа

- 2.1. Компани нь нийт 100,000 ширхэг зарласан хувьцаатай байх бөгөөд үүнээс 94,200 ширхэг хувьцаа нь эргэлтэд гаргасан хувьцаа, 5,800 ширхэг нь халсан хувьцаа байна.
- 2.2. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь нэг бүр нь 14,111 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 94,200 ширхэг хувьцаанаас бүрдэх бөгөөд нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн нийлбэр дүн нь 1,330,009,800 (нэг тэрбум гурван зуун гучин сая төгрөг хинга найман зуу төгрөгөөс бүрдэнэ).
- 2.3. Компани нь өөрийн хуримтлагдсан ашгийн хэмжээгээр хувь нийлүүлсэн хөрөнгөө нэмэгдүүлж болно. Шаардлагатай эсхүл тохиромжтой гэж үзсэн тохиолдолд хувь нийлүүлсэн хөрөнгөд нэмэлт хөрөнгө оруулж болно. Хувь нийлүүлсэн хөрөнгөд нэмэлт оруулах асуудлыг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэнэ.



2023-04-06  
 БҮРТГЭВ-02

СЭХ  
 он сар өдөр  
 БҮРТГЭВ  
 №01

2.4. Компанийн хувь пийлүүлсэн хөрөнгө нь дараах байдлаар энгийн хувьцаанд хуваагдана. Үүнд:

№	Компанийн зарласан энгийн хувьцааны тоо	Хувьцааны төрөл	Хувьцаа нэг бүрийн үнэлгээ	Хувьцаа эзэмшигч
1	94,200 ширхэг	Эргэлтэд гаргасан хувьцаа	14,119 ₮	"Голомт фاینэншил групп" ХХК
2	5,800 ширхэг	Халаасны хувьцаа	14,119 ₮	"Голомт капитал ҮЦК" ХХК

- 2.5. Компани нь өөрийн хүлээсэн үүргийг зөвхөн өөрийн эд хөрөнгийн хэмжээнд хариуцна.
- 2.6. Компанийн хувьцаа эзэмшигч нь компанийн өмнөөс хариуцлага хүлээхгүй, түүний үйл ажиллагаатай холбоотой алдагдлыг зөвхөн эзэмшигч буй хувьцааны хэмжээгээр хариуцна. Компани нь хувьцаа эзэмшигчдийн өмнөөс хариуцлага хүлээхгүй.

**Гурав. Компанийн удирдлагын тогтоолоо, бүтэц**

- 3.1. Компанийн удирдах байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх захирал байна.
- 3.2. Компани нь Төлөөлөн удирдах зөвлөлөөс тогтоосон зохион байгуулалтын бүтцээр үйл ажиллагаагаа явуулна.
- 3.3. Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх захирлын шийдвэрээр зохион байгуулалтын бүтцээс гадуур компанийн үйл ажиллагааны асуудлаар дүгнэлт гаргаж, зөвлөмж өгөх чиг үүрэг бүхий хороо, зөвлөл байгуулан ажиллаж болно.


**Дөрөв. Хувьцаа эзэмшигчдийн хурал**

- 4.1. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь компанийн эрх барих дээд байгууллага мөн.
- 4.2. Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд дараах асуудлууд хамаарна:
  - 4.2.1 Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу түүнийг шинэчилсэн найруулгыг багтах;
  - 4.2.2 Нийлүүлэх, нэгдэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх хэлбэрээр компанийг өөрчлөн байгуулах;
  - 4.2.3 Компанийн өрийг хувьцаагаар солих, хувьцаа нэмж гаргах, түүний тоог тогтоох;
  - 4.2.4 Компанийн хэлбэрийг өөрчлөх;
  - 4.2.5 Компанийг татан буулгах болон татан буулгах комиссийг томилж;
  - 4.2.6 Хувьцааг хуваах буюу нэгтгэх;
  - 4.2.7 Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох;
  - 4.2.8 Аудитын байгууллагаар баталгаажуулсан санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж багтах;
  - 4.2.9 Хуульд заасан тохиолдолд нх хэмжээний хэлэлцлийг багтах;
  - 4.2.10 Хуульд заасан тохиолдолд сонирхлын зорчигчийг багтах;
  - 4.2.11 Компанийн тухай хуульд заасны дагуу компани хувьцаагаа худалдан авахыг зөвшөөрөх;
  - 4.2.12 Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн нөхөн олговрыг хууль ёсоор зэмжээг тогтоох;
  - 4.2.13 Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудлууд;
  - 4.2.14 Хууль болон энг дүрэмд заасан бусад асуудлууд.

Бүртгэлийн хувиар  
 244

2023-04-06

БҮРТГЭВ-02



- 4.3. Хууль болон энэ дүрмээр Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамааруулсан асуудлыг шийдвэрлүүрэхээр Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх захиралд шилжүүлж болохгүй.
- 4.4. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь ээлжит болон ээлжит бус байна. Ээлжит хурлыг компанийн санхүүгийн жил дууссанаас хойш 4 сарын дотор зарлан хуралдуулна. Ээлжит бус хурлыг ТУЗ-ийн санаачлагаар, эсхүл хуульд заасан нөхцөл бий болсон үед зарлан хуралдуулж болно. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг тухайн хурлаас сонгогдсон дарга удирдана.
- 4.5. Хувьцаа эзэмшигчдийн хурал дээр санал хураахдаа "1 хувьцаа 1 санал" зарчмыг баримтална.
- 4.6. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь энэ дүрмийн 4.2.1-4.2.6 болон 4.2.11-д заасан асуудлыг хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхоор шийдвэрлэнэ. Бусад асуудлаарх хувьцаа эзэмшигчдийн хурал шийдвэрийг хуульд өөрөөр заагаагүй бол хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн ердийн олонхоор шийдвэрлэнэ.
- 4.7. Компани нэг хувьцаа эзэмшигчтэй бол хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг хувьцаа эзэмшигч өөрөө буюу түүний төмнөсөн этгээд хэрэгжүүлнэ.

#### Тав. Төлөөлөн удирдах зөвлөл

- 5.1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх зөвхөн байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөл байна. Төлөөлөн удирдах зөвлөл нь энэ дүрэм болон хуулиар хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамааруулсанаас тухал бүх асуудлаар компанийн ерөнхий удирдлагыг хэрэгжүүлнэ.
- 5.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхэд дараах асуу даууд хамаарна:
- 5.2.1 Компанийн стратегийг тодорхойлох, хянан үзэх тухай нөхцөл, бөрчлөлт оруулах, зохион байгуулалтын бүтэц, эрдэлийн удирдлага, өдөт, жилийн төсөв, бизнес төлөвлөгөө, хүний нөөцийн ерөнхий төлөвлөгөө, тухайн болон төсвийн бус үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлтийг батлах;
- 5.2.2 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах;
- 5.2.3 Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлыг саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах, эрдэлийн өдөр болон хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулахтай холбоотой бусад асуудлыг шийдвэрлэх;
- 5.2.4 Компанийн үйл ажиллагааны талаарх үйл ажиллагааны аудитын байгууллагаар баталгаажуулсан санхүүгийн жилийн тайвныг үндэс дээр дүгнэлт гаргаж, Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулах;
- 5.2.5 Компанийн зохистой удирдлагын бодлого, журмыг хэрэгжилтэд хяналт тавих;
- 5.2.6 Компанийн нягтлан болох бүртгэл, санхүүгийн зохистой бодлогын тогтоцоо, хөндлөнгийн болон дотоод аудит, эрдэлийн удирдлага, санхүүгийн аудитын үйл ажиллагааны хяналт цаанлаад харилцагчдын санг тусгаарлах, хувьцаа эзэмшигчдийн хэрэгжилтийг хамарсан зохистой хяналтын тогтоцоог бүрдүүлэх, хэрэгжилтийн хяналтын тогтоцоог;
- 5.2.7 Хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгож, хэрэгжилтийн хяналтын тогтоцоог;
- 5.2.8 Компанийн бүтэц, зохион байгуулалтыг тогтоох;
- 5.2.9 Компанийн Гүйцэтгэх захирлыг сонгох, бөрчлөлт, үүний бүрэн эрхийг тогтоох;
- 5.2.10 Компанийн Гүйцэтгэх захиралтай байгуулсан хамтарсан гэрээний нөхцөл түүнд олгох шагналыг, урамшуулал, хариуцлагын хөндлөнгөөс өөрөөр өгөх;
- 5.2.11 Хуульд заасан тохиромжтой хэмжээний хөрөнгийг хяналтын үйл ажиллагаанд зарцуулах;
- 5.2.12 Хуульд заасан тохиромжтой гурвалжин эрхтэй хувьцаа эзэмшигчдийн хяналтын батлах зөвшөөрөл олгох;





- 5.2.13 Төлөөлөн удирдах зөвлөлөөр шийдүүлэх дөр Гүйцэтгэх захирлаас оруулсан бусад асуудал;
- 5.2.14 Энэ дүрэм болон хуулиар шаардсан бусад асуудлууд.
- 5.3. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь 3 гишүүнтэй байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн нь хувь хүн байна.
- 5.4. Төлөөлөн удирдах зөвлөл нь гишүүдийг энэ дүрэм болон хуульд заасан журмаар Хувьцаа эзэмшигчдийн хурлаас 1 жилийн хугацаатайгаар сонгоно.
- 5.5. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг улируулах сонгодог болно.
- 5.6. Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг гишүүдийн дундаас төсвийн саналаар сонгоно.

### Зургаа. Гүйцэтгэх удирдлага

- 6.1. Гүйцэтгэх захирал нь компанийн дүрэм болон Төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна. Гүйцэтгэх захиралтай байгуулах хөдөлмөрийн гэрээнд компанийг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга төлөөлнө.
- 6.2. Гүйцэтгэх захирлын бүрэн эрхэд дор дурдсан асуудлууд хамаарна:
  - 6.2.1. Энэ дүрэм болон хуульд заасан Хувьцаа эзэмшигчдийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхэд хамааруулснаас бусад компанийн өдөр тутмын бүх үйл ажиллагааг удирдах, компанийн үйл ажиллагааны бодлого журмыг тодорхойлсон баримт бичгүүдийг батлах;
  - 6.2.2. Компанийг итгэмжлэн үгүйгээр төлөөлөх, гэрээнд орж байгуулах;
  - 6.2.3. Компанийн хөрөнгийг захиран зарцуулах, энэ тусгайд их хэмжээний хэлцэл, сонирхлын зорчилтэй хэлцэл хамаарахгүй;
  - 6.2.4. Ажилтнуудын цалин, урамшууллын системийг Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан жилийн төсвийн хэмжээнд тодорих, ажилтнуудын томилолт болон хөдөлмөрийн гэрээг батлах;
  - 6.2.5. Компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд шаардсан үндэс асуудлууд;

### Долоо. Төлөөлөн удирдах зөвлөлийн байнгын болон түр хороо

- 7.1. Төлөөлөн удирдах зөвлөл нь шаардлагатай тохиолдолд тодорхой асуудал эрхэлсэн байнгын болон түр хороог байгуулж болно.
- 7.2. Байнгын болон түр хорооны журмыг Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолоор батална.

### Найм. Их хэмжээний боловсрол эрх болон хөрөнгийн хэлцэл хийх журмыг

- 8.1. Их хэмжээний хэлцэл болон сонирхлын зорчилтэй хэлцэл гэдгийг хуульд зааснаар тодорхойлно.
- 8.2. Их хэмжээний хэлцэл хийх шийдвэрийг Төлөөлөн удирдах зөвлөл сонгодог бөгөөд гэрээг гаргана.
- 8.3. Төлөөлөн удирдах зөвлөл их хэмжээний хэлцэл хийх шийдвэрийг Гүйцэтгэх захирал гаргаж чадахгүй тохиолдолд асуудлыг Хувьцаа эзэмшигчдийн хурал оруулах бөгөөд уг асуудлыг хуралд оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн санал дээр үндэстэй шийдвэрлэнэ.
- 8.4. Сонирхлын зорчилтэй хэлцэл хийх тухай шийдвэр бус гишүүдийг хийх хэлцлийг хийх сонирхолгүй Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийн өмчийн саналаар гаргана.
- 8.5. Төлөөлөн удирдах зөвлөл сонирхлын зорчилтэй хэлцэл хийх шийдвэрийг гаргаж чадахгүй тохиолдолд асуудлыг Хувьцаа эзэмшигчдийн хурал оруулах бөгөөд уг асуудлыг хуралд оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн санал дээр үндэстэй шийдвэрлэнэ.



2023-04-06  
БҮРТГЭВ-02

БҮРТГЭВ  
№ 01

**Ес. Хувьцаа ирилжих, бусад шилжүүлэх үйл ажиллагаа**

- 9.1. Компани үйл ажиллагаагаа явуулахдаа дараах үүргийг биелүүлнэ:
  - 9.1.1 Хууль, журамд заасны дагуу, Санхүүгийн зохиргоо уулах хорооны зөвшөөрлийн үндсэн дээр бүх шаардлагатай тусгай зөвшөөрлийг авах;
  - 9.1.2 Хагас жилийн болон аудитын байгууллагаар баталгаажуулсан жилийн тайлан тэнцлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасан хугацаанд гаргаж, Санхүүгийн зохицуулах хороонд хүргэх, жилийн эцсийн тэнцлийгний хураангуйг хэвлэлд нийтэлж, хөрөнгө оруулагчид мэдээлэх;
  - 9.1.3 Дотоод мэдээлэл эзэмшигчийн гүйлгээний журмыг хөгжиж, тэдгээрийн хуулиар хүлээсэн үүргийн биелэлтэд хяналт тавих;
  - 9.1.4 Үнэт цаастай холбогдсон үнэт зөв мэдээллийн тухай сонирхогч этгээдэд шуурхай өгөх;
  - 9.1.5 Үнэт цаасны арилжаа, үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрх шилжүүлэхтэй холбогдсон гүйлгээг шууд, илтэр, шуурхай хийж гүйцэтгэх;
  - 9.1.6 Үнэт цаас гаргагч болон хөрөнгө оруулагчийн талаарх ажлын гэрээг хамгаалах;
  - 9.1.7 Харилцагчийн талаарх мэдээлэлгүй бүртгэл, хууль ёсны талаар бүртгэл хөглөх;
  - 9.1.8 Зөвхөн Харилцагчийн зөвшөөрлийн дагуу арилжаа хийх;
  - 9.1.9 Үнэт цаасыг худалдах, хуваалдан авахдаа харилцагчийн захиалгыг бүрэн биелүүлсний дараа өөрийн болон аливаа нэгдмэл сонирхолтой этгээдийн захиалгыг биелүүлэх;
  - 9.1.10 Захиалгыг биелүүлэх явцад харилцагч болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн хооронд сонирхлын зорчил үүссэн бөгөөд энэ тухай харилцагчид нэг даруй мэдэгдэх;
  - 9.1.11 Хууль ёсон эрх бүхий байгууллагаас гаргасан журам, шийдвэрт заасан бусад үүрэг.

Арав. Эрх бүхий албан тушаалтан, гүйцэтгэх үйл ажиллагааны харилцаа

- 10.1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх зөвлөл, Гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн, санхүүгийн албан тусгай, ерөнхий нягтлан бодох үйл ажиллагааны мэргэжилтэн, Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга зэрэг ажилтан бүхний албан тушаалтанд тооцно.
“Бэрс финанс ББСБ” ХХК, “Дөлгөөнхайрхан уул Аудит” ХХК-ийн хооронд байгуулсан гэрээ (хэлцэл)-г үндэслэн танай компанийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон баланс, уг өдрөөр дуусгавар болсон жилийн орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайландаудит хийлгэхээр бидэнд хандсан билээ. Бид тус компанийн санхүүгийн тайланд аудит хийхийг хүлээн зөвшөөрч, гэрээт ажлын талаарх өөрсдийн ойлголтыг энэ захидлаараа баталгаажуулахыг хүсч байгаагаа илэрхийлэхэд бидэнд таатай байна.

Манай талаас үзүүлэх аудитын үйлчилгээний зорилт нь санхүүгийн тайлангуудад дүгнэлт өгөх явдал юм. Бид аудитыг Аудитын олон улсын стандартын дагуу явуулна. Санхүүгийн тайлангууд материаллаг зөрчилгүй илэрхийлэгдсэн гэдэг үндэслэлтэй нотолгоо олж авах зорилгоор аудитын ажлыг төлөвлөж, гүйцэтгэхийг уг АОУС-д заасан байдаг. Аудитын явцад санхүүгийн тайлан дахь дүн, нэмэлт тодруулгууд нь зөв эсэхийг нотлоход тестийн аргыг хэрэглэнэ. Түүнчлэн тус компанид хэрэглэгдэж байгаа нягтлан бодох бүртгэлийн зарчмууд, удирдлагын хийсэн томоохон хэмжээний тооцооллууд, түүнчлэн санхүүгийн тайлагналын байдалд бүхэлд нь үнэлэлт өгнө. Эдгээр ажлыг гүйцэтгэхэд танай компанийн ажилтнууд идэвхийлэн оролцоно гэдэгт бид эргэлзэхгүй байна.

Аудитын тестийн арга бусад уламжлалт хязгаарлагдмал шинж чанар, түүнчлэн нягтлан бодох бүртгэлийн ба дотоод хяналтын системийн ямар нэг уламжлалт хязгаарлагдмал байдлын улмаас зарим материаллаг зөрчлийг ч илрүүлэхгүй байх болон зарим алдаатай зүйлс гарах магадлал байхыг бид үгүйсгэхгүй. Гэхдээ ийм төрлийн алдааг аль болохоор хамгийн бага байлгахад бид аудитын ажлыг төлөвлөж явуулна.

Бид жилийн эцсийн санхүүгийн тайланг баталгаажуулах ба хараат бус аудитын тайланг нэмэлт тодруулгын хамт хүргүүлж, нягтлан бодох бүртгэл, хууль эрх зүйн орчны нийцтэй байдлыг тусгасан, дотоод хяналтын системийн эрсдэлтэй сул талуудыг үнэлж, цаашид засаж сайжруулах талаар дэлгэрэнгүй зөвлөмжийг бичиж, хуулийн болон гэрээний хугацаанд танай компанийн удирдлагад хүргүүлнэ.

Аудитын ажлын явцад бидний бэлтгэсэн ажлын баримтууд нь бидний өмч бөгөөд нууц шинж чанартай байна. Эдгээрийг бид дотоод дүрэм журмынхаа дагуу өөрсдөө хадгалах болно. Харин эдгээр баримт бичгүүдийн заримыг хууль журмын дагуу эрх бүхий компанид гаргаж өгөх талаар бидэнд хүсэлт тавьсан тохиолдолд эдгээр баримт бичгүүдийг манай компанийн хариуцлагатай ажилтны хяналтын дор гаргаж өгөх болно.



2023-03-06

БҮРТГЭВ-02



ДӨЛГӨН ХАЙРХАН УУЛ  
АУДИТ ХХК



Зохих нэмэлт тодруулга бүхий санхүүгийн тайланг бэлтгэх нь компанийн удирдлагын хүлээх хариуцлага гэдгийг бид сануулахыг хүсч байна. Үүнд: нягтлан бодох бүртгэлийн зохих бичилтболон дотоод хяналтыг хангах, нягтлан бодох бүртгэлийн бодлгыг сонгож хэрэглэх, байгууллагын хөрөнгийг найвдартайгаар хадгалах, хамгаалах, нөөцийг үр ашигтай зарцуулах зэрэг зүйлс багтана.

Аудитад хамрагдах санхүүгийн болон бусад бүх мэдээлийн үнэн, зөвийн баталгааг бичгээр гаргаж өгөхийг бид хүсэж байна.

Бид танай хамт олонтой хамтран ажиллах чин эрмэлзэлтэй байгаа бөгөөд аудиттай холбоотой бидний хүссэн аливаа бүртгэл, баримт, бусад мэдээллээр биднийг хангана гэдэгт итгэж байна.

Энэ захидлыг хүчингүйд тооцох, түүнд нэмэлт өөрчлөлт оруулах, эсвэл өөр захидлаар орлуулах шийдвэр гараагүй тохиолдолд энэ захидал дараагийн жилүүдэд хүчин төгөлдөр хэвээр байна.

Санхүүгийн тайлангийн аудитын ажлыг та хүлээн зөвшөөрч байгаагаа илэрхийлэн энд гарын үсгээ зурж, баталгаажуулан манай талд ирүүлнэ үү.

Хүндэтгэсэн:

“Дөлгөнхайрхан Уул Аудит” ХХК

Захирал:  Б.Пүрэвдулам

Аудитор:  Н.Янжмаа




Хүлээн зөвшөөрсөн:

“Бэрс финанс ББСБ” ХХК-ийн

Гүйцэтгэх захирал:  С.Отгонбат

Ня-бо:  Д.Урангоо



Нягтлан бодох бүртгэл, аудит,  
санхүүгийн хөндлөнгийн  
хяналтын байгууллага



Accounting, Auditing and  
External Controlling Firm

2023 оны 01 сар 11 өдөр

№ 22/04402

**“БЭРС ФИНАНС ББСБ” ХХК-ИЙН  
ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧИД**

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

### Санхүүгийн тайлангийн аудит хийсэн тухай тайлан

#### Хязгаарлалттай дүгнэлт

Бид “Бэрс финанс ББСБ” ХХК-ийн Цаашид “Компани” гэх/ 2021 оны 12 сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн орлогын, өмчийн өөрчлөлтийн болон мөнгөн гүйлгээний тайлан, санхүүгийн тайлангийн тодруулга болон нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй, бусад тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, “Бэрс финанс ББСБ” ХХК-ийн 2021 оны 12 сарын 31-ний байдлаарх санхүүгийн тайлан нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартад нийцүүлэн гаргасан Сангийн сайдын заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

#### Хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Эдгээр стандартын дагуу бид хүлээх үүрэг хариуцлагынхаа энэхүү аудитын тайлангийнхаа Аудиторын үүрэг хариуцлага хэсэгт багтаан харуулсан. Бидний хувьд санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой нягтлан бодогчдын ёс зүйн стандартын шаардлагуудын дагуу тус компаниас хараат бус бөгөөд бид эдгээр шаардлагын ёс зүйтэй холбоотой бусад үүрэг хариуцлагаа биелүүлсэн болно. Бидний олж авсан нотлох зүйл нь бидний дүгнэлтэд зохистой үндэслэл болж чадна гэдэгт итгэлтэй байна.

#### Тасралтгүй үйл ажиллагааны зарчимтай холбоотой асуудлууд

Тасралтгүй үйл ажиллагаатай холбоотой материаллаг тодорхой бус байдал үүссэн тохиолдол бидэнд ажиглагдаагүй болно.

#### Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн үнэлэмжээр, тайлант жилийн санхүүгийн тайланд хийсэн аудитад хамгийн ихээр нөлөө үзүүлэхүйц асуудлууд нь аудитын гол асуудлууд болдог. Эдгээр асуудлууд нь санхүүгийн тайланг бүхэлд нь хамарсан, аудитын ажлын агуулга болон дүгнэлтийн хэлбэрт тусгалаа олсон бөгөөд эдгээр асуудал дээр бид тусад нь санал дүгнэлт гаргаагүй болно.

Энэхүү тайлан нь Монгол улсын “Компанийн тухай” хуулийн 94 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болон хувьцаа эзэмшигчийн хүсэлтийн дагуу зөвхөн компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулагдсан ба аливаа өөр зорилго агуулаагүй болно. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд бусад этгээдийн өмнө хариуцлага хүлээхгүй болно.

Бид энэхүү аудитын ажлыг хийж гүйцэтгэж аудитын тайланг бэлтгэсэн болно.





АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГУУДЫН ХУРААНГУЙ

Санхүүгийн байдлын тайлан

	Аудитлагдсан дүн (төгрөгөөр)	
	2020 оны 12 сарын 31	2021 оны 12 сарын 31
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	587,773,435.00	2,802,570,983.00
Зээл (цэвэр)	17,507,143,212.10	29,566,529,997.00
Хүүгийн авлага	466,739,591.00	588,274,912.00
Бусад авлага	639,702,315.00	8,681,152,392.00
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	15,795,332.00	33,630,898.00
Үндсэн хөрөнгө (цэвэр)	485,303,189.00	487,616,116.00
Биет бус хөрөнгө (цэвэр)	10,000.00	10,000.00
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>19,702,467,074.10</b>	<b>42,159,785,298.00</b>
Богино хугацаат өр төлбөр	2,299,550,744.10	18,301,816,427.00
Урт хугацаат өр төлбөр	692,951,635.00	2,000,000,000.00
Хувь нийлүүлсэн хөрөнгө	6,090,000,000.00	6,090,000,000.00
Хуримтлагдсан ашиг	10,619,964,695.00	15,767,968,871.00
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>19,702,467,074.10</b>	<b>42,159,785,298.00</b>

Орлого үр дүнгийн тайлан

Хүүгийн орлого	8,604,006,558.00	9,870,159,522.00
Хүүгийн зардал	1,087,549,179.00	933,129,516.00
<b>Цэвэр хүүгийн орлого</b>	<b>7,516,457,379.00</b>	<b>8,937,030,006.00</b>
Хүүгийн бус орлого	107,742,403.00	71,453,484.00
Хүүгийн бус зардал	2,213,871,592.00	3,130,911,690.00
Болзошгүй эрсдлийн зардал	402,098,926.00	137,683,856.00
<b>Үндсэн үйл ажиллагааны зардал</b>	<b>5,008,229,264.00</b>	<b>5,739,887,944.00</b>
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	10,024,207.00	18,284,218.00
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	4,998,205,057.00	5,721,603,726.00
<b>Ердийн үйл ажиллагааны зардал</b>	<b>4,998,205,057.00</b>	<b>5,721,603,726.00</b>
Орлогын татварын зардал	499,907,123.00	573,599,550.00
<b>Цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>4,498,297,934.00</b>	<b>5,148,004,176.00</b>



Мөнгөн гүйлгээний тайлан

Мөнгөн орлогын дүн	46,860,240,493.00	80,363,723,536.00
Мөнгөн зарлагын дүн	47,355,636,256.00	78,148,925,988.00
Цэвэр мөнгөн гүйлгээ	(495,395,763.00)	2,214,797,548.00
<b>Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>1,083,169,198.00</b>	<b>587,773,435.00</b>
<b>Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>587,773,435.00</b>	<b>2,802,570,983.00</b>

АУДИТОР *Нанжмаа* Н.ЯНЖМАА /Мэргэшсэн нягтлан бодогч/

"Дөлгөөнхайрхан уул Аудит" ХХК





Огноо/Date: 2023.02.09 15:01:34

### Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information

Журналын Дугаар/No: 19767244

Системийн өг-оо/System Date: 2023.02.09

Дт	Дансны/Картын дугаар Account, Card number	Нэр/Name	Дүн/Amount	Ханш/Rate
	5028 728 307	БЭРС ФИНАНС ХХК	3,000,000.00 MNT	1.00
/ гурван сая төгрөг /				
Кт	Банкны дугаар/Branch No	Банкны нэр/Bank Name		
	90	- Төрийн Сан		
	Дансны/Картын дугаар Account/Card Number	Нэр/Name	Дүн/Amount	Ханш/Rate
	100900025001	САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО	3,000,000.00 MNT	1.00

Гүйлгээний утга/Transaction description:  
ЕВ-БЭРС ЭЙ БИ ЭС ПЛАС ТУСТАЙ ЗӨВШӨӨРӨЛ ТӨЛБӨР

**Харилцагч танд баярлалаа./Thank you to our customers**



Гүйлгээний баримтыг баталгаажуулсан Transaction statement verified

Салбар, тооцооны төв Branch, card branch:

Гарын үсэг/Signature:

Тамга/Stamp

\_\_\_\_\_ Он/Year (YYYY) \_\_\_\_\_ Сар/Month (MM) \_\_\_\_\_ Өдөр/Day (DD)



**ХААН БАНК**

Огноо/Date: 2023.02.09 14:57:50

**Шилжүүлгийн мэдээлэл / Transaction information**

Журналын/ Journal No: 19448308

Системийн огноо / System Date: 2023.02.09

Дт	Дансны/Картын дугаар Account/Card number	Нэр/Name	Дүн/Amount	Ханш/Rate
	5028 728 307	БЭРС ФИНАНС ХХК	500,000.00 MNT	1.00
/ таван зуун мянган төгрөг /				
Кт	Банкны дугаар Branch No	Банкны нэр/Bank Name		
	90	- Төрийн Сан		
	Дансны/Картын дугаар Account/ Card Number	Нэр/Name	500,000.00 MNT	1.00
	100900025001	САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО		

Гүйлгээний утга/Transaction description:  
ЕВ-БЭРС ЭЙ БИ ЭС ПЛАС ХБҮЦ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛС

**Харилцагч танд баярлалаа./ Thank you to our customers**

Гүйлгээний баримтыг баталгаажуулсан/ Transaction statement verified

Салбар, тооцооны төв / Branch, sub branch

Гарын үсэг/Signature

Тамга/Stamp

\_\_\_\_\_ Огноо/Year (YYYY) \_\_\_\_\_ Сар/Month (MM) \_\_\_\_\_ Өдөр/Day (DD)

МОНГОЛЫН ХААН БАНК  
 2023-02-06  
 БҮРТГЭВ-02

СЗХ  
 он сар өдөр  
 БҮРТГЭВ  
 № 01



Огноо/Date: 2023.02.09 15:04:24

**Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information**  
 Журналын: Journal No: 19926983

Системийн огноо System Date: 2023.02.09

ДТ	Дансны/Картын дугаар Account/Card number	Нэр/Name	Дүн/Amount	Ханш/Rate
	5028 728 307	БЭРС ФИНАНС ХХК	100,000.00 MNT	1.00
/ нэг зуун мянган төгрөг /				
КТ	Банкны дугаар/Branch No 90	Банкны нэр/Bank Name - Төрийн Сэн		
	Дансны/Картын дугаар Account/Card Number 100900025002	Нэр/Name СЗХ.Тэмдэгт хураамж орлого	100,000.00 MNT	1.00

Үйлгээний утга/Transaction description:  
 БВ-БЭРС ЭЙ БИ ЭС ПЛАС ЗӨВШӨӨРӨЛ ХУРААМЖ

**Харилцагч танд баярлалаа./Thank you to our customers**

Үйлгээний баримтыг баталгаажуулсан Transaction statement verified:

Салбар, тооцооны төв/Branch, sub-branch:

Тарьн /Сэг/Signature:

Тамга/Stamp

\_\_\_\_\_ Он/Year (YYYY) \_\_\_\_\_ Сар/Month (MM) \_\_\_\_\_ Өдөр/Day (DD)





**БЭРС ФИНАНС**

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ШИЙДВЭР

2022 11 08  
...Энх ... Сарын ... өдөр

№( 22/472/89

Улаанбаатар хот

### Шинээр охин компани үүсгэн байгуулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59-р зүйлийн 59.2 дахь заалт, 62-р зүйлийн 62.1.16 дахь заалт, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12-р зүйлийн 12.4 дэх заалтыг тус тус үндэслэн ШИЙДВЭРЛЭХ нь:

1. “Бэрс финанс ББСБ” ХХК нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасны дагуу Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах зорилгын хүрээнд “Бэрс Эй Би Эс Плас” гэх оноосон нэртэй Хязгаарлагдмал хариуцлагатай компани буюу “ХХК” (“Компани” гэх)-ийг үүсгэн байгуулсугай.

2. Компанийн оршин байх газар буюу хууль ёсны хаяг нь Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 11-р хороо, 7-р хороолол, Ногоон нуур, 101 барилга, 706 тоот, утасны дугаар 99119632 байхаар тооцон “Бичил глобус” ХХК-тай оффис түрээслэх түрээсийн гэрээ байгуулсугай.

3. Компани үүсгэн байгуулахад оруулсан хувь нийлүүлсэн хөрөнгийн нийт хэмжээ нь 1,000,000 /нэг сая/ төгрөг бөгөөд нэг бүр нь 1,000 /нэг мянга/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 1,000 /нэг мянга/ ширхэг зарласан бөгөөд гаргасан энгийн хувьцааг гаргахаар шийдвэрлэсүгэй.

4. Компани нь хугацаагүйгээр, дараах үйл ажиллагаа явуулсугай. Үүнд:  
- Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа

5. Компанийн дүрмийг энэхүү шийдвэрийн хавсралтаар баталсугай.

6. Компанийн Гүйцэтгэх захирлаар Монгол Улсын иргэн Самдангийн Отгонбат (РД:ИЭ84082978)-ыг томилсугай.

7. Энэхүү шийдвэрийн хэрэгжилтийг хангахад шаардлагатай арга хэмжээг авч ажиллах, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг “Бэрс финанс ББСБ” ХХК-ийн Гүйцэтгэх захирал (С.Отгонбат)-д даалгасугай.


8. Шинээр үүсгэн байгуулж буй компаний холбогдох баримт бичгийг Улсын Бүртгэлийн Ерөнхий Газарт бүртгүүлэх үйл ажиллагааг хариуцан гүйцэтгэхийг “Бэрс финанс ББСБ” ХХК-ийн Санхүү бүртгэлийн газрын Санхүүгийн шинжээч (Д.Энхчимэг)-д үүрэг болгосугай.

“БЭРС ФИНАНС ББСБ” ХХК-ИЙН 100%-ИЙН ТОЛГОЙ КОМПАНИ “БЭРС КАПИТАЛ”  
ХХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ БӨГӨӨД “БЭРС ФИНАНС ББСБ” ХХК-ИЙН

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

БЭРС ФИНАНС

С.ОТГОНБАТ



 **ХААН БАНК**

Огноо/Date: 2022.11.07 18:07:48

**Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information**

Журналын/Journal No: 28498204

Системийн огноо/System Date: 2022.11.07

Дт	Дансны/Картын дугаар Account/Card number	Нэр/Name	Дүн/Amount	Ханш/Rate
	5028 728 307	БЭРС ФИНАНС ХХК	1,000,000.00 MNT	1.00
/ нэг сая төгрөг /				
Кт	Банкны дугаар/Branch No	Банкны нэр/Bank Name		
	15	- Голомт		
	Дансны/Картын дугаар Account/Card Number	Нэр/Name	Дүн/Amount	Ханш/Rate
	3305 138 149	БЭРС ЭЙ БИ ЭС ПЛАС ХХК	1,000,000.00 MNT	1.00

Гүйлгээний утга/Transaction description:  
ЕВ-ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

**Харилцагч танд баярлалаа./Thank you to our customers**


Гүйлгээний баримтыг баталгаажуулсан/Transaction statement verified:

Салбар, тооцооны төв/Branch, sub-branch: *сэдт*

Гарын IG/Signature: 

Тамга/Stamp: 

*2022* Он./Year (YYYY) *11* Сар./Month (MM) *7* Өдөр./Day (DD)



ГАРЫН ҮСЭГ ТАМГАНЫ ЗАГВАР  
AUTHORIZED SIGNATURE, STAMP

Салбар/Branch №: *Нийслэл шарга салбар* Харилцагчийн дугаар/CIF ID: \_\_\_\_\_

**1. ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ / BASIC INFORMATION**

Байгууллагын нэр / Corporate name: *Вэрс Эй Би Эс Плас ХХК*  
 Байгууллагын хаяг / Registered address: *СБД, 11 хороо, 7 хороолол, Ногоонон нуур, 101-406 тоот*  
 Регистрийн № / Registration No: *8949886* Утас / Phone: *99119632*  
 Голомт банкнаас олгосон дансны дугаар / Account No:  
 1. *3305138149* 2. \_\_\_\_\_ 3. \_\_\_\_\_ 4. \_\_\_\_\_

**2. ГАРЫН ҮСГИЙН БАТАЛГАА / SIGNATURE SPECIMAN**

\* Байгууллагын нийт дансны мөнгөн хөрөнгийг захиран засуулахдаа төлбөр тооцосны баримтууд дээр баталгаажуулан гарын үсэг зурах эрх бүхий албан тушаалтнуудын гарын үсэг, тамганы загварыг энэ хэсэгт баталгаажуулан банкинд өгнө.  
 \* Хэрэв олон зурах этгээдийн гарын үсгийн баталгаа өгөх бол баталгааны б хэсэгт зурна.  
 /Please sign on the B section of the specimen to provide multiple specimen

A	Гарын үсэг зурах эрх бүхий албан тушаалтны овог, нэр Name(s) of authorized signatory	Албан тушаал Position	Баталгаат гарын үсгийн загвар Signature specimen	Тамганы загвар Seal specimen
1.	<i>Сандаг Омиондам</i>	<i>Гүйцэтгэх захирал</i>	<i>[Signature]</i>	
2.				
3.				
B	Орлон гарын үсэг зурах эрх бүхий албан тушаалтны овог, нэр Full name of the authorized signatory	Албан тушаал Position	Баталгаат гарын үсгийн загвар Signature specimen	
1.1.	<i>Дорнодвал Франко</i>	<i>Нөлөөлөгч</i>	<i>[Signature]</i>	
1.2.				
2.1.				
2.2.				
3.1.				
3.2.				


НОТАРИАТЫН БАТАЛГАА / NOTARY AUTHENTICATION  
 С.Мандуулсүрэн Би Энхлүү үндэслэлийн үйлчилгээний газар  
 Утас/Phone: \_\_\_\_\_

Гарын үсэг зурах эрх олгосон албан байгууллагын нэр / Name of the organization authorized to sign: *Вэрс Эй Би Эс Плас ХХК*  
 Баталсан / Approved by: \_\_\_\_\_ Нэр / Name: \_\_\_\_\_  
 Албан тушаал / Position: *С.Омиондам Гүйцэтгэх захирал*

Байгууллага / Corporate: \_\_\_\_\_  
 Гарын үсэг / Signature: *[Signature]* Тамга / Stamp:

Банк / Bank: \_\_\_\_\_  
 Огноо: \_\_\_\_\_  
 Банкны ажилтан / Bank employee: \_\_\_\_\_  
 Хянасан ажилтан / Monitored by: \_\_\_\_\_





**НАЙМАН ШАРГА САЛБАР**

Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
2-р хороо, Их Найман Шарга ХХК-н байр  
Утас: 7011-1646 /2920, 2921/  
Вэб: www.golomtbank.com

2022-11-15

№ \_\_\_\_\_  
-ны № 01/015 -т

**ТОДОРХОЙЛОЛТ**

Харилцагчийн нэр : БЭРС ЭЙ БИ ЭС ПЛАС ХХК



Голомт банк нь харилцагчийн дансны үлдэгдлийг 2022.11.15-ны өдрийн байдлаар баталгаажуулж байна.

Дансны дугаар : 3305138149  
Данс нээсэн огноо : 2022.11.07  
Дансны үлдэгдэл : MNT 1,000,000.00  
Мөнгөн дүн үсгээр : (Нэг сая төгрөг)

Энэхүү тодорхойлолт нь зөвхөн уг тодорхойлолтыг гаргасан үедээ хүчинтэй болно. Энэ нь цаашид үргэлжилсэн баталгаа болохгүй бөгөөд данс эзэмшигчийн яаралтай хүсэлтээр гаргасан болно. Уг тодорхойлолтыг гаргасны төлөө Голомт банк, уг банкны захирлууд болон ажилтнууд аливаа гуравдагч талын өмнө ямар нэг хариуцлага хүлээхгүй болно.



000001057



## АЖЛЫН БАЙР ТҮРЭЭСЛЭХ ГЭРЭЭ

2022 оны 11 сарын 08 өдөр

№

Улаанбаатар хот

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Нэг талаас “Бичил глобус” ХХК, түүнийг төлөөлж, санхүүгийн захирал Я.Адъяахүү /цаашид “Түрээслүүлэгч” гэх/, Нөгөө талаас “Бэрс Эй Би Эс Плас” ХХК, түүнийг төлөөлж гүйцэтгэх захирал С.Отгонбат /цаашид “Түрээслэгч”, хамтад нь “Талууд” гэх/ нар Монгол улсын Иргэний хуулийн 318 - 326 дугаар зүйлийг удирдлага болгон дор дурдсан нөхцлөөр харилцан тохиролцож энэхүү “Ажлын байр түрээслэх гэрээ”/цаашид “Гэрээ” гэх/-г байгуулав.
- 1.2. Энэхүү гэрээнд хэрэглэсэн нэр томъёог дор дурьдсан утгаар ойлгоно. Үүнд:
  - 1.2.1. “Чанарын доголдолгүй” гэж түрээсийн байр нь түрээслэгчийн үйл ажиллагаа явуулах шаардлагын хангасан, чанарын норм, стандартыг хангасан байхыг;
  - 1.2.2. “Эрхийн доголдолгүй” гэж түрээслэгчид хүлээлгэн өгсөн түрээсийн байр нь ямар нэг гуравдагч этгээдийн эрх ашгийг хөндөөгүй, Монгол Улсын хууль, тогтоомжийн дагуу байхыг;
  - 1.2.3. “Бодит хохирол” гэж үүргийн гүйцэтгэлийг хангахад гаргасан зардал, учирсан хохирол, алдагдал зэргийг;
  - 1.2.4. “Алданги” гэж хугацаа хэтрүүлсэн хоног тутамд тодорхой хувиар тооцож авдаг мөнгөн төлбөрийг;
  - 1.2.5. “Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл” гэж тухайн гэрээ хэлцэл байгуулах үед урьдчилан таамаглах боломжгүй нөхцөл байдал үүссэн, эсвэл тухайн нөхцөл байдал талуудын хяналтаас гадуур болсон, түүнийг даван туулах боломжгүй болсон нөхцөл байдлыг;

### Хоёр. Гэрээний гол нөхцөл

- 2.1. Энэхүү гэрээгээр түрээслүүлэгч нь өөрийн өмчлөлийн Нийслэлийн СБД-ийн 11-р хороо 7-р хороолол Ногоон нуур 101 барилга 706 тоот хаягт байрлах, 74.59 м.кв талбай бүхий үл хөдлөх эд хөрөнгийн 15 м.кв талбай /цаашид “Түрээсийн байр” гэх/-г оффис /ажлын байр/-ын зориулалтаар, гэрээний 3.1-д заасан хугацаанд түрээслэгчийн эзэмшил ашиглалтанд шилжүүлэх, түрээслэгч нь гэрээний 4.1-д заасан түрээсийн төлбөр төлөх, эдгээртэй холбоотой бусад харилцааг зохицуулна.
- 2.2. Гэрээ хүчин төгөлдөр болсоны дараа ажлын 5 хоногийн дотор түрээслүүлэгч нь түрээсийн байрыг түрээслэгчид хүлээлгэн өгч, акт үйлдэж баталгаажуулна.
- 2.3. Түрээсийн байр нь эрхийн болон чанарын доголдолгүй байна.
- 2.4. Барилгын хийцэд нөлөөлөхгүйгээр салгаж болох хөрөнгө оруулалт нь түрээслэгчийн өмч болно.

### Гурав. Гэрээний хугацаа

- 3.1. Түрээсийн гэрээний хугацаа 2022 оны 11 сарын 08-ны өдрөөс эхлэн 2027 оны 11 сарын 08-ны өдрийн хүртэл 5 жилийн хугацаатай байна.
- 3.2. Түрээсийн гэрээнд заасан эхний 3 /гурав/ жилийн түрээсийн төлбөрөөс Түрээслэгчийг чөлөөлнө.
- 3.3. Гэрээний хугацааг сунгах эсэхийг талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ. Хэрэв гэрээний хугацаанд талууд гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах тухай санал гаргаагүй бол гэрээг анх байгуулсан нөхцөл, хугацаагаар сунгагдсанд тооцно.



#### Дөрөв. Гэрээний төлбөр

- 4.1. Түрээсийн төлбөр: 1мкв нь 10.000 / арван мянга/ сарын 150.000 /хоёр зуун мянга/ төгрөг байна. Дээрхи дүнд НӨАТ-ын дүн орсон болно.
- 4.2. Түрээслэгч нь түрээсийн төлбөрийг сар бүрийн 05-ны өдөр багтааж ХААН банкин дахь түрээслүүлэгчийн 5034719292 тоот дансанд шилжүүлнэ.
- 4.3. Түрээсийн төлбөрт халаалт, халуун, цэвэр, бохир ус болон ариутгал, хог, зэрэг ашиглалтын бусад утсан холбоо, тог цахилгааны зардлыг түрээслүүлэгч дангаар хариуцна.
- 4.4. Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш түрээсийн байрыг хүлээлгэн өгөх хугацааны ашиглаагүй байсан, түрээсийн байранд засвар үйлчилгээ хийсэн, бусад шалтгаанаар түрээслэгч үйл ажиллагаа явуулах боломжгүй байсан хоног тутмыг тооцож, түрээсийн төлбөрөөс хасна.


#### Тав. Түрээслэгчийн эрх, үүрэг

- 5.1. Түрээслэгчийн эрх, үүрэг:
  - 5.1.1. Түрээсийн байрыг гэрээнд заасан хугацаанд хүлээлгэн өгөхийг түрээслүүлэгчээс шаардах;
  - 5.1.2. Түрээслэгч нь өөрийн үйл ажиллагаа явуулахад шаардлагатай барилгын хийцэд нөлөөлөхгүй зохион байгуулалтын өөрчлөлт хийх;
  - 5.1.3. Түрээсийн байрыг ашиглах явцад үйл ажиллагаа явуулахад шаардлагатай хаяг, реклам зэргийг барилгын гадна талд байрлуулах;
  - 5.1.4. Түрээслүүлэгч нь түрээсийн байрыг дахин түрээслэх, худалдан борлуулах тохиолдолд тэргүүн ээлжинд түрээслэгч талд санал тавихыг шаардах;
  - 5.1.5. Түрээслүүлэгчээс гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах;
  - 5.1.6. Түрээслүүлэгч гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй, нэмэлт хугацаа тогтоосон боловч үр дүн гараагүй бол гэрээг цуцлах.
  - 5.1.7. Түрээслэсэн байранд Түрээслэгчээс үл шалтгаалсан цахилгааны тоног төхөөрөмж, инженерийн шугам сүлжээнд осол гэмтэл, эвдрэл гарвал Түрээслүүлэгч нь цаг тухайд нь засварлаж, хэвийн ажиллагаанд оруулж өгөх
  - 5.1.8. Түрээслэж буй байр, эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалтыг сайжруулах талаар Түрээслүүлэгчид санал, хүсэлт тавьж шийдвэрлүүлэх
  - 5.1.9. Түрээслэгч түрээсийн төлбөрийг хугацаанд нь төлөх;
  - 5.1.10. Түрээсийн байрыг түрээслүүлэгчид буцаан шилжүүлэн өгөх хүртэл түүнийг бүрэн бүтэн, хэвийн ажиллагаатай, чанарын шаардлага хангахуйцаар ашиглах;
  - 5.1.11. Түрээслэгч нь түрээслэж буй талбайд засвар хийхдээ барилгын дотоод үндсэн хэв загвар, даацын тулгуур ханыг нураахгүй байх;
  - 5.1.12. Гэрээний хугацаа дуусахад түрээсийн байрыг цаашид түрээслэхгүй гэж үзвэл ердийн элэгдлийг тооцож, хүлээлгэн өгнө.

#### Зургаа. Түрээслүүлэгчийн эрх, үүрэг

- 6.1. Түрээслүүлэгчийн эрх, үүрэг:
  - 6.1.1. Төлбөрөө хугацаандаа төлөхийг шаардах;
  - 6.1.2. Түрээслэгчээс гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах;
  - 6.1.3. Түрээсийн байрыг гэрээнд заасан хугацаанд түрээслэгч талд эрхийн болон чанарын ямар нэгэн доголдолгүйгээр актаар хүлээлгэн өгөх үүрэгтэй
  - 6.1.4. Гэрээний хугацаанд түрээслэгчийн үйл ажиллагааг хэвийн явуулах боломж нөхцлөөр хангах;






- 6.1.5. Түрээсийн байранд засварыг шаардлагатай болсон тохиолдолд өөрийн хөрөнгөөр хийж гүйцэтгэх;
- 6.1.6. Түрээслүүлэгч шаардлагатай засвар үйлчилгээг хийгээгүйн улмаас эсвэл түрээслүүлэгчийн буруутай ажиллагаанаас үүссэн түрээсийн байранд гарсан цахилгааны болон инженерийн шугамд гарсан гэмтэл ослын улмаас түрээслэгчид учирсан бодит хохирлыг үл маргах журмаар нөхөн төлөх үүрэгтэй.
- 6.1.7. Түрээслэгчийн үйл ажиллагааг дэмжих, зайлшгүй шаардлагын үүднээс хаяг, реклам байрлуулах нөхцлөөр хангах;
- 6.1.8. Түрээслэгчийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохгүй байх;
- 6.1.9. Түрээсийн байрыг ашиглах явцад гарч болзошгүй түрээслүүлэгчийн оролцоотой шийдвэрлэгдэх аливаа нэгэн асуудлыг зохицуулахад түрээслүүлэгч туслалцаа үзүүлэх;
- 6.1.10. Түрээсийн гэрээний хугацаанд түрээсийн эд хөрөнгийг гуравдагч этгээдэд түрээслүүлэх болон бусад хэлбэрээр шилжүүлэхгүй байх;
- 6.1.11. Түрээсийн гэрээний хугацаа дууссан тохиолдолд гэрээг үргэлжлүүлэн сунгах саналыг түрээслэгчид тэргүүн ээлжинд тавих.

#### Долоо. Талуудын хариуцлага

- 7.1. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйгээс учруулсан бодит хохирлыг гэм буруутай тал нь хариуцан арилгах үүрэгтэй.
- 7.2. Түрээслэгч түрээсийн төлбөрийг гэрээнд заасан хугацаанаас хожимдуулсан бол хугацаа хэтрүүлсэн хоног тутамд төлөгдөөгүй үнийн дүнгийн 0,3 хувьтай тэнцэх хэмжээгээр алданги төлнө.
- 7.3. Түрээслүүлэгч гэрээнд заасан үүргээ биелүүлээгүйгээс түрээслэгч үйл ажиллагаа явуулаагүй хоног тутам гэрээний нийт үнийн дүнгийн 0,3 хувьтай тэнцэх хэмжээгээр алданги тооцож түрээслэгчид төлнө.
- 7.4. Түрээслүүлэгч нь түрээсийн байрыг худалдан борлуулж, бусдад шилжүүлсэн, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй гэсэн үндэслэлээр түрээслэгч тал гэрээг цуцласан бол Түрээслүүлэгч нь гэрээ цуцалсантай холбоотой хохирлыг нөгөө талдаа нөхөн төлнө.
- 7.5. Алданги төлж буй нь талуудыг гэрээнд заасан бусад үүргээ биелүүлэхээс чөлөөлөх үндэслэл болохгүй.
- 7.6. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлээс шалтгаалсан нөхцөл байдлын улмаас гэрээний үүргээ биелүүлээгүй бол нөгөө талдаа учирсан хохирлыг нөхөн төлөхөөс чөлөөлөгдөнө.

#### Найм. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, Гэрээг цуцлах, дуусгавар болгох

- 8.1. Талууд харилцан тохиролцож гэрээг хугацаанаас нь өмнө цуцалсан, гэрээний хугацааг сунгахаас татгалзсан тохиолдолд гэрээ дуусгавар болно.
- 8.2. Гэрээг хугацаанаас өмнө цуцлах бол саналаа 15-аас доошгүй хоногийн өмнө нөгөө талдаа албан бичгээр мэдэгдэх бөгөөд талууд харилцан зөвшилцон шийдвэрлэнэ.
- 8.3. Түрээсийн гэрээ дуусгавар болсон тохиолдолд түрээслэгч нь ажлын 5 хоногийн дотор түрээсийн барилгыг чөлөөлөн түрээслүүлэгчид хүлээлгэн өгөх актаар эргүүлэн өгнө.
- 8.4. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай саналаа 15-аас доошгүй хоногийн өмнө нөгөө талдаа бичгээр мэдэгдэх бөгөөд талууд нэмэлт, өөрчлөлтийг харилцан зөвшилцож шийдвэрлэнэ.
- 8.5. Гэрээнд хоёр тал харилцан тохиролцсоны үндсэн дээр бичгээр үйлдсэн гэрээний хэлбэрээр нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд эх хувьд засварласан буюу бусад аргаар оруулсан аливаа нэмэлт өөрчлөлтийг хүчингүйд тооцно.



#### Ес. Бусад нөхцөл

- 9.1. Энэхүү гэрээ нь талуудын эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.
- 9.2. Гэрээг 3 хувь үйлдэж ба хувь тус бүр хуулийн адил хүчинтэй байна.
- 9.3. Талуудын эрх бүхий төлөөлөгчид өөрчлөгдсөн эсэхээс үл хамааран энэхүү гэрээ хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 9.4. Гэрээнд оруулсан нэмэлт, өөрчлөлт, хавсралт, холбогдон гарсан актууд нь энэ гэрээний салшгүй хэсэг болох бөгөөд зөвхөн талуудын тэмдэг, эрх бүхий этгээдийн гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөрт тооцогдоно.
- 9.5. Гэрээнээс үүдэлтэй санал, зөрөлдөөн маргаантай асуудлыг аль болох зөвшилцлийн аргаар шийдвэрлэхийг зорих ба зөвшилцөлд эс хүрвэл шүүхэд хандан шийдвэрлүүлнэ.
- 9.6. Гэрээгээр зохицуулаагүй бусад харилцааг Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

#### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ТҮРЭЭСЛҮҮЛЭГЧ:



ТҮРЭЭСЛЭГЧ:



2023-03-06

БҮРТГЭЭ

СЭХ  
БҮРТГЭЭ



МОНГОЛ УЛС  
УЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ӨМЧЛӨХ ЭРХИЙН  
УЛСЫН БҮРТГЭЛИЙН

ГЭРЧИЛГЭЭ

Дугаар 000583950

"Билл Глобус" ХХК /Регистр № 5388961/ нь

Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 11-р хороо, 7-р хороолол /14180/  
Ногоон нуур гудамж, 101 барилгын 706 тоот халт байршилтай

74.59 м.кв талбайтай, Оффисын зориулалттай ул хөдлөх эд хөрөнгийн  
хууль ёсны өмчлөгч тул эрхийн улсын бүртгэлийн

Ү-2203035870 дугаарт бүртгээж гэрчилгээ олгов.



Улсын бүртгэл

/ J.Алтанхурлуу /

НИЙСЛЭЛИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГАЗАР

2017 он 01 сар 12 өдөр





**“БЭРС ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК” ХХК-ААС АВТОМАШИНЫ ФИДУЦИ БҮХИЙ  
ЗЭЭЛИЙН ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН БАТАЛГААТ ҮНЭТ ЦААС (ХБҮЦ)  
ГАРГАН НИЙТЭД САНАЛ БОЛГОХТОЙ ХОЛБОГДУУЛАН БЭЛТГЭСЭН  
ХУУЛЬ ЗҮЙН ДҮГНЭЛТ**

**ХААНА:** “БЭРС ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК” ХХК-д

**ХАЯГ:** МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР ХОТ, СҮХБААТАР ДҮҮРЭГ, 11-Р ХОРОО, 7  
ХОРООЛОЛ, НОГООН НУУР, 101 БАРИЛГА, 706 ТООТ

**УТАС/ФАКС:** (976) 99119632, (976) 88117328

**ХААНААС:** “ӨМГӨӨЛЛИЙН ЭМ ДИ ЭС ЭНД ХААНЛЕКС” ХХН

**ХАЯГ:** УЛААНБААТАР ХОТ, СҮХБААТАР ДҮҮРЭГ, СҮХБААТАРЫН ТАЛБАЙ 2  
СЭНТРАЛ ТАУЭР, 13 ДАВХАР, 1301 ТООТ

**УТАС/ФАКС:** (976-11) 330048, (976-11) 330049

**ОГНОО:** 2023 ОНЫ 02 ДУГААР САРЫН 13-НЫ ӨДӨР



№ \_\_\_\_\_

**“БЭРС ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК” ХХК-ААС АВТОМАШИНЫ ФИДУЦИ БҮХИЙ  
ЗЭЭЛИЙН ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН БАТАЛГААТ ҮНЭТ ЦААС (ХБҮЦ)  
ГАРГАН НИЙТЭД САНАЛ БОЛГОХТОЙ ХОЛБОГДУУЛАН БЭЛТГЭСЭН ХУУЛЬ  
ЗҮЙН ДҮГНЭЛТ**

“Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс” ХХН нь (цаашид “МДСХ” гэх) нь “Бэрс Эй Би Эс Плас ТЗК” ХХК (цаашид “Компани”, эсхүл “Үнэт цаас гаргагч” гэх)-ийн автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гарган нийтэд санал болгохтой холбогдуулан энэхүү хууль зүйн дүгнэлт (цаашид “Дүгнэлт” гэх)-ийг гаргаж байгаа болно. Энэхүү Дүгнэлт нь тухайлан зориулж гаргасан этгээдүүдээс бусад этгээдийн өмнө ямар нэгэн үүрэг хариуцлага бий болгохгүй. Дүгнэлт нь холбогдох хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэгдсэн бөгөөд аливаа гуравдагч этгээдэд ашигтай байх, эсхүл давуу байдлыг бий болгох мэдээлэл, баталгаа өгөх зорилгогүй болно.

Дүгнэлтийг боловсруулахад ирүүлсэн бүрдүүлбэр материал, баримтуудад агуулагдсан дараах асуудлаар МДСХ нь хариуцлага хүлээхгүй ба Дүгнэлт гаргаагүй болно. Үүнд:

1. Дүгнэлт нь зөвхөн хууль зүйн асуудлаар хийгдсэн бөгөөд аливаа бусад мэдээлэл, түүний дотор тоон мэдээллүүдийн талаар МДСХ нь нарийн мэдлэггүй, тэдгээрийн үнэн зөв байдлыг тогтоохгүй болно;
2. Дүгнэлтэд өөрөөр дурдсанаас бусад тохиолдолд МДСХ-ийн хийсэн ажил энэхүү Дүгнэлтийн тайлбар хэсгийн судалгаа шинжилгээний ажлын хүрээгээр хязгаарлагдаж байгаа болно;
3. Нотариатын гэрчилсэн, улсын бүртгэлд бүртгэгдсэн үйлдэл нь бодит эсэх;
4. Бусад улсын хууль тогтоомж буюу бусад эрх зүйн харьяаллын хүрээнд хийгдсэн, хуульд нийцсэн, хүчин төгөлдөр эсэх;
5. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэгт “...санхүүгийн мэдээлэл нь үнэн зөв эсэхийг аудитын үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдээр тус тус хянуулж, дүгнэлт гаргуулна” гэж заасны дагуу санхүүгийн мэдээлэл, андеррайтерын судалгаа, дүгнэлт, таамаглал болон нийтэд илэрхий мэдээллийн талаар;
6. Эд хөрөнгө, эдийн бус баялгийн үнэлгээ, хувьцааны үнэ, ханшийн мэдээллийн талаар;
7. Дүгнэлтэд тусгайлан дурдсанаас бусад аливаа судалгаа, шинжилгээ, асуулга хийгдээгүй болно. Тийнхүү хийгдээгүй судалгаа, шинжилгээ, асуулгын үндэс болсон аливаа мэдээлэл, бүртгэл нь бүрэн биш, шинэчлэгдээгүй, жишээ нь, тухайн баримт бичиг нь



холбогдох эрх бүхий байгууллагад бүртгэгдээгүй, хувийн хэргээс устсан, алга болсон эсхүл бусад байдлаар архив, хувийн хэрэгт байхгүй болсон байж болно;

8. Компанийн бүх баримт бичиг, гэрээ, төлөвлөгөө, харилцаа холбоо, зөвшөөрөл, хувийн хэрэгтэй танилцсан, тэдгээрийг судалсан гэх амлалтыг МДСХ нь энэхүү Дүгнэлттэй холбоотой гаргахгүй болно;
9. Дүгнэлт боловсруулах үед хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа Монгол Улсын хуулийн хүрээнд хийгдсэн бөгөөд МДСХ нь өөр бусад эрх зүйн тогтолцооны холбоо, хамаарал, нөлөөллийн талаар ямар нэгэн үзэл бодол илэрхийлээгүй болно.

Дор дурдсанаас бусад тохиолдолд бидний бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр энэхүү Дүгнэлтийг ашиглах, ишлэл авах, бусад баримт бичигт оруулан дурдах, бусдад хувиан хүргүүлэхийг хориглоно. Үүнд:

1. “Бэрс Эй Би Эс Плас ТЗК” ХХК-аас автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргах (цаашид “Үнэт цаас” эсхүл “ХБҮЦ” гэх)-тай холбогдуулан Компани болон Компанитай гэрээгээр ажиллаж буй нягтлан бодогч, хуульч болон мэргэжлийн зөвлөхүүд;
2. Холбогдох хууль тогтоомжийн дагуу Компанийн мэдээлэл, тайлан гаргаж хүргүүлэх ёстой төрлийн болон өөрийгөө зохицуулах байгууллага.

“Өмгөөллийн Эм Ди эс энд Хаанлекс” ХХН нь “Бэрс Финанс ББСБ” ХХК-тай аливаа сонирхлын зөрчилгүй болохоо үүгээр мэдэгдэж байна.

Дүгнэлтийг дээрх хаягласан этгээдэд хүргүүлсэн өдрөөс хойш хууль тогтоомжид өөрчлөлт орсон болон бусад үйл ажиллагаатай холбогдуулан МДСХ нэмэлт хууль зүйн дүгнэлт гаргах үүрэг хүлээхгүй болно.

Мөн Компанийн зүгээс ач холбогдол бүхий баримт, мэдээллийг нуусан, орхигдуулсан, Дүгнэлт гаргах явцад танилцуулаагүй, буруу, дутуу танилцуулсан нөхцөлд үүсэх асуудлаар МДСХ хариуцлага хүлээхгүй.

Энэхүү албан бичиг нь Дүгнэлтийн салшгүй хэсэг байна.

Хүндэтгэсэн,

“ӨМГӨӨЛЛИЙН ЭМ ДИ ЭС ЭНД ХААНЛЕКС” ХХН-ИЙН

ГИШҮҮН, ХУУЛЬЧ

Д.ДҮГЭРЖАВ








АГУУЛГА

Удиртгал .....	5
Хангагдсанд тооцох нөхцөл.....	5
1.Компани үүсгэн байгуулах ажиллагаа болон түүнийг хуулийн этгээдийн бүртгэлд бүртгүүлсэн байдал нь хууль тогтоомжид нийцсэн эсэх, гэрчилгээ, тусгай зөвшөөрөл нь хүчин төгөлдөр эсэх .....	8
2.Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тухай шийдвэр нь хууль тогтоомжид нийцсэн эсэх .....	10
3.Компанийн дүрэм, үндсэн үйл ажиллагаанд ашиглагдах журам, зааврууд нь хууль тогтоомжид нийцсэн эсэх.....	12
4.Баталгаат үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч этгээд буюу анхны үүрэг гүйцэтгүүлэгч, худалдагчтай байгуулсан хөрөнгө шилжүүлэх, худалдах, худалдан авах, үйлчилгээ үзүүлэх, хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ, хэлцэл болон Компанийн үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой бусад гэрээ, хэлцэл нь хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх, үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагавар байгаа эсэх .....	16
5.Үнэт цаас гаргагч нь хөрөнгө итгэмжлэн удирдагч, үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч бусад этгээдүүдтэй ашиг сонирхлын зөрчилтэй эсэх .....	19
6.Хөрөнгийн багц дахь хөрөнгийн төрөл бүрээс хамааруулан санамсаргүй түүврийн аргаар сонгох замаар үнэт цаас гаргагчаас тогтоосон хууль зүйн шалгуур үзүүлэлт хангаж буй эсэх .....	22
7.Багцын хөрөнгөөс үүргийн гүйцэтгэлийг хангуулахтай холбогдох гэрээ, хэлцэл нь хууль тогтоомжид нийцсэн эсэх, гэрээ, хэлцэлд үүргийн гүйцэтгэлийн зүйлтэй холбоотой аливаа шаардах эрхийг шилжүүлэхгүй болон хэрэгжүүлэхгүй байхыг үүрэг болгосон, эсхүл шилжүүлэхийг хориглосон, хязгаарласан нөхцөл тусгасан эсэх .....	23
8.Үнэт цаасны танилцуулга, түүнд тусгагдсан мэдээлэл нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, бусад холбогдох хууль журамд нийцэж буй эсэх, үнэн зөв, хүчин төгөлдөр эсэх .....	24
9.Тухайн компанийн эрхэлдэг үйл ажиллагаатай холбоотойгоор хийсэн хууль зүйн нэмэлт судалгаа шинжилгээ .....	26



“Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс” ХХН (цаашид “МДСХ”, эсхүл “Бид” гэх) нь Санхүүгийн Зохицуулах Хороо (цаашид “СЗХ” гэх)-ны 2014 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 25 тоот тогтоолоор Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 33.2.1-т зааснаар Үнэт цаасны зах зээлд хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа эрхлэх этгээдээр анх бүртгэгдсэн бөгөөд СЗХ-ны 2016 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 42 тоот тогтоолоор тус бүртгэлд өөрчлөлт оруулан шинэчлэн бүртгүүлсэн Үнэт цаасны зохицуулалттай этгээд (Хавсралт 1.1)-ийн хувьд энэхүү хууль зүйн үйлчилгээг үзүүлэх эрхтэй болно.


Монгол Улсын хуулийн этгээд болох “Бэрс Эй Би Эс Плас” ХХК (Регистрийн дугаар: 6949886) (цаашид “Компани”, эсхүл “Үнэт цаас гаргагч” гэх) нь автомашины зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас (цаашид “ХБҮЦ” гэх) гарган нийтэд санал болгох гэж буйтай холбогдуулан Хууль зүйн дүгнэлт гаргахыг Бэрс Финанс ББСБ ХХК нь биднээс хүсч, улмаар 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр “Хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ” (Хавсралт 1.2) байгуулан, тус гэрээний дагуу энэхүү хууль зүйн дүгнэлтийг гаргаж байна.

Дүгнэлтийг зөвхөн Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн үндсэн дээр гаргаж байна. Тус Компани нь Компанийн тухай хуулийн 42 дугаар зүйл (Үнэт цаас гаргах тухай шийдвэр), Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйл (Үнэт цаас), 6 дугаар зүйл (Үнэт цаас гаргах) 7 дугаар зүйл (Үнэт цаас гаргагч), 8 дугаар зүйл (Нийтэд санал болгон үнэт цаас гаргах журам), 9 дүгээр зүйл (Үнэт цаас бүртгэх, нийтэд санал болгохыг зөвшөөрөх), 11 дүгээр зүйл (Үнэт цаасыг нийтэд санал болгох), Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 7 дугаар зүйл (Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах), Монголын хөрөнгийн бирж ТӨХК (цаашид “МХБ” гэх)-ийн 2020 оны 02-р сарын 07-ны өдрийн 2020/06 тоот тогтоолоор баталсан “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 2.5.5 дугаар зүйл (Хууль зүйн дүгнэлтийн агуулга), Санхүүгийн Зохицуулах хорооны 2022 оны 06-р сарын 22-ны өдрийн 360 дугаар тогтоолоор баталсан “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журам”-ын 2 дугаар зүйл (Тусгай зориулалтын компанид тавигдах шаардлага), 5 дугаар зүйл (Баталгаат үнэт цаасыг бүртгэх шаардлага), 3 дугаар зүйл (Тусгай зориулалтын компанид тавигдах шаардлага), 7 дугаар зүйл (Үйлчилгээ үзүүлэгчид тавигдах шаардлага), 8 дугаар зүйл (Хөрөнгө итгэмжлэн удирдагчид тавигдах шаардлага, хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ), 10 дугаар зүйл (Аудитын шалгалт болон хууль зүйн дүгнэлт)-д тус тус заасны дагуу хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гарган СЗХ, МХБ-д бүртгүүлж, нийтэд санал болгон арилжихаар төлөвлөсөн байна.

#### **Хангагдсанд тооцох нөхцөл**



Энэхүү Дүгнэлтийг боловсруулахдаа Бид дараах нөхцөл хангагдсан гэж үзсэн болно. Үүнд:

1. Дүгнэлт гаргахад ашигласан Үнэт цаасны танилцуулга нь эцсийн хувилбар бөгөөд энэхүү Дүгнэлтийг гаргах үеийн байдлаар Санхүүгийн Зохицуулах Хороонд хүргэгдэж, ХБҮЦ-ны албан ёсны үнэт цаасны танилцуулга болж ашиглагдах;
2. Үнэт цаасны танилцуулгад тусгасан мэдээ, мэдээллийг оруулсан этгээд нь хууль тогтоомж буюу тухайн талын дүрэм, дотоод дүрэм журам, эрх бүхий этгээдтэй байгуулсан гэрээ, эрх



- бүхий этгээдээс авбал зохих хууль ёсны, хүчин төгөлдөр зөвшөөрөл, итгэмжлэл, эрхийг зохих ёсоор авсны үндсэн дээр үнэт цаасны танилцуулгад мэдээллийг үнэн зөв бүрэн гүйцэт байдлаар тусгасан;
3. Үнэт цаасны танилцуулгад тусгасан нөхцөл ирээдүйд хэрэгжих тохиолдолд тухайн нөхцөл нь хуулийн дагуу, зохих ёсоор, эрхийн болон биет байдлын доголдолгүй хэрэгжих;
  4. Үнэт цаасны танилцуулгыг батлах, бүртгүүлэх үйлдэл нь хуульд нийцсэн, зохих ёсоор, хүчин төгөлдөр байдлаар хийгдэх;
  5. Үнэт цаасны танилцуулгад дурдсан санхүүгийн тоо, мэдээ, баримт, үзүүлэлт, тооцоо, тайлан болон бусад үзүүлэлтийг аудитын үйлчилгээ эрхлэх эрх бүхий байгууллага хянан баталгаажуулсан, эдгээр мэдээ мэдээлэл нь үнэн зөв, бүрэн гүйцэт;
  6. Үнэт цаасны танилцуулгад тусгасан хөрөнгийн багцад хийсэн судалгаа шинжилгээ үнэн зөв, бүрэн гүйцэт байх;
  7. Үнэт цаасны танилцуулгад тусгасан хэлцэл хийх, гэрээ байгуулах, хэлцэл батлах талаарх үйлдэл нь хуульд нийцэж зохих ёсоор, хүчин төгөлдөр байдлаар хийгдэх;
  8. Үнэт цаасны танилцуулгад тусгасан талуудын хооронд байгуулагдах гэрээ, хэлцлийг хууль тогтоомжид заасан шаардлагын дагуу зохих ёсоор байгуулах, гэрчлүүлэх, бүртгүүлэх;
  9. Үнэт цаасны танилцуулгад тусгасан андеррайтер, аудитор, мэргэжлийн оролцогчдын хийсэн судалгаа, дүгнэлт, санхүүгийн мэдээлэл нь үнэн зөв;
  10. Дүгнэлт гаргахад ашигласан гэрээ хэлцлийн төсөл нь эцсийн хувилбар бөгөөд энэхүү Дүгнэлтийг гаргах үеийн байдлаар байгуулагдах;
  11. Дүгнэлт гаргахад ашиглагдсан (а) бидэнд ирүүлсэн бүх баримт бичигт дурдсан мэдээлэл үнэн, зөв, бүрэн гүйцэт; (б) тэдгээр баримт бичигт зурагдсан гарын үсэг, дарагдсан тамга, тэмдэг зохих ёсны бөгөөд үнэн зөв; (в) бидэнд ирүүлсэн бичиг баримтуудын хуулбар нь тэдгээрийн эх хувьтай нийцсэн, бүрэн; (г) бидэнд ирүүлсэн бичиг баримтууд нь хамгийн сүүлд батлагдсан хувилбар буюу тэдгээрт өөрчлөлт ороогүй, хүчингүй болоогүй;
  12. МДСХ-ээс тавьсан асуулт, тодруулгад Үнэт цаас гаргагч, түүний хувьцаа эзэмшигч, бусад оролцогчоос амаар болон бичгээр өгсөн хариулт, тайлбар, түүнийг нотлох баримт бичиг үнэн зөв;
  13. Бидний судлан шинжилсэн бүх баримт бичгийн хуулбар, эсхүл загвар, маягтууд нь үнэн зөв, тэдгээр дээрх аливаа тэмдэглэгээ, гарын үсэг, тамга тэмдэг нь үнэн;
  14. Бүх баримт бичгүүд нь тэдгээрийг үйлдсэн талуудын бүрэн эрхийн хүрээнд үйлдэгдсэн;
  15. Бидэнд өгөгдсөн баримт бичгийн дагуу үүсэх аливаа үүрэг нь Монгол Улсаас бусад эрх зүйн тогтолцоонд хүчин төгөлдөр байх ба тэдгээр үүргийн хэрэгжилт хууль бус, хүчин төгөлдөр бус, эсхүл хэрэгжих боломжгүй биш байна;
  16. Монгол Улсаас өөр улсад үйлдэгдсэн аливаа баримт бичиг нь тийнхүү үйлдэгдсэн улсын хуулийн шаардлагыг хэлбэрийн болон агуулгын хувьд бүрэн хангасан, хүчин төгөлдөр баримт бичиг ба тэдгээрийн хэрэгжилт нь тийнхүү хэрэгжих улсын хуулийн шаардлагыг мөн хангасан;
  17. Компани, түүний албан тушаалтан, ажилтнуудаас аливаа хэлбэрээр хүлээн авсан аливаа мэдээлэл нь үнэн зөв, бодитой;
  18. Шүүх, төрийн эрх бүхий байгууллагаас авсан мэдээлэл, баримт бичиг нь үнэн зөв;
  19. Бидний судалж ашигласан бичиг баримтыг бэлтгэсэн болон түүнд гарын үсэг зурсан этгээд нь тийнхүү уг баримт бичгийг бэлтгэх, гарын үсэг зурах бүрэн эрхтэй;







20. Үнэт цаас гаргагчийн үнэт цаас гаргахтай холбоотойгоор бэлтгэл ажил гүйцэтгэхэд шаардлагатай гэрээ, хэлцэл (Хэлцлийн зөвлөх үйлчилгээний гэрээ, Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээ, Хамтран ажиллах гэрээ)-г “Бэрс Финанс ББСБ” ХХК байгуулсан болно. Эдгээр гэрээг “Бэрс Эй Би Эс Плас” ХХК-ийн эрх ашгийн үүднээс байгуулсан тул тэдгээр гэрээнд тусгагдсан Бэрс Финанс ББСБ” ХХК-ийн зарим эрх, үүргийг Үнэт цаас гаргагч хэрэгжүүлж болно.

Энэхүү ХБҮЦ-ны бүртгэл болон арилжаа нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10.6, 10.7, СЗХ-ны 2022 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 360 тоот тогтоолоор батлагдсан “Хөрөнгөө баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журам”, Хууль зүйн сайд, СЗХ-ны даргын хамтарсан 2013 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн А/167/203 тоот тушаалаар батлагдсан “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хөрөнгийн багцыг тусгай тэмдэглэл хийж бүртгэх тухай журам”, МХБ-ийн ТУЗ-ийн 2020 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 2020/06 тоот тогтоолоор батлагдсан “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам”, МХБ-ийн ТУЗ-ийн 2018 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 15 тоот тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам” болон ТУЗ-ийн 2012 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 02 тоот тогтоолоор батлагдсан “МХБ-ийн Арилжааны журам”-д заасны дагуу явагдана гэж үзлээ.

Санхүүгийн зохицуулах хорооноос хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тусгай зөвшөөрөл олгож, зөвшөөрлийг улсын бүртгэлд бүртгүүлэхээс өмнө “Бэрс Эй Би Эс Плас ТЗК” ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр, үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдтэй байгуулсан гэрээнүүд нь тусгай зориулалтын компанийн хувьд хүчин төгөлдөр мөрдөгдөх бөгөөд компанийн нэр уг хугацаанаас өмнө ба дараа өөрөөр туссан болохыг анхаарна уу.

Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн үнэт цаасны танилцуулга, бусад холбогдох мэдээллүүдийг үндэслэн Дүгнэлт гаргах өдрийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн дор дурдсан Дүгнэлтийг гаргаж байна:



1. Компани үүсгэн байгуулах ажиллагаа болон түүнийг хуулийн этгээдийн бүртгэлд бүртгүүлсэн байдал нь хууль тогтоомжид нийцсэн эсэх, гэрчилгээ, тусгай зөвшөөрөл нь хүчин төгөлдөр эсэх


“Бэрс Эй Би Эс Плас” ХХК нь “Бэрс Финанс ББСБ” ХХК-ийн 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 22/17a/69 тоот Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр (Хавсралт 1.3)-ийн үндсэн дээр Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар байгуулагдаж, 2022 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр Улсын бүртгэлд бүртгүүлсэн (Хавсралт 1.4, 1.5) байна. Энэхүү хувьцаа эзэмшигчдийн хурал нь Компанийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.7-д заасан үндэслэлээр тус хуулийн 60 дугаар зүйлд заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай шийдвэрийг хуульд заасан хугацаанд хувьцаа эзэмшигчид мэдэгдсэн байна. Үнэт цаас гаргагчийн цорын ганц хувьцаа эзэмшигч нь “Бэрс Финанс ББСБ” ХХК бөгөөд тус компанийн 100%-ийн хувьцаа эзэмшигчээр “Бэрс Капитал” ХХК (Хавсралт 1.12), “Бэрс Капитал” ХХК-ийн цорын ганц хувьцаа эзэмшигч бөгөөд “Бэрс Финанс ББСБ” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Отгонбат (Хавсралт 10.6) шийдвэрт гарын үсэг зурсан байна.

“Бэрс Эй Би Эс Плас” ХХК нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлөө уг үнэт цаасаа бүртгүүлэхийн өмнө Санхүүгийн зохицуулах хорооноос авахаар төлөвлөж, 2022 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 24/05 дугаартай албан бичгээр хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн албан бичиг (Хавсралт 1.6), холбогдох материалаа Хороонд хүргүүлсэн. Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай” 28 дугаар тогтоолоор Компани нь Хорооноос хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл (Хавсралт 1.7)-ийг авч “Бэрс Эй Би Эс Плас ТЗК” ХХК болж, оноосон нэр, эрхлэх үйл ажиллагааны төрөлд өөрчлөлт оруулан дүрмээ улсын бүртгэлд бүртгүүлсэн байна (Хавсралт 1.8, 1.9).

**Компанийн тухай мэдээлэл:**

- Улсын бүртгэлийн гэрчилгээ дугаар: 000277408
- Улсын бүртгэлийн дугаар: 9011845634;
- Регистрийн дугаар: 6949886;
- Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр: “Бэрс Эй Би Эс Плас ТЗК” Хязгаарлагдмал хариуцлагатай компани;
- Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл: Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах;
- Хугацаа: Хугацаагүй;
- Хувьцаа эзэмшигчдийн тоо: 1;

№	Хувьцаа эзэмшигчийн нэр	Гаргасан хувьцаа			Хувь нийлүүлсэн хөрөнгөд эзлэх хувь
		Тоо ширхэг	Нэрлэсэн үнэ		
			Нэг бүрийн үнэ	Бүгд	



1.	“Бэрс Финанс ББСБ” ХК	1,000	1,000	1,000,000	100%
----	-----------------------	-------	-------	-----------	------

Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ: 1,000,000 төгрөг;

Хуулийн этгээдийн албан ёсны хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 11-р хороо, 7 дугаар хороолол, Ногоон нуур, 101 барилга, 706 тоот;

Гүйцэтгэх захирал: С.Отгонбат;

**Компани үүсгэн байгуулагчийн тухай мэдээлэл:**

Улсын бүртгэлийн гэрчилгээ дугаар: 000206010

Улсын бүртгэлийн дугаар: 9015005096;

Регистрийн дугаар: 6186858;

Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр: “Бэрс Финанс ББСБ” Хязгаарлагдмал хариуцлагатай компани (Хавсралт 1.11);

Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ: СЗХ-ны 2017 оны 11-р сарын 20-ны өдрийн 495 тоот тогтоолын дагуу ТЗ 101/622 дугаар бүхий ББСБ-ын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй (Хавсралт 1.13)



Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл: Зээлийн үйл ажиллагаа эрхлэх, Факторингийн үйлчилгээ, Итгэлцлийн үйлчилгээ үзүүлэх, Төлбөрийн баталгаа гаргах (Хавсралт 1.13);

Хугацаа: Хугацаагүй;

ТЗК үүсгэн байгуулах этгээд нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.4 дүгээр зүйлд зааснаар банк, банк бус санхүүгийн байгууллага, орон сууцны санхүүжилтийн компани болон Хорооноос зөвшөөрсөн санхүүгийн бусад байгууллага байж болно. Компанийг үүсгэн байгуулагч нь “Бэрс Финанс ББСБ” ХХК буюу “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” хуулийн 10.1.1, 15.3.1, “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай” хуулийн 6.1, 9.1-д тус тус заасны дагуу СЗХ-ны 2017 оны 07-р сарын 05-ны өдрийн 144 тоот тогтоол (Хавсралт 1.14)-оор Банк бус санхүүгийн байгууллагын зээлийн үйл ажиллагаа эрхлэх, 2018 оны 11-р сарын 14-ний өдрийн 344 тоот тогтоол (Хавсралт 1.15)-оор факторингийн үйлчилгээ үзүүлэх, 2020 оны 06-р сарын 10-ны өдрийн 350 дугаар тогтоол (Хавсралт 1.16)-оор итгэлцлийн үйлчилгээ үзүүлэх, СЗХ-ны 2022 оны 02-р сарын 23-ны өдрийн 76 дугаар тогтоол (Хавсралт 1.17)-оор төлбөрийн баталгаа гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Түүнчлэн Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 22900002004643 тоот лавлагаа (Хавсралт 1.10)-нд зааснаар “Бэрс Финанс ББСБ” ХХК нь татан буугдсан, дампуурсан талаарх тэмдэглэлгүй тул Дүгнэлт гаргах өдрийн байдлаар идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа, эрх зүйн чадвар, чадамжтай хуулийн этгээд тул “Бэрс Финанс ББСБ” ХХК нь тусгай зориулалтын компани үүсгэн байгуулах эрх бүхий этгээд болно.

Иймд, энэхүү улсын бүртгэлийн гэрчилгээ (Гэрчилгээний дугаар 000277408, Улсын бүртгэлийн дугаар 9011845634, Регистрийн дугаар 6949886) бүхий “Бэрс Эй Би Эс Плас ТЗК” ХХК нь Монгол улсын хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдаж бүртгэгдсэн байна.





**Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тухай шийдвэр нь хууль тогтоомжид нийцсэн эсэх**

**Үнэт цаас гаргах бэлтгэл хангах тухай:**

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах бэлтгэл хангах тухай ТУЗ-ийн 2022 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн 22/17а/68 дугаар тогтоол (Хавсралт 2.1)-оор “Бэрс Финанс ББСБ” ХХК-ийн зээлүүдээс багцлан 9,000,000,000 (есөн тэрбум) төгрөгийн автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргах бэлтгэл ажил хангахыг ББСБ-ын ажилтнуудад үүрэг болгон шийдвэрлэсэн байна.



Хорооны журмын 10.4.6 дахь хэсэгт заасны дагуу зээлийн шинжилгээ хийж, 2022 оны 12 дугаар сарын 26-ны өдөр “Онч Аудит” ХХК-аас гаргасан “Үр дүнгийн тайлан” болон “Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс” ХХН-ийн 2023 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн “Автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас олон нийтэд нээлттэй санал болгох хүрээнд сонгогдсон зээлийн дансдын хуулийн шалгуур үзүүлэлтэд нийцсэн эсэх талаарх хуулийн хөндлөнгийн дүн шинжилгээний тайлан”-г тус тус үндэслэн дээрх Хөрөнгийн багцыг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 9 дүгээр зүйл, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тухай 2023 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 23/24а/02 тоот тогтоол (Хавсралт 2.2)-ын 2, 3 дугаар хавсралтаар баталсан “Хөрөнгийн багцын хуулийн болон санхүүгийн шалгуур үзүүлэлт”-ийг хангасан болохыг баталгаажуулсан.

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах бэлтгэл хангах тухай ТУЗ-ийн 2022 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн 22/17а/68 дугаар тогтоол (Хавсралт 2.1), Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон Үнэт цаас гаргагч нарын хооронд 2023 оны 02 дугаар сарын 09-ний өдөр байгуулсан Хөрөнгө худалдах худалдан авах гэрээ (Хавсралт 4.1)-ний дагуу “Бэрс Финанс ББСБ” ХХК-ийн багцалсан зээлийн хөрөнгийг Үнэт цаас гаргагчид шилжүүлэхээр тохиролцож, Хөрөнгөөр баталгаасан үнэт цаас гаргах тухай шийдвэр гаргасан байна.

**Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах шийдвэрийн тухай:**


Компанийн хувьцаа эзэмшигч “Бэрс Финанс ББСБ” ХХК-ийн 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 22/17а/69 тоот ХЭХ-ийн тогтоол (Хавсралт 1.3)-ын дагуу Компанийн хувьцаа эзэмшигч нь ТЗК байгуулж, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргахаар шийдвэрлэсэн байна. Түүнчлэн Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 28 дугаар тогтоолоор тусгай зөвшөөрөл олгосныг үндэслэн Компанийн ТУЗ-ийн 2023 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 23/24а/02 дугаар Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргах тухай тогтоол (Хавсралт 2.2)-оор Компани Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 10 дугаар зүйлд заасны дагуу автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас (цаашид “Үнэт цаас” гэх)-ыг дараах нөхцөлтэйгөөр гаргахаар шийдвэрлэсэн. Үүнд:

Үнэт цаасны төрөл	Автомашины фидуци бүхий хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас
-------------------	--



Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага	Монголын хөрөнгийн бирж
Үнэт цаасны нэр	“Бэрс-2” ХБҮЦ
Үнэт цаасны тоо ширхэг	90,000 ширхэг
Үнэт цаасны нэгжийн нэрлэсэн үнэ	100,000 төгрөг
ХБҮЦ-аар татан төвлөрүүлэх хөрөнгийн дүн	9,000,000,000 төгрөг
Үнэт цаас гаргахаар төлөвлөж буй хугацаа	2023.03 сар
Үнэт цаасны хүү, хувь хэмжээ: /жил/	19.2%
Үнэт цаасны хугацаа: /хоног, сар, жил/	24 сар
Үнэт цаасны хүүгийн төрөл	Тогтмол
Үнэт цаасны хүү тооцох суурь хоног	365
Үнэт цаасны хүү төлөх хугацаа: давтамж/	Улирал тутам
Үнэт цаасны үндсэн төлбөр төлөгдөх хугацаа	Жилд 1 удаа
Үнэт цаасны хадгалалт, төлбөр тооцоо:	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв
Үнэт цаасны зарцуулалт:	Компанийн үндсэн үйл ажиллагаа
Барьцаа:	Автомашинны фидуци бүхий зээлийн багц

Энэхүү тогтоол нь Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.5, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5.1.6, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2, 7.3 дахь хэсэг, Санхүүгийн Зохицуулах Хорооны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журмын 3.4 дэх хэсэгт тус тус нийцсэн байна.



3. **Компанийн дүрэм** үндсэн үйл ажиллагаанд ашиглагдах журам, зааврууд нь хууль 01 тогтоомжид нийцсэн эсэх

*Компанийн дүрэм:*

**“Бэрс Эй Би Эс Плас” ХХК-ийн дүрэм.** Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 22/17a/69 дугаар шийдвэр (Хавсралт 1.3)-ээр баталж, улсын бүртгэлийн тамгаар баталгаажсан “Бэрс Эй Би Эс Плас” ХХК-ийн дүрмийг (Хавсралт 1.5) баталсан байна. Дүрэм нь нийт 11 бүлэгтэй бөгөөд Компанийн оноосон нэр, оршин байгаа хаяг, үйл ажиллагааны үндсэн чиглэл, хугацаа, Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө, Хувьцаа эзэмшигчийн мэдээлэл, Компанийн үндсэн эрх, үүрэг, хариуцлага, хувьцаа эзэмшигч, хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл, түүний гишүүдийн тоо, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтан, тэдний эрх, үүрэг хариуцлагыг тодорхойлох, Компанийн санхүүгийн үйл ажиллагаа, бүртгэл, тайланд хяналт тавих, Компанийг өөрчлөн байгуулах, татан буулгахтай холбогдсон харилцааг зохицуулсан байна. Дүрэм нь Компанийн тухай хуулийн 16 дугаар зүйл болон бусад холбогдох зохицуулалтад нийцсэн байна. Мөн ХЭХ нь Компанийн тухай 62 дугаар зүйлийн 62.1.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд дүрмийг баталсан, дүрэм батлах тухай ХЭХ-ийн шийдвэр нь тус хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-т заасан саналын эрхийн хэмжээнд хүрсэн, 17.9-т зааснаар улсын бүртгэлд бүртгэгдсэн байх тул дүрэм нь хуулийн хүчин төгөлдөр болно.

**“Бэрс Эй Би Эс Плас ТЗК” ХХК-ийн дүрэм.** Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 23/24a/01 дүгээр шийдвэр (Хавсралт 3.2)-ийн 1 дүгээр хавсралтаар “Бэрс Эй Би Эс Плас ТЗК” ХХК-ийн дүрэм (Хавсралт 1.9)-ийг баталсан байна. Энэхүү дүрэм нь нийт 8 бүлэгтэй бөгөөд Компанийн оноосон нэр, оршин байгаа хаяг, Компанийн зорилго, үйл ажиллагааны үндсэн чиглэл, Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө, гаргасан хувьцаа, Компанийн үндсэн эрх, үүрэг, хариуцлага, хувьцаа эзэмшигч, хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл, түүний гишүүдийн тоо, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гүйцэтгэх удирдлага, тэдний эрх, үүрэг хариуцлагыг тодорхойлж, Компанийн санхүүгийн үйл ажиллагаа, аудит ба хяналтын тогтолцоо, Компанийг татан буулгах, Компанийн дүрэм хүчин төгөлдөр болохтой холбогдсон харилцааг зохицуулсан байна. СЗХ-оос 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 28 тоот тогтоол (Хавсралт 1.7)-оор хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Компанид олгосноор дүрэм нь хүчин төгөлдөр мөрдөгдөх үндэслэл бий болж, 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдөр улсын бүртгэлд бүртгэгдсэн байна (Хавсралт 1.9). Энэхүү дүрэмд Компанийн оноосон нэрэнд “ТЗК” болох болон хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэхээр тусгасан нь Компанийн тухай хуулийн 16 дугаар зүйл, 17 дугаар зүйлийн 17.9 болон Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.9, 12.11, 12.12 дугаар зүйлүүд болон бусад холбогдох зохицуулалтад нийцсэн байна.

*Компанийн дотоод үйл ажиллагааны журмууд:*



**ТУЗ-ийн үйл ажиллагааны журам.** Компанийн ТУЗ-ийн 2023 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 23/24a/05 тоот шийдвэр (Хавсралт 3.1)-ийн 1 дүгээр хавсралтаар энэхүү ТУЗ-ийн үйл



ажиллагааны журам (Хавсралт 3.3)-ыг баталсан байна. Журмаар нийтлэг үндэслэл, төлөөлөн удирдах зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, ТУЗ-ийн дарга, гишүүдийг сонгох, бүрдүүлэх баримт бичиг, бүрэн эрхийн хугацаа, бүрэн эрхийг хугацаанаас өмнө дуусгавар болгох үндэслэл, ТУЗ-ийн энгийн болон хараат бус гишүүний эрх үүрэг, ТУЗ-ийн зохион байгуулалт, ажиллах нөхцөл, хангамж, ТУЗ-ийн хурал, хариуцлагатай холбоотой харилцааг зохицуулсан байна. ТУЗ-ийн үйл ажиллагааны журам нь Компанийн тухай хуулийн 75.8, 76.1, 80.1, 80.5, 80.6, 80.9, 80.11, 80.12, 80.14, 82 дугаар зүйл, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.8, СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журмын 3 дугаар зүйлд заасан холбогдох шаардлагыг тус тус хангасан байхаас гадна болон Компанийн дүрэмд нийцсэн байна.

**Хөндлөнгийн аудитор, үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох, солих журам.** Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 23/24а/05 тоот тогтоол (Хавсралт 3.1)-ын 2 дугаар хавсралтаар Хөндлөнгийн аудитор, үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох, солих журам (Хавсралт 3.4)-ыг баталжээ. Энэхүү журам нь нийт 8 бүлэгтэй бөгөөд хөндлөнгийн аудитор, үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагчид тавигдах шаардлага, тэдгээрийг сонгох, гэрээ байгуулах, хөндлөнгийн аудитор, үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагчийг солихтой холбогдсон харилцааг зохицуулсан байна. Уг журам нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10.6, 10.7, 33.2 дахь хэсэг, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.11.4, 19.1, 19.8, 19.10, 20.1, 20.3, 40.1, дэх хэсэг, Аудитын тухай хуулийн 17 дугаар зүйл, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журмын холбогдох хэсэг, Монголын хөрөнгийн биржээс баталсан Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 3.2.12.2 дэх хэсэг болон бусад холбогдох зохицуулалтад нийцсэн байна.

**Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлэх журам.** Компанийн хөрөнгө оруулагч, үнэт цаас эзэмшигчид Компанийн үйл ажиллагааны талаар болон хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг тогтмол хүргэх, уг мэдээллийн төрөл, хэлбэр, давтамж, мэдээллийн ил тод байдлыг хангах, нийтэд хүргэх, нэгдсэн нэг мэдээллийн урсгалтай байх, түүнийг хэрэгжүүлэх, хяналт тавих зорилгоор нийт 4 бүлэг бүхий зохицуулалттай энэхүү журам (Хавсралт 3.5)-ыг 2023 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 23/24а/05 тоот тогтоол (Хавсралт 3.1)-ын 3 дугаар хавсралтаар баталсан байна. Энэхүү журмаар Компанийн хугацаат тайлант нийтэд мэдээлэх, тогтмол мэдээлэх, тухай бүр нээлттэй мэдээлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх, мэдээллийг үнэт цаас эзэмшигчид хүргэхэд баримтлах зарчмыг тодорхойлж, мэдээллийг хадгалах, архивлахтай холбогдсон харилцааг зохицуулсан байна. Компанийн тухай хуулийн 98 дугаар зүйл, Үнэт цаасны тухай хуулийн 20.1, 79.1 дэх хэсэг, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20.2.3, 39, Санхүүгийн зохицуулах хорооны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журмын 11 дүгээр зүйлийн холбогдох хэсэг, Үнэт цаасны зах зээл дэх дотоод мэдээллийн жагсаалт, түүнийг мэдээлэх журам, Үнэт цаас гаргагчаас мэдээллийг нийтэд тогтмол хүргэх тухай журам, Монголын Хөрөнгийн Биржийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 9.5-9.7 дах хэсэгт заасан шаардлагыг хангасан байна.





**Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх тухай журам.** Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 23/24а/05 тоот тогтоол (**Хавсралт 3.1**)-ын 4 дүгээр хавсралтаар Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх тухай журам (**Хавсралт 3.6**)-ыг баталжээ. Журмаар ТЗК-ийн гаргах хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны төлбөрийг Зээлдэгчид болон Үйлчилгээ үзүүлэгчдээс цуглуулах, цуглуулсан төлбөрөөр үнэт цаас эзэмшигчдэд үнэт цаасны төлбөр төлөхтэй холбогдсон Компанийн үйл ажиллагаа болон Компанийн Үйлчилгээ үзүүлэгч, Хөрөнгө итгэмжлэн удирдагч болон бусад холбогдох этгээдүүдийн үйл ажиллагаа, хариуцлагатай холбоотой харилцааг зохицуулсан байна. Журам нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцсэн байна.

**Эрсдэл, сонирхлын зөрчлийг илрүүлэх, үнэлэх, удирдах дотоод хяналтын журам.** Компанийн ТУЗ-ийн 2023 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 23/24а/05 тоот тогтоол (**Хавсралт 3.1**)-ын 5 дугаар хавсралтаар энэхүү журам (**Хавсралт 3.7**)-ыг баталсан байна. Журмаар нийтлэг үндэслэл, эрсдлийн ангилал, эрсдлийг удирдах арга хэмжээ, эргэн төлөлтийг сайжруулах, журам зөрчсөн ажилтанд хариуцлага тооцохтой холбоотой харилцааг зохицуулсан байна. Журам нь холбогдох хууль тогтоомжийн зөрчилгүй байна.

**Хөрөнгө итгэмжлэн удирдах журам.** Компанийн ТУЗ-ийн 2023 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 23/24а/05 тоот тогтоол (**Хавсралт 3.1**)-ын 6 дугаар хавсралтаар энэхүү журам (**Хавсралт 3.8**)-ыг баталсан байна. Журмаар нийтлэг үндэслэл, хөрөнгийн багцад өөрчлөлт оруулах, хөрөнгийн багцад өөрчлөлт оруулах дараалал, үндэслэлийг тодорхойлж, журмыг зөрчсөн ажилтанд хариуцлага тооцохтой холбоотой харилцааг зохицуулсан байна. Журам нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 9 дүгээр зүйл, 15 дугаар зүйл, 18.2 дах хэсэг, СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцсэн байна.

**Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам.** Компанийн ТУЗ-ийн 2023 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 23/24а/05 тоот тогтоол (**Хавсралт 3.1**)-ын 7 дугаар хавсралтаар энэхүү журам (**Хавсралт 3.9**)-ыг баталсан байна. Журмаар мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, холбогдох хууль тогтоомж, зохицуулалтын байгууллагаас баталсан дүрэм, журам, стандартуудыг дагаж мөрдөх, үүсэж болох эрсдэлээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон харилцааг зохицуулсан байна. Журам нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, СЗХ-ны 2019 оны 01-р сарын 21-ний өдрийн А-26 дугаар тушаалаар баталсан Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журамд нийцсэн, холбогдох бусад хууль тогтоомжийн зөрчилгүй байна.

“Бэрс Эй Би Эс Плас ТЗК” ХХК-ийн ТУЗ нь Компанийн дотоод үйл ажиллагааны журмуудыг Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.10, 76.1.13 дах хэсэг, ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын 3 дугаар зүйлийн 3.3-г заасан бүрэн эрхийн хүрээнд баталсан, ТУЗ-ийн хурал нь Компанийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.5-д заасны дагуу хүчин төгөлдөр байх ба ТУЗ-ийн тогтоол нь Компанийн тухай хуулийн 80.6-д зааснаар саналын эрхийн хэмжээнд



хүрэн байх тул дээр дурдсан журмуудыг баталсан ТУЗ-ийн 2023 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 23/24а/05 тоот тогтоол (**Хавсралт 3.1**) нь хуулийн хүчин төгөлдөр байна.

Компанийн дүрэм, ТУЗ-ийн 2023 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 23/24а/05 тоот тогтоолоор баталсан журмууд нь хуулийн хүчин төгөлдөр, хууль тогтоомжид нийцсэн ба ТЗК-ийн дүрэм нь холбогдох эрх зүйн актаар тогтоосон аливаа зөрчилгүй байна.



**Бүтэцтэй** үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч этгээд буюу анхны үүрэг гүйцэтгүүлэгч, худалдагчтай байгуулсан хөрөнгө шилжүүлэх, худалдах, худалдан авах, үйлчилгээ үзүүлэх, хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ, хэлцэл болон Компанийн үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой бусад гэрээ, хэлцэл нь хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх, үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагавар байгаа эсэх

Бид тус Компаниас ирүүлсэн Компанийн үйл ажиллагаанд голлох ач холбогдол бүхий дор дурдсан гэрээг хянасан болно.


*Үндсэн үйл ажиллагаатай холбоотой гэрээний төслүүд:*

**Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ.** Компанийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргахтай холбоотой “Бэрс Финанс ББСБ” ХХК, “Бэрс Эй Би Эс Плас ТЗК” ХХК нарын хооронд 2023 оны 02-р сарын 09-ний өдөр 23/559 тоот “Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ” (Хавсралт 4.1) байгуулагдсан байна. Тус гэрээ нь нийт 14 бүлгээс бүрдсэн бөгөөд тус гэрээний дагуу Үнэт цаас гаргагч нь зээлийн багц хөрөнгө болон түүнд холбогдох эрхийг худалдан авч, гэрээнд заасан үнийг төлөх, анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь хөрөнгийн багцыг худалдах, зээлийн хөрөнгийг солихтой холбоотой харилцааг зохицуулж байна. Энэхүү гэрээ нь Иргэний хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.


**Төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлэх гэрээ.** Компанийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргахтай холбоотой “Бэрс Эй Би Эс Плас ТЗК” ХХК, “Бэрс Финанс ББСБ” ХХК, “Юнайтед Айр Файнэнс” ХХК нарын хооронд 2023 оны 02-р сарын 09-ний өдөр 23/561 тоот “Төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлэх гэрээ” (Хавсралт 4.2) байгуулагдсан байна. Тус гэрээ нь нийт 9 бүлгээс бүрдсэн бөгөөд тус гэрээний дагуу Үйлчилгээ үзүүлэгч нь Үнэт цаас гаргагчаас гаргах хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны төлбөрийг цаг хугацаанд нь цуглуулан, шилжүүлэх, бүртгэлийг хөтлөх, тайлагнах, Зээлийн эрсдэлийг удирдах журмын дагуу зээлийн хяналт тавьж, зээл төлүүлэх ажиллагаа явуулах, Хөрөнгө итгэмжлэн удирдагчаас төлбөр цуглуулах үйл ажиллагаанд хяналт тавих, Үнэт цаас гаргагч нь үйлчилгээний төлбөрийг төлөхтэй холбогдох харилцааг зохицуулсан байна. Энэхүү гэрээ нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.

**Фидуцийн барьцааны гэрээ.** “Бэрс Эй Би Эс Плас ТЗК” ХХК, “Бэрс Финанс ББСБ” ХХК нарын хооронд 2023 оны 02-р сарын 09-ний өдөр 23/560 тоот “Багцын хөрөнгийн барьцааны гэрээ” (Хавсралт 4.3) байгуулагдсан байна. Тус гэрээ нь нийт 8 бүлгээс бүрдсэн бөгөөд тус гэрээгээр Хөрөнгө худалдах худалдан авах гэрээний дагуу шилжүүлэх Хөрөнгийн багц, уг багцад буй автомашины зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны эргэн төлөлтийн үүргийн гүйцэтгэлийг хангуулах зорилгоор фидуцийн зүйлийн өмчлөх эрхийг барьцаалагчид барьцаалуулахтай холбоотой харилцааг зохицуулсан байна. Энэхүү гэрээ нь Иргэний хууль, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.

**Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ.** “Бэрс Эй Би Эс Плас ТЗК” ХХК, “Юнайтед Айр Файнэнс” ХХК нарын хооронд 2023 оны 02-р сарын 09-ний өдөр 23/563 тоот “Хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээ үзүүлэх гэрээ” (Хавсралт 4.4) байгуулагдсан байна. Тус гэрээ нь гэрээний тусгай



MDSKhanLex



нөхцөл, гэрээний ерөнхий нөхцөл, хавсралтаас бүрдсэн байна. Гэрээний дагуу Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т заасан үйлчилгээ үзүүлэх буюу Үнэт цаас гаргагчийн Хөрөнгийн багцыг итгэмжлэн удирдах, Үнэт цаас эзэмшигчдэд төлбөр төлөх, Үнэт цаас гаргагч нь Хөрөнгө итгэмжлэн удирдагчид үйлчилгээний хөлс төлөх холбоотой харилцааг зохицуулсан байна. Энэхүү гэрээ нь Иргэний хууль, СЗХ-ны “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам”-ын 8.2 дугаар зүйлд заасан мэдээллийг тусгасан, холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.



**Зээлийн эргэн төлөлтийн дансны барьцааны гэрээ.** Компанийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргахтай холбоотой “Бэрс Эй Би Эс Плас ТЗК” ХХК, “Бэрс Финанс ББСБ” ХХК, “Юнайтед Айр Файнэнс” ХХК нарын хооронд 2023 оны 02-р сарын 09-ний өдөр 23/562 тоот “Зээлийн төлбөр хүлээн авах дансны барьцааны гэрээ” (Хавсралт 4.5) байгуулагдсан байна. Тус гэрээ нь нийт 13 бүлгээс бүрдсэн бөгөөд тус гэрээний дагуу Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь үйлчилгээ үзүүлэгчийн нэр дээр банканд нээлгэсэн зээлийн эргэн төлөлтийн мөнгөн хөрөнгийг цуглуулах данс дахь Үнэт цаас гаргагчийн өмчлөлийн мөнгөн хөрөнгийг барьцаалах, түүний захиран зарцуулалтыг хязгаарлахтай холбоотой харилцааг зохицуулж байна. Энэхүү гэрээ нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.

*Үнэт цаас гаргахтай холбоотойгоор байгуулсан гэрээнүүд:*

**Аудитын ажлыг гүйцэтгэх гэрээ.** Үнэт цаас гаргагчийн 2023 оны санхүүгийн тайланд аудитын шалгалт хийж, дүгнэлт гаргах ажлыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд (СТОУС) болон Аудитын тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актыг удирдлага болгон гүйцэтгүүлэх зорилгоор “Ниямазон аудит” ХХК-тай 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдөр 22/6949886 тоот “Аудитын ажлыг гүйцэтгэх гэрээ” (Хавсралт 4.6)-ээр зохицуулсан байна. Уг гэрээ нь нийтлэг үндэслэл, гэрээний үнэ, төлбөрийн нөхцөл, гэрээний хугацаа, үйлчлүүлэгчийн эрх, үүрэг, гүйцэтгэгчийн эрх, үүрэг, хүлээх хариуцлага, давагдашгүй хүчин зүйл, гэрээ дуусгавар болох, цуцлах, бусад гэсэн 9 бүлгээс бүрдэх зохицуулалттай байна. Гэрээний агуулгаас харвал, Аудитын тухай хуульд заасан гэрээнд тусгавал зохих мэдээллийг тусгасан, гэрээ нь хуулийн хүчин төгөлдөр гэрээ байна. “Ниямазон аудит” ХХК нь Сангийн сайдын 2015 оны 01 сарын 14-ний өдрийн 02 тоот тушаалын дагуу аудитын үйл ажиллагаа эрхлэх 02-2015 тоот тусгай зөвшөөрөл (Хавсралт 4.7, Хавсралт 4.8)-тэй байх тул аудитын үйлчилгээ үзүүлэх этгээдээр бүртгүүлсэн, энэхүү гэрээг байгуулах эрхтэй болно.

**Програм хангамж түрээсээр ашиглах гэрээ.** СЗХ-ны “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам”-ын 2.1.5, 11.2-т заасны дагуу ТЗК нь хөрөнгөтэй холбоотой мэдээллийг хадгалах нэгдсэн системтэй байх шаардлага тавигдсан. Үүнтэй холбоотойгоор “Бэрс Эй Би Эс Плас ТЗК” ХХК болон “Грэйпсити Монгол” ХХК нарын хооронд 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдөр ЛА-23/13 тоот “Програм хангамж түрээсээр ашиглах гэрээ” (Хавсралт 4.9) байгуулсан байна. Уг гэрээгээр “Грэйпсити Монгол” ХХК нь Захиалагчийн захиалгын дагуу поларис системийг хөгжүүлж захиалагчид түрээсээр ашиглуулах, түүнтэй холбоотой нэвтрүүлэлтийн ажил, дагалдах засвар үйлчилгээг хүргэхтэй холбогдсон харилцааг зохицуулсан байна.

**Түрээсийн гэрээ.** Үнэт цаас гаргагч нь Сүхбаатар дүүрэг, 11-р хороо, 7-р хороолол, Ногоон нуур 101 барилга, 706 тоот хаягт байрлах нийт 74.59 м.кв бүхий оффисын зориулалттай талбайг сар бүр түрээслэхээр “Бичил Глобус” ХХК-тай 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр Түрээсийн




гэрээ (Хавсралт 4.10) байгуулжээ. Түрээсийн гэрээг 5 жилийн хугацаатайгаар байгуулсан ба тус гэрээ нь Иргэний хуульд нийцэж байна.

**Хэлцлийн зөвлөхийн гэрээ.** Үнэт цаас гаргагчийн тусгай зориулалттай компани үүсгэн байгуулах, хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргах, хөрөнгө оруулалт татан төвлөрүүлэхэд зөвлөх үйлчилгээ авахаар “Бэрс Финанс ББСБ” ХХК нь “Юнайтед Айр Файнэнс” ХХК-тай 2022 оны 11-р сарын 08-ны өдөр ЗҮ/22-10 тоот “Хэлцлийн зөвлөхийн гэрээ” (Хавсралт 4.11)-г байгуулжээ. Гэрээ нь 15 бүлэг бүхий нийтлэг үндэслэл, гэрээний хугацаа, гэрээгээр гүйцэтгэх ажил, ажлын хөлс, талуудын эрх, үүрэг, хариуцлага, давагдашгүй хүчин зүйл, гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах нөхцөл, гэрээ цуцлах үндэслэл, нөхцөлийг тодорхойлох, талуудыг төлөөлөх эрхийг баталгаажуулах, талууд баталгаа гаргах, гэрээний зарим хэсэг хүчингүй болгох зэрэг зохицуулалттай байна. Тус гэрээ нь холбогдох хууль тогтоомжийн зөрчилгүй байна.

**Андеррайтерийн, аудитын, хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээ.** Энэхүү гэрээний талаар Дүгнэлтийн 5 дугаар бүлгээс танилцана уу.

Баталгаат үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч этгээдтэй байгуулсан гэрээ, Компанийн үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой бусад гэрээ, хэлцэл нь хууль тогтоомжид нийцсэн, үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагавар үүсгээгүй байна.





**Бүтэцтэй үнэт цаас гаргагч нь хөрөнгө итгэмжлэн удирдагч, үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч бусад этгээдүүдтэй ашиг сонирхлын зөрчилтэй эсэх**

***Оролцогч байгууллагууд:***

Үнэт цаас гаргагчийн үнэт цаас гаргах ажиллагаанд Үйлчилгээ үзүүлэгч болон Захиргааны ажил гүйцэтгэгчээр “Бэрс Финанс ББСБ” ХХК, Хөндлөнгийн хуулийн шинжээч, хуулийн зөвлөхөөр “Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс” ХХН, Санхүүгийн шинжээчээр “Онч Аудит” ХХК, Андеррайтераар “Голомт Капитал ҮЦК” ХХК, Хэлцлийн зөвлөх болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчаар “Юнайтед Айр Файнэнс” ХХК, Хөндлөнгийн аудиторроор “Ниямазон аудит” ХХК нар тус тус ажиллаж байгаа болно (Хавсралт 5.1).

***Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ.*** Гэрээний дэлгэрэнгүй тайлбартай Дүгнэлтийн 3 дах хэсгээс танилцана уу (Хавсралт 4.4). Хөрөнгө итгэмжлэн удирдагч “Юнайтед Айр Файнэнс” ХХК нь Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 10 сарын 28-ны өдрийн 473 дугаар тогтоолын дагуу ТЗ 316/18 тоот үнэт цаасны зах зээлд хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл (Хавсралт 5.2, 5.3)-тэй тул тус гэрээг байгуулах эрх бүхий этгээд болно.

***Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээ.*** Үнэт цаас гаргагчийн ХБҮЦ гаргах, Монголын Хөрөнгийн Биржээр нийтэд санал болгох үнэт цаасны танилцуулгад тусгагдсан хууль зүйн мэдээлэл нь үнэн зөв эсэх, сонгогдсон зээлийн дансдууд хуулийн шалгуур үзүүлэлт хангасан эсэх талаар хууль зүйн дүгнэлт гаргуулахаар “Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс” ХХН-тэй Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээ (Хавсралт 1.2)-г 2022 оны 11-р сарын 08-ны өдөр байгуулсан байна. Гэрээ нь нийтлэг үндэслэл, гэрээт ажил, гэрээний хугацаа, хуулийн зөвлөхийн эрх, үүрэг, үйлчлүүлэгчийн эрх, үүрэг, харилцах хүмүүс, хариуцлагын хязгаарлалт, гэрээг дуусгавар болгох, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл, бусад зүйл гэсэн 11 бүлгээс бүрдэх зохицуулалттай байна. Дүгнэлтийн 1 дүгээр бүлэгт зааснаар “Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс” ХХН нь үнэт цаасны зохицуулалттай этгээдэд хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрх бүхий этгээд болно (Хавсралт 1.1).

***Хамтран ажиллах гэрээ.*** Үнэт цаас гаргагчийн үнэт цаас гаргах, олон нийтэд санал болгох үнэт цаасны танилцуулгад тусгагдсан санхүүгийн мэдээлэл нь үнэн зөв эсэх, сонгогдсон зээлийн дансдууд санхүүгийн шалгуур үзүүлэлт хангасан эсэх талаарх дүгнэлт гаргуулахаар “Онч аудит” ХХК-тай Хамтран ажиллах гэрээ (Хавсралт 5.4)-г 2022 оны 11-р сарын 07-ны өдөр байгуулсан байна. Энэхүү гэрээгээр ажлын хамрах хүрээ, зээлийн шалгуур, хязгаарлалт, ажлын баг, цаг хугацаа болон үйлчилгээний хөлс, бизнес үйл ажиллагааны ерөнхий нөхцөл буюу талуудын хүлээх хариуцлага, үйлчилгээний төлбөр зэрэг бусад харилцааг зохицуулсан байна. Гэрээ нь Аудитын тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 33.2.3, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 40.1, СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журмын холбогдох шаардлагыг хангасан байна. “Онч Аудит” ХХК нь үнэт цаасны зохицуулалттай этгээдэд аудитын үйлчилгээ үзүүлэх эрх олгогдсон этгээд байна (Хавсралт 5.5, 5.6).

***Андеррайтерийн үйлчилгээний гэрээ.*** Үнэт цаас гаргагчийн нийтэд нээлттэй үнэт цаас санал болгох хүрээнд 9 тэрбум хүртэлх төгрөгийн үнийн дүн бүхий ХБҮЦ гаргах ажлыг зохион

байгуулах, мэргэжлийн андеррайтераар ажиллуулахаар “Голомт Капитал ҮЦК” ХХК-тай 23/558 тоот “Андеррайтерийн үйлчилгээний гэрээ” (Хавсралт 5.7)-г 2023 оны 02-р сарын 09-ний өдөр байгуулсан байна. Гэрээ нь нийтлэг үндэслэл, нэр томъёоны тайлбар, гэрээний хугацаа, үйлчилгээний төлбөр, талуудын эрх, үүрэг, нууц хадгалах, хариуцлага, гэрээ дуусгавар болгох, бусад гэсэн 10 бүлэг бүхий зохицуулалттай байна. Энэхүү гэрээгээр андеррайтер нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 41.4.1-т заасан үнэт цаасны танилцуулга бэлтгэх, 41.4.3-т заасан хөрөнгө оруулагчид тухайн үнэт цаасыг танилцуулах замаар түүнийг худалдахад шаардлагатай бүх хүчин чармайлт гаргах хэлбэрээр үйлчилгээ үзүүлэхээр тохиролцсон байна. Гэрээ нь Иргэний хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцсэн байна. “Голомт Капитал ҮЦК” ХХК нь Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 11-р сарын 02-ны өдрийн ТЗ 301/97 тоот үнэт цаасны зах зээлд андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл (Хавсралт 5.8, 5.9)-тэй тул тус гэрээг байгуулах эрх бүхий этгээд болно.

**Захиргааны үйлчилгээ үзүүлэх гэрээ.** Компанийн ХЭХ, ТУЗ-ийн хурлын бэлтгэлийг хангах, албан бичиг хэргийн ажил гүйцэтгэх, Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай хамтран нягтлан бодох бүртгэл хөтлөх, ТЗК-ийн мөнгөн хөрөнгөөс шаардлагатай мөнгөн гүйлгээг ХИУ-ийн хяналт доор хамтран гүйцэтгэх, хүүгийн орлогын албан татвар төлөх, компанийн цахим хуудас хөтлөх зэрэг Үнэт цаас гаргагчийн өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулахтай холбоотойгоор 23/564 тоот “Захиргааны үйлчилгээ үзүүлэх гэрээ” (Хавсралт 5.10)-г Үнэт цаас гаргагч нь “Бэрс Финанс ББСБ” ХХК-тай 2023 оны 02-р сарын 09-ний өдөр байгуулсан байна. Гэрээ нь нийтлэг үндэслэл, үзүүлэх үйлчилгээ, үйлчилгээний хөлс, баталгаа, мэдэгдэл, гэрээ дуусгавар болох, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл, нууц мэдээлэл, маргаан шийдвэрлэх, бусад зүйл гэсэн 9 бүлэг бүхий зохицуулалттай байна. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.12.5-д зааснаар Тусгай зориулалтын компани нь хөдөлмөрийн гэрээ болон бусад гэрээний үндсэн дээр ажилтан авч ажиллуулахыг хориглодог тул компанийн захиргааны шинжтэй ажлуудыг бие даасан хуулийн этгээдээр гүйцэтгүүлэхээр тохиролцсон энэхүү гэрээ нь хуулийн хүчин төгөлдөр байна.

**Сонирхлын зөрчилтэй хэлцэл батлах тухай.** ТУЗ-ийн 2023 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 23/24а/03 тоот “Сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцэл батлах тухай” тогтоол (Хавсралт 5.11)-оор “Бэрс Финанс ББСБ” ХХК-тай дараах гэрээг байгуулахыг зөвшөөрсөн байна.

- Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ (Хавсралт 5.1)
- Төлбөр цуглуулах, үйлчилгээ үзүүлэх гэрээ (Хавсралт 5.2)
- Фидуцийн барьцааны гэрээ (Хавсралт 4.3)
- Зээлийн эргэн төлөлтийн дансны барьцааны гэрээ (Хавсралт 43.5)
- Захиргааны үйлчилгээ үзүүлэх гэрээ (Хавсралт 5.10)
- Андеррайтерийн үйлчилгээний гэрээ (Хавсралт 5.7)

Энэхүү тогтоолыг Компанийн тухай хуулийн 12 дугаар бүлэгт нийцүүлэн гаргасан байна (Хавсралт 5.12).

МОНГОЛЫН ХӨРӨНГӨ  
МОНГОЛЫН МЭТЭРЖЭЭГЧИЙН ХЕВЧИЛГЭЭ  
2023-04-06



MDSKhanLex

СЭХ  
ОН СЭР  
өдөр  
БҮЛЭГ  
№ 01

Үнэт цаас гаргагч нь энэхүү үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч андеррайтер, хөрөнгө  
итгэмжлэн удирдагч, хөндлөнгийн хуулийн шинжээч, санхүүгийн шинжээч байгууллагуудтай  
аливаа сонирхлын зөрчилгүй талаарх мэдээллийг бидэнд ирүүлсэн (Хавсралт 5.13).



**БЭГ Хөрөнгийн багц дахь хөрөнгийн төрөл бүрээс хамааруулан санамсаргүй түүврийн аргаар сонгох замаар үнэт цаас гаргах цаас тогтоосон хууль зүйн шалгуур үзүүлэлт хангаж буй эсэх**

Бид Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон Үнэт цаас гаргагчийн хүсэлтийн дагуу санамсаргүй түүврийн аргаар сонгосон 31 зээлийн дансад Үнэт цаас гаргагчийн тогтоосон 6 шалгуур үзүүлэлтээр 2022 оны 11 дүгээр сарын 24-ний өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн хооронд хууль зүйн дүн шинжилгээ гүйцэтгэж, 2023 оны 02-р сарын 05-ны өдрийн Автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас (ХБҮЦ) олон нийтэд нээлттэй санал болгох хүрээнд сонгогдсон зээлийн дансдын хуулийн шалгуур үзүүлэлтэд нийцсэн эсэх талаарх хуулийн хөндлөнгийн дүн шинжилгээний тайлан (Хавсралт 6.1)-г гаргасан.

Тус тайлангаар санамсаргүй түүврийн аргаар сонгосон 31 зээлийн дансдууд нь Үнэт цаас гаргагчийн тогтоосон дараах шалгуурыг хангасан болохыг тэмдэглэж байна. Үүнд:

1. Зээлийн хөрөнгө нь хууль зүйн хувьд Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн бүрэн өмчлөлд байх бөгөөд Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс бусад этгээдийн хувьд аливаа байдлаар үүргээс ангид байх;
2. Зээлийн гэрээ нь зээлдэгч (Үүрэг гүйцэтгэгч)-ийн хувьд хуульд нийцсэн, хүчин төгөлдөр, заавал биелэгдэх үүрэг үүсгэх бөгөөд шаардлагатай тохиолдолд уг зээлийг барьцаа (фидуцийн) хөрөнгөөс гаргуулан төлүүлэх боломжтой байх;
3. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид байгаа мэдээллээр, тасалбар болгох өдрийн байдлаар зээлийн гэрээ нь Үүрэг гүйцэтгэгчийн хувьд үүргээ хугацаанаас өмнө дуусгавар болгох/урьдчилан төлөх нөхцөл, хэлцлээс татгалзах, харилцан суутгал хийх замаар үүргийг дуусгавар болгох, сөрөг нэхэмжлэл гаргах, эсхүл үүргээс татгалзах (илт хохиролтой хэлцлийн улмаас үүргээс татгалзах нөхцөлийг хамааруулан) эрх үүсээгүй, эсхүл эрхээ хэрэгжүүлэх хүсэл зориг илэрхийлээгүй байх;
4. Зээл нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн хувьд хууль, гэрээ, эсхүл бусад байдлаар аливаа үүргээс ангид, фидуцийн гэрээний зүйлийн хамтаар гуравдагч этгээдэд шилжихэд хориглогдоогүй, эсхүл хязгаарлаагүй байх;
5. Зээлтэй холбоотойгоор Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон зээлдэгчийн хооронд байгуулсан фидуцийн гэрээ нь зээлдэгч (Үүрэг гүйцэтгэгч)-ийн хувьд хуульд нийцсэн, хүчин төгөлдөр, заавал биелэгдэх үүрэг үүсгэсэн зээлдэгч үүргээ биелүүлээгүй тохиолдолд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч өмчлөгчийн эрхээ хэрэгжүүлж, худалдан борлуулж зээл, үүнтэй холбоотой бүх төлбөрийг гаргуулах боломжтой байх;
6. Фидуцийн гэрээ хүчин төгөлдөр болгоход Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн ердийн практикт мөрддөг бүх дүрэм журмыг дагаж мөрдсөн, тухайн үүргийн гүйцэтгэлийг хангуулах аргыг нотолж буй бүх баримт бичиг нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн зэмшил, хадгалалт хамгаалалтад байх.

Дэлгэрэнгүй мэдээллийг тус тайлан (Хавсралт 6.1)-аас үзнэ үү.

2023-04-06

**БҮГД** Багцын хөрөнгөөс үүргийн гүйцэтгэлийг хангуулахтай холбогдох гэрээ, хэлцэл нь хууль тогтоомжид нийцсэн эсэх, гэрээ, хэлцэлд үүргийн гүйцэтгэлийн зүйлтэй холбоотой аливаа шаардах эрхийг шилжүүлэхгүй болон хэрэгжүүлэхгүй байхыг үүрэг болгосон, эсхүл шилжүүлэхийг хориглосон, хязгаарласан нөхцөл тусгасан эсэх


Хууль зүйн дүн шинжилгээний тайлан (Хавсралт 6.1)-аар багцын хөрөнгөөс үүргийн гүйцэтгэлийг хангуулахтай холбогдох зээлийн болон фидуцийн гэрээ нь хууль тогтоомжид нийцсэн бөгөөд тус гэрээ, хэлцэлд үүргийн гүйцэтгэлийн зүйл (фидуци)-тэй холбоотой шаардах эрхийг шилжүүлэхгүй болон хэрэгжүүлэхгүй байхыг үүрэг болгосон, эсхүл шилжүүлэхийг хориглосон, хязгаарласан нөхцөл тусгагдаагүй болно. Дэлгэрэнгүй мэдээллийг Хууль зүйн дүгнэлтийн Хавсралт 6.1-ээс үзнэ үү.

8. Үнэт цаасны танилцуулга, түүнд тусгагдсан мэдээлэл нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, бусад холбогдох хууль журамд нийцэж буй эсэх, үнэн зөв, хүчин төгөлдөр эсэх


МДСХ нь Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан хууль зүйн ач холбогдол бүхий дараах мэдээлэл Үнэт цаас гаргагч, төрийн болон бусад эрх бүхий байгууллагаас гаргуулсан баримттай нийцэж байх тул үнэн зөв тусгагдсан байна гэж үзлээ. Үүнд:

- Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргах шийдвэр, нөхцөл;
- Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны эргэн төлөлт, хүү, хүүг тооцох аргачлал, төлбөрийн хуваарь, үнэт цаас гаргагч гаргасан үнэт цаасаа буцаан худалдаж авах эрхтэй эсэх тухай;
- Хөрөнгийн багц дахь зээлийн дансдын тоо;
- Үнэт цаас гаргагчийн оноосон нэр, оршин байгаа газрын шуудангийн болон холбоо барих хаяг, эрхэлж байгаа үйл ажиллагаа;
- Үнэт цаас гаргагч хуулийн этгээдийн улсын бүртгэлийн болон регистрийн дугаар, бүртгэсэн огноо;
- Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, түүнд хувьцаа эзэмшигч нарын эзлэх хувь, зарласан болон гаргасан үнэт цаасны тоо, төрөл, нэрлэсэн үнэ болон өөрийн хөрөнгийн хэмжээ;
- Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөл, ТУЗ-ийн гишүүний талаарх мэдээлэл, тэдгээрийн боловсрол, ажлын туршлагын талаарх мэдээлэл;
- Зөвшөөрөгдсөн данснуудын мэдээлэл, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны буцаан дуудах нөхцөл;
- Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагч, анхны үүрэг гүйцэтгүүлэгч, үйлчилгээ үзүүлэгч, зээлийн шинжилгээ гаргагч, хууль зүйн дүгнэлт гаргагч, хөндлөнгийн аудитор, хөрөнгө итгэмжлэн удирдагч, андеррайтерийн улсын бүртгэлийн болон регистрийн дугаар, бүртгэсэн огноо, хаяг, холбоо барих мэдээлэл болон тэдгээртэй байгуулсан гэрээгээр хүлээсэн эрх, үүрэг, хариуцлагын талаарх мэдээлэл;
- Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн үйл ажиллагааны чиглэл, түүний хувьцаа эзэмшигчийн мэдээлэл;
- 2023 оны 02-р сарын 07-ны өдрийн байдлаар үүсгэн байгуулагч, анхны үүрэг гүйцэтгүүлэгч, үнэт цаас гаргагчийн хугацаа хэтэрсэн буюу чанаргүй зээлийн талаарх мэдээлэл;
- Төлбөрийн чадваргүй байдалд орсон хөрөнгийг цуглуулах, худалдан борлуулах, хөрөнгийг итгэмжлэн удирдагчийн гүйцэтгэлийг хянах, түүнийг солих зохицуулалт;
- ТЗК-ийн ТУЗ-ийн эрх, үүргийн талаар хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах тухай;
- Баталгаат үнэт цаасны төлбөр хугацаандаа төлөгдөхгүй нөхцөлд авах арга хэмжээ;
- ТЗК-ийн журмууд;
- Хөрөнгийн багцад хөрөнгө нэмж оруулах, хасах, солих нөхцөл, түүний зохицуулалт;
- Хөрөнгийн багцад тавигдах хуулийн болон санхүүгийн шалгуур үзүүлэлт;
- Үнэт цаасны арилжаа зохион байгуулах үндсэн мэдээлэл;
- Үнэт цаас эзэмшигчийн эрх, үүрэг;





MDS KhanLex ГЭВ



- ТЗК-ийг татан буулгах нөхцөл, журам;
- БҮРГЭ** Хөрөнгө оруулагчдад танилцуулах мэдээллүүд, тэдгээрийг тайлагнах хугацаа.

Дээр дурдсан хууль зүйн ач холбогдолтой мэдээллээс бусад Үнэт цаас гаргагч, түүний үүсгэн байгуулагч, анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн санхүүгийн үзүүлэлт, борлуулалтын хэмжээ, ашиг, алдагдал зэрэг бизнесийн үйл ажиллагаа, хөрөнгийн багц дахь нийт зээлийн дансдын тооноос бусад мэдээлэл, Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны үндсэн чиглэлд хамаарах зах зээлд эзэлж буй байр суурь, өрсөлдөгч байгууллагуудын тухай мэдээлэл, хөрөнгө оруулалтын орчин, Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны тухай болон Үнэт цаас гаргагчийн зах зээлийн төлөвлөгөө зэрэг агуулагдсан эдийн засгийн ерөнхий мэдээлэл, салбарын үзүүлэлт, Үнэт цаас гаргагчийн талаар олон нийтэд ил, тодорхой үйл баримт, үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд тусгагдсан баталгаажуулах боломжгүй тоон үзүүлэлт болон хараат бус байгууллагуудын хийсэн дүн шинжилгээ, санхүүгийн тооцоолол, үнэлгээ, Үнэт цаас гаргаж хуримтлуулсан хөрөнгийг зарцуулах бизнесийн төлөвлөгөө, дунд хугацааны бизнес төлөвлөгөөний тойм, Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд учирч болох эрсдэл, эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө, ХБҮЦ-ийг нээлттэй хүрээнд санал болгох ажиллагаанд хамтран оролцож байгаа зохицуулалттай этгээд болон бусад мэргэжлийн үйлчилгээ үзүүлж (МДСХ-ээс бусад) байгаа этгээдийн туршлага, удирдлага, бүтэц зохион байгуулалт, эрх бүхий албан тушаалтны боловсрол, ажлын туршлага зэрэг энэхүү Дүгнэлтийн 8 дугаар бүлэгт заасан мэдээллээс бусад үнэт цаасны танилцуулгад тусгагдсан мэдээлэл буюу андеррайтерийн цуглуулсан мэдээлэл, дүн шинжилгээ, судалгаа, таамаглалд МДСХ нь дүн шинжилгээ хийгээгүй, үнэн зөв болохыг тогтоогоогүй болно.

**Компанийн төлөөлөн удирдах зөвлөл**

Компанийн ТУЗ-ийг Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 22/24a/02 дугаартай шийдвэр (Хавсралт 9.1)-ээр дараах бүрэлдэхүүнтэйгээр сонгож, ТУЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хурлын 22/24a/03 дугаартай тогтоол (Хавсралт 9.2)-оор ТУЗ-ийн даргаар Б.Болор-Эрдэнийг сонгож, ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар Г.Юмсүрэнг томилсон байна. Дүгнэлт гаргах өдрийн байдлаар ТУЗ нь дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

№	Нэр	Боловсрол	Ажлын туршлага
Ердийн гишүүд:			
1.	Самдангийн Отгонбат (Хавсралт 9.3)	2006-2010 онд Алтай коллежийн Компьютерийн техникийн инженер чиглэлээр бакалавр;  2011-2013 онд Монгол Улсын Их Сургуулийн Олон улсын эдийн засгийн харилцаа чиглэлээр магистр.	2006-2007 онд “Оргил хотхон” ХХК-д Гүйцэтгэх захирал;  2008-2009 онд “Номин холдинг” ХХК-д Ахлах менежер;  2013 оноос одоог хүртэл, “Бичил Глобус Финанс ББСБ” ХХК-д Гүйцэтгэх захирал;  2017 оноос одоог хүртэл, “Бэрс финанс ББСБ” ХХК-д Гүйцэтгэх захирал.  “Бичил Глобус Финанс ББСБ” ХХК, “Бэрс Эй Би Эс Актив ТЗК” ХХК-ийн ТУЗ-ийн гишүүн, “Бичил Эй Би Эс Актив ТЗК” ХХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр тус тус ажиллаж байна.
Хараат бус гишүүд:			

2. Б	Дамбын Ганхүрэл (Хавсралт 9.4)	2012-2017 онд Монгол Улсын Их Сургуулийн Хууль Зүйн Сургуульд Эрх зүйн бакалавр;  2018-2020 онд Япон улсын Чүо Их Сургуульд Эрх зүйн магистр;  2021 оноос одоог хүртэл Япон улсын Нагояа Их Сургуульд Эрх зүйн докторант.	2016-2017 онд “MBS” хуулийн фирмд Өмгөөлөгчийн туслах;  2018-2020 онд “Накано Нозава” хуулийн фирмд Хуульчийн туслах;  2020 оноос одоог хүртэл “Монгол Улсын Их Сургууль”-д Багш;  2022 оноос одоог хүртэл “Корэкс” ХХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн.
3.	Баатарын Болор-Эрдэнэ* (Хавсралт 9.5)	2008-2012 онд Монгол Улсын Их Сургуулийг Олон улсын эдийн засгийн харилцаа чиглэлээр магистр;  2021 оноос Монгол Улсын Их Сургуульд Олон улсын эдийн засгийн харилцаа чиглэлээр докторант.	2006-2008 онд “НҮБ-ийн ХАС”-ийн ЗЗХ-ын гишүүн;  2008-2016 онд Голомт банкинд Харилцагчийн үйлчилгээний хэлтсийн захирал;  2016-2020 Баянгол дүүргийн Иргэдийн хурлын төлөөлөгч;  2020 оноос одоог хүртэл “Мета Майнд” ХХК-д Гадаад харилцаа хариуцсан захирал;  2022 оноос одоог хүртэл “Бэрс Эй Би Эс Актив ТЗК” ХХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн.

\*ТУЗ-ийн дарга

Компанийн ТУЗ-ийн дарга, гишүүд нь Компанийн тухай хуульд заасан эрх бүхий албан тушаалтны шаардлагыг хангаж байгаа эсэхийг дараах хүснэгтээр харуулав:

КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАНД ТАВИГДАХ ШААРДЛАГА					
№	Нэрс/Шаардлага	Төрийн болон орон нутгийн захиргааны байгууллага, цэрэг, цагдаа, прокурорын	Ял шийтгэл эдэлж байгаа эсэх (КтХ-	Компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан	Хувь хүн байх (КтХ-ийн 77.3, 83.2, 83.3)



	байгууллагад удирдах албан тушаал хашдаг эсэх	ийн 84.3.2)*	эсэх (КтХ-ийн 75.8)		
1.	<b>Б.Болор-Эрдэнэ</b> (ТУЗ-ийн дарга ТУЗ-ийн хараат бус гишүүн)	Үгүй	Үгүй*	Тийм /2022.04.22-ны өдөр, Дугаар 0521278/ <b>(Хавсралт 9.6)</b>	Тийм
2.	<b>С.Отгонбат</b> (ТУЗ-ийн ердийн гишүүн)	Үгүй	Үгүй*	Тийм /2016.09.09-ний өдөр, Дугаар 0730735/ <b>(Хавсралт 9.7)</b>	Тийм
3.	<b>Д.Ганхүрэл</b> (ТУЗ-ийн хараат бус гишүүн)	Үгүй	Үгүй*	Тийм /2021.02.22-ны өдөр, Дугаар 0430793/ <b>(Хавсралт 9.8)</b>	Тийм

\*Монгол Улсын Хууль зүйн сайдын 2017 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн А/195 тоот тушаалын 6 дугаар зүйлд заасны дагуу Ял шийтгэлтэй эсэх лавлагааг өмгөөллийн нөхөрлөлд олгодоггүй тул Компанийн тухай хуулийн 84.3.2-т заасан шийтгэл эдлээгүй байх шаардлагыг ТУЗ-ийн гишүүд хангаж байгаа эсэхийг СЗХ-ны “Банкнаас бусад санхүүгийн болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх тохиромжтой этгээдийг тодорхойлох журам”-ын дагуу бөглөсөн асуулгын хуудас болон ТУЗ-ийн гишүүний мэдүүлэг, баталгааг үндэслэж дүгнэв.

Компанийн ТУЗ-ийн гишүүд нь Компанийн тухай хууль болон Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасан ТУЗ-ийн гишүүнд тавих нэмэлт шаардлагыг хангаж байгаа эсэхийг дараах хүснэгтээр харуулав:


ТУЗ-ийн гишүүнд тавигдах нэмэлт шаардлага			
№	Шаардлага	ТУЗ-ийн хараат бус гишүүд	
		Д.Ганхүрэл (Хавсралт 9.4)	Б.Болор-Эрдэнэ (Хавсралт 9.5)
1.	Өөрөө эсхүл компанийн нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн энгийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшдэггүй байх (КтХ-ийн 79.1.1)	Тийм**	Тийм**
2.	Төрийн үйлчилгээнийхээс бусад төрийн алба хашдаггүй байх (КтХ-ийн 79.1.3)	Тийм**	Тийм**

3.	Компанитай бизнесийн гэрээ хэлцэл байгуулаагүй байх, тийм холбоогүй байх (КтХ-ийн 79.1.4)	Тийм**	Тийм**
4.	Анхны үүрэг гүйцэтгүүлэгч, үүсгэн байгуулагч, худалдагч, тэдгээрийн хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан болон тэдгээрийн гэр бүлийн гишүүн биш (ХБҮЦТХ-ийн 12.8)	Тийм**	Үгүй** (Хорооны журмын 3.3-г зааснаар ТЗК-ийн ТУЗ-ийн гишүүн нь гурваас дээшгүй ТЗК-ийн ТУЗ-ийн гишүүний албан тушаалыг хавсран эрхэлж болно)
5.	Бүрэн эрхээ хэрэгжүүлэх үед хувийн ашиг сонирхол нийтийн ашиг сонирхолтой зөрчилдөх болон албан үүргээ тэгш, шударгаар хэрэгжүүлэхэд харшаар нөлөөлж болохуйц нөхцөл байдал бий болоогүй.	Тийм**	Тийм**
6.	Төрийн үйлчилгээнийхээс бусад төрийн алба хашдаггүй (КтХ-ийн 79.1.3)	Тийм**	Тийм**
7.	Төрийн болон нутгийн захиргааны байгууллага, цэрэг, цагдаа, шүүх, прокурорын байгууллагад удирдах албан тушаал хашдаггүй (КтХ-ийн 84.3.1)	Тийм**	Тийм**
8.	Компанийн засаглалын чиглэлээр сургалтанд хамрагдаж гэрчилгээ авсан (КтХ-ийн 75.8)	Тийм**	Тийм**
9.	Ял шийтгэл эдлээгүй (КтХ-ийн 84.3.2)	Тийм**	Тийм**
10.	Мэргэжил, боловсрол, ажлын туршлагын хувьд “Бэрс Эй Би Эс Плас ТЗК” ХХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр ажиллахад шаардагдах туршлагатай (СЗХ-ны ХБҮЦ гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журмын 3.13)	Тийм**	Тийм**
11.	Тохиромжтой этгээд байх (МХБ-ийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 6.4, СЗХ-ны ХБҮЦ гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журмын 2.1.3)	Тийм** (Хавсралт 2.1)	Тийм** (Хавсралт 2.1)


\*\*Компанийн тухай хууль, Хөрөнгөөр баталгааж үнэт цаасны тухай хууль, СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам, МХБ-ийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмуудад заасан ТУЗ-ийн гишүүнд тавигдах шаардлагыг тус компанийн ТУЗ-ийн гишүүд хангаж байгаа эсэхийг тэдний гаргаж өгсөн мэдүүлэг, баталгааг үндэслэж дүгнэв.

Компанийн ТУЗ-ийн гишүүд нь холбогдох хууль, журмуудад заасан ТУЗ-ийн гишүүний шаардлагыг хангаж байгаа бөгөөд тэдгээр нь Компанийг удирдах чадвар, дадлага туршлагатай гэж дүгнэв.

**Бусад нэмэлт судалгаа:**




MDSKhanLex




Бид Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, СЗХ-ны “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам” болон МХБ-ийн “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам”-ын зохицуулалтаас гадна хөрөнгө оруулагчид шийдвэр гаргахад ач холбогдолтой гэж үзэн хөндлөнгийн мэдээлэл цуглуулж, тус Компанитай холбоотой дараах нөхцөл байдлуудыг тогтоосон болно. Үүнд:

- Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын дэргэдэх Монголын олон улсын арбитрын 2022 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 4/1742 тоот тодорхойлолт (Хавсралт 9.9)-д тусгаснаар “Бэрс Финанс ББСБ” ХХК нь тус арбитраар хянан шийдвэрлэгдсэн болон арбитрын ажиллагаа явагдаж байгаа хэрэгт нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдээр оролцоогүй байна;
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Шийдвэр гүйцэтгэх албанаас 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр гаргасан Тодорхойлолт (Хавсралт 9.10)-д “Бэрс Финанс ББСБ” ХХК нь шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд өр төлбөргүй байна;
- Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн тусгай архиваас 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр гаргасан 1/3286, 1/3287 тоот тодорхойлолт (Хавсралт 9.11)-д тусгаснаас үзвэл “Бэрс Финанс ББСБ” ХХК нь сүүлийн 3 жилийн байдлаар Чингэлтэй болон Хан-Уул дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн иргэний хэрэгт хариуцагчаар оролцож байсан. Маргааныг тодруулбал:
  - Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 02-р сарын 12-ны өдрийн 183/ШШ2020/00415 дугаар шийдвэртэй 3.Оюунсүрэнгийн ажилд эгүүлэн тогтоолгож, ажилгүй байсан хугацааны цалин олговор, урамшуулал, ээлжийн амралтын мөнгөд 5,037,266 төгрөг гаргуулах тухай нэхэмжлэлтэй иргэний хэрэгт зохигчид эвлэрлийн журмаар хэргийг хянан шийдвэрлэсэн байна.
- Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны Шүүхийн тамгын газраас 2022 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр гаргасан 2859 тоот тодорхойлолт (Хавсралт 9.12)-д тусгаснаар “Бэрс Финанс ББСБ” ХХК нь Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нэхэмжлэгч болон гуравдагч этгээдээр сүүлийн 3 жилд оролцож байгаагүй байна;
- Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газраас 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр гаргасан 01/1952 тоот албан бичиг (Хавсралт 9.13)-т тусгаснаар “Бэрс Финанс ББСБ” ХХК нь тодорхойлолт өгсөн өдрийн байдлаар Өрсөлдөөний тухай хууль тогтоомжийг зөрчсөн үндэслэлээр захиргааны шийтгэл хүлээж байгаагүй бөгөөд Өрсөлдөөний тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д заасны дагуу давамгай байдалтай аж ахуйн нэгжээр тогтоогдоогүй байна;
- “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ТӨХК-аас 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр ирүүлсэн 01/1633 тоот албан бичиг (Хавсралт 9.14)-т тусгаснаар “Бэрс Финанс ББСБ” ХХК нь тус өдрийн байдлаар Биржийн бус зах зээлд хаалттай хүрээнд Бэрс Бонд 1-12М-15%, Бэрс Бонд2-12М-15% гэсэн 2 төрлийн өрийн хэрэгсэл тус тус гаргасан, нээлттэй хүрээнд Бэрс ХБҮЦ гаргасан (өөрийн 100 хувийн "Бэрс Эй Би Эс ТЗК" ХХК байгуулах замаар - Зөвлөх), үндсэн болон хүүгийн төлбөрөө хугацаандаа төлсөн ба гэрээний үүргийн хэрэгжилтийн зөрчилгүй, өр төлбөрийн тооцоогүй байна.






MDSKhanLex



- Монголын татварын албанаас 2023 оны 02 дугаар сарын 07-ны өдөр ирүүлсэн Аж ахуйн нэгж байгууллагын тодорхойлолт (Хавсралт 9.15)-д тусгаснаар “Бэрс Финанс ББСБ” ХХК нь 164,089,890.38 төгрөгийн дутуу төлөлтэй, 26,261,465.00 төгрөгийн илүү төлөлтэйгээр бүртгэгдсэн байна;
- Монголын татварын албанаас 2023 оны 02 дугаар сарын 07-ны өдөр ирүүлсэн Аж ахуйн нэгж байгууллагын тодорхойлолт (Хавсралт 9.16)-д тусгаснаар “Бэрс Эй Би Эс Плас ТЗК” ХХК нь татвар төлөлтийн аливаа мэдээлэл бүртгэгдээгүй, татварын үлдэгдэлгүй байна;
- Цагдаагийн ерөнхий газар Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаас 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдөр ирүүлсэн 136/2471 тоот Тодорхойлолт (Хавсралт 9.17)-д “Бэрс Финанс ББСБ” ХХК-ийн эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх, гэмт хэрэгт холбогдон шалгагдсан эсэхийг цагдаагийн байгууллагын ял шийтгэлийн мэдээллийн сангаас тус тус шалгахад ямар нэг мэдээлэл бүртгэгдээгүй байна;
- Санхүүгийн Зохицуулах Хорооноос 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдөр ирүүлсэн 9/4631 тоот албан бичиг (Хавсралт 9.18)-т тусгаснаар “Бэрс Финанс ББСБ” ХХК нь СЗХ-ны 2017 оны 144 дүгээр тогтоолоор банк бус санхүүгийн байгууллагын зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, 2018 оны 344 дүгээр тогтоолоор факторинг, 2020 оны 350 дугаар тогтоолоор итгэлцэл, 2022 оны 76 дугаар тогтоолоор төлбөрийн баталгаа гаргах тусгай зөвшөөрлүүдийг тус тус эзэмшдэг байна. ББСБ-ын үйл ажиллагаанд СЗХ-ны даргын 2022 оны 280 дугаар тушаалаар баталсан удирдамжийн хүрээнд газар дээрх хэсэгчилсэн шалгалтыг хийж гүйцэтгэсэн бөгөөд шалгалтаар СЗХ-ны 2008 оны 05 дугаар тушаалаар баталсан “Банк бус санхүүгийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийг хөглөх үлгэрчилсэн заавар”-ыг зөрчсөн тул нягтлан бодогч (х)-т Зөрчлийн тухай хуулийн 11.5 дугаар зүйлийн 11.5.2 дахь заалтаар 2 сая төгрөгийн торгууль ногдуулж, ББСБ-д хугацаатай үүрэг даалгавар хүлээлгэсэн байна. Тус хугацаатай үүрэг, даалгаврыг ББСБ бүрэн биелүүлсэн. Мөн ББСБ нь СЗХ-нд ирүүлбэл зохих сар, улирал бүрийн тайлан, мэдээг хугацаанд нь бүрэн ирүүлсэн бөгөөд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээний 2022 оны эхний хагас жилийн асуулгын байдлаар эрсдэлээр “бага” буюу 2.47 гэж үнэлэгдсэн байна.
- 2023 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн байдлаар КУБ зээлийн мэдээллийн систем (Хавсралт 9.19)-ийн мэдээллээр “Бэрс Финанс ББСБ” ХХК нь 2023 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн байдлаар 2021 оны 12-р сарын 31-ний өдрийн 2022 оны 12-р сарын 15-ны өдөр төлөгдөж дуусах нөхцөлтэй 13,365,188,373 төгрөгийн үнийн дүн бүхий зээлээс 2 тэрбум төгрөг, 2022 оны 01-р сарын 31-ний өдрийн 2024 оны 01-р сарын 15-ны өдөр төлөгдөж дуусах нөхцөлтэй 2,4 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий зээлээс 1,4 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй, 2023 оны 01-р сарын 19-ний өдрийн 2023 оны 02-р сарын 16-ны өдөр төлөгдөж дуусах нөхцөлтэй 493,526,020.31 төгрөгийн үнийн дүн бүхий зээлээс 493,526,020.31 төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй, 2022 оны 12-р сарын 01-ний өдрийн 2023 оны 02-р сарын 23-ны өдөр төлөгдөж дуусах нөхцөлтэй 192,257,045.04 төгрөгийн үнийн дүн бүхий зээлээс 192,257,045.04 төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй, бусад зээлийн үлдэгдэл 0 төгрөг байна. Эдгээр зээлүүд нь “хэвийн” ангилагдаж байна.



УБЕГ-ын Эд хөрөнгийн бүртгэлийн 2022 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн албан бичиг (Хавсралт 9.20)-ээр Компани нь доорх үл хөдлөх хөрөнгийг өмчилдөг болно. Үүнд:

№	Улсын бүртгэлийн дугаар	Үл хөдлөх эд хөрөнгийн зориулалт	Байршил	Үл хөдлөх эд хөрөнгийн хэмжээ мкв
1	Г-1723005138	Гэр бүлийн хэрэгцээний	Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 14-р баг, 27 гудамж, 03 тоот	587
2	Ү-1723002109	Хувийн сууц	Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 1-р баг, 34 гудамж, 12а тоот	56
3	Ү-1723000273	Хувийн сууц	Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 6-р баг, 39 гудамж, 3 тоот	48
4	Ү-0118003748	Орон сууц	Архангай аймаг, Эрдэнэбулган сум, 2-р баг, 34 байр, 403 тоот	61.95

- Монголын ББСБ-уудын холбооны 2022 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 2022/040 дугаар албан бичиг (Хавсралт 9.21)-т тус тус зааснаар лавлагаа авсан өдрийн байдлаар, Бэрс Финанс ББСБ ХХК нь Холбооны гишүүн бөгөөд Гишүүний ёс зүйн дүрэм зөрчсөн үйлдэл гаргаж хариуцлага хүлээж байгаагүй байна.

**ХҮНДЭТГЭСЭН,**

“ӨМГӨӨЛЛИЙН ЭМ ДИ ЭС ЭНД ХААНЛЕКС” ХХН-ИЙН

ГИШҮҮН, ХУУЛЬЧ



Д.ДҮГЭРЖАВ

No.	Баримт бичгийн нэр	Дугаар	Огноо	Олгосон байгууллага/ Гэрээний ногоо тал
1	Нийтлэг үндэслэл, Компани үүсгэн байгуулах ажиллагаа болон түүнийг хуулийн этгээдийн бүртгэлд бүртгүүлсэн байдал нь хууль тогтоомжид нийцсэн эсэх, гэрчилгээ, тусгай зөвшөөрөл нь хүчин төгөлдөр эсэх			
1.1.	“Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс” ХХН-ийн үнэт цаасны зах зээлд хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдээр бүртгэх тухай	42	2016.02.24	Санхүүгийн зохицуулах хороо
1.2.	Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээ	Д-С1272230	2022.11.08	“Бэрс Финанс ББСБ” ХХК болон “Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс” ХХН
1.3.	Компани үүсгэн байгуулах тухай шийдвэр	22/17a/69	2022.11.08	“Бэрс Финанс ББСБ” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурал
1.4.	Улсын бүртгэлийн гэрчилгээ (“Бэрс Эй Би Эс Плас” ХХК)	00026709	2022.11.10	Улсын бүртгэлийн ерөнхий газар Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар
1.5.	Компанийн дүрэм (“Бэрс Эй Би Эс Плас” ХХК)	1-р хавсралт	2022.11.08	“Бэрс Эй Би Эс Плас” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурал
1.6.	Тусгай зөвшөөрөл хүсэх тухай	24/05	2022.12.26	“Бэрс Эй Би Эс Плас” ХХК-ийн гүйцэтгэх захирал
1.7.	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай	28	2023.01.25	Санхүүгийн зохицуулах хороо
1.8.	Улсын бүртгэлийн гэрчилгээ (“Бэрс Эй Би Эс Плас ТЗК” ХХК)	000277408	2023.02.08	Улсын бүртгэлийн ерөнхий газар Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар
1.9.	“Бэрс Эй Би Эс Плас ТЗК” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрэм	-	2023.02.08	“Бэрс Эй Би Эс Плас ТЗК” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурал
1.10.	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн лавлагаа (“Бэрс Финанс ББСБ” ХХК)	229000020 04643	2022.11.23	Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газар
1.11.	Улсын бүртгэлийн гэрчилгээ (“Бэрс Финанс ББСБ” ХХК)	000206010	2017.05.18	Улсын бүртгэлийн ерөнхий газрын



				Хуулийн этгээдийн бүртгэлийн газар
1.12.	Компанийн дүрэм (“Бэрс Финанс ББСБ” ХХК)	Хавсралт 1	2022.02.25	“Бэрс Финанс ББСБ” ХХК-ийн хувьцаа эзэмшигч
1.13.	Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ	ТЗ 101/622	2017.07.05	Санхүүгийн зохицуулах хороо
1.14.	Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай тогтоол (зээлийн үйл ажиллагаа)	144	2017.07.05	Санхүүгийн зохицуулах хороо
1.15.	Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл нэмж олгох тухай тогтоол (факторингийн үйлчилгээ)	344	2018.11.14	Санхүүгийн зохицуулах хороо
1.16.	Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл нэмж олгох тухай тогтоол (итгэлцлийн үйлчилгээ)	350	2020.06.10	Санхүүгийн зохицуулах хороо
1.17.	Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл нэмж олгох тухай тогтоол (төлбөрийн баталгаа гаргах үйл ажиллагаа)	76	2022.02.23	Санхүүгийн зохицуулах хороо
2	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тухай шийдвэр нь хууль тогтоомжид нийцсэн эсэх			
2.1	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах бэлтгэл хангах тухай	22/17а/68	2022.11.07	“Бэрс Финанс ББСБ” ХХК-ийн ТУЗ
2.2	Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргах тухай	23/24а/02	2023.02.09	“Бэрс Эй Би Эс Плас ТЗК” ХХК-ийн ТУЗ
2.3	Хувьцаа эзэмшигчийн эрх хэрэгжүүлэх бүрэн эрх олгох тухай	23/01а/03	2023.02.02	“Бэрс Финанс ББСБ” ХХК-ийн хувьцаа эзэмшигч
3	Компанийн дүрэм, үндсэн үйл ажиллагаанд ашиглагдах журам, зааврууд нь хууль тогтоомжид нийцсэн эсэх			
3.1	Журам батлах тухай	23/24а/05	2023.02.09	“Бэрс Эй Би Эс Плас” ХХК-ийн Хувьцаа эзэмшигч
3.2	Компанийн оноосон нэрэнд өөрчлөлт оруулж, дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах тухай	23/24а/01	2023.02.02	“Бэрс Эй Би Эс Плас” ХХК-ийн Хувьцаа эзэмшигч
3.3	ТУЗ-ийн үйл ажиллагааны журам	Хавсралт 1	2023.02.09	“Бэрс Эй Би Эс Плас” ХХК-ийн Хувьцаа эзэмшигч
3.4	Хөндлөнгийн аудитор, үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагчийн сонгох, солих журам	Хавсралт 2	2023.02.09	“Бэрс Эй Би Эс Плас” ХХК-ийн ТУЗ
3.5	Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлэх журам	Хавсралт 3	2023.02.09	“Бэрс Эй Би Эс Плас” ХХК-ийн ТУЗ

3.6	Үнэт цаасны төлбөр цуглуулах, толбор толох тухай журам	Хавсралт 4	2023.02.09	"Бэрс Эй Би Эс Плас" ХХК-ийн ТУЗ
3.7	Эрсдэл, сонирхлын зөрчлийг илрүүлэх, үнэлэх, удирдах дотоод хяналтын журам	Хавсралт 5	2023.02.09	"Бэрс Эй Би Эс Плас" ХХК-ийн ТУЗ
3.8	Хөрөнгө итгэмжлэн удирдах журам	Хавсралт 6	2023.02.09	"Бэрс Эй Би Эс Плас" ХХК-ийн ТУЗ
3.9	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам	Хавсралт 7	2023.02.09	"Бэрс Эй Би Эс Плас" ХХК-ийн ТУЗ
4	Баталгаат үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч этгээд буюу анхны үүрэг гүйцэтгүүлэгч, худалдагчтай байгуулсан хөрөнгө шилжүүлэх, худалдах, худалдан авах, үйлчилгээ үзүүлэх, хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ, хэлцэл болон Компанийн үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой бусад гэрээ, хэлцэл нь хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх, үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагавар байгаа эсэх			
4.1	Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ	23/559	2023.02.09	"Бэрс Эй Би Эс Плас ТЗК" ХХК, "Бэрс Финанс ББСБ" ХХК
4.2	Төлбөр цуглуулах, үйлчилгээ үзүүлэх гэрээ	23/561	2023.02.09	"Бэрс Эй Би Эс Плас ТЗК" ХХК, "Бэрс Финанс ББСБ" ХХК, "Юнайтед Айр Файнэнс" ХХК
4.3	Фидуцийн барьцааны гэрээ	23/560	2023.02.09	"Бэрс Эй Би Эс Плас ТЗК" ХХК, "Бэрс Финанс ББСБ" ХХК
4.4	Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ	23/563	2023.02.09	"Бэрс Эй Би Эс Плас ТЗК" ХХК, "Юнайтед Айр Файнэнс" ХХК
4.5	Зээлийн эргэн төлөлтийн дансны барьцааны гэрээ	23/562	2023.02.09	"Бэрс Эй Би Эс Плас ТЗК" ХХК, "Бэрс Финанс ББСБ" ХХК, "Юнайтед Айр Файнэнс" ХХК
4.6	Аудитын ажлыг гүйцэтгэх гэрээ	22/694998 86	2023.02.09	"Бэрс Эй Би Эс Плас" ХХК, "Ниямазон аудит" ХХК
4.7	Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ (Ниямазон аудит ХХК)	02-2015	2015.01.14	Сангийн яам
4.8	Улсын бүртгэлийн гэрчилгээ (Ниямазон аудит ХХК)	000008909 3	2012.02.10	Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийг этгээдийн бүртгэлийн газар
4.9	Програм хангамж түрээсээр ашиглах гэрээ	ЛА-23/13	2023.02.08	"Грэйпсити Монгол" ХХК


Хууль зүйн дүгнэлтэд ашигласан баримт бичиг

4.10	Түрээсийн гэрээ	-	2022.11.08	“Бэрс Эй Би Эс Плас” ХХК, “Бичил Глобус” ХХК
4.11	Хэлцлийн зөвлөхийн гэрээ	ЗҮ/22-10	2022.11.08	“Бэрс Финанс ББСБ” ХХК, “Юнайтед Айр Файнэнс” ХХК
5	Үнэт цаас гаргагч нь хөрөнгө итгэмжлэн удирдагч, үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч бусад этгээдүүдтэй ашиг сонирхлын зөрчилтэй эсэх			
5.1	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргахтай холбоотойгоор мэргэжлийн байгууллагуудыг сонгох тухай	22/24a/05	2022.12.19	“Бэрс Эй Би Эс Плас” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл
5.2	Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ (Юнайтед Айр Файнэнс ХХК)	ТЗ 316/18	2021.10.28	Санхүүгийн зохицуулах хороо
5.3	Улсын бүртгэлийн гэрчилгээ (Юнайтед Айр Файнэнс ХХК)	00023678 1	2021.09.16	Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийг этгээдийн бүртгэлийн газар
5.4	Хамтран ажиллах гэрээ	-	2022.11.07	“Бэрс Эй Би Эс Плас ТЗК” ХХК, “Онч Аудит”
5.5	Тусгай зөвшөөрлийн тодорхойлолт (Онч Аудит ХХК)	-	2022.04.28	Тусгай зөвшөөрлийн цахим системийн лавлагаа тодорхойлолтын маягт
5.6	Улсын бүртгэлийн гэрчилгээ (Онч Аудит ХХК)	-	2006.06.28	Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийг этгээдийн бүртгэлийн газар
5.7	Андеррайтерийн үйлчилгээний гэрээ	23/558	2023.02.09	“Голомт Капитал ҮЦК” ХХК
5.8	Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ (Голомт Капитал ҮЦК ХХК)	ТЗ 301/37	2011.11.02	Санхүүгийн зохицуулах хороо
5.9	Улсын бүртгэлийн гэрчилгээ (Голомт Капитал ҮЦК ХХК)	00018928 7	2011.05.19	Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийг этгээдийн бүртгэлийн газар
5.10	Захиргааны үйлчилгээ үзүүлэх гэрээ	23/564	2023.02.09	“Бэрс Эй Би Эс Плас ТЗК” ХХК, “Бэрс Финанс ББСБ” ХХК
5.11	Сонирхлын зорчилтэй хэлцэл батлах тухай	23/24a/03	2023.02.09	“Бэрс Эй Би Эс Плас ТЗК” ХХК-ийн ТУЗ
5.12	ТУЗ-ийн хурлын тэмдэглэл	-	2023.02.09	“Бэрс Эй Би Эс Плас ТЗК” ХХК-ийн ТУЗ



2023-04-04

Хууль зүйн дүгнэлтэд ашигласан баримт бичиг



5.13	Тайлбар хүргүүлэх тухай (мэргэжлийн оролцогч партий сонирхлын зорчилгүй талаар)	24/05	2023.02.10	“Бэрс Эй Би Эс Плас ТЗК” ХХК
6	Хөрөнгийн багц дахь хөрөнгийн төрөл бүрээс хамааруулан санамсаргүй түүврийн аргаар сонгох замаар үнэт цаас гаргагчаас тогтоосон хууль зүйн шалгуур үзүүлэлт хангаж буй эсэх			
6.1	Автомашинь фидуци бүхий зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас (ХБҮЦ) олон нийтэд нээлттэй санал болгох хүрээнд сонгогдсон зээлийн дансдын хуулийн шалгуур үзүүлэлтэд нийцсэн эсэх талаарх Хуулийн хөндлөнгийн дүн шинжилгээний тайлан	Д-23/27	2023.02.05	“Өмгөөллийн Эм Ди Эс энд ХаанЛекс” ХХН
7	Багцын хөрөнгөөс үүргийн гүйцэтгэлийг хангуулахтай холбогдох гэрээ, хэлцэл нь хууль тогтоомжид нийцсэн эсэх, гэрээ, хэлцэлд үүргийн гүйцэтгэлийн зүйлтэй холбоотой аливаа шаардах эрхийг шилжүүлэхгүй болон хэрэгжүүлэхгүй байхыг үүрэг болгосон, эсхүл шилжүүлэхийг хориглосон, хязгаарласан нөхцөл туегасан эсэх			
7.1	-	-	-	-
8	Үнэт цаасны танилцуулга, түүнд тусгагдсан мэдээлэл нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, бусад холбогдох хууль журамд нийцэж буй эсэх, үнэн зөв, хүчин төгөлдөр эсэх			
8.1	-	-	-	-
9	Тухайн компанийн эрхэдэг үйл ажиллагаатай холбоотойгоор хийсэн хууль зүйн нэмэлт судалгаа шинжилгээ			
9.1	ТУЗ-ийн гишүүдийг томилох тухай	22/24a/02	2022.12.19	“Бэрс Эй Би Эс Плас” ХХК-ийн хувьцаа эзэмшигч
9.2	ТУЗ-ийн дарга, нарийн бичгийн даргыг сонгох тухай	22/24a/03	2022.12.19	“Бэрс Эй Би Эс Плас” ХХК-ийн ТУЗ
9.3	С.Отгонбатын боловсон хүчний тодорхойлолт, анкет, баталгаа, дипломын хуулбар, тохиромжтой этгээдийг тодорхойлох асуулга, иргэний, эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх тухай тодорхойлолт	-	2022.12.09	С.Отгонбат
9.4	Д.Ганхүрэлийн боловсон хүчний тодорхойлолт, асуулгын хуудас, баталгаа, дипломын хуулбар, тохиромжтой этгээдийг тодорхойлох асуулга, иргэний, эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх тухай тодорхойлолт	-	2022.12.12	Д.Ганхүрэл
9.5	Б.Болор-Эрдэнийн боловсон хүчний тодорхойлолт, анкет, баталгаа, дипломын хуулбар, тохиромжтой этгээдийг тодорхойлох асуулга, иргэний, эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх тухай тодорхойлолт	-	2022.12.12	Б.Болор-Эрдэнэ
9.6	Б.Болор-Эрдэнийн засаглалын сургалтын сертификат	0521278	2022.04.22	СЗХ, Компанийн засаглалын хөгжлийн төв

9.7	С.Отгонбатын засаглалын сургалтын сертификат	0730735	2016.09.09	СЗХ, Компанийн засаглалын хөгжлийн төв
9.8	Д.Ганхүрэлийн засаглалын сургалтын сертификат	0132212	2022.12.05	СЗХ, Компанийн засаглалын хөгжлийн төв
9.9	Тодорхойлолт	4/1742	2022.11.14	Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын дэргэдэх Монголын олон улсын арбитра
9.10	Өр төлбөргүй тухай тодорхойлолт	0003036	2022.11.15	Шийдвэр гүйцэтгэх алба
9.11	Өмгөөллийн "Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН-д	1/3287, 1/3286	2022.11.15	Шүүхийн ерөнхий зөвлөл Шүүхийн тусгай архив
9.12	Тодорхойлолт	2859	2022.11.14	Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн тамгын газар
9.13	"Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН-д	01/1952	2022.11.21	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар
9.14	"Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН-д	01/1633	2022.11.17	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв
9.15	Аж ахуй, байгууллагын тодорхойлолт (Бэрс Финанс ББСБ ХХК)	-	2023.02.07	Монголын Татварын алба
9.16	Аж ахуй, байгууллагын тодорхойлолт (Бэрс Эй Би Эс Плас ХХК)	-	2023.02.07	Монголын Татварын алба
9.17	Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс ХХН-ийн гишүүн, хуульч Дүгэржав танаа	136/2471	2022.12.01	Цагдаагийн ерөнхий газар Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба
9.18	Хариу хүргүүлэх тухай	9/4631	2022.12.02	Санхүүгийн зохицуулах хороо
9.19	Зээлийн мэдээллийн сан	-	2023.02.07	Куб систем
9.20	Эд хөрөнгө бүртгэлтэй эсэх лавлагаа	-	2022.11.16	Улсын Бүртгэлийн Ерөнхий Газрын Улсын бүртгэлийн


				мэдээллийн нэгдсэн сан
9.21	“Эм Ди Эс энд Хаанлекс” ХХН-д	2022/040	2022.11.16	Монголын Банк Бус Санхүүгийн Байгууллагуудын Холбоо
10	Бусад			
10.1	Бэрс Финанс ББСБ ХХК-д	7/1493	2020.04.10	Санхүүгийн зохицуулах хороо
10.2	Төлөөлөн Удирдах Зөвлөл байгуулах тухай	19/05a/274	2019.11.04	“Бэрс Финанс ББСБ” ХХК-ийн хувьцаа эзэмшигч
10.3	Төлөөлөн Удирдах Зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай	20/17a/03	2020.01.28	“Бэрс Финанс ББСБ” ХХК-ийн хувьцаа эзэмшигч
10.4	Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай	20/05a/25	2020.03.16	“Бэрс Финанс ББСБ” ХХК-ийн хувьцаа эзэмшигч
10.5	Улсын бүртгэлийн гэрчилгээ (“Бэрс Капитал” ХХК)	000143000	2015.01.19	Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газар
10.6	Компанийн дүрэм (“Бэрс Капитал” ХХК)	Хавсралт	2017.05.17	“Бэрс Капитал” ХХК-ийн хувьцаа эзэмшигч
10.7	Сонгогдсон зээлүүдэд гүйцэтгэсэн харилцан тохиролцсон ажил үйлчилгээний үр дүнгийн тайлан	-	2022.12.26	“Онч Аудит” ХХК
10.8	Зөвшөөрөл олгох тухай	23/01a/04	2023.02.09	“Бэрс Финанс ББСБ” ХХК-ийн хувьцаа эзэмшигч

~oOo~



МОНГОЛЫН ҮНДЭР СТАМ БИРХ  
MONSOLIAN STOCK EXCHANGE  
2023-03-06  
БҮРТГЭВ

СЗХ  
№ сар өдөр  
БҮРТГЭВ  
№ 1



**АВТОМАШИНЫ ФИДУЦИ БҮХИЙ ЗЭЭЛИЙН ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН  
БАТАЛГААТ ҮНЭТ ЦААС (ХБҮЦ) ОЛОН НИЙТЭД НЭЭЛТТЭЙ САНАЛ БОЛГОХ  
ХҮРЭЭНД СОНГОГДСОН ЗЭЭЛИЙН ДАНСДЫН ХУУЛИЙН ШАЛГУУР  
ҮЗҮҮЛЭЛТЭД НИЙЦСЭН ЭСЭХ ТАЛААРХ**

**ХУУЛИЙН ХӨНДЛӨНГИЙН  
ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

**ХААНА:** “Бэрс Эй Би Эс Плас ТЗК” ХХК-д  
**ХАЯГ:** МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР ХОТ, СҮХБААТАР ДҮҮРЭГ, 11-Р  
ХОРОО, 7 ХОРООЛОЛ, НОГООН НУУР, 101 БАРИЛГА, 706 ТООТ  
**УТАС/ФАКС:** (976) 99119632, (976) 88112461

**ХААНААС:** “ӨМГӨӨЛЛИЙН Эм Ди Эс энд ХаанЛекс” ХХН  
**ХАЯГ:** Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Сүхбаатарын талбай 2  
Сэнтрал Тауэр, 13 давхар, 1301 тоот  
**УТАС/ФАКС:** (976-11) 330048, (976-11) 330049

**Огноо:** 2023 оны 02-р сарын 05-ны өдөр

Утас: +976 11 330048  
Факс: +976 11 330049  
Олон улс: +1 (978) 9033574

№ \_\_\_\_\_

### **“БЭРС ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК” ХХК-д**

Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 11-р хороо, 7 хороолол, Ногоон нуур, 101 барилга, 706 тоот

### **АВТОМАШИНЫ ФИДУЦИ БҮХИЙ ЗЭЭЛИЙН ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААС (ХБҮЦ) ОЛОН НИЙТЭД НЭЭЛТТЭЙ САНАЛ БОЛГОХ ХҮРЭЭНД СОНГОГДСОН ЗЭЭЛИЙН ДАНСДЫН ХУУЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД НИЙЦСЭН ЭСЭХ ТАЛААРХ ХУУЛИЙН ХӨНДЛӨНГИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

Хүндэт Үнэт цаас гаргагч танаа,

Тус “Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс” ХХН (цаашид “МДСХ” гэх) нь “Бэрс Эй Би Эс Плас ТЗК” ХХК (цаашид “Бэрс ЭБС Плас” эсхүл “Үнэт цаас гаргагч” гэх)-ийн хэрэгжүүлж буй Автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас (цаашид “ХБҮЦ”, эсхүл “Үнэт цаас” гэх) гаргах үйл ажиллагаатай холбоотойгоор Үнэт цаас гаргагчийн хөндлөнгийн шинжээч, хуулийн зөвлөхөөр ажиллаж байна.

Хуулийн хөндлөнгийн шинжээчийн үйлчилгээ үзүүлэх ажлын даалгаврын хүрээнд МДСХ нь “Бэрс Эй Би Эс Плас ТЗК” ХХК-аас ирүүлсэн хуулийн шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхэд “Бэрс Финанс ББСБ” ХХК (цаашид “Бэрс Финанс ББСБ” эсхүл “Анхны үүрэг гүйцэтгүүлэгч” гэх)-ийн зээлийн дансаас түүврийн аргаар сонгогдсон 31 зээлийн дансдын энэхүү Тайлангийн Хавсралт 2-т дурдсан “ялгаатай шийдвэрлэгдсэн” асуудлыг харгалзан хөндлөнгийн хуулийн дүн шинжилгээ хийж тайланг (цаашид “Тайлан”, эсхүл “Дүн шинжилгээ”) Үнэт цаас гаргагчид хүлээлгэн өгөх үүрэг хүлээсэн.

Иймд дээр дурдсан үндэслэлээр МДСХ нь Үнэт цаас гаргагчийн хөндлөнгийн шинжээчийн хувиар энэхүү Тайланг гаргаж байгаа болно. Энэхүү тайлан нь тухайлан зориулж гаргасан этгээдүүдээс бусад этгээдийн өмнө ямар нэгэн үүрэг хариуцлага бий болгохгүй. Энэхүү Тайлан нь зөвхөн Үнэт цаас гаргагчийн шаардлага, тодруулгын дагуу гүйцэтгэгдсэн бөгөөд энэ нь аливаа гуравдагч этгээдэд ашигтай байх, эсхүл давуу байдлыг бий болгох мэдээлэл болох, баталгаа өгөх зорилгогүй болно.

Сонгогдсон зээлийн дансдын хувийн хэргийн бүрдүүлбэр материал, баримтуудад агуулагдсан дараах асуудлаар МДСХ нь хариуцлага хүлээхгүй болно. Үүнд:

1. Фидуцийн зүйлийн үнэлгээ нь зөв эсэх;
2. Зээлийн хувийн хэрэгт авагдсан гүйлгээний, кассын баримт, төлбөрийн баримтууд, бусад санхүүгийн анхан шатны баримтууд нь бодитоор үйлдэгдсэн, хүчин төгөлдөр, зохих шаардлага хангаж буй эсэх;
3. Зээлдэгч болон бусад холбогдох этгээдийн зээлийн хувийн хэрэгт авагдсан депозит дансны хуулга, хөрөнгийн жагсаалт, картын гүйлгээ, орлого тодорхойлох баримт бичгүүд нь үнэн зөв, хүчин төгөлдөр эсэх, зохих шаардлага хангаж буй эсэх;
4. Фидуцийн зүйлийн тээврийн хэрэгслийн болон жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нөхцөлүүд нь эрсдэлийг бүрэн хаасан, хүчин төгөлдөр эсэх;



МОНГОЛЫН ХААРИУЦЛАГА БИРЖ  
MONGOLIAN COLLATERAL EXCHANGE  
2023-08-06  
БҮРТГЭ

МОНГОЛЫН ХААРИУЦЛАГА БИРЖ  
MONGOLIAN COLLATERAL EXCHANGE  
92101



5. Зээлдэгч автомашины зээлийг авснаас хойш санхүүгийн тооцоолол буюу ӨОХ нь 45%-иас бага, ЗҮХ нь 75%-аас ихгүй, ӨОХ, ЗҮХ нь зохих шаардлагыг хангасан эсэх, үүнийг нотлох баримт байгаа эсэх;
6. Зээлдүүлэгч буюу Бэрс Финанс ББСБ-ыг төлөөлөн гэрээ байгуулсан этгээд, эсхүл бусад үйл ажиллагаанд төлөөлөх этгээд (төлөөлөх гэдэгт гэрээ болон бусад аливаа шийдвэрт гарын үсэг зурах, шийдвэр гаргах, тухайн харилцаанд үр дагавар бий болгосон үйлдэл, эс үйлдлийг хамааруулах бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй) нь зээлдүүлэгчийг бүрэн төлөөлөх эрхтэй эсэх нь хууль ёсны байсан эсэх, итгэмжлэгдсэн эрх бүхий этгээд мөн эсэх;
7. Фидуцийн зүйл нь ашиглахыг хориглосон эвдрэл, гэмтэл, техникийн зөрчилтэй эсэх, ашиглахыг хориглосон тээврийн хэрэгслийн жагсаалтад багтсан эсэх;
8. Тээврийн хэрэгсэл /автомашин/ худалдах худалдан авах гэрээ нь зах зээлийн зарчмаар, бодитой хийгдсэн эсэх;
9. Зээлийн хувийн хэрэгт байгаа нотлох баримтуудыг гэрчилсэн нотариат, улсын бүртгэгчийн үйлдэл, тэмдэглэл нь үнэн зөв, хүчин төгөлдөр эсэх;
10. Зээлийн хувийн хэрэгт авагдсан зээлийн мэдээллийн сангийн лавлагаа нь үнэн зөв, алдаагүй, хүчин төгөлдөр эсэх, зээлдэгч нь шүүхийн шийдвэрийн дагуу төлбөл зохих өр төлбөртэй эсэх;
11. Зээлийн гэрээний хавсралт, зээлийн хэсэгчилсэн хуваарь, эргэн төлөлтийн хуваарь нь үнэн зөв, алдаагүй, өөрчлөлт орох бүрт шинэчлэгдэж байгаа эсэх;
12. Түүврийн аргаар сонгосон зээлүүдээс бусад зээлтэй холбоотой асуудал;
13. Нотариатын гэрчилсэн, улсын бүртгэлд бүртгэгдсэн үйлдэл нь бодит эсэх.

Мөн Бэрс Финанс ББСБ-ын зүгээс ач холбогдол бүхий баримт, мэдээллийг нуусан, орхигдуулсан, дүн шинжилгээний явцад танилцуулаагүй, буруу, дутуу танилцуулсан нөхцөлд үүсэх асуудлаар МДСХ хариуцлага хүлээхгүй.

Энэхүү албан бичиг Тайлангийн салшгүй хэсэг байна.

Хүндэтгэсэн,

“ӨМГӨӨЛЛИЙН ЭМ-ДИ ЭС ЭНД ХААНЛЕКС” ХХН-ИЙН  
ГИШҮҮН, ХУУЛЬЧ  
  
Д. ДҮГЭРЖАВ ТАР ХУТ



## АГУУЛГА


<b>НЭГ. УДИРТГАЛ</b> .....	6
Дүн шинжилгээний зорилго.....	6
Ажлын хийж гүйцэтгэсэн хугацаа, баг.....	6
Тайлангийн үр өгөөж.....	6
Сонгогдсон зээлийн дансдын мэдээлэл.....	6
Дүн шинжилгээ хийсэн аргачлал.....	7
Дүн шинжилгээ хийсэн арга зүй.....	7
Тайлан гаргахад үндэслэл болгон ашигласан баримт бичиг.....	8
Хангагдсанд тооцох нөхцөл.....	9
Материал хадгалах хугацаа.....	10
<b>ХОЁР. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ХОЛБОГДОХ ДҮГНЭЛТ</b> .....	10
Шалгуур үзүүлэлт 1. Зээлийн хөрөнгө нь хууль зүйн хувьд Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн бүрэн өмчлөлд байх бөгөөд Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс бусад этгээдийн хувьд аливаа байдлаар үүргээс ангид байх.....	10
Шалгуур үзүүлэлт 2. Зээлийн гэрээ нь зээлдэгч (Үүрэг гүйцэтгэгч)-ийн хувьд хуульд нийцсэн, хүчин төгөлдөр, заавал биелэгдэх үүрэг үүсгэх бөгөөд шаардлагатай тохиолдолд уг зээлийг барьцаа (фидуцийн) хөрөнгөөс гаргуулан төлүүлэх боломжтой байх;.....	12
Шалгуур үзүүлэлт 3. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид байгаа мэдээллээр, тасалбар болгох өдрийн байдлаар зээлийн гэрээ нь Үүрэг гүйцэтгэгчийн хувьд үүргээ хугацаанаас өмнө дуусгавар болгох/урьдчилан төлөх нөхцөл, хэлцлээс татгалзах, харилцан суутгал хийх замаар үүргийг дуусгавар болгох, сөрөг нэхэмжлэл гаргах, эсхүл үүргээс татгалзах (илт хохиролтой хэлцлийн улмаас үүргээс татгалзах нөхцөлийг хамааруулан) эрх үүсээгүй, эсхүл эрхээ хэрэгжүүлэх хүсэл зориг илэрхийлээгүй байх. ....	13
Шалгуур үзүүлэлт 4. Зээл нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн хувьд хууль, гэрээ, эсхүл бусад байдлаар аливаа үүргээс ангид, фидуцийн гэрээний зүйлийн хамтаар гуравдагч этгээдэд шилжихэд хориглогдоогүй, эсхүл хязгаарлаагүй байх.....	13
Шалгуур үзүүлэлт 5. Зээлтэй холбоотойгоор Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон зээлдэгчийн хооронд байгуулсан фидуцийн гэрээ нь зээлдэгч (Үүрэг гүйцэтгэгч)-ийн хувьд хуульд нийцсэн, хүчин төгөлдөр, заавал биелэгдэх үүрэг үүсгэсэн зээлдэгч үүргээ биелүүлээгүй тохиолдолд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч өмчлөгчийн эрхээ хэрэгжүүлж, худалдан борлуулж зээл, үүнтэй холбоотой бүх төлбөрийг гаргуулах боломжтой байх.....	14
Шалгуур үзүүлэлт 6. Фидуцийн гэрээ хүчин төгөлдөр болгоход Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн ердийн практикт мөрддөг бүх дүрэм журмыг дагаж мөрдсөн, тухайн үүргийн гүйцэтгэлийг хангуулах аргыг нотолж буй бүх баримт бичиг нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эзэмшил, хадгалалт хамгаалалтад байх.....	14
<b>Нэгдсэн дүгнэлт</b> .....	15
<b>ГУРАВ. САНАЛ/ЗӨВЛӨМЖ</b> .....	16



Хавсралт-1. Гүүврийн аргаар сонгогдсон зээлийн статус ..... 18

Хавсралт 2. БЭРС ЭБС ПЛАС-ын зүгээс өгсөн хөндлөнгийн шинжилгээнд зөрчилд тооцожгүй  
ялгаатай шийдвэрлэгдсэн асуудал ..... 19





**НЭГ. УДИРТГАЛ**

**Дүн шинжилгээний зорилго**

МДСХ нь ХБҮЦ-ийн хэлцэлд Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс худалдахаар санал болгосон зээлийн хөрөнгийн нэгдсэн багцаас нийт зээлийн багцын үнийн дүнгээр 95%-ийн итгэлцлийн түвшин, 5%-ийн хүлээгдэж буй алдааны дээд хязгаартай байхаар сонгогдсон 31 зээлийн дэд дансад Хуулийн шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхэд хөндлөнгийн хуулийн дүн шинжилгээ хийж, дүн шинжилгээний материалыг үндэслэн Тайлан гаргах зорилготой.

**Ажлын хийж гүйцэтгэсэн хугацаа, баг**

МДСХ нь Хөндлөнгийн дүн шинжилгээг 2022 оны 11 дүгээр сарын 24-ний өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ.

МДСХ нь хөндлөнгийн хуулийн дүн шинжилгээг нийт 7 гишүүдийн бүрэлдэхүүнтэйгээр хийж гүйцэтгэлээ. Үүнд:

№	Овог	Нэр	Албан тушаал
1.	Даш-Онолт	Дүгэржав	Нөхөрлөлийн гишүүн, хуульч
2.	Мөнгөн	Ариунзул	Хуульч, ассошейт
3.	Төмөрхуяг	Мөнгөнцэцэг	Ассошейт
4.	Отгонбаатар	Должинсүрэн	Ассошейт
5.	Баянбилэг	Билэгт	Ассошейт
6.	Баатархүү	Хишигдулам	Ассошейт
7.	Цоодол	Дөлгөөн	Ассошейт


**Тайлангийн үр өгөөж**

Энэхүү Тайлан үнэт цаасжуулах ажиллагаатай нь холбогдуулан зөвхөн Үнэт цаас гаргагчид зориулан гаргасан бөгөөд энэхүү Тайлангийн үр өгөөжийг Үнэт цаас гаргагч хүртэх эрхтэй байна.


**Сонгогдсон зээлийн дансдын мэдээлэл**

МДСХ нь Хөндлөнгийн дүн шинжилгээг хийхдээ санхүүгийн хөндлөнгийн шинжээчийн сонгосон зээлийн данстай давхардаагүй зээлийн дансдыг сонгож дүн шинжилгээ хийсэн болно. Зээлийн дансдыг сонгохдоо Бэрс Финанс ББСБ-аас хүргүүлсэн автомашины фидуци бүхий зээлийн багцын жагсаалтаас зээлийн данс түүврээр сонгох шалгуур үзүүлэлтийг харгалзан нийт 2160 зээлийн дансаас санамсаргүй түүврийн аргаар 31 зээлийн дансдыг сонгож авсан. Санамсаргүй түүврийн аргаар сонгогдсон дансдын хамаарах мэдээллийг авч үзвэл:

Зээл олгосон үнийн дүнгийн хэмжээ 20,000,000 (хорин сая) төгрөгөөс дээш байх шалгуурын хүрээнд дараах 20,000,000 (хорин сая) төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 31 зээлийн дансыг сонгосон. *График 1. Зээл олгосон үнийн дүнгийн хэмжээ 20,000,000 (хорин сая) төгрөгөөс дээш байх зээлийн дансдын тоо*



Зээлийн төлөгдөөгүй төлбөрийн үнийн дүнгийн хэмжээ 18,000,000 (арван найман сая) төгрөгөөс их байх шалгуурын хүрээнд 18,000,000 (арван найман сая) төгрөгөөс их зээлийн үлдэгдэл бүхий 31 зээлийн дансыг сонгосон. *График 2. Зээлийн үлдэгдлийн хэмжээ 18,000,000 (арван найман сая) төгрөгөөс дээш байх зээлийн дансдын тоо*



**Дүн шинжилгээ хийсэн аргачлал**

Хөндлөнгийн дүн шинжилгээ хийхдээ сонгогдсон зээлийн дансны зээлийн хувийн хэрэг (зээлийн гэрээ, фидуцийн гэрээ, хувийн мэдээлэл, орлого нотолсон баримт зэрэг), түүнд агуулагдсан Бэрс Финанс ББСБ-ын дотоод мэдээлэл, дүгнэлт, шийдвэр, бусад нотлох баримт, үйл баримтыг Үнэт цаас гаргагчтай урьдчилан тохиролцож, баталгаажуулан бэлтгэсэн шалгуур болон МДСХ-ийн зүгээс боловсруулсан шалгуурын дагуу шалгах, үнэлэх замаар санамсаргүй түүврийн аргаар сонгогдсон зээлийн дансыг анхны үүрэг гүйцэтгүүлэгч буюу Бэрс Финанс ББСБ-аас цахим болон цаасан хэлбэрээр авч шалгах буюу өөрийн байранд биечлэн гүйцэтгэсэн.

**Дүн шинжилгээ хийсэн арга зүй**

Дүн шинжилгээ хийхдээ Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 23/24а/05 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Хөндлөнгийн аудитор, үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох, солих тухай журам”, “Хэлцлийн хүрээнд худалдан авах хөрөнгийн багцад тавигдах хуулийн шалгуур үзүүлэлт”-д тодорхойлсон ХБҮЦ гаргах хэлцлийн хүрээнд хөрөнгийн багцад тавигдсан хуулийн 6 шалгуур үзүүлэлт, тэдгээрийн хүрээнд МДСХ-ийн зүгээс боловсруулсан 69 шалгуур асуултын дагуу

хууль тогтоомжийн хүрээнд Бэрс Финанс ББСБ-ын гаргаж өгсөн зээлийн дансны хувийн хэрэг, түүнд агуулагдсан материал болон Тайлан гаргахад үндэслэл болгон ашигласан баримт бичиг, хууль тогтоомжид тулгуурлан бэлтгэлээ. Үнэт цаас гаргагчийн зүгээс өгсөн хөндлөнгийн шинжилгээнд зорчилд тооцохгүй буюу “Автомашинны зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас (ХБҮЦ) гарган нийтэд санал болгоход анхаарах “ялгаатай шийдвэрлэгдсэн асуудлуудын жагсаалт”-ыг энэхүү Тайлангийн Хавсралт 2-т тусгав.

Дүн шинжилгээ хийх явцад нэмэлт тодруулга, тайлбар, нотлох баримт шаардлагатай асуудлаар Бэрс Финанс ББСБ-д тухай бүр цахим шуудан илгээж хариу тайлбар, нотлох баримтуудыг хүлээн авсан болно.

МДСХ нь сонгогдсон зээлийн дансыг шалгуур үзүүлэлтийн асуултын дагуу шалгаж шалгуур үзүүлэлтийн асуултанд хариулах замаар үнэлсэн. Зээлийн данс нь шалгуур үзүүлэлтийг хангасан түвшингээр нь улаан, шар, ногоон өнгөөр ялгаж тодруулсан. Үүнд:

★ - Зээлийн гэрээ, фидуцийн гэрээний аль нэг нь эсхүл түүний гол нөхцөлийг тодорхойлсон заалт нь хүчин төгөлдөр бусад тооцогдох эрсдэлтэй, хуулийн шаардлага хангаагүй зээлийн дансыг улаан өнгөөр тэмдэглэсэн.

★ - Зээлийн гэрээ, фидуцийн гэрээний аль нэг нь эсхүл түүний гол нөхцөлийг тодорхойлсон заалт нь эрсдэлтэй байж болзошгүй, эрсдэлийн зэргийг дахин үнэлэх шаардлагатай шар өнгөөр тэмдэглэсэн.

★ - Зээлийн гэрээ, фидуцийн гэрээний аль нэг нь зээлийн дансны шалгуур үзүүлэлт, хуулийн шаардлага хангасан, хүчин төгөлдөр зээлийн дансыг ногоон өнгөөр тэмдэглэсэн.

Нэгдсэн дүгнэлтийг гаргахдаа зээлийн дансыг бүрдүүлж буй зээлийн гэрээ, фидуцийн гэрээний аль нэг нь улаан, шар өнгөөр тэмдэглэгдсэн нөхцөлд зээлийн данс нь эрсдэлтэй бүлэгт орохоор тооцож үнэлсэн.

Зарим зээлийн хувийн хэргийн бүрдүүлбэрийн талаар анхаарах асуудлыг Үнэт цаас гаргагчид мэдээлэл өгөх зорилгоор энэхүү Тайлангийн санамж/зөвлөмж хэсэгт дурдсан болно.

Тайлан гаргахад үндэслэл болгон ашигласан баримт бичиг

Энэхүү Тайланг дор дурдсан материалуудын үндсэн дээр гаргасан болно. Үүнд:

1. Бидэнд нээлттэй, ил болгон өгөгдсөн анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс гаргаж өгсөн материалууд;
2. Хууль тогтоомж:

Хууль

- 2.1. Иргэний хууль (2002);
- 2.2. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль (2002);
- 2.3. Банк, эрх бүхий этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль (2021);
- 2.4. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль (2010);
- 2.5. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль (2013);
- 2.6. Хөрөнгийн үнэлгээний тухай хууль (2022);
- 2.7. Зээлийн мэдээллийн тухай хууль (2011);
- 2.8. Нотариатын тухай хууль (2011);
- 2.9. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль (2017);
- 2.10. Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль (2009);
- 2.11. Автотээврийн тухай хууль (1999);
- 2.12. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль (2015);
- 2.13. Зөрчлийн тухай хууль (2017);
- 2.14. Даатгалын тухай хууль (2004);
- 2.15. Жолоочийн даатгалын тухай хууль (2011).



- 2.16. СЗХ-ноос баталсан Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам (2022);
- 2.17. СЗХ-ноос баталсан Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам (2022);
- 2.18. МХБ-ээс баталсан Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам (2020);
- 2.19. Улсын бүртгэлийн Ерөнхий газрын даргын тушаалаар баталсан эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх журам (2018);
- 2.20. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны А/222 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам (2020);
- 2.21. Засгийн газраас баталсан Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэм (2018);
- 2.22. Бусад холбогдох хууль тогтоомж.

#### Хангагдсанд тооцох нөхцөл

Энэхүү Тайланг боловсруулахдаа бид дараах нөхцөл хангагдсан гэж үзсэн болно. Үүнд:

1. Бидний судлан шинжилсэн бүх баримт бичгийн хуулбар, эсхүл маягтууд нь үнэн зөв, тэдгээр дээрх тэмдэгтийн хураамжийн төлбөр нь төлөгдсөн гэсэн тэмдэглэгээ болон бусад аливаа тэмдэглэгээ, гарын үсэг, тамга тэмдэг нь үнэн;
2. Бүх баримт бичгүүд нь тэдгээрийг үйлдсэн талуудын бүрэн эрхийн хүрээнд үйлдэгдсэн бөгөөд, одоо хүчин төгөлдөр байгаа, цаашид хүчин төгөлдөр хэвээр байх бөгөөд тэрхүү баримт бичгийн талуудын тухайн баримт бичгийн дагуу хүлээсэн үүрэг нь бүх холбогдох хуулийн хүрээнд бүрэн хүчин төгөлдөр хэрэгжинэ;
3. Бидэнд өгөгдсөн аливаа баримт бичгийн хуулбар нь тухайн баримт бичгийн эх хувьтайгаа нийцсэн бөгөөд тэдгээрийг бүрэн хуулбарласан, цаашид ямар нэгэн өөрчлөлт орохгүйгээр хүчин төгөлдөр хэрэгжинэ;
4. Зээлийн хувийн хэрэгт авагдсан зээлийн гэрээ, фидуцийн гэрээ нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид эх хувиар хадгалагдаж байгаа;
5. Бидэнд өгөгдсөн баримт бичгийн дагуу үүсэх аливаа үүрэг нь Монгол Улсаас бусад эрх зүйн тогтолцоонд хүчин төгөлдөр байх ба тэдгээр үүргийн хэрэгжилт хууль бус, хүчин төгөлдөр бус, эсхүл хэрэгжих боломжгүй биш байна;
6. Монгол Улсаас өөр улсад үйлдэгдсэн аливаа баримт бичиг нь тийнхүү үйлдэгдсэн улсын хуулийн шаардлагыг хэлбэрийн болон агуулгын хувьд бүрэн хангасан, хүчин төгөлдөр баримт бичиг ба тэдгээрийн хэрэгжилт нь тийнхүү хэрэгжих улсын хуулийн шаардлагыг мөн хангасан болно;
7. Тухайн баримт бичгүүд дээр төрийн байгууллага болон бусад эрх бүхий байгууллагаас авах шаардлагатай зөвшөөрөл, батламжийг авсан, зохих шийдвэр гарсан, тэдгээр баримт бичгийг хүчин төгөлдөр болгоход шаардагдах аливаа бусад хэлцэл хийгдсэн, бусад баримт бичгүүд үйлдэгдсэн;
8. Төрийн эрх бүхий байгууллагын тодорхойлолт, лавлагаа, Төрийн үйлчилгээний цахим (ТҮЦ) машины албан ёсны хэвлэмэл хуудас бүхий лавлагаа нь зээлийн хувийн хэрэгт байх тохиолдолд тус лавлагааг авахад шаардлагатай аливаа хураамж, төлбөрийг төлсөн;
9. Бэрс Финанс ББСБ, түүний ажилтнуудаас аливаа хэлбэрээр хүлээн авсан аливаа мэдээлэл нь үнэн зөв, бодитой;
10. Тээврийн хэрэгслийн даатгал болон жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын төлбөр бүрэн төлөгдсөн;
11. Зээлдэгчид зээл олгохын өмнө Бэрс Финанс ББСБ нь фидуцийн зүйл болох тээврийн хэрэгсэл, тээврийн хэрэгслийн гэрчилгээ, гаалийн мэдүүлэг, татвар төлсөн эсэхийг авч шалгадаг.
12. МДСХ нь энэхүү Дүн шинжилгээний явцад холбогдох ажилтнуудаас тодруулга мэдээллийг газар дээр нь авч ажилласнаас гадна нэмэлт мэдээлэл тодруулга шаардлагатай дансдын талаар цахим шуудан илгээж холбогдох нотлох баримт, тодруулгыг авч ажилласан.
13. Хөндлөнгийн санхүүгийн шинжээч нь өр орлого болон зээл үнэлгээний харьцаа, орлого нотлох баримтыг шалгадаг.
14. Зээлдэгч нь тээврийн хэрэгсэл (автомашин)-ийн урьдчилгаа төлбөр төлсөн эсэхийг шалгадаг.

15. [www.portal.smartcar.mn](http://www.portal.smartcar.mn) вэбсайтад оруулсан мэдээллээр фидуци буюу автомашин нь тээврийн хэрэгслийн болон жолоочийн хариуцлагын албан журмын даатгалтай гэж үзэв.

Бид дараах нөхцөлөөр тайланг боловсруулсан болно. Үүнд:

1. Энэхүү тайланд өөрөөр дурдсанаас бусад тохиолдолд энэхүү судалгаа шинжилгээ нь зөвхөн хууль зүйн асуудлаар хийгдсэн бөгөөд автомашины фидуци бүхий зээлтэй холбоотой дурдагдсан аливаа тоон мэдээллүүдийн талаар бид нарийн мэдлэггүй, тэдгээрийн үнэн зөв байдлыг тогтоохгүй болно;
2. Энэхүү тайланд өөрөөр дурдсанаас бусад тохиолдолд бидний хийсэн ажил энэхүү тайлангийн тайлбар хэсгийн судалгаа шинжилгээний ажлын хүрээгээр хязгаарлагдаж байгаа болно;
3. Энэхүү Тайланд тусгайлан дурдсанаас бусад аливаа судалгаа, шинжилгээ, асуулга хийгдээгүй болно. Тийнхүү хийгдээгүй судалгаа, шинжилгээ, асуулгын үндэс болсон аливаа мэдээлэл, бүртгэл нь бүрэн биш, шинэчлэгдээгүй, жишээ нь, тухайн баримт бичиг нь холбогдох эрх бүхий байгууллагад бүртгэгдээгүй, хувийн хэргээс устсан, алга болсон эсхүл бусад байдлаар хувийн хэрэгт байхгүй болсон байж болно;
4. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн бүх баримт бичиг, гэрээ, төлөвлөгөө, харилцаа холбоо, зөвшөөрөл, хувийн хэрэгтэй танилцсан, тэдгээрийг судалсан гэх амлалтыг энэхүү судалгаа шинжилгээтэй холбоотой бид гаргахгүй болно;
5. Бидний судалгаа шинжилгээ нь энэхүү Тайлан гарах үед хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа Монгол Улсын хуулийн хүрээнд хийгдсэн бөгөөд бид өөр бусад эрх зүйн тогтолцооны холбоо, хамаарал, нөлөөллийн талаар ямар нэгэн үзэл бодол илэрхийлээгүй болно;
6. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс гаргуулан үзсэн зээлийн хувийн хэргүүдэд хийсэн судалгаа нь зээлийн хувийн хэргүүдийн ерөнхий төлөөлөл, эсхүл тэрхүү хувийн хэргүүдийн багцын төлөөлөл, эсхүл аливаа ерөнхий дүгнэлт, санал гаргахад хангалттай статистик мэдээлэл болж тайлбарлагдахгүй, тооцогдохгүй болно.
7. Түүврийн аргаар сонгосон зээлийн дансаас бусад зээлийн данстай холбоотой дүгнэлт гаргаагүй болно;
8. Фидуцийн зүйл болох автомашины бүрэн бүтэн байдал, эдэлгээ, чанарын талаар бид нарийн мэдлэггүй, тэдгээрийн болон түүний эзэмшлийн талаарх нөхцөл байдлыг тогтоохгүй болно.

Энэхүү Тайланг гаргахдаа фидуцийн гэрээнүүд хуульд заасны дагуу зохих ёсоор, үнэн зөв, бүрэн гүйцэд байдлаар байгуулагдаж, эрх бүхий этгээдээр батлуулан, автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяа байгууллага (Авто тээврийн үндэсний төв)-д бүртгүүлсэн гэж үзсэн болно.

#### Материал хадгалах хугацаа

МДСХ нь хуулийн тайлан гаргахад ашигласан болон судалгаа шинжилгээнд хамруулсан зээлийн данс бүрийг шалгаж баримтжуулсан баримт бичиг, эцсийн тайланг Үнэт цаас гаргагчид хүлээлгэж өгснөөс хойш 2 (хоёр) жилийн хугацаанд хадгална.

### ХОЁР. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ХОЛБОГДОХ ДҮГНЭЛТ

Шалгуур үзүүлэлт 1. Зээлийн хөрөнгө нь хууль зүйн хувьд Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн бүрэн өмчлөлд байх бөгөөд Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс бусад этгээдийн хувьд аливаа байдлаар үүргээс ангид байх.

МДСХ нь нэгдүгээр шалгуур үзүүлэлтийн хүрээнд санамсаргүй түүврийн аргаар сонгогдсон нийт 31 зээлийн дансны зээлийн гэрээ, фидуцийн гэрээ нь хүчин төгөлдөр эсэх, фидуцийн гэрээний дагуу тээврийн хэрэгсэл буюу автомашин нь улсын бүртгэлд бүртгэгдсэн эсэх, мөнгөн төлбөрийн үүрэг болон фидуцийн зүйлийг шаардах эрх нь аливаа үүргээс ангид байсан эсэхийг нягталж шалгалаа.

Бэрс Финанс ББСБ-ын үндсэн зээлдэгч, эсхүл хамтран зээлдэгчтэй байгуулсан зээлийн гэрээ, фидуцийн гэрээг талуудын гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулсан эх хувийг, фидуцийн зүйлийн өмчлөгчөөр бүртгэгдсэн авто тээврийн хэрэгслийн гэрчилгээний хуулбар хувийг шалгасан. Фидуцийн гэрээний дагуу фидуцийн зүйл болох автомашиныг Зээлдүүлэгч өмчилж буй боловч автомашиныг Зээлдэгч эзэмшиж ашигладаг байна. Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн 3.1, Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлийн 8<sup>1</sup>-д зааснаар механикжсан тээврийн хэрэгслийн жолооч нь тухайн тээврийн хэрэгслийн бүртгэлийн гэрчилгээтэй байх ба тээврийн хэрэгслийн гэрчилгээ холбогдох бусад баримт бичгийн хамт тээврийн хэрэгслийг жолоодохоор заажээ. Ийнхүү тус хууль тогтоомжийн дагуу Бэрс Финанс ББСБ нь тээврийн хэрэгслийн гэрчилгээг хуулбар хувь нь хадгалах ба хуулийн хөндлөнгийн шинжээчид үзүүлэх боломжгүй байна.

Бид зээлийн хувийн хэргийн материалыг шалгахад сонгогдсон 31 зээлийн дансдын тээврийн хэрэгсэл (автомашин)-ийн гэрчилгээний хуулбарт Бэрс Финанс ББСБ өмчлөгчөөр бүртгэгдсэн байна.

Авто тээврийн тухай хуулийн 17.1, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 21.2-д тус тус заасны дагуу бүх тээврийн хэрэгслийн гэрчилгээг авто тээврийн асуудал эрхэлсэн бүртгэлийн байгууллагаас олгосон байна. Тээврийн хэрэгслийн гэрчилгээ (хуулбар хувь)-г бүртгэлийн байгууллага бүртгэж, баталгаажуулсан эсэхийг бүртгэгчийн тамга, тэмдэглэгээгээр гэрчилснээс үзвэл фидуцийн зүйл болох тээврийн хэрэгсэл нь зохих ёсоор бүртгэгдэж, тээврийн хэрэгслийн гэрчилгээ нь Бэрс Финанс ББСБ-д олгогдсон байна. Түүнчлэн, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 21.2-т “Импортоор оруулж ирсэн тээврийн хэрэгсэл, түүний хөдөлгөөний аюулгүй байдалд нөлөөлөх хийцийн бүрэлдэхүүн хэсэг, нэмэлт тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл нь зохих техникийн норм, дүрэм, стандарт, замын хөдөлгөөний аюулгүй байдлын шаардлагыг бүрэн хангасан байх бөгөөд холбогдох хууль тогтоомжид заасан журмын дагуу техникийн хяналтын үзлэг, оношилгооны дүгнэлт буюу гэрчилгээгээр баталгаажсан байна”, 21.4-д “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын шаардлага хангасныг гэрчлэх шинжлэх ухааны холбогдох байгууллага, эсхүл техникийн хяналтын үзлэг, оношилгооны дүгнэлтгүйгээр тухайн тээврийн хэрэгслийг бүртгэхийг хориглоно”, Авто тээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журмын 10 дугаар зүйлийн 1.2-т зааснаар “техникийн хяналтын үзлэгт тэнцээгүй бол авто тээврийн хэрэгслийг бүртгэхээс татгалзана” гэж заасны дагуу фидуцийн зүйл болох тээврийн хэрэгсэл нь хуульд заасан техник хяналтын үзлэгт хамрагдсан гэж үзэж байна. Мөн журмын 10 дугаар зүйлийн 1.3, 1.4, 1.9-т тус тус зааснаар “авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар төлөөгүй, хуулийн дагуу оногдуулсан торгуулийг төлж барагдуулаагүй, Жолоочийн даатгалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т заасны дагуу тээврийн хэрэгслийн өмчлөгч жолоочийн даатгалд даатгуулаагүй бол тээврийн хэрэгслийг бүртгэхээс татгалзах”-аар зохицуулсан тул тээврийн хэрэгсэлтэй холбоотой татвар, торгууль байхгүй, эсхүл бүрэн төлөгдсөн байж тээврийн хэрэгсэл бүртгэгдсэн гэж үзэв.

Иймд дүн шинжилгээ хийх явцад зээлийн дансны хувийн хэрэгт авагдсан материал, Бэрс Финанс ББСБ-ын өгсөн нэмэлт мэдээллийн дагуу зээлийн дансыг бусад гуравлагч этгээдэд худалдах, уг зээлийн мөнгөн хөрөнгө, зээлийн хүүгийн төлбөрийн шаардах эрх, фидуцийн зүйлийн шаардлагыг бусдын өмнө үүрэг хүлээсэн аливаа хэлцлийн үүргийн гүйцэтгэлд тавьсан нөхцөл байдал илрээгүй учир сонгогдсон зээлийн дансдын фидуцийн зүйл болох автомашин нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс бусад этгээдийн хувьд аливаа байдлаар үүргээс ангид байх шалгуур хангагдаж байна гэж дүгнэлээ.

МДСХ нь санамсаргүй түүврээр сонгогдсон 31 зээлийн дансанд хамаарах автомашины зээл нь хууль зүйн хувьд анхны үүрэг гүйцэтгүүлэгч буюу Бэрс Финанс ББСБ-ын бүрэн өмчлөлд байгаа бөгөөд анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс бусад этгээдийн хувьд аливаа байдлаар үүргээс ангид байна гэж үзлээ.

<sup>1</sup> Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлийн 8, Замын хөдөлгөөний дүрмийн заасан баримт бичиггүй тээврийн хэрэгсэл жолоодсон бол хувийг хорши таван нэгжтэй тэнцэх хэмжээний торгоогоор торгоно



Шалгуур үзүүлэлт 2. Зээлийн гэрээ нь зээлдэгч (Үүрэг гүйцэтгэгч)-ийн хувьд хуульд нийцсэн, хүчин төгөлдөр, заавал биелэгдэх үүрэг үүсгэх бөгөөд шаардлагатай тохиолдолд уг зээлийн барьцаа (фидуцийн) хөрөнгөөс гаргуулан төлүүлэх боломжтой байх:

Уг шалгуур үзүүлэлтийг хүрээнд Бэрс Финанс ББСБ-ын зээлдэгчтэй байгуулсан зээлийн гэрээ хуулиар тодорхойлсон хэлбэрийн шаардлагыг хангасан, хуульд нийцсэн, хүчин төгөлдөр эсэх, зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг шаардлагатай тохиолдолд фидуцийн хөрөнгө болох тээврийн хэрэгслээс гаргуулан төлүүлэх нөхцөлийг гэрээнд тусгасан эсэх, хуульд зааснаар, эсхүл итгэмжлэлээр төлөөлөх эрх нь хүчин төгөлдөр эсэх зэрэг асуудлыг шалгаж үзлээ.

Нийт дүн шинжилгээнд хамрагдсан зээлийн дансдын хувьд БЭБХЭМХМХШЗҮАтХ-ийн 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.8<sup>2</sup>-д заасан зээлийн гэрээнд “зээлийн дансны дугаар”, “Зээлдүүлэгчийн оршин байгаа хаяг” тусгагдаагүй байсан бөгөөд “ялгаатай шийдвэрлэгдсэн асуудлуудын жагсаалт”-д зарим нөхцөл тусгагдаагүй байж болох тухай заасны дагуу бид эрсдэлтэй зээлийн дансдын тоонд оруулаагүй болно. МДСХ нь зээлийн гэрээнд тусгасан байх ёстой нөхцөлүүдийг бүрэн тусгах зөвлөмжийг энэхүү Тайлангийн зөвлөмж хэсэгт тусгасныг анхаарах шаардлагатай байна.

Энэхүү дурдсан 2 нөхцөлөөс бусдаар зээлийн гэрээнд тусгасан байх бусад нөхцөлийг зээлийн гэрээндээ тусгасан, зээлийн гэрээ, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлтөд зээлдүүлэгч болон хамтран зээлдэгч гарын үсэг зурсан нь Иргэний хуулийн 42.2, 451.2 дугаар зүйл, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль (цаашид “БЭБХЭМХМХШЗҮАтХ” гэх)-ийн 19.3 болон 20 дугаар зүйлд тус тус тодорхойлсон шаардлагыг хангасан байна (Тайлангийн зөвлөмж хэсгийг харна уу).

Бэрс Финанс ББСБ-аас зээлийн төлбөрийг зээлдэгчийн дансанд, эсхүл гэрээгээр тохиролцсон, тусгайлан бичгээр зөвшөөрөл авсны үндсэн дээр гуравдагч этгээдийн дансанд шилжүүлсэн нь БЭБХЭМХМХШЗҮАтХ-ийн 19.5-д “Зээлийн гэрээнд заасны дагуу зээлийг зээлдэгчийн зээлийн дансанд шилжүүлсэн, эсхүл зээлдэгч зээлийн данснаас зээлээ ашигласныг зээл олгосонд тооцно” гэж заасантай нийцэж буй тул зээл олголт нь хуулийн хүчин төгөлдөр болно.

Түүнчлэн зээлийн гэрээ нь Бэрс Финанс ББСБ-аас зээлдэгчид санал болгож байгаа, хуулийн заалтыг тодотгосон журам тогтоосон, байнга хэрэглэгдэх шинжтэй, урьдчилан тогтоосон нөхцөл болохын хувьд Иргэний хуулийн 200 дугаар зүйлд заасан стандарт гэрээний нөхцөл болно. Гэрээний зохицуулалтаас харвал, зээлийн гэрээ нь Иргэний хуулийн 202 дугаар зүйлд заасан гэрээний стандарт нөхцөлийг хүчин төгөлдөр бусад тооцох зохицуулалт агуулаагүй байна.

Түүнчлэн нийт зээлийн дансдын хувьд зээлийн гэрээний 1.2<sup>3</sup>-т зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулах баталгаа болгож фидуцийн хөрөнгө болох тээврийн хэрэгслийн өмчлөх эрхийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид шилжүүлэх тухай дурдсан байх тул зээлийг фидуцийн хөрөнгөөс гаргуулан төлүүлэх боломжтой байна гэж үзлээ.

Иймд, сонгогдсон нийт 31 зээлийн дансны тээврийн хэрэгсэл/автомашин худалдан авах зориулалтаар зээл олгох хэлцэл нь зээлдэгч (үүрэг гүйцэтгэгч)-ийн хувьд хуульд нийцсэн, хүчин төгөлдөр, заавал биелэгдэх үүрэг үүсгэх бөгөөд зээлийн гэрээ нь зээлдэгч (Үүрэг гүйцэтгэгч)-ийн хувьд хуульд нийцсэн хүчин төгөлдөр, заавал биелэгдэх үүрэг үүсгэсэн байх шалгуурыг хангаж байна гэж үзлээ.

<sup>2</sup> “20.2.3 зээлийн гэрээнд дараах зүйлийг тусгасан байна: 20.2.3 зээлийн дансны дугаар; 20.2.8 зээлийн гэрээнд оролцогч талуудын оршин байгаа, оршин суугаа хаяг”

<sup>3</sup> Гэрээний үүргийн гүйцэтгэлийг баталгаажуулах зорилгоор барьцаа хөрөнгө болох тээврийн хэрэгслийн өмчлөх эрхийг зээлдүүлэгч, зээлдүүлэгчийн төлөөлөгч рүү шилжүүлнэ.

2023-04-06

Шалгуур үзүүлэлт 3. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид байгаа мэдээллээр, тасалбар болгох өдрийн байдлаар зээлийн гэрээ нь Үүрэг гүйцэтгэгчийн хувьд үүргээ хугацаанаас өмнө дуусгавар болгох/урьдчилан төлөх нөхцөл, хэлцлээс татгалзах, харилцан суутгал хийх замаар үүргийг дуусгавар болгох, сөрөг нэхэмжлэл гаргах, эсхүл үүргээс татгалзах (илт хохиролтой хэлцлийн улмаас үүргээс татгалзах нөхцөлийг хамааруулан) эрх үүсээгүй, эсхүл эрхээ хэрэгжүүлэх хүсэл зориг илэрхийлээгүй байх.

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд МДСХ нь түүврийн аргаар сонгосон 31 зээлийн дансдын хувьд зээлийн гэрээ, фидуцийн гэрээнд тусгагдсан үүрэг хугацаанаас өмнө дуусгавар болох, гэрээг цуцлах, гэрээнээс татгалзах нөхцөлүүд болон үүргээ хугацаанаас өмнө дуусгавар болгох тухай хүсэл зориг илэрхийлсэн эсэх талаар шалгаж үзлээ.

Иргэний хуулийн 283.3-д зааснаар “талууд урьдчилан тохирсон буюу зээлдүүлэгч зөвшөөрсөн тохиолдолд” зээлдэгч зээлээ урьдчилан төлөх боломжтой тухай зохицуулсан байдаг. Хэдийгээр энэ талаар зээлийн гэрээнд зохицуулалт тусгагдаагүй ч зээлдэгч нь хуульд заасны дагуу зээлийн гэрээний төлбөрийг урьдчилан төлөх эрхтэй.

Тайлан гаргах өдрийн байдлаар Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид байгаа мэдээллээр сонгогдсон 31 зээлийн дансдын зээл олгох хэлцэл нь үүрэг гүйцэтгэгчийн хувьд үүргээ хугацаанаас өмнө дуусгавар болгох/урьдчилан төлөх нөхцөл, хэлцлээс татгалзах, харилцан суутгал хийх замаар үүргийг дуусгавар болгох, сөрөг нэхэмжлэл гаргах, эсхүл үүргээс татгалзах (илт хохиролтой хэлцлийн улмаас үүргээс татгалзах нөхцөлийг хамааруулан) эрх үүсээгүй, эсхүл эрхээ хэрэгжүүлэх хүсэл зориг илэрхийлээгүй байх тул энэхүү шалгуур үзүүлэлтийг хангаж байна.

Шалгуур үзүүлэлт 4. Зээл нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн хувьд хууль, гэрээ, эсхүл бусад байдлаар аливаа үүргээс ангид, фидуцийн гэрээний зүйлийн хамтаар гуравдагч этгээдэд шилжихэд хориглогдоогүй, эсхүл хязгаарлаагүй байх.

Уг шалгуур үзүүлэлтийн хүрээнд МДСХ нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь фидуци болон зээлийн мөнгөн хөрөнгийг эргүүлэн шаардах эрхийг гуравдагч этгээдэд шилжүүлэхэд хууль болон гэрээгээр хориглосон, хязгаарласан нөхцөл байгаа эсэх, фидуцийн зүйл хамтран өмчлөгчтэй тохиолдолд хамтран өмчлөгчийн зөвшөөрөл байгаа эсэх, хамтран өмчлөгч фидуцийн гэрээнд гарын үсэг зурсан эсэх зэрэг асуудлыг шалган үзлээ.

Бэрс Финанс ББСБ нь зээлдүүлэгч зээлийн гэрээний шаардах эрхийг үүргийн гүйцэтгэлийг хангуулах эрхийн хамт бусдад шилжүүлэхийг хориглоогүй, аливаа байдлаар хязгаарлаагүй байх талаар зээлийн гэрээнд тусгаагүй байна. Гэвч Иргэний хуулийн 123.3-т заасны дагуу үүрэг гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд шаардах эрхийг шилжүүлэхийг хязгаарласан нөхцөл байхгүй тохиолдолд шаардах эрх эзэмшигч нь уг эрхээ Иргэний хуулийн 123.2-т заасны дагуу үүргийн мөн чанарт харшлаагүй нөхцөлд үүрэг гүйцэтгэгчийн зөвшөөрлийг авахгүйгээр бусдад шилжүүлэх эрхийг олгосон байна. Зээлийн гэрээнд энэхүү эрхийг хязгаарласан аливаа зохицуулалт ороогүй болно.

Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн өмчлөлд буй фидуцийн зүйл болох автомашиныг зээлдэгч (эсхүл түүний итгэмжилсэн этгээд) эзэмшдэг болохыг дурдахын зэрэгцээ дүн шинжилгээнд хамрагдсан 31 зээлийн дансаас 31 зээлийн дансдын хувьд автомашины зээл нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн хувьд хууль, гэрээ, эсхүл бусад байдлаар аливаа үүргээс ангид, бусдад шилжихийг хориглогдоогүй, эсхүл хязгаарлаагүй байх шалгуур үзүүлэлтийг хангасан гэж үзэв. Түүнчлэн фидуцийн гэрээний дагуу фидуцийн зүйл болох автомашины цорын ганц өмчлөгч нь Зээлдүүлэгч (Анхны үүрэг гүйцэтгүүлэгч) байх ба фидуцийн зүйлтэй холбоотой хамтран өмчлөгчийн эрх байхгүй болохыг бид шалгасан болно. Иймд, зээл төлүүлэх зорилгоор автомашиныг барьцаалуулах, худалдан борлуулах, бусдад шилжүүлэх эрхийг фидуцийн гэрээний дагуу түүнийг өмчилж буй Анхны үүрэг гүйцэтгүүлэгч эдэлнэ. Харин эзэмших, ашиглах эрхийг өөр этгээд хэрэгжүүлж байгаа нь ажиллагааны шуурхай байдалд нөлөөлж болох талтайг дурдах нь зүйтэй.

Зөрчлийн тухай хуулийн 5.6-д зааснаар зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд нь зээлийн хувийн хэргийн бүрдүүлбэрийг хангаагүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж, тухайн зөрчил гаргасан үйлдлээс олсон орлогыг хурааж хуулийн этгээдийг хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгуулах хариуцлага хүлээхээр байгааг анхаарна уу.

Соногдсон зээлийн дансдын заримд нь зээлийн үнийн дүнг “ХХХ” ХХК, эсхүл Монгол Улсын иргэн ХХХ буюу тээврийн хэрэгсэл нийлүүлэгчийн дансанд шилжүүлсэн тохиолдол илэрсэн. Бэрс Финанс ББСБ ХХК нь тээврийн хэрэгсэл нийлүүлэгч байгууллага болон хувь хүнтэй Хамтран ажиллах гэрээ байгуулж, автомашины зээлийн бүтээгдэхүүний хувьд зээлийн төлбөрийг нийлүүлэгчид дараа тооцоогоор шилжүүлж байхаар тохиролцсон байна. Хэдийгээр зээлийн төлбөрийг автомашин нийлүүлэгчийн дансанд шилжүүлэхийг талууд гэрээ ( эсхүл тусгайлсан зөвшөөрөл бүхий бичиг)-ээр тохиролцсон боловч зээлийн гэрээ нь бодит хэлцэлд хамаарахын хувьд зээлийн төлбөрийг зээлдэгчийн дансанд шилжүүлж байх нь зүйтэй байна.

Түүнчлэн шалгуур 2-т дурдсанчлан зээлийн гэрээнд БЭБХЭМХМХШЗҮАтХ-ийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т заасан “зээлийн дансны дугаар”, 20.2.8-д заасан “зээлдүүлэгчийн оршин байгаа хаяг” тусгагдаагүй зөрчил илэрсэн. Ийнхүү илэрсэн зөрчил нь ялгаатай шийдвэрлэсэн асуудлуудын жагсаалтад багтсан хэдий ч цаашдаа БЭБХЭМХМХШЗҮАтХ-д нийцүүлэн тус нөхцөлүүдийг тусгах нь зүйтэй байна. Ийнхүү тусгаагүйтэй холбоотойгоор Иргэний хуулийн 56 дугаар зүйлийн 56.1<sup>4</sup>-д заасны дагуу хуульд зөрчсөн гэх үндэслэлээр хүчин төгөлдөр бус болох эрсдэлтэй байгааг анхаарах шаардлагатай. Түүнчлэн нийт зээлийн дансдын хувьд зээлдэгч, хамтран зээлдэгч нар нь шүүхийн шийдвэрээр өр төлбөртэй эсэх лавлагааг аваагүй байсан. Үүнтэй холбоотойгоор зээлдэгчийн төлбөрийн чадварыг судлахдаа шүүхийн шийдвэрээр өр төлбөртэй эсэх лавлагааг авдаг, энэ талаарх мэдээллийг аливаа хэлбэрээр шалгадаг байх нь зээлийн төлбөр төлөгдөх боломжийг тодорхойлоход чухал ач холбогдолтой.

НӨХӨРЛӨЛИЙН  
ГИШҮҮН, ХУУЛЬЧ



Д.ДҮГЭРЖАВ

<sup>4</sup> “56.1 Дараахь хэллэл хүчин төгөлдөр бус байна: 56.1.1.хууль зөрчсөн буюу нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харилцсан хэллэл.”







Хавсралт 1. Түүврийн аргаар сонгогдсон зээлийн статус

№	ББСБ	Зээлийн дансны дугаар	Статус
1.	Бэрс Финанс ББСБ ХХК	2101130101023375	★
2.	Бэрс Финанс ББСБ ХХК	2101130101023478	★
3.	Бэрс Финанс ББСБ ХХК	2101130110002848	★
4.	Бэрс Финанс ББСБ ХХК	2101130110002853	★
5.	Бэрс Финанс ББСБ ХХК	2101130110002860	★
6.	Бэрс Финанс ББСБ ХХК	2101130110002869	★
7.	Бэрс Финанс ББСБ ХХК	2101130110002880	★
8.	Бэрс Финанс ББСБ ХХК	2101130110002960	★
9.	Бэрс Финанс ББСБ ХХК	2101130110003068	★
10.	Бэрс Финанс ББСБ ХХК	2101130110003109	★
11.	Бэрс Финанс ББСБ ХХК	2101130110003134	★
12.	Бэрс Финанс ББСБ ХХК	2101130110003395	★
13.	Бэрс Финанс ББСБ ХХК	2101130110003434	★
14.	Бэрс Финанс ББСБ ХХК	2101130110003441	★
15.	Бэрс Финанс ББСБ ХХК	2101130110003493	★
16.	Бэрс Финанс ББСБ ХХК	2101130110003509	★
17.	Бэрс Финанс ББСБ ХХК	2101130110003508	★
18.	Бэрс Финанс ББСБ ХХК	2101130110003500	★
19.	Бэрс Финанс ББСБ ХХК	2101130110003531	★
20.	Бэрс Финанс ББСБ ХХК	2101130110003542	★
21.	Бэрс Финанс ББСБ ХХК	2101130110003571	★
22.	Бэрс Финанс ББСБ ХХК	2101130110003573	★
23.	Бэрс Финанс ББСБ ХХК	2101130110003591	★
24.	Бэрс Финанс ББСБ ХХК	2101130110003597	★
25.	Бэрс Финанс ББСБ ХХК	2101130110003590	★
26.	Бэрс Финанс ББСБ ХХК	2101130110003607	★
27.	Бэрс Финанс ББСБ ХХК	2101130110003613	★
28.	Бэрс Финанс ББСБ ХХК	2101130110003626	★
29.	Бэрс Финанс ББСБ ХХК	2101130110003621	★
30.	Бэрс Финанс ББСБ ХХК	2101130141000002	★
31.	Бэрс Финанс ББСБ ХХК	2101130110003595	★

-ooOoo-



Хавсралт 2. Үнэт цаас гаргагчийн зүгээс өгсөн хөндлөнгүй шинжилгээнд зөрчилд тооцохгүй ялгаатай шийдвэрлэгдсэн асуудал

**Автомашинны фидуци бүхий зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас (ХБҮЦ) гарган нийтэд санал болгоход анхаарах ялгаатай шийдвэрлэгдсэн асуудлуудын жагсаалт**

**Нэг.** Хөндлөнгийн хуулийн дүн шинжилгээний явцад анхаарах асуудлууд нь Захиалагч буюу “Бэрс Эй Би Эс Актив” ХХК (цаашид “анхны үүрэг гүйцэтгэгч” гэх)-ийн өгсөн ажлын даалгаврын салшгүй хэсэгт тооцогдоно.

**Хоёр.** Хөндлөнгийн хуулийн дүн шинжилгээний явцад эдгээр харилцан тохиролцож шийдвэрлэсэн асуудлууд үүссэн нөхцөлд тухайн дансыг хуулийн шаардлага хангасан (зөвхөн энэхүү харилцан тохиролцсон асуудлын хувьд) гэж тооцно.

**Гурав.** Бэрс Эй Би Эс Актив багцад ялгаатай шийдвэрлэгдсэн асуудлын тайлбартай давхцсан зээл байж болно.

**Дөрөв.** Ялгаатай шийдвэрлэгдсэн асуудлуудын дэлгэрэнгүй тайлбар, жагсаалт:

1	Зээлийн шимтгэл, тээврийн хэрэгслийн урьдчилгаа төлбөр, татвартай холбоотой	<p>Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 6.5-д зааснаар “Банк, эрх бүхий хуулийн этгээд харилцагчаас зөвхөн гэрээнд тусгасан шимтгэл, хураамжийг төлүүлэх бөгөөд өөрийн үзүүлсэн нэг төрлийн үйлчилгээнд үйлчилгээний шимтгэл, хураамжийг давхардуулан авахгүй” гэж заасны дагуу “Бэрс Финанс ББСБ” ХХК нь харилцагчаас Зээлийн гэрээний 6.6-д зааснаар “зээлийн төлбөр төлөхтэй холбоотой аливаа төлбөр тооцоог Зээлдүүлэгчийн тухайн үед мөрдөгдөж буй хүү, шимтгэлийн нөхцөлөөр гүйцэтгэхийг зөвшөөрч байна” гэж тохиролцсон тул зээлийн хүү, ерөнхий нөхцлийн дагуу зээл тус бүрээс тодорхой хэмжээний зээлийн шимтгэл авдаг. Бэрс Финанс ББСБ ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 22/17а/39 тоот тушаалаар зээлийн шимтгэлийг суутган төлүүлэхгүй байхаар шийдвэрлэсэн ба тус тушаал хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэхээс өмнөх хугацааны зээлийн хувьд зээлийн шимтгэлийг зээлийн төлбөрөөс суутган тооцож болно. Мөн цөөн зээлийн дансдын хувьд салбарын зээлийн газрын захирлын зөвшөөрлөөр зээлийн шимтгэл тооцоогүй байж болно.</p> <p>“Бэрс Финанс ББСБ” ХХК-ийн Зээлийн үйл ажиллагааны журмын 3.2 дугаар зүйлийн 3.2.6-д зааснаар 10 сая төгрөгнөөс дээш үнийн дүн бүхий автомашины зээлд хамтран зээлдэгчтэй байх шаардлага тавьсан. Харин “Бэрс Финанс ББСБ” ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2021 оны 04-р сарын 02-ны өдрийн 21/17а/35 тоот тушаалаар бүх төрлийн худалдан авалтын зээлийн хувьд харилцагч урьдчилгаа төлбөрөө 30 болон түүнээс дээш хувь төлсөн тохиолдолд хамтран үүрэг гүйцэтгэгчгүй байж болохоор зохицуулсан тул зарим зээлийн хувьд хамтран зээлдэгчгүй байгаа болно.</p> <p>Тээврийн хэрэгсэл худалдах, худалдан авах гэрээнд зээлдэгч урьдчилгаа төлбөр төлсөн гэх агуулга бүхий заалт орсон бол урьдчилгаа төлбөрийн баримтыг хувийн хэрэгт хавсаргадаггүй тул зарим зээлийн хувийн хэрэгт энэ талаарх баримтыг бүрдүүлээгүй байж болно.</p> <p>Зээлийн гэрээний харилцаа дуусгавар болоход Бэрс Финанс ББСБ ХХК нь тээврийн хэрэгслийн татвар төлөгдсөн эсэхийг шалгасны үндсэн дээр тээврийн хэрэгслийг Зээлдэгчийн нэр дээр шилжүүлдэг тул тээврийн хэрэгслийн татвар төлсөн баримтыг зээл олгоход шаарддаггүй, энэ талаарх баримтыг зээлийн хувийн хэрэгт хавсаргадаггүй болно.</p> <p>Зээлийн гэрээний 3.2.5-д зааснаар зээлдэгч нь тээврийн хэрэгслийн даатгал, албан татвар, бусад татвар хураамж, тээврийн хэрэгсэлд ноогдсон торгуулийн хуудас, журамлагдсан зогсоолын төлбөр зэргийг цаг тухайд нь төлөх үүрэгтэй тул зарим фидуцийн эд зүйл буюу автомашин нь татвар, торгуультай байж болно.</p>
---	---	--

2023-03-06

2	Зээлийн хорооны шийдвэртэй холбоотой	<p>“Бэрс Финанс ББСБ” ХХК-ийн Зээлийн үйл ажиллагааны журмын 9.1-т зааснаар зээлийн шийдвэрийн дагуу зээлдэгчтэй зээлийн гэрээ байгуулахаар заасан. Харин “Бэрс Финанс ББСБ” ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2021 оны 07-р сарын 21-ний өдрийн 21/17а/03 тоот тушаалаар 30 сая төгрөг хүртэлх, 2022 оны 03-р сарын 22-ны өдрийн 22/17а/24 тоот тушаалаар 40 сая төгрөг хүртэлх, 2022 оны 02-р сарын 08-ны өдрийн 22/17а/09 тоот тушаалаар Бэрс 22 салбараас олгогдох зээлийн хувьд 40 сая төгрөг хүртэлх үнийн дүнтэй автомашины зээлийг салбар дангаараа төвийн зээлийн хорооны шийдвэргүйгээр шийдвэрлэх боломжтой болно. Иймд, зарим зээлийн дансдын хувийн хэрэгт зээлийн хорооны шийдвэр хавсаргаагүй байж болно. Зарим зээлийн дансдын хувьд зээлдэгчийн орлого хүрэлцээтэй, барьцаа хөрөнгийн үнэлгээ хангалттай байсан тул Гүйцэтгэх захирлаас зөвшөөрөл авч салбартаа зээлийг шийдвэрлэж гаргасан байж болно.</p>
3	Даатгалтай холбоотой	<p>Зээлдэгч даатгалын төлбөрийг тухайн даатгалын компанийн дансанд шилжүүлсний дараа гэрээ болон баталгаа гардаг, мөн <a href="http://www.portal.smartcar.mn">www.portal.smartcar.mn</a> вэбсайтад оруулсан мэдээллээр автомашин нь тээврийн хэрэгслийн болон жолоочийн хариуцлагын албан журмын даатгалтай байх тул даатгалын гэрээ нь тээврийн хэрэгслийг даатгуулсан, даатгалын хураамж төлсөн гэх баримт болно. Түүнчлэн Зээлийн үйл ажиллагааны журмын дагуу даатгалын хураамж төлсөн баримтыг зээлийн хувийн хэрэгт хавсаргахгүй байж болно. Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээнд даатгалын эрсдлийг хязгааргүй хариуцахаар тэмдэглэсэн бол даатгалын гэрээнд жолоочийн нэр, регистрийн дугаар, утасны дугаар зэрэг хувийн мэдээллийг оруулахгүй байж болно.</p>
4	Хувийн хэрэгт авагдсан баримттай холбоотой	<p>Зээлийн үйл ажиллагааны журамд зааснаар зээлдэгчийн орлого нотлох баримт нь үндсэн болон хамтран зээлдэгчийн нийгмийн даатгалын лавлагаагаар тодорхойлогдох тул хөдөлмөрийн гэрээ, ажлын газрын тодорхойлолт, цалингийн дансны хуулгыг зээлийн хувийн хэрэгт хавсаргадаггүй. Харин зээлдэгч нь хувиараа хөдөлмөр эрхлэгч бол зөвхөн дансны хуулга шалгадаг болно.</p> <p>Харилцагчийн орлого нотлох баримтаар 6 сарын дансны хуулгыг интернет банкаар судалж, 2-3 сарын дансны хуулгыг зээлийн хувийн хэрэгт хавсаргадаг. Харилцагч нь Бэрс Финанс ББСБ ХХК-аас 2 ба түүнээс дээш удаа зээл авч байгаа тохиолдолд зээлдэгч болон хамтран зээлдэгчийг орлого нотлохыг шаарддаггүй болно.</p> <p>Зээлдэгчийн зээлийн мэдээллийн сангийн хэвийн бус ангилал засагдсан эсхүл өр төлбөргүй, зээлийн эргэн төлөлт хэвийн болсон бол түүнийг Зээлийн үйл ажиллагааны журамд заасан зээлийн мэдээллийн санд хэвийн ангилалтай байх шаардлагыг хангасан гэж үзнэ.</p> <p>Фидуци буюу автомашины өмчлөх эрхийг Бэрс Финанс ББСБ ХХК нь шилжүүлэн авсан, зээлдэгч автомашиныг бодит эзэмшилдээ авч ашиглаж байгаа нь зээл зориулалтын дагуу ашиглагдсан гэж үзэх тул БЭБХЭМХМХШЗҮАтХ-ийн 22 дугаар зүйлийн 22.2-т заасны дагуу зээлийн хувийн хэрэгт зээлийн ашиглалт шалгасан баримт бичгийг бүрдүүлээгүй байж болно.</p> <p>Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Газарт өр төлбөртэй эсэх лавлагаа аваагүй байж болно.</p>
5	Зээлийн гэрээ, фидуцийн гэрээтэй холбоотой	<p>Хамтран зээлдэгч нь фидуцийн зүйлийг өмчлөөгүй тохиолдолд барьцааны гэрээ буюу Фидуцийн гэрээнд хамтран зээлдэгчийн мэдээллийг оруулаагүй, гарын үсэг зуруулаагүй байж болно.</p> <p>Зарим зээлийн дансдын хувьд фидуцийн гэрээг хамтран зээлдэгчийн гарын үсгээр баталгаажуулаагүй байж болно. Иргэний хуулийн 235.1-т “үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар эд хөрөнгө өмчлөлд шилжүүлэх гэрээгээр (цаашид “фидуци” гэх) үүрэг хүлээгч нь мөнгө төлөх үндсэн үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор хөдлөх эд хөрөнгийг үүрэг гүйцэтгүүлэгчийн өмчлөлд шилжүүлэх, үүрэг хүлээгч үндсэн үүргээ хугацаанд гүйцэтгэсэн тохиолдолд үүрэг гүйцэтгүүлэгч уг эд хөрөнгийг түүнд буцаан өгөх үүргийг тус тус хүлээнэ”, 235.4-т “үүрэг хүлээгч мөнгө төлөх үүргээ хугацаанд нь биелүүлж, шилжүүлсэн эд хөрөнгөө буцаан авсан буюу ийнхүү үүргээ биелүүлээгүй бол өмчлөлд шилжүүлсэн эд хөрөнгийг үүрэг гүйцэтгүүлэгч бодитойгоор гаргуулан авснаар үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар эд хөрөнгө өмчлөлд</p>



		<p>шилжүүлэх гэрээ дуусгавар болно” гэж тус тус заасан. Мөн фидуцийн гэрээний 1.1-т зээлийн гэрээний үүргийн биелэлтийг хангуулахаар доорх барьцааны зүйлийг барьцаалав, 1.3-т МУ-ын Иргэний хуулийн 235.1 заалтыг үндэслэн барьцаа болох автомашины өмчлөх эрхийг Бэрс Финанс ББСБ-ийн болон төлөөлөгчийн нэр дээр шилжүүлэх ба зээлийн гэрээний үүрэг бүрэн дуусгавар болсон үед Барьцаалуулагчид буцаан шилжүүлнэ гэж заажээ. Дээрхээс үзвэл, фидуцийн гэрээний дагуу Бэрс Финанс ББСБ ХХК нь зээлийн гэрээний үүрэг хангагдсан тохиолдолд тээврийн хэрэгслийн өмчлөлийг үүрэг гүйцэтгэгчид буюу зээлдэгчид буцаан шилжүүлэх үүрэг хүлээж байна. Иймд, зээлийн гэрээний дагуу үүрэг гүйцэтгэгч нь үндсэн зээлдэгч, эсхүл хамтран зээлдэгчийн хэн байгаагаас үл шалтгаалан зээлийн гэрээний үүрэг гүйцэтгэж буй этгээдэд (ихэвчлэн үндсэн зээлдэгч) тээврийн хэрэгслийн өмчлөх эрхийг буцаан шилжүүлэх үүрэг хүлээж байна. Гэвч Бэрс Финанс ББСБ нь зээлийн төлбөрийг үндсэн эсхүл хамтран зээлдэгчийн аль нь гүйцэтгэж байгаа болохыг тогтоох боломжгүй тул фидуцийн гэрээг баталгаажуулсан үндсэн зээлдэгчид буцаан шилжүүлдэг.</p> <p>Фидуцийн зүйл болох автомашиныг тээврийн хэрэгслийн гэрчилгээнд заасан арлын дугаараар тодорхойлох бөгөөд тээврийн хэрэгслийн улсын дугаар өөрчлөгдсөнийг зээлийн гэрээ, барьцааны гэрээ (фидуцийн гэрээ)-нд оруулаагүй нь зөрчил болохгүй.</p> <p>Зээлийн гэрээ, барьцааны гэрээ (фидуцийн гэрээ)-нд зээлдэгчийн оршин суугаа хаягийг оршин суугаа газрын тодорхойлолтоор бус иргэний үнэмлэхийн хаягаар бичсэн тохиолдолд зөрчил гэж үзэхгүй.</p> <p>Зээлийн гэрээ, барьцааны гэрээ (фидуцийн гэрээ)-нд үндсэн болон хамтран зээлдэгчийн хаягийг тусгахдаа утгад нөлөөлөхгүй, илт алдаатай бус техникийн алдаа гаргасан тохиолдолд хүлээн зөвшөөрнө.</p> <p>Талууд зээлийн гэрээ, фидуцийн гэрээг Бэрс Финанс ББСБ ХХК-ийн салбарт биечлэн ирж байгуулж буй тул Зээлийн гэрээнд Зээлдүүлэгчийн оршин байгаа хаягийг бичээгүй байж болно.</p> <p>Зээлийн дансны дугаараар Зээлийн гэрээнд дугаар олгож буй тул тус гэрээнд зээлийн дансны дугаар оруулахгүй байж болно.</p> <p>Зарим зээлийн дансдын хувьд зээлийн үнийн дүнг “XXX” ХХК, эсхүл Монгол Улсын иргэн ХХХ буюу тээврийн хэрэгсэл нийлүүлэгчийн дансанд шилжүүлсэн тохиолдол илэрсэн. Бэрс Финанс ББСБ ХХК нь тээврийн хэрэгсэл нийлүүлэгч байгууллага болон хувь хүнтэй Хамтран ажиллах гэрээ байгуулж, автомашины зээлийн бүтээгдэхүүний хувьд зээлийн төлбөрийг нийлүүлэгчид дараа тооцоогоор шилжүүлж байхаар тохиролцсон байна. Хэдийгээр зээлийн төлбөрийг автомашин нийлүүлэгчийн дансанд шилжүүлэхийг талууд гэрээ (эсхүл тусгайлсан зөвшөөрөл бүхий бичиг)-ээр тохиролцсон боловч зээлийн гэрээ нь бодиг хэлцэлд хамаарахын хувьд зээлийн төлбөрийг зээлдэгчийн дансанд шилжүүлж байх нь зүйтэй байна.</p>
6	Бусад	<p>Зарим зээлийн данс, хувийн хэрэгт авагдсан баримт бичиг нь “Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай” хууль ( шинэчилсэн найруулга) 2021.07.01-нд хүчин төгөлдөр болсноос хойш олгогдсон боловч уг хуулийн 20.2, 22.2-22.5 дахь заалтын шаардлагыг бүрэн хангаагүй, уг хууль хүчин төгөлдөр болохоос өмнө үйлчилж байсан хуульд нийцүүлсэн байж болно.</p>

---oOo---

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ  
MONGOLIAN STOCK EXCHANGE  
2023-04-06  
БҮРТГЭВ 3-02

СЗХ  
он 2023 сар 06, өдөр:  
БҮРТГЭВ  
№ 1



Сонгогдсон зээлүүдэд  
гүйцэтгэсэн харилцан тохиролцсон  
ажил үйлчилгээний

үр дүнгийн тайлан





## ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН


### **Бэрс Финанс ББСБ ХХК-д,**

Бид харилцан тохиролцсон ажил үйлчилгээний дагуу 2022 оны 11 сарын 03-ны (цаашид "тасалбар болгосон өдөр" гэх) байдлаарх Бэрс Финанс ББСБ ХХК-ийн (цаашид "анхны үүрэг гүйцэтгүүлэгч" гэх) олгосон зээлүүдээс Хавсралт А-д заасан шалгууруудын дагуу сонгосон 119 зээлд хийсэн шалгалтын үр дүнг дор тайлагналаа. Бидний гүйцэтгэсэн ажил нь Хамааралтай Ажил Үйлчилгээний Олон Улсын Стандарт 4400 'Харилцан Тохиролцсон Ажил Үйлчилгээ'-ний дагуу хийгдсэн болно. Бидний гүйцэтгэсэн процедурууд нь зөвхөн сонгогдсон зээлүүд нь Бэрс Финанс ББСБ ХХК (цаашид "Бэрс Финанс" гэх)-ийн удирдлагаас тодорхойлсон 6 санхүүгийн шалгууруудыг хангаж байгаа эсэхийг үнэлэхэд та бүхэнд туслах зорилготойгоор хийгдсэн бөгөөд гүйцэтгэсэн процедуруудыг хураангуйлан үзүүлбэл доорхи байдалтай байна.

Доорхи гүйцэтгэсэн ажлууд болон үр дүн нь зөвхөн зээлийн хувийн хэрэгт хавсаргасан баримтууд дээр үндэслэсэн болно.

### **Зээлийн файлуудыг шалгахад хийж гүйцэтгэсэн ажлууд**

1. Бид Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэх хөрөнгийн мэдээлэл нь зээлийн хувийн хэрэг дэх үндсэн баримттай нийцэж байгаа эсэхийг тодорхойлохын хүчин төгөлдөр, гарын үсэгтэй зээлийн гэрээ (цаашид "ЗГ" гэх)-г шалгасан.
2. Зээл нь Монгол төгрөгөөр олгогдсон бөгөөд Монгол төгрөгөөр эргэн төлөгдөх зээл болохыг тодорхойлохын тулд бид ЗГ болон зээлийн дансны хуулгыг шалгасан.
3. Зээлийн эргэн төлөлтийн хуваарьт зээлдэгчийн сар бүр төлөх дүнг (төлж дуусгах хугацаа) тусгасан байх, зээл нь зээлийн хугацааны эцэст бүрэн төлөгдөж дуусах эсэхийг тодорхойлохын тулд ЗГ-нд тусгагдсан сар бүрийн эргэн төлөлтийн хуваарийг шалгасан.
4. Үндсэн үүрэг гүйцэтгэгчийн даатгал хүчинтэй эсэхийг тодорхойлохын тулд гэрээт баталгааг шалган хамгийн багадаа 2022 оны 11 дүгээр сарын 03-ныг дуустал хүчинтэй эсэхийг шалгасан.
5. Зээл нь тасалбар болгосон өдрийн байдлаар хэвийн төлөлттэй бөгөөд сар бүрийн төлбөр ЗГ-нд тусгагдсан төлбөрийн хуваарийн дагуу бүрэн төлөгдөж байгааг тодорхойлохын тулд зээлийн дансны хуулга болон ЗГ-г шалгасан.
6. Зээлийг Гүйцэтгэх захирлын 2021 оны 5-р сарын 20-ны өдрийн 21/17А/42 тоот тушаалаар баталсан "Зээлийн үйл ажиллагааны журам"-ын дагуу үүсгэсэн байх бөгөөд зээлийн стандарт нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн дотооддоо хэрэгжүүлдэг ерөнхий стандартаас дутуугүй шалгууруудыг хангасан болохыг тодорхойлохын тулд бид дараах процедуруудыг гүйцэтгэсэн:



- 6.1 Тасалбар болгосон өдрийн байдлаар зээлдэгчийн өр орлогын харьцаа (ӨОХ) 55%-с хэтрээгүй болохыг тодорхойлохын тулд зээлийн хувийн хэрэгт хавсаргасан ЗГ болон зээлдэгчийн гаргаж өгсөн орлого болон зээлийн мэдээллийн сангийн мэдээллийг шалгасан. Жич: ӨОХ-г Бэрс Финанс-ын тодорхойлсон доорх томъёоны дагуу бодсон болно.

$$\text{ӨОХ} = \frac{\text{Зээлийн сарын төлбөр} + \text{Бусад зээлийн сарын төлбөр}}{\text{Өрхийн сарын орлого (татвараас өмнөх)}} \leq 55\%$$

- 6.2 Тасалбар болгосон өдрөөрх зээл үнэлгээний харьцаа (ЗҮХ) 75%-с хэтрээгүй болохыг тодорхойлохын тулд анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн бэлтгэсэн үнэлгээний хуудас, шинэ автомашин худалдан авах зээлийн хувьд худалдах, худалдан авах гэрээ болон ЗГ-г шалгасан. Жич: ЗҮХ-г Бэрс Финанс-ын тодорхойлсон доорх томъёоны дагуу бодсон болно;

$$\text{ЗҮХ} = \frac{\text{Тасалбар болгосон өдрийн байдлаарх үндсэн зээлийн өрийн хэмжээ}}{\text{Үндсэн барьцаа хөрөнгийн үнэлгээ} + \text{Пэмэлт барьцаа хөрөнгийн үнэлгээ}} \leq 75\%$$

- 6.3 Барьцаа хөрөнгийн үйлдвэрлэсэн он нь 2000 оноос хойш, импортлосон он нь 2010 оноос хойш, Япон болон Солонгос улсад үйлдвэрлэгдсэн суудлын тэрэг, 1,5 тонноос ихгүй ачааны тэрэг болохыг тодорхойлохын тулд авто тээврийн хэрэгслийн гэрчилгээний хуулбарыг шалгасан.

- 6.4 Зээл олгосон өдрийн байдлаар үндсэн болон хамтран зээлдэгчид нь 12 сараас багагүй хугацаанд тус тус хөдөлмөрийн гэрээний дагуу ажиллаж байгаа, эсхүл төрийн албан хааж байгаа, хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа бөгөөд сүүлийн дараалсан 6 сарын баталгаажсан орлогоо Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн зөвшөөрөхүйц хэлбэрээр гарган өгсөн болохыг тодорхойлохын тулд дансны хуулга, хар дэвтэр, түрээсийн гэрээ, хамтын ажиллагааны гэрээ, нийгмийн даатгалын дэвтэр эсвэл Хур систем болон ТҮЦ машины лавлагаа зэргийг шалгасан. Харилцагч нь бизнесийн орлоготой бол багадаа сүүлийн 6 сарын дансны хуулга, цалингийн орлоготой тохиолдолд ХУР системийн нийгмийн даатгалын мэдээллээр орлогыг баталгаажуулсан.

## Үр Дүн

Ажлын үр дүнг тайлагнавал:

Дээр жагсаасан 1-6 дугаар процедуруудын үр дүнг дэлгэрэнгүйгээр Хавсралт Б-д харуулав.

а) Нэгдүгээр шаардлагын хувьд, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэх хөрөнгийн мэдээлэл нь зээлийн хувийн хэрэг дэх үндсэн баримттай нийцсэн ба хүчин төгөлдөр, гарын үсэгтэй зээлийн гэрээтэй байсан.

б) Хоёрдугаар шаардлагын хувьд, Монгол төгрөгөөр олгогдсон бөгөөд Монгол төгрөгөөр эргэн төлөгдөх хуваарьтай байсан.

в) Гуравдугаар шаардлагын хувьд, зээлийн эргэн төлөлтийн хуваарьт зээлдэгчийн сар бүр төлөх дүнг тусгасан, зээл нь зээлийн хугацааны эцэст бүрэн төлөгдөж дуусахаар тусгасан байсан.

г) Дөрөвдүгээр шаардлагын хувьд, үндсэн үүрэг гүйцэтгэгчид нь автомашин худалдан авалтын зээлийн хувьд жолоочийн хариуцлагын албан журмын даатгал болон тээврийн хэрэгслийн даатгал,



автомашин барьцаалсан зээлийн хувьд жолоочийн хариуцлагын албан журмын даатгал хийлгэсэн бөгөөд шинжилгээ хийх өдрийн байдлаар даатгалын гэрээ нь хүчин төгөлдөр байсан.

д) Тавдугаар шаардлагын хувьд, зээл нь шинжилгээ хийх өдрийн байдлаар дараах зээлдэгчдээс бусад зээлдэгч хуваарьт төлбөрийн зөрчилгүй байсан.

Зээлийн дансны дугаар	Зээлдэгчийн нэр	Зээлдэгчийн овог	Зээлдэгчийн регистрийн дугаар	Салбар
2101130101012584	БАТМАНДАЛ	БАТЖАРГАЛ	УЗ89062110	ХАН-УУЛ

е) Зургаадугаар шаардлагын хувьд, зээлийг Гүйцэтгэх захирлын 2021 оны 5-р сарын 20-ны өдрийн 21/17А/42 тоот тушаалаар баталсан "Зээлийн үйл ажиллагааны журам"-ын дагуу үүсгэсэн ба зээлийн стандарт нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн дотооддоо хэрэгжүүлдэг ерөнхий стандартаас дутуугүй шалгууруудыг хангасан байсан. Тухайлбал:

- i. Тасалбар болгосон өдрийн байдлаар дараах зээлдэгчдээс бусад зээлдэгчдийн өр орлогын харьцаа (ӨОХ) 55%-с хэтрээгүй байсан. Жич: Гүйцэтгэх захирлын 2021 оны 5-р сарын 20-ны өдрийн 21/17А/42 тоот тушаалаар баталсан "Зээлийн үйл ажиллагааны журам"-ын дагуу 5 сая төгрөг болон түүнээс доош дүнтэй зээл олгоход орлого нотлохгүй ба өр орлогын харьцаа тооцох шаардлагагүй тул 5 сая төгрөг болон түүнээс доош дүнтэй зээлийн хувьд энэхүү шаардлагыг харгалзан үзээгүй болно.

Зээлийн дансны дугаар	Зээлдэгчийн нэр	Зээлдэгчийн овог	Зээлдэгчийн регистрийн дугаар	Салбар
2101130101021184	БЭРХБИЛЭГ	ХИШИГДҮҮРЭН	УВ86101811	ХАН-УУЛ
2101130110003396	ЖАРГАЛ	БАЯРАА	ОЗ90011111	УВС
2101130101021186	ДАРЬМАА	БАЛТ	ЕГ94112203	ДОРНОГОВЬ
2101130101024051	БАТТУЛГА	ДҮГЭРЖАВ	ОО68070117	СҮХБААТАР
2101130101018275	ГОНЧИГДАМИРАН	ЭРДЭНЭХҮЯГ	ЛЮ01250219	СҮХБААТАР
2101130101024435	ДАВААДОРЖ	ЦЭВЭЭНБУД	КЮ72021412	ӨМНӨ-ГОВЬ
2101130101022412	ГАНЧИМЭГ	БААСАН	РЭ71122669	ХӨВСГӨЛ
2101130101024632	БАТЗОРИГ	АРИУНБОЛД	УЗ96041213	ЭРДЭНЭТ
2101130101024052	НАРМАНДАХ	БАТСУУРЬ	РН90051977	ХӨВСГӨЛ
2101130101024609	ӨЛЗИЙСАЙХАН	ИҮРЭВДАШ	МЮ76091477	СЭЛЭНГЭ
2101130101024422	ЗОЛБОО	ИДЭШ	ПБ68081065	ХОВД
2101130110001425	ТУНГАЛАГ	ЖАМАА	ГИ64050103	ЭРДЭНЭТ

- ii. Тасалбар болгосон өдрийн байдлаар зээл үнэлгээний харьцаа (ЗҮХ) 75%-с хэтрээгүй байсан. Жич: Гүйцэтгэх захирлын 2021 оны 5 сарын 21-ний өдрийн 21/17А/50 тоот тушаалын 1-д дугааргүй автомашин худалдан авалтын зээлийн урьдчилгаа төлбөр 20% гэж заасан тул уг тушаалаас хойш олгогдсон дугааргүй автомашин худалдан авалтын зээлийн хувьд энэхүү шаардлагыг харгалзан үзээгүй болно.
- iii. Зээлийн барьцаа хөрөнгүүд нь барьцаа хөрөнгийн шалгуурыг хангасан байсан.
- iv. Зээл олгосон өдрийн байдлаар үндсэн болон хамтран зээлдэгчид нь 12 сараас багагүй хугацаанд тус тус хөдөлмөрийн гэрээний дагуу ажилласан ба хувиараа хөдөлмөр эрхэлдэг үүрэг гүйцэтгэгч нь сүүлийн дараалсан 6 сарын баталгаажсан орлогоо Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид зөвшөөрөхүйц хэлбэрээр гарган өгсөн байсан. Жич: Гүйцэтгэх захирлын 2021 оны 5-р сарын 20-ны өдрийн 21/17А/42 тоот тушаалаар баталсан "Зээлийн үйл ажиллагааны журам"-ын дагуу 5 сая төгрөг болон



түүнээс доош дүнтэй зээл олгоход орлого нотлох баримт шаарддаггүй тул 5 сая төгрөг болон түүнээс доош дүнтэй зээлийн хувьд энэхүү шаардлагыг харгалзан үзээгүй болно.

Бид та бүхэнтэй харилцан тохиролцон гүйцэтгэсэн процедурууд нь ажил үйлчилгээний хангалттай байдлын талаар ямар нэгэн мэдэгдэл гаргахгүй. Цаашлаад бид зөвхөн энэхүү тайлангийн үр дүнг тайлагнасан бөгөөд бид ямар нэгэн материаллаг зөрчил илрээгүй байх магадлалын талаар мэдэгдэл гаргахгүй.

Бэрс Финанс-ын санхүү болон нягтлан бодох бүртгэлийн асуудлуудыг эрхэлсэн захирлууд болон удирдлага нь зээлүүдийн жагсаалт болон өгсөн мастер файлын мэдээллүүд нь Бэрс Финанс-ын бүртгэл дэх дүнгүүдээс бэлтгэгдсэн болохыг бидэнд мэдэгдсэн.


Бидний гүйцэтгэсэн ажил нь Аудитын Олон Улсын Стандарт болон Нягтлах Үйлчилгээний Олон Улсын Стандартын дагуу аудит эсвэл хянах үйл ажиллагаанд тус тус хамаарахгүй тул бид сонгогдсон зээлүүдэд гүйцэтгэсэн процедуруудад аливаа баталгаа гаргахгүй болно.

Хэрэв бид нэмэлт процедур гүйцэтгэсэн эсвэл Аудитын Олон Улсын Стандарт эсвэл Нягтлах Үйлчилгээний Олон Улсын Стандартын дагуу зээлүүдэд аудит эсвэл хяналт хийсэн бол та бүхэнд тайлагнах өөр асуудлууд илэрч болох байсныг анхаарна уу.

Бидний тайлан нь гагцхүү энэхүү тайлангийн нэгдүгээр хэсэгт дурдсаны дагуу та бүхэнд мэдээлэл өгөх зорилготой бөгөөд өөр зорилгоор, биднээс урьдчилж бичгээр зөвшөөрөл авалгүйгээр хэн нэгэнд өгөх, ашиглуулах, иш татах (бүхэлд нь эсвэл хэсэгчлэн), дамжуулах болон аливаа бусад этгээдэд түгээхийг хориглоно. Энэхүү тайлан нь зөвхөн дээр сонгогдсон зээлүүдтэй холбоотой ба анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн олгосон нийт зээлүүдтэй холбоогүй болно.



Шагдарсүрэнгийн Норжинбат  
Гүйцэтгэх захирал  
Онч Аудит ХХК  
2022 оны 12-р сарын 26



## Хавсралт А

### Түүвэр сонголт

Бид нийт 2,160 зээлээс итгэлцлийн түвшин 95%, байж болох хамгийн их алдаа 10% (БХИА), хүлээгдэж буй алдаа 5% гэсэн үзүүлэлтүүдийг авч үзсэний үр дүнд түүврийн хэмжээ болох 119 зээлийн тоог тодорхойлсон.

	Итгэлцлийн түвшин 95%		
	БХИА 10%	БХИА 15%	БХИА 20%
Түүврийн хэмжээ	119	52	32
Алдааны дээд хэмжээ	6	3	2

Зээлүүдийг сонгоход дараах шалгуур үзүүлэлтүүдийг харгалзаж үзсэн:

**Шалгуур үзүүлэлт – 1:** Салбар бүрээс багадаа хоёр зээл хамрагдсан байх;

**Шалгуур үзүүлэлт – 2:** Зээлийн үлдэгдлийн хэмжээг харгалзахгүй бөгөөд сонголтоос хамааран хөдөө орон нутагт олгосон түүвэрт сонгогдох боломжгүй тохиолдолд хамгийн их үлдэгдэлтэй зээлээс эхлэн сонгох;

**Шалгуур үзүүлэлт – 3:** Түүврээр сонгогдсон зээлийн хөрөнгийн багц нь, Улаанбаатар хот болон хөдөө орон нутагт зээлийн барьцаа хөрөнгө нь байршилтай зээлийн тоо нь нийт багцын бүтэцтэй ойролцоо байх;

**Шалгуур үзүүлэлт – 4:** Зээл Үнэлгээний Харьцаа (ЗҮХ) өндөр зээлийн дансдыг түүвэрт аль болох ихээр хамруулах;

**Шалгуур үзүүлэлт – 5:** Өр Орлогын Харьцаа (ӨОХ) өндөр зээлийн дансдыг түүвэрт аль болох ихээр хамруулах;

**Хавсралт Б**

**Зээлийн хувийн хэргүүдэд гүйцэтгэсэн ажлын хураангуй (1-6 дугаар процедурууд)**

**Процедуруудын Хүснэгтчилсэн Хураангуй**

No.	Зээлийн дансны дугаар	Бэрс Финанс ББСБ ХХК-ийн шалгуурууд										
		1	2	3	4	5	6	6.1	6.2	6.3	6.4	
1	2101130101023401	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
2	2101130110003322	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
3	2101130101021184	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
4	2101130101020411	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
5	2101130110003113	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
6	2101130110003489	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
7	2101130101024533	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
8	2101130101022075	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
9	2101130110003221	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
10	2101130101023048	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
11	2101130110002538	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
12	2101130110003396	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
13	2101130110003044	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
14	2101130101023889	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
15	2101130101021186	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
16	2101130110003589	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
17	2101130110003570	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
18	2101130101012584	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
19	2101130110003466	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
20	2101130110003231	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
21	2101130101022070	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
22	2101130110003625	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
23	2101130101023397	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
24	2101130110003567	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
25	2101130101023612	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
26	2101130110003511	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
27	2101130101023749	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
28	2101130101023678	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
29	2101130110001073	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
30	2101130101022267	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
31	2101130101022505	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
32	2101130101024567	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
33	2101130101023795	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
34	2101130101022839	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
35	2101130110002945	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
36	2101130101024142	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
37	2101130101024608	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
38	2101130101022802	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
39	2101130101024051	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
40	2101130101019945	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
41	2101130110003381	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
42	2101130101018275	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
43	2101130101024752	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
44	2101130101024601	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
45	2101130101022514	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
46	2101130110003319	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
47	2101130110002398	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
48	2101130110003278	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
49	2101130101023734	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
50	2101130101024218	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
51	2101130110003484	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
52	2101130101023621	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
53	2101130101024435	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
54	2101130101023471	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
55	2101130110003523	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
56	2101130101024256	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
57	2101130101020008	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
58	2101130101024667	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
59	2101130110003060	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
60	2101130101023066	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓




**Хавсралт Б**

**Зээлийн хувийн хэргүүдэд гүйцэтгэсэн ажлын хураангуй (1-6 дугаар процедурууд)**

**Процедуруудын Хүснэгтчилсэн Хураангуй**

No.	Зээлийн дансны дугаар	Бэрс Финанс ББСБ ХХК-ийн шалгуурууд										
		1	2	3	4	5	6	6.1	6.2	6.3	6.4	
61	2101130101024081	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
62	2101130110003470	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
63	2101130101022707	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
64	2101130110002986	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
65	2101130101022412	✓	✓	✓	✓	✓	✓	✗	✓	✓	✓	✓
66	2101130110003435	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
67	2101130101022593	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
68	2101130101024328	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
69	2101130001000037	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
70	2101130110003447	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
71	2101130110003058	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
72	2101130101021326	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
73	2101130110003430	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
74	2101130101024436	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
75	2101130110003614	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
76	2101130101024643	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
77	2101130101023814	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
78	2101130110003293	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
79	2101130101023993	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
80	2101130110003446	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
81	2101130101024632	✓	✓	✓	✓	✓	✓	✗	✓	✓	✓	✓
82	2101130101024052	✓	✓	✓	✓	✓	✓	✗	✓	✓	✓	✓
83	2101130101023535	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
84	2101130110003370	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
85	2101130110000854	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
86	2101130101022394	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
87	2101130101022062	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
88	2101130110003488	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
89	2101130101024663	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
90	2101130110002868	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
91	2101130101023209	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
92	2101130101023447	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
93	2101130110003020	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
94	2101130101024558	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
95	2101130101020022	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
96	2101130101023504	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
97	2101130110003612	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
98	2101130110001345	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
99	2101130101022692	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
100	2101130101023645	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
101	2101130101024609	✓	✓	✓	✓	✓	✓	✗	✓	✓	✓	✓
102	2101130101024010	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
103	2101130110000836	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
104	2101130110001332	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
105	2101130101022695	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
106	2101130101024017	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
107	2101130101024377	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
108	2101130101021322	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
109	2101130110003410	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
110	2101130110003606	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
111	2101130101024422	✓	✓	✓	✓	✓	✓	✗	✓	✓	✓	✓
112	2101130101024101	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
113	2101130110003139	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
114	2101130110001425	✓	✓	✓	✓	✓	✓	✗	✓	✓	✓	✓
115	2101130101021879	✓	✓	✓	✓	✓	✓	✗	✓	✓	✓	✓
116	2101130110003526	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
117	2101130101023860	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
118	2101130101024696	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
119	2101130101024455	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓



## АНДЕРРАЙТЕРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ

2023 оны 02 сарын 09 өдөр

Дугаар: 28/1538

Улаанбаатар хот

Энэхүү Андеррайтерийн үйлчилгээний гэрээ (цаашид “Гэрээ” гэх)-г Монгол Улсын Иргэний хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржээс гаргасан тогтоол, журам, заавар болон бусад энэ төрлийн харилцааг зохицуулсан холбогдох эрх зүйн актуудыг үндэслэн,

Нэг талаас “БЭРС ФИНАНС ББСБ” ХХК (цаашид “Компани” гэх), түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал С.ОТГОНБАТ,

“БЭРС ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК” ХХК (цаашид “ТЗК” гэх), түүнийг төлөөлж Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Б.БОЛОР-ЭРДЭНЭ,

### БОЛОН

Нөгөө талаас “ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК” ХХК (цаашид “Андеррайтер” гэх), түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал С. ГАН-ЭРДЭНЭ (цаашид гэрээ байгуулагч талуудыг хамтад нь “Талууд”, тусад нь “Тал” гэх) нар нь дараах нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ



### 1.1. Гэрээний зорилго:

Андеррайтер нь Үнэт цаас гаргагчид хөрөнгийн зах зээлээс 9,000,000,000 /есөн тэрбум/ төгрөг хүртэлх хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг олон нийтэд санал болгох, худалдах ажлыг удирдан зохион байгуулах, хөрөнгийн зах зээлээс санхүүжилт татан төвлөрүүлэхэд шаардлагатай магадлан шинжилгээ, тооцоолол, судалгаа, бэлтгэл ажлуудыг гүйцэтгэх, боломжит хөрөнгө оруулагчдад Үнэт цаас гаргагч, түүний олон нийтэд санал болгож буй үнэт цаасыг танилцуулах, санал болгох зэрэг мэргэжлийн үйлчилгээг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн үзүүлэх;

Компани, ТЗК нь Андеррайтерийг Гэрээгээр хүлээсэн ажлаа гүйцэтгэхэд нь бүрэн дэмжин ажиллаж, шаардлагатай бүх санхүүгийн тайлан тэнцэл болон бусад бичиг баримт, материалыг гарган өгч хамтран ажиллахаар харилцан тохиролцсонтой холбоотой талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

### 1.2. Талууд Гэрээний зорилгоо хэрэгжүүлэх явцад бие биенийхээ хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хүндэтгэх, хамгаалах болон шударга байх зарчмыг баримтлан ажиллана.

### 1.3. Талуудын мэдээлэл:



Компани: “БЭРС ФИНАНС ББСБ” ХХК

Регистрийн дугаар: 6186858  
Хаяг: Улаанбаатар, Сүхбаатар, 11-р хороо, 7 хороолол, ногоон  
нуур, 101 барилга, 706 тоот  
Утас/Факс: 7712-2020

ТЗК: “БЭРС ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК” ХХК

Регистрийн дугаар: 6949886  
Хаяг: Улаанбаатар, Сүхбаатар, 11-р хороо, 7 хороолол, ногоон  
нуур, 101 барилга, 706 тоот  
Утас/Факс: 99119632



Андеррайтер: “ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК” ХХК

Регистрийн дугаар: 5481589  
Хаяг: Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн  
өргөн чөлөө 24, Парк плэйс оффис, 403 тоот;  
Утас/Факс: 7012-1530

### ХОЁР. НЭР ТОМЬЁНЫ ТАЙЛБАР

- 2.1 Энэхүү гэрээнд дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:
- 2.1.1. “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас” гэж Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх заалтад заасан үнэт цаасыг;
  - 2.1.2. “Баталгаат үнэт цаас” гэж Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх заалтад заасан үнэт цаасыг;
  - 2.1.3. “Тусгай зориулалтын компани” гэж Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх заалтад заасан этгээд буюу СЗХ-ны тусгай зөвшөөрөлтэй “Бэрс Эй Би Эс Плас ТЗК” ХХК (цаашид “ТЗК” гэх);
  - 2.1.4. “Үнэт цаас гаргагч” гэж Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг гаргаж буй СЗХ-ны тусгай зөвшөөрөлтэй ТЗК-г;
  - 2.1.5. “Үүсгэн байгуулагч” гэж Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4 дэх шаардлагыг хангасан, ТЗК-г үүсгэн байгуулсан эрх бүхий этгээд буюу “Бэрс Финанс ББСБ” ХХК-г;
  - 2.1.6. “Анхны үүрэг гүйцэтгүүлэгч” гэж өөрийн санхүүгийн тайлан, тэнцэлд туссан хөрөнгийг ТЗК-д шилжүүлсэн, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд буюу Компанийг;
  - 2.1.7. “Үнэт цаасны танилцуулга” гэж үнэт цаасны захиалга авах, худалдах зорилгоор үнэт цаас гаргагч болон Андеррайтерийн зүгээс холбогдох хууль, тогтоомжид заасан журмын дагуу СЗХ болон МХБ-д үнэт цаасыг бүртгүүлэх зорилгоор бэлтгэсэн танилцуулга, баримт бичгийн иж бүрдлийг;
  - 2.1.8. “Хөрөнгө оруулагч” гэж хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас өмчлөгч иргэн, хуулийн этгээд буюу, түүний өв, эсхүл эрх залгамжлагчийг;
  - 2.1.9. “Андеррайтерийн үйл ажиллагаа” гэж үнэт цаас гаргагч, үүсгэн байгуулагчтай байгуулсан гэрээний дагуу үнэт цаасны танилцуулгыг бэлтгэх, үнэт цаас






- худалдан авах, худалдах, эсхүл үнэт цаас гаргагчийн нэрийн өмнөөс олон нийтэд нээлттэйгээр санал болгох, танилцуулах, арилжих, үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг хийж гүйцэтгэхэд шаардлагатай бусад ажиллагааг;
- 2.1.10. “Нууц мэдээлэл” гэж Талууд хоорондоо солилцсон аливаа төрлийн нийтэд ил болоогүй мэдээлэл, ноу-хау, бизнесийн чухал мэдээлэл, төлөвлөгөө, харилцагчийн мэдээлэл, санхүүгийн мэдээлэл зэрэг баримт бичиг, мэдээллийг;
  - 2.1.11. “Анхдагч зах зээлийн арилжааг амжилттай хэрэгжүүлэх” гэж Үнэт цаас гаргагч анхдагч зах зээл дээрээс татан төвлөрүүлэхээр төлөвлөсөн хөрөнгийг амжилттай бүрдүүлэх;
  - 2.1.12. “СЗХ” гэж Санхүүгийн Зохицуулах Хороог;
  - 2.1.13. “МХБ” гэж олон нийтэд шинээр санал болгох үнэт цаасыг гаргах бирж болох Монголын Хөрөнгийн Биржийг;
  - 2.1.14. “ҮЦТХТ” гэж “Үнэт цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв” ХХК-ийг;
  - 2.1.15. “Эрх бүхий этгээд” гэж СЗХ, МХБ, ҮЦТХТ зэрэг нээлттэй зах зээлд хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гарган арилжаалахтай холбоотой ажилд зохицуулагчийн үүрэгтэй оролцож байгаа болон бусад төрийн эрх бүхий байгууллагыг тус тус ойлгоно.

### ГУРАВ. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

- 3.1 Гэрээнд талуудын эрх бүхий албан тушаалтнууд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.
- 3.2 Гэрээг аль нэг талын санаачилгаар цуцалсан эсхүл талууд харилцан тохиролцож дуусгавар болгосноос бусад тохиолдолд талуудын гэрээний дагуу хүлээсэн үүрэг, хамтын ажиллагааны зорилго бүрэн биелснээр Гэрээ дуусгавар болно.

### ДӨРӨВ. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨР

- 4.1 Андеррайтерийн нийт үйлчилгээний төлбөр нь Гэрээний 4.2-т заасан тогтмол төлбөр болон Гэрээний 4.5-т заасан хувьсах төлбөрөөс бүрдэнэ. Андеррайтерийн үйлчилгээний төлбөрт НӨАТ болон холбогдох бусад татвар хураамж, бүх зардал багтсан болно.
- 4.2 Андеррайтераас үзүүлж буй үйлчилгээний тогтмол төлбөр нь ТЗК-д шаардлагатай нийт санхүүжилтийг татан төвлөрүүлсэн эсэхээс үл хамаарсан, Хавсралт №1-д тусгагдсан анхдагч зах зээлийн арилжаа зохион байгуулагдах хүртэлх Андеррайтерийн үзүүлэх төлөвлөгөөт ажлын төлбөр буюу **20,000,000 /хорин сая төгрөг/** байна.
- 4.3 Үнэт цаас гаргах ажиллагаа явагдаж СЗХ болон МХБ-ээс холбогдох зөвшөөрөл гарсны дараа Андеррайтерийн буруутай үйлдлээс үл шалтгаалан Компани, ТЗК-ийн санаачилгаар энэхүү гэрээг түдгэлзүүлсэн эсхүл цуцалсан тохиолдолд үйлчилгээний тогтмол төлбөрийг буцаан олгохгүй.
- 4.4 Гэрээний 4.2-т заасан тогтмол төлбөрийн 50 хувийн урьдчилгаа төлбөрийг гэрээ байгуулагдсан өдрөөс хойш ажлын 3 /гурав/ өдрийн дотор, үлдэгдэл төлбөрийг Гэрээнд заасан үйлчилгээг бүрэн үзүүлж дууссан буюу энэ Гэрээний 4.6 дахь хэсгийн дагуу гэрээт ажлыг дүгнэх акт үйлдэн Талууд гарын үсэг зурж баталгаажуулснаас хойш ажлын 3 /гурав/ өдрийн дотор Андеррайтерийн нэхэмжлэхийг үндэслэн доорх дансанд төлнө.





Банкны нэр:	Голомт банк
Дансны дугаар:	2005002269 /MNT/
Данс эзэмшигч:	Голомт Капитал ҮЦК

- 4.5 Үнэт цаасыг нийтэд санал болгох андеррайтерийн үйлчилгээний хувьсах төлбөр нь хөрөнгө оруулагчдаас татан төвлөрүүлсэн дүнгийн 2.2 /хоёр бүхэл аравны хоёр/ хувьтай тэнцүү байна.
- 4.6 Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа амжилттай явагдаж татан төвлөрүүлсэн хөрөнгө ТЗК-ийн дансанд бүрэн шилжсэний дараа Талууд гэрээ дүгнэх акт үйлдэж, гарын үсгээр баталгаажуулна. Гэрээ дүгнэх акт үйлдсэнээс хойш ажлын 3 /гурав/ хоногийн дотор Гэрээний 4.4-т заасан тогтмол төлбөрийн үлдэгдэл төлбөр, 4.5-д заасан хувьсах төлбөрийг Гэрээний 4.4-т заасан Андеррайтерийн дансанд төлнө.
- 4.7 Компани нь Гэрээний зорилтод заасан үр дүнг бий болгохтой холбоотой дараах төлбөр, зардлуудыг бүрэн хариуцна. Үүнд:
- 4.7.1 Компани нь Үнэт цаасыг нийтэд санал болгох үйл ажиллагаатай холбоотойгоор Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, СЗХ болон МХБ-ийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн холбогдох журмын дагуу хөндлөнгийн дүгнэлт гаргах байгууллагуудтай гэрээ байгуулан ажиллах ба хөндлөнгийн дүгнэлт гаргах байгууллагуудын тайлан, дүгнэлт гаргахтай холбоотой зардлыг бүрэн хариуцна.
- 4.7.2 Компани нь Гэрээний зорилтод заасан үр дүнг бий болгохтой холбоотой өөрийн бүрэн эрхийн хүрээнд Маркетинг, PR-ийн сурталчилгаа явуулах, үйл ажиллагаа зохион байгуулах, Үнэт цаас танилцуулах аян зохион байгуулах зэрэгтэй холбоотой зардлыг бүрэн хариуцна. Андеррайтерийн зүгээс авч хэрэгжүүлэх Маркетинг, PR-тай холбоотой Компанид өгсөн санал, зөвлөмж, өөрийн боломжит олон нийтийн сувгуудаар танилцуулах, боломжит хөрөнгө оруулагчтай Компанийг төлөөлөн холбогдох зэрэг үйл ажиллагаа нь Компанийн энд заасан хариуцах ажилд хамаарахгүй болно.
- 4.7.3 Компани нь үнэт цаасыг нийтэд гаргах үйл ажиллагаатай холбогдуулан СЗХ, МХБ, МҮЦКТ, ҮЦГХТ зэрэг бүх эрх бүхий этгээдүүд болон бусад төрийн байгууллагуудын бусад шимтгэл, татвар, хураамжийг холбогдох хууль, журамд заасны дагуу тухай бүр бүрэн хариуцан төлнө.


#### **ТАВ. КОМПАНИ БОЛОН ТЗК-ИЙН ЭРХ, ҮҮРЭГ**

- 5.1 ТЗК болон Компанийн эрх:
- 5.1.1 Үнэт цаас гаргах, түүний танилцуулга бэлтгэх, олон нийтэд хувьцааг санал болгох, худалдах, эзэмшүүлэх, хөрөнгө татан төвлөрүүлэх, хөрөнгө оруулагч татах үйл ажиллагааг мэргэжлийн өндөр түвшинд хэрэгжүүлэхийг Андеррайтераас шаардах;
- 5.1.2 Андеррайтерийн үйл ажиллагааны явцын талаар бүрэн мэдээлэл авч, үйлчилгээний явц, үр дүнд өөрийн зүгээс тайлбар санал өгөх;
- 5.1.3 Андеррайтерийн буруутай үйл ажиллагааны улмаас Компанид учирсан хохирол, түүнийг арилгахтай холбоотой зардлыг Андеррайтераас шаардах;





- 5.1.4 Андеррайтераас санал болгосон хөрөнгө оруулагч буюу түүний тавьж буй хөрөнгө оруулалтын санал нь энэхүү гэрээнд заасан нөхцөлтэй нийцэж байгаа эсэхээс үл хамааран Андеррайтераас санал болгосон хөрөнгө оруулагчтай гэрээ байгуулах, мөн тухайн хөрөнгө оруулалтыг хүлээн авахаас татгалзах;
- 5.1.5 Хууль болон гэрээнд заасан үндэслэлээр гэрээг цуцлах, татгалзах, дуусгавар болгох;
- 5.1.6 Хууль тогтоомжид заасан бусад эрх;
- 5.2 ТЗК болон Компанийн үүрэг:  
Компани нь энэхүү гэрээгээр тохирсон зардал, төлбөрийг хариуцаж тохиролцсон хугацаанд төлөх үүрэг хүлээнэ.
- 5.2.1 ТЗК нь дараах үүрэг хүлээнэ:
- 5.2.1.1 ТЗК нь Андеррайтерт ажил үүргээ гүйцэтгэхэд шаардагдах аливаа зөвшөөрөл, мэдээ мэдээлэл, баримт бичгийг заасан тухай бүрд бүрэн, үнэн зөв гаргаж өгөх;
- 5.2.1.2 Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах, Үнэт цаасжуулах үйл ажиллагаанд шаардлагатай тогтоол дүрмийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн батлах;
- 5.2.1.3 ТУЗ-ийг хуралдуулж Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг гаргах нөхцөлийг тодорхойлох, шийдвэрлэх;
- 5.2.1.4 Төлбөр гүйцэтгэх болон харилцах дансыг нээх, хуульд заасны дагуу ашиглах;
- 5.2.1.5 Үнэт цаасжуулах үйл ажиллагаатай холбоотойгоор Үнэт цаасжуулах үйл ажиллагаанд оролцогчид болон тэдгээрийн албан тушаалтан болон гэрээлэгчид заавал дагаж мөрдөх журмуудыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн батлах; /Үүнд: ТУЗ-ийн үйл ажиллагааны журам; Хөндлөнгийн аудиторыг сонгох, солих журам; Үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох, солих журам; Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагааны журам; Багцын хөрөнгөнд өөрчлөлт оруулах, хөрөнгийг багцаас хасах журам; Эрсдэлийн удирдлага, дотоод хяналт хэрэгжүүлэх, эрсдэлийн сан байгуулах, сангийн хөрөнгийг зарцуулах журам; Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлөх журам; Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргэх, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах журам тус тус багтана/
- 5.2.1.6 Үнэт цаасжуулах хэлцлийн оролцогчидтой холбогдох гэрээг байгуулах /Үүнд: Анхны үүрэг гүйцэлдүүлэгчтэй байгуулах Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ; Фидуцийн барьцааны гэрээ; Төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлэх гэрээ болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай байгуулах Хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээ үзүүлэх гэрээ болон Үйлчилгээ үзүүлэгчтэй байгуулах Төлбөр цуглуулах дансны барьцааны гэрээ, Захиргааны үйлчилгээний гэрээ, Зээлийн эргэн төлөлтийн дансны барьцааны гэрээ/, оролцогч этгээдийн талаарх мэдээллийг Андеррайтерт үнэн зөв мэдүүлэх;





- 5.2.1.7 Хөндлөнгийн аудитортой “Аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээ”, Зээлийн шинжилгээ гаргагчтай “Тохиролцсон горимоор ажил гүйцэтгэх гэрээ”, Үнэт цаасны зах зээлд хууль зүйн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хөндлөнгийн хуулийн компанитай “Хууль зүйн үйлчилгээ үзүүлэх гэрээ”-г тус тус байгуулах, оролцогч этгээдийн талаарх мэдээллийг Андеррайтерт үнэн зөв мэдүүлэх;
- 5.2.1.8 Үнэт цаас танилцуулах аяныг маркетингийн төлөвлөгөөний дагуу явуулахад шаардлагатай бүх мэдээлэл, нөхцөлөөр хангах; Стратегийн хөрөнгө оруулагчид болон олон нийтэд үнэт цаасыг танилцуулах аянд оролцох, танилцуулга хийх удирдах албан тушаалтан эсхүл мэргэжилтнүүдийг тодорхойлж Андеррайтертай хамтран ажиллуулах;
- 5.2.1.9 Гэрээний үүргээ зөрчсөний улмаас Андеррайтер болон аливаа гуравдагч этгээдэд учирсан хохирлыг бүрэн хариуцах;
- 5.2.1.10 Тогтоосон хугацаанд аливаа дотоод мэдээллийг Андеррайтертай зөвшилцөлгүйгээр олон нийтэд мэдээлсэн, түүний улмаас үнэт цаасны үнэлгээнд нөлөөлөх, хөрөнгө оруулалт, санхүүжилт татах ажиллагаанд саад учруулсан, хөрөнгө оруулагчдад буруу мэдээлэл хүргэсэн болон бусад байдлаар Андеррайтерийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд саад учруулсан тохиолдолд учирсан хохирлыг хариуцах;
- 5.2.1.11 Хууль болон Гэрээний оролцогч талуудтай байгуулсан бусад гэрээний дагуу хүлээсэн бусад үүрэг;
- 5.2.2 Компани болон ТЗК хамтдаа дараах үүрэг хүлээнэ:
- 5.2.2.1 Андеррайтерт ажил үүргээ гүйцэтгэхэд шаардагдах аливаа зөвшөөрөл, мэдээ мэдээлэл, баримт бичгийг заасан тухай бүрд бүрэн, үнэн зөв гаргаж өгөх;
- 5.2.2.2 Үнэт цаас гаргах бэлтгэл ажлыг хариуцан гүйцэтгэх ажилтныг томилон ажиллуулах;
- 5.2.2.3 Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасны дагуу өөрсдийн зээлийн хөрөнгийг Андеррайтертай хэлэлцэн багцалж, Хөрөнгө шилжүүлэх гэрээний үндсэн дээр ТЗК-д шилжүүлэх; хэрэв тухайн хөрөнгө шаардлага хангахгүй тохиолдолд өөр шаардлага хангасан хөрөнгөөр солих;
- 5.2.2.4 Үнэт цаас танилцуулах аяныг маркетингийн төлөвлөгөөний дагуу явуулахад шаардлагатай бүх мэдээлэл, нөхцөлөөр хангах;
- 5.2.2.5 Стратегийн хөрөнгө оруулагчид болон олон нийтэд үнэт цаасыг танилцуулах аянд оролцох, танилцуулга хийх удирдах албан тушаалтан эсхүл мэргэжилтнүүдийг тодорхойлж Андеррайтертай хамтран ажиллах;
- 5.2.2.6 Гэрээний үүргээ зөрчсөний улмаас Андеррайтер болон аливаа гуравдагч этгээдэд учирсан хохирлыг бүрэн хариуцах; болон
- 5.2.2.7 Хууль тогтоомжийн дагуу хүлээсэн бусад үүрэг.



## ЗУРГАА. АНДЕРРАЙТЕРИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 6.1 Андеррайтерийн эрх:
- 6.1.1 Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай мэдээ мэдээлэл, тоо баримт, санхүүгийн тайлангууд болон бусад холбогдох бичиг баримтуудыг Компани болон ТЗК-аас гаргуулан авах;
  - 6.1.2 Компани, ТЗК-ийн буруутай үйл ажиллагааны улмаас Андеррайтерт учирсан хохирлыг Компаниас нэхэмжлэн төлүүлэх замаар барагдуулах;
  - 6.1.3 ТЗК-ийн татан төвлөрүүлэх хөрөнгийг босгох зорилгоор боломжит хөрөнгө оруулагч нарт хаалттай хүрээнд үнэт цаасыг танилцуулах;
  - 6.1.4 Андеррайтерийн үйлчилгээний хүрээнд Компанийн ажлын байр болон гэрээний үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотойгоор холбогдох газарт саадгүй нэвтрэх хүсэлт гаргах.
- 6.2 Андеррайтерийн үүрэг:
- 6.2.1 Гэрээ хүчин төгөлдөр байх хугацаанд Үндсэн Андеррайтерийн үйлчилгээний явц, үр дүн, тайланг Компани болон ТЗК-д тухай бүрд нь танилцуулж, цаашид хийгдэх ажлын тухай мэдээллээр хангах;
  - 6.2.2 Андеррайтераас үл хамаарах шалтгаанаар Андеррайтерийн үйлчилгээ, үнэт цаасыг нийтэд санал болгох ажлын чанар, үр дүнд муугаар нөлөөлж болзошгүй ямар нэг нөхцөл байдал бий болсон тохиолдолд Компани болон ТЗК-д нэн даруй мэдэгдэх, түүнийг даван туулах боломжтой хувилбаруудыг танилцуулах, шаардлагатай зөвлөгөө өгч, хамтран ажиллах, нөхцөл байдлыг хамтран давах;
  - 6.2.3 ТЗК-ийн нийтэд санал болгож буй үнэт цаасны тооцооллын дэлгэрэнгүй мэдээллийг агуулсан үнэт цаасны танилцуулга материалыг Монгол хэл дээр СЗХ болон МХБ-ийн холбогдох хууль журмын дагуу боловсруулах, Эрх бүхий этгээдээс холбогдох зөвшөөрөл авахад хүчин чармайлт гарган ажиллах;
  - 6.2.4 Гуравдагч этгээдтэй харилцах аливаа харилцаанд Компани болон ТЗК-ийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;
  - 6.2.5 Гадаад, дотоодын боломжит хөрөнгө оруулагчдыг тодорхойлох, тэдгээрээс хөрөнгө оруулалт татан төвлөрүүлэх, Компани болон ТЗК-ийг төлөөлөн танилцуулга хийх, санал тавих, уулзалт зохион байгуулах, зуучлах, хөрөнгө оруулагчидтай хэлцэл хийхэд болон гэрээ байгуулахад зуучлах, хамтран ажиллах;
  - 6.2.6 ТЗК-ийн гаргаж буй үнэт цаасыг олон нийтэд сурталчлах маркетингийн төлөвлөгөөг боловсруулахад зөвлөмж өгөх, өөрийн боломжит сувгаар сурталчлах, шаардлагатай танилцуулга, видео контент болон бусад олон нийтийн сурталчилгааны материал бэлтгэхэд санал, зөвлөмж өгөх, түгээх;
  - 6.2.7 Анхдагч зах зээлийн арилжааг холбогдох хууль журамд заасны дагуу зохион байгуулахад бүхий л дэмжлэг үзүүлэх, Үнэт цаасны тухай хуулийн 41.4.3-т заасны дагуу хөрөнгө оруулагчид худалдан тухайн үнэт цаасыг танилцуулах замаар түүнийг худалдахад шаардлагатай бүх хүчин чармайлт гаргах;





## ДОЛОО. НУУЦ ХАДГАЛАХ

- 7.1 Талууд Эрх бүхий байгууллага шаардсанаас бусад тохиолдолд байгууллагын нууцад хамаарах мэдээллийг Гэрээний бус зорилгоор шууд болон шууд бус замаар ашиглахгүй, задруулахгүй эсхүл гуравдагч этгээд болон олон нийтэд мэдээлэхгүй байх үүргийг хүлээнэ.
- 7.2 Гэрээний дор хүлээж буй Андеррайтерийн нууц хадгалах үүрэгт дараах нөхцөл байдал хамаарахгүй буюу Андеррайтер хариуцлага хүлээхгүй болно. Үүнд:
  - 7.2.1 Андеррайтерт мэдээлэл өгөх үед болон дараа нь тухайн мэдээлэл Андеррайтераас хамааралгүйгээр олон нийтэд зарлагдсан.
  - 7.2.2 Компанийн бусад эх үүсвэрээр дамжин олон нийтэд нээлттэй материал Андеррайтерт хүрсэн.
  - 7.2.3 Хуулийн дагуу эрх бүхий байгууллагын шийдвэрээр тухайн нууцлалын зэрэглэлийн мэдээлэл олон нийтэд ил болсон.
- 7.3 Андеррайтерийн үйлчилгээний хүрээнд хийгдэх танилцуулга материал болон бусад нийтэд нээлттэй болох шаардлагатай мэдээллүүдийг Компани болон ТЗК зөвшөөрснөөр Андеррайтер нийтэд танилцуулж болох бөгөөд Гэрээнд заасан нууц мэдээллийг задруулсан гэж үзэхгүй.

## НАЙМ. ХАРИУЦЛАГА

- 8.1 Андеррайтер нь үнэт цаасыг олон нийтэд танилцуулах, сурталчлахтай холбоотой хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор гүйцэтгээгүйн улмаас Компани нь шинэ андеррайтер томилсон бол тус үйлчилгээний төлбөр болон үнэт цаас гаргах ажиллагаа хойшилсний улмаас үүссэн нэмэлт зардлыг Андеррайтер хариуцна.
- 8.2 Талууд СЗХ-ны “Үнэт цаасны зах зээл дэх дотоод мэдээллийн жагсаалт, түүнийг мэдээлэх журам”-д заасан үүргээ биелүүлээгүйгээс үүдэх хариуцлагыг хүлээнэ.
- 8.3 Монгол улсын Иргэний хуульд заасан Гэнэгийн буюу давтагдашгүй хүчин зүйлийн улмаас аль нэг тал Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон бол хариуцлагаас чөлөөлөгдөнө. Энэ тохиолдолд тэрхүү нөхцөл байдлаа нэн даруй нөгөө талдаа мэдэгдэж, нотлох үүрэгтэй. Нотолж чадаагүй тохиолдолд Гэрээгээр хүлээсэн үүргээсээ чөлөөлөгдөхгүй.
- 8.4 Компанийн буруутай, хууль бус үйл ажиллагаанаас үүдэн гарсан ямар нэг хохирол, өр төлбөрийг Андеррайтер хариуцахгүй болно.
- 8.5 Компанийн ирүүлсэн бөгөөд мэргэжлийн байгууллага (хуульч, санхүүгийн шинжээч, үнэлгээний байгууллага, эсхүл аудитын дүгнэлт гэх мэт)-аас баталгаажсан мэдээлэл нь худал буюу бодит байдалд нийцээгүй, төөрөгдүүлсэн байсны улмаас ирээдүйд учрах аливаа хохирлыг Андеррайтер хариуцахгүй болно.
- 8.6 Компани нь энэхүү Гэрээний 4.4, 4.6-д заасан хугацаанд үйлчилгээний төлбөрийг Андеррайтерт төлөөгүй тохиолдолд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувьтай тэнцэх алдангийг хугацаа хоног тутам төлнө.
- 8.7 Гэрээ хүчин төгөлдөр үйлчилж байх хугацаанд Үнэт цаас гаргагч, Компаниас үл хамаарах шалтгаанаар Андеррайтер нь Гэрээг цуцлах санал гаргасан, эсвэл гэрээнд заасан нөхцөлийн дагуу санхүүжилт татах үүргээ бүрэн болон хэсэгчлэн гүйцэтгээгүй



тохиолдолд Гэрээний 4.1-т заасан толборийг Үнэт цаас гаргагч төлөх үүргээс чөлөөлөгдөх үндэслэл болно.

### ЕС. ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛОХ

- 9.1 Гэрээ нь дор дурдсан үндэслэлээр дуусгавар болно. Үүнд:
- 9.1.1 Талууд Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлснээр,
  - 9.1.2 Талууд харилцан тохиролцсоноор;
  - 9.1.3 Энэ гэрээнд болон хуульд зааснаар гэрээ цуцлагдсанаар;
  - 9.1.4 Хуульд заасан бусад үндэслэлээр.
- 9.1 Гэрээний үүргээ зөрчсөний улмаас гэрээ цуцалснаас үүсэх үр дагаврыг тухайн гэм буруутай тал бүрэн хариуцна.
- 9.2 Гэрээг дуусгавар болгохоос өмнө нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг гэрээний талууд харилцан тохиролцож шийдвэрлэх ба гэрээний өөрчлөлтийг үндсэн гэрээний нэгэн адил үйлдэнэ.

### АРАВ. БУСАД ЗҮЙЛ

- 10.1 Гэрээг дуусгавар болгохоос өмнө нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг гэрээний талууд харилцан тохиролцож шийдвэрлэх ба гэрээний өөрчлөлтийг үндсэн гэрээний нэгэн адил үйлдэнэ.
- 10.2 Энэхүү Гэрээ нь сайн дурын үндсэн дээр, талуудын эрх, ашиг сонирхлын төлөө байгуулагдсан бөгөөд талуудын хувьд зайлшгүй дагаж мөрдөх баримт бичиг мөн.
- 10.3 Талууд Гэрээтэй холбоотойгоор үүссэн санал зөрөлдөөн, үл ойлголцол, маргааныг харилцан тохиролцож, эв зүйгээр шийдвэрлэх ба тохиролцоонд хүрч чадахгүй тохиолдолд маргааныг Монгол улсын хуулийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.
- 10.4 Гэрээг Монгол хэл дээр, ижил хүчинтэй 3 хувь үйлдэх ба Компанид 1 хувь, ТЗК-д 1 хувь, Андеррайтерт 1 хувь хадгалагдана.
- 10.5 Гагцхүү бичгээр үйлдэн талууд гарын үсэг зурж баталгаажуулсан тохиолдолд Гэрээний нөхцөл, болзол болон үйлчилгээний цар хүрээг засварлах, өөрчлөх болон үүнтэй холбоотойгоор гэрээнд өөрчлөлт оруулж болно.


### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

БЭРС ФИНАНС ББСБ ХХК-ийг төлөөлж:	БЭРС ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК ХХК-ийг төлөөлж:	ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК-ийг төлөөлж:
Гүйцэтгэх захирал С.ОТГОНБАТ	ТУЗ-ийн дарга Б.БОЛОР-ЭРДЭНЭ	Гүйцэтгэх захирал С.ГАН-ЭРДЭНЭ



МОНГОЛЫН ХӨРӨНГӨӨН ШИРХ  
MONGOLIAN STATE - BUSINESS  
2023-01-013  
Б.УРГАТЭВ

СЭХ  
ОМ ДАР АДАР  
Б.УРГАТЭВ  
1 1 0





2023 оны 02 сарын 09-ны өдрийн ..... тоот  
 Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх  
 гэрээний Хавсралт №1

**ХБҮЦ-ыг нээлттэй гаргахтай холбоотойгоор хийгдэх ажлууд**

Дугаар	Төлөвлөгдсөн ажлууд	Гүйцэтгэх тал	Хугацаа хоног
1.1	Андеррайтерийн үйлчилгээний гэрээ баталгаажуулах	Компани, ТЗК, Андеррайтер	7
1.2	ТЗК ХХК-г байгуулан ТУЗ-ыг томилох, компанийн холбогдох дүрэм, журмыг батлах, Зээлийн багцыг сонгох	Компани	14
1.3	Хөрөнгийн багцыг сонгох	Компани, Андеррайтер	7
1.4	Хуулийн зөвлөхийн баталгаажуулсан гэрээ	Компани, Хуулийн компани	7
1.5	Хөндлөнгийн аудитортой байгуулах гэрээ	ТЗК, Аудит	7
1.7	Зээлийн шинжилгээ гаргагчтай байгуулах зээлийн шинжилгээ хийлгэх гэрээ	Компани, Үнэлгээний компани	7
1.8	ХБҮЦ гаргах ТЗК тусгай зөвшөөрлийн өргөдлийг СЗХ-нд хүргүүлэх	Компани	7
<b>2</b>	<b>Бэлтгэлийн үе шат</b>		
2.1	Зээлийн шинжилгээ гаргагчийн дүгнэлт	Аудит	30
2.2	Зээлийн багц хууль зүйн шалгуурт нийцсэн эсэх дүгнэлт	Хуулийн фирм	40
2.3	Хуулийн дүгнэлт	Хуулийн фирм	40
2.4	Магадлан шинжилгээ: -Бизнесийн гэрээ, санамж бичиг -Тусгай зөвшөөрлүүд, өмч эзэмшлийн гэрчилгээ -Үйл ажиллагааны журам, - Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн санхүүгийн болон салбарын шинжилгээ, - ХБҮЦ зах зээлийн орчны судалгаа (олон улс болон дотоодын зах зээлд) -Зах зээлийн судалгаа - Санхүүгийн төсөөлөл, шинжилгээ - ХБҮЦ эргэн төлөлтийн эрсдэлийн шинжилгээ	Андеррайтер	30
2.5	Үнэт цаасжуулах үйл ажиллагаанд оролцогчид болон тэдгээрийн албан тушаалтан болон гэрээлэгчид заавал дагаж мөрдөх журмуудыг батлах;	ТЗК	7
2.6	Үнэт цаасжуулах хэлцлийн оролцогчидтой холбогдох гэрээнүүдийг байгуулах (Хөрөнгө	ТЗК	7

	итгэмжлэн удирдагчтай гэрээ байгуулахдаа зээлийн багцын шинжилгээг хийлгэсэн байх)		
2.7	СЗХ-ноос ХБҮЦ гаргах тусгай зөвшөөрөл олгох	СЗХ	30
2.8	Компанийн оноосон нэр, үйл ажиллагааны төрөлд өөрчлөлт оруулан улсын бүртгэлд бүртгэх	ТЗК	14
2.9	ХБҮЦ-ыг ямар нөхцөлтэйгөөр гаргахыг тогтоох	ТЗК-ТУЗ	7
2.10	Үнэт цаасны танилцуулгыг бэлтгэх	Андеррайтер	14
2.11	Үнэт цаасны танилцуулгад санал өгөх	Хуулийн фирм	3
2.12	Үнэт цаасны танилцуулгыг хянаж, засварлах	Андеррайтер	7
2.13	Андеррайтерийн дүгнэлт	Андеррайтер	7
2.13	Үнэт цаасны проспектус бэлэн болох	ТЗК, Компани, Андеррайтер	7
2.14	СЗХ, МХБ-д өгөх Үнэт цаасны проспектус хэвлэж бэлтгэх	Андеррайтер	7
3	<b>Бүртгэлийн үе шат</b>		//
3.1	ХБҮЦ-ыг СЗХ-нд бүртгүүлэх	Андеррайтер	7
3.2	СЗХ хурлаар хэлэлцэн, бүртгэсэн тухай тогтоол хүлээн авах	ТЗК, Андеррайтер	40
3.3	ХБҮЦ-ыг МХБ-д бүртгүүлэх	Андеррайтер	7
3.4	МХБ хурлаар хэлэлцэн, бүртгэсэн тухай тогтоол хүлээн авах	ТЗК, Андеррайтер	30
4	<b>Арилжааны үе шат</b>		
4.1	Хөрөнгө оруулагчдад зориулсан үнэт цаасны хураангуй танилцуулга болон брошюр бэлтгэх	Андеррайтер	14
4.2	Хаалттай хөрөнгө оруулагчдад зориулсан илтгэл бэлтгэх	Андеррайтер	14
4.3	Олон нийтэд зориулсан илтгэл бэлтгэх	Андеррайтер	14
4.4	Боломжит хөрөнгө оруулагчидтай санамж бичиг, үнэт цаас худалдан авах урьдчилсан захиалгын гэрээ байгуулах /Cold Call/	Андеррайтер	30
4.5	ҮЦК-уудад танилцуулах уулзалт, үнэт цаасны товч танилцуулга, брошюр тараах	ТЗК, Андеррайтер	7
4.6	Роуд шоу-г эхлүүлж, үнэт цаасны мэдээллийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нээлттэй түгээх, хөрөнгө оруулагчидтай уулзалт зохион байгуулах.	ТЗК, Андеррайтер	14
4.7	МХБ-ын гадна сурталчилгаа байршуулах	ТЗК, Андеррайтер	2
4.8	Анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг гүйцэтгэх	Андеррайтер	7
5	<b>Арилжааг хаах</b>		
5.1	Андеррайтер арилжааны тайланг СЗХ-нд хүргүүлэх	Андеррайтер	7
5.2	Үнэт цаас гаргагч үнэт цаасны гүйлгээний товч тайланг нийтэд мэдээлэх	ТЗК, Андеррайтер	7

	 <p>МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЭХ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-04-06</p>		 <p>өдөр Б.В.Р.Г.Э.В. № 1</p>
5.3	СЗХ нь ҮЦГХТ-д омчлох эрхийн бүртгэл хийх, МХБ-д үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх зөвшөөрөл олгох	СЗХ	7
5.4	Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх	МХБ, Андеррайтер	7

**БАТАЛГААЖУУЛСАН :**

**БЭРС ФИНАНС ББСБ ХХК-ийг төлөөлж:**

**БЭРС ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК ХХК-ийг төлөөлж:**

**ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК-ийг төлөөлж:**

Гүйцэтгэх захирал  
С.ОТГОНБАТ



ТУЗ-ийн дарга

Б.БОЛОР-ЭРДЭНЭ



Гүйцэтгэх захирал


С.ГАН-ЭРДЭНЭ





МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ  
MONGOLIAN STOCK EXCHANGE  
2023-04-06  
LPT133-02

СХ  
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ  
MONGOLIAN STOCK EXCHANGE  
2023-04-06  
LPT133-02



2023 оны 02 сарын 06-ны өдрийн 21/558 тоот  
Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх  
гэрээний Хавсралт №2

**ХБҮЦ-ИЙГ НЭЭЛТТЭЙ ГАРГАХ ТӨСЛИЙН БАГ**


№	Овог / Нэр	Албан тушаал	Утас	И-мэйл
<b>Компани</b>				
1	Б.Баярчимэг	Дэд захирал	99100957	bayarchimeg.b@bichilglobus.mn
2	Я.Адъяахүү	Санхүү бүртгэлийн газрын захирал	88117328	adiyakhuu@bichilglobus.mn
3	Д.Энхчимэг	Санхүүгийн шинжээч	88105354	enkhchimeg@bichilglobus.mn
<b>ТЗК</b>				
4	Б.Болор-Эрдэнэ	ТУЗ-ийн дарга	99092286	bolordereneb@gmail.com
<b>Андеррайтер</b>				
5	С.Ган-Эрдэнэ	Гүйцэтгэх захирал		ganerdene@golomtcapital.com
6	Н.Нарангарав	Хөрөнгө оруулалтын газрын захирал	89043735	narangarav@golomtcapital.com

**БАТАЛГААЖУУЛСАН :**

**БЭРС ФИНАНС ББСБ ХХК-ийг төлөөлж:**



**БЭРС ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК ХХК-ийг төлөөлж:**



**ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК-ийг төлөөлж:**



МОНГОЛЫН ХОРГИНГҮЙН БИРЖ  
MONGOLIAN STOCK EXCHANGE

2023-04-06

БҮРТГЭВ-02

CSX  
ON OFF KORE  
БҮРТГЭВ  
№. 02



Гарк Плейс 403, Чингисийн өргөн чөлөө-24,  
СБД 1-р хороо, Улаанбаатар хот,  
Утас: 7012-1530, 7012-1529  
И-мэйл: info@golomtcapital.com,  
Вэбсайт: www.golomtcapital.com



Санхүүгийн  
зохицуулах хорооны  
үнэт цаасны газарт

№  
2023-02-13 ны № 03/83 т

**БЭРС ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК ХХК-ИЙН АВТОМАШИНЫ ЗЭЭЛИЙН ХӨРӨНГӨӨР  
БАТАЛГААЖСАН БАТАЛГААТ ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААС  
ГАРГАХ ХӨТӨЛБӨРТ ӨГӨХ АНДЕРРАЙТЕРИЙН ДҮГНЭЛТ**

"Голомт Капитал УЦК" ХХК нь (Цаашид "Андеррайтер" гэх) Санхүүгийн Зохицуулах Хорооноос 2015 оны 03 сарын 23-ны өдрийн 156 дугаартай шийдвэрийн дагуу олгосон "Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх" тусгай зөвшөөрлийн хүрээнд Үнэт цаас гаргагчтай 2023 оны 02 сарын 09-ний өдрийн 23/558 тоот "Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээ" (Цаашид "Гэрээ" гэх) байгуулж, Бэрс Эй Би Эс ТЗК Плас ХХК-ийн (цаашид "Үнэт цаас гаргагч" гэх) 9,000,000,000 (есөн тэрбум) төгрөг хүртэлх Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй арилжаалах үйл ажиллагаанд Андеррайтераар оролцож байна.



Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хөтөлбөрийг олон нийтэд санал болгон хөрөнгө оруулалт татах бэлтгэл ажлын хүрээнд Андеррайтер нь Үнэт цаасны танилцуулгыг боловсруулан, дараах мэргэжлийн дүгнэлтийг танилцуулж байна. Үүнд:

1. Үнэт цаасны тухай мэдээлэл
2. Үнэт цаас гаргах бэлтгэл ажлын тухай мэдээлэл
3. Үнэт цаас гаргах хэлцлийн хүрээнд байгуулагдсан гэрээнүүд
4. Үнэт цаас гаргах үйл ажиллагаанд дагаж мөрдөх батлагдсан журмууд
5. Хөрөнгийн багцын талаарх дүгнэлт
6. Ерөнхий дүгнэлт

**НЭГ. ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ**

Үнэт цаас гаргагч нь нэг бүр нь 100,000 (нэг зуун мянга) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий, 90,000 (ерэн мянга) ширхэг, нийт 9,000,000,000 (есөн тэрбум) төгрөг хүртэлх үнийн дүн бүхий Автомашины зээлийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй арилжаалах ба санхүүжилтийг Бэрс финанс ББСБ ХХК-иас үнэт цаасны





танилцуулгад тусгасан автомашины зээлээс бүрдэх хөрөнгийн багцын үлдэгдлийг худалдан авахад зарцуулахаар төлөвлөсөн. Үнэт цаас гаргагчийн санал болгож буй ХБҮЦ нь 24 сарын хугацаатай байх бөгөөд хүүгийн түвшин жилийн 19.2 хувь, хүүгийн төлбөр улирал тутам, үндсэн төлбөрийг жилд 1 удаа төлөх нөхцөлтэй байна.

### **ХОЁР. ҮНЭТ ЦААС ГАРГАХ БЭЛТГЭЛ АЖЛЫН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ**

“Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс” ХХН нь 2023 оны 2-р сарын 05-ны өдрийн Д-23/27 тоот Автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас олон нийтэд нээлттэй санал болгох хүрээнд сонгогдсон зээлийн дансдын хуулийн шалгуур үзүүлэлтэд нийцсэн эсэх талаарх хуулийн хөндлөнгийн дүн шинжилгээний тайланг гаргуулсан. Тус шинжилгээний тайланд түүвэрт сонгогдсон зээл, фидуцийн гэрээнүүд нь хуульд заасан шаардлагыг хангасан, хүчин төгөлдөр байна гэж тайлагнасан байна.


Түүнчлэн Үнэт цаас гаргагчийн үнэт цаас гаргах, олон нийтэд санал болгох үнэт цаасны танилцуулгад тусгагдсан санхүүгийн мэдээлэл нь үнэн зөв эсэх, сонгогдсон зээлийн дансдууд санхүүгийн шалгуур үзүүлэлт хангасан эсэх талаарх шинжилгээ гаргуулахаар “Онч аудит” ХХК-тай Хамтран ажиллах гэрээг 2022 оны 11-р сарын 07-ны өдөр байгуулсан байна. Тус ажлын хүрээнд гүйцэтгэсэн үр дүнгийн тайланд түүвэрт сонгогдсон зээлүүд нь шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн хангасан байна гэж тайлагнасан байна.

Мөн үнэт цаас гаргагч нь Юнайтед Айр Файнэнс ХХК-тай хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээг байгуулсан ба ТЗК -ийн мөнгөн хөрөнгө, авлагыг захиран зарцуулах эрхийг олгосон байна.

### **ГУРАВ. ҮНЭТ ЦААС ГАРГАХ ХЭЛЦЛИЙН ХҮРЭЭНД БАЙГУУЛАГДСАН ГЭРЭЭНҮҮД**

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах ажлын хүрээнд оролцогч талууд шаардлагатай гэрээ хэлцлүүдийг байгуулах ба гэрээний төслүүдийг талууд зөвшөөрч, эрх бүхий этгээдийн шийдвэрээр баталгаажуулсан. Ийнхүү гэрээг баталгаажуулсан нь үнэт цаасыг бүртгэсэн үед оролцогч талуудын эрх, үүрэг хангагдаж байна гэж үзэж байна. Үүнд:

- I. Үнэт цаас гаргагч болон анхны үүрэг гүйцэтгүүлэгч нарын хооронд байгуулах хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний төсөл
- II. Үнэт цаас гаргагч, анхны үүрэг гүйцэтгүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагч нарны хооронд байгуулах Төлбөр цуглуулах, үйлчилгээ үзүүлэх гэрээ
- III. Үнэт цаас гаргагч болон анхны үүрэг гүйцэтгүүлэгч нарын хооронд байгуулах Фидуцийн барьцааны гэрээний төсөл



- IV. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч үнэт цаас гаргагч, хөрөнгө илгэмжлэн удирдагч нарын хооронд байгуулах Зээлийн эргэн төлөлтийн дансны барьцааны гэрээ
- V. Үнэт цаас гаргагч болон анхны үүрэг гүйцэтгүүлэгч нарын хооронд байгуулах Захиргааны үйлчилгээ үзүүлэх гэрээ
- VI. Үнэт цаас гаргагч болон хөрөнгө итгэмжлэн удирдагч нарын хооронд байгуулах Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ

**ДӨРӨВ. ҮНЭТ ЦААС ГАРГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ДАГАЖ МӨРДӨХ БАТЛАГДСАН ЖУРМУУД**

Үнэт цаас гаргах үйл ажиллагаатай холбоотойгоор Үнэт цаас гаргагчаас холбогдох журмуудыг баталсан нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах нөхцөлийг бүрдүүлсэн байна гэж Андеррайтерийн зүгээс үзэж байна.

- I. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам
- II. Хөндлөнгийн аудитор, үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох, солих журам
- III. Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлэх журам
- IV. Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх журам
- V. Эрсдэл, сонирхлын зөрчлийг илрүүлэх, үнэлэх, удирдах дотоод хяналтын журам
- VI. Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам

**ТАВ. ХӨРӨНГИЙН БАГЦЫН ТАЛААРХ ДҮГНЭЛТ**

Үнэт цаас гаргагч нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс санал болгосон автомашины фидуци бүхий 2022 оны 11-р сарын 07-ны өдрөөр тасалбар болгосон нийт 2,160 зээлийн гэрээнээс бүрдсэн 13,082,498,702 (арван гурван тэрбум зуун наян хоёр сая дөрвөн зуун ерөн найман мянга долоон зуун хоёр) төгрөгийн үнийн дүн бүхий хөрөнгийн багцыг бүрдүүлсэн.

Харин Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үед тус хөрөнгийн багц дахь зээлүүд төлөгдөж 2023 оны 2-р сарын 28-ны өдрөөр тасалбар болгосон 2,318 зээлийн гэрээнээс бүрдсэн 10,005,596,403 (арван тэрбум таван сая таван зуун ерөн зургаан мянга дөрвөн зуун гурав) төгрөгийн үнийн дүн бүхий багц болж өөрчлөгдсөн байна.

2023-04-06

Хөрөнгийн багцын үлдэгдэл жигнэсэн дундаж хугацаа 32 сар, сарын жигнэсэн дундаж хүү 3.44 хувь байна. Нийт зээлийн багцын 57.87 хувийг 10 сая хүртэлх үнийн дүн бүхий зээлүүд, 42.13 хувийг 10-50 сая хүртэлх үнийн дүн бүхий зээлүүд бүрдүүлж байна. Түүнчлэн нэг гэрээнд ногдох зээлийн дундаж үлдэгдэл 4.3 сая төгрөг байна.

Автомашинны зээлийн багцыг хугацаагаар ангилан харуулбал нийт автомашинны фидуци бүхий зээлийн багцын 4.81 хувийг 0-12 сарын хугацаатай зээлүүд, 22.84 хувийг 12-24 сарын хугацаатай зээлүүд, 26.51 хувийг 24-36 сарын хугацаатай зээлүүд, үлдсэн 45.84 хувийг 36-аас дээш сарын хугацаатай зээлүүд эзэлж байна. Зээлийн багцын үлдэгдэл хугацаанд ногдох жигнэсэн дундаж хугацаа нь 32 сар байна.

2021 оны байдлаар Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн нийт зээлд эзлэх анхаарал хандуулах зээл 2 хувь, чанаргүй зээл 2.8 хувь байсан бол 2022 оны эцсийн байдлаар анхаарал хандуулах зээлийн нийт зээлд эзлэх дүн 1 хувь, чанаргүй зээл 1.2 хувь болж буурсан байна. Түүнчлэн үнэт цаас гаргагч нь зээлийн багцаас зөвхөн хэвийн зээлүүдийг багцалж, хөрөнгийн багц дахь зээлийн багц муудсан тохиолдолд хэвийн зээлээр солих нөхцөлтэй учир хөрөнгийн багц дахь чанаргүй зээлийн хэмжээ тогтмол 0 хувь байх юм.

#### **ЗУРГАА. ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ**

Андеррайтер нь судалгаа шинжилгээ болон хөндлөнгийн зөвлөх байгууллагуудын зээлийн багцын шинжилгээ, хуулийн дүгнэлтэд үндэслэн Үнэт цаас гаргагчийн гаргаж буй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас нь Монголын Хөрөнгийн Биржээр нээлттэй арилжаалагдах шалгуурыг хангасан бөгөөд олон нийтэд санал болгох боломжтой гэж үзлээ.

Энэхүү дүгнэлт нь Үнэт цаас гаргагчийн итгэл үнэмшилд тулгуурлан хийгдсэн ба төсөөлөл, таамаглал болон биелэлтийн баталгаа болохгүй. Иймд хөрөнгө оруулагчдыг компанийн үйл ажиллагаа, үнэт цаасны танилцуулга, хөрөнгийн багцын бүтэц, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар судалсны үндсэн дээр шийдвэрээ гаргахыг зөвлөж байна.

#### **Баталгаажуулсан:**

Овог, нэр: САНЖХУЯГ овогтой ГАН-ЭРДЭНЭ

Албан тушаал: Гүйцэтгэх захирал

Гарын үсэг:

2023-04-06

БҮРТГЭВ-02

**Golomt Capital**  
Delivering Diversity

Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,  
Чингисийн өргөн чөлөө 24, Парк Плэйс  
оффисын барилга, 4 давхар, 403 тоот,  
Утас: 7012-1530, 7012-1529  
И-мэйл: info@golomtcapital.com,  
Вэбсайт: www.golomtcapital.com

САНХҮҮГИЙН  
ЗОХИЦУУЛАХ ХОРООНД

№ \_\_\_\_\_  
2023.03.02 -ны № 23/101 Т

*Нэгдмэл сонирхол, бизнесийн ашиг  
сонирхлын талаар мэдэгдэл гаргах тухай*

“Голомт Капитал ҮЦК” ХХК нь “Бэрс Эй Би Эс Плас ТЗК” ХХК-ийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг биржийн зах зээлд олон нийтэд танилцуулах, санал болгох төсөлд андеррайтерын үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна. Компани нь уг үнэт цаас гаргах үйл ажиллагаанд оролцогч бусад талуудтай холбогдох хууль, журам болон талуудын хооронд байгуулагдсан гэрээ, хэлцлийн хүрээнд хамтран ажиллаж буй бөгөөд доор дурдсан этгээдүүдтэй уг үнэт цаасыг гаргахаас бусад аливаа асуудлаар нэгдмэл сонирхол, бизнесийн ашиг сонирхолгүй болохоо үүгээр баталгаажуулан мэдэгдэж байна.

1. Үнэт цаас гаргагч “Бэрс Эй Би Эс Плас ТЗК” ХХК
2. Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагч, анхны үүрэг гүйцэтгүүлэгч бөгөөд үйлчилгээ үзүүлэгч “Бэрс Финанс ББСБ” ХХК
3. Хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээ үзүүлэгч “Юнайтед Айр Файнэнс” ХХК
4. Зээлийн шинжилгээ гаргагч “Онч Аудит” ХХК
5. Хөндлөнгийн хуулийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч “Өмгөөллийн Эм Ди Эс Энд Хаанлекс” ХХН

Баталгаажуулсан,  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



С. ГАН-ЭРДЭНЭ

000623



2023-04-06



**MDSKhanLex**

Монгол Улс Улаанбаатар хот 14200  
Сүхбаатар дүүрэг, Сүхбаатарын талбай 2  
Сэнтоар Тэвэр 13 давхар, 1301 тоот

Утас: +976 11 300048

Факс: +976 11 300048

Олон улс: +1 975 9632674

2023.02.13

№ Ө-23/31



**САНХҮҮГИЙН  
ЗОХИЦУУЛАХ ХОРОО,  
МОНГОЛЫН  
ХӨРӨНГИЙН БИРЖИД**

*Мэдэгдэл хүргүүлэх тухай*

“Өмгөөллийн Эм Ди эс энд Хаанлекс” ХХН нь “Бэрс Эй Би Эс Плас ТЗК” ХХК-ийн автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас (хбүц) гарган нийтэд санал болгохтой холбогдуулан хууль зүйн дүгнэлт гаргах, зөвлөх үйлчилгээ үзүүлсэн болно.

“Өмгөөллийн Эм Ди эс энд Хаанлекс” ХХН нь Санхүүгийн Зохицуулах Хорооны 2022 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 226 тоот тогтоолоор батлагдсан Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журмын 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэгт заасныг удирдлага болгон, үнэт цаас гаргагч “Бэрс Эй Би Эс Плас ТЗК” ХХК-тай аливаа сонирхлын зөрчилгүй болохоо үүгээр мэдэгдэж байна.

Түүнчлэн тийм нөхцөл үүсэж болзошгүй тохиолдолд сонирхлын зөрчлөөс сэргийлэх арга хэмжээг тухай бүрд нь холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу авч хэрэгжүүлэхээ илэрхийлж байна.


Хүндэтгэсэн,

“ӨМГӨӨЛЛИЙН ЭМ ДИ ЭС ЭНД ХААНЛЕКС” ХХН-ИЙН  
ГИШҮҮН, ХУУЛЬЧ

  
Д. ДҮГЭРЖАВ ХОТ



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ  
ХОРООНД



Монгол Улс, Улаанбаатар хот, СБД, 8-р хороо  
Соёлын төв өргөө 10 давхар 1005 тоот  
Утас/факс: 976-70122346, Утас: 976-70142346  
Шуудангийн хаяг: Улаанбаатар хот 15160, Ш/Х 186

АДЛЗ. 02. 05 № 23107

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Баталгаа гаргах тухай,

"Юнайтед Айр Файнэнс" ХХК (РД: 2870657) (цаашид "Компани" гэх) нь "Бэрс Эй Би Эс Плас ТЗК" ХХК-ийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргах ажиллагаанд хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээ үзүүлж байгаа бөгөөд энэхүү үйл ажиллагаатай холбоотойгоор дараах мэдэгдэл, баталгааг гаргаж байна. Үүнд:

1. "Бэрс Эй Би Эс Плас ТЗК" ХХК-ийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах ажиллагаанд хамтран оролцож буйгаас өөрөөр Компани нь дараах этгээдтэй санхүүгийн болон санхүүгийн бус аливаа нэгдмэл ашиг сонирхолгүй болно. Үүнд:
  - i. "Бэрс Эй Би Эс Плас ТЗК" ХХК болон түүний үүсгэн байгуулагч "Бэрс Финанс ББСБ" ХХК;
  - ii. Зээлийн шинжилгээ гаргагч "Онч Аудит" ХХК;
  - iii. Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэгч "Голомт Капитал ҮЦК" ХХК;
  - iv. Хөндлөнгийн хууль зүйн дүгнэлт гаргаж буй "Өмгөөллийн Эм Ди Эс Энд ХаанЛекс" ХХН.
2. Компани нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргагчид хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээ үзүүлэх бүрэн эрхтэй бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон тохиромжтой этгээдийн болон бусад шалгуур, шаардлагыг бүрэн хангаж байгаа болно.
3. Компанийн эрх бүхий албан тушаалтнууд нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах ажиллагаанд оролцоход шаардлагатай мэдлэг туршлагатай бөгөөд Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж зэрэг зохицуулагч байгууллагаас тогтоосон шаардлагыг хангаж байгаа болно.

БАТАЛГАА ГАРГАСАН:  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Х.МАРГАД-ЭРДЭНЭ

2023-04-06

БЭРС ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК ХХК

Монгол улс, Улаанбаатар хот  
Сүхбаатар дүүрэг, 11-р хороо, 7-р хороолол,  
Ногоон нуур, 101 барилга, 706 тоот  
Утас: 99119632

2023.02.10 № 24/05

Танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ  
ХОРООНД

Тайлбар хүргүүлэх тухай

“Бэрс Эй Би Эс Плас ТЗК” ХХК нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгүүлэхтэй холбоотойгоор дараах тайлбарыг хүргүүлж байна. Үүнд:

1. “Бэрс Эй Би Эс Плас ТЗК” ХХК болон үүсгэн байгуулагч “Бэрс финанс ББСБ” ХХК, түүний эрх бүхий албан тушаалтан нь Санхүүгийн зохицуулах хороо болон Төрийн эрх бүхий байгууллагаас аливаа байдлаар захиргааны болон эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй болно.

2. “Бэрс Эй Би Эс Плас ТЗК” ХХК нь үүсгэн байгуулагч, анхны үүрэг гүйцэтгүүлэгч, үйлчилгээ үзүүлэгч болон хөрөнгө худалдагч этгээдтэй аливаа байдлаар ашиг сонирхлын зөрчил үүсгэхгүй ажиллах бөгөөд холбогдох хууль тогтоомжийн хүрээнд гэрээ хэлцэл байгуулан ажиллана.

3. “Бэрс Эй Би Эс Плас ТЗК” ХХК нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргахтай холбоотойгоор Санхүүгийн хөндлөнгийн шинжээч, зөвлөхийн үйлчилгээ болон хөндлөнгийн аудитын үйлчилгээ үзүүлэгч “Онч аудит” ХХК, Хуулийн хөндлөнгийн шинжээч, зөвлөх үйлчилгээ үзүүлэгч “Өмгөөллийн Эм Ди Эс Энд Хаанлекс” ХХН, Хөрөнгө итгэмжлэн удирдагч болон Хэлцлийн зөвлөх “Юнайтед Айр Файнэнс” ХХК, Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэгч “Голомт капитал ҮЦК” ХХК-тай тус тус аливаа байдлаар ашиг сонирхлын зөрчилгүй болохыг үүгээр тодорхойлж байна.

Хүндэтгэсэн,

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Б.БОЛОР-ЭРДЭНЭ

Шалгуур үзүүлэлт 5. Зээлтэй холбоотойгоор Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон зээлдэгчийн хооронд байгуулсан фидуцийн гэрээ нь зээлдэгч (Үүрэг гүйцэтгэгч)-ийн хувьд хуульд нийцсэн, хүчин төгөлдөр, заавал биелэгдэх үүрэг үүсгэсэн зээлдэгч үүргээ бислүүлээгүй тохиолдолд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч өмчлөгчийн эрхээ хэрэгжүүлж, худалдан борлуулж зээл, үүнтэй холбоотой бүх төлбөрийг гаргуулах боломжтой байх.

Уг шалгуур үзүүлэлтийн хүрээнд Бэрс Финанс ББСБ-ын зээлдэгчтэй байгуулсан фидуцийн гэрээ хуулиар тодорхойлсон хэлбэрийн шаардлагыг хангасан, хуульд нийцсэн, хүчин төгөлдөр эсэх, хуульд зааснаар, эсхүл итгэмжлэлээр төлөөлөх эрх нь хүчин төгөлдөр эсэх, фидуцийн эрх нь үүргийн гүйцэтгэлээр хангах аргаар баталгаажсан бусад шаардлагаас давуу, тэргүүн ээлжинд шаардлага хангуулах боломжтой эсэх, зохих ёсоор үүсгэгдэж хүчин төгөлдөр болсон эсэх зэрэг асуудлыг шалгаж үзлээ.

Тайлангийн шалгуур 2-т дурдсаны дагуу түүврийн аргаар сонгосон зээлүүдийн зээлийн гэрээ нь хуульд нийцсэн, хүчин төгөлдөр байна. Зээлдэгч зохих ёсоор үүргээ гүйцэтгээгүй тохиолдолд фидуцийн зүйлээр үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Зээлийн гэрээ болон фидуцийн гэрээгээр зохицуулсан байна. Иймд талууд фидуцийн зүйлээр үүргийн гүйцэтгэлийг хангуулахыг зөвшөөрсөн байна.

Иргэний хуулийн 235.5-д “хуульд өөрөөр заагаагүй бол үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар эд хөрөнгө өмчлөлд шилжүүлэх гэрээг бичгээр хийнэ” гэж заасны дагуу Анхны үүрэг гүйцэтгэгч нь фидуцийн эрхийг баталгаажуулсан гэрээг зээлдэгчтэй бичгээр байгуулсан нь Фидуцийн гэрээний хуульд заасан хэлбэрийн шаардлагыг хангасан байна. Мөн сонгогдсон 31 зээлийн дансад итгэмжлэлээр төлөөлүүлж гэрээг байгуулсан тохиолдол гараагүй тул хуульд заасан төлөөлөх, төлөөлүүлэх харилцаа үүсээгүй болно.

Фидуцийн гэрээний 1.9-т “Энэхүү гэрээний 1.7-д заасан мэдэгдлийг авснаас хойш Зээлдэгч нь зээл төлөх ямар нэг үйлдэл хийгээгүй бол мэдэгдэх хуудас хүргүүлсэн өдрөөс хойш 15 хоногийн ..... хөрөнгийг бусдад худалдах, болон бусад хэлбэрээр борлуулж хохирлоо барагдуулна” гэж зохицуулснаас үзвэл, фидуцийн эрх нь хуульд нийцсэн, хүчин төгөлдөр, заавал биелэгдэх үүрэг үүсгэх бөгөөд үүрэг гүйцэтгэгчийн зээлийг фидуцийн зүйл болох автомашиныг худалдан борлуулж төлүүлэх боломжтой байх шалгуурыг хангаж байна (Тайлангийн Зөвлөмж хэсгийг харна уу).

Мөн Иргэний хуулийн 235.1, Фидуцийн гэрээний 1.4-т “Барьцаалагчийн зөвшөөрөлгүй, зээл хаагдаагүй байхад Барьцаалуулагч нь барьцаа болох хөдлөх хөрөнгийн эзэмшил ашиглалтыг, өмчлөх эрхийг хууль бусаар гуравдагч этгээдэд шилжүүлэх, бусдад дамжуулах худалдах, барьцаалахыг хориглоно” гэж зохицуулснаас үзвэл Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь фидуцийн өмчлөгч бөгөөд зээлдэгч нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн зөвшөөрөлгүйгээр фидуцийн хөрөнгийг бусад үүргийн гүйцэтгэл хангуулахаар барьцаалах зэргээр захиран зарцуулах боломжгүй тул зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг давуу буюу тэргүүн ээлжинд фидуцийн эрхээр хангуулахаар талууд тохиролцсон гэж үзнэ.

Иймд, Бэрс Финанс ББСБ-ын фидуцийн гэрээ нь хуульд нийцсэн, хүчин төгөлдөр, заавал биелэгдэх үүрэг үүсгэсэн, зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг фидуцийн эрхээр гаргуулах боломжтой байна.

Шалгуур үзүүлэлт 6. Фидуцийн гэрээ хүчин төгөлдөр болгоход Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн ердийн практикт мөрддөг бүх дүрэм журмыг дагаж мөрдсөн, тухайн үүргийн гүйцэтгэлийг хангуулах аргыг нотолж буй бүх баримт бичиг нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эзэмшил, хадгалалт хамгаалалтад байх.

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгогдсон зээлийг ердийн практикт мөрддөг бүх дүрэм журмын дагуу олгосон эсэх, тухайн үүргийн гүйцэтгэлийг хангуулах аргыг нотолж буй бүх баримт бичиг нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эзэмшил, хадгалалт хамгаалалтад байгаа эсэхийг шалгалаа.

Энэхүү хүрээнд сонгогдсон зээлийн дансыг шалгах явцад Бэрс Финанс ББСБ-ын Зээлийн үйл ажиллагааны журамд заасан зээлийн шимтгэлийг зарим тохиолдолд суутган авах, зарим тохиолдолд суутгалгүйгээр хүлээн авсан зэрэг ялгаатай байдал илэрсэн болно. Бэрс Финанс



ББСБ ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 22/17а/39 тоот тушаалаар зээлийн шимтгэлийг суутган төлүүлэхгүй байхаар шийдвэрлэсэн ба тус тушаал хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэхээс өмнөх хугацааны цөөн зээлийн хувьд зээлийн шимтгэлийг зээлийн төлбөрөөс суутган тооцжээ. Хэдийгээр Зээлийн үйл ажиллагааны журмын шимтгэлтэй холбоотой нөхцөлд өөрчлөлт оруулаагүй боловч зээлийн үйл ажиллагааны журам батлах эрх бүхий субъект нь өөрчлөлт оруулах шийдвэр гаргасан байх тул дурдсан тушаалыг үндэслэл болгон шалгасан болно.

Түүнчлэн Зээлийн үйл ажиллагааны журамд заасан зээлийн хорооны шийдвэр гарах нөхцөл, журам буюу зээлийн хорооны шийдвэрээр шийдвэрлэх зээлийн үнийн дүнгийн хэмжээг Бэрс Финанс ББСБ ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2021 оны 07-р сарын 21-ний өдрийн 21/17а/64 тоот тушаал, 2022 оны 03-р сарын 22-ны өдрийн 22/17а/24 тоот тушаал, Гүйцэтгэх захирлын 2022 оны 02-р сарын 08-ны өдрийн 22/17а/09 тоот тушаалаар өөрчлөлт оруулан шийдвэрлэснийг мөн дээр дурдсантай адил удирдлага болгон зээлийн дансдыг шалгасан болно.

Бэрс Финанс ББСБ-ын сонгогдсон 31 зээл нь зээлийн үйл ажиллагаатай холбоотойгоор дотоодод дагаж мөрддөг журмын дагуу олгогдсон, фидуцийн хөрөнгө нь фидуцийн хөрөнгийн үйл ажиллагаатай холбоотой дотоодод дагаж мөрддөг журмын дагуу тодорхойлогдож, шаардлага хангасан байна.

Шалгуур 1-т дурдсаны дагуу зээлийн гэрээ, фидуцийн гэрээ нь эх хувиар, тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн гэрчилгээ нь хуулбараар хувийн хэрэгт хадгалагдаж байв. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн өмчлөлд буй фидуцийн зүйл болох автомашиныг зээлдэгч (эсхүл түүний итгэмжилсэн этгээд) эзэмшиж, ашиглаж байна. Тээврийн хэрэгслийн гэрчилгээг Анхны үүрэг гүйцэтгүүлэгч өөрийн эзэмшил, хадгалалтад эх хувиар байлгадаггүй нь Автотээврийн тухай хуулийн 17.1, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 21.2-д заасан хууль зүйн үндэслэлтэй, хуулбарыг хувийн хэрэгт хадгалдаг байна. Ийнхүү үүргийн гүйцэтгэлийг хангуулах аргыг нотолж буй дээр дурдсан баримт бичгийн нь эх хувь, эсхүл хуулбар хувиар анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эзэмшил, хадгалалтад хамгаалалтад байна гэж үзлээ.

### Нэгдсэн дүгнэлт

Хуулийн хөндлөнгийн дүн шинжилгээ хийсний үндсэн дээр нийт 31 зээлийн дансны хувьд Дүн шинжилгээ хийх өдрийн байдлаар зээлийн гэрээ, фидуцийн гэрээ нь хүчин төгөлдөр, аливаа эрсдэл үүсээгүй байна.

Зээлийн болон фидуцийн гэрээнд үүргийн гүйцэтгэлийн зүйл (фидуци)-тэй холбоотой шаардах эрхийг шилжүүлэхгүй болон хэрэгжүүлэхгүй байхыг үүрэг болгосон, эсхүл шилжүүлэхийг хориглосон, хязгаарласан нөхцөл тусгагдаагүй болно.

Энэхүү Тайлангийн Хавсралт 2-т заасан Үнэт цаас гаргагчийн зээлийн багцын шинжилгээний явцад анхаарах банк бус санхүүгийн байгууллагад ялгаатай шийдвэрлэгдсэн асуудлын жагсаалтад заасны дагуу бид тус зөрүүтэй зохицуулалтыг илрүүлсэн хэдий ч хүлээн зөвшөөрсөн бөгөөд дүн шинжилгээ хийх явцад гарсан алдаа, зөрчлийг тухай бүр засуулсан болно.

#### 1. Шалгуур үзүүлэлтүүдийг хангасан дансдууд.

Энэ ангилалд багтсан нийт данс Үнэт цаас гаргагчаас тавигдсан шалгуур үзүүлэлтүүдийг хангасан (Хавсралт 1. Түүврийн аргаар сонгогдсон зээлийн статус) бөгөөд Зээлийн гэрээ, Фидуцийн гэрээ, Тээврийн хэрэгслийн гэрчилгээ нь хүчин төгөлдөр байгаа утгыг илэрхийлнэ. Энд гарсан алдаа нь эрх зүйн эрсдэл үүсгэхгүй, хууль тогтоомжоор заасан шаардлага зөрчөөгүй зээлийг ойлгоно. Гэвч энд зарим эрсдэл болох тухайн зээл авахад шаардлага хангаж байсан боловч хөндлөнгийн дүн шинжилгээ хийх үед өөрчлөгдсөн нөхцөл байдал орж байгаа болно. Тухайлбал, зээл авах үед үйл ажиллагаа явуулах эрхийн зөвшөөрөл, эсхүл ажил эрхлэлт, тээврийн хэрэгслийн даатгалын гэрээ нь хүчинтэй байсан боловч энэхүү тайлан гаргах өдрийн байдлаар хугацаа нь дууссан байх магадлалтай зээлийн данс орсон байж болно.


**2. Эрсдэлийн зэргийг дахин үнэлэх шаардлагатай данс.**

Дүн шинжилгээ хийж тайлан гаргах өдрийн байдлаар зээлийн гэрээ, фидуцийн гэрээний аль нэг нь, эсхүл түүний гол нөхцөлийг тодорхойлсон заалт нь эрсдэлтэй байж болзошгүй, эрсдэлийн зэргийг дахин үнэлэх шаардлагатай зээлийн данс илрээгүй болно.

**3. Хүчин төгөлдөр бусад тооцогдох эрсдэлтэй данс.**

Дүн шинжилгээ хийж тайлан гаргах өдрийн байдлаар зээлийн гэрээ, фидуцийн гэрээний аль нэг нь эсхүл түүний гол нөхцөлийг тодорхойлсон заалт нь хүчин төгөлдөр бусад тооцогдож болзошгүй, хуулийн шаардлага хангаагүй зээлийн данс илрээгүй болно.

*График 3. Зээлийн гэрээ, фидуцийн гэрээний хүчин төгөлдөр байдлын үзүүлэлт.*



Энэхүү тайлан нь түүнийг тухайлан зориулж гаргасан этгээдүүдээс бусад этгээдийн өмнө ямар нэгэн үүрэг хариуцлага бий болгохгүй.

**ГУРАВ. САНАЛ/ЗӨВЛӨМЖ**

Фидуцийн гэрээний загварыг хуульд нийцүүлэх шаардлагатай. Үүргийн гүйцэтгэлийн хангах харилцааны зүйл болох хөдлөх хөрөнгө нь үүрэг гүйцэтгүүлэгчийн өмчлөлд шилждэг үндсэн шинжийг үгүйсгэж, барьцааны зохицуулалттай хольсон агуулгыг Фидуцийн гэрээний загварт тусгасныг зөвтгөх шаардлагатай.

Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн зээлийн дансдын хувийн хэрэгт зээлийн хяналтын тайлан үйлдээгүй байна. Зээл олгосноос хойш тодорхой хугацаа өнгөрсний дараа зээлийг эргэн шалгадаг байх, даатгалын хугацаа дууссан эсэх зэрэг мэдээллийг шалгах шаардлагатай учраас зээлийн хяналтын тайлан үйлдэн хувийн хэрэгт хавсаргадаг байх шаардлагатай гэж үзлээ.

БЭБХЭМХМХШЗҮАтХ-ийн 22 дугаар зүйлийн 22.2-т заасны дагуу зээлийн хувийн хэрэгт зээлийн ашиглалт шалгасан баримт бичгийг нэмж бүрдүүлдэг болох шаардлагатай. Энэ талаар тодруулахад “Зээлийн үйл ажиллагааны журмаар харилцагчаас зээлийн ашиглалт шалгана гэж заагаагүй тул материалд хавсаргаагүй” гэх хариу ирүүлсэн. Фидуцийн зүйл болон автомашиныг худалдан авахдаа уг зээлийг зориулалтын дагуу зарцуулсан гэж үзэх талтай. Харин зээл төлж дуусгах хүртэл хугацаанд фидуцийн гэрээний дагуу ББСБ-ын өмчлөлд байгаа автомашиныг ихэнх тохиолдолд Зээлдэгч ашиглаж, унаж байгаа учраас уг хөрөнгийн бүрэн бүтэн байдал, ашиглалтын талаар ББСБ-ийн зүгээс зохих хяналттай байх нь Үнэт цаас гаргагчийн эрх ашигт нийцэхээр байгааг цаашид анхаарах нь зүйтэй. Үүнтэй холбоотойгоор Зээлийн үйл ажиллагааны журамд фидуцийн зүйлийн бүрэн бүтэн байдал, ашиглалт шалгасан баримт бичгийг хувийн хэрэгт хавсаргах зохицуулалт оруулах зэрэг арга хэмжээ авахыг зөвлөж байна.